

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 24 ДЭХ ИЛТГЭЛ



АГУУЛГА

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 24 ДЭХ ИЛТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА 3

I БҮЛЭГ. СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ 2024 ОНЫ СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 6

1.1. ТАНИЛЦУУЛГА	8
1.2. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	10
1.3. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ	21
1.4. СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА	22
1.5. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	23
1.6. БҮХ НИЙТИЙН БАЙХ ЗАРЧИМ	25
1.7. ТЭГШ БАЙДЛЫН ЗАРЧИМ	37
1.8. ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЗАРЧИМ	44
1.9. СОНГУУЛИЙН САНАЛАА НУУЦААР ГАРГАХ ЗАРЧИМ	48
1.10. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ	49
1.11. СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧСӨН ТАЛААРХ ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ	54

II БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ӨМГӨӨЛӨГЧ, СЭТГҮҮЛЧИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 62

2.1. ТАНИЛЦУУЛГА	64
2.2. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	65
2.3. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАЧ СЭТГҮҮЛЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	81
2.4. ДҮГНЭЛТ	94

III БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ БА ЦАХИМ ТЕХНОЛОГИ 99

3.1. ТАНИЛЦУУЛГА	101
3.2. ЦАХИМ ХӨГЖЛИЙН СУУРЬ НӨХЦӨЛ	102
3.3. ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРСДЭЛ	116
3.4. ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХИЙДЭЛ ХЭРЭГЖИЛТ	147

IV БҮЛЭГ. ТЕХНОЛОГИ АШИГЛАН ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ 176

4.1 ТАНИЛЦУУЛГА	178
4.2. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	178
4.3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН	184
4.4. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА	191

4.5. ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЖ БУЙ ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ	194
4.6. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	196
V БҮЛЭГ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ	200
5.1. ТАНИЛЦУУЛГА	202
5.2. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	202
5.3. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ АЖИЛЛАГАА	209
5.4. ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ	215
5.5. ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ХОХИРЛОО БАРАГДУУЛАХ ЭРХ	216
5.6. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БУСАД БҮТЦИЙН ОРОЛЦОО	221
VI БҮЛЭГ. ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ	226
6.1. ТАНИЛЦУУЛГА	228
6.2. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХ	229
6.3. МЭДҮҮЛЭГ АВАХ ҮЕИЙН ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ	236
6.4. ӨМГӨӨЛӨЛ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ	239
6.5. СЭТГЭЦИЙН ШИНЖИЛГЭЭ БА ХҮНИЙ ЭРХ	243
6.6. ТӨРИЙН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ, МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА	249
6.7. МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ	251
6.8. ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	252
6.9. ХИЛЭЭР ГАРАХЫГ ХОРИГЛОХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	257
6.10. ХОРИХ ЯЛ БА ХОРИХ АНГИЙН НӨХЦӨЛ	260
6.11. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙРНЫ НӨХЦӨЛ	266
6.12. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ДАВЖ ЗААЛДАХ ЭРХ	267
6.13. ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ	271
6.14. СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	278
МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР ӨГЧ БУЙ САНАЛ	284
МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	288
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	295

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАЙДЛЫН ТАЛААРХ 24 ДЭХ ИЛТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12, 9 дүгээр зүйлийн 9.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлдэг.

Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг “Сонгох, сонгогдох эрх: 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа”, “Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал”, “Хүний эрх ба цахим технологи”, “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал, анхаарах асуудал”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал” “Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт” гэсэн 6 бүлгийн хүрээнд боловсрууллаа.

Энэхүү илтгэлийг Комиссын стратеги төлөвлөгөө, жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд хийсэн хяналт шалгалт, иргэдээс Комисст ирүүлсэн гомдол, мэдээлэл, Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, судалгаа, дүн шинжилгээ, төрийн болон бусад байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн боловсруулж Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 45 саналыг танилцуулж байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийн агуулгыг бүлэг тус бүрээр тоймловол:

Нэгдүгээр бүлэг. Сонгох, сонгогдох эрх: 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах үзэл баримтлалд тулгуурлан Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох, иргэний сонгох, сонгогдох эрхийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн баталгаажуулсан.

2024 онд Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн ээлжит сонгууль зохион байгуулагдлаа.

1992 оноос хойш Монгол Улсын Их Хурал 76 гишүүнтэй байгуулагдаж байсан бол Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 2024 оноос 126 гишүүдээс бүрдэх болсон бөгөөд 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох холимог сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлсэн онцлогтой сонгууль байлаа.

Комисс хуулиар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд 2024 оны Монгол Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулиар сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй, нууцаар гаргах үндсэн зарчмыг хэрэгжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний талаарх санал, зөвлөмжийг танилцуулж байна.

Хоёрдугаар бүлэг. Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал

Хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хамгаалахад үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчид, нийгмийн шударга ёсыг шаардан, үзэл бодлоо илэрхийлж, олон нийтийн мэдэх эрхийг хангахын төлөө ажилладаг сэтгүүлч нь бусдын болон нийтийн эрх ашгийг хамгаалсан үйлдлийн улмаас бусдын заналхийлэл, дарамт шахалт, халдлагад өртөх, ял шийтгүүлэх, амь насаа алдах эрсдэлтэй байна.

Ялангуяа хүний эрх хамгаалагч өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нь удирдлага болгодог Өмгөөллийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, сэтгүүлчийн

хувьд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ нэгэнтээ бий болсон байна. Эдгээр хуулиар өмгөөлөгч, сэтгүүлч нь хүлээсэн үүргээ чанартай, хариуцлагатай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ аюулгүй байдлыг нь хангасан, хариуцлагын тогтолцоог оновчтой хэрэгжүүлдэг механизмтай байх нь чухал юм.

Комиссоос 2024 онд хийсэн “Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааны үр дүн тулгуурлан өмгөөлөгч, сэтгүүлчийн аюулгүй байдал, хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломж, баталгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, шийдлийг энэ бүлэгт дэвшүүлсэн болно.

Гуравдугаар бүлэг. Хүний эрх ба цахим технологи

Цахим технологийн хөгжил харилцаа холбооны хувьсгал хийж, мэдлэгийг “ардчилж”, бүтээмжийг дээшлүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулах төдийгүй хүн төрөлхтний энх тогтвортой орших найдвар, шийдэл болж байна. Гэвч мэдээлэл, өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж, боловсруулах үндсэн горимоор ажилладаг цахим технологиуд хүний эрх, эрх чөлөөний ноцтой эрсдэлийг дагуулдаг.

Цахим технологийн эриний “газрын тос” гэгдэж буй хүний хувийн мэдээлэл, түүнд агуулагдах хувийн нууц, халдашгүй байх эрхийг хамгаалах нь орчин цагийн тулгамдсан асуудал юм. Иймд тус Комисс 10 салбарын 36 асуудлыг хамруулан “Хүний эрх ба цахим технологи” олон нийтийн хяналт шалгалтыг 2023-2025 онд зохион явуулж байна.

Энэхүү бүлгийг тус хяналт шалгалтын эхний үр дүнд суурилан боловсруулсан бөгөөд цахим хөгжлийн суурь нөхцөл, хууль сахиулах, ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж буй зарим төрлийн технологийн хүний эрхийн үнэлгээ, хиймэл оюуны бодлого, зохицуулалт болон Хүний хувийн мэдээллийг хамгаалах хуулийн хийдэл ба хэрэгжилтийг дүгнэн илтгэж байна.

Дөрөвдүгээр бүлэг. Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл

Дэлхий нийтээр технологийн хурдацтай хөгжил нь жендэрт суурилсан хүчирхийлэл үйлдэх шинэ сувгуудыг бий болгож, хүчирхийллийн арга хэлбэр өөрчлөгдөж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь цахим болон бодит орчинд аль алинд нь нөлөөлж буй асуудалд онцгой анхаарал хандуулж, илүү үр дүнтэй, цогц арга хэмжээ авах, хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг Нэгдсэн үндэстний байгууллагын хүний эрхийн механизмууд зөвлөж байна.

Охид, эмэгтэйчүүдийн цахим орон зайг илүү аюултай болгож буй энэ асуудалд Комисс анхаарал хандуулж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4.б-д заасан чиг үүргийнхээ хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан болон Нэгдсэн үндэстний байгууллагаас гаргасан холбогдох тогтоол, зөвлөмжид үндэслэн бичиж, цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал, цаашид авч авах арга хэмжээний талаар танилцууллаа.

Тавдугаар бүлэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн зарим асуудал

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжид хүүхдийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах зохицуулалт, төрийн зохих байгууллагын үүргийг хуульчилсан ч нийгэм хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй энэ цаг үед хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болох тохиолдол буурахгүй харин хурдацтай өсөж байгаад төр анхаарал хандуулах шаардлагатай байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орны хувьд 2010 оноос НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлийн ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг, Хүний эрхийн гэрээний хороодод

Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх тайлан болон Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг тогтмол хэлэлцүүлж ирсэн бөгөөд НҮБ-ын механизмуудаас хүүхдийн эрх, түүний дотор нөхөн үржихүй, хүчирхийллээс ангид байх эрхэд онцгой ач холбогдол өгч нэн тэргүүнд анхаарахыг зөвлөж байна.

Комисс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг тусгайлан судалж, хүүхдийн эрхийн асуудлаар мэргэшсэн судлаач, шинжээч, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нарт тусламж үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, ярилцлага, хууль хяналтын болон хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр ажиллаж буй төрийн байгууллагын тоон мэдээлэл, хяналт шалгалт, дүн шинжилгээний үр дүнд үндэслэн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх, хамгааллын талаар эн тэргүүнд анхаарах асуудлын талаарх санал дүгнэлтийг танилцуулж байна.

Зургаадугаар бүлэг. Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт

Шударгаар шүүлгэх эрхийн агуулга нь аливаа хүн эрүүгийн хэрэгт татагдсан үеэс эхлэн ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх үе шатыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм. Гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүнтэй мөрдөн шалгах, шүүх эрх мэдлийн байгууллагууд хэрхэн харьцаж байгаа, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэн хамгаалж байгаагаас тухайн улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар төвшинд хүрснийг илэрхийлэх шалгуур үзүүлэлт болдог.

Хүний эрхийн Үндэсний Комисст 2024 онд ирсэн гомдол, мэдээллийн 52.9 хувь нь шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл эзэлж байх ба агуулгаар нь авч үзвэл, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, хилс хэрэг хүлээсэн, эрүү шүүлтээс ангид байх, хууль бусаар цагдан хоригдсон, орон байрны халдашгүй байдалд халдсан, гэмт хэрэг үйлдсэн мэтээр олон нийтийн сүлжээнд зарласан, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон зэрэг гомдлууд дийлэнх хувийг эзэлж байна.

Энэ бүлэгт Комисст ирүүлсэн гомдол мэдээлэл, зохион байгуулсан хяналт шалгалт, шинжээч, судлаач нартай хамтран боловсруулсан судалгааны үр дүн, комиссын гишүүний шаардлага зөвлөмж, холбогдох байгууллагын баримт мэдээлэлд үндэслэн шударгаар шүүлгэх эрхийн зарим асуудлыг хөндөж, цаашид авах арга хэмжээний талаар боловсруулсан дүгнэлт саналыг тусгалаа.

I БҮЛЭГ

СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХ: 2024 ОНЫ СОНГУУЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА

“Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалт)

“...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт)

“...Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.

Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 1,3 дах хэсэг)

“...Иргэн бүр аливаа алагчилалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах эрх, боломжийг эдэлнэ: -төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох;- сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй...”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлийн а,б хэсэг)

“...Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн эрхийг баталгаажуулж, эдгээр эрхээ бусдын нэгэн адил эдлэх боломжийг бий болгох үүднээс дараах үүрэг хүлээнэ:

Бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрх, боломжийг оролцуулан шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулан улс төр, нийгмийн амьдралд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцох...”

(Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 29 дүгээр зүйл)

“...Оролцогч улсууд тухайн улсын улс төр, олон нийтийн амьдралд эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах үүднээс зохистой бүхий л арга хэмжээг авна, тухайлбал, эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд дараах эрхээр хангана: бүх сонгууль, ард нийтийн санал хураалтад санал өгөх болон нийтээр сонгох бүх байгууллагад сонгогдох;

(Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 7 дугаар зүйлийн а хэсэг)

1.1 ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн улс орнуудад XVII-XVIII зууны өрнөсөн хувьсгалын үр дүнд ардчиллын үзэл санааг биежүүлж, эхэндээ хүйс, нийгмийн гарал байдал, арьс өнгөөр ялгавартайгаар улс төрийн шийдвэр гаргах төлөөллийг сонгох, сонгогдох эрхийг зохицуулж байсан бол XX зуунаас эхлэн бүх нийтээр сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан билээ. Ийнхүү иргэний улс төрийн нэг үндсэн эрх болох сонгох, сонгогдох эрхийг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, холбогдох бусад олон улсын гэрээ, конвенцод тусгажээ.

Иргэн бүрийн сонгох, сонгогдох эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 25 дугаар зүйлд баталгаажуулсан бөгөөд Үндсэн хууль болон төрийн тогтолцооноос үл хамаарч иргэд нь эдгээр эрхийг үр нөлөөтэй эдлэх боломжийг хангахад зайлшгүй хууль зүйн болон бусад арга хэмжээг төрийн зүгээс авч хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.¹

Ардчилсан нийгэмд төрийн үйл хэрэгт иргэдийн оролцох суурь нь иргэдийн мэдэх эрх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхэд суурилах бөгөөд тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчим, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, сонгох сонгогдох эрхээр баталгааждаг, харилцан уялдаа холбоотой хэрэгждэг. Төрийн үйл хэрэгт оролцох эрхийг хангахын тулд төрөөс дараах нөхцөлийг бүрдүүлсэн байхыг НҮБ-ын ХЭДКГ-аас зөвлөжээ.² Үүнд: Үндсэн хуулиар баталгаажсан байх, үндэсний бодлогын баримт бичиг, хууль тогтоомжоор зохицуулсан байх, хууль тогтоомж тэгш эрхийн зарчимд суурилан хэрэгждэг байх, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрх, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх,³ үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хууль тогтоомжоор баталгаажуулсан байх, иргэний нийгмийн оролцоог хүлээн зөвшөөрсөн байх, хараат бус бие даасан олон ургальч хэвлэл мэдээллийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны аюулгүй байдлыг хангах, хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, эмэгтэй хүний эрх хамгаалагч зэрэг иргэний нийгмийн байгууллагын оролцогчдын эрхийг хамгаалах, эрхийн зөрчил гарвал шуурхай хараат бусаар гомдлыг шалгах ажиллагаа явуулах, төрийн байгууллагаас нээлттэй бодитой мэдээллийг түгээж иргэн, нийгмийн бүлгүүдтэй харилцах, ингэхдээ зорилтот бүлгийг ялгаварлахгүй мэдээлэл, харилцааг хүртээмжтэй байлгах, иргэний нийгмийн байгууллага ба төр хоорондын итгэлцлийг бүрдүүлэх, хэрэв эрхийн зөрчил гарвал сэргээх тогтолцоотой байх зэрэг нөхцөл болно.

Монгол Улс 1924, 1940, 1960 оны Үндсэн хуульд зарим шалгуураар хязгаарлалтай сонгох, сонгогдох эрхийг тусгасан бол 1992 оны Үндсэн хуулиар иргэний сонгох, сонгогдох эрхийн ардчилсан зарчмыг баталгаажуулсан юм. Монгол Улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах үзэл баримтлалд тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх заалтад “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох суурь агуулгыг илэрхийлжээ.

Монгол Улсын иргэд Үндсэн хуульд зааснаар улс төрийн шийдвэр гаргах гурван институт болох Монгол Улсын Ерөнхийлөгч, МУИХ, АНСДИТХ-д сонгох, сонгогдох, харин баг, хорооны иргэдийн Нийтийн хуралд шууд оролцох эрхтэй. Монгол Улсын Үндсэн хуулиар сонгуулийн үндсэн зарчмыг сонгогчдын буюу иргэдийн сонгох, сонгогдох үндсэн эрхийн шинж байдлыг гол шалгуур болгож⁴ нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр

¹ НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №25

² [GuidelinesRightParticipatePublicAffairs_web 1.pdf](#)

³ НҮБ-ын ХЭДКГ, “Цахим эринд нууцлалын эрх” тайланд “Мэдээлэл солилцох онлайн орчинд тавигдах хяналт дэлхий даяар өргөжиж, олон нийтийн санаа бодлыг хэмжих, хүмүүсийн нийгмийн үйлдэлд анализ хийж байгаа зэрэг нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван цуглаан хийх, ардчилалд оролцох эрхийг зөрчих аюултай” талаар дурдсан байна.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл

саналаа чөлөөтэй, нууцаар гаргана гэж тодорхойлсон. Иймд ардчилсан сонгууль нь засгийн эрх мэдлийг тодорхойлох ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, сонгогчдын өөрсдийн сонголтын хувилбар байх бөгөөд ардчилсан төрийн шийдвэр гаргалтад нөлөөлөх боломж юм.

Дэлхийн улс орнуудын ардчиллын төлөв, үзүүлэлтээр (IDEA) Монгол Улс ардчиллын бүх үзүүлэлтээр дэлхийн дундаж байгаа бөгөөд сонгуулийн эрх, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийн тухайд дэлхийн улсуудын эхний 25 хувьд багтаж байна. Сүүлийн таван жилийн хугацаанд иргэний эрх чөлөө, эдийн засгийн тэгш байдал, үг хэлэх эрх чөлөө, улс төрийн намуудын чөлөөт байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзүүлэлт ухарсан үзүүлэлттэй байна.⁵

Дэлхийн банкнаас гаргадаг улс орнуудын улс төрийн тогтолцооны үзүүлэлт, сонгуулийн ардчиллын индексээр Монгол Улс 2023 оны байдлаар 0.527 оноотойгоор 171 орноос 82 дугаарт Бутан, Босни-Херцеговин Улстай адил оноотой эрэмбэлэгдэж байна.⁶ Түүхийн хувьд Монгол Улс энэ үзүүлэлтээр 1960 онд хамгийн бага буюу 0.175 оноотой байсан бол, 1997 онд 0.712 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байжээ. Парламентын сонгуулийн үзүүлэлт 169 орноос 119 дүгээрт, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны үзүүлэлтээр 171 орноос 84 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Мөн уг судалгааны дүнгээр иргэдийн оролцоо, ил тод байдлын индексийн хувьд төр, орон нутгийн байгууллагын сонгуульд оролцох, сонгох, сонгогдох эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх хэмээх дэд хэсгүүдээс бүрддэг бөгөөд 2023 оны байдлаар 192 орноос 0.25 оноотой 79 дүгээрт эрэмбэлэгдэж байна.⁷

Монгол Улс 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 онд Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг 8 удаа зохион байгуулж, төрийн эрх мэдлийг сонгуулийн үр дүнд үндэслэн тайван замаар шилжүүлэх соёл төлөвшсөн. Эдгээр сонгуулийг олон улсын байгууллагууд болон гадаад улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл ажиглаж ардчилсан сонгууль явуулж хэвшсэн гэж үнэлдэг.

Монгол Улсад 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр МУИХ-ын, 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр АНСДИТХ-ын 9 дэх удаагийн ээлжит сонгууль зохион байгуулагдлаа.

1992 оноос хойш 76 гишүүнээс МУИХ бүрдэж байсан бол Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2024 оноос МУИХ-ын гишүүдийн тоо 126 болж, 78 гишүүн иргэдийг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн сонгох холимог тогтолцоог хэрэгжүүлэхээр заасан нь хууль тогтоох байгууллагын нийгмийг төлөөлөх чадавх, нийгмийн бүлгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, ардчилсан шинжийг нэмэгдүүлэхэд түлхэц болох боломж бүрджээ. Сонгуулийн тогтолцооны энэ өөрчлөлт нь МУИХ-д суудал авч байгаагүй намуудаас суудал авах боломжийг нэмэгдүүлж, нэг нам давамгайлахаас сэргийлэх, эмэгтэй гишүүдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодитой арга хэмжээ байлаа.

Ийнхүү МУИХ-ын 2024 оны ээлжит сонгууль тогтолцоо, зохион байгуулалтын хувьд онцлогтой түүхэн сонгууль болж өнгөрлөө. Томсгосон тойрогт, хувь тэнцүүлсэн ба олонхыг төлөөлөх холимог тогтолцоогоор олон тооны нам, эвсэл, нэр дэвшигчээс сонголт хийх сорилт тулгарсан ч сонгогчид 69,58 хувийн ирцтэйгээр Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэн Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллагад төлөөллөө сонгов.

Монгол Улс ардчиллын замыг тууштай сонгон бэхжүүлэхийг зорьсон 32 жилийн хугацаанд сонгуулийг зохион байгуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, иргэний сонгох, сонгогдох эрхийг бодитой хангахын тулд сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангахаар хүчин зүтгэл гаргаж байна. Хэдийгээр тийм боловч 2024

⁵ [In Mongolia, electoral reform ushers in a record number of women to parliament Interactive Map | The Global State of Democracy](#)

⁶ https://www.theglobaleconomy.com/rankings/electoral_democracy_index/

⁷ https://www.theglobaleconomy.com/rankings/wb_voice_accountability/

оны ээлжит сонгуулийн үйл явцаас дүгнэхэд сонгуулийн зарчмыг тууштай хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс иргэний болон улс төрийн эрхийн нөхцөл байдалд тогтмол дүн шинжилгээ хийж өнгөрсөн хугацаанд Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх нийт 5 удаагийн илтгэлд сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг дүгнэж, эн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмжийг хүргүүлж байв. Тухайлбал: Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2005 оны илтгэлд сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, нэрийн жагсаалтын үнэн зөв эсэхэд тавих сонгуулийн хороодын болон хөндлөнгийн хяналтыг үр дүнтэй, оновчтой болгох, МУИХ-ын сонгуулийн тойргуудын сонгогчдын тоо эрс зөрүүтэй байгаад дүгнэлт хийж, тойргуудын цэсийг шинэчлэн тогтоох, бүх нийтийн байх, тэгш байх, чөлөөтэй байх зарчмуудыг хэлбэрэлтгүй хангах зэрэг саналыг МУИХ-д хүргүүлсэн боловч өнөөг хүртэл эдгээр асуудлууд бүрэн шийдэгдээгүй хэвээр байна.

ХЭҮК-оос “МУИХ-ын 2024 оны ээлжит сонгууль: эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт”,⁸ “АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль: эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт мониторингийн тайлан”,⁹ “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан сонгуулийн үндсэн зарчмууд: Улсын Их Хурлын болон сонгуулийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн нарийвчилсан дүн шинжилгээ”, “МУИХ-ын 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээний платформ ашиглаж байгаа байдалд хийсэн мониторинг”¹⁰ судалгааг гүйцэтгүүлсэн бөгөөд эдгээр тайланд үндэслэн сонгуулийн үндсэн зарчмыг хэрэгжүүлсэн байдлыг дүгнэж, 2024 оны сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, зөрчил, шалтгаан нөхцөл, тулгамдсан асуудлыг тодорхойлсон. Комисст ирсэн гомдол, мэдээлэл, хяналт шалгалтын үр дүн, холбогдох бусад байгууллагын тайлан мэдээ, судалгаа, дүн шинжилгээ, мэдээлэлд үндэслэн энэхүү бүлгийг боловсруулж, дүгнэлт саналыг тусгалаа.

1.2 ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад сонгох, сонгогдох эрхийг бодитойгоор эдлүүлэхэд чиглэсэн хууль, бодлого, журам бүхэлдээ сонгуулийн зарчимд үндэслэн, сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааны суурь бүрдсэн бөгөөд 1992 оноос хойш 3 түвшний 37 удаагийн¹¹ сонгуулийг явуулж ардчиллын соёл, оролцоонд суралцаар байна.

МУИХ-ын 2008 оны ээлжит сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн олон нийтийн жагсаал цуглаан нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг бий болгож, хүний эрхийг ноцтой зөрчсөн сургамж болсон тул сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх, сонгууль явуулах журам, үйл явцыг нарийвчлан зохицуулах, оролцогч талуудыг хүртээмжтэй мэдээллээр хангах, сонгогчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, сонгуулийг ил тод, нээлттэй явуулах, иргэний нийгмийн хяналтыг бий болгох чиглэлээр сонгуулийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг өөрчилсөн. Энэ хүрээнд 2011 онд Сонгуулийн автоматжуулсан системийн хуулийг МУИХ-аас баталж, сонгогчдын бүртгэл болон санал тоолох үйл явцыг автоматжуулж, сонгуулийн үр дүнд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэж

⁸ Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, малчин, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, улс төрийн нам, ТББ-ын төлөөлөлтэй 20 удаагийн (14 нь ганцаарчилсан, 6 нь бүлгийн) ярилцлага хийсэн. Ярилцлагад МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч, сонгогч, сонгууль зохион байгуулагч болон ажиглагч талын төлөөлөл оролцов.

⁹ Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, малчин, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагч, улс төрийн нам, ТББ-ын төлөөлөлтэй 25 удаагийн (21 нь ганцаарчилсан, зургаа нь бүлгийн) ярилцлага хийсэн. Ярилцлагад орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч, сонгогч, сонгууль зохион байгуулагч болон ажиглагч талын төлөөлөл оролцов. Сэлэнгэ аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал, Алтанбулаг сум, Дархан-Уул аймаг, Дархан-Уул аймгийн Дархан сум, Төв аймгийн Баянчандмань суманд ажиллаж эмэгтэйчүүд, ахмад настан, малчин болон аймаг, сумын сонгуулийн хороонд ажилласан албан хаагч нартай ярилцлаа. Ярилцлага бүрийн өмнө судалгаанд оролцогчдын зөвшөөрлийг урьдчилан авсан болно.

¹⁰ Олон нийтийн сүлжээний платформуудаас фэйсбүүк, инстаграм, ютүб, твиттер буюу ийкс, хиймэл оюун ухаан (ЭйАй)-ыг сонгон авч мониторинг хийв.

¹¹ 1992-2025 оныг хүртэлх нийт 33 жилийн хугацаанд МУИХ-ын сонгууль 9, Ерөнхийлөгчийн сонгууль 8, орон нутгийн Хурлын сонгууль 9, МУИХ-ын нөхөн болон дахин сонгууль 11, нийт 37 сонгууль явуулсан.

байна. Олон улсын сонгууль ажиглах багаас Монгол Улсын зохион байгуулсан сонгуулийг шударга, чөлөөтэй, нийтээрээ, тэгш оролцох ардчиллын үндсэн зарчмуудын дагуу зохион байгуулагдаж ирсэн гэж дүгнэдэг ч Үндсэн хуулийн болон олон улсын зарчимд бүрэн нийцэхгүй тулгамдсан асуудлууд байсаар байна.

МУИХ-ын болон орон нутгийн Хурлын сонгуулийн онцлог, ялгаатай нөхцөл байдлыг харгалзан хууль тогтоомжоор зохицуулах нь сонгох, сонгогдох эрхийн үндсэн зарчмыг хангах, сонгуулийн үйл ажиллагааны үр нөлөөг бүхэлд нь дээшлүүлэхэд ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”¹², “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн”¹³ гэж заасан.

Хүснэгт 1.1 МУИХСтХ болон АНСДИТХСтХ-ийн харьцуулалт

№	Хууль тогтоомж	Хуулийн бүлэг	Хуулийн зүйл, заалт	Ижил заалтууд ¹⁴	Ялгаатай заалтууд ¹⁵
1	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	12	83 зүйл, 595 заалт	Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.5, 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсэг мөн бусад.	Хуулийн 29 дүгээр зүйлийн 6, 30 дугаар зүйлийн 30.2, 39 дүгээр зүйлийн 39.1, 60 дугаар зүйлийн 62.1, 66 дугаар зүйл бусад.
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	12	83 зүйл, 534 заалт	Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.4, 64 дүгээр зүйлийн 64.5 дахь хэсэг мөн бусад.	Хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 29 дүгээр зүйлийн 29.2, 38 дугаар зүйлийн 38.1, 61, 65 дугаар зүйл бусад.

Хоёр түвшнийг төлөөлөх байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ, төсөв, шийдвэр гаргах асуудлын хамрах хүрээ, иргэдэд үзүүлэх үр нөлөөний тухайд ялгаатай учир сонгууль явуулах ерөнхий зарчим, зохион байгуулалт, үйл явцыг төсөөтэй байдлаар зохицуулах

¹² Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл
¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин наймдугаар зүйл
¹⁴ МУИХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй”, АНСДИТХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй”; МУИХСтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсэгт “Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөх бөгөөд сонгогчдын саналыг энэ хуулийн ...-т заасан ажиллагааг хийж дууссаны дараа авч эхэлнэ”, АНСДИТХСтХ-ийн 64 дугаар зүйлийн 64.5 дахь хэсэгт Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөх бөгөөд сонгогчдын саналыг энэ хуулийн ...-т заасан ажиллагааг хийж дууссаны дараа авч эхэлнэ” гэж заасан.
¹⁵ МУИХСтХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна”, АНСДИТХСтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна”; МУИХСтХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно”, АНСДИТХСтХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно”; МУИХСтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт “Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшихийг хориглоно”, АНСДИТХСтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5 дэх хэсэгт “Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно”, МУИХСтХ-ийн 60 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт “Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 22:00 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна”, АНСДИТХСтХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.14 дэх хэсэгт “Санал авах өдрийн 20:00 цагт сонгогчдын бүртгэл зогсох бөгөөд бүртгэлийн хуудсаа авсан сонгогчийн саналыг нь өгүүлнэ” гэж заасан.

боломжтой ч бусад ялгаатай харилцааг тухайн сонгуулийн онцлогт тохирсон байдлаар нарийвчлан хуульчлах нь ач холбогдолтой юм.

Ээлжит сонгууль зохион байгуулагдахын өмнөх болон тухайн жилд сонгуулийн хуулийг өөрчилж байгаа нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд нөлөөлөх суурь шалтгаан болж байна.

МУИХ-ын болон орон нутгийн Хурлын сонгуулийг 9 удаа зохион байгуулжээ. МУИХ-ын сонгуулийн тогтолцоог 5 удаа хуулиар (1992, 2005, 2011, 2015, 2019 онд), 3 удаа хуулийн нэмэлт өөрчлөлтөөр (1996, 2012, 2016 онд) өөрчилж, өөрчлөлт бүр МУИХ-ын ээлжит сонгуулиас 1-6 сарын өмнө хугацаанд хийгдэж байсан нь сонгуулийн хуулийг сайжруулах нэртэй ч нөлөө бүхий намуудын тохиролцоо, ихэнхдээ эрх баригч намын улс төрийн шийдвэр байсан¹⁶ талаар тэмдэглэгджээ. Ингэхдээ сонгуулийн тогтолцооны талаарх нийтийн ашиг сонирхол, үнэт зүйлсийг чухалчлахгүй өөрсдийн дахин сонгогдох кампанит ажилд зориулан хийж ирсэн нь богино хугацааны ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр байсан бөгөөд энэ нь засаг захиргааны байгууллагуудын “легитим” чанар буурахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг¹⁷ гэж судлаачид дүгнэсэн байна.

МУИХ-ын нийт 9 удаагийн сонгуулийн 7 удаад мажоритар тогтолцоогоор, 2 удаад холимог тогтолцоогоор явуулсан бол орон нутгийн Хурлын нийт 9 удаагийн сонгуулийн 8 удаа мажоритар тогтолцоогоор, 2012 онд холимог тогтолцоогоор явуулсан байна. 2016 оны ээлжит сонгуулийг явуулахаас 2 сар 7 хоногийн өмнө Үндсэн хуулийн Цэцийн “Сонгуулийн холимог тогтолцоо нь Үндсэн хууль зөрчсөн” гэх дүгнэлт¹⁸ гарч 2016, 2020 оны сонгуулиудыг мажоритар тогтолцоогоор явуулжээ. Ийнхүү өмнөх бодит сургамжид үндэслэн 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх заалтад “... Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж заасан билээ.

Сонгуулийн тогтолцоо тогтвортой байх нь тухайн улсын улс төр, нийгэм, эдийн засаг, үндсэн хуульт ёсны төлөвшилд чухал нөлөөтэй бөгөөд сонгуулийн тогтолцоо богино хугацаанд тогтмол өөрчлөгдөх нь мэдээллийн хүртээмж, сонгуулийн ирц, оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэд нөлөөлдөг.

Шигтгээ 1.1

Үндсэн хууль батлагдсанаас хойших хугацаанд парламентын сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх харьяалал, хянан шийдвэрлэх журмын талаарх тогтсон нэг ойлголт, шийдэлд хүрэлгүй явсны нэг шалтгаан нь сонгуулийн эрх зүйн орчин тогтворгүй буюу парламентын сонгууль бүрийн өмнө шинэ хууль батлагдаж, эсхүл маш олон нэмэлт, өөрчлөлт орж байдагтай холбоотой.

(“Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал” нийтлэлээс¹⁹)

¹⁶ МУИХ, “Зөвлөлдөж шийдье” Улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын лавлагаа, танилцуулга, УБ, 2023, 67 дахь тал, Азийн сан, “Монгол Улсын сонгууль (1992-2021) эмхэтгэл”, УБ, 2023 он, 27 дахь тал

¹⁷ Азийн сан, “Монгол Улсын сонгууль (1992-2021) эмхэтгэл”, УБ, 2023, 12 дахь тал

¹⁸ Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлт (хүчингүй болсон)

¹⁹ Легалдата, “Парламентын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харьяалал”, Д.Бат-Эрдэнэ, 21MINUM1041

Хүснэгт 1.2 МУИХ болон орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцооны харьцуулалт

Оноор	МУИХ-ын сонгуулийн тогтолцоо			Орон нутгийн Хурлын сонгуулийн тогтолцоо		
	Нэршил	Агуулга	Тайлбар	Нэршил	Агуулга	Тайлбар
1992	Томсгосон мажоритар	Нэг тойрог-Олон мандат				
1996	Жижигсгэсэн мажоритар	Нэг тойрог-Нэг мандат		Жижигсгэсэн мажоритар	Нэг тойрог-Нэг мандат	
2000						
2004						
2008	Томсгосон мажоритар	Нэг тойрог-Олон мандат		Томсгосон мажоритар	Нэг тойрог-Олон мандат	
2012	Холимог	Мажоритар болон пропорциональ хослуулсан	48 тойрог, 28 жагсаалт	Холимог	Хувь тэнцүүлэх болон нэг буюу олон мандаттай олонх (мажоритар)	Нийт төлөөлөгчдийн 1/3 нь намын жагсаалтаар сонгогдсон (5,241 нь мажоритар, 2,779 нь хувь тэнцүүлсэн)
2016	Томсгосон мажоритар	Нэг тойрог-Олон мандат		Олонхын мажоритар	Нэг тойрог-Олон мандат	
2020						
2024	Холимог	Мажоритар болон пропорциональ хослуулсан	78 тойрог, 48 жагсаалт	Олонхын мажоритар	Нэг тойрог-Олон мандат	

МУИХ-ын сонгуулийг хамгийн олон удаа олонхын буюу мажоритар тогтолцоо ашиглаж зохион байгуулсан. Жижигсгэсэн мажоритар тогтолцоог ашигласан 1996, 2000, 2004 оны сонгуулиар нэр дэвшигч сонгуульд ялахын тулд сонгогчдын 50-иас дээш хувийн санал авах шалгууртай байсан бөгөөд энэ хувьдаа хүрээгүй бол хоёр дахь шатны сонгууль зохион байгуулах зохицуулалттай байсан. Харин 2008, 2016, 2020 оны сонгуулиар сонгуульд оролцсон сонгогчдын олонхын санал авснаар МУИХ-ын гишүүн болох зохицуулалттай байв.

Энэ тогтолцооны сул тал нь суудал-саналын харьцааны алдагдал бөгөөд заримдаа ихээхэн гажуудал үүсгэж байв. Тухайлбал: 2000 оны МУИХ-ын ээлжит сонгуульд МАХН сонгогчдын 53.32 хувийн санал авсан боловч 72 суудал, АН нийт сонгогчдын саналын 13.35 хувийг авч 1 суудал, Эх-Орон Бүгд найрамдах нам 10.95 хувийн санал авч 1 суудал, Иргэний зориг нам 3.45 санал авч 1 суудал, бие даагчид 2.92 хувийн сонгогчдын санал авч 1 суудал, бусад намууд 15.97 хувийн сонгогчдын санал авсан ч суудалгүй үлдсэн. Уг сонгуульд нийт 16 хувь буюу 190,000 сонгогчийн санал гээгдсэн нь 10 тойргийн сонгогчдын саналтай тэнцэх дүн байв.²⁰


2008 оны томсгосон мажоритар тогтолцооны үр дүнд МАХН-ын сонгогчдын 52.03 хувийн санал авсан боловч 45 суудал, АН сонгогчдын 47.9 хувийн санал авсан боловч 28 суудал авсан нь хоёр намын авсан саналын хувийн зөрүү бага боловч суудлын тоо ихээхэн зөрүүтэй байв.

2008 оны МУИХ-ын сонгуулийн үр дүнг зарласны дараа 07 дугаар сарын 01-ний өдрийн сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн үйл явдлаас улбаалан 2012 оны сонгуульд холимог тогтолцоог ашиглан, МУИХ-ын 76 гишүүний 48-ыг нь 26 томсгосон тойргоос, 28-ыг нь Монгол Улсыг нэг тойрогт тооцож, улс төрийн намын авсан саналтай хувь тэнцүүлэн намын жагсаалтаас сонгосон. Энэ нь нийт суудлын 63 хувийг мажоритар тогтолцоогоор, 37 хувийг

²⁰ О.Мөнхсайхан, Р.Очирбал, "Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл", УБ, 2021 он

нь пропорциональ буюу хувь тэнцүүлсэн намын жагсаалтын тогтолцоогоор хослуулан холимог тогтолцоог хэрэгжүүлжээ. 2012 оны сонгуулийн үр дүнгээс үзвэл жижиг намуудын төлөөлөл нэмэгдсэн хэдий ч энэ сонгууль нь тэнцвэртэй холимог тогтолцоо бус, харин илүү хувь тэнцүүлсэн тогтолцоотой ижил төстэй үр дүнг гаргажээ. Өөрөөр хэлбэл нийт 41 хувийн санал гээгдсэн байх бөгөөд 2012 онд хослуулан хэрэглэсэн хоёр тогтолцооны давуу болон сул талуудыг тэнцвэржүүлж чадаагүй байна. 1992-2004 онд зохион байгуулсан МУИХ-ын сонгуулийн үр дүнд санал хураалтад оролцсон нийт сонгогчдын саналын 54.79 хувийн төлөөллөөр МУИХ-ын гишүүд сонгогдож байжээ.²¹

Бүдүүвч 1.1 Сонгогчдын санал МУИХ-д тусгалаа олсон байдал²²



Улс орнууд улс төр, нийгэм, эдийн засгийн онцлог байдалд тохируулан сонгуулийн тогтолцоог тодорхойлох нь сонгох, сонгогдох эрхийг хангах, улс төрийн намын төлөвшил, шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлдөг. Иймд сонгуулийн тогтолцоог дур зоргоор өөрчлөхгүй байх хуулийн хязгаарлалтыг хийснээр сонгуулийн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, сонгууль зохион байгуулах үндсэн зарчим, журмыг ойлгомжтой хэвшүүлэх үндсэн нөхцөл болно. Сонгуулийн тогтолцоог тодорхойлох, сонгуулийг зохион байгуулах бүх үе шатанд хүйсийн төлөөллийн тэнцвэр, цөөнхийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад зорилтот бүлгийн хэрэгцээг харгалзаж зохицуулах нь сонгуулийн үндсэн зарчимд нийцнэ.

Мандатын тоонд ногдох тойргийн сонгогчдын тооны хэт зөрүүтэй байдал сонгуулийн тэгш эрхийн зарчмын “нэг сонгогч-нэг санал” ба “сонгогчдын саналын жин тэгш байх” нөхцөлийг хангаагүй байна.

Сонгуулийн тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн нь сонгуулийн тойрог бөгөөд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг МУИХ-ын тогтоолоор²³ хэт томсгон нийт 13 тойргийг (аймагт 7, Нийслэлд 6 сонгуулийн тойргоор) 2-10 мандаттай байгуулсан нь МУИХ-ын нэг гишүүн дунджаар орон нутагт 26,758, Улаанбаатар хотод 45,546 иргэнийг төлөөлөх буюу 18,788 сонгогчийн тооны зөрүү гарч байна. Энэ нь Улаанбаатар хотын тойргийн мандат хуваарилалт орон нутгаас дунджаар 70 хувиар бага бөгөөд зарим тойрогт үүнээс бага байна.²⁴

²¹ Азийн сан, “Монгол Улсын сонгууль (1992-2021) эмхэтгэл”, УБ, 2023 он, 31 дэх тал

²² Мөн тэнд

²³ МУИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 112 дугаар тогтоол

²⁴ ХЭҮК, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль: Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт, мониторингийн тайлан”, УБ, 2024 он

Хүснэгт 1.3 Нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тооны харьцуулалт (орон нутаг болон Улаанбаатар хотоор)

МУИХ-ын сонгууль (Он)	Орон нутгийн мандатын тоо	Орон нутгийн нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо	Улаанбаатар хотын мандатын тоо	Улаанбаатар хотын нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо	Нэг мандатад ногдох сонгогчдын тооны зөрүү
1992	52	13,992	24	15,130	1,138
1996	56	14,674	20	16,921	2,247
2000	56	15,556	20	19,318	3,753
2004	56	15,807	20	23,273	7,466
2008	56	17,210	20	29,609	12,399
2012	34	31,376	14	56,417	25,041
2016	48	24,128	28	29,708	5,580
2020	52	15,779	24	27,561	11,781
2024	54	26,758	24	45,546	18,788

1992-2024 оны тойргийн сонгогчдын тоо аймагт 13,992-31,376 хооронд, Улаанбаатар хотын сонгогчдын тооны дундаж 15,130-56,417 хэлбэлзэлтэй байжээ. Тогтолцооны онцлогоос шалтгаалан холимог тогтолцоогоор явуулсан 2 удаагийн сонгуульд нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо хамгийн өндөр байна.

Шигтгээ 1.2

Сонгуулийн тойрог нь сонгуулийн тогтолцооны гол бүрэлдэхүүн бөгөөд тойргийг хэрхэн байгуулах нь сонгуулийн үр дүнд шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой тул сонгууль бүрээр шинээр байгуулах нь тогтолцоог дахин дахин өөрчилсөнтэй ижил үр дагавартай юм.

(ННФ, “Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024, Чөлөөт шударга сонгуулийн зарчмуудыг хандсан зарим асуудал”)

ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгууль ажиглах хорооны эцсийн тайланд сонгуулийн тойргийг хэрхэн зохион байгуулах нь сонгуулийн үр дүнд шууд нөлөөлдөг тул сонгуулийн тойргийг хуваахдаа тойрог тутамд ногдох сонгогчийн тооны улсын дунджаас 10-15 хувиас илүүгүй байх, Улаанбаатар хотын хүн амд тохируулж мандатыг хуваарилах мөн тойргийг тогтвортой байлгах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг бодитой тооцох нь зүйтэй болохыг дурдсан бөгөөд сонгогчийн тоог сонгуулийн тойрог тогтоохдоо “харгалзах” бус “үндэслэх” шалгуур болгон хуулийн зохицуулалтыг нарийвчлах нь зүйтэй байна.

МУИХСтХ-ийн зарим зүйл, заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй байна.

Цэцэд 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан МУИХСтХ-ийн холбогдох зүйл заалтын талаар иргэдээс 69 удаа, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан АНСДИТХСтХ-ийн холбогдох зохицуулалтын талаар иргэдээс 17 удаа хандаж, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргажээ.²⁵

2025 онд Цэцээс МУИХСтХ-ийн тодорхой заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаар хянан шийдвэрлэсэн хоёр дүгнэлтийг дор тоймлов.

1. Цэц МУИХСтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4²⁶ дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 01 дүгээр дүгнэлтэд

²⁵ ХЭҮК-т Цэцийн Тамгын газраас 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн ТГ-1/165 дугаар албан бичиг. ҮХЦ 2020 онд 02, 03, 09, 11 дүгээр дүгнэлт, 01 дүгээр тогтоол, 2022 онд 01 дүгээр тогтоол, 2024 онд 01 дүгээр дүгнэлт, 2025 онд 01, 03 дугаар дүгнэлтийг тус тус гаргасан байна.

²⁶ МУИХСтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.”, мөн зүйлийн 31.3 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос

“МУИХСтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ...-оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “...Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэж үзээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн. МУИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Цэцийн 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж, хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзлээ.

Шигтгээ 1.3

“...бие даан нэр дэвшүүлэгч тухайн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулахаар хуульчилсан нь иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг хязгаарласан байх тул энэ талаарх үндэслэл, журам нь тодорхой хуульчлагдсан, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх шаардлагатай. Бие даан нэр дэвшүүлэгчийн цуглуулсан гарын үсгийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл, журам нь тодорхойгүйгээс эрх бүхий этгээд үзэмжээрээ хэрэгжүүлэх эрсдэлтэй. Энэ нь иргэн сонгогдох эрхээ эдлэх эсэхийг тодорхой, объектив шалгуураар бус, харин дүр мэдэн шийдвэрлэх эрсдэлийг бий болгосон тул эрх зүйн тодорхой байдалд нийцэхгүй байна”

(Цэцийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн “Нэгтгэн дүгнэхэд” хэсгээс)

2. Цэцийн МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 03 дугаар дүгнэлтэд: “МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ...-оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “...Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна”, мөн “МУИХСтХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө УИХ-ын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...” гэснийг тус тус зөрчсөн байна” гэж үзээд МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна. МУИХ-ын Төрийн бодлогын байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Цэцийн 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж, хүлээн зөвшөөрөхийг дэмжээгүй бөгөөд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтлоо.

баталсан маягтыг тэмдэг дарж баталгаажуулан бие даан нэр дэвшүүлэгчид энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс олгоно”, мөн зүйлийн 31.4 дэх хэсэгт “Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна” гэж заасан.

Шигтгээ 1.4

МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр МУИХ-ын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлынхаа талаар тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрч, харин УИХ-ын гишүүн бус иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй байна. Хуулийн зохицуулалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг хангахгүй байх тул иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан байна.

(Цэцийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн “Нэгтгэн дүгнэхэд” хэсгээс)

Сонгуулийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн зарим зүйл, заалт нь хийдэл, зөрчилтэй байна.

Сонгуулийн харилцааг МУИХСтХ, АНСДИТХСтХ, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, МУЗЗНДНТУтХ, Эрүүгийн, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татварын ерөнхий, Улс төрийн намын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Эдгээр хууль тогтоомжид дүн шинжилгээ хийхэд хууль хоорондын зөрчил, хуулиар зохицуулаагүй хийдлүүд байна. Тухайлбал МУЗЗНДНТУтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад “Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаанд өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байх”-ыг хориглосон бол АНСДИТХтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Сум, дүүргийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын Төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно” гэсэн дээрх хоёр хуулийн заалт зөрчилтэй байна.

МУИХСтХ-ийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт “Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан энэ хуульд өөрөөр заагаагүй бол тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ”, ЗХШХШтХ-ийн 112 дугаар зүйлийн 112.1.3 дахь заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Их Хурлын сонгуулийн маргаан”-ыг 112.2 дахь хэсэгт зааснаар “шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд хугацааг нэг удаа 10 хүртэл хоногоор сунгаж болно” гэж заасан нь зөрчилтэй.

МУИХСтХ-ийн 63 дугаар зүйлийн 63.1.3 дахь заалтад “захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар түүний хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн санал авахаар зохицуулсан бол АНСДИТХСтХ-ийн 62 дугаар зүйлд захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа сонгогчийг саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авах ажиллагааг тусгаагүй хийдэлтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна” гэж тодорхой заасан. Гэтэл МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.15 дахь хэсэгт “сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь брайль үсэгтэйгээр хэвлүүлж болно”, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.27 дахь хэсэгт “сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно” гэж заасан нь заавал биелэгдэх шинжийг агуулаагүй, АНСДИТХСтХ-д сурталчилгаа, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх талаар тухайлан зохицуулаагүй байна.

АНСДИТХСтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Нам, эвсэл тухайн аймаг, сум, нийслэл, дүүрэгтээ сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.” гэж заасан нь МУИХСтХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.” хэмээн хоёр өөрөөр тогтоож байгаа учир сонгуулийн зардлын дансыг нам, эвсэл,

эсвэл нэр дэвшигч тус бүрээр заавал бүртгүүлэх эсвэл зөвхөн нам данстай байх эсэх нь ойлгомжгүй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хороод АНСДИТХСтХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Сонгуулийн хороод энэ хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэн хуралдаанд оролцсон бүрэлдэхүүний олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана”, хэрэв энэ хуулийн үүргээ хэрэгжүүлээгүй, хугацааг баримтлаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт тусгаагүй.

МУИХСтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсэг, АНСДИТХСтХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.5 дахь хэсэгт заасны дагуу сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөхөөр хуульчилсан. “Сонгогч” гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, тухайн засаг захиргааны нэгжид байнга оршин суугчаар бүртгэгдэн оршин сууж байгаа сонгуулийн эрх бүхий иргэнийг; “Байнга оршин суугаа газар” гэдгийг²⁷ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж байна. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягийг “байнга оршин суугаа газар” гэж ойлгох бөгөөд яг тухайн мөчид амьдран суугаа хаяг нь хэдийгээр 180-аас дээш хоног амьдран суусан байсан ч иргэний бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягнаас зөрүүтэй бол тухайн амьдарч буй хаяг дээрээ саналаа өгөх боломжгүй болдог. Мөн зохицуулалтаас харахад 180-аас доош хоногийн хугацаагаар “түр оршин суух” гэсэн ойлголт байх боловч энэ төрлийн хаягийн бүртгэлтэй сонгогчид сонгуульд хэрхэн оролцох талаар иргэний бүртгэлийн болон сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулаагүй.

Жагсаалтаар нэр дэвшигчдийн хувьд МУИХСтХ-ийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх зааснаар “нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна” гэж заасан боловч уг хандивыг сонгогч дэмжигчдээсээ хандив байдлаар бүрдүүлэх боломжтой эсэх асуудлыг хуулиар зохицуулаагүй.


Сонгуулийн зардлын тайланд тусгасан сонгуулийн зардлын өр төлбөр төлөгдөхгүй, хуулийн этгээд, иргэний авлага барагдахгүй байх эрсдэлтэй тул барагдуулах эх үүсвэрийг тодорхой мэдээлж, тайлагнах, нэр дэвшигчдийн сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэх талаар хуулийн зохицуулалтгүй мөн түүнчлэн иргэний сонгох, сонгогдох эрх зөрчигдсөнийг шүүхийн шийдвэрээр тогтоосон тохиолдолд эрхийг хэрхэн сэргээх талаар тодорхой зохицуулалтгүй байна.

АНСДИТХСтХ-д сонгогчийн ирцийн босго хувь заах нь иргэдийн олонхыг төлөөлөх агуулгад нийцнэ.

Орон нутгийн Хурлын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012 оны ээлжит сонгуульд сонгогчийн ирц 50 хувь байх талаар заасан байсан бол 2016 оноос хойших буюу 2016, 2020, 2024 оны сонгуульд сонгогчийн ирцийн босго хувь заагаагүй байна. МУИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц харьцангуй өндөр байдаг бол харин орон нутгийн Хурлын сонгуулийн ирц 15 орчим хувиар бага байна.


²⁷ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг түр оршин суух гэнэ.”, мөн зүйлийн 18.2 дахь хэсэгт “Иргэний 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа газрын хаяг нь энэ хуулийн 19.1-д заасны дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна” гэж тус тус заажээ.

Бүдүүвч 1.2 Орон нутгийн Хурлын сонгуулийн ирц, хувиар




Сонгуулийн насны иргэн бүрийг сонгуульд оролцуулж, санал өгүүлэх нь сонгуулийн чухал асуудал бөгөөд үүнийг хангахгүй байх нь сонгуулийн легитим чанар алдагдуулахад хүргэдэг.

Бүдүүвч 1.3 Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын ирц (аймаг, нийслэлээр, хувиар)



Сонгогчдын ирц аль ч аймагт 80 хувьд хүрээгүй бөгөөд хүн ам хамгийн ихээр төвлөрсөн Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт 50 хувьд хүрээгүй.

Бүдүүвч 1.4 Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын ирц (дүүргээр, хувиар)



Сонгогчдын ирцийг Нийслэлийн 9 дүүргээр үзвэл, алслагдсан Багануур, Налайх, Багахангай дүүрэгт 50 хувьд хүрсэн бөгөөд хүн ам хамгийн ихээр төвлөрсөн бусад дүүрэгт ирц 50 хувьд хүрээгүй байна.

Тохиолдол 1.1

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгогчдын ирц бага байхад дараах хэдэн шалтгаан нөлөөлсөн. Нэгдүгээрт, сонгуулийн санал авах өдөр олон нийтийн худалдаа, үйлчилгээний байгууллагууд хямдрал урамшуулал зарласан. Хоёрдугаарт, МУИХ-ын сонгуулиар санал авах хугацаа 22:00 цаг байсан бол орон нутгийн Хурлын сонгуулиар 20:00 цаг болгосон. Гуравдугаарт, баасан гарагт санал авсан нь иргэд сонгуулиа өгөхөөс илүүтэй хотоос гадагш гарах хандлага ажиглагдсан.

(ХҮН намын Нийслэлийн намын хорооны төлөөлөл, эмэгтэй нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн оролцооны байдлыг дүгнэхэд хүн ам ихээр төвлөрсөн орон нутгийн 2 сонгогч тутмын 1 нь сонгуульд оролцоогүй байна.

Ардчилсан сонгуулийн үндсэн зарчмын дагуу олонхын санал авсан төлөөллөөр иргэдийг төлөөлөх байгууллага бүрдэх нь суурь зарчим билээ. АНСДИТХСтХ-д сонгогчдын 50-иас доошгүй хувь санал өгснөөр сонгуулийг хүчинтэйд тооцдог байх нь сонгуулийн үндсэн агуулга, зарчимд нийцэх тул энэ хуульд ирцийн босго заах, орон нутгийн Хурлын сонгуулиар сонгогчдын ирц, оролцоо буурахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид сонгогчдыг идэвхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Олон улсын сонгууль ажиглах багаас өмнөх сонгуулийн жилүүдэд хийсэн ажиглалтын дүгнэлт, зөвлөмжүүдийн ихэнхийг Монгол Улс хэрэгжүүлсэн бөгөөд зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын Ардчилсан Институт Хүний эрхийн газраас (ЕАБХАБ/АИХЭГ) 2016 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн МУИХ-ын ээлжит сонгуулийн санал хураах үйл ажиллагааг ажигласан Сонгуулийн ажиглах хорооны нэн тэргүүний зөвлөмжид “хуульд чухал өөрчлөлт оруулах бол оролцогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг өрнүүлэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор сонгуулийн санал хураалтын өдөр болохоос хангалттай хугацааны өмнө батлах, сонгуулийн үйл явцын тогтвортой байдлыг хангах, сонгуулийн нэг тойрогт ноогдох сонгогчдын тоог үндэслэлтэй тогтоох, төрийн байгууллага болон улс төрийн зааг, хязгаарыг тогтоох, сурталчилгааны зардлын тайланг Үндэсний аудитын газарт улирал тутам ирүүлдэг байхыг шаардах” зэрэг асуудлыг тусгажээ.

Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ зэрэг бодит шалгуурыг хайхралгүй орхигдуулсны улмаас тойргуудын хүн амын тоо харилцан адилгүй болж, энэ нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагений баримт бичгийн 7.3 дахь зүйлд заасан иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байх зарчим, бусад хэм хэмжээнд нийцэхгүй байна гэж дүгнэж байжээ. Тэгвэл МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг ажигласан дүгнэлтэд “...хуульд сонгуулийн тойргийг тодорхойлох төрөл

бүрийн шалгуурыг тусгасан хэдий ч, сонгуулийн тойргийн хэмжээ жигд бус, улмаар сонгогчдын саналын үнэ цэн тэнцүү байхад сөрөг нөлөөлсөн нь Олон улсын стандарт ЕАБХАБ-ын үүрэг амлалттай зөрчилдсөн” гэж ЕАБХАБ/АИХЭГ 2024 оны Сонгууль ажиглах хорооны эцсийн тайландаа дахин дурджээ.

ЕАБХАБ/АИХЭГ-ын сонгууль ажиглах хорооноос МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг ажиглаад хууль эрх зүй, сонгуулийн тогтолцоотой хамаарах дараах зөвлөмжийг хүргүүлсэн.²⁸ Үүнд:

1. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзэл, бие даасан байдлыг баталгаажуулахын тулд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж улс төрийн намын гишүүнчлэл, намын дотоод зохион байгуулалтад тавьсан шаардлагагүй хязгаарлалтуудыг арилгах ёстой.

2. Хуулийн хохирол барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохын тулд улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд хуулийн хамгаалал хүсэх бололцоог олгох зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтөөр тусгах эсэхийг анхаарч үзэх.

3. Өмнө нь зөвлөмж гаргаж байсанчлан, саналын тэгш байдлыг хангахад олон нийтийн хил хязгаарыг хадгалахад анхаарч, сонгуулийн тойрогт ногдох сонгогчдын дундаж тооноос гажуудуулж болох дээд хязгаарыг үндэслэлтэйгээр тодорхойлж хуульчлах хэрэгтэй.

1.3 СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ

Сонгогчдын боловсролыг үндэсний хэмжээнд, иргэн бүрд тасралтгүй хүргэх нь эрх эдлэгчдийг эрх мэдэлжүүлэх, үүрэг хүлээгчдийг хариуцлагажуулахад үр нөлөөтэй юм.

Дэлхийн улс орнууд сонгогчдын боловсролд ихээхэн анхаарч ажилладаг. Тухайлбал: БНСУ-ын Үндэсний сонгуулийн комисс нь дэргэдээ ардчилал, сонгогчдын боловсрол олгох чиг үүрэг бүхий нэгжтэй.²⁹ Иргэдэд сонгуулийн боловсрол олгох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагуудын хамтаар түншлэн ажилладаг. Канад, Австрали, Финланд, Энэтхэг, Их Британи, Франц, Герман зэрэг орнуудад сонгогчдын боловсролд зориулсан зардлыг сонгуулийн асуудал хариуцсан төрийн байгууллагад төсөвлөхөөс гадна үндэсний хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.³⁰

Монгол Улсад сонгогчдын боловсролд зориулсан үндэсний хөтөлбөр хэрэгждэггүй, сонгуулийн төв байгууллагын бүрэн эрхэд хамааруулан хуульчилсан³¹ нь хангалтгүй. Боловсрол олгох үйл ажиллагаа нь цаг хугацаа, хөрөнгө, хүний нөөц ихээр шаардсан ажил учир үндэсний хэмжээнд төрийн болон төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагаатай өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Сонгогчдод бүх талаар ойлгомжтой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь сонгуулийг зардал багатай, цаг хугацаа хэмнэн явуулахад тустай бөгөөд сонгогчдын боловсрол сайн байх тусам сонгуулийн ирц, оролцоо илүү байдаг.³²

²⁸ ЕАБХАБ/АИХЭГ, МУИХ-ын сонгууль, 2024 оны 6 дугаар сарын 28, Сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан, 28-29 дэх тал

²⁹ Сонгогчдын Боловсрол Төвийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяа, “Сонгогчдын боловсрол: Чиг үүрэг, онцлог” илтгэлээс, “Үндсэн хуульт ардчиллыг хамгаалахад сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг” Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал

³⁰ Мөн тэнд

³¹ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах” гэж заасан.

³² Сонгогчдын Боловсрол Төвийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяа, “Сонгогчдын боловсрол: Чиг үүрэг, онцлог” илтгэлээс, “Үндсэн хуульт ардчиллыг хамгаалахад сонгуулийн төв байгууллагын гүйцэтгэх үүрэг” Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал

Сонгогчдын боловсрол төвөөс 2023 онд нийт 557 иргэнээс асуулга авахад саналаа өгөөгүй сонгогчийн тоог насны бүлгээр авч үзвэл 18-24 насныхан зонхилж байна.

“Сонгогчдын боловсролын талаарх мэдээллийг өмнө нь авч байсан уу?” гэсэн асуултад нийт оролцогчдын 373 буюу 67 хувь нь “тийм”, 184 буюу 33 хувь нь “үгүй” гэж хариулсныг насны бүлгээр харахад 18-34 насны буюу залуу сонгогчдын хувьд энэ мэдээлэл хангалттай байдаггүй болох нь харагдаж байна.

Хүснэгт 1.4 Сонгогчдын боловсролын талаар мэдээлэл авч байгаагүй оролцогчдын насны бүтэц

Насаар		18-24	25-34	35-44	44-54	55-аас
Үгүй	Тоо	66	67	25	12	14
	Хувь	42.6%	34.4	21.9	22.6	25

Сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд улс төрийн намуудыг татан оролцуулах, уг үйл ажиллагааг иргэдэд тасралтгүй хүргэхэд анхаарахаас гадна бүх шатны боловсролын сургалтын байгууллагад хавсарга/интеграцжуулах байдлаар түгээх нь үр нөлөөтэй юм.

1.4 СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГА

Сонгуулийн ерөнхий хороо хуульд заасан бүрэн эрхээ зохих хэмжээнд хэрэгжүүлж хэвшжээ. СЕХ ээлжит сонгуулийн үеэр хэсгийн хороодын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, сонгуулийн бус жилд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай байна.

Монгол Улсын Бага хурлын 1992 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороог байгуулжээ.

СЕХ сонгуулийн үйл ажиллагааг улс орон даяар удирдан зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй хараат бус, бие даасан, хамтын удирдлагын зарчмаар явуулдаг байгууллага юм.

Өнгөрсөн хугацаанд иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сонгуулийн бүх шатны байгууллагад ажиллах хүний нөөцийг сургаж бэлтгэх, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн бүхий л үйл ажиллагаанд техник, технологи нэвтрүүлж автоматжуулахад анхаарч иржээ.

СЕХ сонгуулийн үйл ажиллагааг ил тод, хараат бусаар бие даан зохион байгуулахад хүний болон төсвийн хангалттай нөөцтэй байх шаардлагатай.

Сонгуулийн ерөнхий хороо нь ээлжит сонгуулийн жил эхэлсэн үеэс сонгогчдын боловсролыг дээшлүүлэхээр хууль тогтоомжийг сурталчилж, сонгогчийн гарын авлага, брошур, видео мэдээлэл бэлтгэн гаргадаг бөгөөд сонгуульгүй жилүүдэд сонгогчийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа зогсонги байдалд ордог байна. Энэ нь сонгуульгүй жилүүдэд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах төсөв байдаггүйтэй холбоотой байна.³³

2024 оны ээлжит сонгуулийн жил дээрх дүгнэлт өөрчлөгдсөнгүй.

Шигтгээ 1.5

Сонгогчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааг сонгуулийн болон сонгуулийн бус жилд иргэдэд хүртээмжтэй, тогтмол явуулахаар онцгой анхаарч буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ эрх зүйн орчныг бэхжүүлэх, төсөв санхүүгийн дэмжлэг шаардлагатай байгааг онцолжээ.

(МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай СЕХ-ны даргын илтгэлээс)

³³ ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал, УБ, 2023 он

СЕХ-оос ээлжит сонгуулийн жилийн завсрын үед ч сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээрх үйл ажиллагааг тогтмол, шинэлэг аргаар, сонгогчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдлаар тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

ЕАБХАБ/АИХЭГ-ын дүгнэлтэд Сонгуулийн ерөнхий хороо нь байнгын ажиллагаатай, 9 гишүүнээс бүрдэх байгууллага бөгөөд нэг л эмэгтэй гишүүн байна гэснийг анхааралдаа авч хорооны гишүүдийн жендэрийн харьцааг тэнцвэржүүлэхэд анхаарвал зохистой байна.

Комиссоос улс төрийн намуудтай хийсэн уулзалтын³⁴ үеэр сонгуулийн хороог олон талын төлөөлөл бүхий тэнцвэртэй байгуулах талаар санал илэрхийлж байсан, мөн зарим намаас уг хүсэлтийг бичгээр³⁵ илэрхийлсэн байна.

МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад шат шатны сонгуулийн хороодод давхардсан тоогоор 67,310 төрийн албан хаагч, нэр дэвшигчийн менежер, шадар туслах, ухуулагчаар 288,353 хүн, гадаад, дотоодын 30,000 гаруй ажиглагч, 4,600 гаруй сэтгүүлч, зураглаач, инженер техникийн ажилтнууд ажилласан бөгөөд улсын төсвөөс сонгууль зохион байгуулахад 88.1 тэрбум төгрөг зарцуулжээ.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны талаар сонгуулийн хэсгийн хороодын ажлын тайланг нэгтгэн дүгнэвэл хяналтын тооллого хүртэл ачаалалгүй ажилласан ч тооллогыг 20-56 гаруй цаг завсарлагагүй тоолсон нь хүндрэлтэй байсан талаар дурдаж цаашид хяналтын тооллогыг түүврээр буюу хэсэгчилсэн байдлаар хийх санал хүсэлтийг илэрхийлжээ. Мөн сонгуулийн үеэр ажилласан төрийн албан хаагчдын цалин, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэхээс гадна үйл ажиллагааны зардлыг бодитой тооцох, сургалт мэдээллээр хангах, хууль, журмыг ойлгомжтой, тодорхой танилцуулах хэрэгцээтэй байгаа талаар дурджээ.³⁶

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн өдөр үндсэндээ нам гүм, эмх цэгцтэй, санал хураах үйл явц холбогдох журмын дагуу явагдсан боловч зарим санал авах байрны зохион байгуулалт, хэт ачаалал, санал тоолох төхөөрөмжийн байршил зэрэг нь сонгогч саналаа нууцаар өгөхөд сөрөг нөлөө үзүүлсэн. СЕХ ирцийн мэдээллийг өдрийн туршид үзүүлж, санал өгөх хугацаа дуусмагц, сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь сонгуулийн ил тод байдалд чухал хувь нэмэр оруулсан.³⁷

1.5 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар үнэн зөв, бүрэн мэдээлэлтэй, сонгуулийн бүхий л үйл явцыг иргэд хянах боломжтой байх нь иргэд сонгох, сонгогдох эрхээ саадгүй эдлэх үндэс болдог.

СЕХ хуульд³⁸ заасан бүрэн эрхийн хүрээнд МУИХ, Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой мэдээллийг өөрийн цахим хуудас³⁹, фейсбүүк⁴⁰, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд хүргэсэн нь сонгогчдод сонгуульд өрсөлдөж буй нам эвсэл, нэр дэвшигч, тэдний бодлого, мөрийн хөтөлбөр болон саналаа хэрхэн хаана өгөх, саналын нууцлал хэрхэн хангагдаж байгаа, сонгогчдын ирцийн мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. СЕХ сонгуулийн үйл ажиллагааг, ҮАГ сонгуулийн зардлын тайланг, УБЕГ сонгогчдын нэрийн жагсаалтыг, Харилцаа холбооны

³⁴ ХЭҮК 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 22 намын 31 төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулсан.

³⁵ ХЭҮК-т Ард түмний олонхийн засаглал намаас ирүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 88 дугаар албан бичиг

³⁶ СЕХ-оос 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 3-/101 дүгээр албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

³⁷ ЕАБХАБ/АИХЭГ, МУИХ-ын сонгууль, 2024 оны 6 дугаар сарын 28,

³⁸ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь хэсэгт "... сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах" гэж заасан.

³⁹ <https://m-election.mn/>

⁴⁰ <https://www.facebook.com/gecmongolia>

зохицуулах хороо интернэт, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээллийг тухай бүр нь шинэчлэн цахим хуудсаар дамжуулан мэдээлж байлаа.

Шигтгээ 1.6

Санал хураалтын турш сонгогчдын ирцийн мэдээллийг хүйс болон насны ангиллаар нарийвчилж шууд дамжуулан олон нийтэд мэдээлж байсан нь энэ удаагийн ээлжит сонгуулийн зохион байгуулалтад гарсан чухал дэвшил байлаа. Санал өгөх хугацаа дуусмагц, сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн нь сонгуулийн ил тод байдалд чухал хувь нэмэр оруулжээ.

(ННФ, Ерөнхий тойм "Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024 оны Чөлөөт сонгуулийн зарчмуудыг хөндсөн зарим асуудал")

МУИХ-ын болон орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар ХХЗХ-оос олон нийтийг мэдээллээр хангахаар өөрийн цахим хуудсанд www.crc.gov.mn "Монгол Улсын Их Хурлын ээлжит Сонгууль-2024", "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Сонгууль-2024" хуудас нээн, сонгуулийн сурталчилгааны цахим орчны хяналт, мониторинг тавих үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, зөвлөмж, мэдээлэл, цахим орчны бүртгэл, тайлан мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж нийтэд мэдээлж ажилласан байна.

Хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил, тод нээлттэй байлгах үүргийг бүх төрийн байгууллага хүлээж үйл ажиллагаандаа хэвшүүлэх шаардлагатай байна.

Сонгуульд иргэний нийгэм хяналт тавих боломжтой байх нь шударга сонгуулийн үндсэн баталгаа болдог. МУИХ-ын болон орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар ТББ-ууд⁴¹ сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдалд мониторинг хийхэд зарим төрийн байгууллагаас хуулийн хүрээнд нээлттэй мэдээллийг⁴² өгөхөөс татгалзсан тохиолдол гарсан байна.

Тохиолдол 1.2

"Бодлогод залуусын хяналт" НҮТББ-аас "Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт тавих байгууллагын хувьд хуулиар олгогдсон эрхийн дагуу Цагдаагийн ерөнхий газарт ирсэн өргөдөл, гомдлын тоон мэдээллийг гаргуулахаар хандахад тус газраас хуулийг буруу тайлбарлан, нийтэд нээлттэй байлгах мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан", мөн "Монополын эсрэг газраас сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас тус байгууллагад хүргүүлсэн Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны тайланг хүссэн боловч удаа дараа татгалзсан" гэх гомдлыг Комисст гаргасан.

Комиссоос төрийн бус байгууллагын мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үйл явцтай холбогдуулан зарим төрлийн зөрчил, гэмт хэргийн тоо, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг ЦЕГ-аас, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудаас сурталчилгаа явуулсан тайланг МЭГ-аас "Бодлогод залуусын хяналт" НҮТББ-д даруй гаргаж өгөх шаардлагыг хүргүүлсэн.

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлагаас⁴³)

⁴¹ Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний гишүүн байгууллагууд дараах хэд хэдэн чиглэлээр мониторингийн ажлыг хийсэн байна. Үүнд: "Глоб Интернэшнл" ТББ хэвлэл мэдээлэлд, "МИДАС" ТББ сонгуулийн автоматжуулсан системд болон сонгогчдын нэрийн жагсаалтад, "Бодлогод залуусын хяналт" ТББ

⁴² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана" гэж заасан. НҮБ-ын Хүний эрхийн Хорооны 34 дүгээр ерөнхий зөвлөмжид "Мэдээлэл авах эрхийг хангахын тулд Оролцогч улс нийтийн ашиг сонирхолд хамаарах өөрт байгаа мэдээллийг өөрийн санаачлагаар ил болгож, олон нийт хялбар, шуурхай, үр дүнтэй бодитой танилцах боломжийг бүрдүүлнэ..." гэжээ.

⁴³ ХЭҮК-ын гишүүний 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 04/04 дугаар, ХЭҮК-ын гишүүний 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 04/05 дугаар шаардлага

1.6 БҮХ НИЙТИЙН БАЙХ ЗАРЧИМ


Сонгуулийн бүх нийтийн байх зарчим нь иргэд тэгш эрхтэй, нийтээрээ сонгуульд оролцох боломжтой байхыг ойлгоно. Сонгуульд болон ард нийтийн санал асуулгад саналаа өгөх эрхийг хуулиар тогтоосон байх ёстой бөгөөд түүнд зөвхөн үндэслэлтэй хязгаарлалт тогтоож болно. Тухайлбал: сонгуульд оролцох насны доод хэмжээг тогтоох, сонгох эрхийг хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэггүй гэсэн шалтгаанаар эсхүл боловсролын болон эд хөрөнгийн шалгуураар хязгаарлах нь үндэслэлгүй юм. Намын гишүүнчлэл нь сонгуульд оролцуулах эсхүл оролцуулахаас түдгэлзүүлэх нөхцөл болох ёсгүй⁴⁴. Монгол Улсын хууль тогтоомжоор 18 насанд хүрээгүй, хорих ял эдэлж байгаа иргэн, эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол сонгуульд оролцохгүй. Дээрхээс бусад аливаа шинж, шалгуураар сонгуулийн эрхийг хязгаарлаагүй.

Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэд нийтээр оролцох, бүх нийтийн байх зарчим бүрэн хангагдахгүй байна. Тухайлбал: хөгжлийн бэрхшээлтэй, гадаад улсад амьдарч буй иргэд, оюутан, суурин газраас алслагдмал нутаг дэвсгэрт амьдарч буй иргэд, малчид, уртын ээлжээр ажиллаж буй ажилтнууд, санал авах өдөр сонгуулийн хэсгийн хороонд ажиллаж буй төрийн албан хаагчид, эрүүл мэндийн шалтгааны улмаас өөр газар эмчлүүлж байгаа иргэд сонгох эрхээ бүрэн эдэлж чадахгүй байна.

МУИХ, орон нутгийн Хурлын сонгуулийн сонгогчийн ирц улам бүр буурсаар байна.


МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт 2,089,939 сонгогчийн 1,450,037 нь буюу 69.4 хувь саналаа өгсөн нь ардчилсан сонгуулийн түүхэнд сонгогчдын ирц 70 хувьд хүрээгүй хоёр дахь удаагийн сонгууль боллоо.

Бүдүүвч 1.5 МУИХ-ын ээлжит сонгуулийн ирц (хувиар)



Орон нутгийн Хурлын 2024 оны сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт 2,107,290 сонгогчийн 1,119,881 нь буюу 53.1 хувь нь саналаа өгчээ. Сонгогчдын ирц 21 аймагт 80 хувьд хүрээгүй бөгөөд хүн ам хамгийн ихээр төвлөрсөн Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймагт 50 хувьд хүрээгүй байна.

График 1.6 орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн ирц (хувиар)



Гадаад улсад байгаа иргэдийн сонгох эрх

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд гадаад улсад байгаа Монгол Улсын иргэд саналаа өгөх эрх зүйн орчин бүрдсэн нь сонгууль бүх нийтийн байх зарчмыг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшил боловч гадаад улсад байгаа бүх иргэд саналаа өгч чадахгүй байна.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ээс 216 улс орнуудыг хамруулан хийсэн судалгаагаар 150 улс буюу 69.4 хувь нь гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авдаг бол 66 улс буюу 29.6 авдаггүй байна. Эдгээр улс орнуудын 109

⁴⁴ НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №25, 1996 он

нь буюу 50.5 хувь нь санал авах байранд, 53 буюу 24.5 хувь нь шуудангаар, 15 буюу 7 хувь нь цахимаар, 19 буюу 8.8 хувь нь итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж санал авдаг.⁴⁵

Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэд МУИХ-ын 2012 оны ээлжит сонгуулиар анх удаа сонгуульд оролцож⁴⁶ байсан бол 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр МУИХ-ын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох зохицуулалттай холбогдуулан Дипломат төлөөлөгчийн газар байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож санал өгөх эрхтэй байхаар МУИХСтХ-д тусгаж, гадаад улсад байгаа сонгогч санал өгөхтэй холбогдох журам, хугацааг хуульд тусган баталсан. Ингэснээр хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдох МУИХ-ын 48 гишүүнийг сонгоход гадаад улсад байгаа санал өгөх эрх бүхий иргэдийн санал өгөх боломж бүрдсэн.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар 33 улс дахь Дипломат төлөөлөгчийн 47 газраар дамжуулан гадаад улсад ажиллаж, амьдарч, суралцаж байгаа 13,095 сонгогч санал өгөхөөр бүртгүүлснээс 74,6 хувь нь Дипломат төлөөлөгчийн газарт очиж саналаа өгөв.

Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэд МУИХ-ын 2012 болон 2024 оны ээлжит сонгуульд оролцсон байдлыг харьцуулан үзвэл:

Хүснэгт 1.5 Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон байдал

УИХ-ын ээлжит сонгууль	Салбар комиссын тоо	Гадаадад оршин суугаа иргэдийн тоо ⁴⁷	Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн иргэдийн тоо	Саналаа өгсөн иргэдийн тоо	Санал авсан өдөр	Сонгогчдын ирц (хувиар)
2012	39	107,140	4,276	2,779	2012.06.10	64.99
2024	47	122,301	13,095	9,760	2024.06.20, 21, 22, 23	74.53 ⁴⁸

2024 оны МУИХ-ын сонгуульд саналаа өгөхөөр бүртгүүлсэн, саналаа өгсөн иргэдийн тоог 2012 оны сонгуулийн үеийнхтэй харьцуулахад гадаадад байгаа сонгогчдын сонгууль өгөх эрмэлзэл өссөн байна. Энэ нь гадаадад санал авах үйл явцын журмыг сонгогчдод хүртээмжтэй болгох тал дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн буюу санал авах байрны тоо нэмэгдүүлсэн⁴⁹, сонгуульд оролцох иргэдийн бүртгэлийг цахимаар хийсэн⁵⁰, санал авах хугацаа зөвхөн нэг өдөр байсныг 4 өдөр болгон нэмсэн, түүнчлэн тухайн улсад байгаа төрийн бус байгууллага, сэтгүүлчидтэй хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг түгээсэн⁵¹ нь нөлөөлжээ.

⁴⁵ <https://www.idea.int/data-tools/data/voting-abroad>

⁴⁶ СЕХ, “Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн дүн, УИХ-ын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 оны ээлжит сонгууль, 1997-2001 онуудад явагдсан нөхөн сонгуулийн дүнг аймаг, дүүрэг, сум, тойрог, хэсэг, нэр дэвшигч, нам, эвсэл бүрээр нэгтгэн гаргав”, Улаанбаатар, 2022 он, https://gec.gov.mn/uploads/ih_huraliin_songuuli-2022.03.22.pdf, 237, 238 дугаар талд, СЕХ-ны даргын 2012 оны сонгуулийн үр дүнгийн талаар УИХ-д хийсэн танилцуулгад “... Монгол Улс түүхэндээ анх удаа гадаад оронд байгаа сонгогчдынхоо саналыг авлаа. Уг ажлыг зохион байгуулах комиссыг СЕХ, Гадаад харилцааны яам хамтран зохион байгуулсан бөгөөд гадаад оронд байгаа Дипломат төлөөлөгчийн газарт сонгуулийн 39 салбар комисст 188 хүн ажиллаж, гадаад улсад амьдарч буй саналаа өгөхөөр бүртгүүлсэн 4,276 иргэнээс 2,779 хүн иргэн сонгуульд оролцож саналаа өглөө...” гэжээ.

⁴⁷ “Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын шилжих хөдөлгөөн, суурьшил” сэдэвчилсэн судалгаа, УБ, 2021 он, https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Migration_2020.pdf&ln=Mn, 56 дугаар талд “... Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Монгол Улсын харьяат 3,296,866 хүн тоологдсоны 3,174,565 нь Монгол Улсын нутаг дэвсгэрт, 122,301 нь гадаадад тоологдов. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын харьяат хүн амын 3.7 хувь нь гадаадад оршин сууж байна. Гадаадад суугаа хүн амын тоо хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоос 14.2 хувиар өсжээ...” гэжээ.

⁴⁸ Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв комиссын мэдээлэл, 2024.06.24, “Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагаа дууслаа”, <https://m-election.mn/news/6721>

⁴⁹ 2012 оны МУИХ-ын сонгуульд 39 дипломат төлөөлөгчийн газар санал авч байсан бол 2024 оны сонгуульд 47 газарт авсан.

⁵⁰ 2012 оны МУИХ-ын сонгуульд саналаа өгөх сонгогч биечлэн бүртгүүлдэг байсныг 2024 оны сонгуульд өөрчлөн цахимаар бүртгэсэн.

⁵¹ СЕХ, Монгол Улсын Их Хурлын Сонгууль-2024, УБ, 2024 он, 36 дахь тал

МУИХСтХ-иар гадаадад байгаа сонгогчид зөвхөн нам, эвслийн жагсаалтад саналаа өгөх бөгөөд тойрогт нэр дэвшигчдэд санал өгөх эрхгүй байна. Мөн Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа иргэд зөвхөн тухайн газарт буюу салбар комиссын тогтоосон санал авах байранд биечлэн очиж саналаа өгөхөөр зохицуулсан нь тухайн дипломат төлөөлөгчийн газар байрладаг хотоос өөр хот, тосгонд амьдарч байгаа иргэдэд эдийн засгийн болоод цаг хугацааны хувьд хүндрэл учруулж байна.

Шигтгээ 1.7

Сонгогчид нэр дэвшигчийг сонгоно гэсэн ойлголттой ирсэн цөөнгүй тохиолдол байсан ба зөвхөн нам сонгох боломжтой байгааг маш их гайхан хүлээж авсан. Гадаадад байгаа сонгогчид зөвхөн нам сонгох тухай мэдээллийг аваагүй байсан. Онлайнаар бүртгүүлсэн боловч иргэний үнэмлэхний зургаа дутуу оруулснаас болоод бүртгэл нь баталгаажаагүй гэдгийг мэдээгүй саналаа өгөхөөр ирсэн нэг иргэн байсан. Урьдчилж бүртгүүлээгүй ч саналаа өгөх боломжтой эсэхийг асуусан залуус хэд хэд ирсэн. Үүнээс гадна урьдчилж бүртгүүлж байж санал өгөх ёстой гэдгийг мэдээгүй иргэд олон байсан.

(“Бодлогод залуусын хяналт” ТББ-аас хийсэн ажиглалтын дүнгээс)

Монгол Улстай ижил төстэй, сонгуулийн холимог тогтолцоо хэрэглэж байгаа бусад улс орны туршлагыг харахад гадаадад оршин суугаа сонгогчид сонгуулийн холимог тогтолцооны 2 бүрэлдэхүүний аль алинд нь санал өгөх боломжоор хангаж, сонгуульд оролцуулах нь улам бүр нийтлэг болж байна.⁵² Энэ тохиолдолд сонгогчийг аль нэг мажоритар тойрогт хуваарилах шаардлага үүсэх бөгөөд Итали Улс хувь тэнцүүлэх тогтолцооны зарчмын дагуу намын жагсаалтаар санал хураах сонгуулийн 4 тойргийг гадаадад байгуулдаг, Герман, Япон⁵³, Шинэ Зеланд зэрэг улсад тухайн сонгогчийг эх орондоо байх үеийн хамгийн сүүлд бүртгэгдсэн тойргийнх нь саналын хуудсаар санал өгүүлэх, эсвэл тухайн улсын парламентын ордон байрладаг тойрогт санал өгүүлдэг Латви Улсын жишээ байна.

Иймд Дипломат төлөөлөгчийн газар байрладаг хотод биечлэн ирж саналаа өгөх бус техник технологийн дэвшлийг ашиглаж гадаад улсад байгаа иргэдийн сонгох эрхийг бүрэн хангахад чиглэсэн цахим, шуудан, харилцаа холбооны сүлжээг ашиглах зэргээр хувилбарт саналаа өгөх боломжийг олгох, тойрогт нэр дэвшигчид санал өгөх нээлттэй зохицуулалтыг судалж, зохицуулах хэрэгцээтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрх

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрхийг хангахад анхаарч холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, санал авах байрны орчны хүртээмжийг сайжруулах, холбогдох стандарт, дүрэм, журмыг батлах, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, нам, нэр дэвшигчдээс мэдээллийн хүртээмжийн төрөл, хэлбэрийг өргөжүүлэх зэргээр өмнөх сонгуультай харьцуулахад ахиц дэвшилтэй алхмууд хэрэгжүүлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн саадгүй хүртээмжтэй байранд санал өгөх, чөлөөтэй, нууцаар санал өгөх эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нийцүүлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх”-аар заасан. МУИХСтХ, АНСДИТХСтХ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд, ялгаварлалгүйгээр сонгох эрхийн үндсэн дээр нууцаар, хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, сонгуульд санал өгөх боломжоор хангахад чиглэсэн санал авах байр тэргэнцэртэй сонгогч орох боломжтой байх, харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байранд байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлдэх зэрэг

⁵² Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Сонгуулийн холимог тогтолцоо: Онол, практик, ННФ, 2024 он, 9 дэх тал

⁵³ Тус улсад гадаадад байгаа сонгогчид зөвхөн намын жагсаалтаар санал хураахад оролцож байсан бөгөөд мажоритар суудлын төлөө өрсөлдөж буй нэр дэвшигчид санал өгөх саналын хуудсыг өгөхгүй байгааг Дээд шүүх нь хууль бус гэж 2005 онд шийдвэрлэсэн байна.

санал авах байрны стандарт, саналын хуудасны хүртээмжтэй байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгажээ.

Сонгуулийн санал авах байрны зохион байгуулалт, үйл ажиллагаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх талаарх хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэх үүднээс СЕХ холбогдох журмуудыг батлан гаргажээ.⁵⁴

Нэг талаар хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгуулийн эрх, оролцоотой холбоотой сонгуулийн хууль тогтоомжийн эдгээр зохицуулалтаас харахад “сонгох эрх”-ийг агуулга бүхий тодорхой төрлийн бэрхшээлд зориулсан зохицуулалтуудаар хязгаарласан⁵⁵, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нийцүүлэн нарийвчлан зохицуулаагүй байна. Нөгөө талаар батлагдсан хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангалтгүй байна.

ХЭҮК-оос 2024 оны 06 дугаар 27-ны өдөр 19 аймгийн 56, Нийслэлийн 9 дүүргийн 21, нийт 77 хэсгийн хорооны санал авах байрны зохион байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэх, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааны явцад мониторинг хийхэд хэсгийн хорооны ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах арга зүй эзэмшээгүй, санал авах байр 2, 3 болон В1 давхарт байрласан, санал авах байрны хэмжээнээс хамаарч ширээ хоорондын зай хэт ойр, орц, гарц саадтай, хүртээмжгүй, мэдээллийн самбарыг ойлгомжтой, хүртээмжтэй байршуулаагүй, бүхээгт тэмдэглэгээ байхгүй, түүнд түгээмэл хэрэглэх үг яриаг ойлгомжтой байдлаар зургаар дүрслээгүй, гэрэлтүүлэг муу байх зөрчил нийтлэг гарсан. Дээрх зөрчлийг “Бодлогод залуусын хяналт” ТББ-аас хийсэн ажиглалтын дүн давхар баталгаажуулж байна. Ажиглалт хийсэн нийт 112 хэсгээс 48 хэсэг тэргэнцэртэй сонгогч санал авах байр руу орох боломж хангагдаагүй, 29 хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан нэгээс доошгүй санал авах бүхээг бэлтгээгүй, 16 хэсэгт харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, санал тэмдэглэх зориулалтын брайль үсэг бүхий хавтас байгаагүй гэжээ.⁵⁶

Санал авах байрны хүртээмжийг сайжруулах, стандартын шаардлага хангасан байршилд санал авах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрх, нийгмийн оролцооны эрхийг хангахад эерэг нөлөөлнө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлээс нь хамааран ялгаатай хүндрэл учирдаг. 2024 оны ээлжит сонгуулийн үеэр хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх бүрэн хангагдсангүй.

Хөдөлгөөний бэрхшээлтэй болон харааны бэрхшээлтэй сонгогчид санал авах байранд очих, ирэх болон саналаа өгөх, сонсголын бэрхшээлтэй иргэн сонгогчид сонгуулийн сурталчилгааны талаар мэдээлэл авахад илүүтэй бэрхшээл тохиолдсон талаар 2024 оны МУИХ-ын сонгуулийг ажигласан Олон улсын сонгууль ажиглах хорооны урьдчилсан дүгнэлтэд тэмдэглэсэн байв⁵⁷.

“Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-аас хөгжлийн бэрхшээлтэй 202 иргэдийн дунд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр тулгарсан асуудлын талаар судалгаа хийхэд нийт судалгаанд оролцогчдын 30.5 хувь нь нэр дэвшигчийн талаар мэдээлэл авсан гэсэн бол 69.5 хувь нь хангалттай мэдээлэл авч чадаагүй гэж хариулжээ.⁵⁸

⁵⁴ Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 23 дугаар тогтоолоор “Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага”, “Санал авах байр бэлтгэх заавар”-ыг тус тус шинэчлэн баталж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага, MNS 6055:2009” стандарт, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар, MNS 6056:2009” стандартыг тус тус мөрдлөг болгохыг журамд тусгажээ.

⁵⁵ Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн судалгаа”, УБ, 2023 он, 31 дэх тал

⁵⁶ <https://forum.mn/post/157235>

⁵⁷ Мөн тэнд

⁵⁸ “Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгааны тайлан (МУИХ-ын 2024 оны ээлжит сонгууль), УБ, 2024 он, 58 дахь тал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Бүх шатны сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.” гэж тодорхой заасан. Гэтэл МУИХСтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.15 дахь хэсэгт сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь брайль үсэгтэйгээр хэвлүүлж болно, 46 дугаар зүйлийн 46.27 дахь хэсэгт сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно гэх заавал үүрэгжүүлсэн бус, сонгох боломжийн хүрээнд шийдэхээр зохицуулалт тусгажээ. Харин АНСДИТХСтХ-д мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх талаар тухайлан зохицуулаагүй.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 11 нам, эвслээс 4 нам, эвслийн бэлтгэсэн сурталчилгааны нэвтрүүлгийн 20 хүрэхгүй хувь нь дохионы хэлмэрч, бичгэн тайлбартай байсан бол бусад нь дохионы хэлмэрч, бичгийн тайлбаргүй байсан нь хангалтгүй үзүүлэлт юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн талаарх мэдээлэл авах эрхийг хангахын тулд улс төрийн нам, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны материалыг зөвхөн брайль үсгээр хэвлэхээс гадна аудио, видео, зурган зэрэг олон арга хэрэгслийг ашиглах боломжтой.

СЕХ сонгуулийн зохион байгуулалтын талаар мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байлгах зорилгоор дохионы хэлмэрчийг ажиллуулдаг болсон нь сайшаалтай.

Тохиолдол 1.3

Сонгуулийн сурталчилгааны ажилчид гэрийн үүдэнд сурталчилгааны материал үлдээгээд явдаг...сонгуулийн сурталчилгааны үеэр мэдээлэл маш дутуу өгдөг гэж боддог. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сонгуулиа хэрхэн өгөх...мэдээлэл өгдөггүй.

(Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ахмад настануудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс, 2024.08.14)

Иймд нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаа, СЕХ-оос сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл бэлтгэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаатай хэрэгцээ шаардлагыг үнэлж, тохирсон арга хэлбэрээр мэдээлэл авах эрхийг хангах шаардлагатай байна.

Шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдоогүй сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй зарим иргэдийн сонгох эрх хангагдсангүй.

Сэтгэцийн өвчний улмаас шүүх тухайн этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүйд тооцдог.⁵⁹ МУИХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, АНСДИТХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт эрх зүйн чадамжгүй⁶⁰ нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрхгүй гэж заасан.

Монгол Улсад 2023 оны байдлаар 21,396 сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн байна.⁶¹ Иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээр 1992-2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 946 сонгуулийн насны иргэн байна.⁶²

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 12 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрнө гэж заасан. Сэтгэцийн хөгжлийн

⁵⁹ Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно.” гэж заасан.

⁶⁰ Иргэний эрх зүйн чадамжгүй гэдгийг Монгол Улсын Иргэний хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг шүүх иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцож, түүнд асран хамгаалалт тогтооно” гэж тодорхойлжээ

⁶¹ ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212.mn

⁶² Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 05/696 албан бичиг

бэрхшээлтэй иргэдийг иргэний эрх зүйн чадамжгүй гэх ангилалд хамруулсныг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооноос шүүмжлэлтэй хандсан байна.⁶³

Тохиолдол 1.4


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон янз байдаг. Тэдний зарим нь бие даан сонгох чадамжтай байдаг. Хэл яриа хэвийн, хүнтэй бүрэн харилцдаг байхад сонгох эрхийг нь эдлүүлдэггүй. Тэр хүн сонгуулиа өгөх чадалтай байвал өгүүлэх хэрэгтэй.

(Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ахмад настнуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

“Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ-аас хөгжлийн бэрхшээлтэй 202 иргэдийн дунд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр хийсэн судалгааны үр дүнгээс харахад сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох эрхээ эдлэхэд дараах асуудал тулгарсан байна.

Бүдүүвч 1.7 Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй иргэдэд тулгарсан асуудал (хувиар)

Оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй сонгогчид



Дээрх судалгааны үр дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 25 хувь нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй учир сонгуулиа өгч чадаагүй байна.

Иймд шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдоогүй сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний сонгох эрхийг хязгаарлахгүй байх, туслах үйлчилгээ, саналын хуудас, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэсгийн хорооны ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээтэй.

Байнга оршин суугаа хаягаас өөр байршилд амьдарч байгаа иргэдийн сонгох эрх

ХЭҮК-оос “шилжин суурьшигчид болон оюутнуудын хувьд сонгуульд оролцож, саналаа өгөх боломжгүй байгаа нь нэгэнт хэвшсэн зүйл болжээ”⁶⁴ гэж Монгол Улс

⁶³ “Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгааны тайлан, /УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль/, Улаанбаатар хот, 2024 он, 23 дугаар талд “... НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны 16 дугаар ерөнхий санал дүгнэлтийн 48 дугаар зүйлд “хүний шийдвэр гаргах чадвараас хамааран хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн эрх, түүний дотор сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхээс хасах үндэслэл болохгүй.” гэжээ. Үүний дагуу Хорооны зүгээс сэтгэцийн болон оюуны хомсдолтой гэсэн үндэслэлээр эрх зүйн чадамжийг хасахыг зөвшөөрдөггүй гэдгийг тодорхой онцолж байна. Шүүхийн ерөнхий болон ганцаарчилсан шийдвэр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрхийг үгүйсгэх үндэслэл болохгүй ...” гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын 2006 оны конвенцын Хорооны захидал харилцааны 4/2011 тоот хэсгийн 9.4-т 29 дүгээр зүйлд ямар нэгэн хязгаарлалтыг тавиагүйгээс гадна ямар ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүлэгт эрхийг нь хасахыг зөвшөөрөхгүй. Тиймээс сэтгэцийн болон оюуны бэрхшээлтэй гэж үзсэн, эсхүл бодит байдалд нь тулгуурлан санал өгөх эрхийг нь хасах, үүнд хувь хүний үнэлэмжийн дагуу хязгаарлалт хийх нь Конвенцын 2 дугаар зүйлд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгаварлан гадуурхах явдал юм ...” гэжээ.

⁶⁴ ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай ээлжит 4 дэх илтгэл, УБ, 2005 он, 15 дахь тал

дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2005 оны илтгэлд дүгнэсэн нөхцөл байдал 20 жилийн дараа ч төдийлөн өөрчлөгдөөгүй хэвээр байна.


МУИХСтХ, АНСДИТХСтХ-д заасны дагуу сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөхөөр хуульчилсан. “Байнга оршин суугаа газар” гэдгийг⁶⁵ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж байна. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягийг “байнга оршин суугаа газар” гэж ойлгох бөгөөд яг тухайн мөчид амьдран суугаа хаяг нь хэдийгээр 180-аас дээш хоног амьдран суусан байсан ч иргэний бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягаас зөрүүтэй бол тухайн амьдарч буй хаяг дээрээ саналаа өгөх боломжгүй болдог. Мөн зохицуулалтаас харахад 180-аас доош хоногийн хугацаагаар “түр оршин суух” гэсэн ойлголт байх боловч энэ төрлийн хаягийн бүртгэлтэй сонгогчид сонгуульд хэрхэн оролцох талаар иргэний бүртгэлийн болон сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулаагүй.

Байнга оршин суугаа газартаа санал өгч сонгох эрхээ эдэлж чадахгүй байгаа иргэдийг бүлгээр авч үзвэл оюутан, суралцагчид, өөрсдийн өмчлөлийн орон байргүй түрээсийн байранд амьдардаг иргэд, уртын ээлжээр ажилладаг уул уурхай, зам тээвэр, барилга дэд бүтцийн салбарын ажилтнууд, өөрийн харьяанаас өөр хэсгийн хороодод ажиллаж буй төрийн албан хаагчид, эрүүл мэндийн шалтгааны улмаас өөр газар эмчлүүлж байгаа иргэд байна.

Монгол Улсад 2023 оны байдлаар их, дээд сургууль болон коллежид 145,345⁶⁶ суралцагч суралцаж байгаа бөгөөд нийт сонгогчдын 6.8 хувь болно. Үүнээс нарийвчилсан байдлаар орон нутагт байнга оршин суугаа газрын бүртгэлтэй оюутан, суралцагчдын тоон мэдээлэл байхгүй байна.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн ирцээс ажиглахад сонгуулийн 18-19 насны иргэдийн 62 хувь нь, 20-24 насны иргэдийн 50.5 хувь нь сонгуульд саналаа өгчээ. Энэ насны сонгогчид бусад насны сонгогчидтой харьцуулбал хамгийн бага хувиар санал өгчээ. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ирцийг харахад сонгуулийн 18-19 насны иргэдийн 36 хувь нь, 20-24 насны иргэдийн 31 хувь нь сонгуульд саналаа өгчээ.

Бүдүүвч 1.8 МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн ирц, насны бүлэг (хувиар)



Сонгуулийн 18-24 насны иргэдийн (оюутан, суралцагч) ирц бага байгаа нь байнга оршин суух газраа саналаа өгөх хуулийн зохицуулалт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх магадлалтай.

Тохиолдол 1.5

Байнгын оршин суух хаяг дээрээ сонгуульд оролцох шаардлага болон иргэний бүртгэлтэй холбоотой процесс нь залуучуудад сонгуульд оролцож чадахгүй байх нэг том шалтгаан болдог.

⁶⁵ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Иргэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй хаягаас өөр хаягт шилжин 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг байнга, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухаар бүртгүүлэхийг түр оршин суух гэнэ.”, мөн зүйлийн 18.2 дахь хэсэгт “Иргэний 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа газрын хаяг нь энэ хуулийн 19.1-д заасны дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна” гэж тус тус заажээ.

⁶⁶ ҮСХ, статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn>

2021 онд 1400 оролцогчоос авсан сонгогчдын судалгаагаар сонгогчдын саналаа өгдөггүй гол шалтгаануудын нэг нь хаягийн бүртгэлтэй холбоотой зөрчил гэж гарч ирсэн. Энэхүү судалгаанд дурдсанаар Улсын Их Хурлын сонгуульд саналаа өгөөгүй нийт сонгогчдын 18 хувь нь иргэний үнэмлэх дээрх хаягаасаа өөр газар оршин сууж байсан тул саналаа өгч чадаагүй гэж хариулсан байна. Хаягийн бүртгэлтэй холбоотой энэхүү асуудал нь залуу сонгогчид, ялангуяа өөрийн байнга оршин суугаа хаягаасаа өөр газар суралцаж байгаа их, дээд сургуулийн оюутнуудад шууд нөлөөлдөг байна.

(Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, “Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд” судалгааны тайлангаас)

Уртын ээлжээр ажилладаг уул уурхай, зам тээвэр, барилга дэд бүтцийн салбарын ажил олгогч нь ажилтнууддаа санал өгөх боломжоор хангах үүргийг хуулиар хүлээсэн тул чөлөө олгодог. Гэвч тухайн салбарт уртын ээлжээр ажиллаж буй сонгогчдын хувьд санал өгөх байрнаас хэр алслагдсан газар ажиллаж байгаагаас хамаардаг.

Сонгуулийн санал авах өдөр сонгогч биечлэн ирж сонгуульд санал өгөх хуулийн зохицуулалт Монгол Улсын хүн амын суурьшил, монголчуудын амьдралын хэв маягаас шалтгаалан төвлөрсөн суурин газраас алс хол оршин суудаг болон өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийж байгаа иргэд, оюутан суралцагчид, улирлын чанартай ажил хийдэг ажилтнууд, өөр байршилд ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтнуудын сонгуульд саналаа өгөх боломж тодорхой хэмжээнд хязгаарлагдаж ирсэн. Эдгээр иргэдийн сонгох эрхийг хангах уян хатан хувилбар бүхий эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

МУИХСтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна.” гэж заасан хугацаа нь ээлжийн амралт, бүтээн байгуулалт, дэд бүтэц, уул уурхай, газар тариалан зэрэг улирлын шинж чанартай ажилтай давхацдагтай холбоотой ажлын байрыг дагасан шилжилт хөдөлгөөн хамгийн өндөр оргил үе таардаг.

АНСДИТХСтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 10 дугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна” гэж заасан хугацаа нь хичээлийн шинэ жилтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, хадлан, тариалан, ногоо хураалт, отор нүүдэл, өвөлжилтийн бэлтгэл ажил хангахтай давхацдаг. Ардчилал судлалын төвөөс хийсэн судалгаанд “...орон нутгийн Хурлын сонгуульд оролцоогүй шалтгааныг судалгаанд оролцогчдын 30 хувь нь шилжилт хөдөлгөөн буюу өөр газар байсан, шилжилт хөдөлгөөнөө урьдчилан хийлгэж чадаагүй, орон нутаг руу очиж саналаа өгөхөд цаг хугацаа, зардал мөнгө их гардаг.”⁶⁷ гэж тайлбарлажээ.

Шигтгээ 1.6

Эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хугацаанаас өмнө цэргийн албанаас чөлөөлөгдсөн албан хаагчийн мэдээллийг тухай бүр ирүүлээгүйн улмаас эдгээр иргэдийн санал өгөх эрхийг орхигдуулсан, цагдаагийн албан хаагчийн шилжилтийг хийлгэх хүсэлтийг хугацаа тулгаж ирүүлсэн.

(УБЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 15-ны 1/3629 дугаар албан бичиг)

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиар сонгуулийн саналыг тоолох үйл ажиллагааг цахим сүлжээ ашиглан зохион байгуулах боловч санал хураалтад сонгогч биечилж оролцох зохицуулалт нь мэдээллийн технологи хурдтай хөгжиж, хэрэглээнд өргөнөөр нэвтэрсэн өнөө үед хүмүүсийн амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

Сонгууль зохион байгуулж буй улс орнууд биечилж санал өгөх энэ уламжлалт аргаас гадна сонгогч нэг бүрийг сонгуульд оролцуулахын тулд саналаа эрт өгөх буюу урьдчилан санал өгөх, шуудангаар санал өгөх, итгэмжлэгдсэн хүнээр дамжуулж саналаа өгөх, байнгын оршин суух хаягаас үл хамаарах санал авах байранд очиж нэрийн жагсаалтад бичүүлэн

⁶⁷ Ардчилал судлалын төв, НУС, МУИС, Орон нутгийн сонгуулийн талаарх иргэдийн ойлголт, хандлага тодорхойлох судалгаа, УБ, 2022 он

саналаа өгөх, зөөврийн хайрцгаар саналаа өгөх, и-мэйл болон бусад цахим платформуур дамжуулан санал өгөх зэрэг хувилбарт санал хураах аргыг ашиглаж байна.

Хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрхгүй гэх ерөнхий хязгаарлалт нь тохирсон хязгаарлалт эсэхийг⁶⁸ авч үзэж тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ болон гэм буруугийн хэлбэрт тохирсон эсэх, хөнгөн, хүндийг харгалзан сонгох эрхийг эдлүүлэх боломжийг судалж үзэх нь зүйтэй байна.

МУИХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, АНСДИТХСтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт хорих ял эдэлж байгаа Монгол Улсын иргэн сонгуульд оролцох эрх эдлэхгүй гэж заасан нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд⁶⁹ болон олон улсын бусад хэм хэмжээнд⁷⁰ бүрэн нийцэхгүй байна.

Монгол Улсад 2021 онд 3044, 2022 онд 4157, 2023 онд 4526⁷¹, 2024 онд 4260 иргэн хорих ял эдэлж байна⁷². Сонгуулийн эрхийг хязгаарласан аливаа хязгаарлалт нь зөвхөн онцгой нөхцөл байдал буюу хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд үндэслэх ёстой.⁷³ Энэ талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25 дугаар ерөнхий зөвлөмжийн 14 дэх хэсэгт “хэрэв гэмт хэрэгт ногдуулж буй ял шийтгэл нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэл болсон бол ийнхүү түдгэлзүүлсэн хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял шийтгэлтэй тохирч байх ёстой” гэж тайлбарлажээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 10 дугаар зүйлд “Хорих байгууллагын дэглэмийн нэн чухал зорилго нь хоригдлыг засан хүмүүжүүлж, нийгмийн хэвийн гишүүн болгох явдал” гэж заасан. Тиймээс хорих ял эдэлж буй этгээдийн сонгох эрхийг хязгаарлах нь тэднийг нийгэмшүүлэх, ардчилсан нийгмийн үнэт зүйлсэд дасган журамлах, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгод харш гэж үздэг.⁷⁴

Зарим улс орны энэ талаарх туршлагыг харахад хорих газар ял эдэлж байгаа этгээдүүдийн сонгуулийн эрхийг хуулиар шууд хязгаарладаг, тухайн этгээдийн үйлдсэн хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хөнгөн, хүндийг харгалзан сонгуулийн эрхийг хязгаарлах эсэхийг хуулиар тусгайлан болон шүүхийн журмаар тогтоодог, хорих газар ял эдэлж байгаа эсэхээс үл хамааран сонгуулийн эрхийг эдлүүлдэг гэсэн 3 төрөлд ангилан авч үздэг байна.⁷⁵

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчийн эрхийг бодитой хангахад зарим хүндрэлтэй асуудлууд тулгарч байна.

МУИХСтХ-ийн 63 дугаар зүйлд заасны дагуу эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй, Дайчилгааны тухай хуульд заасны дагуу нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон иргэн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөхөөр зохицуулсан бол АНСДИТХСтХ-д эрүүгийн хэрэгт

⁶⁸ Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл, УБ, 2021 он

⁶⁹ ЕАБХАБ-ын Копенгагены Баримт бичгийн 24 дэх хэсэгт “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа заалт нь холбогдох хуулийн аль нэг зорилттой уялдаж байхаас гадна тухайн хуулийнхаа зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэж заасан.

⁷⁰ Ял эдэлж байгаа хүний сонгох, сонгогдох эрхийг хязгаарласан байдал нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, эрүүгийн хариуцдагд тохирсон бөгөөд тэнцвэртэй байна. НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №25, 1996 он

⁷¹ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэл, УБ, 2024 он, 324 дэх тал

⁷² ШШГЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 02/634

⁷³ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA). Олон улсын сонгуулийн стандартууд, гарын авлага, УБ, 2007 он, 23 дахь тал

⁷⁴ Р.Очирбал “Сонгуульд иргэд нийтээрээ оролцох зарчим ба хорих газар ял эдэлж байгаа хоригдлуудын сонгуулийн эрхийн асуудал” эрдэм шинжилгээний өгүүлэл, УБ, 2012 он, 11 дэх тал

⁷⁵ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA). Олон улсын сонгуулийн стандартууд, гарын авлага, УБ, 2007 он, 23 дахь тал

холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа иргэн зөөврийн хайрцгаар санал өгнө гэсэн зохицуулалт байхгүй байна.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар 17,156 иргэнээс, харин орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар нийт 18,617 иргэнээс зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авсан байна.

МУИХСтХ-ийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаа нийслэл, сумын хэмжээнд явагдах хуулийн зохицуулалтай байсан бол АНСДИТХСтХ-ийн 62 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулалгүй оршин суугаа газраас нь очиж авахаар зохицуулсан. Гэвч зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогчийн байршил хэсгийн хорооноос хол тохиолдолд энэ зохицуулалт хэрэгжихгүй байна. Энэ талаар 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн явцад мониторинг хийж, холбогдох зөвлөмжийг⁷⁶ Комиссоос хүргүүлж байв.

Тохиолдол 1.6

Дарханы сонгогчдоос өөр аймагт байна, зөөврийн хайрцгаар саналаа өгье гэдэг хүсэлт ирүүлсэн. Эдгээр хүсэлтэд сонгуулийн хэсгийн хороо зөөврийн хайрцгаар санал авахдаа аймаг, сумын нутаг дэвсгэрээс гарах боломжгүй гэсэн хариу өгсөн. Өөрөөр хэлбэл, хүсэлт ирүүлсэн сонгогчдын саналыг зөөврийн хайрцгаар аваагүй.

(Сонгуулийн хэсгийн хорооны гишүүнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Шигтгээ 1.7

Зөөврийн хайрцгаар санал авах ажиллагаа бүрэн хэрэгжихгүй байна гэж үе үеийн сонгуулийн үеэр яригддаг. Гэтэл 1 хүний саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар байгаа газарт очиж авахад цаг хугацаа болоод зардлын тухайд маш их хүндрэл үүсдэг.

(СХХ-ны удирдах ажилтантай хийсэн ярилцлагаас)

Захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа сонгогчийн саналыг МУИХСтХ-ийн 63 дугаар зүйлийн 63.1.3 дахь заалтад заасны дагуу зөөврийн хайрцгаар авахаар, АНСДИТХСтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу түр хасав тэмдэглэгээ хийж саналыг түдгэлзүүлэхээр зохицуулжээ.

Согтуурах мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчлүүлж байгаа иргэдийн сонгох эрхэд хуулиар хязгаарлалт тогтоогоогүй. Гэтэл тэд байнга оршин суугаа харьяаллаас өөр газарт албадан эмчлүүлж байгаа тул тухайн нутаг дэвсгэрийн сонгогчийн нэрийн жагсаалтад ороогүй үндэслэлээр саналаа өгөх боломж бүрдээгүй байна.

Тохиолдол 1.7

МУИХСтХ-иар албадан эмчлүүлж байгаа иргэд сонгууль өгөх эрхтэй. Манай сонгуулийн хэсгийн хороонд Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газраас 104 хүний хүсэлт ирүүлсэн. Гэтэл МУИХСтХ-д сонгогч бүртгэлтэй харьяаллын дагуу саналаа өгнө гэж заасан. Бид хүсэлтүүдийг 17 аймаг, зургаан дүүргийн харьяалах хэсгийн хороонд хуулийн хугацаанд багтаан яаралтай илгээсэн ба “боломжгүй” гэсэн хариу өгсөн. Бид тэдгээр иргэдийн саналыг авах боломжгүй. Учир нь харьяалагдах нутаг дэвсгэрийнх нь саналын хуудас манай хэсгийн хороонд байхгүй, сонгуулийн хар машин саналын хуудсыг нь уншихгүй. Зөөврийн хайрцгаар санал авах мөн боломжгүй.

Сонгогчдын нэрийн жагсаалт

Сонгуулийн бүх нийтийн байх зарчмыг хэрэгжүүлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх хүмүүсийг бүртгэх, давхардлыг арилгах, бүртгэгдээгүй сонгуулийн насны иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх нь нэн чухал. Энэ

⁷⁶ Комиссын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 1/24 дүгээр зөвлөмж, 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 1/743 албан тоотор зөвлөмжийг СХХ-ны даргад хүргүүлсэн.

үүргийг МУИХСтХ, АНСДИТХСтХ-ийн 20 дугаар зүйлд 20.1 дэх хэсэгт заасны дагуу УБЕГ хэрэгжүүлж байна.

МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч, үндсэн сонгогч, түр хасав төлөвтэй иргэдийн тоо зөрүүтэй байх бөгөөд түр хасав төлөв тэмдэглэгээнд хамаарахгүй зарим иргэдийг уг төлөвт оруулсан гомдол, мэдээллүүд байна.

Хүснэгт 1.6 МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт дахь сонгогчдын тоо

№	Сонгуулийн хэлбэр	Нийт сонгогч	Үндсэн сонгогч	Түр хасав
1	Улсын Их Хурлын сонгууль ⁷⁷	2,224,233	2,089,949	165,368
2	Орон нутгийн Хурлын сонгууль ⁷⁸	2,246,164	2,107,296	144,267

МУИХ-ын сонгуулийн санал авах өдөр 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр, орон нутгийн Хурлын сонгуулийн санал авах өдөр 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан. 2024 оны дээрх хоёр сонгууль 114 хоногийн зөрүүтэй зохион байгуулагджээ.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн нийт сонгогчийн тоо МУИХ-ын сонгуулийн нийт сонгогчийн тооноос 21,931 илүү буюу ойролцоогоор 1 хувиар илүү байна. Түр хасав төлөвтэй иргэд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн 7,4 хувийг, орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн 6,4 хувийг эзэлж байна.

МУИХСтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.6.3 дахь хэсэгт заасан эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдээлэл бодит бус, зөрүүтэйн улмаас сонгуулийн санал авах өдөр ихээхэн маргаан дагуулж, сонгогчдод бухимдал үүсгэсэн, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.4, 20.6.5, 20.6.6 дахь хэсэгт заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан албан хаагчийн мэдээллийг зөрүүтэй бүртгэсний улмаас өөр иргэнийг бүртгэж сонгогчдын нэрийн жагсаалтад олон удаа өөрчилж, хүндрэл учруулж байсан талаар УБЕГ-аас ирүүлснийг⁷⁹ дурдах нь зүйтэй.

Эдгээр иргэдийг сонгогчдын нэрийн жагсаалтаас хасалгүй түр хасав төлөвтэй үлдээх боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд оруулан тооцохгүй гэсэн хуулийн заалтын үндэслэл, ач холбогдол ойлгомжгүй, түр хасав төлөвтэй иргэдийн тоо олон байх нь сонгуулийн үр дүнд нөлөөлөх үр дагавартайг анхаарах шаардлагатай байна.

Зарим улс төрийн намууд сонгогчдын дахин бүртгэлийн тоон задаргааг авах хүсэлт гаргасан боловч УБЕГ-аас тус мэдээллийг өгөхөөс татгалзсан нь сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдлыг хязгаарлаж байна гэжээ.⁸⁰

УБЕГ-аас МУИХСтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхдээ эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон, хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийг “түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийдэг.

Харин АНСДИТХСтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхдээ эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон, хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэн, тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлгүй боловч санал авах өдөр тухай нутаг дэвсгэрийн зэвсэгт хүчин, хилийн цэрэг,

⁷⁷ СЕХ, Монгол Улсын Их Хурлын Сонгууль-2024, УБ, 2024 он

⁷⁸ СЕХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль-2024, УБ, 2024 он

⁷⁹ ХЭҮК-т УБЕГ-аас 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/3629 дүгээр албан бичиг

⁸⁰ ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны тайлан, урьдчилсан дүгнэлт, 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр

дотоодын цэргийн анги, байгууллагад алба хааж байгаа алба хаагч, ажилтныг “түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийдэг.

Түр хасав нэмэлт тэмдэглэгээ бүхий сонгогчдын 95.6 хувь нь гадаад улсад зорчсон, 3.7 хувь нь хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа, 0.7 хувь нь эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон иргэд байна.

ХХЕГ сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу 60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг СЕХ-нд хүргүүлэх үүргийг хүлээдэг.

ХХЕГ-ын мэдээллийн нэгдсэн систем бүрэн шинэчлэгдэж, хуучин болон шинэ мэдээллийн санг нэгтгэх, зөрүүтэй болон дутуу мэдээллийг засварлах ажил хийгдэж байгаатай холбоотой хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээлэл бүрэн сэргээгүй байна.

Сонгогчийн нэрийн жагсаалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс өмнө хэсгийн хороодод өгөхөөр ажиллаж нэрийн жагсаалттай танилцахад түр хасав төлөвтэй маш олон иргэдийн бүртгэл гарч ирсэн бөгөөд жилийн өмнө БНХАУ-ын Эрээн хот руу өдөртөө зорчоод ирсэн иргэдийн бүртгэл олноороо орж ирсэн нь сонгох эрхийн зөрчил юм.⁸¹

Шигтгээ 1.8

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр нэрийн жагсаалттай холбоотой гомдол, мэдээллийн нэлээдгүй хувийг 60 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон шалтгаанаар түр хасав нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн иргэдийн гомдол, мэдээлэл эзэлж байв. Сүүлийн 5-10 жилийн хугацаанд гадаад улсад зорчоогүй, гадаад улсад зорчоод эргэж хилээр орж ирсэн, зарим иргэн хилээр огт зорчоогүй байхад нэмэлт тэмдэглэгээ хийсэн тухай гомдол, мэдээлэл гаргажээ.

(УБЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/3629 дүгээр албан бичиг)

“Бодлогод залуусын хяналт” ТББ-аас томилогдсон ажиглагч нарын ажиглалтын дүнгээс харахад сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй зөрчил нийт 19 хэсэгт 68 тохиолдол гарсан. Нэрийн жагсаалтад нэмж бүртгэсэн тохиолдол 8 хэсэгт 17 тохиолдол гарчээ.

“Сонгогчдын боловсрол” төв сонгогчийн лавлах утас 1800-2800 ажиллуулж, 2024 оны ээлжит сонгуулийн үеэр 3184 гомдол, мэдээлэл хүлээн авсны 112 нь “түр хасав” тэмдэглэгээтэй холбоотой, 221 нь сонгуулийн зохион байгуулалтын талаар, 112 нь санал авах байрны талаар, 76 нь нэр дэвшүүлэх үйл ажиллагааны талаар, 44 нь сонгуулийн сурталчилгаатай холбоотой, бусад нь зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлт байжээ.

МУИХСтХ, АНСДИТХСтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт Итгэмжлэгдсэн ажилтан сонгогчдын нэрийн жагсаалтад “түр хасав” гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн иргэний сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийлгэсэн шалтгаан арилсан тохиолдолд тухайн сонгогчийн өөрийнх нь хүсэлт, үндэсний гадаад паспорт, холбогдох нотлох баримтыг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалт дахь зохих тэмдэглэгээг хүчингүй болгож, тухайн сонгогчийн бүртгэлийг сэргээн, энэ тухай тэмдэглэл үйлдэн хэсгийн хороонд мэдэгдэнэ гэж заажээ.

Шигтгээ 1.9

2024 оны УИХ-ын сонгуулиар Сонгогчдын Боловсрол Төвийн “Сонгогчийн лавлах” утсанд ирсэн дуудлагаас харахад “эрх зүйн чадамжгүйд тооцогдож байгаагүй”, “гадаадад сүүлийн хэдэн жил яваагүй, зарим нь огт гадагшаа явж байгаагүй”, “хорих ял эдэлж байгаагүй” сонгогчдыг “түр хасав” төлөвтэй болгосон тохиолдол байсан. Мөн ялангуяа гадаадад урт болон богино хугацаагаар зорчоод ирсэн сонгогчид сонгуулийн өдөр саналаа өгөхөөр очсон ч “түр хасав” гэсэн төлөвөөс болж саналаа өгч чадахгүй байгаа талаарх дуудлагууд ирсэн.

Сонгуулийн санал авах байранд ажиллаж байгаа хэсгийн хорооны ажилтнуудаас түр хасав төлөвтэй сонгогчоос онгоцны тийз, гадаад паспорт, гадаад паспорт дээрх хил нэвтэрсэн дардас, хорих ялаа эдлээд дууссан иргэнээс хорих ангийн даргын бичиг

⁸¹ ХЭҮК-оос 2024 оны МУИХ-ын сонгуулийн үйл явцад хийсэн мониторингийн илтгэх хуудсаас

шаардсан цөөн тохиолдол гарсан талаар дурдсан байх тул хуулийг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэн ажиллах ёстой байна.

1.7 ТЭГШ БАЙДЛЫН ЗАРЧИМ

Сонгуулийн тэгш байдлын зарчмыг сонгуулийн харилцааг зохицуулсан үндэсний хууль тогтоомжид тусгайлан хуульчлаагүй ч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан байна. Сонгогчийн өгсөн санал нэг бүрийн хувийн жин ижил байх, тойрог тус бүрийн сонгогчдын тоо ойролцоо байх, сонгогдсон төлөөлөгч адил тооны сонгогчдыг төлөөлөх, сонгуулийн үйл ажиллагаанд нэр дэвшигч адил тэгш боломжоор хангагдах, тэгш хүртээмжтэй мэдээлэл авах эрхийг хангах нь сонгуулийн тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэх чухал баталгаа юм.

Нэг хүн нэг саналын эрхтэй байх зарчим нь улс бүрийн сонгуулийн тогтолцоонд туссан байх ба нэг сонгогчийн санал нөгөө сонгогчийн саналтай хувь тэнцүү байна. Сонгуулийн тойрогт хамаарах хилийн цэсийг тогтоох болон санал хуваарилахдаа тойрогт ноогдох мандатын тоог гажуудуулахыг хориглоно⁸² гэжээ.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт ногдох мандат, тойргийн сонгогчдын тоо, сонгогдсон гишүүдийн иргэдийг төлөөлөх тооны ялгаатай байдал сонгуулийн тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна.

Сонгуулийн тойргийг тодорхойлохдоо тэгш эрхийн зарчимд нийцүүлэх нь сонгогч бүр ижил тооны санал өгөх, сонгогч бүрийн саналын жин ижил байх, тойрог тус бүрийн сонгогчдын тоо ойролцоо байх, сонгогдсон төлөөлөгчид адил тооны сонгогчдыг төлөөлөх зэрэг чухал ач холбогдолтой.

МУИХСтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “ ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойргийг байгуулна” гэж заасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйл, 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлд үндэслэн МУИХ-аас 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” 112 дугаар тогтоолыг баталж, сонгуулийн мажоритар тойргуудыг бүсчилсэн байдлаар буюу 2-10 мандаттай 13 тойрог байхаар шийдвэрлэсэн.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын тоо нийслэлд 963,274 буюу 46.8 хувь нь, орон нутагт 1,095,591 буюу 53.2 хувь байхаар, мажоритар тойргийн 78 мандатын 54 нь орон нутгийн 7 тойрогт, 24 нь нийслэлийн 6 тойрогт ногдож, нэг тойрогт буй сонгогчийн тоо, мандатын тоо, нэг мандатад ногдох сонгогчийн тоо зөрүүтэй байна. Тухайлбал: сонгуулийн 7 дугаар тойрогт нэг мандатад ногдох сонгогчдын тоо 19,487 байхад 12 дугаар тойрогт 57,545 буюу 3 дахин их байна.

Хүснэгт 1.7 МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн тойргийн сонгогчдын болон мандатын тоо, нэг мандатад ногдох сонгогчдын тоо (тойрог тус бүрээр)

Тойргийн дугаар	Сонгогчдын тоо	Мандатын тоо	Нэг мандатад ногдох сонгогчдын тоо
1	191,312	9	21,256
2	196,522	10	19,652
3	69,014	3	23,004
4	199,691	8	24,961
5	203,506	10	20,350
6	146,717	7	20,960
7	136,410	7	19,487
8	273,573	5	54,643
9	163,496	3	54,498
10	203,069	6	33,845


⁸² НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №25, 1996 он

11	219,313	5	43,863
12	172,634	3	57,545
13	48,976	2	24,488

МУИХСтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.4, 12.5 дахь хэсэгт сонгуулийн тойрог байгуулахдаа аймаг, дүүргийн хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байршлыг харгалзахын зэрэгцээ хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэж болохоор хуульчилсан.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн тойргийг өмнөх сонгуулиудын тойргоос харьцангуй томсгосон байдлаар зохион байгуулсан нь улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд сонгуулийн өрсөлдөөний тэгш бус гарааг бий болгож, сонгогчдын мэдээлэл авах эрхийг хөндсөн.⁸³ Сонгуулийн тойргийг аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг “харгалзан” байгуулахаар хуульчилсан⁸⁴ хэдий ч сонгуулийн тойрог тогтоохдоо энэ шалгуурыг бодитоор хангаагүй байна. Сонгууль ажигласан олон улсын болон иргэний нийгмийн байгууллагаас хийсэн дүгнэлтэд МУИХ-ын сонгуулийн 13 тойргийн 11 тойрогт сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооны хязгаараас 15 хувиар, Улаанбаатар хотын 4 тойрогт 50 хувиар хэтэрсэн нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна гэжээ.

Бүдүүвч 1.9 МУИХ-ын 2024 оны сонгуулийн нэг мандатад ногдох сонгогчдын тоо, тойргоор




Сонгуулийн тойрог байгуулах, мандат хуваарилах аргачлал нь сонгогчдын тоо байршлаас гажуудаагүй, ялгаварлан гадуурхалтгүй, иргэдийн төлөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулсан байх ёстой. Сонгуулийн тойргийг байгуулах, тойрогт ногдох мандатын тоог тогтоохдоо МУИХ-д олонх болсон, суудал авсан нам шийдвэр гаргах бус бүх талын төлөөллийг хамруулсан хараат бус, бие даасан хороо байгуулах эсхүл сонгуулийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид нарийвчилсан шалгуурыг хуульд нарийвчлан зохицуулах шаардлагатай.

АНСДИТХтХ-ийн 12 дугаар зүйлд заасны дагуу аймаг, нийслэлийн 570 сонгуулийн тойргийн 796 мандатын төлөө 1,992 нэр дэвшигч өрсөлдсөн. Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчийн нэрийн жагсаалтад 2,246,164 сонгогч бүртгэгдсэн бөгөөд нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо 2,811 байна.

⁸³ ХЭҮК, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгууль:Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт” мониторингийн тайлан, УБ, 2024 он

⁸⁴ МУИХСтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “УИХ ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойргийг байгуулна” мөн зүйлийн 12.3 дахь хэсэгт “Сонгуулийн тойргийг байгуулахдаа аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно” гэж заасан.

Бүдүүвч 1.10 Аймаг, нийслэлийн ИТХ-ын нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо (аймаг, нийслэлээр)



МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны мэдээлэл түгээхэд намуудад ногдсон цаг тэнцвэргүй байна.

“Глоб интернэшнл” төвөөс сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх албан ёсны эрхтэй МҮОНРТ, TV9, Монгол TV, NTV, Eagle news гэсэн 5 телевизийг хамруулан 2025 оны 06 дугаар сарын 10-16 өдрүүдэд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хийсэн мониторингоос үзэхэд МҮОНРТ-ийн сонгуультай холбоотой мэдээллийн 19 хувийг МАН, 16 хувийг ХҮН нам эзэлсэн бол АН, ИХН-д адил тэнцүү 12 хувьтай тэнцэх цаг оногджээ. Харин 5 телевизийн дүнгээс харахад МАН-ын тухай мэдээлэл дунджаар 31 хувийг, МҮОНРТ-ийн мэдээний хөтөлбөрийн талаас илүү буюу 52% хувийг МАН дангаараа эзэлжээ.⁸⁵ Үүнээс телевизүүдийн сонгуультай холбоотой мэдээллийн дийлэнх цагийг эрх баригч намд зориулсан нь харагдаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өргөн хүрээнд ажилласан ч мэдээ сурвалжилга, дүн шинжилгээ бүхий мэдээний хөтөлбөрийн хязгаарлагдмал байдал, эрх баригч намыг илүү дэмжсэн байр суурь нь сонгогч мэдээлэлд суурилан сонголтоо хийх чадварт сөргөөр нөлөөлсөн⁸⁶ гэж хараат бус ажиглагчид дүгнэжээ.

Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, залуучууд зэрэг нийгмийн олон талт төлөөлөл болох иргэдийн сонгогдох эрхийг тусгайлан дэмжих нь чухал юм.

Монгол Улсын хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд бүх шатны сонгуульд идэвхтэй оролцооор ирсэн боловч эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо, гарааны нөхцөл тэнцвэргүй хэвээр байна.

Төрөөс улс төрийн хүрээн дэх эмэгтэйчүүдийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай авч ирсэн хэдий ч улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчийг тодруулахдаа МУИХСтХ, УТНтХ-иас гадна намын дүрэм, дотоод журмыг баримталдаг. Улс төрийн намын дүрэмд нэр дэвшигчдэд тавигдах нийтлэг шаардлага, ёс зүйн болон бусад шаардлага, сонгон шалгаруулах асуудлыг журмаар зохицуулахаар заажээ. Эмэгтэйчүүд МУИХ-ын сонгуульд нэр дэвших эрхээ авах нь намын дотоод үйл ажиллагаа, ардчиллаас шууд хамааралтай байна.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эсвэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дарааллыг үндэслэнэ. МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байхаар

⁸⁵ <https://www.gic.mn/post/r/1779> “Глоб интернэшнл” төвөөс 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Хэвлэлийн бага хурал

⁸⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны тайлан, урьдчилсан дүгнэлт, 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр


хуульчилсантай холбоотой МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд түүхэндээ хамгийн олон буюу 32 эмэгтэй МУИХ-ын гишүүнээр сонгогдлоо. Эдгээр эмэгтэй гишүүдийн 24 нь нам, эвслийн жагсаалтаар буюу “1:1” гэсэн хуулийн зохицуулалтын үр дүнгээр, 8 нь тойргоос сонгогдсоныг дурдах нь зүйтэй.

Тохиолдол 1.8

Эмэгтэйчүүдийн хувьд улс төрийн нам нь нэр дэвшүүлэх нь чухал байдаг. Иргэд эмэгтэй гэдэг шалтгаанаар сонгохгүй гэсэн зүйл байдаггүй, сонгодог юм билээ.

(Төв аймгийн Баян сумын сонгуулийн хэсгийн хорооны төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Бүдүүвч 1.11 МУИХ-ын сонгуулийн нийт болон эмэгтэй нэр дэвшигчдийн тоо, сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо




Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нийт 17,278 нэр дэвшигч бүртгүүлсний 67.6 хувь нь эрэгтэй, 32.4 хувь нь эмэгтэй байна. Үүнээс аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн 1,992 нэр дэвшигчийн 74.2 хувь нь эрэгтэй, 25.8 хувь нь эмэгтэй, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд өрсөлдсөн 15,286 нэр дэвшигчийн 66.7 хувь нь эрэгтэй, 33.3 хувь нь эмэгтэй байна.⁸⁷

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 8,031 төлөөлөгч сонгогдсоноос 5,819 буюу 72.5 хувь нь эрэгтэй, 2,212 буюу 27.5 хувь нь эмэгтэй байна. Эдгээрээс аймаг, нийслэлийн сонгуулийн хувьд 796 төлөөлөгч сонгогдсоны 18 хувь, сум, дүүрэгт 7,235 төлөөлөгч сонгогдсоны 28.6 хувь нь эмэгтэй байгаагаас харахад, аймаг, нийслэлийн дүнгээр эмэгтэй төлөөлөгчийн тоо дөнгөж 2 хувиар өссөн бол сум, дүүргийн хувьд 2020 оны дүнтэй адил байна.⁸⁸

⁸⁷ ХЭҮК, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/, “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль: Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт, мониторингийн тайлан”, УБ, 2024 он

⁸⁸ ХЭҮК, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан сонгуулийн үндсэн зарчмууд: Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн нарийвчилсан дүн шинжилгээ

Бүдүүвч 1.12 Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь



МУИХСтХ-д хүйсийн квот тогтоосон холбогдох журмыг нам, эвслээс зөрчсөн тохиолдолд нийт нэр дэвшигчийг сонгуулийн байгууллага бүртгэхээс татгалзах үндэслэл болохоор хуульчилсан бол АНСДИТХТХ-д 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна гэж ялгаатай зохицуулжээ.

Тохиолдол 1.9

Эмэгтэйчүүд жендэр, мөнгө, санхүү болон нийгмийн бусад хүчин зүйлээс шалтгаалан УИХ-ын сонгуульд нэр дэвшихэд хүндрэлтэй байдаг. Төрөөс квот тогтоосноор эмэгтэй хүн УИХ-ын сонгуульд өрсөлдөх боломжийг бий болгож эхэлсэн.

(АН-ын эмэгтэй гишүүнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Сонгуулийн сурталчилгаанд хамгийн түгээмэл бөгөөд үр дүнтэй ашиглагдаж буй хэрэгсэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж буй сурталчилгаа юм. Үүнээс телевизээр дамжуулж буй сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн дийлэнх цаг эрэгтэйчүүдэд зориулагдаж байна. Түүнчлэн эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх тэнцвэртэй мэдээлэл авах сонгогчдын эрх зохих ёсоор хэрэгжээгүй нь сонгуулийн үед ажиглалт хийсэн ТББ-уудын судалгаанаас харагдаж байна. Тухайлбал: “Глоб интернэшнл төв” ТББ-аас МҮОНРТ, TV9, Монгол TV, NTV, Eagle news гэсэн 5 телевизийн МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгаанд хийсэн мониторингийн дүнгээс харахад сурталчилгааны 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл байна.⁸⁹

МҮОНРТ 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 55 удаагийн мэтгэлцээнд 304 нэр дэвшигч оролцсоноос 73 буюу 24 хувь нь эмэгтэйчүүд, 231 буюу 76 хувь нь эрэгтэйчүүд байна.⁹⁰ Түүнчлэн мэтгэлцээний дийлэнх нь оргил цагаар цацагдаагүйгээс сонгогчид нэр дэвшигчдийн талаар мэдээлэл авч чадсан эсэх нь эргэлзээтэй хэмээн ЕАБХАБ/АИХЭГ-аас үзжээ.

Эндээс дүгнэхэд телевизийн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн дийлэнх цаг эрэгтэйчүүдэд зарцуулагдсан, эмэгтэйчүүдэд өөрийгөө танилцуулах боломж хомс байсан.

Эмэгтэй нэр дэвшигчид ташаа мэдээлэл, хиймэл оюун ухаан, хуурамч хаягаар түгээсэн мэдээлэл, ялгаварлан гадуурхалтын бай болж байв. Ихэвчлэн хүйсээр, үзэн ядсан үг хэллэгээр, боловсрол, царай зүс, биеийн байдал, нам, үзэл бодол зэргээр нь ялгаварлаж, үндэслэлгүй гүтгэсэн байв. Энэ нь улс төрд оролцох эмэгтэйчүүдийн оролцоонд саад болж буй асуудал юм.⁹¹

ҮСХ-ны мэдээллээс харахад Монгол Улсад 2023 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 111,228 байгаа нь хүн амын 3.2 хувийг эзэлж байна. 2012-2024 оны бүх шатны сонгуульд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй сонгогч болон нэр дэвшигчдийн талаарх статистик тоо баримт СЕХ-оос гаргадаг статистик мэдээлэлд байхгүй байна.⁹²

⁸⁹ <https://www.gic.mn/post/r/1781>

⁹⁰ ОУСАХ, “Монгол Улс - Парламентын сонгууль, 2024.06.28, урьдчилсан дүгнэлт”, УБ, 2024, 15 дахь тал

⁹¹ ХЭҮК, Хүний эрх хамгаалагч хүчирхэг залуус ТББ, “МУИХ-ын 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээний платформ ашиглаж байгаа байдалд хийсэн мониторинг”

⁹² Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгууль: эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт мониторингийн тайлан

Харин МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хоёр иргэн улс төрийн намын жагсаалтаар МУИХ-ын гишүүнээр сонгогдсон нь Монгол Улсад анхны тохиолдол байв.

МУИХ болон орон нутгийн Хурлын 7 удаагийн сонгуульд нийт 6 хөгжлийн бэрхшээлтэй хүн нэр дэвшиж, өрсөлдсөнөөс 5 нь хөдөлгөөний, 1 нь сонсголын бэрхшээлтэй бөгөөд хүйсийн хувьд 5 эрэгтэй, 1 эмэгтэй нэр дэвшигч байна. Тэдний хувьд хандив цуглуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон биечлэн сурталчилгаа хийх, материал хэвлүүлэх тараах, сонгуулийн штабын байрны болон ухуулагчдын зардлаа төлөх зэрэг санхүүгийн асуудал хамгийн хүнд, дохионы хэлмэрчгүй ажилласан, уулзалтын байрны хүртээмжгүй байдал, сонгогчдод өөрийгөө таниулахад бэрхшээл учирсан гэжээ.⁹³

Тохиолдол 1.10

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгогдох эрхийг хангахын тулд улс төрийн намууд хүний нөөцөө бэлтгэхээс эхлэн бүх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах шаардлагатай. Тухайн хүний сонгогдох эрхийг бодитоор хангахын тулд сонгуулийн сурталчилгааны хугацаанд дохионы хэлмэрч авах, брайль үсгээр материал хэвлүүлэх зэрэг зардлыг төрөөс хариуцах хэрэгтэй.

(Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны албан хаагч, судлаачтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийг жагсаалтаар оруулахыг урьтал болгохоос илүүтэй сонгуулийн тойрогт бусад нэр дэвших нөхцөлийг бүрдүүлж, сонгуулийн сурталчилгаа, зардлын хувьд анхаарал хандуулж, бусадтай эн тэнцүү өрсөлдөх боломжийг бий болгох шаардлагатай юм.

Сонгуулийн үйл явц, зохион байгуулалт, улс төрийн нам, эвсэл нэр дэвшигчийн мэдээлэл, мөрийн хөтөлбөр, бодлогын талаар үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэлтэй байх нь сонгогчдод хариуцлагатай сонголт хийх боломжийг олгодог. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны мэдээллийг иргэдийн ялгаатай хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүргэх нь чухал юм.

Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл сонгогчдын зарим бүлэгт хүртээмжгүй байв.

“Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ-аас хийсэн судалгаанд оролцогчид “Та сонгуулийн мөрийн хөтөлбөрийг уншдаг уу” гэсэн асуултад 56.4 хувь нь “ерөнхийд нь уншдаг”, 32.6 хувь нь “бүрэн уншдаг”, 11 хувь нь “огт уншдаггүй” гэж хариулжээ.⁹⁴

Сонгогчдын нийгмийн оролцоо, амьдарч буй газар зүйн байршил, нас, хүйс, сонирхол зэргээс хамааран мэдээлэл авах эх сурвалж нь өөр өөр байдаг. Тухайлбал, ахмад настнууд хэвлэмэл материал уншиж танилцахаас илүүтэй ухуулагчдын яриа, нэр дэвшигчдийн уулзалт, хуралд сууж мэдээлэл авах, харилцан ярилцах сонирхолтой байна.

Ахмад настнууд нь Монгол Улсын нийт хүн амын 10.1 хувийг эзэлдэг бөгөөд 2050 он гэхэд таван хүн тутмын нэг нь ахмад настан болох урьдчилсан тооцоо байдаг. Иймд ахмад настнуудын сонгох, сонгогдох эрхийн хүрээнд тэдэнд сонгуулийн сурталчилгааны мэдээллийг хүртээмжтэй, тохирсон арга хэлбэрээр хүргэхэд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид зайлшгүй анхаарах ёстой болж байна.

Тохиолдол 1.11

Сонгуулийн сурталчилгааны материал тараадаг хүмүүс мэдээлэл дутуу өгдөг. Сонгуулийн хэвлэмэл материалыг сонин тарааж буй мэт биш харин аль намаас хэн гэдэг нэр дэвшигч дэвшиж байгаа, ямар агуулга бүхий сурталчилгааны материал тарааж байгаа талаар тайлбарладаггүй.

(Ахмад настан, малчдын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

⁹³ ХЭҮК-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” судалгаа 2024 он

⁹⁴ “Цогц хөгжлийн үндэсний төв” ТББ, “Сонгогчийн зан төлөвийн судалгаа” 2022 он, 37 дахь тал

Тохиолдол 1.12

Сонгуулийн сурталчилгааны ажилчид гэрийн үүдэнд сурталчилгааны материал үлдээгээд явдаг. Би сонгуулийн сурталчилгааны үеэр мэдээлэл маш дутуу өгдөг гэж боддог. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сонгуулиа хэрхэн өгөх болон нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн агуулгын талаар танилцуулах хэрэгтэй. Нэр дэвшигч сонгогдоод юу хийх талаар мэдээлэл өгч чадахгүй, тайлбарлахгүй болохоор сонгуулийн сурталчилгааны ажил дутуу дулимаг болдог. Аль ч нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгаа хийдэг хүмүүс ажлаа чанартай хийх хэрэгтэй.

(Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ахмад настануудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Ухуулагчид “авбал ав, байвал бай” гэсэн шиг уутанд хийгээд хашаан дээр өлгөчихдөг. Энэ нь эргээд хог болоод гудмаар тардаг.

(Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ахмад настануудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

МУИХ, Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны хугацаа богино байсантай холбоотойгоор зарим нэр дэвшигчид хүн ам ихээр төвлөрсөн суурин газарт сонгуулийн сурталчилгаа явуулахыг эрмэлзэж байсан бөгөөд алслагдсан сум, баг, хорооны сонгогчдод хүрэх мэдээлэл бага байсан.

Тохиолдол 1.13

Нэр дэвшигчдийн зүгээс сурталчилгааны хугацаа бага хэрнээ томсгосон тойрогтой энэ оны сонгуулиар хүн ам багатай суманд ач холбогдол өгч ажиллаагүй, МАН, АН-аас бусад намууд сурталчилгаа бараг хийгээгүй болохоор ихэнх нэр дэвшигч нартай уулзаж чадаагүй. Тиймээс жижиг нам, нэр дэвшигчид манай сумаас бага санал авсан байх.

(Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ахмад настануудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Алслагдсан аймаг, сумын төв, багт амьдардаг нийгмийн оролцоо өндөртэй малчид, сонгуулийн сурталчилгааны материалтай танилцаж, уулзалт, хуралд оролцох зэргээр мэдээлэл авч байсан бол нийгмийн оролцоо дунд түвшинд байх малчид телевизийн мэдээлэлд үндэслэн сонголтоо хийж, нийгмийн оролцоо сул малчид бусдаас сонссон мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргадаг байна.

Тохиолдол 1.14

Манайх энэ удаагийн сонгуулиар Дархан, Сэлэнгэ аймгийг багтаасан том тойрог болсон. Сонгуулийн сурталчилгааны хугацаа богино болохоор нэр дэвшигчид ирж амждаагүй. Намын хүмүүс нь суманд хуваагдаад ирсэн. Гурван нэр дэвшигч нэг удаа нэг цаг орчим уулзалт хийсэн. Сонгогчдод өөрийгөө таниулах өөр арга байхгүй. Иймд сонгогчид өмнө мэддэг байсан хүнээ л сонгосон.

(Төв аймгийн Баян сумын ахмад настны төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хангалтгүй ирсэн, нэр дэвшигчдийн уулзалт цөөхөн болсон зэргээс шалтгаалан ахмад настан, малчид сонгуулийн сурталчилгааны мэдээллийг ихэвчлэн телевизээс авчээ. Гэтэл телевизийн сурталчилгааны нэвтрүүлэгт хийсэн мониторингоор эрх баригч намын сурталчилгаа түлхүү явагдсан байна.⁹⁵

Залуу сонгогчдын тухайд интернэт, цахим платформ, олон нийтийн сүлжээ мэдээлэл авах нь гол суваг болдог бөгөөд ихэвчлэн фэйсбүүк, твиттер, инстаграм зэрэг платформ ашиглаж, сонгуулийн мэдээллийг онлайн орчноос авдаг байна.

⁹⁵ “Глоб интернэшнл төв” ТББ-ын МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр хийсэн мониторинг

1.8 ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЗАРЧИМ

Сонгуулийн чөлөөтэй байх зарчим нь сонгогч аливаа дарамт шахалт, сүрдүүлэг, бусдын нөлөөлөлгүйгээр хуульд заасан хэлбэрээр нэр дэвшигчээ чөлөөтэй сонгох боломжтой байхыг ойлгоно.

Сонгогдох эрхтэй этгээд нь боловсрол, оршин суугаа газар, үндэс угсаа, улс төрийн намын зэрэг үндэслэлгүй ялгаварлан гадуурхсан шаардлага тавьж сонгуульд нэр дэвшихээс хасагдах ёсгүй. Сонгох эрхтэй этгээд аль нэг нэр дэвшигчид саналаа чөлөөтэй өгөх бөгөөд аливаа саналыг эсэргүүцэх, дэмжих дэмжихгүй байх эрхтэй. Сонгогч ийнхүү өөрийн хүслийг чөлөөтэй илэрхийлэхэд хууль бусаар нөлөөлөх, албадах ёсгүй.⁹⁶

Сонгуулийн хууль тогтоомжид заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх зарчмыг ерөнхийд нь хангаж хэвшсэн ч зарим нэг анхаарах асуудал байна.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар иргэд сонгуулийн тойрогт нэр дэвшигчид өгсөн саналыг тэмдэглэх, нам, эвсэлд өгсөн саналыг тэмдэглэх гэсэн хоёр саналын хуудсаар саналаа өгсөн бол орон нутгийн Хурлын сонгуульд нэг саналын хуудсаар саналаа өгсөн байна.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хоёр шатны сонгууль дахь мандатын тоо нь харилцан адилгүй байдгаас нэг саналын хуудсаар санал өгч байгаа нь нэг сонгуульд алдаа гаргаж саналаа буруу тэмдэглэхэд нөгөө сонгуульд өгсөн санал дагаад хүчингүй болох эрсдэл үүсгэж байв. МУИХ болон орон нутгийн Хурлын сонгуульд сонгогч ахин нэг удаа саналын хуудас авах боломжтой бөгөөд дахин алдаа гаргавал саналаа өгөх боломжгүй юм.

Сонгогч буруу тэмдэглэл хийснээс, эсхүл санал тоолох төхөөрөмж таньж уншаагүйгээс хүчингүй болсон саналын хуудасны нийт тоо 2024 оны орон нутгийн Хурлын сонгуульд зарцуулсан саналын хуудас⁹⁷ 41,483 байсан бол МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд 48,665 саналын хуудас байсан. Сонгогчид саналын хуудсыг буруу бөглөснөөс дахин авсан саналын хуудсаа буруу тэмдэглэсний улмаас хүчингүй болгож, санал өгч чадаагүй сонгогчдын тоо, мэдээлэл байхгүй байна.

Саналын хуудсанд тавигдах шаардлага, саналын хуудсыг дахин нэг удаа олгох зохицуулалт нь сонгогчдод тохирсон, нийцтэй эсэхэд анхаарч сонгогчдод саналын хуудаст саналаа зөв тэмдэглэх мэдээлэл түгээх хэрэгцээтэй байв.

Сонгогч өөрийн хүсэл зоригоор саналаа чөлөөтэй гаргах буюу хэнийг дэмжиж, эс дэмжих нь сонгогчийн эрх бөгөөд саналын хуудсанд байгаа нэр дэвшигчдээс өөрийг нь “төлөөлж чадна” гэсэн итгэл үнэмшил, хүсэл зоригтоо үндэслэж саналаа илэрхийлэх нь сонгуулийн чөлөөт байдлын зарчим юм.

МУИХСтХ-ийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэг, АНСДИТХтХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасан мандатын тоотой тэнцүү тооны санал өгөх хуулийн шаардлага нь чөлөөтэй байх зарчимд харшилж байна.

МУИХСтХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.10 дахь хэсэгт “Сонгогч нэг ч нэр дэвшигч, эсхүл нам, эвслийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн ... саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно” гэж заасан нь сонгогчид саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгож буй зохицуулалт юм. Тухайн сонгогчийг саналаа өгсөн сонгогчдын тоонд оруулдаг нь сонгогчийг саналаа өгсөн буюу бүх нэр дэвшигчийг татгалзаж хүсэл зоригтоо илэрхийлсэн гэж үзэж буй хэрэг.

⁹⁶ НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж №25, 1996 он

⁹⁷ СЕХ, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн саналын хуудасны зарцуулалтын тайлан.

Гэвч сонгогчийг мандатын тоотой тэнцүү тооны санал өгөхийг албадаж, мандатын тооноос дутуу санал тэмдэглэвэл саналын хуудсыг хүчингүйд тооцох хуулийн зохицуулалт нь хүсээгүй нэр дэвшигчдээ санал өгөхөөс аргагүй байдалд хүргэх, сонгогчийн итгэл үнэмшил, хүсэл зоригоос гадуур шинжийг агуулж байна. Мөн 2024 оны МУИХСтХ-д мандатын тооноос илүү, эсхүл дутуу тэмдэглэхэд саналын хуудас хүчингүй, харин АНСДИТХтХ-д мандатын тооноос дутуу тэмдэглэхэд саналын хуудас нь хүчинтэйд тооцож адил сонгуулийн тогтолцооны хувьд ялгаатай зохицуулалт үйлчилж байна.

Цэц 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцээд, МУИХСтХ-ийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт “Тойрогт ногдсон мандатын тооноос ... дутуу нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд ... чөлөөтэй ... сонгох эрхийн үндсэн дээр ... сонгоно.” гэж заасныг зөрчсөн гэж үзэн дүгнэлт гаргаж холбогдох заалтыг 2025 оны 3 дугаар 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлж, шийдвэрлэжээ.⁹⁸

АНСДИТХтХ ба МУЗЗНДНТУтХ-ийн зохицуулалт хоорондоо зөрчилтэй байна.

АНСДИТХтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт Сум, дүүргийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн Хурлын төлөөлөгчид зэрэг нэр дэвшиж болно гэж заажээ. Энэ нь иргэн хоёр шатны сонгуульд зэрэг нэр дэвших эрхтэй бөгөөд сонгогчдын дэмжлэг авч сонгогдсон тохиолдолд аль ч шатны Хуралд төлөөллөө хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байна. Гэтэл МУЗЗНДНТУтХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад Хурлын төлөөлөгч өөр шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байхыг хориглоно гэж заасан зохицуулалтыг орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан.

АНСДИТХтХ-иар 2 шатны хуралд нэр дэвших эрхтэй гэж зохицуулсан ч сонгогдсоны дараа 2 шатны хуралд Төлөөлөгч байхыг хориглосон хууль тогтоомжийн зөрчил бий болгож, нэр дэвшигчийн эрхийг хязгаарлах, нөгөө талаас тухайн нэр дэвшигчийг дэмжиж саналаа өгсөн сонгогчийн хүсэл зоригийг үгүйсгэж, тэдний төлөөллийг хязгаарлаж байна. Иймд хууль тогтоомжийн зөрүүтэй байдлыг арилгаж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах шаардлагатай байна.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх хуулийн зохицуулалт нь улс төрийн нам, нэр дэвшигчийн олон ургалч үзэл, бодлогоороо ялгарах, өрсөлдөх боломжид нөлөөлж байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь улс орны болон тухайн орон нутгийн хүний хөгжил, олон нийтийн нийтлэг эрэлт, хэрэгцээнд тохирсон, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хугацаа, арга зам, хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтад нь багтаасан, хууль тогтоомжид заасан тодорхой шаардлагыг хангасан бодлогын баримт бичиг болдог.

Сонгууль бол ялгаатай үзэл бодол, ялгаатай байр суурь, үзэл баримтлалын өрсөлдөөн байх ёстой. Гэтэл МУИХСтХ, АНСДИТХтХ-д нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газраар хянуулж дүгнэлт гаргуулдаг.⁹⁹

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг 2024 оны 03 дугаар сарын 22, 23, 24-ний өдрүүдэд хүлээн авч, Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон МУИХСтХ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож хянажээ.

⁹⁸ Цэцийн 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дунд суудлын хуралдаанаас

⁹⁹ МУИХСтХ-ийн 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэг, АНСДИТХтХ-ийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсэг

Тохиолдол 1.15

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор мөрийн хөтөлбөрөө хүргүүлсэн 27 нам, 2 эвслийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичгүүд болон бусад хуульд нийцэхгүй байгаа учраас буцааж, мөрийн хөтөлбөрөө өөрчлөхийг даалгажээ.¹⁰⁰

Тохиолдол 1.16

Улс төрийн намууд мөрийн хөтөлбөртөө амлалт өгсөн, хуульд нийцээгүй байх, төсвийн хуулиудад зааснаас өндөр дүн тавьсан, бичиг баримт нь боловсруулалтын шаардлага хангаагүй гэх мэт зөрчлүүд хамгийн түгээмэл байдаг.

(УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах ажлын хэсгийн нарийн бичгийн даргатай хийсэн ярилцлагаас.)

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг ажигласан ЕАБХАБ/АИХЭГ-ын тайланд “Өрсөлдөгчид өөрсдийн мөрийн хөтөлбөрийг урт хугацааны хөгжлийн бодлого, төсвийн тогтвортой байдлын шаардлага зэрэг засгийн газрын хөтөлбөрүүдтэй нийцүүлэхийг хуулиар шаарддаг. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзлийг хязгаарлаж байна¹⁰¹” гэж дүгнэжээ.

Улс төрийн намууд мөрийн хөтөлбөрийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан байх нь зүй ёсны хэрэг боловч МУИХ-аас баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заавал нийцүүлэх хуулийн шаардлагыг нягтлах шаардлагатай.

Сонгуулийн сурталчилгаа үргэлжлэх хугацаа богино байгаа нь нэг талаас нам, эвсэл, нэр дэвшигчдэд бодлого, мөрийн хөтөлбөр, өөрийгөө таниулах боломжийг хязгаарлаж нөгөө талаас сонгогчдын сонгуульд оролцож буй нам, эвсэл нэр дэвшигчдийн талаар үнэн зөв, бодитой, тэнцвэртэй, хангалттай мэдээллийг хүлээн авахад нөлөөлж байна.

МУИХСтХ 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, АНСДИТХТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно гэж заажээ.

МУИХСтХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, АНСДИТХТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно гэж зохицуулсан. Ингэснээр МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны үргэлжлэх хугацаа 17 хоног, орон нутгийн Хурлын сонгуулийн хувьд 14 хоног байв.

МУИХ-ын сонгуулийн сурталчилгаа хийх хугацааг 1992-2004 оны сонгуульд нэр дэвшигчид 44, нам эвсэлд 64 хоног, 2008 оны сонгуульд 20 хоног, 2012 оны сонгуульд 22 хоног, 2016 оны сонгуульд 17 хоног, 2020 оны сонгуульд 21 хоног, 2024 оны сонгуульд 17 хоног болгон хуульчилж, сонгуулийн зардлыг бууруулах нэрийдлээр сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа ээлжит сонгуулийн жил бүр өөрчлөгдөж, харилцан адилгүй хугацаа тогтоож байжээ.

Сонгуулийн тогтолцоог өөрчилсөнтэй холбоотойгоор МУИХ-аас сонгуулийн мажоритар тойргийг байгуулахдаа аймгуудыг олноор нэгтгэж томсгон бүсчилсэн байдлаар байгуулж, нэг тойрогт ногдох нутаг дэвсгэрийг өмнөх сонгуулиудаас хэд дахин томруулж, мандатын тоог ихэсгэж нэг тойрогт 10 хүртэл байхаар тогтоосон хэдий ч сонгуулийн сурталчилгааны хугацааг нэмэлгүйгээр 2023 оны 06 сарын 16-ны өдрийн хуулиар 21 хоног байсныг 17 хоног болгож бууруулжээ. Энэ нь олон нийтэд танигдсан, санхүүгийн нөөцтэй, эрх барьж буй улс төрийн нам, нэр дэвшигчдэд давуу тал боллоо.

¹⁰⁰ ЯАГ, <https://audit.mn/?p=25106>

¹⁰¹ ЕАБХАБ/АИХЭГ-ын урьдчилсан дүгнэлт, 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр


Хуулиар тогтоосон 17 хоногийн хугацаанд томсгосон тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн насны иргэн бүрд хүрч ажиллан тулгамдсан асуудал, дэвшүүлж буй санал, бодлого, мөрийн хөтөлбөрөө таниулах боломж хязгаарлагдмал байв.

Сонгогч сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн дэвшүүлж буй бодлого, хөтөлбөртэй танилцаж, үүнд үндэслэн сонгуульд санал өгөх эрхтэй.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд анх удаа 19 нам, 2 эвслээс 1299 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигчээр 42 хүн өрсөлдөж нэг тойрогт дунджаар 80 орчим нэр дэвшигч байсан гэж тооцоход 17 хоногийн хугацаанд сонгогч нь нам, эвсэл, нэр дэвшигчийн бодлого, мөрийн хөтөлбөр, хувийн байдал, боловсрол, мэдлэг, туршлагын талаар хангалттай мэдээлэл авах боломжгүй байна.

2024 оны сонгуулийн өмнө Сонгогчдын боловсрол төвөөс 600 орчим иргэдийн дунд сонгогчдод хамгийн хэрэгцээтэй мэдээллийн төрөл болон авахыг хүсэж буй мэдээллийн сувгийг тодорхойлох судалгаагаар сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалт, нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээллийг хамгийн их хэрэгцээтэй гэж нэрлэжээ.

Бүдүүвч 1.13 Сонгуульд оролцоход хамгийн их хэрэгцээтэй мэдээллийн төрөл (хувиар)



- сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалт
- нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээлэл
- сонгуулийн систем, тогтолцоо
- саналаа хаана, яаж өгөх
- сонгууль хэзээ болох
- ямар сонгууль болох

Тохиолдол 1.17

Томсгосон тойрогтой, сурталчилгааны хугацаа богино байсан тул нэр дэвшигчид хүн ам олонтой суманд ач холбогдол өгч, сурталчилгаагаа түлхүү явуулсан. МАН, АН-аас бусад намын хувьд манай сумыг цөөхөн сонгогчтой гэж үзээд сурталчилгаа бага явуулсан байх талтай. Ихэнх нэр дэвшигч нартай уулзаж чадаагүй. Тиймээс жижиг нам, нэр дэвшигчид манай сумаас санал бага авсан байх.

(Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ахмад настнуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс¹⁰²)

Тохиолдол 1.18

Манайх энэ удаагийн сонгуулиар Дархан, Сэлэнгэ аймгийг багтаасан том тойрог болсон. Сонгуулийн хугацаа бага болохоор нэр дэвшигчид ирж амждаагүй. Намын хүмүүс нь суманд хуваагдаад ирсэн. Гурван нэр дэвшигч нэг удаа нэг цаг орчмын уулзалт хийсэн. Иймд сонгогч өмнө мэддэг байсан хүнээ л сонгосон.

(Төв аймгийн Баян сумын ахмад настнуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс¹⁰³)

¹⁰² Хил хязгааргүй хуульчид төрийн бус байгууллага, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль: Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт, мониторингийн тайлан, УБ, 2024 он, 57 дахь тал

¹⁰³ Мөн тэнд

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог томорсонтой холбоотойгоор сонгуулийн сурталчилгаа явуулах, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах зардал өсжээ.

1.9 СОНГУУЛИЙН САНАЛАА НУУЦААР ГАРГАХ ЗАРЧИМ

Сонгуулийн саналаа нууцаар гаргах зарчмыг хэрэгжүүлж, сонгууль зохион байгуулах бүх үе шатанд нууцлалыг хангах нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн үүрэг юм.

Саналаа нууцаар гаргах зарчмын хэрэгжүүлж хэвшсэн хэдий ч сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах журам, санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилт хангалтгүй байна.

МУИХСтХ, АНСДИТХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт сонгогчийн саналаа нууцаар гаргах зарчмыг, МУИХСтХ-ийн 61 дүгээр зүйл, АНСДИТХтХ-ийн 61 дүгээр зүйлд сонгогч саналаа нууцаар тэмдэглэхэд шаардагдах зохицуулалтыг хуульчилсан.

Санал авах байрны зохион байгуулалт, зай талбай нь сонгогчдын саналын нууцлалыг хадгалахад чухал нөлөөтэй. СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар Санал авах байранд тавигдах ерөнхий шаардлага, Санал авах байр бэлтгэх зааврыг баталсан бөгөөд уг зааварт тусгаснаар санал авах байранд тавигдах ерөнхий шаардлагад аймгийн төв, дүүрэгт 80 мкв, сумын төвд 60 мкв, багт 20 мкв-аас багагүй байна.

2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Комиссын ажиглалт, мониторингд хамрагдсан санал авах байрны 12.8 хувь нь зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа нууцаар өгөх боломжийг бүрдүүлээгүй, санал авах айлд бүхээггүй очиж, санал авах ажиллагааг зохион байгуулсан бол зарим санал авах байрны ширээ хоорондын зайг хэт ойрхон байрлуулснаас болж сонгогч нууцаар санал өгөх боломж бүрдээгүй байна гэж дүгнэжээ.¹⁰⁴

ЕАБХАБ/АИХЭГ-ын тайланд дурдсанаар, ажиглалт хийсэн санал авах байрны 14 хувь нь сонгогч нууцаар саналаа өгөхөд өрөөний зохион байгуулалт муутай, ялангуяа Улаанбаатар хотод санал авах байрны 10 хувь нь хэт ачаалалтай байснаас сонгогч, сонгуулийн хэсгийн хорооны гишүүд санал тоолох төхөөрөмжид хэт ойр, сонгогчид саналын хуудсаа ихэвчлэн дээш нь харуулан уншуулж байсан тул саналын хайрцагт ойрхон зогсож буй хүн сонгогчийн саналаа хэрхэн өгч буйг харах боломжтой байна гэж дүгнэжээ.¹⁰⁵

Санал авах байрны зай талбайгаас хамаарч саналын нууцлал алдагдах эрсдэлтэй боловч нөгөө талаас стандартад нийцсэн зай талбайтай ч хэсгийн хорооны зохион байгуулалт, ажилтнуудын хандлагаас шалтгаалж санал бэлтгэх бүхээгийг хэт ойр байршуулсан зөрчил байсныг дурдах нь зүйтэй.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар ахмад настан, ямар нэг байдлаар чадвар сул, харааны бэрхшээлтэй, бичиг үсэггүй иргэд ганцаар ирсэн тохиолдолд хэсгийн хорооны ажилтан туслах, нэр дэвшигчээ дутуу дугуйлсан бол хэсгийн хорооны дарга мандатын тоог гүйцээж сонгуулахаар хажуугийн ширээнд суулгаж, саналын хуудсыг бөглүүлэх, сонгогч саналаа төхөөрөмжид уншуулах үед саналын нууцлал алдагдах нөхцөл байдал хэсгийн 80 хороонд нийт 2,157 удаа давтагдсан.¹⁰⁶

МУИХСтХ-ийн 63 дугаар зүйл, АНСДИТХтХ-ийн 62 дугаар зүйлд зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах зохион байгуулалт, санал авах сонгогчдыг тодорхойлсон. МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар 17,156 иргэнээс харин орон нутгийн

¹⁰⁴ ХЭҮК-оос 2024 оны 06 дугаар 27-ны өдөр 19 аймгийн 56, Нийслэлийн есөн дүүргийн 21, нийт 77 хэсгийн хорооны санал авах байрны зохион байгуулалт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэх, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааны явцад мониторинг хийсэн

¹⁰⁵ Олон улсын сонгууль ажиглах хорооны 2024 оны 06 дугаар сарын 28-ны урьдчилсан дүгнэлт

¹⁰⁶ 2024 оны сонгуулийг ажигласан “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын хэвлэлийн мэдээ. <https://forum.mn/post/157235>

Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар нийт 18,617 иргэнээс зөөврийн битүүмжилсэн хайрцагар санал авсан байна.

Тохиолдол 1.19

Зөөврийн хайрцагар санал өгөхөд саналын бүхээг ашиглаагүй, өөр өрөөнд орж саналаа өгсөн. Брайль хавтас ойлгомжгүй байсан тул брайль хавтас хэрэглээгүй. Саналаа эгчээрээ дамжуулан өгсөн.

(Хөгжлийн бэрхшээлтэй сонгогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Саналаа нууцаар гаргах зарчмыг хангахад батлагдсан хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилтийг мөрдүүлэх, хяналт тавих нь чухал байна.

1.10 СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Сонгуулийн зардал, зарцуулалтад хяналт тавих, хариуцлага тооцох нь маш чухал бөгөөд 2020 оноос хойш МУИХ-ын сонгуульд оролцогчид сонгуулийн зардлын болон хандивын тайланг санал авах өдрөөс 3 өдрийн өмнө ЯАГ-т хүргүүлж, ЯАГ тайланг нийтэлдэг болсон. Улс төрийн нам, эвсэл сонгуулийн өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан эцсийн тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан хүргүүлэх¹⁰⁷ үүрэг хүлээдэг. ЯАГ нь зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох эрх хэмжээгүй ба хандив өгөхийг зөвшөөрсөн хүн хандив өгсөн эсэхийг ТЕГ, тайлантай холбоотой асуудлыг Сангийн яаманд¹⁰⁸, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлыг Төв банканд хүргүүлдэг.

Олон улсад улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуульд хамгийн ихдээ ямар хэмжээний хөрөнгө мөнгө ашиглаж болохыг хязгаарласан зардлын дээд хэмжээг тогтоох зохицуулалт түгээмэл байдаг бөгөөд дэлхийн улс орнуудын 30 орчим хувь нь улс төрийн намуудын зардалд, 40 гаруй хувь нь нэр дэвшигчдийн зардалд дээд хэмжээ тогтоодог байна.¹⁰⁹

Зардлын дээд хэмжээ нь иргэдийн сонгуульд нэр дэвших, өрсөлдөх боломжид нөлөөлж байна.

Монгол Улсын хувьд 2008 оноос сонгуулийн зардлын дээд хязгаарыг тогтоож эхэлсэн бөгөөд СЕХ-ны 2024 оны 06 дугаар тогтоолоор¹¹⁰ баталсан аргачлалын дагуу ЯАГ-аас МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 6,434.5 сая төгрөг, тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 894.7-1,526.1 сая төгрөгийн хооронд тогтоожээ.¹¹¹

¹⁰⁷ МУИХСтХ-ийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсэг

¹⁰⁸ Сангийн яамны 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02/2286 дугаар албан бичиг.

¹⁰⁹ ННФ, Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилт, Улс төрийн санхүүжилтийн гарын авлага", УБ, 2020 он, 36 дахь тал.

Зардлын дээд хэмжээ тогтоох зорилго нь хандивлагчдын нөлөөг зохицуулах гэхээсээ илүүтэй, санхүүгийн боломж ихтэй улс төрийн нам, нэр дэвшигчдийн давуу байдлыг тэгшитгэхэд чиглэдэг. Тухайлбал: ардчилал тогтсон болон шинээр тогтож байгаа орнуудын аль алинд нь хувийн мөнгөөрөө кампанит ажлаа санхүүжүүлж байгаа нэр дэвшигчид, эсвэл намынхаа санхүүжилтийн нэлээд хэсгийг гаргаж байгаа намын удирдагчид олон байдаг жишээг дурдаж болно. Хандивын хязгаарлалтын нэгэн адил, энэ төрлийн зохицуулалтын үр дүн нь нэг талаас санхүүгийн бололцоо сайтай талуудын давуу байдлыг тэгшитгэхийн сацуу сонгогчдод ойр, хүртээмжтэй кампанит ажил явуулахад саад болохооргүй зохистой түвшинд зардлын дээд хэмжээг тогтоохоос шалтгаалах ба хэрэгжилтийг хэрхэн хангахаас хамаарна.

¹¹⁰ СЕХ-ны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн "Аргачлал батлах тухай" 06 дугаар тогтоолоор "Монгол Улсын Их Хурлын сонгуульд нам, эвсэл болон сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох" аргачлалыг шинэчлэн баталсан.

¹¹¹ ЯАГ МУИХСтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт "Төрийн аудитын дээд байгууллага нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг ээлжит сонгуулийн жилийн 3 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө энэ хуулийн 50.2 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу тогтоож, нийтэд мэдээлнэ" гэж заасан. Үүний дагуу МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл болон тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хугацаанд тогтоож, нийтэд мэдээлсэн. Зардлын дээд хэмжээ тогтоохдоо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, мөн хуулийн 13, 36, 37, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 49, 52-т заасныг тус тус харгалзан тооцоолол хийсэн байна.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд 2,203.2 сая, аймгуудын хувьд Төв аймгийн ИТХ-ын сонгуульд 1,620.1 сая төгрөг хамгийн өндөр, нэр дэвшигчдийн хувьд нийслэлийн ИТХ-ын дундаж 566.8 сая, аймгуудын хувьд Дархан-Уул аймгийн ИТХ-ын дундаж 164.8 сая төгрөг, Сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээний дундаж Дархан-Уул аймгийн сумдад 129.6 сая төгрөг, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээний дундаж Дархан-Уул аймагт 101 сая төгрөг байна.

ЕАБХАБ/АИХЭГ-ын ОУСАХ-ны хэд хэдэн ярилцлагад сонгуулийн зардлын дээд хэмжээ хэт өндөр байгаа нь хэдийнээ бэхэжсэн, парламентад суудалтай улс төрийн намуудад болон намаас санхүүгийн ихээхэн нөөц боломжтой нэр дэвшигчдэд давуу тал олгож буйг тэмдэглэсэн байна.¹¹²

МУИХСтХ-ийн 2023 оны нэмэлт өөрчлөлтөөр нэр дэвшигчийн “А” самбарыг болиулж нэгдсэн самбар байршуулан зардлыг орон нутгийн засаг захиргаанаас гаргах, ухуулагчийн тоог цөөрүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиас хэтрэхгүйгээр урамшууллыг олгох, тээврийн хэрэгслийн тоог хоёр дахин бууруулах, хэвлэмэл материалын тоог цөөрүүлэх өөрчлөлтийг баталж,¹¹³ телевиз, радиогийн мэтгэлцээнийг үнэ төлбөргүй зохион байгуулах, цахим сурталчилгааны зардал нийт зардлынхаа 15 хувиас хэтрэхгүй байх, сум, дүүргийн Засаг дарга тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулах нэгдсэн самбарыг бэлтгэж, байршуулах ажлыг зохион байгуулах зэргээр сонгуулийн зардлыг бууруулах боломжийг бүрдүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлыг бууруулах зорилтыг дэвшүүлсэн.¹¹⁴

Сонгуулийн зардлыг бууруулах МУИХСтХ¹¹⁵, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн¹¹⁶ зорилт, арга хэмжээ МУИХ-ын тойргийг томсгож баталсан МУИХ-ын тогтоолын¹¹⁷ улмаас үр нөлөөгүй болсон тул сонгуулийн зардлын хэмжээг тооцох аргачлал, хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлан зохицуулах, АНСДИТХСтХ-д сонгуулийн зардлыг бууруулах талаар тусгаагүй тул холбогдох заалтыг тусгаж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Улс төрийн намд УТНтХ-д заасан шаардлага хангасан нөхцөлд төрөөс санхүүжилт болон шууд бус дэмжлэг үзүүлэхээр хуульчилсан нь ач холбогдолтой.

Төрийн санхүүжилтийг жил бүр болон дөрвөн жилд нэг удаа гэсэн хоёр хэлбэрээр олгохоор заасан. Мөн сонгуулийн хууль тогтоомжид заасан нэр дэвшигчийн хүйсийн квотоос илүү нэр дэвшүүлсэн эмэгтэй улс төрчийн болон хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоонд санхүүжилт олгохоор зохицуулсан.

СЕХ-ны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Журам батлах тухай” 209 дүгээр тогтоолоор “Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам”-ыг баталсан нь хуулийн хэрэгжилтийг хангахад чухал алхам болжээ.

¹¹² СЕХ, “Сонгуулийн боловсрол” сэтгүүл, 2024/4 дугаар, 45-46 дахь тал

¹¹³ Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан, МУИС-ийн Улс төр судлал, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль, Төрийн байгуулал судлал, №6, УБ, 2024 он, 76 дахь тал.

¹¹⁴ “МУИХ-ын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлах тухай 59 дүгээр тогтоол. Зорилт 1.4.Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахуйц эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлэх, сонгуулийн болон сонгуулийн бус үеийн санхүүжилтийг ил тод болгож, сонгуулийн зардлыг бууруулан иргэний сонгох, сонгогдох эрхийг хамгаалах, нэр дэвшигчийг өрсөлдөх тэгш боломжоор хангана, 1.4.4.Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлыг бууруулна”.

¹¹⁵ МУИХСтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.2 дэх хэсэгт “Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох аргачлал нь сонгуулийн зардлыг бууруулахад чиглэх бөгөөд сонгуулийн нутаг дэвсгэрийн хэмжээ, байршил, өрхийн болон сонгогчийн тоо, энэ хуульд заасан бусад шаардлагад үндэслэнэ. Аргачлалыг төрийн аудитын дээд байгууллагын саналаар Сонгуулийн ерөнхий хороо батална” гэжээ.

¹¹⁶ МУИХ-ын 2023 оны 06 сарын 30-ны өдрийн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” батлах тухай 59 дүгээр тогтоол.

¹¹⁷ МУИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” 112 дугаар тогтоолоор сонгуулийн тойргийг томсгож баталсан.

УТНТХ-ийн шинэчилсэн найруулгад нам, эвсэлд төрийн санхүүжилтийг 2 төрлөөр буюу жил бүр болон дөрвөн жилд нэг удаа олгох зохицуулалтын дагуу МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дүнд УИХ-д 68 суудал авсан Монгол Ардын Намд 2,819.7 сая төгрөг, 42 суудал авсан Ардчилсан Намд 2,173.0 сая төгрөг, 8 суудал авсан ХҮН намд 993.6 сая төгрөг, 4 суудал авсан Үндэсний Эвсэлд 446.1 сая төгрөг, 4 суудал авсан Иргэний Зориг Ногоон Намд 455.4 сая төгрөг, Шинэ нэгдсэн эвсэлд 312.4 сая төгрөг, Үнэн ба Зөв намд 250.0 сая төгрөг буюу нийтдээ 7,450.6 сая төгрөг олгохоор байна.¹¹⁸

Улс төрийн намд төрөөс олгох санхүүжилтийг зарцуулах зориулалтыг тодорхой болгож хуульчилсан нь эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжихэд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Харин АНСДИТХСтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг МУИХ-аар хэлэлцсэн боловч батлагдаагүй бөгөөд уг хуульд эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн талаар нарийвчлан тусгах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

АСДҮОУХ-ээс 2018 онд Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээний дүгнэлт зөвлөмжид¹¹⁹ “...төрийн санхүүжилтийг сонгуулийн зардал болон намын өдөр тутмын бусад зардлыг нөхөх зорилгоор сонгуулийн амжилтад нь үндэслэн (тухайлбал, нийт сонгогчдын 2-3 хувийн санал авсан) МУИХ-д суудалтай эсэхээс үл хамааран намуудад хүртээмжтэй олгосноор улс төрд төлөөлөл нэмэгдэж, улс төрийн намуудын тэгш өрсөлдөх нөхцөл сайжирна” гэж дурдсаныг анхаарч үзэх нь зүйтэй байна.

Нам, эвсэл, нэр дэвшигч нарын сонгуулийн зардлын дансаа бүртгүүлэх, хандив өгөхийг хориглосон этгээдээс¹²⁰ өгсөн хандив, хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгаагүй хандивыг хандивлагч нарт буцаан шилжүүлэх үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Сонгуульд оролцсон нам, эвсэл давхардсан тоогоор 142 хуулийн этгээдээс 3,311.4 сая төгрөгийн хандив авчээ. Гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, байгуулагдаад 1 жил болоогүй хуулийн этгээдүүдээс нийт 150.0 сая төгрөгийн хандив 3 намын хандивын дансанд орж ирснийг улсын орлогод төвлөрүүлсэн байна. Идэвхтэй эцсийн өмчлөгчөөр гадаад орны иргэн бүртгэгдсэн 5 хуулийн этгээдээс 120.0 сая төгрөгийн хандив авсан. Мөн хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгаагүй 1,700.2 сая төгрөгийн хандивыг хандивлагч нарт буцаан шилжүүлсэн байна.¹²¹

Нэр дэвшигчдийн хувьд МУИХСтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.4¹²² дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй нийт 14,215.6 сая төгрөгийн хандив 492 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд орсноос 13,642.6 сая төгрөгийг буцаан шилжүүлж, 11 нэр дэвшигч 23.4 сая төгрөгийн буцах хаяг тодорхойгүй хандивыг улсын төсөвт төвлөрүүлж, 47 нэр дэвшигч 549.6 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүй байна.¹²³

ТЕГ-аас ирүүлсэн тоон мэдээллээс үзэхэд МУИХ-ын сонгуульд нэр дэвшигч 141 иргэн зардлын дансны дугаараа бүртгүүлээгүй, банкны нэрийн мэдээллээ ҮАГ-т ирүүлээгүй бол

¹¹⁸ СЕХ “Сонгуулийн боловсрол” сэтгүүл, 2024/4 дугаар, 37 дахь тал.

¹¹⁹ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, “ННФ, Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ, санал зөвлөмж” УБ, 2018 он, 31 дэх тал.

¹²⁰ Гадаад улс, гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, 18 нас хүрээгүй хүн, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага, байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

¹²¹ <https://open.audit.mn/reportSingle/12272>

¹²² МУИХСтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсэгт Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.

¹²³ <https://open.audit.mn/reportSingle/12177>

47 нэр дэвшигч, 9 нам хууль зөрчсөн хандивыг буцаан шилжүүлээгүй байна. Орон нутгийн сонгуулиар 13 аймаг, нийслэлд нийтдээ 1566 нэр дэвшигч, 10 нам эвсэл данс бүртгүүлээгүй зөрчлийг, 329 нэр дэвшигч, 1 нам, эвсэл хандив зарцуулахтай холбоотой зөрчил гаргасан байна.

АСДҮОУХ-ээс 2018 онд Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээний мөрөөр "...Хуулийн этгээдээс авах хандивын хэмжээг багасгаж хувь хүний өгч болох хэмжээг нэмэх замаар улс төрийн нам иргэдтэйгээ холбоотой байж, тэдний өмнө хариуцлага хүлээдэг болох нөхцөлийг бүрдүүлэх" зөвлөмжийг өгсөн¹²⁴ боловч хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

Нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны үлдэгдэл, төлөгдөөгүй үлдсэн зардал, өглөг, зээлийг ямар эх үүсвэрээс санхүүжүүлэн барагдуулсан талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох зохицуулалт дутагдаж байна.

Сонгуулийн зардлын тайланд тусгасан сонгуулийн зардлын өр төлбөр төлөгдөхгүй, хуулийн этгээд, иргэний авлага барагдахгүй байх эрсдэлтэй тул барагдуулах эх үүсвэрийг тодорхой мэдээлж, тайлагнах, нэр дэвшигчдийн сонгуулийн үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн санхүүжилтээс зарцуулагдаагүй үлдэгдлийг хэрхэх талаар хууль, эрх зүйн орчин дутагдалтай байна. Сонгуулийн хууль тогтоомжид сонгуулийн зардлын дансны үлдэгдэл хөрөнгө болоод төлөгдөөгүй зардлыг тодорхой үе шаттай тайлагнах талаар зохицуулалт дутагдалтай байна.

Зардлын тайлантай холбоотой анхаарал татсаар ирсэн бас нэг асуудал нь сонгуульд өрсөлдөгч талуудын өр болон дансны үлдэгдлийн асуудал бөгөөд 2024 оны ээлжит сонгуулиар нэр дэвшигчдийн зардлын тайланд туссан өглөгийг авч үзвэл, 471.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 17.4 сая төгрөгийн бараа материалын өглөгтэй, нам, эвслийн хувьд 2,191.8 сая төгрөгийн өглөгтэй байна.¹²⁵

Энэ харилцааг хууль тогтоомжоор тодорхой болгож зохицуулах шаардлагатай байна.

Сонгуулийн зардлын тайлагналт, хяналт ба нээлттэй, ил тод байдлыг хангах талаар сонгуулийн болон холбогдох хууль тогтоомжид заасан боловч сонгуульд өрсөлдсөн нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланг ирүүлдэггүй, алдаатай тайлагнадаг зөрчлүүд нийтлэг байна.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 19 нам, 2 эвслээс 3 нам сонгуулийн зардлын тайлангаа УАГ-т ирүүлээгүй.

МУИХ-ын сонгуулийн 13 тойрогт нийт 19 нам, 2 эвслээс 927, бие дааж 42, нийт 969 иргэн нэр дэвшсэн бөгөөд төрийн аудитын дээд байгууллагад 820 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн бөгөөд 149 нэр дэвшигч тайланг ирүүлээгүй байна.

МУИХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл нийт 12,898.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 14,941.0 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулж, харилцах дансны үлдэгдэл 3.9 сая төгрөг, төлөгдөөгүй нийт 2,191.8 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.¹²⁶

Нийт 681 нэр дэвшигч сонгуулийн зардлын эх үүсвэрт нам, эвслийн хөрөнгөөс 1,353.3 сая төгрөг, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс 20,364.0 сая төгрөг, мөнгөн хандиваар 71,132.8 сая төгрөгийн, мөнгөн бус хандиваар 770.2 сая төгрөг нийт 93,620.3 сая төгрөгийн эх үүсвэр, санхүүжилт бүрдүүлж, 93,574.5 сая төгрөгийн зардал гарган, 471.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн, 17.4 сая төгрөгийн бараа материалын, 532.3 сая төгрөгийн өглөгийн

¹²⁴ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, ННФ, Монголын улс төрийн санхүүжилтийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ, санал зөвлөмж" УБ, 2018 он, 30 дахь тал.

¹²⁵ <https://open.audit.mn/reportSingle/12272>

¹²⁶ <https://open.audit.mn/reportSingle/12272>

үлдэгдэлтэй, 139 нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд огт зардал гаргаагүй гэж тайлагнажээ.¹²⁷

ҮАГ-аас МУИХ-ын сонгуулийн нэр дэвшигчид холбогдох 241, нам, эвсэлд холбогдох 9, нийт 250 зөрчлийн шинжтэй мэдээллийг шийдвэрлүүлэхээр ТЕГ-т хүргүүлжээ. ТЕГ үүнээс нэр дэвшигчид холбогдох 120 зөрчлийг шийдвэрлэж, 130 зөрчлийг үргэлжлүүлэн шалгаж байна. Мөн орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбогдуулан нэр дэвшигчид холбогдох 1,895 зөрчлийн мэдээлэл, нам, эвсэлд холбогдох 11 зөрчлийн мэдээллийг хүргүүлсэн байна. Үүнээс 2025 оны 03 сарын байдлаар 401 зөрчлийг шалган шийдвэрлэж, 160 зөрчлийн шинжтэй мэдээллийг шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх шатанд, 1,345 зөрчлийн шинжтэй мэдээллийг шалгах ажиллагааг хэрэгжүүлэхээр харьяалах аудитын газар, прокурорын байгууллагаас мэдээлэл, зөвлөгөө авах, баримт гаргуулах ажиллагаа хийгдэж байна.¹²⁸

Сангийн яам ҮАГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу Сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргаж ирүүлээгүй 149 зөрчлийн шинжтэй мэдээллээс 49 нэр дэвшигчийн холбогдох гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 100 нэр дэвшигчдэд холбогдох зөрчлийг шалгаж байна. Мөн сонгуулийн сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайлангаа ирүүлээгүй 112 зөрчлийн шинжтэй мэдээллээс 21 нэр дэвшигчийн холбогдох гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, 1 нэр дэвшигчийн зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож, 3 нэр дэвшигчид 60.0 сая төгрөгийн торгууль оногдуулж, 87 нэр дэвшигчид холбогдох зөрчлийг шалгаж байна.¹²⁹

ҮАГ-аас нэр дэвшигч, нам эвсэлд холбогдох 2,156 зөрчлийг ТЕГ-т шилжүүлснээс үзэхэд ҮАГ сонгуулийн санхүүжилт, зардлыг хянах хуулиар хүлээсэн үүрэгтэй боловч, зөрчилд хориг арга хэмжээ авах эрх мэдэлгүй, харин мэдээллийг холбогдох байгууллагууд руу шилжүүлэн шийдвэрлүүлж байгаа нь сонгуулийн зардлын тайлантай холбоотой зөрчлүүдийг арилгуулах, хүлээлгэх хариуцлагыг үр дүнтэй болгох шаардлагатайг харуулж байна.

Сангийн сайд, СЕХ-ны 2024 оны “Журам батлах тухай” А/243, 208 дугаар хамтарсан тушаал, тогтоолоор “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”-ыг баталж, журмыг танилцуулах, хэрэгжүүлэх талаар 2025 оны 1 дүгээр сард улс төрийн намуудын төлөөлөлд сургалт зохион байгуулж, зааварчилгаа өгсөн¹³⁰ боловч 2025 оны 03 сарын байдлаар Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй 37 намаас 10 нам санхүүгийн жилийн эцсийн тайланг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй¹³¹ байгаа нь журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх, намд тооцох хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улс Ази тивээс анх удаа Нээлттэй Засгийн түншлэл (OGP)-ийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хангах Сорилтод нэгдэж, 2025 оны 2 дугаар сард гэрчилгээгээ гардан авсан нь улс төрийн намын санхүүжилтийг ил тод байдлыг хангахад чухал алхам болжээ.¹³²

¹²⁷ <https://open.audit.mn/reportSingle/12272>

¹²⁸ ТЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/762 дугаар албан бичиг

¹²⁹ Сангийн яамны 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02/2286 дугаар албан бичиг

¹³⁰ <https://m-election.mn/news/17274137732091&id=1737438302876046>

¹³¹ СЕХ-ны цахим хуудастаа 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр байршуулсан мэдээллээс үзэхэд Улс төрийн намууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2025 оны 2 дугаар сарын 10-ны дотор СЕХ-нд ирүүлэхээр Улс төрийн намын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дэх хэсэгт заасан бөгөөд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн намаас 27 нь санхүүгийн жилийн эцсийн тайлангаа хуулийн хугацаанд ирүүлжээ. Санхүүгийн жилийн эцсийн тайлангаа дараах намууд ирүүлээгүй байна. Эх орон нам /ЭОН/, Монголын Либерал Нам /МЛН/, Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нэгдсэн нам /МЭҮНН/, Хамуг Монгол Хөдөлмөрийн Нам /ХМХН/, Тусгаар Тогтнол, Эв Нэгдлийн Нам /ТТЭНН/, Монгол Хүний Төлөө Нам /МХТН/, Миний Монгол Нам /ММН/, Монгол Шинэчлэл Нам /МШН/, Зүй Ёс Нам /ЗЁН/, Ардчилал шинэчлэлийн нам /АШН/.

¹³² Төр, засгийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, иргэдийн оролцоог дээшлүүлэх, авлигын эсрэг тэмцэх, нээлттэй засгийн үйл ажиллагааг цахимжуулах замаар дэмжих олон улсын санаачлага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2011 оны чуулганаар байгуулагдсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг олон улсын конвенци (United Nations Convention Against Corruption (UNCAC))-ийн улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг хэрэгжүүлэх тухай 7.3 дахь заалтын

ЕАБХАБ/АИХЭГ 2024 оны эцсийн тайландаа¹³³ "...АИХЭГ-аас өмнө нь зөвлөмжүүд гаргаж байсан ч сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн орчинд хяналт тавих үр дүнтэй механизм анхааруулах арга хэмжээ авах зохицуулалт хангалтгүй байна. Ил тод байдлыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд кампанит ажлын санхүүжилтийн эрх зүйн орчныг чангатгаж, санхүүжилттэй холбоотой зөрчилд тохирохуйц хариуцлага тооцох цогц механизмыг бий болгож хэрэгжүүлэх ёстой" гэж зөвлөсөн.

Жагсаалтаар нэр дэвшигчдийн хувьд МУИХСтХ-ийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт зааснаар нам, эвслийн сонгуулийн сурталчилгаанд зориулан хандив өгч болох бөгөөд нэг нэр дэвшигчийн өгсөн хандивын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон нэр дэвшигчээс тойрогт зарцуулах зардлын хэмжээний дунджаас хэтрэхгүй байна гэж зохицуулсан боловч уг хандивыг сонгогч дэмжигчдээсээ хандив байдлаар бүрдүүлэх боломжтой эсэх асуудлыг хуулиар зохицуулаагүй байна.

1.11 СОНГУУЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧСӨН ТАЛААРХ ГОМДОЛ, МАРГААН ШИЙДВЭРЛЭЛТ

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар эрх зөрчигдсөн эсэхийг хянан шийдвэрлэх, эрхийг сэргээх нь төрийн байгууллагын үүрэг юм. Сонгуулийн үйл явцад холбогдох зөрчил, гэмт хэргийн талаар гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжтой байх нь процессын шударга ёсыг хангах, сонгуулийн үр дүн, үйл явцын талаарх олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн талаарх гомдол, маргааныг хүлээж авах харьяаллын байгууллага тодорхой бөгөөд харин гомдлыг шалгаж шийдвэрлэх хугацаа ялгаатай, хууль тогтоомжийн нэгдмэл хэрэглээний асуудлууд байна.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дугаар зүйлд заасан сонгуулийн хуулийг зөрчих 39 төрлийн зөрчлийг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу хянан шийдвэрлэхээр хуульчилсан. Мөн МУИХСтХ-д сонгуулийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллагаар бүх шатны сонгуулийн хороод¹³⁴, Харилцаа холбооны зохицуулах хороо¹³⁵, Төрийн аудитын дээд байгууллага¹³⁶, Цагдаагийн байгууллага¹³⁷, Захиргааны хэргийн шүүх, дээд шүүх¹³⁸, Үндсэн хуулийн цэц¹³⁹, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (хуучин нэр)¹⁴⁰, Улсын бүртгэлийн ерөнхий газар¹⁴¹ Тагнуулын байгууллага¹⁴² байхаар зохицуулжээ.

Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцоор баталгаажсан сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн талаар МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс нийт 2,649 гомдол мэдээллийг төрийн холбогдох байгууллагад гаргасны 1,428 нь МУИХ-ын сонгуультай, 1,221 нь орон нутгийн Хурлын сонгуультай холбоотой байна.

хэрэгжилтийг идэвхжүүлэхээр Транспэрэнси интернэшнл байгууллага, Нээлттэй засгийн түншлэл хамтран санаачилж, тогтоолын төслийг боловсруулаад байгаа. Монгол Улс уг тогтоолын төслийг дэмжин батлуулах байр суурь баримталж байгаа орнуудын нэг юм.

¹³³ ЕАБХАБ/АИХЭГ-ын эцсийн тайлан, 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

¹³⁴ Сонгуулийн зохион байгуулалттай холбоотой өргөдөл, гомдол

¹³⁵ Радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны талаарх

¹³⁶ Сонгуулийн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд

¹³⁷ Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг

¹³⁸ Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг

¹³⁹ Санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргаан

¹⁴⁰ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах талаарх


¹⁴¹ Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг

¹⁴² Саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах үйл ажиллагааны хамгаалалтын талаарх

Хүснэгт 1.8 МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо


Д №	Нэрс	Монгол Улсын Их Хурлын сонгуультай холбоотой			Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой		
		Нийт	Үүнээс		Нийт	Үүнээс	
			Шилжүүлсэн	Шийдвэрлэсэн		Шилжүүлсэн	Шийдвэрлэсэн
1	ХЭҮК	3	2	1	2		2
2	СЕХ	85	56	29	35	8	27
3	ЗХДЗШШ	16	11	5			
4	ЗХАШШ	10	8	2			
5	ТЕГ	17	12	5	4	4	
6	ХХЗХ	31	24	7			
7	МЭГ				3	3	
8	УБЕГ	3	3				
9	ЦЕГ	1263	44	88	1177	24	54
	Нийт	1428	160	137	1221	39	83

Бүдүүвч 1.14 МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо



ЦЕГ МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үед 1,263 гомдол, мэдээлэл хүлээн авсны **756 нь нийслэлээс, 507** орон нутгаас ирүүлсэн байна. Эдгээрээс гэмт хэргийн шинжтэй **474** гомдол хүлээн авснаас **412** буюу 86 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, **29** буюу 6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, **33** буюу 7 хувийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад нь шилжүүлсэн байна. Зөрчлийн шинжтэй **789** гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс **663** буюу 84 хувийг нь хүлээн авахаас татгалзсан, **56** буюу 8 хувьд нь зөрчлийн хэрэг нээсэн, 11 буюу 2 хувийг нь холбогдох байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж, **59** буюу 8 хувийг нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна.

Бүдүүвч 1.15 Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс гаргасан гомдол, маргааны тоо



Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй **1,177** гомдол, мэдээлэл бүртгэгдсэн. Үүнээс гэмт хэргийн хэргийн шинжтэй **411** гомдол хүлээн авснаас **375** буюу 91 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, **23** буюу 5 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, **13** буюу 3 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн байна. Зөрчлийн шинжтэй **766** гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс **701** буюу 91 хувийг нь хүлээн авахаас татгалзаж, **32** буюу 4 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, **9 буюу 1 хувийг** харьяаллын дагуу шилжүүлж, хялбаршуулсан журмаар **24** буюу 3 хувийг нь шийдвэрлэсэн байна.

МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотой 2,649 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний **2,440** гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллага шалгаснаас **2,151** буюу 88 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, **66** буюу 3 хувийг харьяалах байгууллагад шилжүүлж, **83** буюу 4 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ.¹⁴³

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн агуулгаас харахад 40 хувь нь сонгуулийн үеэр нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах эсвэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд тараасан, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн, сонгуулийн хорооны ажилд саад хийх, сонгуулийн байранд танхайрсан, хэрүүл маргаан үүсгэсэн, ухуулагчийн эрх чөлөөнд халдсан, мөнгө, эд зүйл тараасан бол зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 30 хувь сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлээгүй болон дууссан үед цахим орчинд сурталчилгаа явуулсан, 20 хувь сонгогчдын саналыг татах зорилгоор мөнгө эд бараа өгөх гэрээ, хэлцэл хийх, амлалт өгсөн, сонгуулийн сурталчилгааны зурагт самбар болон сурталчилгааны материалыг санаатайгаар устгаж, бохирдуулсан, цоолох, эвдсэн гэх зүйчлэлтэй байна.¹⁴⁴

Сонгуулийн үед иргэдээс цагдаагийн байгууллагад эзэн холбогдогч нь тодорхойгүй, нотлох баримтгүй, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулаагүй, илтэд хуурамч дуудлага мэдээлэл өгдөг гэжээ. Цагдаагийн байгууллагаас ирсэн гомдол, мэдээллийг шалгах ажиллагаа явуулан, хянан үзэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.8 дугаар зүйлд заасны дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлдэг байна. Эрх бүхий албан тушаалтны гаргасан саналын хүрээнд

¹⁴³ ЦЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 03/41 дүгээр албан бичиг

¹⁴⁴ Мөн тэнд

прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Прокурорын хяналтын явцад, эсхүл энэ хуулийн 30.8 дугаар зүйлийн 1.2-т заасан саналыг үндэслэж прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай тогтоол гаргана” гэж заасны дагуу шийдвэрлэж байна.

Тохиолдол 1.20
УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргаагүй. Учир нь УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар мөнгө тараасан үйлдлийг баримтын хамт төрийн байгууллагад мэдэгдсэн ч хяналт шалгалт хийдэггүй юм билээ.
(ХҮН намын Удирдах зөвлөлийн гишүүнтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Тохиолдол 1.21
Манай намаас сонгуулийн сурталчилгааны үеийн хууль бус үйлдлийн талаар цагдаагийн байгууллагад өмнө нь өргөдөл, гомдол гаргаж байсан. Тухайлбал, мөнгө өгч, авч байгаа талаар нотлох баримтын хамт цагдаагийн байгууллагад өргөдөл гаргахад хэрэг үүсгээгүй. Иймд энэ удаагийн сонгуулиар өргөдөл, гомдол гаргаагүй.
(Шинэ намын эрх бүхий албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Цагдаагийн байгууллагад гаргасан гомдол, мэдээллийн 86-90 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 10 орчим хувийг шийдвэрлэсэн байна. МУИХ-ын сонгуульд өрсөлдөж байгаа зарим улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн төлөөлөл гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нотлох баримтын хамт гаргасан ч цагдаагийн байгууллага хэрэг үүсгэдэггүй, шалгадаггүй тул гомдол мэдээлэл гаргаагүй гэж судалгааны тайланд дурдсан байна.¹⁴⁵

Сонгуулийн хууль тогтоомжоор 9 байгууллага харьяаллын дагуу гомдол, мэдээлэл хүлээж авч, шалгаж шийдвэрлэхээр хуульчилсан ч СЕХ-оос 47, МЭГ-аас 3, Тагнуулын ерөнхий газраас 11, ХХЗХ-ноос 20 гомдол мэдээллийг Цагдаагийн байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн байгаа нь МУИХ, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үеэр иргэдээс сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн талаар гаргасан нийт 2,646 гомдол, мэдээллийн 2,440 нь буюу 92,2 хувийг Цагдаагийн байгууллага, үлдсэн 7,8 хувийг бусад байгууллага шалгажээ.

Хуулиар тогтоосон харьяаллын дагуу СЕХ 29, Тагнуулын ерөнхий газар 5, МЭГ 2024 оны сонгуулийн жилд цахим орчин ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулж, нийтэлсэн 79 зөрчлийг, ХХЗХ 7, УБЕГ 3 гомдол, мэдээллийг тус тус шийдвэрлэсэн байна.

Шигтгээ 1.10
УБЕГ-аас нам, эвсэл, ТББ сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхтэй холбоотой хүндрэл, иргэний оршин суух хаягт бүртгэгдсэн өөр иргэнийг шалгуулах, зохиомол хаяг үүсгэн сонсогч бүртгэсэн зэргийг мэдээлж, мэдээллийн нэгдсэн санд шалгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Тус уулзалтаар нийт 11 иргэний мэдээллийг иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримттай тулган шалгаж зөрчилгүйг нотолж шийдвэрлэсэн.
(Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/3629 дүгээр албан бичгийн мэдээллээс)

Шударга сонгуулийн үр дүн нь сонгуулийн бүх үе шатанд иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн хангахтай шууд холбоотой. Иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх нь Үндсэн хуульд заасан төрийн үндсэн үүрэг болно.

¹⁴⁵ “Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаа ба хүний эрхийн зөрчил” мониторингийн тайлан, УБ, 84 дэх тал

Шигтгээ 1.11

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеэр Ховд аймгийн Булган сумын 7119 ширхэг, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 515 ширхэг саналын хуудас алдаатай хэвлэгдсэн шалтгаанаар саналын хуудсыг дахин хэвлэж хүргүүлжээ.

(Тагнуулын ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 09/313 дугаар албан бичгийн мэдээллээс)

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор гомдол, маргаан хүлээж авах харьяалал тодорхой боловч хүлээж авсан байгууллагууд гомдол, маргааныг хүлээж авахаас татгалзсан үндэслэл, шийдвэрлэлтээ гомдол гаргагч болон олон нийтэд мэдээлэх хэрэгцээтэй байна.

СЕХ-ны зарим шийдвэр иргэний сонгогдох эрхийг зөрчсөн талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж сонгогдох эрхээ сэргээлгэсэн байна.

Сонгуулийн маргааныг тухайн нутаг дэвсгэрийг харьяалах сонгуулийн хороо хүлээн авч шийдвэрлэх эрх зүйн зохицуулалттай. Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмын дагуу ажилладаг бөгөөд сонгуулийн хорооны шийдвэртэй холбогдуулан дээд шатны сонгуулийн хороонд гомдол гаргаж, сонгуулийн хорооны шийдвэрт холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэдэг.

СЕХ-нд сонгуулийн тухай хууль зөрчсөн, нэр дэвшигчтэй холбоотой, нэр дэвшигчээр бүртгэхгүй байх, нэр дэвшихээс татгалзсан, хууль бус сурталчилгаа явуулсан талаар 85 өргөдөл, гомдол хүлээн авснаас, 56 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 29 гомдлыг шийдвэрлэсэн байна.¹⁴⁶

СЕХ-нд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн 19 нам, 2 эвслээс сонгуулийн тойрогт нэр дэвшүүлэх 985, жагсаалтаар нэр дэвшүүлэх 385, бие даан нэр дэвшүүлэгч 46, нийт 1,416 хүний баримт бичгийг ирүүлжээ.

СЕХ-ны хуралдаанаар МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс нэр дэвшүүлсэн 1,299, бие даан нэрээ дэвшүүлсэн 42, нийт 1,341 хүнийг нэр дэвшигчээр бүртгэж, үнэмлэх олгосон байна. СЕХ-оос нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан 156 хүний 95 буюу 61 хувь нь зөрчлөө арилган шаардагдах баримт бичгийг хүргүүлж, нэр дэвшигчээр бүртгэгджээ.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан Шатны шүүх орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуультай холбоотойгоор 10 нэхэмжлэл хүлээн авснаас 1 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 1 нэхэмжлэл бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй улмаас буцааж, 8 нэхэмжлэлд захиргааны хэрэг үүсгэжээ.¹⁴⁷

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үед нам, нэр дэвшигчдийн бүртгэлтэй холбоотой 16 нэхэмжлэл хүлээн авснаас 6 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 5 нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 5 нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгож, нэр дэвших боломжоор хангаж шийдвэрлэжээ¹⁴⁸.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үед нэр дэвшигчийн бүртгэхээс татгалзсан 5 нэхэмжлэлийг хүлээн авч, СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгосны дагуу дээрх 5 иргэний сонгогдох эрх баталгаажсан байна.

¹⁴⁶ СЕХ-ны 2025 оны 3 дугаар сарын 10-ны 3-/101 дүгээр албан бичиг

¹⁴⁷ Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 175 дугаар албан бичиг

¹⁴⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 65 дугаар албан бичиг

СЕХ-ны нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай алдаатай шийдвэрийн улмаас зарим нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаагаа хоцорч эхлүүлсэн, зарим нь сонгуулийн сурталчилгаа дуусах үед нэр дэвшигчийн үнэмлэхээ гардаж авсан байна.¹⁴⁹

Тохиолдол 1.22

Шүүх хуралдаан 2024.06.19-ний өдөр болж, миний нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр мөн өдөртөө бичгээр гарсан. СЕХ 2024.06.21-ний өдөр хуралдаад намайг бүртгэх шийдвэр гаргасан ч надад шийдвэр, үнэмлэхийг өгөхгүй байсан. СЕХ-той холбогдоход “гарын үсэг дутуу, дарга хуралтай байна” гэх зэргээр нэг даргаас хамааралтай мэт хариу өгч байсан. Би СЕХ-ны үүдэнд хүлээж байгаад 2024.06.24-ний өдрийн ажлын цаг дуусаж байхад буюу 18:00 цагийн үед нэр дэвшигчийн үнэмлэхээ авсан. Сурталчилгаа явуулж чадаагүй.

(Үндэсний эвслээс жагсаалтаар нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

МУИХСтХ-д сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааныг сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ гэж заасан нь иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг зөрчиж байгаа тул сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэх эрх бүхий этгээд нь иргэний сонгогдох эрхийг бүрэн хангах зорилгоор тухайн гомдол, маргааныг сонгуулийн үйл явц дуусахаас өмнө шуурхай, шударга, хүртээмжтэй байдлаар хянан шийдвэрлэхээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

МУИХСтХ, АНСДИТХСтХ-д сонгох, сонгогдох эрх зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяаллыг тодорхой тусгаж өгснөөр шүүх сонгуультай холбоотой маргааныг цөөн хоногийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэж байгаа боловч сонгуулийн сурталчилгааны богино хугацаатай нийцэхгүй, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг бүрэн хангаж чадахгүй байна.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх журмыг тусгайлан тогтоож, ердийн бусад захиргааны хэрэг маргаантай харьцуулахад богино хугацаанд хянан шийдвэрлэхээр хуульчилсныг сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хугацаатай уялдуулах шаардлагатай байна.

Сонгуулийн санал хураалтын дүн гарсны дараа зөрчигдсөн эрхийг сэргээх шийдвэр гарсан тохиолдолд хэрхэх талаар хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй. Иргэний сонгогдох эрх зөрчигдсөнийг шүүхийн шийдвэрээр тогтоосон тохиолдолд, уг зөрчлийг төр эсвэл эрх бүхий албан тушаалтан арилгах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна.

Тохиолдол 1.23

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21 дэх хэсэгт “Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны дагуу эрх бүхий улсын байцаагч иргэн “А”-г хуулиар зөвшөөрөөгүй хандив болох “100,000” төгрөгийг буцаан шилжүүлээгүй байна гэх зөрчилд зөрчлийн хэрэг нээж, 10.0 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулсан. Мөн иргэн “Э”-г хуулиар зөвшөөрөөгүй хандив болох 33.9 сая төгрөгийн буцаан шилжүүлээгүй байна гэх зөрчилд зөрчлийн хэрэг нээж, шийтгэлийн хуудсаар 10.0 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан байна.

(Татварын улсын байцаагчийн оногдуулсан шийтгэлээс)

¹⁴⁹ “Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн” ТББ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаа ба хүний эрхийн зөрчил” мониторингийн тайлан, 51 дүгээр тал

Хүснэгт 1.9 Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн оногдуулах ял, шийтгэл

№	Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль
1	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.5 дугаар зүйл иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх 1.Иргэний сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд; сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа үйл ажиллагаанд зориуд саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 450,000-5,400,000	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэг “Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор аялал зохион байгуулсан, амралт сувилалд амраасан, ирээдүйд болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулсан, хэлцэл хийсэн ...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” 20,000,000-200,000,000
2	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 14.8 дугаар зүйл сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэрэг 1.Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” 450,000-5,400,000	Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 18. “Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад 18.1 дэх хэсэг хуульд зааснаас өөр хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа явуулсан, 18. 2. зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэн 18.3 сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт өгсөн, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашигласан.... бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” 20,000,000-200,000,000

Дээр хүснэгтэд ишилсэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар сонгуулийн хуулийг зөрчсөн гэмт хэрэг, зөрчилд ногдуулж буй торгуулийн хэмжээний ялгаатай байдал, түүнчлэн Зөрчлийн тухай хуульд “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.” гэж заасан боловч Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21 дэх хэсэгт хохирлын хэмжээнээс үл хамаарч ижил хэмжээний мөнгөн дүнгээр торгож байгаа нь шударга ёсны зарчим, гэм бурууд шийтгэл тохирсон байх зарчимд нийцэж буй эсэхийг анхаарах нь зүйтэй байна.

Цаашид иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг сэргээх, гэм хорыг арилгуулах, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон шийтгэл оногдуулах эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай.

МУИХ-ын 126 гишүүнийг холимог тогтолцоогоор сонгох сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлсэн нь МУИХ-д олон намын төлөөлөл суудал авах боломжийг нэмэгдүүлсэн, 32 эмэгтэй гишүүн, хөгжлийн бэрхшээлтэй 2 хүн улс төрийн намын жагсаалтаар сонгогдсон зэргээр нийгмийн бүлгүүдийн улс төрийн идэвх, оролцоог нэмэгдүүлэхэд түлхэц болсон, гадаадад байгаа иргэдийн сонгуульд оролцох, СЕХ санал хураалтын турш сонгогчдын ирцийн мэдээллийг хүйс болон насны ангиллаар нарийвчлан шууд дамжуулан олон нийтэд мэдээлж, санал өгөх хугацаа дуусмагц, сонгуулийн үр дүнг дамжуулж эхэлсэн, түүнчлэн иргэд, сонгуульд өрсөлдөж буй субъектүүдийн хууль ёсны төлөөлөл болон олон улсын

байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангасан зэрэг эерэг үр дүнгүүд гарсан сонгууль болж өндөрлөжээ.

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор нийт 19 нам, 2 эвсэл, нийт 1,341 нэр дэвшигч бүртгүүлсэн нь МУИХ-ын сонгуулийн түүхэнд хамгийн олон нам, эвсэл, нэр дэвшигч оролцсон, орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд аймаг, нийслэл, сум, дүүргийн 8031 мандатын төлөө 10 нам, 1 эвслээс 17,010, бие даан 268 нэр дэвшигч өрсөлдсөн онцлогтой сонгууль болжээ.

Сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, шууд, тэгш эрхийн үндсэн дээр саналаа чөлөөтэй, нууцаар гаргах үндсэн зарчмыг Монгол Улс тууштай хэрэгжүүлэн, олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэхийг зорьж ирсэн. Гэсэн хэдий ч эрх зүйн зохицуулалтын үр нөлөө, хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, хянах механизм, сонгогчдын боловсрол, мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал зэрэг нь Монгол Улсын иргэдийн сонгох, сонгогдох эрхэд тодорхой нөлөө үзүүлж буйг энэхүү бүлэгт тусгаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцууллаа.

II БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ӨМГӨӨЛӨГЧ, СЭТГҮҮЛЧИЙН
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй.

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт)

“Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалт)

“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт)

“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйл)

“Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2 дахь заалт)

“Хүн бүр ганцаар болон бусадтай эвлэлдэн нэгдэж, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүндэтгэн биелүүлэх явдлыг хөхиүлэн дэмжих, түүний төлөө тэмцэх эрхтэй”

(Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх үүргийн тунхаглал “Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал”-ын 1 дүгээр зүйл)

2.1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг хуульчлан тогтоож, тэдний эрх, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамгаалах механизм бий болсон. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль (ХЭХЭЗБтХ)-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо ажиллаж, уг хуулийн хэрэгжилт болон хүний эрх хамгаалагчийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, судалгаа хийж, жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд тусгах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хүний эрх, эрх чөлөө, нийтийн эрх ашгийг хамгаалахад үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхол хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчид, нийгмийн шударга ёсыг шаардах, үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн мэдэх эрхийг хангахын төлөө ажилладаг сэтгүүлч нь бусдын болон нийтийн эрх ашгийг хамгаалсан үйлдлээсээ шалтгаалж заналхийлэл, дарамт, шахалт, халдлагад өртөх, ял шийтгүүлэх, амь насаа алдах зэрэг эрсдэлтэй байна. Ялангуяа хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нь удирдлага болгодог хууль тогтоомжийг өмгөөлөгчдийн хувьд сайжруулах, сэтгүүлчдийн хувьд шинэчлэх хэрэгцээ байна. Ингэхдээ тэднийг ажлаа чанартай, хариуцлагатай хийх боломжийг бүрдүүлэхээс гадна аюулгүй байдлыг нь хангасан, алдаа гаргасан үед хариуцлагыг оновчтой оногдуулдаг механизмтай байх явдал чухал байгаа нь Комиссоос 2024 онд хийсэн “Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Иймээс энэ бүлэгт “Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааны үр дүнд тулгуурлан өмгөөлөгч, сэтгүүлчийн аюулгүй байдал, хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломж, баталгааг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, шийдлийг дэвшүүлж байна. Мөн Комисст хандаж хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн асуудлаар ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны дүгнэлт, Комиссын гишүүний зөвлөмж, хүний эрх хамгаалагчийн асуудлаар хүний эрхийн олон улсын гэрээний хороодоос Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж, олон улсын болон үндэсний бусад судалгаа шинжилгээний ажлын үр дүнг харьцуулан үзэж, дараах асуудлыг тусгалаа. Үүнд:

Нэгдүгээрт, Хүний эрх хамгаалагчийн аюулгүй байдал, хамгаалалтын талаарх олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, баримт бичгүүд болон өмгөөлөгч, сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагааны бодлого, хууль тогтоомжийг харьцуулан судалж, тэдэнд тулгардаг бэрхшээл, эрсдэлийг тодорхойлж, дүгнэлээ.

Хоёрдугаарт, өмгөөлөгч, сэтгүүлчтэй холбоотой кейс тохиолдлыг шинжлэн судалж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлийг хийхэд анхаарвал зохих асуудлын талаар саналаа тусгалаа.

Гуравдугаарт, өмгөөлөгч, сэтгүүлчтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн зарим эрүү, иргэний хэрэг, маргааны шийдвэрт дүн шинжилгээ хийж, дүгнэсэн болно.

Дөрөвдүгээрт, өмгөөлөгч, сэтгүүлчийг дарамт заналхийлэлээс хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдний аюулгүй байдлыг хамгаалах асуудлаар эрх зүйн дүгнэлт хийв.

2.2. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

2.2.1. Өмгөөлөгчтэй холбоотой олон улсын болон үндэсний бодлого, хууль тогтоомжийн хүрээ

Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг өмгөөллийн үйл ажиллагаа гэж ойлгох¹ бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд өмгөөлөгчөөс хуульд захирагдаж, эрх зүйн өргөн хүрээнд хууль зүйн мэргэжлийн ур чадвар гаргаж ажиллахыг шаарддаг онцлогтой болно. Иймээс өмгөөлөгч хүний эрхийн зөрчил, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг арилгуулах, шударгаар шүүгдэх эрхийг хангахад мэргэжлийн хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг хүний эрх хамгаалагч юм.

НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах хувь хүн, бүлэг, нийгмийн байгууллагуудын эрх, үүргийн тухай (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал) тунхаглалыг дэмжих зорилгоор 2024 онд боловсруулсан “Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал +25” баримт бичигт хүний эрх хамгаалагчдын эсрэг аливаа аюул заналхийлэл, халдлагыг шуурхай, бүрэн гүйцэд, хараат бус, шударгаар мөрдөн шалгах баталгааг хангах, хүний эрх хамгаалагчдын эсрэг зөрчил гаргасан тохиолдолд шүүхэд хандах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хариуцлага хүлээлгэх баталгааг хангах нь төрийн үүрэг байхаар тодорхойлсон².

Өмгөөлөгч нь хүний эрх хамгаалагчийн хувьд шүүх болон бусад байгууллагад үйлчлүүлэгчээ төлөөлж хууль ёс, хүний эрх, тэгш эрх, шударга ёсыг шаардах мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа төрийн болон төрийн бус бусад оролцогчдын шууд болон шууд бус дарамт шахалт, халдлага, айлган сүрдүүлэлтэд өртөх, амь насаа алдах, хууль бусаар баривчлагдах, хоригдох, эх орноосоо хөөгдөх зэрэг эрсдэлтэй тулгарах явдал дэлхийн улс орнуудад, тэр дундаа ардчилсан бус, мөргөлдөөн бүхий улс орнуудад нэмэгдсээр байна.³ Иймээс өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг аюул заналхийлэл, айлган сүрдүүлэлт, зүй бус хариуцлага, ял шийтгэлээс ангид байдлаар хэрэгжүүлэх баталгааг хангах асуудал чухал юм.

Олон улсын Хуульчдын холбооноос 1990 онд баталсан “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”-д “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдал” нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чухал баталгаа бөгөөд хуульчийн мэргэжлийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шууд болон шууд бус зохисгүй хязгаарлалт, шахалт, хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах шударга ёсны тогтолцоо зайлшгүй чухал⁴ болохыг онцлон тэмдэглэсэн.

Уг стандартад зааснаар хуульч нь мэргэжлийн тогтсон дүрэм, хэм хэмжээ, ёс зүйг баримтлан үүргээ биелүүлэхдээ үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн эрх бүхий байгууллага, олон нийтийн зүгээс ямар нэгэн дарамт шахалт, саадгүйгээр чөлөөтэй, нягт нямбай хэрэгжүүлэх⁵ бөгөөд хууль ёсны дагуу зөвлөсөн, төлөөлөн оролцсоных нь төлөө хуульчид эрүүгийн, иргэний, захиргааны, эдийн засгийн болон бусад шийтгэл, дарамт шахалт, заналхийлэлд өртөх ёсгүй⁶. Түүнчлэн шүүх болон захиргааны аливаа байгууллага

¹ Өмгөөллийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14859>

² Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал +25, Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал” (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал)-ыг дэмжих нь, 2024 он, 11 дэх тал. <https://ishr.ch/defenders-toolbox/resources/declaration-25/>

³ Шударга бус байдлын эсрэг тэсвэр хатуужил, Хуульчид хүний эрхийг хамгаалагчид болох нь. <https://www.freiheit.org/human-rights-resilience-against-injustice>

⁴ Олон улсын Хуульчдын холбооноос 1990 онд баталсан “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”. <https://www.ibanet.org/MediaHandler?id=F68BBBA5-FD1F-426F-9AA5-48D26B5E72E7>

⁵ “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”-ын 6 дугаар зүйл. <https://www.ibanet.org/MediaHandler?id=F68BBBA5-FD1F-426F-9AA5-48D26B5E72E7>

⁶ “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”-ын 8 дугаар зүйл. <https://www.ibanet.org/MediaHandler?id=F68BBBA5-FD1F-426F-9AA5-48D26B5E72E7>

тухайн нутаг дэвсгэрт хуульчийн үйлчлүүлэгчийнхээ өмнөөс оролцох эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах ёсгүй⁷ гэжээ.

Харин “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-д Засгийн газар нь арьс үндэс, арьс өнгө, угсаатны гарал, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал байдал, эд хөрөнгө, эдийн засгийн болон бусад байдлаар нь ялгаварлан гадуурхах гэх мэт аливаа төрлийн ялгаварлалгүйгээр нутаг дэвсгэрийнхээ харьяалалд хамаарах бүх хүмүүст хуульчдыг үр дүнтэй, тэгш хүртээмжтэй болгох үр ашигтай журам, хариу арга хэмжээний механизмыг хангах үүрэг хүлээнэ⁸ гэж заасан.

Дээрх баримт бичиг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах дараах баталгааг Засгийн газар баталгаажуулахаар заасан. Эдгээрт:⁹

- (а) аливаа айлган сүрдүүлэлт, чөдөр тушаа, зүй бус хөндлөнгийн оролцооноос ангид байдлаар хуульчийн мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг хангах; (б) эх орондоо болон гадаадад чөлөөтэй зорчих, үйлчлүүлэгчидтэйгээ зөвлөлдөх боломжтой байх; (в) хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн үүрэг, хэм хэмжээ, ёс зүйн дагуу хийсэн аливаа үйлдлийнхээ төлөө эрүүгийн, захиргааны, эдийн засгийн болон бусад шийтгэл хүлээхгүй байх, эсвэл тийм заналхийлэлд өртөхгүй байх;
- Чиг үүргээ хэрэгжүүлсний улмаас хуульчийн аюулгүй байдалд заналхийлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаар зохих ёсоор хамгаалуулах;
- Хуульчийн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө үйлчлүүлэгч, эсхүл үйлчлүүлэгчийн үйлдэлтэй холбоотой гэж үзэхгүй байх;
- Хуульчийг үндэсний хууль тогтоомж, практикт нийцүүлэн эдгээр зарчмын дагуу хуульчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасаагүй бол шүүх болон захиргааны ямар ч байгууллага үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хуульчийн эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж болохгүй;
- Шүүх, шүүх хуралдаан, эсхүл хууль зүйн болон захиргааны бусад байгууллагад мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд бичгээр болон амаар өгсөн холбогдох мэдэгдлийнхээ төлөө иргэний болон эрүүгийн хариуцлагаас ангид байх;
- Хуульч өөрийн үйлчлүүлэгчдээ хууль зүйн үр дүнтэй туслалцаа үзүүлэхэд шаардлагатай зохих мэдээлэл, баримт, бичгийг өөрийн мэдэл буюу хяналтад байлгаж байгаа эрх бүхий байгууллага хугацаанд нь мэдээлэл олж авах баталгааг хангах бөгөөд боломжит хурдан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй;
- Хуульч болон тэдний үйлчлүүлэгчидтэй мэргэжлийн харилцааны хүрээнд хийсэн бүх харилцаа холбоо, зөвлөлдөөний нууцыг Засгийн газар хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ зэрэг болно.

Хүн бүр өөрийгөө өмгөөлөх, мөн өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах үндсэн эрхтэй бөгөөд энэхүү эрхийг шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд олон улсын хүний эрхийн эрх зүйгээр хамгаалж, баталгаажуулсан¹⁰.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө

⁷ “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”-ын 9 дүгээр зүйл. <https://www.ibanet.org/MediaHandler?id=F68BBBA5-FD1F-426F-9AA5-48D26B5E72E7>

⁸ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнүүдтэй харилцах талаар 1990 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс 09 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд Куба Улсын Гавана хотод хуралдсан НҮБ-ын 08 дугаар чуулганаар “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-ыг баталсан.

<https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-role-lawyers>

⁹ “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-ын 16-22 дугаар зүйл.

<https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-role-lawyers>

¹⁰ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217 А (III) тогтоолоор Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан. <https://legalinfo.mn/mn/detail/1271>

ИБУТЭОУП-ыг Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1257>

өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” гэж Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрхийг баталгаажуулсан¹¹.

Өмгөөллийн тухай хууль нь өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүрэг, өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг хангах суурь хууль юм. Монгол Улс анх 1994 онд Өмгөөллийн тухай хуулийг баталж, 2002 онд шинэчлэн найруулсан. Гэвч энэ төрлийн харилцааг 2012 онд батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах болсонтой холбоотойгоор Өмгөөллийн тухай хуулийг хүчингүй болгосон. Хууль зүйн салбарын хэмжээнд өргөн хүрээний маргаан, саналын зөрүүтэй байсан хэдий ч УИХ-аас 2019 онд Өмгөөллийн тухай хуулийг дахин баталж эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсад өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг Өмгөөллийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай зэрэг хуулиар зохицуулж байна. УИХ-аас 2021 онд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг баталсан нь өмгөөлөгч хүний эрх хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрх хамгаалагчийн хувьд эрх зүйн нэмэлт баталгаагаар хангагдаж байгаагаараа чухал ач холбогдолтой болсон.

Хэдийгээр Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчийн эрх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг хангах талаар тодорхой зохицуулсан боловч уг баталгааг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй. Зөрчлийн тухай хуулийн 15.29 дүгээр зүйлээр “Өмгөөллийн тухай хууль зөрчих” гэсэн заалт өмгөөлөгчид хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмгөөлөгчийг зөрчлийн хэрэгт холбогдуулан цагдаагийн байгууллагаас шалгах нөхцөл бүрдсэн гэж үзэхээр байна. Энэ нь НҮБ-ын “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-д заасан хуульч, өмгөөлөгчийн бие даасан байх зарчмыг алдагдуулж болзошгүй байна.

Өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зохицуулалт нь олон улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, стандартын агуулгад нийцсэн боловч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, үр дүнтэй хэрэгжүүлэх явдал учир дутагдалтай байна.

Ялангуяа улс төрийн агуулгатай, нууцлалтай холбоотой эсхүл өндөр албан тушаал хашиж байсан хүмүүст холбогдох эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр ажилладаг хуульчдад шууд болон шууд бусаар дарамт шахалт үзүүлэх, айлган сүрдүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх, түүнчлэн өмгөөллийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн өмгөөлөгчдийг эрүүгийн хэрэгт яллагдагчаар татах, Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээлгэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгуулахаар холбогдох байгууллагад нөлөөлөх явдал гарч байна.

МӨХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороонд иргэн хуулийн этгээдээс нийт 177 гомдол ирүүлснээс, маргаан үүсгэж Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан хянан шийдвэрлэх хуралдаанаар шийдвэрлэсэн 26, гишүүний захирамжаар маргаан үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн 21, гишүүний захирамжаар маргааныг хэрэгсэхгүй болгосон 68, ажлын албаны хариу албан тоотоор шийдвэрлэсэн 42, хянан шалгагдаж байгаа 20 гомдол байна¹². Тухайлбал Өмгөөлөгч “Г.Б”, “А.Б” нарт холбогдуулан хэргийн оролцогч прокурор, шүүгч нар МӨХ-ны Мэргэжлийн хариуцлагын хороонд гаргасан гомдлын дагуу тус Хороо 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд МТ/42 дугаар тогтоол гаргасан боловч гомдолд холбогдон шалгагдаж байгаа өмгөөлөгчид дээрх тогтоолыг эс зөвшөөрч шүүхэд хандсанаар шүүхээс эцэслэн шийдвэрлэгдээгүй өнөөдрийг хүртэл 2 жил 6 сарын хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа нөхцөл байдал үүссэн байна.

¹¹ Монгол Улсын Үндсэн Хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

¹² Монголын Өмгөөлөгчдийн холбооны 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 05/80 дугаар албан бичиг.

Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх” гэсэн заалтаар өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсонтой нь холбогдуулан өөрт нь болон ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлэх, эсхүл ятгасан бол торгох, эсхүл хорих ял оногдуулахаар зохицуулсан. Одоогийн Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2017 оноос хойш 2025 оны 03 дугаар сарын хооронд Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлд заасан “Өмгөөлөгчид хууль бусаар нөлөөлсөн” гэмт хэргийн 1 тохиолдлыг шүүхээр шийдвэрлэж гэм буруутай этгээдийг торгох ялаар шийтгэжээ¹³.

Үүний тулд цагдан хоригдож, саатуулагдсан хүмүүст эрхээ хасуулсан үеэс эхлэн өмгөөлөгчид нэн даруй хандах эрхийг баталгаатай эдлүүлэн хугацаа алдалгүй эрх зүйн туслалцаа авах нь тухайн хүнд холбогдох асуудал гэмт хэргийн шинжтэй эсэхээс үл хамаарах бөгөөд уг эрхээ хэрэгжүүлэх нь хууль хяналтын байгууллагын болон захиргаанаас гаргасан аливаа шийдвэрээс ангид хэрэгжих учиртай¹⁴.

Гэвч эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдон шалгагдсан хэргийн оролцогчдоос хэдэн хувь нь өмгөөлөгчөөс туслалцаа авах эрхээ хэрэгжүүлсэн талаарх нарийвчилсан тоо баримт гаргах боломжгүй байна. Харин Комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Халдашгүй чөлөөтэй байх эрх” бүлэгт шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан 864 сэжигтний 242 нь өмгөөлөгч авсан бол 622 буюу 72 хувь нь баривчлагдах хугацаандаа өмгөөлөгч аваагүй талаар дурдсан байна. Үүнээс үзэхэд өмгөөлөгч авах, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт хангалтгүй байна. Хэдийгээр өмгөөлөгч авах эрх нь тухайн хүний сонголт хэдий ч саатуулагдсан этгээдэд өмгөөлөгч авах, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг танилцуулах, төлбөрийн чадваргүй оролцогчдод хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчид хандах боломжтой талаар хуульд заасан эрхийг нь бүрэн танилцуулж байгаа эсэхэд анхаарах шаардлагатай юм.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах талаарх шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгчийн оролцоог үр дүнтэй хангадаггүй, шүүх мэтгэлцээнд үндэслэсэн хөндлөнгийн шийдвэр гаргадаггүй, хавтаст хэргийн материал болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар гаргаж буй саналын үндэслэл, түүнийг нотолсон нотлох баримттай өмгөөлөгчийг танилцуулдаггүй, талуудыг мэтгэлцэх боломж олгодоггүй, хуралдааны товыг тулгаж мэдэгддэг¹⁵ зэрэг эрх зүйн зохицуулалт хууль хэрэглээнээс үүдсэн асуудал байсаар байна.

Комисс нь 2024 онд “Цогц Хөгжлийн Үндэсний Төв” ТББ-тай хамтран улсын хэмжээнд “Хүний эрх хамгаалагч болох өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр судалгааны ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 426 өмгөөлөгчөөс анкет асуулга авч, ганцаарчилсан болон бүлгийн 7 удаагийн ярилцлагад 27 өмгөөлөгчийг хамруулсан байна.

Судалгааны явцад өмгөөлөгчдийн зүгээс мөрдөн байцаалтын шатанд хэргийн материалтай урьдчилан танилцах, холбогдох ажиллагааны талаар гомдол, хүсэлт гаргах зэргээр өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн, үр дүнтэй гүйцэтгэх боломжийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хязгаарлаж байгааг цаашид анхаарах шаардлагатай талаар дурдсан. Дээрх асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг, бусад судалгаанд тодорхой тэмдэглэсэн байна.

¹³ Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2022/ШЦТ/886 дугаар шийтгэх тогтоол, Хэргийн дугаар: 105/2020/1291/Э/.

https://shuukh.mn/single_case/83479?daterange=2015-11-01%20-%202025-01-01&id=1&court_cat=2&bb=1

¹⁴ Эмнести интернэшнл байгууллага, “Шударгаар шүүлгэх эрх” гарын авлага. УБ, 2010 он.

¹⁵ Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл 22 дугаар илтгэл, 2023 он, 36-39 дэх тал. https://nhrcm.gov.mn/pdf/22_%D0%B8%D0%BB%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB.pdf

Тохиолдол 2.1

“...Мөрдөн байцаалтын шатанд зөвхөн шинжээчийн дүгнэлттэй танилцуулж, хэрэгт авагдсан бусад нотлох баримттай танилцуулдаггүй нь өмгөөлөгчийн ажиллах боломжийг алдагдуулж тодорхой мэдээлэлгүй, таамгаар үйл ажиллагаа явуулахад хүргэдэг байна. Иймд хуулиар өмгөөлөгч мөрдөн байцаалтын үйл ажиллагааны нууцыг алдагдуулахгүй гэсэн баталгаа гаргасан тохиолдолд хэргийн материалтай танилцах боломжийг нээж өгөх нь оновчтой...”

(“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дах өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал” Бодлогын судалгааны хэсгээс)¹⁶

Тохиолдол 2.2

“...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад яллах болон өмгөөлөх тал тэгш эрхтэй гэсэн эрүүгийн эрх зүйн зарчим байдаг. Гэтэл хэрэг бүртгэх, мөрдөн шалгах үе шатанд ямар ч тэгш эрхийн баталгааг хуульчлаагүй. Жишээлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар мөрдөгч, прокурор нь яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй гэж заасан. Гэтэл прокурор нь хэргээ боогоод шүүхэд очихдоо “Улсын яллагч” болдог. Улсын яллагч хийх прокурор цагаатгах талын баримт цуглуулах нь ховор, иймд түүнээс шаардах нь ч бодитой биш. Тийм хүсэл зориг прокурорт угаасаа байдаггүй. Энэ байдлыг засахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой аливаа үйлдэл хийхэд өмгөөлөгч, прокурор хоёрын санал зөрөлдвөл шүүхэд очиж эцэслэн шийдвэрлэдэг хуулийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Тэгж байж харьцангуй тэгш эрхтэй оролцооны тухай яригдах юм...”

(Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх, түүний баталгаа: Өнгөрсөн-Одоо-Ирээдүй симпозиумаас гаргасан зөвлөмжөөс)¹⁷

Иймд Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд нь захиргааны болон хуулийн байгууллагын дотоод дүрэм, журмаар үгүйсгэж, хязгаарлахгүй байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

2.2.2. Өмгөөлөгчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

НҮБ-ын Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудлаарх тусгай илтгэгч Маргарет Саттервейт 2023 оны 11 дүгээр сарын 06-15-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж гаргасан тайланд¹⁸ “Өмгөөлөгч, тэдний гэр бүлийнхэн мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө, ялангуяа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дарамт шахалтад өртөж байгааг Тусгай илтгэгчид мэдэгдэв. Өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, саад тотгор учруулах, дарамтлах, зүй бусаар хөндлөнгөөс оролцохгүйгээр мэргэжлийн чиг үүргээ гүйцэтгэх боломжийг Засгийн газар баталгаажуулж, хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн үүрэг, хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүйн дагуу хийсэн аливаа үйлдлийнхээ төлөө өмгөөлөгчид хориг арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах аюулд өртөхгүй байх ёстой гэдгийг Тусгай илтгэгч онцолж байна” гэжээ.

Дэлхийн шударга ёсны төсөл (World Justice Project) олон улсын байгууллагаас эрхлэн гаргадаг Эрх зүйт ёсны индекс (Rule of Law Index)-ээр улс орнуудыг 1 хүртэлх оноогоор дүгнэж, эрэмбэ олгодог юм. Монгол Улсын хувьд 2024 оны байдлаар дэлхийн 142 улс орноос 0,53 оноо буюу 66 дугаар байр, бүс нутгийн хэмжээнд 15 улс орноос 8 дугаарт эрэмбэлэгджээ. Шударга шүүхээр шүүлгэх болон хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилттэй холбогдуулан Эрх зүйт ёсны индексийн үндсэн болон дэд шалгуур үзүүлэлтүүдийг авч үзвэл Монгол Улс нь иргэний шүүхийн шударга байдлын үнэлгээгээр

¹⁶ Нээлттэй нийгэм форум, Монголын Хуульчдын холбоо зэрэг байгууллагуудаас хийсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дах өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал” судалгаа, УБ, 2024 он, 136 дахь тал.


¹⁷ Монголын Хуульчдын холбоо, “Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх, түүний баталгаа: Өнгөрсөн-Одоо-Ирээдүй” Симпозиумаас гаргасан зөвлөмж, 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр, <https://www.facebook.com/photo.php?fbid=839581229709943&id=183646631970076&set=a.183951955272877%D1%81%D1%81>

¹⁸ НҮБ-ын Шүүгч, хуульчдын хараат бус байдлын асуудлаарх тусгай илтгэгч Маргарет Саттервейтийн Монгол Улсад ажилласан тайлан. <https://digitallibrary.un.org/record/4045064?ln=en&v=pdf>

(Civil Justice) 0.54 оноо авч, 142 улс орноос 65-д, эрүүгийн шүүхийн шударга байдлын үнэлгээгээр (Criminal justice) 0.48 оноо авч, 142 улсаас 58-д тус тус эрэмбэлэгдсэн байна¹⁹.

Монголын Өмгөөлөгчдийн холбооны нэгдсэн бүртгэлд 2025 оны 01 дүгээр сарын байдлаар 3,097 өмгөөлөгч байгаагаас өмгөөллийн эрхээ түдгэлзүүлээгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 2,238 өмгөөлөгч байна. Үүнээс эмэгтэй 1,115, эрэгтэй 1,123 буюу нийт өмгөөлөгчдийн 49 хувь нь эмэгтэй, 51 хувь нь эрэгтэй өмгөөлөгч байна. Харин 61 өмгөөлөгч улсын өмгөөлөгчийн эрх аван ажиллаж байна.

Бүдүүвч 3.1 Монголын Өмгөөлөгчдийн Холбооны нэгдсэн бүртгэл, 2025 оны 1 дүгээр сарын байдлаар, өмгөөлөгчдийн тоо



Мөн өмгөөллийн хуулийн этгээдийн бүртгэлтэй 249 нөхөрлөл, компани байгаагаас Улаанбаатар хотод 243, Төв аймагт 2, Дорнод аймагт 1, Дархан-Уул аймагт 1, Архангай аймагт 1, Өвөрхангай аймагт 1 хуулийн этгээд өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байна²⁰.

Бүдүүвч 3.2 Монголын Өмгөөлөгчдийн Холбооны нэгдсэн бүртгэл, 2025 оны 1 дүгээр сарын байдлаар, өмгөөллийн хуулийн этгээдийн тоо



“Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 16.9 хувь нь өмгөөллийн чиглэлээр хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад маш их бэрхшээлтэй тулгардаг гэсэн бол 24.4 хувь нь бэрхшээл ихтэй, 44.1 хувь нь бэрхшээлтэй хэдий ч уг бэрхшээлийг даван туулах боломжтой гэжээ.

¹⁹ Дэлхийн Шударга Ёсны төсөл “World Justice Project” (WJP) нь дэлхий даяар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, мэдлэг олгох, хууль дээдлэх соёл, ухамсрыг төлөвшүүлэх зорилготой, бие даасан, олон талт байгууллага юм. Тус байгууллага нь практикт хууль дээдлэх ёсны хэрэгжилтийг үнэлэх тоон үзүүлэлт бүхий индекс (шалгуур үзүүлэлт)-ийг боловсруулж гаргасан.

<https://worldjusticeproject.org/rule-of-law-index/country/2024/Mongolia/Open%20Government/>

²⁰ Монголын Өмгөөлөгчдийн холбооны 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 05/80 дугаар албан бичиг.

Бүдүүвч 3.3 Өмгөөллийн чиглэлээр хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад бэрхшээл тулгардаг эсэх, хувиар



Энэхүү судалгааны үр дүн болон бусад ижил төстэй судалгаанаас үзэхэд өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах бэрхшээл тулгарч байна.

Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх явдал төлөвшөөгүй байна. Хууль зүйн туслалцаа авах хүний үндсэн эрх болон хуульч, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг шүүхийн, захиргааны гэх зэрэг аливаа байгууллага үгүйсгэж болохгүй. Гэвч эрх зүйн маргаан шийдвэрлэхэд өмгөөлөгчийн оролцоог үгүйсгэх, хязгаарлах байдал гарсаар байна. Энэ нь ХЭХЭЗБТХ-ийн 9 дүгээр зүйлд заасан хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээх зөвшөөрөх, зөрчихгүй байх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах талаарх төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүлээх үүргийг зөрчиж буй хэлбэр юм.

Тохиолдол 2.3

“...Үндсэн хуулийн Арван Зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох...” гэж иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Гэтэл сахилгын хорооны хянан үзэх хуралдаанд намайг биечлэн оролцох, өөрийгөө өмгөөлөх, үг хэлэх, хууль зүйн туслалцаа авах, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхийг эдлүүлэлгүй хяналтын хуралдааныг хийсэн. Хянан үзэх хуралдааны даргалагч, гишүүд “нэг бол итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл өөрөө тус хуралдаанд оролцох ёстой, өмгөөлөгч оролцох учиргүй” гэх шаардлагыг тавьсан. Ингээд миний бие аргагүй эрхэнд өөрөө хуралдаанд оролцохоос татгалзаж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөө оролцуулсан. Шүүгч миний бие өөрөө хуралдаанд оролцож, тайлбар гаргах хүсэлтэй байсан, мөн өөрийгөө өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцааг өмгөөлөгчөөс авах хүсэлтэй байсан боловч уг эрхийг маань хуралдааны гишүүд эдлүүлээгүй. Мөн Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т “үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасан эрх, үүргийн хүрээнд аль ч байгууллагад төлөөлөх” гэж өмгөөлөгчийн эрхийг заасныг Шүүхийн сахилгын хороо зөрчиж, өмгөөлөгч нарын хуулиар олгосон мэргэжлийн үйл ажиллагааны эрхийг ялгаагүй зөрчсөн...”

(Шүүгч “Н.Д”, “О.О” нарт холбогдох сахилгын хэргийн тухай 2023 оны 06 сарын 28-ны өдрийн 001/СХХШТ2023/0004 дүгээр УДШ-ийн шүүх хуралдааны тогтоол)²¹

Шүүхийн сахилгын хороо нэр бүхий шүүгчид холбогдох сахилгын хэргийг хуралдаанаар хэлэлцэхдээ сахилгын хэргийн оролцогчийн өмгөөлөгчтэй оролцох хүсэлтийг хангахаас татгалзсан үйлдлийг УДШ-ээс хяналтын журмаар хянаад “Сахилгын хэргийн хуралдаанд өмгөөлөгчийн оролцох эрх, үүргийг Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулаагүй тул зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хуралдаанд оролцуулж, ингэхдээ холбогдох шүүгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн аль нэгний тайлбар, хүсэлтийг авах тухай сахилгын хорооны дүгнэлт нь Монгол Улсын хэд, хэдэн хууль тогтоомжоор олгогдсон хууль зүйн туслалцаа авах эрхийг хязгаарлаж буй талаар УДШ-ийн хяналтын шатны 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр, мөн оны 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар сахилгын хэргийн хуралдааны тогтоолуудаар нэгэнт дүгнэсэн” гэсэн нь зарим эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг зөрчиж байгааг илтгэж байна.

²¹ Шүүхийн шийдвэрийн цахим сан <https://www.supremecourt.mn/mn/printc?id=39311>

Өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах эрх

Өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах, харилцах эрхэд ямар нэг саад, хяналтгүйгээр өмгөөлөгчтэйгөө уулзах орчныг бүрдүүлэх, өмгөөлөгч, үйлчлүүлэгчийн хоорондын харилцаа болон тэдний зөвшилцлийн нууцлалыг хүндэтгэн үзэх ёстой байдаг. Ялангуяа баривчлагдсан, цагдан хоригдсон хүн өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах, харилцах нөхцөлийг хангахдаа өмгөөлөгч хоорондын аман ба бичгийн харилцаа холбооны нууцлалыг хадгалахуйц хэлбэрээр бүрдүүлэх нь чухал юм.

Өмгөөллийн тухай²² хууль болон бусад хуулиар²³ баталгаажуулсан өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах эрхийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай байна. Судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 7.3 хувь нь эрх огт хангагддаггүй, 22.5 хувь нь хангалтгүй, 27.9 хувь нь зарим талаар хангагдсан хэмээн хариулсан бол 28.6 хувь нь ерөнхий хангагдсан, 13.6 хувь нь хангалттай сайн хангагдсан хэмээн тус тус хариулжээ.

Хэдийгээр энэ эрхийг хангах эрх зүйн орчин бүрдсэн боловч ганцаарчлан уулзах эрхийн агуулгыг орчин үеийн техник хэрэгслийн хэрэглээтэй уялдуулан хэрхэн ойлгож, хэрэгжүүлэх асуудал анхаарал татаж байна. Тухайлбал цахим буюу онлайнаар явагдаж байгаа шүүх хуралд өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэй чөлөөтэй харьцах, ганцаарчлан уулзах эрхийг хэрхэн хангах, түүнчлэн камераар тоноглож, утсан харилцуураар харилцаж байгааг харилцааны нууцлал хангасан орчинд ганцаарчлан уулзах эрхийг хангасан гэж үзэхэд эргэлзээтэй байна.

ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангийн хоригдол болон хоригдогчийн өмгөөлөгчтэй уулзалт хийх өрөөний багтаамжаас шалтгаалж өмгөөлөгч 30 минутаас 2 цаг орчим зарим тохиолдолд түүнээс дээш хугацаагаар хүлээдэг байсныг шийдвэрлэх зорилгоор 6 өрөөг 8 тасалгаа бүхий том өрөөгөөр сольж, шинээр цахимаар уулзах 4 тасалгааг нэмж нийт 12 өмгөөлөгч зэрэг уулзах боломжийг бүрдүүлэх мөн цагдан хорих байранд цахим шүүх хуралдааны өрөөнд шинээр 4 тасалгаа бүхий өрөөг 2023 оны 01 дүгээр сард ашиглалтад оруулсан. Гэвч уулзалтын өрөөнд шилээр тусгаарлалт хийсэн нь түүнийг хагалж хоригдогч өөртөө болон бусдад гэмтэл учруулах, мөн утсан харилцуураар холбогдож байгаа нь шугам сүлжээг ашиглан яриаг чагнах, нууцлал алдагдах эрсдэлтэй байж болзошгүй болохыг Комиссын гишүүний 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06/16 дугаар зөвлөмжид тэмдэглэсэн²⁴. Мөн өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид үйлчлүүлэгчтэй камертай өрөөнд утсан харилцуураар ярилцахад чагнахгүй гэсэн баталгаа байхгүй тул үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах эрх зөрчигдөж байгаа талаар ярьж байв.

Тохиолдол 2.4

“...ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги дээр үйлчлүүлэгчтэйгээ утасны цаанаас харьцдаг. Энэ нь чагнаж байгаа сэжиг үүсгэдэг. Мөн тухайн байр нь камертай байдаг. Энэ нь өмгөөлөгчид үйлчилгээгээ үзүүлэх боломжгүй болгодог. Камер тавьсан мөн утасны цаанаас ярьж байгаа нь хууль бусаар тагнаж чагнаж байгаа хэрэг гэж үзэж байна. Ер нь чагнахгүй байна гэсэн баталгаа байхгүй...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах эрхийг баталгаажуулсан холбогдох хуулийн зохицуулалт харилцан адилгүй байгаад анхаарч, зохицуулалтыг нэг мөр

²² Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т “үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломжоор хангагдах” гэж өмгөөлөгчийн эрхийг заасан.

²³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт “Гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан даруй уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих” гэж заасан. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэгт “холбогдогчтой ганцаарчлан уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих, тэмдэглэлд тусгуулах” гэж өмгөөлөгчийн эрхийг заасан. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих, шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Хоригдсон этгээд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно. Хоригдсон этгээд өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах нөхцөлөөр хангагдсан байна” гэж заасан.

²⁴ Комиссын гишүүний 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06/16 дугаар зөвлөмж.

ойлгомжтой болгох шаардлагатай юм. Тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт өмгөөлөгч гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан “даруй” уулзах эрхтэй байхаар зохицуулсан бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 4.1 дэх хэсэгт өмгөөлөгч холбогдогчтой ганцаарчлан уулзах эрхийг заасан боловч даруй уулзах эрхийг хуульчлаагүй байна.

Зарим аймаг, орон нутагт цагдан хоригдож байгаа үйлчлүүлэгчтэйгээ уулзахын тулд шүүгчийн зөвшөөрлийг шаардах зэрэг хууль бус асуудал байгааг өмгөөлөгчид ярилцлагын үеэр онцолж байв.

Тохиолдол 2.5

“...2023 онд Ховд аймагт хэрэг өмгөөлж байхад Ховд аймгийн шүүх дээр цагдан хоригдож байгаа үйлчлүүлэгчтэйгээ уулзахын тулд шүүгчээс зөвшөөрөл авдаг кэйс одоог хүртэл үйлчилж байсан. Гэтэл энэ чинь аль хэдийн байхгүй болсон зүйл өмгөөлөгчид саадгүйгээр үйлчлүүлэгчидтэйгээ уулзаж үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрхтэй. Гэтэл өмгөөлөгч нар хуульд заасан эрхээ эдэлж чадахгүй шүүгчээс зөвшөөрөл авдаг тохиолдол байна...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Мөн Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хэргийн оролцогчдыг цахимаар оролцуулахдаа шүүгдэгчийн өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах эрх, түүнчлэн өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэйгөө зөвлөлдөх эрхийг цахим орчинд хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байсан нь цаашид шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх бодлого, үйл ажиллагааг нэвтрүүлэхэд анхаарах чухал асуудлын нэг юм.

Хөндлөнгийн нөлөөлөл, эрсдэлээс ангид байх эрх

НҮБ-ын “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-д хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг айлган сүрдүүлэлт, дарамт шахалт, зүй бус хөндлөнгийн нөлөөллөөс ангид байдлаар хэрэгжүүлэх баталгааг төр хангах үүрэгтэй²⁵ хэмээн заасан бол НҮБ-ын Хүний эрх хамгаалагчдын тунхаглалд хүний эрх хамгаалах эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж, захиргааны болон бусад алхмуудыг оролцогч улс бүр авч хэрэгжүүлэхээр заасан. Олон улсын Хуульчдын холбооны “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандартад” зааснаар хуульч нь мэргэжлийнхээ тогтоосон дүрэм, хэм хэмжээ, ёс зүйг баримтлан үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн эрх бүхий байгууллага, олон нийтийн дарамт шахалт, айдасгүйгээр мэргэжлийн үйл ажиллагаагаа чөлөөтэй хэрэгжүүлэх ёстой²⁶.

Өмгөөллийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Төрийн байгууллага, албан тушаалтан, гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч, улс төрийн нам, хүн, хуулийн этгээд хэн боловч өмгөөлөгч хуулийн хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэхэд нь дарамт шахалт үзүүлэх, саад учруулах, баталгаа шаардах, заналхийлэх, бусад байдлаар хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” хэмээн заасан нь хууль зүйн чухал баталгаа юм. Гэвч дээрх хуулийн заалтын бодит хэрэгжилт хангалтгүй хэмээн судалгаанд оролцсон өмгөөлөгчид үзэж байна. Судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 12.4 хувь дээрх баталгаа огт хангагдаагүй гэсэн бол 33.8 хувь нь хангалтгүй, 36.4 хувь нь зарим талаар хангагдсан гэсэн бол ердөө 6.1 хувь нь хангалттай сайн, 11.3 хувь нь ерөнхий хангагдсан хэмээн дүгнэжээ.

Өмгөөлж байгаа хэрэг, маргаан, эсхүл гаргасан гомдолтой нь холбогдуулан эрх мэдэл, албан тушаалаар айлган сүрдүүлэх, заналхийлэх, гуравдагч этгээдээр дамжуулан шууд болон шууд бусаар дарамт шахалт үзүүлэн, нөлөөлөх гэж оролдох явдал гардаг болохыг өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр зарим өмгөөлөгчид онцолж байв.

²⁵ “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-ын 16 дугаар зүйл.

<https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-role-lawyers>

²⁶ “Хуульчийн мэргэжлийн бие даасан байдлын талаарх стандарт”-ын 6 дугаар зүйл.

<https://www.ibanet.org/MediaHandler?id=F68BBBA5-FD1F-426F-9AA5-48D26B5E72E7>

Тохиолдол 2.6

“...Иргэний хэрэг шийдвэрлэхдээ ёс зүйн ноцтой зөрчил гаргасан шүүгчид холбогдуулан шүүхийн Сахилгын хороонд гомдол гаргасан. Шүүхийн Сахилгын хорооны хянан үзэх хуралдаан товлогдсоны дараа нөгөө шүүгч нөлөө бүхий өөр албан тушаалтнаар дамжуулан нөлөөлөх гэж оролдсон. Хэдийгээр айлган сүрдүүлж, дарамтлаагүй боловч өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нөлөөлдөг энэ мэт зүйлсийг тэвчээд өнгөрдөг...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулснаас өмгөөлөгчийн аюулгүй байдалд заналхийлсэн, айлган сүрдүүлсэн тохиолдолд ХЭХЭЗБТХ-иар хамгаалагдахаар зохицуулсан. Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо нь хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдлыг шуурхай хангах арга хэмжээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу цагдаагийн байгууллагад хандаж шийдвэрлүүлдэг.

Улс төрийн агуулгатай, эсхүл өндөр албан тушаал хашиж байсан хүмүүст холбогдох эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа өмгөөлөгчдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамт, шахалт үзүүлсэн талаар өмгөөлөгчид олон нийтэд хандан мэдээлсэн нь цөөнгүй байгаа хэдий ч одоогоор өмгөөлөгчид Комисст аюулгүй байдлын хамгаалалтын асуудлаар хандсан тохиолдол байхгүй байна.

Тохиолдол 2.7

“...Мөрдөн байцаагч Т, АТГ-ын томоохон албан тушаал хашдаг бололтой нүдний шилтэй нэг хүний хамт шатан дээр тосож уулзсан. Нүдний шилтэй нөхөр “Чи муу гөлөг яах гээд байгаа юм бэ. Яасан их хэл ам хийж сэтгүүлч дууддаг новш вэ. Зөрүүлээд сэтгүүлч дууд. Наад муу чинь өмгөөлөгч мөн юм уу”. Үнэмлэхийг нь шалга. Ална шүү. Амьдралгүй болгоно шүү п... минь гэх мэтээр дарамталсан. Би ч үнэмлэхээ үзүүлсэн. Тэгсэн “Энэ муугаас архи үнэртээд байгаа юм биш үү” гэхээр нь халаасандаа байсан долоогонын хандаа үзүүлсэн. Тэгсэн долоогонын хандыг булааж авах гэж оролдсон. Нэг нь гар мушгиж, нөгөөх нь авах гээд байдал эвгүйдээд эхэлсэн. Намайг яаж ч магадгүй юм байна гэдгийг гаргасан авир байдлаас нь ойлгосон. Дугаараа нууцалсан утаснаас хоёр ч удаа үл таних этгээд залгаж дарамталсан. “Чамайг ална. “Г.Д” энэ тэр гэж хуцаад байвал ална шүү. Аятайхан байгаарай. Үг хэлээ бодож хуцаарай” гэх мэтээр амь нас, гэр бүлд минь дарамт шахалт учруулж байгаа болохоор арга буюу үйлчлүүлэгчийг өмгөөлөхөөс татгалзсан...”

(Өмгөөлөгч “Д.С”-ийн 2015 онд хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагаас)²⁷

Түүнчлэн өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр зарим өмгөөлөгч улс төрийн оролцоотой хэргүүд дээр ажиллахад хаанаас, юунаас гэдэг нь мэдэгдэхгүй зүй бус нөлөөлөл, шууд болон шууд бус дарамт шахалт, заналхийлэл, сүрдүүлэг ирдэг тул аюулгүй байдлаа хангахын тулд зарим тохиолдолд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, эсхүл аль болох улс төртэй холбоотой хэрэгт өмгөөлөгчөөр ажиллахаас зайлсхийдэг талаар хэлж байв.

Тохиолдол 2.8

“...Ер нь өмгөөлөгчид жоохон дугаараа байвал чимээгүй болгочихдог. Яагаад чимээгүй болчихсон бэ гэхээр дарамт нь дийлдэхгүй байна гэсэн зүйлс их байдаг. Мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулснаа төлөө өөрийнхөө хувийн амьдралаар хохирсон өмгөөлөгчид олон байдаг. Тиймээс өөр өөрсдийнхөө жижиг хэргийг аваад амьдралаа залгуулаад явж байхыг боддог. Томоохон хэрэг аваад ажиллахад АТГ тагнаж, чагнаж, өмгөөлөгч дээр гүйцэтгэх ажиллагаа явуулдаг гэж боддог. Мэдээллийн аюулгүй байдал огт хангаагдаагүй. Хүний эрх хамгаалах гэж явж байгаад өөрөө хэрэгт ордог, улс төрийн хэрэг маргаан өмгөөлөхөд маш их ганцаарддаг. Ямар нэгэн байдлаар дарамталж чимээгүй болгосон тохиолдол их байдаг болохоор өмгөөлөгчдийн хувьд мөрөөрөө амь зуугаад явж байсан нь дээр гэж үздэг. Худлаа, үнэн нь мэдэгдэхгүй олон асуудал тавьж шалгадаг, зоригийг нь мохоодог...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

²⁷ <https://medee.mn/p/79637>

Тохиолдол 2.9

“...Өмгөөлөгч “Г.Б” нь 2024 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр гэрээсээ гараад ор сураггүй алга болсон гэх гомдлыг түүний төрсөн дүү Г.Н-ээс Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газрын 1 дүгээр хэлтэст энэ оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 00 цаг 57 минутад гаргасан.

Тус хэлтсээс эрэн сурвалжлах ажиллагаа хийснээр 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Нийслэлийн Хан-Уул дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Богд хаан” амралтын газрын автомашины зогсоол орчмоос иргэн “Г.Б”-ийн унаж явсан улсын дугаартай автомашинд хэргийн газрын үзлэг хийхэд тэрээр арын суудалд нас барсан байдалтай олдсон.

Амь хохирогчийн буудуулж нас барсан үхлийн шалтгааныг тогтоохоор Шүүх шинжилгээний ерөнхий газраас цогцост задлан шинжилгээ хийсэн бөгөөд Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна...

(Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэлийн төлөөлөгчийн 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хийсэн мэдээллээс)²⁸

Монгол Улс 2013 онд Тахарын албаны тухай хуулийг баталж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах зэрэг чиг үүрэг хэрэгжүүлэх бие даасан байгууллага буюу "Тахарын алба"-ыг байгуулсан хэдий ч 2016 онд татан буулгасан байна. Одоо Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс уг чиг үүргийг хэрэгжүүлж байна. Улс орнууд биечилсэн хамгаалалтыг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэхээр зохицуулсан боловч энэ биечилсэн хамгаалалт нь хүний эрх хамгаалагчдад айдас, түгшүүр төрүүлдэг сул талтай талаар НҮБ-ын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Мишель Форст 2019 оны 04 дүгээр сард Монгол Улсад ажилласан тайландаа дурджээ. Хүний эрхийн олон улсын байгууллагууд хүний эрх хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах үүднээс мэргэшсэн аюулгүй байдлын тусгай байгууллагыг байгуулах талаар санал дэвшүүлдэг. Иймд хүний эрх хамгаалагчдыг аюул, эрсдэлээс хамгаалах үр дүнтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дагнасан байгууллага бий болгох асуудлыг бодлого, үйл ажиллагааны хүрээнд анхаарах нь зүйтэй юм. Тухайлбал 2005 онд төрсөн охиндоо бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн гэх гэмт хэрэгт хохирогчийн өмгөөлөгчөөр ажилласан “Л.Х”-д ял шийтгүүлсэн этгээд нь ялаа эдэлж байх хугацаандаа бусдаар дамжуулан заналхийлж сүрдүүлсэн шинжтэй үйлдлүүд гаргадаг байсан учраас тухайн үед Тахарын алба хяналт тавьж түүнийг эрсдэлд орохоос хамгаалж байсан боловч тус алба татан буугдсан. Ял шийтгүүлсэн этгээд “А.А” нь 16 жилийн дараа ялаа эдэлж суллагдан хамт орон нутагт амьдарч, дахин заналхийлэх болсон миний эрхийг хамгаалж өгнө үү.” гэх агуулга бүхий гомдлыг Комисст гаргасан.

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө аливаа хариуцлагад татагдахгүй байх баталгаагаар хангуулах, эрх чөлөө нь хязгаарлагдсан үйлчлүүлэгчтэйгээ уулзах, зохих хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжоор хангагдах, өмгөөлөгч-үйлчлүүлэгчийн нууцлалыг бүрэн дүүрэн хангуулах, үйлчлүүлэгчээ төлөөлөх, эрх ашгийг хамгаалах үүднээс шүүх болон төрийн бусад байгууллагад чөлөөтэй хандах, мэдээлэл олж авах эрхийг баталагаатай эдлэх хэрэгцээ өмгөөлөгчдөд байна.

Өмгөөлөгчийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан саатуулах, эрхийг нь хязгаарлах

Өмгөөлөгчдийг өмгөөллийн үйл ажиллагаатай нь холбогдуулан хууль бусаар баривчлах, саатуулах тохиолдол гарч байгаа нь хүний эрх хамгаалах үйл ажиллагаанд тулгарч байгаа өндөр эрсдэл бөгөөд энэ нь үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн хүрээнд тууштай хамгаалах өмгөөллийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим алдагдахад хүргэж байна.

²⁸ <https://www.facebook.com/zugii/videos/%D1%88%D1%83%D1%83%D0%B4/3627319150866176/>

Тохиолдол 2.10

“...Миний өмгөөлж байгаа 4 хүний гурвыг нь цагдан хорьсон. Гэтэл би өөрөө 30 хоног баривчлагдсан. Үйлчлүүлэгч нартаа их санаа зовж байна. Манай хүмүүсийг Өвөрхангай аймгаас баривчилж ирсэн өглөө намайг Улсын мөрдөн байцаах газраас дуудаад “Б өмгөөлөгчөөрөө авъя гэж байна, та зөвлөгөө өгөх хэрэгтэй байна” гэж хэлсэн. Тэгээд нэг өрөөнд оруулаад хашчихсан. Бас л хуурч аваачсан гэсэн үг. Нэлээд удсаны дараа хэрэг бүртгэгчийн өрөөнд оруулаад жагсаал, цуглаан зохион байгуулсан талаараа тайлбар өг гэсэн. Миний хувд “Гал үндэстэн” холбооны хуулийн зөвлөх учраас тайлбар өгөхгүй. Өмгөөлөгч хүнийг тухайн үйлчлэгчийнх нь явуулсан үйл ажиллагаа, бусад шалтгаанаар тайлбар авахыг хориглоно гэж заасан учраас ямар ч тайлбар өгөхгүй. Хэрэг бүртгэгч таны явуулж байгаа үйл ажиллагаа хууль бус байна гэдгийг хэлсэн...”

(Өмгөөлөгч “Г.Д”-ийн хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагаас)²⁹

Тохиолдол 2.11

“...2009 оны 02 дугаар сард Нийслэлийн цагдаагийн газар Монгол Улсаас албадан гаргах гэж байгаа шашны ажилтнуудыг төлөөлсөн орон нутгийн өмгөөлөгчийг 4 цагийн турш баривчилж саатуулсан. Тус өмгөөлөгчийг ямар ч хэрэгт яллаагүй боловч өмгөөлөгчийн мэдэгдэж байгаагаар түүнд торгууль ногдуулж, захиргааны арга хэмжээ авсан бөгөөд цаашид гадаадын шашны ажилтнуудыг төлөөлөхгүй байхыг анхааруулсан. Тус өмгөөлөгч шүүхэд гомдол гаргахад шүүхээс цагдаагийн байгууллага хууль бусаар ажилласан болохыг тогтоосон...”

(АНУ-ын Төрийн департаментын 2009 оны олон улсын шашны эрх чөлөөний тухай тайлангаас)³⁰

Тохиолдол 2.12

“...Эрүүгийн хэргийн мөрдөгч С, түүний мөрдөж байсан хэрэгт өмгөөлөгчөөр ажиллаж байсан А нар хэрэгт хүсэлт гаргах асуудлаар санал зөрөлдөж, цагдаагийн хэлтсийн байранд маргалдах үед мөрдөгч С нь өмгөөлөгчийг “архи үнэртүүлж маргасан” гэх шалтгаанаар тушаал өгч албадан эрүүлжүүлсэн. Уг хэргийг 2022 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлээд мөрдөгч С-г Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан гэм буруутайд тооцсон. Анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх хүчингүй болгож С-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон. Харин хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн...”

(УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 159 дүгээр тогтоолоос)³¹

Өмгөөллийн үйл ажиллагаа явуулсантай холбогдуулан өмгөөлөгчид эрүүгийн хэрэг үүсгэх, шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдол гарч байгаа тул өмгөөлөгчийн мэргэжлийн үүргээ зохих ёсоор биелүүлсэнтэй нь холбогдуулан хариуцлага хүлээлгэхгүй байх зохицуулалтыг бүрдүүлэх нь чухал байна.

Өмгөөллийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсний төлөө зүй бусаар шийтгэхгүй байх баталгаа

НҮБ-ын Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмуудад өмгөөлөгчийн хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн чиг үүрэг, хууль болон ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн аливаа үйлдлийнх нь төлөө эрүүгийн, захиргааны, эдийн засгийн болон бусад шийтгэл хүлээхгүй, эсвэл ийм заналхийлэлд өртөхгүй байх баталгааг хангах нь төрийн үүрэг байхаар заасан³². Түүнчлэн хүний эрх хамгаалагчийг хуулиар хамгаалагдсан ажил, үйл

²⁹ Сэтгүүлч “С.О”, “Өлсгөлөн зарлахаас өөр арга байгаагүй”, 2011 оны 07 дугаар сарын 10-ны өдөр. <https://news.mn/r/74153/>

³⁰ АНУ-ын Элчин сайдын яамнаас 2009 онд гаргасан “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан”. <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2009-international-religious-freedom-report/>

³¹ УДШ-ийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 159 дүгээр тогтоол. <https://supremecourt.mn/mn/printc?id=36546>

³² “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/basic-principles-role-lawyers>

ажиллагааных нь төлөө болон бусад нотлогдоогүй үндэслэлээр яллах, баривчлах зорилгоор эрх зүйн тогтолцоог буруугаар ашиглах, захиргааны хяналт хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, эрүүгийн болон бусад хариуцлага хүлээлгэхгүй байх талаар Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал+25 баримт бичигт онцлон тэмдэглэсэн³³.

Харин Өмгөөллийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид өмгөөллийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлсэнтэй нь холбогдуулан өмгөөлөгчид эрүүгийн болон бусад хариуцлага хүлээлгэхгүй байх баталгааг хангах талаар ойлгомжтой, тодорхой зохицуулаагүйгээс өмгөөлөгчийг мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан сэжигтэн, яллагдагчаар татах, баривчлах, саатуулах, шийтгэл оногдуулах тохиолдол гарч байна.

Хүний эрх хамгаалах үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчид эрүүгийн болон зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж байсан гэсэн асуултад нийт судалгаанд оролцсон өмгөөлөгчдийн 1.4 хувь нь зөрчлийн хэрэгт, 7.3 хувь эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан хэмээн хариулжээ. Гэвч өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотойгоор эрүүгийн хэрэгт шүүгдэгчээр орж, ял шийтгэл хүлээсэн талаарх мэдээлэл судалгааны явцад олдсонгүй.

Тохиолдол 2.13

“...Өмгөөлөгч “А.П” миний бие шөнийн 01:00 цаг өнгөрч байхад Д.М надаас өмгөөллийн туслалцаа хүссэний дагуу нийслэлийн Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс дээр яваад очиход намайг үйлчлүүлэгчтэй уулзуулаагүй. Ямар ч шалтгаангүй хагас цаг орчим хүлээлгэж, эцэст нь хуулийн шаардлага тавьж байж дээш гартал зөрүүлээд Д-г Цагдан хорих 461 дүгээр анги руу аваад явчихсан. Би Д.М-ийн араас ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги руу очиход гадна нь хэсэг залуус хууль ёс шаардаж байсан. Би ч үнэмлэхээ үзүүлээд дотогш нэвтэрсэн. Намайг ороход энгийн хувцастай хүн “Өөрөө өмгөөлөгч нь үү, түр хүлээж бай, удахгүй уулзуулна” гээд хүлээлгэсэн. Энд бас л хууль зөрчигдөж байгаа юм. Нэлээд байсны эцэст эмчийн үзлэгийн өрөөнөөс Д.М “Би энд байна” гээд орилсон нь шөнийн 02:00 цаг өнгөрч байсан үе ба, яг түүнтэй давхцаад шүүхийн шийдвэрийнхэн “Хүнээ аваарай, явууллаа” гээд Д.М-г гаргаад ирсэн.

Прокурорын тогтоолгүй, баривчлах зөвшөөрөлгүйгээр хүнийг цагдаа нар баривчлаад аваад ирсэн учраас шүүхийн шийдвэрийнхэн хуулиа мөрдөөд гаргасан ба гадна байсан залуус Д-г гаргаад ирэхэд бүчиж аваад гарсан ийм л үйл явдал болсон, би тэр үед хөндлөнгөөс хараад зогсож байсан. Миний бие ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги руу очин өөрийн мэргэжлийн нэвтрэх үнэмлэхийг үзүүлэн зөвшөөрөл аваад дотогш нэвтэрсэн байтал өнөөдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1-ийн дагуу хууль сахиулагчдын биед халдсан хэргээр яллагдагч болгоод байна...”

(Өмгөөлөгч “А.П”-ын хэвлэл мэдээлэлд өгсөн ярилцлагаас³⁴)

Болсон үйл явдалтай холбогдуулан өмгөөлөгч “А.П”-г ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангиас “Д.М”-г авч явах зорилгоор “Хууль бус баривчилгаа явагдаж байна, хүнээ авъя” гэх зэргээр яллагдагчдыг уриалж, улмаар албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэн эсэргүүцсэн гэмт хэрэг үйлдэхэд зориуд хүргэсэн үндэслэлээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан. 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн прокурорын тогтоолоор түүнд холбогдох хэргийг гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон байна.

Ийнхүү өмгөөлөгчийг өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн үйлдэлтэй нь холбогдуулан яллагдагчаар татах нь өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх баталгааг алдагдахад хүргэж, улмаар энэ нь хүний эрх хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь үзүүлж буй айлган сүрдүүлэлт, дарамт шахалтын хэлбэр болж байна.

³³ Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал +25, НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал” (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал) <https://ishr.ch/defenders-toolbox/resources/declaration-25/>

³⁴ <https://ubn.mn/p/19689>

Өмгөөлөгчийн төлөөлөх бүрэн эрх

Хүн бүр өөрийн эрхэлсэн ажил, мэргэжлээ хууль ёсоор хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд мэргэжлийнхээ үр дүнд бусдын нэр төр, хүний эрх, үндсэн эрх чөлөөнд нөлөөлж чадах хүн бүр эдгээр эрх, эрх чөлөөг хүндэтгэх ёстой³⁵. Өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаа нь хүний эрхийн зөрчил, хүчирхийллийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасан эрх, үүргийн хүрээнд аль ч байгууллагад төлөөлөх эрхээр илэрдэг.

Өмгөөллийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т өмгөөлөгчийн төлөөлөх бүрэн эрхийг ойлгомжтой, тодорхой хуульчилсан хэдий ч хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг өмгөөлөгчид онцолж байна. Хуульд өөрөөр заагаагүй бол өмгөөлөгч хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолт, баримт сэлтийг тухайн асуудлыг хариуцсан төрийн, төрийн бус байгууллагаас гаргуулан авах зорилгоор өмгөөлөгчийн хүсэлт гаргах эрх, хүсэлтээ шийдвэрлүүлэх эрхийн баталгаа хэрхэн хэрэгждэг талаарх асуултад өмгөөлөгчийн 19 хувь нь огт хангагдаагүй, 33.1 хувь нь хангалтгүй, 32.4 хувь нь зарим талаар хангагдсан гэсэн бол ердөө 9.6 хувь нь ерөнхий хангагдсан, 5.9 хувь нь хангалттай сайн гэж хариулжээ.

Өмгөөллийн үйл ажиллагааны хүрээнд холбогдох байгууллагаас мэдээлэл, баримт, тодорхойлолт гаргуулах зэргээр хуульд заасан төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүйгээс үйлчлүүлэгчээс итгэмжлэл авах жишиг тогтжээ. Гэвч мэргэжлийн үйл ажиллагааны алхам тутам үйлчлүүлэгчээс ийнхүү итгэмжлэл авах нь цаг хугацаа, зардал шаардахаас гадна зарим тохиолдолд үйлчлүүлэгчээс итгэмжлэл авах бодит боломжгүй болсон үед мэргэжлийн үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагддаг талаар өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр өмгөөлөгчид онцолсон юм.

Тохиолдол 2.14

“...Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль ч байгууллагад төлөөлөх эрх хэрэгждэггүй. Заавал итгэмжлэл хийлгэдэг учир хугацаа алдах зэрэг чирэгдэл үүсдэг. Жишээ нь, Баянзүрх дүүргийн Нийгмийн халамжийн газарт лавлагаа авахаар хандсан боловч мэргэжилтнээс нь авч чадаагүй тул дарга дээр нь орж асуугаад дарга нь өгөхгүй гээд гаргаж байсан. Яг ийм жишээ дээр өөр нэг өмгөөлөгч төрийн захиргааны байгууллагыг шүүхэд өгөөд, давж заалдах шатны шүүх хүртэл яваад, ялалт байгуулаад тэр байгууллагаас лавлагаагаа гаргуулж авч байсан. Баянзүрх дүүргийн Нийгмийн халамжийн газарт энэ жишээг хэлээд ч лавлагааг авч чадаагүй...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг тууштай хамгаалах чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллагаас баримт сэлт, тодорхойлолт, лавлагаа гаргуулах боломж хязгаарлагдмал байгаа нь яллах болон өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцэх зарчмыг алдагдуулахад хүргэж байна. Өмгөөллийн тухай хуульд заасан нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх, эсхүл хэрэг, маргаанд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт сэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулах өмгөөлөгчийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.

Тохиолдол 2.15

“...Лавлагаа авч чадахгүй байгаа тохиолдолд өмгөөлөгчид ихэвчлэн прокурор, мөрдөгч рүүгээ л хүсэлт гаргадаг. Энэ нөхцөлд тухайн хүн нь гайгүй мөрдөгч байвал лавлагаа гаргаж өгдөг, хүсэхгүй бол гаргаж өгдөггүй. Хүний үзэмжээр шийдэгдэх асуудал болж хувирдаг. Ерөнхийдөө прокурор өмгөөлөгчийн хүсэлтийг хангахаас татгалзах тохиолдол их байдаг. Яллах болон өмгөөлөх тал тэгш биш. Яллах талд илүү их эрх мэдэлтэй. Жишээ нь өмгөөлөгч лавлагаагаа хуулийн хүрээнд тухайн байгууллагаас авч чадахгүй байгаа тул прокурор, мөрдөгчөөс энэ лавлагааг аваад өгөөч гэж гуйдаг. Энэ үед прокурор, мөрдөгч нар чи энэ мэдээллийг юунд хэрэглэх гэж байгаа вэ? гэж асуудаг. Ийм нөхцөлд өмгөөлөгч өмгөөллийнхөө бүх тактик,

³⁵ “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал” (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал)-ын 11 дүгээр зүйл.

төлөвлөгөөгөө ярьж өгөх хэрэгтэй болдог. Зарим тохиолдолд өмгөөлөгчийн мэдээлэл, лавлагаа авах хүсэлт дээр хэргийн талаар өмгөөлөгчийн бүх төлөвлөгөөг яриулж бичиж авсныхаа дараа хүсэлт хангахаас татгалздаг. Ингээд өмгөөлөгч прокурорт хамаг хөзрөө дэлгэнэ гэдэг шиг зүйл болдог...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Өмгөөллийн тухай хууль болон бусад хуулиар баталгаажуулсан өмгөөлөгчийн эрх, өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг алдагдуулж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох шаардлагатай байна. Тухайлбал УИХ-аас 2002 онд баталсан Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-т өмгөөлөгч нь өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдолтой тэдгээрийн байгаа газарт чөлөөтэй нэвтрэн орж, ганцаарчлан уулзах эрхтэй байхаар заасан. Гэвч 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчийн чөлөөтэй нэвтрэх эрхийг баталгаажуулаагүйгээс зарим хуулийн байгууллагуудын журам, зохицуулалт нь өмгөөлөгчийг нэвтрэх эрхийг бодитоор хязгаарлах, үйлчлүүлэгчтэйгээ уулзах боломжид саад учруулах тохиолдол гарч байгаа нь өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг алдагдуулах нөхцөл болж байна. Мөн судалгааны хүрээнд өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр өмгөөлөгчид энэ талаар хэлж байв.

Тохиолдол 2.16

“...Цагдаагийн болон АТГ зэрэг байгууллагууд руу ороход цүнх, бичиг баримт, гар утас хурааж авдаг. Энэ бол өмгөөлөгчийн биед халдаж байгаа хэлбэр юм. Цагдаагийн байгууллага дээр “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-ийн дагуу жагсагчдын эрхийг хангахаар ажиллахад өмгөөлөгчийн эрх хангагддаггүй, тийм хүн цагдаагийн газарт ирээгүй гэх зэргээр үндэслэлгүйгээр нэвтрүүлдэггүй. Цагдаагийн байгууллага, төрийн байгууллага, төрийн тусгай байгууллага дотогш нэвтрэх, үйлчлүүлэгчидтэйгээ уулзах эрх зөрчигддөг...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Тохиолдол 2.17

“...АТГ-ын даргын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/32 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Авлигатай тэмцэх газрын байранд нэвтрэх журмын 2.11, 3.1.1, 3.2.1 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгоулах талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Ерөнхийдөө дээрх заалтууд нь өмгөөлөгч нарыг АТГ-ын байранд нэвтрэх бүрд нэгжиж, шалгах тухай, цүнх, гар утас оруулахгүй, бичиг баримт, цүнх, гар утсаа орхих тухай агуулгатай заалтууд юм. Дээрх заалт нь бид нарыг өмгөөллийн үйл ажиллагаа явуулахад саад учруулж, хэргийн материалыг хувилж, хуулбарлаж авах хуульд заасан эрхийг хязгаарлаж байгаа юм. Мөн АТГ-ын байранд нэвтрэх, тэнд үйл ажиллагаа явуулах хугацаанд бидний гар утсыг үүдний хэсэгт авч үлдсэнээр бид тус хугацаанд бусадтай харилцах боломжгүй болдог. Хэргийн материалтай танилцах хугацаанд бидэнд гэр бүл, ажлын хүмүүс болон үйлчлүүлэгчид залгах, холбогдохыг хүсэх үед бид түүнийг мэдэх боломжгүй байдал үүсгэж, бусадтай харилцах харилцаанд хязгаарлалт тогтоох үр дагаврыг үүсгэдэг...”

(Өмгөөлөгч “Ө.Э”-тэй хийсэн ярилцлагаас)³⁶

Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах эрхтэй байх боловч зарим тохиолдолд эрх бүхий байгууллагаас цаг хугацаа, орчин нөхцөлөөр нь хязгаарлалт тогтоох, уулзалтын нууцад халдах асуудал гарч байна.

Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрх

НҮБ-ын “Хуульчдын гүйцэтгэх үүргийн талаарх үндсэн зарчмууд”-ын 16 дугаар зүйлд хуульч нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхдээ өөрийн улс болон гадаад улсад чөлөөтэй зорчих эрхийг баталгаажуулсан. Уг эрхийг Өмгөөллийн тухай хууль болон бусад хуульд тодорхой баталгаажуулаагүй боловч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах эрхийн агуулгад багтаан тайлбарлаж болох үндэстэй. Гэвч гамшиг, онц байдал болон дайн бүхий зэрэг онцгой нөхцөлд байдалд өмгөөлөгчийн чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлах нь шударга

³⁶ Өмгөөлөгчдийг шалгаж, нэгжих болсон нь тэдний эрх ашгийг зөрчиж байна, 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, <https://www.inews.mn/a/32546>

шүүхээр шүүлгэх, хууль зүйн туслалцаа авах зэрэг хүний үндсэн эрхэд сөргөөр нөлөөлдөг болохыг Ковид-19 цар тахлын үеэр Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ тодорхой илтгэж байна.

Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг тогтоохдоо “Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалт”-ийн 10 дугаарт шүүх, прокурорын байгууллагыг жагсаалтад оруулсан атал хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал болох өмгөөлөгч, өмгөөллийн нөхөрлөлийн үйл ажиллагааг орхигдуулсан. Монголын өмгөөлөгчдийн холбооноос тухайн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан шат дараатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч хэрэгжүүлснээр өмгөөлөгчид Улаанбаатар хотод автомашинаар зорчих “QR” код олгосон³⁷.

Тохиолдол 2.18

“...Анхан шатны шүүх дээрх шүүх хуралдаанд шүүгдэгчийг цахим хэлбэрээр буюу онлайнар оролцуулсан нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчилсан “өмгөөлөгчтэйгөө чөлөөтэй харьцах, ганцаарчлан уулзах” зэрэг шүүгдэгчид хуулиар олгогдсон эрхийг эдлүүлэх нөхцөл боломжийг хангасан гэж үзэх үндэслэл болохгүй юм. Шүүгдэгчийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулаагүйгээс шүүгдэгч нь өмгөөлөгчтэйгөө чөлөөтэй харьцах, ганцаарчлан уулзах эрхээ эдлэх, мөн шүүх хуралдаанд биечлэн оролцож хэргийн талаар мэдүүлэг өгөх нөхцөл бүрэн боломжоор хангагдаагүй байхад шүүх хэргийг шийдвэрлэсэн нь шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий хууль ёсны байх нөхцөл бүрдээгүй гэж үзлээ...”

(Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдөр, 0012 дугаар магадлалаас)³⁸

Ковид-19 цар тахлын үед нийслэл болон хот хооронд зорчих хөдөлгөөнийг хязгаарлах хугацаа тодорхой биш, хот хооронд зорчсон иргэдийг аймаг орон нутагт нь тусгаарлаж байгаа зэргээс шалтгаалж, аймаг орон нутагт зохион байгуулагдаж байгаа шүүх хуралд өмгөөлөгч нийслэлээс хүрэлцэн ирж, оролцох боломжгүй болсон. Цахимаар шүүх хуралдаанд оролцоход орон зайн хязгаарлалтгүйгээр оролцох давуу талтай боловч техникийн саатлаас шалтгаалсан хүндрэл бэрхшээлээс³⁹ гадна өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах боломж нөхцөл хязгаарлагдсан зэргээс үүдэн шударгаар шүүлгэх хүний эрхийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлсөн.

Өмгөөллийн нууцыг хадгалах баталгаа

Өмгөөллийн тухай хуульд зааснаар өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, тэдгээрийн харилцаатай холбоотой бүхий л баримт сэлт, мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарах бөгөөд үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс гэрчийн мэдүүлэг, тайлбар авахыг хориглодог. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа эрүүгийн хэрэгтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс мэдүүлэг авах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглосон.

Судалгааны хүрээнд өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үеэр өмгөөлөгчийг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс тайлбар, мэдүүлэг авах гэж оролддог талаар зарим өмгөөлөгчид хэлж байв.

³⁷ Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ, 2021 он, 128 дахь тал. <https://nhrcm.gov.mn/assets/img/349b6c8a2917777a1ac71ea5f9a2477a.pdf>

³⁸ Орхон аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 0012 дугаар магадлал. https://shuukh.mn/single_case/11846?start_date=&end_date=&id=2&court_cat=2&bb=1

³⁹ Мөн тэнд.

Тохиолдол 2.19

“...АТГ-ын мөрдөгчид өмгөөлөгчөөс байцаалт авах гээд байдаг. Өмгөөлөгч өмгөөлж байгаа хэрэгтэйгээ холбоотойгоор ямар нэгэн байдлаар мэдүүлэг тайлбар өгөхгүй байх баталгаа байгаа хэдий ч хэд хэдэн удаа мэдүүлэг авах гэж оролдсон...”

(Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)

Эрүүгийн хэргээс бусад иргэний болон захиргааны хэрэгт ажилласан өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх явцдаа олж авсан мэдээлэлтэй нь холбогдуулан тайлбар, мэдүүлэг авах эрсдэлтэй байна. Иймд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад өмгөөлөгчийг хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс тайлбар, мэдүүлэг авахыг хориглох талаар тусгах шаардлагатай байна.

Тохиолдол 2.20

“...2002 болон 2017 оны эрүүгийн процессын хуулиар өмгөөлөгчөөс зөвхөн эрүүгийн хэрэгтэй нь холбоотой мэдүүлэг авахыг хориглодог. Эрүүгийнхээс бусад буюу иргэний болон захиргааны хэргийн өмгөөлөгчөөс өмгөөллийн ажилтай нь холбоотой мэдүүлэг авч, үйлчлүүлэгчийнхээ нууцыг хадгалах эрхийг нь зөрчих эрсдэл үүсгэж байна. Мөн, АТГ болон ТЕГ-ын харьяаллын болон бусад томоохон хэрэг маргаанд өмгөөлөгчөөр ажилладаг хүмүүс өөрсдийг нь тагнаж чагнадаг хэмээн өмгөөлөгчид хэлдэг. Эрүүгийн процессын явцад нууцаар тагнаж чагнах, шалгах, өмч хөрөнгө хураах ажиллагааг шүүхийн хяналтад оруулахааргүй, нарийвчлан зохицуулаагүй байгаа нь жирийн иргэний хувийн халдашгүй байдал төдийгүй өмгөөллийн үйл ажиллагаа явуулах баталгааг эрсдэлд оруулж байна...”

(МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор,
хууль зүйн доктор О.Мөнхсайханы хэвлэлд өгсөн ярилцлагаас)⁴⁰

Өмгөөллийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг өмгөөлөгчийг гэмт хэрэгт холбогдуулан шалгах явцдаа тухайн хэрэгт хамааралгүй, бусад үйлчлүүлэгчтэй холбоотой баримт сэлтийг гаргуулан авахыг хориглохоор зохицуулсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд уг баталгааг хуульчлаагүй нь тухайн шалгагдаж байгаа эрүүгийн хэрэгтэй нь холбогдолгүй бусад үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах баталгааг алдагдуулах эрсдэлтэй байна. Холбогдох байгууллагаас нэр бүхий хуульч, өмгөөлөгч эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгах явцдаа ажлын байр, гэр, баримт бичигт үзлэг, нэгжлэг хийхдээ дээрх баталгааг хангахын тулд шүүгчийн зөвшөөрлөөс гадна Хуульч, өмгөөлөгчдийн өөрийн удирдлагын байгууллагын удирдлагын төлөөллийг байлцуулах зэрэг⁴¹ эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх нь чухал байна.

2.3. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧ СЭТГҮҮЛЧИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

2.3.1. Сэтгүүлчтэй холбоотой олон улсын болон үндэсний бодлого, хууль тогтоомжийн хүрээ

УИХ-аас 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, хэвлэл мэдээллийн салбар дахь сэтгүүлчийн хараат бус, олон ургалч дуу хоолой нэмэгдсэн хэдий ч тэд өөрсдийн үйл ажиллагааг ямар нэгэн айдас, дарамтгүйгээр чөлөөтэй эрхлэх бололцоог бүрдүүлэх нь чухал байна.

Мэдэх эрх болон мэдээлэл авах эрх нь хүний үндсэн эрх юм. Сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаараа мэдээлэл хайх, олж авах, хүлээн авах, түгээх зэргээр нийтийн мэдэх эрхийг хангадаг учраас тэд хүний эрх хамгаалагчид болно. Мэдэх эрх нь иргэний мэдээлэлтэй байхыг хэлэх бөгөөд тэд үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр хангагдах ёстой билээ.

⁴⁰ О.Мөнхсайхан, Хууль дээдлэх ёсны баталгаа болсон Хуульчдын холбоог татан буулгах гэж үү?, 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр. <https://ikon.mn/opinion/1fdh>

⁴¹ Мөн тэнд

Олон улсын хэмжээнд үйл ажиллагааны статус, төрлөөсөө (хэвлэл, радио, телевиз, эсвэл интернэт) үл хамааран хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа сэтгүүлч бүр хүний эрх хамгаалагч юм⁴².

ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх, төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрх хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд 3 дахь хэсэгт энэхүү эрх чөлөөг хязгаарлах нөхцөлийг заасан. Үүнд:

- а) Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;
- б) Үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаас үүдэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг хуулиар хязгаарлаж болно гэжээ.

ИБУТЭОУП-ын оролцогч улсууд нь итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүхэлд нь хүндэтгэн сахих хууль зүйн үүрэгтэй болно. Түүнчлэн хүний эрхийн олон улсын жишиг хэм хэмжээ нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтын талаарх албан ёсны тайлбар юм. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос ИБУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн талаар гаргасан 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмжийн 45 дахь хэсэгт "Гишүүн орнууд мэдээллийн эх сурвалжаа илчлэхгүй байх сэтгүүл зүйн хязгаарлагдмал давуу эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний бүрэлдэхүүн болохыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэвэл зохино" ⁴³ гэжээ.

Хэвлэл мэдээллийн байгууллага сэтгүүлчийн нийтэлж боловсруулсан мэдээллийн агуулгыг нийгэм, улс төр, ёс суртахуун, шашин, аюулгүй байдал гэсэн шалтгаанаар хянах аливаа үйл ажиллагаа нь цензур тогтоож буй хэлбэр юм⁴⁴. НҮБ-ын Хүний эрхийн хороо, ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 34 дүгээр Ерөнхий зөвлөмжийн 9 дэх хэсэгт "Чөлөөт, цензургүй, хориг саадгүй хэвлэл мэдээлэл нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах, бусад эрх чөлөөг эдлэхэд нийгмийн салшгүй хэсэг юм" ⁴⁵ гэжээ.

ИБУТЭОУП-аар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, гэрээний үүргээс ухрахад баримтлах Сиракузагийн зарчмуудын⁴⁶ 10 дугаар зүйлд зааснаар хүний эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь гурван үндсэн шалгуурыг хангах ёстой. Үүнд:

- Хүний эрхийг хязгаарлах нөхцөлийг хуулиар тогтоосон байх;
- Хүний эрхийг хязгаарлах шаардлагатай байх;
- Хүний эрхийг хязгаарласан байдал, хэр хэмжээ нь тавьсан зорилгодоо тохирсон байх зэрэг болно.

Иймд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аливаа зохицуулалтыг хуулиар тогтоосон байх, зөвхөн олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр тодорхойлсон үндэслэлд нийцсэн, зайлшгүй шаардлагатай бөгөөд зохистой байх шалгуурыг хангасан байх ёстой юм⁴⁷.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан сэтгүүлчдийн аюулгүй байдлын асуудлаарх 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн A/RES/78/215 дугаар тогтоолд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах нь сэтгүүлчдийг хамгаалахтай шууд хамааралтай болохыг тэмдэглэж, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг заналхийлэл, халдлагаас

⁴² ЕАБХАБ-аас гаргасан "Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах удирдамж". <https://www.osce.org/files/f/documents/1/7/454269.pdf>.

⁴³ НҮБ-ын Хүний эрхийн хороо, ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмж, CCPR/C/GC/34, <https://www.refworld.org/>.

⁴⁴ Америкийн Иргэний эрх чөлөөний холбоо, "Цензур гэж юу вэ?", <https://www.aclu.org/other/what-censorship>.

⁴⁵ НҮБ-ын Хүний эрхийн хороо, ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар гаргасан 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмж, CCPR/C/GC/34, <https://www.refworld.org/>.

⁴⁶ НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл 1984 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн E/CN.4/1985/4 дүгээр тогтоолоор баталсан.

⁴⁷ Үзэл бодлоо илэрхийлэх онлайн ба офлайн эрх чөлөөний талаарх Европын холбооны хүний эрхийн удирдамж, https://www.eeas.europa.eu/sites/default/files/09_hr_guidelines_expression_en.pdf.

урьдчилан сэргийлэх, мөн сэтгүүлчийн үйл ажиллагааны эсрэг, ялангуяа эмэгтэй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааг бүрэн явуулах замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийг, тэр дундаа ийм төрлийн гэмт хэргийг үйлдэхийг тушаасан, зохион байгуулсан, туслалцаа үзүүлж, далдалж буй хүмүүсийг шүүхэд шилжүүлэх, хохирогч болон тэдний гэр бүлийнхэнд өөрийгөө хууль зүйн арга замаар хамгаалах боломжоор хангах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг заналхийлэл, халдлагыг шударга, шуурхай, нягт нямбай, хараат бус, үр дүнтэй мөрдөн шалгах замаар хариуцлага тооцохыг гишүүн орнуудад уриалсан⁴⁸.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмжид “Сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулсны төлөө эрүүгийн хуулиар шийтгэх нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогдоно⁴⁹” гэжээ. Эрүүгийн хуулиар хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлах нь сэтгүүл зүйн үйл ажиллагаанд цензур тогтоох үр дагавартай талаар хүний эрхийн гэрээний хороодын дүгнэлт, зөвлөмжид дурдсан байна⁵⁰.

Улс орнууд сэтгүүлчдэд Эрүүгийн хуулиар хариуцлага тооцохоос татгалздаг бол манай улсад сэтгүүлчдийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай биш, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ажлыг хийхэд хууль, тогтоомжоор хориглосон зохицуулалт их байгаагаас сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө худал мэдээлэл тараасан, бусдын нэр төр, алдар хүндэд халдсан, эдийн бус хохирол учруулсан гэх асуудлаар хуулийн байгууллагад шалгагдах нь нийтлэг байна.

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн "Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах" асуудлаар 2021-2024 оны эхний хагас жилийн байдлаар 56 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 30 нь сэтгүүлчтэй холбоотой байна. Тодруулбал 2021 онд 18 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 9 буюу 50 хувь, 2022 онд 21 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 10 буюу 47.6 хувь, 2023 онд 10 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 6 буюу 60 хувь, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 7 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний 4 буюу 57.1 хувь нь сэтгүүлчидтэй холбоотой байна⁵¹.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд зааснаар илт худал мэдээлэл тараах гэмт хэрэгт 2023 онд 3 сэтгүүлч, 2024 оны эхний хагас жилийн байдлаар 2 сэтгүүлчийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна⁵².

Комиссоос 2024 онд өмгөөлөгч, сэтгүүлчтэй холбоотой эрүү, иргэний хэрэг маргаантай шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна⁵³. Тухайлбал:

- Эрүүгийн 10 хэрэгт 14 этгээдийг хохирогчоор тогтоосны 9 нь улс төрийн албан тушаалтан, 1 нь улс төрийн албан тушаалтантай хамаарал бүхий, 2 нь хууль сахиулах байгууллагын албан тушаалтан, 1 нь төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан, 1 нь ерөнхий боловсролын сургуулийн захирал байв. Тэд өөрсдийнх нь нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан гэж үзэж, нэр төр, алдар хүндээ сэргээлгэхээр цагдаагийн байгууллагад ханджээ. Эдгээр 10 хэрэгт 12 сэтгүүлчийг холбогдуулан шалгагдсаны 11-ийг нь гэм буруутайд тооцож, 8-д нь ял оногдуулж, 2 нь Өршөөлийн тухай хуульд хамруулсан бол, 1 сэтгүүлчид холбогдох хэргийг шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна. Дээрх ял авсан 8 сэтгүүлчид торгох болон зорчих эрх хязгаарлах гэсэн 2 төрлийн ял оногдуулсан. Торгох ял оногдуулсан мөнгөн торгуулийн дээд хэмжээ нь 1,800 нэгж буюу 1,800,000

⁴⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн A/RES/78/215 дугаар тогтоол. <https://documents.un.org/doc/undoc/gen/n23/422/04/pdf/n2342204.pdf>.

⁴⁹ НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр Ерөнхий зөвлөмж, CCPR/C/GC/34. <https://www.refworld.org/https://www.refworld.org/>.

⁵⁰ “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” Боть I, II. <https://nhrcm.gov.mn/#/page/209/post/list/209/209>

⁵¹ ШЕЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 03/1935 дугаар албан бичиг.

⁵² ШЕЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 03/1935 дугаар албан бичиг.

⁵³ Комиссоос 2024 онд “Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны шийдвэрт хийсэн дүн шинжилгээ”-ний тайлан.

төгрөг, доод хэмжээ 500 нэгж буюу 500,000 төгрөг байв. Харин 1 шүүгдэгчид 6 сарын хугацаанд өөрийн амьдарч буй дүүргээс гарахгүй байх зорчих эрх хязгаарлах ял оногдуулжээ. Мөн хэрэгт шалгагдаж байх хугацаандаа хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг 10 шүүгдэгчид, Монгол Улсын хилээр гарахыг хориглох таслан сэргийлэх арга хэмжээг 2 сэтгүүлчид авч, 4 хэргийн хохирогчдоос нийт 72,369,000 (далан хоёр сая гурван зуун жаран есөн мянга) төгрөгийн хохирол нэхэмжилсэн. Үүнээс 2 сэтгүүлчээс нийт 7,116,280 (долоон сая нэг зуун арван зургаан мянга хоёр зуун наяд) төгрөгийг гаргуулж, хохирогчид олгуулахаар шийдвэрлэсэн байна.

- Иргэний 10 хэрэгт нэхэмжлэл гаргагчдын 6 нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага байна. 3 хэргийн нэхэмжлэгчээс эдийн бус гэм хорын хохиролд нийт 2,013,867,000 (хоёр тэрбум арван гурван сая найман зуун жаран долоон мянга) төгрөг шаардсанаас шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон байна. Мөн 10 хэрэгт 6 сэтгүүлч, 9 хэвлэл мэдээллийн байгууллага, 1 өмгөөлөгчийг хариуцагчаар тогтоосон байна. Анхан шатны шүүхээр 10 хэргээс 2 хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, 4 хэргийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, 4 хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож тус тус шийдвэрлэжээ. Эдгээрээс 4 хэрэгт нэхэмжлэгч талаас давж заалдах гомдол гаргаж, 1 хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж буюу гомдлын шаардлагын зарим хэсгийг хангаж, бусад 3 хэрэгт давж заалдах гомдлыг хангаж буюу нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж шийдвэрлэсэн байна.

Тохиолдол 2.21

“...Шүүгдэгч сэтгүүлч “З.У” нь иргэн “Б.Э”-ыг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах нэр бүхий төрийн байгууллагын захирлаар ажиллаж байхад нь “байн байн гадаадад аялдаг, аяллын золиосонд тус байгууллагын ажилтнууд цалингаа авч чадахгүй өнөөдрийг хүрч байна” гэх хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг “MN Barimt” фэйсбүүк цахим хуудсаар олон нийтэд тарааж худал мэдээлэл тараасан гэмт хэрэгт холбогджээ. Улмаар Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн “З.У”-д холбогдох эрүүгийн хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, цагаатгажээ...”

(Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 2023/ШЦТ/674 дүгээр цагаатгах тогтоол⁵⁴)

Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан Эрүүгийн хууль болон Иргэний хуулийн тодорхой заалтуудыг үндэслэн хэрэг, маргаан үүсгэх тохиолдол багагүй гарч байгаа нь хүний эрхийг хязгаарлах үндэслэл, журмыг Монгол Улсын үндэсний эрх зүйн хэм хэмжээнд тодорхой тусгаж, хуульчлаагүй, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх явдал хангалтгүй байгаагаар холбоотой юм. Тухайлбал 2002 оны Эрүүгийн хуульд байсан “гүтгэх, доромжлох” гэмт хэрэгт холбогдох заалт, Зөрчлийн хуульд байсан “гүтгэх” заалтыг хүчингүй болгосон хэдий ч Эрүүгийн хуульд 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлтээр оруулсан “худал мэдээлэл тараах” тухай зохицуулалт нь сэтгүүлчийн үйл ажиллагааг хязгаарлахад ашиглагдаж байгааг дээрх баримтаас харж болох юм.

Комисс нь Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж эхэлснээс хойш хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн гэх асуудлаар 2022-2025 онуудад 180 орчим гомдол, мэдээллийг хүлээж авч шийдвэрлэсэн. Үүнээс ХЭХЭЗБТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо 2023 онд 2, 2024 онд 7, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 1 дүгнэлтийг тус тус гаргасан. Хорооны 2 дүгнэлт нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай хамааралтай байв.

⁵⁴ Шүүхийн шийдвэрийн цахим сан https://shuukh.mn/single_case/98539?daterange=2023-01-01%20-%202023-12-31&id=1&court_cat=2&bb=1

Тохиолдол 2.22

“...Цагдаагийн байгууллага болон Прокурорын байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа нэрийн дор үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хязгаарлаж эрх зүйт төр, хууль ёсыг уландаа гишгэж, дураараа авирлаж байгаа үйлдлүүд нь хэрээс хэтэрч байх тул та бүхэнд хандахаас өөр аргагүйд хүрлээ.” гэсэн агуулга бүхий гомдолд Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо холбогдох ажиллагааг хийсэн.

Сэтгүүлч “Н.Ө” иргэд, олон нийтэд мэдээлсэн мэдээ, мэдээлэл болон түүнд холбогдох баримтуудыг шинжлэн судлахад хуулийн дагуу болон нууцад хамааруулснаас бусад мэдээ, мэдээллийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдээс хуульд заасан аргаар олж аван, хэвлэн нийтэлж, бусдад түгээсэн нь Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа гэж үзэх үндэслэлтэй байна.

Сэтгүүлч “Н.Ө”-тэй холбогдох хувь хүний тодорхой үйлдлүүдийг гэмт хэрэгт холбогдуулан шалгаж байх үедээ түүний хамаарал бүхий аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд болох “Zarig.mn” цахим сайтын Монгол Улсаас хандах хандалтыг бүхэлд нь тодорхой хугацаагаар хаасан нь иргэд, олон нийтийн мэдэх эрхийг хязгаарлаж, сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна.⁵⁵

(Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээс)

Комиссын дэргэдэх хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооноос гаргаж буй дүгнэлт нь сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулсныг нотлох эрх зүйн баримт бичиг болох бөгөөд сэтгүүлчийг хүний эрх хамгаалагч болохыг хүлээн зөвшөөрсөн жишиг юм. Комисс нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 10 удаагийн илтгэлдээ үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэл мэдээлэл болон хэвлэн нийтлэх эрхийн асуудлаар тусгаж ирсэн⁵⁶.

Монгол Улсад нэр бүхий сэтгүүлчдийг баривчилж, цагдан хорьж, хорих ялаар шийтгэж буй явдал нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг нэн даруй хангах шаардлагатай байгааг “Хил хязгааргүй сэтгүүлчид”⁵⁷, “Олон улсын Сэтгүүлчдын холбоо”⁵⁸ зэрэг олон улсын байгууллагууд сануулж, шаардсан.

Тохиолдол 2.23

...ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газраас “Ноорог Креатив Студио” ХХК-ийн О.У, Б.Х, А.О, Б.П, Ё.Т, Н.Б, Б.Б, Б.Б нарын 8 ажилтныг 2025 оны 3 дугаар сарын 17-18-ны шилжих шөнө 22.00-07:00 цагийн хооронд хойшлуулшгүй ажиллагаа явуулж ажлын

⁵⁶ Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт” хоёрдугаар бүлэгт Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай, Төрийн бус байгууллагын тухай зэрэг хуулиудад хийсэн дүн шинжилгээний үр дүнг үндэслэн эдгээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлийг УИХ-д танилцуулсан. Дэлгэрэнгүй мэдээллийг Комиссын цахим хуудсаас авна уу.

https://nhrcm.gov.mn/pdf/22_%D0%B8%D0%BB%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB.pdf

⁵⁷ Монгол Улс: “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас zarig.mn сайтын ерөнхий редакторыг суллахыг уриаллаа, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр.

<https://rsf.org/en/mongolia-rsf-urges-release-zarigmn-news-site-chief-editor>.

Монгол Улс: Шадар сайдын хөрөнгө шамшигдуулсан байж болзошгүй хэргүүдийг илчилсэн сэтгүүлч найман жилийн хорих ялаар шийтгүүлэхээр байна. <https://rsf.org/en/mongolia-journalist-faces-eight-years-prison-exposing-suspected-embezzlement-deputy-prime-minister>

“Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллага: Ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэдэг гэж Монгол Улсын Засгийн газар мэдэгдэж байсан хэдий ч сүүлийн үед Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө хумигдсаар байна. Монгол Улсын Шадар сайд, УИХ-ын гишүүн хууль бус үйлдэл хийснийг гэж мэдээлсний улмаас 2024 оны 05 дугаар сард сэтгүүлч “А.Б”-г баривчилж, цагдан хорьж, улмаар яллагдагчаар татсан байна.

<https://rsf.org/en/mongolia-closed-door-appeal-trial-detained-journalist-alarming-sign-press-freedom>

⁵⁸ “Олон улсын Сэтгүүлчдын холбоо”, Монгол: Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн мэдээлэл нийтэлснийхээ төлөө редактор баривчлагдаж, цахим сайт буруутгагдав. <https://www.ifj.org/media-centre/news/detail/article/mongolia-editor-arrested-and-website-targeted-for-reporting-in-the-public-interest>

байранд нь нэгжлэг хийж, цахим төхөөрөмжүүдийг хураан авч, тэдний халдашгүй, чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөн байж болзошгүй гэх мэдээлэл олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн. Энэхүү мэдээллийн мөрөөр Комисс хуулийн дагуу ажиллагаа явуулж, тогтоогдсон нөхцөл байдлын талаар 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдөр иргэд, олон нийтэд танилцуулсан. Үүнд:

“Ноорог Креатив Студио” ХХК-ийн 8 ажилтанд холбогдох хойшлуулшгүй ажиллагаа ямар үндэслэлээр явуулсан, ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан эсэх талаар эрх бүхий хууль сахиулах, төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудаас хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өгсөн мэдээлэл зөрүүтэй, тодорхой бус байсан нь олон нийтэд эргэлзээ төрүүлэхүйц, ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэсэн...

Мэдээлэл авах эрх, үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16, ИБУТЭТОУП-ын 18, 19 дүгээр зүйлээр баталгаажсан эрх чөлөө юм. Чөлөөтэй, ямар нэг хууль бус, дур зоргын шинжтэй цензур, хязгаарлалт, дарамт шахалтаас ангид үзэл бодлоо илэрхийлэх, ялангуяа төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны талаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүний эрхийн эрх зүй онцгойлон хамгаалдаг.

Иймд иргэн О.У, Б.Х, А.О, Б.П, Ё.Т, Н.Б, Б.Б, Б.Б нарын халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөндөж, Монгол Улсын иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрмэлзэл, зоригийг мохоох үр дагавар үүсгэсэн...

Төрийн байгууллагууд болсон үйл явдлын талаар мэдээлэхдээ олон нийтийн мэдээлэл авах эрхийг бодитой хангаагүй гэжээ.

(2024 оны 03 дугаар сарын 24-ний өдөр иргэд, олон нийтэд танилцуулсан Хэвлэлийн хурлын үеэр хийсэн мэдээллээс⁵⁹⁾

“Хил хязгааргүй сэтгүүлчид” байгууллага нь хараат бус “Ноорог” цахим мэдээллийн хэрэгслийн редакцын байранд цагдаагийнхан хойшлуулшгүй ажиллагаа явуулж, ажилтнуудыг нь шөнөжин байцаан, мэргэжлийн техник хэрэгслийг нь хураан авсныг буруушааж байна. “Ноорог” сайтынхан сонгуулийн тухай баримтат киногоо нээхээр зэхэж байгаа талаар олон нийтэд мэдээлсний дараахан “үндэсний эв нэгдлийг бусниулсан” гэх үндэслэл муутай шалтгаанаар энэхүү дур зоргын ажиллагааг явуулжээ гэсэн мэдэгдэл гаргасан⁶⁰. Түүнчлэн “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллага нь үүсээд буй энэхүү санаа зовоосон нөхцөл байдал, мөн Засгийн газраас Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэхээр төлөвлөж буйтай холбогдуулан Монгол Улсын хууль тогтоогчдод сэтгүүлчдийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлэх талаар багц зөвлөмж хүргүүлсэн байна⁶¹.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрхийг баталгаажуулсан⁶².

Олон ургалч үзэл санаа, редакцын хараат бус байдлыг баталгаажуулах зорилгоор Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй.”, мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэж тус тус заасан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт “Мэдээг олон талт эх сурвалжийг ашигласан, үйл явдлыг үнэн, шударга, тэнцвэртэй, хараат бус байхаар мэдээлнэ”, 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт “Ивээн тэтгэгч иргэн, хуулийн этгээд мэдээ,

⁵⁹ <https://www.facebook.com/nhrm/videos/1045436887618155>

⁶⁰ “Хил хязгааргүй сурвалжлагчид” байгууллага, Хараат бус “Ноорог” мэдээллийн хэрэгслийн эсрэг цагдаагийн ажиллагааг дур зоргоор явуулсныг буруушааж байна. <https://rsf.org/en/mongolia-rsf-condemns-arbitrary-police-operation-against-independent-media-outlet-noorog>

⁶¹ <https://rsf.org/en/mongolia-rsf-presents-its-recommendations-strengthen-ambitious-press-freedom-bill>

⁶² Монгол Улсын Үндсэн Хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

нэвтрүүлгийн агуулга, хугацаа болон сэтгүүлч, редакцын бие даасан, хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно”, 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч нь өөрийн редакцын бодлого, дүрэмтэй байх” гэж тус тус заажээ.

2018 онд хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох” судалгаанд 300 сэтгүүлчийг хамруулснаас тэдний 52 хувь нь редаксаас зарим асуудалтай холбоотойгоор нийтлэл, нэвтрүүлгийг нь хориглосон гэжээ. “Таны нийтлэл, нэвтрүүлгийг нийтлэгдэх, нэвтрүүлэхээс өмнө хориглосон эсэх” гэж асуухад 23.3 хувь нь “тийм” гэж хариулсан бөгөөд дийлэнх нь “Хаалтын гэрээ” эсвэл редакцын удирдлагын заавраар нийтлэл, мэдээллээ гаргаж чадаагүй гэжээ. Хэвлэл мэдээллийн салбар дахь “Хаалтын гэрээ”, бизнес улс төрийн ашиг сонирхлын хамаарлаас үүдэлтэй редакцын цензур хэвшмэл зүйл болж эхэлжээ⁶³. Хэвлэл мэдээллийн байгууллагууд “Хаалтын гэрээ” байгуулах нь хэвлэл мэдээллийн тэнцвэртэй, чөлөөт, олон ургалч, хараат бус байх зарчимтай үл нийцэх⁶⁴ юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд “Хаалтын гэрээ” байгуулахыг хориглосон шинжтэй заалтыг сонгуулийн тухай хууль тогтоомжид⁶⁵ тусгаж, үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай⁶⁶ хуульд хариуцлага тооцохоор заасан нь зөвхөн сонгуулийн сурталчилгааны үед хамаарч байна. Иймээс хэвлэл мэдээллийн байгууллага “Хаалтын гэрээ” байгуулахыг хориглосон зохицуулалтыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгах нь зүйтэй юм.

Хараат бус хэвлэл мэдээлэл нь олон талын санаа бодлыг сонсох, олон нийтийг мэдээллээр хангах, шийдвэр гаргагчдыг хариуцлагатай байлгах, иргэд эрх чөлөөгөө эдэлж, шийдвэр гаргах боломжийг бүрдүүлдэг ач холбогдолтой билээ. Иймээс хэвлэл мэдээллийн хараат бус байдал нь редакцын хараат бус байдал хэрхэн хангагдаж байгаагаас хамааралтай тул редакцын хараат бус байдлыг баталгаажуулж, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх зохицуулалтыг бий болгох хэрэгтэй.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 73 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам”-ын 2.2-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээдээс хараат бус, бие даасан, мэргэжлийн Редакцын зөвлөлтэй байна” гэж заасан. Гэвч өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогоос бусад буюу сонин, сэтгүүл, мэдээллийн сайтын хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, нэгдмэл сонирхолтой этгээд нь хараат бус, бие даасан, мэргэжлийн редакцтай байх, тэдгээрийн ашиг сонирхлын зөрчил нь сэтгүүлчдийг өөрийн цензурт автахаас сэргийлэх тусгайлсан зохицуулалт байхгүй. Редакцын хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид тусгаагүй орхигдуулсан байна.

Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 14.3 дугаар зүйлд “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт нь олон ургалч үзэл санаа, редакцын хараат бус байдлыг баталгаажуулахад дангаараа хангалтгүй байна.

⁶³ Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2017”. УБ, 2018 он, 6 дахь тал. https://www.globeinter.org.mn/images/upld/media_freedom_report_2017_mn.pdf

⁶⁴ Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2020”, УБ 2021 он, 33 дахь тал. https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2020_mn.pdf

⁶⁵ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/14869>

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891958781>

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.8 дахь хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15125>

⁶⁶ Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 19 дэх хэсэг. <https://legalinfo.mn/mn/detail/12695>

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах нь сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалахтай харилцан хамааралтай юм. Олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийн сэтгүүл зүйн эх сурвалжийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг олон улсын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгоход анхаарах шаардлагатай байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д хүний эрх хамгаалагч нь “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явцад олж авсан мэдээллийн эх сурвалжийг тухайн хүний эрхийн зөрчил арилж, эрх нь бүрэн сэргээгдэх хүртэл хугацаанд нууцлах” бүрэн эрхтэй гэж заасан.

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй” гэжээ. Үүнээс үзэхэд мэдээллийн эх сурвалжийг албадан ил болгох эрхийг зөвхөн шүүх хэрэгжүүлэх бөгөөд олон нийтийн радио, телевизийн бус редакц, сэтгүүлчийн хувьд мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхийг хуулиар баталгаажуулаагүй байна. Харин Хэвлэл мэдээллийн зөвлөлийн Ёс зүйн хороодын 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8 дахь хэсэгт “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэж зааснаар сэтгүүлчид нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүргийг хүлээж байна.

УИХ-аас 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он)-ийн 3.4 дэх хэсэгт Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэхтэй зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно.
- Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг аливаа дарамт, шахалт, сүрдүүлгээс хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ.
- Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ гэжээ⁶⁷.

Эрүүгийн хуулийн зарим зохицуулалт сэтгүүлч болон түүний мэдээллийн нууц эх сурвалжийн хамтын ажиллагааг хязгаарлах үр дагавартай байна. НҮБ-ын Тусгай илтгэгч тэргүүтэй төлөөлөгчдийн Хамтарсан тунхаглалд “Төрийн нууцыг хамгаалах үүргийг зөвхөн түүнийг хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан хүлээнэ. Сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгч зэрэг бусад этгээдийн хувьд мэдээллийг нийтэлж, түгээсний төлөө хууль зүйн хариуцлага хүлээх ёсгүй. Зөвхөн төрийн нууц хариуцсан этгээд түүнийг түгээсний төлөө хариуцлага хүлээх нөхцөлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт тусгах ёстой” гэж дурдсан⁶⁸.

Гэвч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 19.11 дүгээр зүйлд “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэргийг шинээр оруулсан нь зөвхөн төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд бус иргэн,

⁶⁷ УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2023–2030 он) <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139806351&showType=1>

⁶⁸ НҮБ-ын Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (OSCE) Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх Төлөөлөгч, Америкийн орнуудын байгууллагын (OAS) Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын гаргасан “Хамтарсан тунхаглал”, 2004 он. <https://www.osce.org/fom/99558?download=true>

сэтгүүлчийн хувьд энэ гэмт хэрэгт холбогдон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр шалгагдах нөхцөл бүрдсэн байна⁶⁹.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх 2016 оны 33/2 дугаар тогтоолд НҮБ-ын гишүүн улсуудыг сэтгүүлчдийн эх сурвалжийн нууцлалыг хангах хууль тогтоомж батлах, хэрэгжүүлэхийг уриалсан⁷⁰.


Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах асуудлыг хуульчлан тогтоогоогүйгээс тэд ямар нэгэн дарамт шахалт, заналхийлэлд өртөж, сэтгэл санааны хямралд орох явдал багагүй гарч байна. Иймээс сэтгүүлчид, редакторын мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах зохицуулалтыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгаж, ингэхдээ бусад улс орны сайн туршлагад тулгуурлан хуульчлахад анхаарах хэрэгтэй юм.

2.3.2. Сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

Монгол Улсад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, эх сурвалжаа нууцлах эрхийг баталгаажуулах, редакцын хараат бус байдлыг бий болгох, хэвлэл мэдээллийн салбарын бие даасан байдлыг улам бэхжүүлэх замаар сэтгүүлчид мэргэжлийн хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хэвлэлийн эрх чөлөөний байдал Монгол Улсад хангалтгүйг олон улсын байгууллагууд анхааруулж байна. Тухайлбал “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс”-ийн 2023 оны тайланд Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөө 70-аас бага оноотой буюу “асуудалтай” гэж дүгнэсэн бол 2024 онд Монгол Улсын хэвлэл мэдээллийн эрх чөлөөг 51.34 оноотойгоор “муу” гэж дүгнэгдсэн бөгөөд 180 орноос 109 дүгээрт эрэмбэлэгджээ.⁷¹ Энэ нь 2023 оны үзүүлэлтээс 21 байр ухарсан үзүүлэлт бөгөөд хэвлэлийн эрх чөлөө улам бүр хумигдаж байгаа улс орнуудын тоонд багтсан гэсэн үг юм.

Бүдүүвч 3.4 Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний индекс, 2013-2024



⁶⁹ Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2019”, УБ, 2020 он, 14 дэх тал. <https://www.gic.mn/post/r/1528>

⁷⁰ НҮБ-ын “Хүний эрхийн зөвлөлийн сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх” 2016 оны 33/2 дугаар тогтоол. https://ap.ohchr.org/documents/dpage_e.aspx?si=a/hrc/res/33/2

⁷¹ “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас танилцуусан Монгол Улсын үзүүлэлт. Тус байгууллага нь улс орнуудын хэвлэлийн эрх чөлөөний индексийг дүгнэхдээ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний нөхцөл байдлыг түүний олон талт байдал, хэвлэл мэдээллийн хараат бус байдал, хууль тогтоомжийн зохицуулалтын чанар, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг экспертүүдээс авсан асуулга болон сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн тоон дээр үндэслэдэг. Уг индекс нь тухайн улс орны сэтгүүл зүйн чанарын үзүүлэлт биш юм. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексийн оноог 86-100 оноо “сайн”, 70-85 оноо “эерэг”, 55-70 оноо “асуудалтай”, 40-55 оноо “муу”, 0-40 оноо “маш муу” гэж ангилдаг. <https://rsf.org/en/mongolia>

Энэ үзүүлэлтийн шалтгааныг дараах байдлаар тайлбарласан байна. Үүнд:

- Улс төрийн нөхцөл-Хэвлэл мэдээллийн эзэмшил төвлөрсөн бөгөөд ил тод бус байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн намууд, Засгийн газрын хамааралтай ба хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломж улс төрчдийн шахалтаар хязгаарлагдмал байна.
- Эдийн засгийн асуудал-Хэвлэл мэдээллийн эзэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг улс төрийн давуу тал олж авах, эдийн засгийн ашиг сонирхлоо хамгаалах хэрэгсэл болгон ашиглаж байна. Цалин багатай, ачаалал ихтэй байгаагаас сэтгүүлчид тодорхой контент бэлтгэж цалин авахыг хүлээн зөвшөөрдөг нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг алдагдуулж байна.
- Эрх зүйн асуудал-Нэр төр, алдар хүндтэй холбоотой хэргийн ихэнх нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг чиглэж байна. Өндөр дүнтэй нэхэмжлэл, эрүүгийн хариуцлага нь тэднийг өөрсдийгөө цензур тогтоон, хараат бус байх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх зоригийг мохоож байна. Сэтгүүлч худал мэдээлэл тараасан хэргээр буруутгагдаж буй олон тохиолдолд улс төрчид, УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчид болон төрийн байгууллагууд гомдол гаргаж байна.
- Нийгэм, соёлын нөхцөл байдал-Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үл итгэх хандлага нэмэгдсэн байна.
- Сэтгүүлчдийн эсрэг дарамт шахалт-Олон сэтгүүлч ажилтайгаа холбоотойгоор заналхийлэл, дарамт шахалт, доромжлолд өртөж, энэ төрлийн хэргүүдийн хохирогч болж байна.

Ерөнхийдөө олон улсын хэмжээнд сэтгүүлчидтэй холбоотой нөхцөл байдал хүнд байна. Тухайлбал олон улсын хэмжээнд 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 528 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн 26 ажилтан мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор цагдан хоригдож байгаа бол 2024 онд 48 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотойгоор амь насаа алдсан байна⁷².

Монгол Улсад тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо 2020 оноос хойш жил тутам буурсан үзүүлэлттэй байна. Тодруулбал 2020 онд 513 байсан бол 2023 оны байдлаар 434 болж 79-өөр буурчээ. 2023 оны байдлаар 51 сонин, 41 сэтгүүл, 45 радио, 111 телевиз, 186 мэдээллийн сайт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна⁷³.

2024 оны байдлаар хэвлэл мэдээллийн салбарын 434 байгууллагад 4,378 хүн ажиллаж байна. Насны хувьд нийт ажиллагчдын 28 хувийг 30 хүртэлх насныхан, 38 хувийг 30-40 хүртэлх насныхан бүрдүүлж байна. Тус салбарт ажиллаж буй хоёр хүн тутмын нэг нь сэтгүүл зүйн бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, редактор, тоймчид байгаа бөгөөд тэдгээрийн тал хувь нь сэтгүүлч мэргэжилтэй байна⁷⁴.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “хүний эрх хамгаалах үйл ажиллагаа” гэж хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжиж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн эсрэг хүчирхийллийн бус аргаар үзэл бодлоо илэрхийлж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг хүндэтгэж, аливаа хэлбэрээр хүний эрхийг хамгаалахыг ойлгоно, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д хүчирхийллийн арга хэрэглэж, тайван бус замаар үйл ажиллагаа явуулах, явуулахыг уриалахыг хориглосон. Үүнээс үзэхэд хүчирхийллийн бус, тайван замаар сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй үйлдэл нь хүний эрх

⁷² “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагаас гаргасан барометр, 2025 он. https://rsf.org/en/barometer?type%5Btue%5D=tue&type%5Bemprisonnement%5D=emprisonnement&type%5Botage%5D=otage&type%5Bdisparition%5D=disparition&annee_start=2024&annee_end=2024#exaction-victimes

⁷³ Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, УБ, 2024 он, 4 дэх тал.

⁷⁴ Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл-өнөөдөр”. УБ, 2024 он, 66-67 дахь тал.

хамгаалагчийн үйлдэл болох тул сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаандаа хүчирхийллийг өөгшүүлэхгүй, сурталчлахгүй байх шаардлагатай юм.

“Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч, сэтгүүлчийн өнөөгийн нөхцөл байдал” судалгааны хүрээнд 424 сэтгүүлчээс анкетын асуулга авч, 5 удаагийн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагыг 10 сэтгүүлчийг оролцуулан хийсэн судалгааны үр дүнгээс харахад сэтгүүлчдэд тулгамдаж буй дараах нийтлэг асуудал байна. Үүнд:

- Улс төрийн хараат байдал, хуулийн байгууллагаар шалгагдаж буйгаас үүсэж буй дарамт;
- Мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийн хязгаарлалт;
- Сэтгүүлчдийн эсрэг сэтгэл санааны дарамт шахалт;
- Санхүүгийн хараат байдал зэрэг болно.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн байгууллагууд нь улс төрийн хамааралтай, хараат байгаагаас сэтгүүлчид заналхийлэл, айлган сүрдүүлэлт, дарамт шахалтад өртөх эрсдэлтэй байна. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 35 хувь нь төрийн байгууллага, албан тушаалтнуудаас дарамт шахалт ирдэг гэжээ. Харин 13.4 хувь нь сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбогдуулан зөрчлийн хэрэгт шалгагдсан байна. Тэдний 14.1 хувь нь Улаанбаатар хотод, 8.3 хувь нь аймаг, орон нутагт сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө зөрчлийн хэрэгт шалгагджээ.

Тохиолдол 2.24

“...Олон жил энэ салбарт ажилласан ч сүүлийн жилүүдэд л анх удаа шүүхэд дуудагдаж, эрүүгийн хэрэгт холбогдох шахав. Миний бичсэн нийтлэлд нэр дурдагдсан хүн намайг шүүхэд өгсөн. Тэр хүний талаар бичсэн бүхэн нотолгоотой, үнэн байтал намайг “илт худал мэдээлэл тараасан” гэж буруутгасан. Шүүхийн процесс сунжирч, намайг удаан хугацаанд сэтгэл санааны дарамтад оруулсан. Энэ мэт эрүүгийн хэрэгт татах эрсдэл өндөр байдаг. Сэтгүүлч мэдээ мэдээлэл олж авах, түүнийгээ хэвлэн нийтлэх үндсэн ажлынхаа төлөө өөрөө хэрэгт холбогдох эрсдэл байгааг би хүлээн зөвшөөрдөггүй...”

(Сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас)

Судалгаанд оролцогчид мэргэжлийнхээ хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулахад учирч буй аюул, эрсдэлийг 1-5 оноогоор үнэлэхдээ хувь хүний хүрээн дэх эрсдэлийг хамгийн өндөр буюу 3.25 оноогоор үнэлсэн бол нийгмийн хүрээний аюул эрсдэлийг 3.07, хамт олны хүрээнд 3.05, гэр бүлийн хүрээнд 3.04 оноогоор тус тус үнэлсэн байна.

Тохиолдол 2.25

“...Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хамгаалах ямар ч систем Монголд байхгүй юм байна гэж бодсон. Ямар нэгэн байдлаар хэрэг төвөгт орооцолдчихвол гэр бүл үр хүүхдүүд маань яаж амьдрах билээ гэсэн айдастай байдаг. Жоохон хөдөлгөөнтэй байгаад мэдээ мэдээлэл бэлдэж байгаа сэтгүүлчид бол дарамтад их өртдөг эсвэл, зорилготой л ажилладаг гэж боддог. Тийм ч зүйл ажиглагддаг шүү дээ...”

(Сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас)

Эдгээр аюул ихэвчлэн хэнээс болж үүсдэг вэ? гэхэд 35 хувь нь төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас, 25 хувь нь хууль сахиулагчдаас, 15 хувь нь хэвлэл мэдээллийн салбарын хүмүүсээс, 15 хувь нь ажиллаж буй редакцияас, 8 хувь нь иргэдээс, 2 хувь нь хэвлэл мэдээллийн байгууллагын эзэмшигч, өмчлөгчөөс гэж тус тус хариулжээ.

Мэдээллийн нууцыг хадгалах, мэдээллийн сүлжээний аюулгүй байдал хангагдсан байх нь сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагааны чухал хэсэг юм. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчид мэдээллийн аюулгүй байдал хангагдсан байдлыг 3.19 оноогоор үнэлсэн байна. Үүнээс үзэхэд сэтгүүлчдийн хувьд мэдээллийн нууцыг хадгалах, сүлжээний аюулгүй байдал дунд зэрэг хангагдсан байна.

Сэтгүүлчдийн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрх хязгаарлагдсан хэвээр байна. УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах асуудлыг зохицуулдаг бөгөөд энэ нь төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт бий болгоход чухал үүрэгтэй юм. Гэвч төрийн байгууллагууд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өгөхгүй байх, мэдээлэл хүсэгчдэд саад учруулах хандлага ажиглагдаж байна. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 29.7 хувь нь эх сурвалж олох, хуулийн хүрээнд ажиллах боломжгүй байгаад санаа зовж буйгаа илэрхийлсэн. Мөн 42.7 хувь нь төрийн байгууллагад асуудлаа шийдвэрлүүлэхээр хандсан ч шийдвэрлэлтийн түвшин “дунд” болон “доогуур” гэж үнэлжээ.

Үүнээс үзэхэд нийтийн албан тушаалтан олон нийтэд хандан мэдээлэл хийх үеэрээ сэтгүүлчдийн асуултад агуулгын хяналт тогтоон хариулах, эс хариулахаа өөрийн үзэмжээр шийдэн илтэд зүй бус хандах явдал нь сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа, олон нийтийн мэдэх эрхийг зөрчиж буй үйлдэл юм.

Тохиолдол 2.26

“...Сэтгүүлч болсон цагаасаа хойш олон сэдэв хөндөж ирсэн. Хамгийн хэцүү нь Засгийн газар, улс төрчидтэй холбоотой шүүмжлэл бичих байдаг. Зарим тохиолдолд редакторын зүгээс бүтээлийг маань нийтлэхгүй байх, устгах зэрэг зүйл тохиолддог. Шалтгааныг нь тодорхой тайлбарладаггүй. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн бодит байдал тийм ч хангалттай биш шүү дээ. Сэтгүүл зүй улам л ямар нэгэн байдлаар хараат байдалд ороод байгаа юм шиг санагдах болсон...”

(Сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас)

Үүнээс үзэхэд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар үүрэг хүлээсэн субъектүүд хүний эрх хамгаалагчдын эрхийг хүлээн зөвшөөрөх, үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах, шаардлагатай мэдээллээр хангах явдал бодитой хэрэгжихгүй байгаагаас хүний эрх хамгаалагчдын эрх зөрчигдөж, хүний эрхийн соёл, хандлага төлөвшиж чадахгүй байна⁷⁵.

Сэтгүүлчид мэдээлэл авах эрх хязгаарлагдаж байгаа талаар санаа зовниж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг 1-5 оноогоор үнэлүүлэхэд 3.19 буюу дунд зэрэг хангагдсан гэж үзжээ. Харин мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад тулгарч буй асуудалд 29.7 хувь нь эх сурвалж олох, хуулийн хүрээнд ажиллах боломж гэж хариулсан бөгөөд энэ нь тэдний хувьд хамгийн их санаа зовоосон асуудал гэжээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх, мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх, мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх зэрэг зарчмууд мөрдөгдөх ёстой⁷⁶. Мөн хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийн тоо 67, хаалттай мэдээлэл буюу Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт” дахь мэдээлэл 572 байна. Харин төрийн нууцад хамаарах мэдээллээс 3 дахин их мэдээлэл албаны нууцад хамаарч байна⁷⁷.

Тохиолдол 2.27

“...Манай улс мэдээлэл авах эрхийг хуулиар баталгаажуулсан ч, бодит амьдрал дээр энэ эрхээ хэрэгжүүлэх нь амаргүй. Нэг удаа би нийтийн хөрөнгийн зарцуулалтын талаар мэдээлэл авах хүсэлт гаргасан. Гэтэл төрийн байгууллага ‘Энэ мэдээлэл нууцлалтай’ гэж татгалзсан. Тиймээс би тухайн мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу

⁷⁵ ХЭХЭЗБТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд дараах нийтлэг үүргийг хүлээнэ. Үүнд:

- хүний эрх хамгаалагчийн эрхийг хүлээн зөвшөөрөх, зөрчихгүй байх;
- үйл ажиллагаанд нь хүндэтгэлтэй хандах;
- шаардлагатай мэдээллээр хангах байх зэрэг болно.

⁷⁶ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

⁷⁷ Глоб Интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан”, (2022-2023 он). <https://www.gic.mn/post/r/1769>

нээлттэй байх ёстойг тайлбарлаж, дахин хүсэлт явуулсан. Хариуд нь огт холбоо барихгүй, удаашруулах тактик хэрэглэж эхэлсэн. Ингээд сүүлдээ утсаа авахгүй, хариу бичихгүй болсон. Үүнээс болж би хэдэн долоо хоногийн турш шаардлагатай мэдээллээ авч чадахгүй, нийтлэлээ бичих боломжгүй болсон. Энэ мэтээр төрийн байгууллагууд мэдээллийг зориуд нууж, нээлттэй байх зарчмыг үл хэрэгсэх нь бидний ажилд хамгийн их саад учруулдаг...”

(Сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас)

Тохиолдол 2.28

Иргэн “Д.Т” нь гомдолдоо “...Миний бие 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Өдрийн сонинд ярилцлага өгсний дараа “Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байхад “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгч 1.2 тэрбум төгрөгийн цалин, урамшуулал авч байна” гэсэн гарчигтайгаар миний өгсөн ярилцлага нийтийн хүртээл болсон. ...Энэ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсанаас хойш над руу дайрах дайралт олширч, цахим орчинд миний тухай илт худал мэдээлэл гаргах болж, миний нэр хүндийг гутаан доромжлох оролдлогуудыг удаа дараа хийсээр байна. Иймд миний үндсэн эрх зөрчигдсөн, иргэдийн мэдэх эрхийг хангаж мэдээлсний төлөө олон талаас дарамт шахалт үзүүлж, гутаан доромжилж дайралтад өртөөд байгааг ил байгаа мэдээллийн хүрээнд шалгаж, хүний эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулга бүхий гомдолд Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо холбогдох ажиллагааг хийсэн.

“Д.Т”-ын уг үйлдэл нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд төрийн өмчит компанийн үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглал, эрх ашгийн төлөө хараат бусаар ажиллах чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд төрийн хөрөнгийг хууль бусаар зарцуулж урамшуулал олгосон байж болзошгүй талаар нийтэд мэдээлж, иргэд хувьцаа эзэмшигчдийн мэдэх эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд хамаарна гэж үзэж байна. Мэдэх эрх болон мэдээлэл авах эрх нь хүний үндсэн эрх юм. Мэдэх эрх нь иргэний мэдээлэлтэй байхыг хэлэх бөгөөд үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээллээр хангах ёстой. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн асуудлыг зохицуулсан. Хүчирхийллийн бус тайван замаар нээлттэй мэдээлэлд үндэслэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж буй үйлдэл нь хүний эрх хамгаалагчийн үйлдэл болно...⁷⁸

(Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтээс)

Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд байнга тулгарч буй нэг нийтлэг асуудал бол эрх бүхий албан тушаалтнууд мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг явдал юм. Энэ талаар хэд хэдэн судалгаанд дурдсан. Тухайлбал 10 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан тутмын 6 нь холбогдох этгээд “мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалздаг” асуудалтай тулгарч байна.⁷⁹ Мөн тодорхой албан тушаалтан өөрийн үзэмжээр иргэдийн мэдээлэл авах хүсэлтийг байгууллагын нууц гэх үгээр халхавчилж мэдээлэл өгөхөөс татгалзах явдал гарч байна.⁸⁰ Энэ нь иргэний нийгмийн байгууллага болон төрийн байгууллагаас хийсэн хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар нээлттэй мэдээллийг ил болгох байдал хангалтгүй байгаатай холбоотой байна.⁸¹

“Сэтгүүлчдийн аюулгүй байдал”⁸² судалгаанд оролцсон 386 сэтгүүлчийн үзсэнээр хэвлэл мэдээллийн салбарт ажиллагчдын хувьд хамгийн чухал аюулгүй байдлын асуудлын

⁷⁹ Глоб интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2022-2023 он”, УБ, 2024 он, 37 дахь тал. https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2022_2023_mn.pdf

⁸⁰ Глоб интернэшнл төв. “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ”. УБ, 2019 он, 42 дахь тал.

https://www.gic.mn/public/docs/publications/public_restrictions_right_to_information_acts_pdf_2019.pdf

⁸¹ Глоб интернэшнл төв, “Хэвлэлийн эрх чөлөөний тайлан”, 2022-2023 он. УБ, 2024 он, 16 дахь тал

⁸² Глоб Интернэшнл төв, Нээлттэй Нийгэм Форум болон Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжин хамгаалах (IFEX) олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээлэлтэй байх, улс төрийн үйл явцад мэдээлэлтэй оролцох эрх” төслийн хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд уг судалгааг хийжээ. Судалгаанд Улаанбаатар хотын болон орон нутгийн телевиз, сонин, сэтгүүл, радио, фм, цахим хуудасны нийт 386 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан хамрагдсан байна.

нэгд 65 хувь нь “эх сурвалжийн аюулгүй байдал”, хоёрт 63 хувь нь “мэдээллийн аюулгүй байдал”, гуравт 62 хувь нь “хувийн аюулгүй байдал” гэсэн байна.

Сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэх явцад сэтгэл санааны дарамтад өртөх, ялгаварлан гадуурхагдах явдал түгээмэл байна. Судалгаанд оролцогчдын үнэлгээгээр сэтгэл санааны дарамт 3.27 оноогоор, дарамт шахалт үзүүлэх байдал 3.17 оноогоор, ялгаварлан гадуурхалт 3.14 оноогоор хамгийн өндөр үнэлэгдсэн байна. Сэтгүүлчдийн 35 хувь нь төрийн байгууллага, 25 хувь нь хууль сахиулагчдын зүгээс заналхийлэл, дарамт шахалт ирдэг гэж хариулсан нь эрх мэдэл бүхий байгууллагууд сэтгүүлчдийн эрх, аюулгүй байдалд тодорхой хэмжээнд халддаг гэж үзэхээр байна.

Түүнчлэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдал”⁸³ судалгаанд оролцсон сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын 89 хувь нь сэтгэл зүйн дарамтад ямар нэгэн байдлаар ордог гэж хариулжээ. Тэдний 13 хувь нь байнга сэтгэл санааны дарамтад ордог, 76 хувь нь ихэвчлэн сэтгэл санааны дарамтад ордог гэж хариулсан бол 11 хувь нь заримдаа сэтгэл санааны дарамтад ордог гэж хариулжээ⁸⁴.

Сэтгүүлчид хэвлэл мэдээллийн хэрэгслүүд санхүүгийн хүндрэлээс болж улс төрчид, эрх мэдэлтнүүдийн санхүүжилтээс хамааралтай болох нөхцөл бүрдэж байна. Судалгаанд оролцогчдын 44.1 хувь нь 11-20 жил ажилласан туршлагатай бөгөөд тэдний ихэнх нь санхүүгийн бэрхшээлээс үүдэн мэдээллийн хараат бус байдлаа алдах эрсдэлтэй гэж үзжээ. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 61.3 хувь нь тогтвортой ажлын байртай гэж хариулсан бол 38.7 хувь нь санхүүгийн хувьд тогтворгүй нөхцөлд ажиллаж байна гэжээ.

Тохиолдол 2.29

“...Орон нутгийн сэтгүүлч байхын нэг том асуудал нь санхүүгийн тогтворгүй байдал юм. Би ганцхан телевизийн цалингаар амьдрах боломжгүй учраас өөр нэмэлт ажил хийх хэрэгтэй болдог. Манайд заримдаа улстөрчид санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Харин үүний хариуд тэдний хүссэн мэдээллийг гаргаж, эсвэл зарим сэдвийг хөндөхгүй байх шаардлага тавина. Хэрвээ энэ шаардлагыг биелүүлэхгүй бол бидэнд ажиллах орон зай улам л багасна. Би үнэнийг олон нийтэд хүргэж байгаа ч гэсэн дэмжиж байгаа хүний мэдээг ганц нэг илүү гаргах нь байдаг л зүйл гэж боддог...”

(Сэтгүүлчтэй хийсэн ярилцлагаас)

Үүнээс үзэхэд сэтгүүлчид хэвлэл мэдээллийн байгууллагууддаа цалин багатай, эсвэл тогтворгүй ажилладаг тул захиалгатай, мэдээ, нийтлэл бичих, тодорхой бүлэглэлийн шахалтад орж байгаагаас сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүй, эрх чөлөөнд сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

2.4. ДҮГНЭЛТ

Өмгөөлөгч, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь хүний эрх хамгаалах үйл ажиллагааны чухал хэсэг юм. Тэд мэргэжлийн хүрээнд хүний эрх хамгаалах үйл ажиллагааг явуулахдаа аливаа заналхийлэл, айлган сүрдүүлэлт, дарамт шахалт шууд болон шууд бус нөлөөллөөс ангид байх ёстой. Ингэснээр өмгөөлөгч, сэтгүүлчийн эрх, хууль ёсны баталгаа хангагдах нөхцөл бүрдэнэ.

Өмгөөллийн үйл ажиллагааг аливаа нөлөөллөөс ангид, бие даан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг Өмгөөллийн тухай хуульд хангалттай бүрдүүлсэн хэдий ч эрүү, иргэн, захиргааны болон зөрчлийн хэрэг маргааныг шийдвэрлэх процессын хууль тогтоомжид тэдгээр баталгааг улам бүр баталгаажуулах, өмгөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжийг захиргааны болон шүүх, цагдаа, авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын дүрэм, журмаар хязгаарлахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Ялангуяа улс төрийн агуулгатай, төрийн өндөр албан тушаал хашиж байсан, эсхүл нийгмийн анхааралд байгаа хэрэг, маргаанд өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа

https://cdn.greensoft.mn/uploads/users/5970/files/media_freedom_report_2022_2023_mn.pdf

⁸³ Мөн тэнд

⁸⁴ Мөн тэнд

өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснийх нь төлөө төрийн болон төрийн бус оролцогч этгээдээс шууд болон шууд бусаар амь насанд нь заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамтлах, дур зоргоор баривчлах, эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгуулахаар холбогдох байгууллагад хандах зэргээр зүй бусаар нөлөөлөх явдал гарч байгаад өмгөөлөгчид санаа зовниж байна. Энэ нь өмгөөлөгчид өөрийн болон гэр бүлийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзахад хүргэж, улмаар шударгаар шүүлгэх хүний үндсэн эрхийн баталгааг алдагдахад хүргэж байна.

Түүнчлэн зарим төрлийн хэрэг, маргаанд өмгөөлөгчийн оролцоо, эрхийг хуулиар нарийвчлан зохицуулаагүй гэх үндэслэлээр өмгөөлөгчийг оролцуулахгүй байх, үйлчлүүлэгчийг төлөөлөх бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэхгүй байх, түүнчлэн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоог хуулиар хязгаарласнаас үүдэн өмгөөлөгчийн бүрэн, үр дүнтэй мэргэжлийн оролцоог хангахгүй байх, шүүхийн өмнө эрх тэгш мэтгэлцэх зарчмыг зөвхөн шүүхийн хэлэлцүүлгээр хязгаарлан тайлбарлах зэрэг нь өмгөөллийн үйл ажиллагааны баталгааг алдагдуулж байна.

Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө аливаа хариуцлагад татагдахгүй байх баталгаагаар хангуулах, эрх чөлөө нь хязгаарлагдсан үйлчлүүлэгчтэйгээ уулзах, зохих хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжоор хангагдах, өмгөөлөгч-үйлчлүүлэгчийн нууцлалыг бүрэн дүүрэн хангуулах, үйлчлүүлэгчээ төлөөлөх, эрх ашгийг хамгаалах үүднээс шүүх болон төрийн бусад байгууллагад чөлөөтэй хандах, мэдээлэл олж авах эрхийг бодитой хангах, холбогдох байгууллагад чөлөөтэй нэвтрэх эрхийг хууль зөрчсөн дүрэм, журмаар хязгаарлахгүй байх шаардлагатай юм.

Түүнчлэн хүний эрхийг хамгаалагч өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах баталгааг бодитой бүрдүүлэх, яллах, өмгөөлөх талын мэтгэлцээн, оролцооны эрх тэгш байдлыг хангах нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шударгаар шүүгдэх эрхийг баталгаатай эдлүүлэх, түүнчлэн Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхийг үр дүнтэй хамгаалах шаардлагатай байна. Тодруулбал өмгөөлөгчийн эрх зүйн байдал, оролцоо нь яллах чиг үүрэгтэй оролцож буй прокурорын эрх, оролцоотой харьцуулахад хязгаарлагдмал байгаа тул хүний эрхийг хангах хүрээнд үйл ажиллагаа явуулж буй өмгөөлөгчдийн эрх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх нь чухал гэж үзэж байна.

Монгол Улсад сэтгүүлчдийг хамгаалах эрх зүйн орчин хангалтгүй байгаагаас гадна төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын зүгээс мэдээллийн хүртээмжийг хязгаарлах, шүүхийн дарамт үзүүлэх зэрэг ноцтой асуудал үргэлжилсээр байна. Олон улсын хэмжээнд сэтгүүлчдийг хамгаалах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь ардчиллын суурь зарчим болох мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулахад чухал үүрэгтэй гэж үздэг.

Монгол Улсад сэтгүүлчид эрүүгийн гэмт хэрэгт яллагдах, шийтгэгдэх явдал нэмэгдсээр байна. Энэ байдал нь хувь сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйгээс үл хамааран сэтгүүлчдийн эсрэг зориуд чиглэсэн шинжтэй бөгөөд шударга шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлчийн дуу хоолойг хязгаарлах хэлбэрээр илэрч байна. Мөн сэтгүүлчид мэргэжлийн хүрээнд ажил үүргээ гүйцэтгэх явцад сэтгэл санаа, ялгаварлан гадуурхалтад өртөх явдал түгээмэл гарч байна.

Эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын зүгээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах, шүүх, цагдаа, прокурор зэрэг олон газарт сэтгүүлчийн эсрэг гомдол өгч, залхаан цээрлүүлэх явдал түгээмэл байна. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад тулгарч буй дээрх асуудлуудыг бууруулахын тулд авч хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээ бол эрх зүйн орчныг сайжруулах гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь хариулжээ. Мөн сэтгүүлчийн үйл ажиллагаанд заналхийлэл, айлган сүрдүүлэлт, дарамт шахалт ихсэж байгаа нь тэдний аюулгүй байдал, мэргэжлийн эрх чөлөөнд халдаж буй хэлбэр юм.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн үед эрхээ сэргээлгэхэд нийтлэг хандаж буй газар нь хуулийн байгууллагууд боловч тэдгээрийн ажилтан, албан хаагчдын хойрго байдал, үл хүндэтгэсэн үйлдэл зэргээс шалтгаалан сэтгүүлчид эрхээ хамгаалуулах, сэргээлгэхэд хүндрэл учирч байна. Мөн хэвлэл мэдээллийн салбарт тогтолцооны шинжтэй, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд тулгамдаж байгаагаас сэтгүүлчтэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх нь чухал байна. Ингэснээр хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгааг нэмэгдүүлж, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ, олон нийтэд үнэн зөв, ил тод мэдээллийг хүргэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм.

Иймд Засгийн газраас УИХ-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр өргөн барьсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх мэдээллийн эх сурвалж нууцлах эрхийг хамгаалах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтыг бэхжүүлэх, хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигч нь редакцын хараат бус байдлыг хангах, талуудын эрх, үүргийг тодорхойлох гэрээ байгуулах зохицуулалт нь сэтгүүлчдэд тулгамдаж буй аюул, эрсдэлийг бууруулах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой тул хууль тогтоогчийн зүгээс даруй хэлэлцэн батлах нь зүйтэй юм.

Сэтгүүлчийн эдийн засгийн баталгааг сайжруулах нь тэдний бие даасан байдлыг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүний тулд төрөөс сэтгүүл зүйн бие даасан байдлыг дэмжиж, хэвлэл мэдээллийн салбарын шударга өрсөлдөөнийг хангах шаардлагатай. Энэ нь сэтгүүлчийн санхүүгийн хүндрэлийг багасгаж, мэдээ мэдээллийг бие даан, нээлттэй байдлаар дамжуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарын чөлөөт үйл ажиллагааны зарчим хангагдах, иргэд, олон нийтийн үнэн бодит мэдээлэл авах нөхцөл бүрдүүлэхэд ач холбогдолтой алхам болно.

Хүнд суртал, төрийн байгууллагуудын харилцааны төвөгтэй байдлыг арилгах нь сэтгүүлчийн эрхийг хамгаалж буй нэг хэлбэр мөн бөгөөд сэтгүүлчдийн ажлын нөхцөлийг хөнгөвчлөх нь мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтэд үнэн зөв мэдээллийг цаг алдалгүй хүргэхэд хувь нэмэр оруулах болно. Тиймээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг дэмжих, сэтгүүлчдийн ажлын нөхцөлийг сайжруулах нь төрийн хариуцлага, эрх зүйн тогтолцооны чадавхыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно.

Мөн өмгөөлөгч, сэтгүүлчийг заналхийлэл, хүчирхийллээс хамгаалах хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдний аюулгүй байдлыг эрх зүйн хамгаалалтаар баталгаажуулснаар өмгөөлөгч, сэтгүүлчдийн ажиллах орчныг илүү аюулгүй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймээс өмгөөлөгч, сэтгүүлчийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах бодлого, хамгааллын механизм нь тухайн салбарын үнэ цэнийг нэмэгдүүлж, өмгөөлөгч, сэтгүүлчийн хүний эрх хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэг чухал хөшүүрэг юм.

Энэ нь хуулийн хэрэгжилтийг бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлж, төлөвшүүлэх нь чухал болохыг Монгол Улсын жишээ тод харуулж байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт төрийн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаандаа хүлээх нийтлэг үүргийг заасан. Эдгээр үүрэгт хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах асуудал багтдаг. Комисс нь тус зохицуулалтын хүрээнд Хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусгаж, хэрэгжилтийг хангах, сургалт зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэх аргачлал боловсруулсан бөгөөд түүнд НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газрын ажилтнуудын саналыг авч тусгасан болно. Уг аргачлалын дагуу төр, хувийн хэвшил, хуулийн этгээдийн эрхтэй байгууллагууд дотоод журамдаа хүний эрх хамгаалагчийн үйлдлийг хамгаалах зохицуулалтыг тусгаж, мөрдөх нь хууль хэрэглээний нэг мөр ойлголтыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

САНАЛ

Хүний эрх хамгаалагч өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх баталгааг хангахын тулд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Холбогдох хуулиар өмгөөлөгч авах эрх, өмгөөлөгчийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулсан эсэхээс үл хамааран Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль зүйн туслалцаа авах эрхийн хүрээнд эрх зүйн бүх төрлийн маргаанд өмгөөлөгчийн оролцоог хүлээн зөвшөөрөх баталгааг хангах;
- Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, бүрэн эрхийн баталгааг эрүү, иргэн, захиргааны болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тодорхой нарийвчлан зохицуулах. Ялангуяа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд өмгөөлөгчийн бүрэн, үр дүнтэй, тэгш оролцоог хангаж, мэтгэлцэх боломжийг бүрдүүлэх;
- Хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийг эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдуулан дур зоргоор шалгах, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах, хариуцлага хүлээлгэхгүй байх хуульд заасан баталгааг үр дүнтэй хангахын тулд ийм зөрчил үйлдсэн холбогдох байгууллага, албан тушаалтны үйлдлийг хуулийн хүрээнд мөрдөн шалгах, тэдгээрт хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тодорхой хуульчлах;
- Өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, бусад байдлаар нөлөөлсөн этгээдийн үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах, хуульд заасан хариуцлага хүлээлгэх баталгааг хангах;
- Өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах, түүний байгаа газарт чөлөөтэй нэвтрэх эрхийг хэрэгжүүлэх бодит боломжийг хязгаарласан хууль хяналтын байгууллагын дотоод дүрэм, журмыг хүчингүй болгох. Цахимаар явагдаж байгаа шүүх хуралд өмгөөлөгчийн үйлчлүүлэгчтэй, болон бусад оролцогчидтой чөлөөтэй үр дүнтэй харьцах, боломжийг нарийвчлан зохицуулах.
- Өмгөөлөгчийн хууль ёсны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, хуульд заагдаагүй аливаа шаардлага тавьж өмгөөллийн үйл ажиллагааг саатуулахыг хориглох талаар хуульчлах.
- Өмгөөлөгчийн ажил үүргээ гүйцэтгэх явцад түүний эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан тохиолдолд нийгмийн баталгаа хэрхэн хангагдах талаар зохицуулалт Өмгөөллийн тухай хуульд тусгах.
- Өмгөөлөгчийн үйлчлүүлэгчийг төлөөлөх хуульд заасан бүрэн эрхийг төрийн болон төрийн бус оролцогчид хүлээн зөвшөөрч, хэрэгт хамааралтай баримт, лавлагаа, мэдээллийг хэрэгцээтэй байгаа үед нь зохих шаардлагад нийцүүлэн, хүнд сурталгүйгээр гарган өгөх үүргийн талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх.

Хүний эрх хамгаалагч сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх баталгааг хангахын тулд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгад сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн тусгах;
- Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг өөрчлөх, иргэний нэр төр, алдар хүндийн талаарх хуулийн зохицуулалтыг санаатай худал мэдээлэл тараах болон сэтгүүлч мэргэжлийн алдаа гаргах гэсэн ойлголтыг ялгаж зохицуулах;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх замаар төрийн байгууллагуудын мэдээллийн хүлээн авах, хуваарилах үйл явцыг ил тод болгож, иргэдэд нээлттэй мэдээллийг цаг алдалгүй хүргэх боломжийг хангах;
Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийн байгууллагууд сэтгүүлчдийг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэл тохиолдсон үед үнэлгээ хийж аюулгүй байдлыг хамгаалах агуулга бүхий заалт оруулах;
- Олон нийтэд үйлчлэх зорилго бүхий хамтын хэвлэл мэдээллийн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг байгуулж түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах

зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох, ингэхдээ төрөөс шууд хараат байдлаар санхүүжилт авах арга замаас зайлсхийж, өрсөлдөөнд суурилсан шударга зохицуулалт хийх боломжийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулах;

- Редакцын хараат бус байдлыг хангах зорилгоор нийтлэл, нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч нь редакцын хараат бус байдал, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, бодлогод нөлөөлөхийг хориглох;
- Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд ихэвчлэн холбогдож байгаа Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт заасан “ Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан ... этгээд түүнийхээ үнэн зөвийг өөрөө нотлох ...” гэж заасныг нотлох үүргийнхариуцагч тал нь сэтгүүлч бол эх сурвалжийг хамгаалах зорилгоор нотлох баримт гаргаж өгөх үүргээс чөлөөлөх агуулга бүхий заалтыг Иргэний хуульд оруулах;
- Сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмж, туршлагын талаар нийтлэл, нэвтрүүлэг бэлдэж түгээх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д заасны дагуу төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамдаа хүний эрх хамгаалагчийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хамтран ажиллах агуулга бүхий зохицуулалтыг тусгаж хэрэгжүүлэх, энэ талаар сургалт мэдээлэл хийх.

III БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ БА ЦАХИМ ТЕХНОЛОГИ

“...Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...Иргэний хувийн ба гэр бүл, захидал, харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэг)

“...Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэг)

“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал шашин шүтлэг, үзэл, бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

3.1. ТАНИЛЦУУЛГА

Цахим технологийн хөгжил харилцаа холбооны хувьсгал хийж, мэдлэгийг “ардчилж”, бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, хүний амьдралын чанарыг сайжруулахын зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол нүүрлэж буй өнөөгийн дэлхийд идэвхтэй өсөж буй хүн төрөлхтний аюулгүй, тогтвортой орших шийдэл, найдвар болж байна. Гэвч мэдээлэл, өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж, хадгалж, боловсруулж, ашиглах үндсэн горимоор ажилладаг цахим технологиуд хүний эрх, эрх чөлөөний ноцтой эрсдэлийг дагуулдаг.

Орчин үеийн нийгэмд хүний хувийн мэдээлэл бүртгэгдэхгүй орон зай хомс болжээ. “Ухаалаг” тодолголтой гар утас, таблет, цаг, компьютер, видео тоглоом, олон нийтийн сүлжээ зэрэг тэдгээрт суулгасан программ хангамжууд, орон байрны аюулгүйн систем, тасалгааны гэрэлтүүлэг, телевиз, чанга яригч, угаалгын машин гэх мэт ахуйн эд зүйлс, хяналтын камерууд, нийтийн интернэт (WiFi), автомашины дугаараар хянах систем, зогсоолын төлбөр төлөх цэг зэрэг нийтийн орон зайд суурилуулсан цахим төхөөрөмжүүд хүний амьдралын талаарх их хэмжээний мэдээллийг тасралтгүй бүртгэн цуглуулж байна. Хотын иргэдийн амьдралын хэв маягийн талаарх мэдээллийг цуглуулж, замын хөдөлгөөн, нийтийн тээвэр, дэд бүтэц, барилга байгууламж, эрчим хүчний зарцуулалт, хог хаягдал, орчны бохирдол зэрэг суурь асуудлыг мэдээлэлд үндэслэн шийдвэрлэх зорилготой “ухаалаг хот” санаачилга идэвхжиж, орчны чанар, хөдөлгөөний мэдээлэл цуглуулах технологиуд хэрэглээнд өргөн нэвтэрч байна. Хүний амьдрал бүхэлдээ ямар нэг цахим төхөөрөмжид бүртгэгдэх боломжтой өнөө үед нэг эх сурвалжаас олж авсан хувь хүний талаарх мэдээллийг бусад эх үүсвэрийн мэдээлэлтэй холбон задлан шинжилж, хэн болохыг тогтоож, хувийн нууцад халдах боломжтой юм. Хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж ажилладаг бизнес моделиуд өндөр ашиг олж, хүний хувийн мэдээлэл алдагдах, гэмт хэрэгт ашиглагдах тохиолдол нэн түгээмэл байна.¹ Энгийн цахим төхөөрөмжийн зэрэгцээ хүнийг тагнах, мөрдөх, хувийн цахим хэрэгсэл дэх мэдээллийг зайнаас татан цуглуулах өндөр хүчин чадалтай төхөөрөмжүүд хэрэглээнд нэвтэрчээ.²

Хувийн мэдээлэл, хувийн нууц, хувийн орон зай чанд хамгаалагдах нь хүн халдашгүй, эрх чөлөөтэй оршихын үндэс билээ. Дарамт, хавчлагаас эмээх айдас хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрмэлзлийг бөхөөж, төрийн үйл хэрэгт оролцох эрхийг “хэлбэр төдий” болгож, улмаар ардчилал хэврэгшдэг. Хиймэл оюун, цахим технологийн тооцооллын алдаа хүмүүс ялгаварлан гадуурхагдах, хэлмэгдэх нөхцөлийг үүсгэж, алгоритмын ил тод бус байдал нь түүнд хяналт тавих, шүүхэд хандаж, эрхээ сэргээх боломжийг хязгаарлах боллоо.³ Цахим технологийн хөгжлийн үр шимийг нийгмийн зарим бүлгийн хүмүүс эс хүртэж, тэгш бус байдал гүнзгийрч байна. Технологи уламжлалт хөдөлмөрийг орлох болсны зэрэгцээ цахим технологид суурилсан хөдөлмөрийн шинэ салбар (gig economy) хөгжсөн нь орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж, хөдөлмөрлөх эрхийн баталгааг сулруулж байна.

Цахим технологийн хүний эрхийн эрсдэл өндөр боловч энэ талаарх Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын хөгжил эхлэл шатандаа, хэрэгжилт хангалтгүй, ялангуяа хүний эрхийн эрсдэлийг бүрэн тооцохгүй, нэн шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ үгүйлэгдэж байгааг Комисс анхааруулж, “Хүний эрх ба цахим технологи” сэдвээр илтгэж байна. Энэ илтгэлийг Комиссоос 2023-2025 онд 10 салбарын 36 асуудлыг хамруулан явуулж буй “Хүний эрх ба цахим технологи” олон нийтийн хяналт шалгалтын эхний үр дүнд суурилан, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (ХХМХтХ)-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.6 дахь заалтаар хүлээсэн чиг үүргийн хүрээнд боловсрууллаа. Илтгэлд мэдээлэл, өгөгдлийг их хэмжээгээр цуглуулж, боловсруулж, ашиглах горимоор ажилладаг

¹ НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын A/HRC/39/29 дугаартай “Дижитал эрин зуун дахь хувь хүний нууцын эрхийн тайлан”, 12-16 догол мөр.

² НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Тамгын газрын A/HRC/51/17 дугаартай Дижитал эрин зуун дахь хувь хүний нууцын эрхийн тайлан, 4-19 догол мөр.

³ НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын A/HRC/48/31 дугаартай Дижитал эрин зуун дахь хувь хүний нууцын эрхийн тайлан, 12-36 догол мөр.

бүх төрлийн хэрэгсэл, сүлжээ, программ хангамж, алгоритмын системийг “цахим технологи” гэж тодорхойлсон болно.

“Хүний эрх ба цахим технологи” бүлэг гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт Монгол Улсын цахим хөгжлийн ирээдүйг тодорхойлох суурь нөхцөлүүд болох бодлого, эрх зүйн орчин, засаглал, технологийн нэвтрэлт, иргэдийн цахим ур чадвар, цахим боловсролын түвшнийг хүний эрхийн үүднээс үнэлснээ танилцуулж байна. Хоёрдугаар хэсэгт хууль сахиулах ажиллагаанд тулгуур үүрэгтэй камерын хяналт, зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох цахим гавыг ашиглаж буй байдал, тагнах төхөөрөмжийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад анхаарах хүний эрхийн асуудлуудыг танилцуулж, Монгол Улс дахь хиймэл оюуны хөгжүүлэлт, хэрэглээг үнэлж, “Хиймэл оюуны үндэсний стратеги”-д тусгавал зохих зарчмуудыг санал болгов. Түүнчлэн, энэ хэсэгт Монгол Улсад цахим хуваагдал оршин буйг илтгэж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг цахимжилтаас үл орхих, цахим хөгжлийн үр шимийг хүртэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай болохыг анхаарууллаа. Гуравдугаар хэсэгт, цахим эриний “газрын тос” гэгдэж буй хувийн мэдээллийг хамгаалах Монгол Улсын эрх зүйн үндсэн баталгаа болох Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (ХХМХтХ)-ийн хийдэл болон түүний нийтлэг зөрчлийн талаар илтгэж, хэрэгжилтийг сайжруулах арга замыг санал болголоо.

3.2.ЦАХИМ ХӨГЖЛИЙН СУУРЬ НӨХЦӨЛ

Монгол Улсын цахим засаглалын бодлого, эрх зүйн орчин, дэд бүтэц сайжирч, цахим үйлчилгээний тоо, хүртээмж нэмэгдэж, иргэдийн цахим боловсрол, ур чадвар дээшилж, олон нийтийн оролцоо, төрийн нээлттэй байдалд ахиц гарч байна. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (цаашид “e-Mongolia” систем гэх) энэхүү ахиц дэвшлийн бодит жишээ юм. Засгийн газрын “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2020 оны 90 дүгээр тогтоолын дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ)-аас 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр “e-Mongolia” системийг нээсэн бөгөөд төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон.

Түүнчлэн хэрэглэгчийн хандалт, сүлжээний урсгал, системийн ачааллаа хянан тохируулж, нэг агшинд хоёр сая хэрэглэгчид үйлчлэх чадавхтай “4.0” хувилбарыг 2024 онд хэрэглээнд нэвтрүүлжээ. Тус системд 2025 оны 03 дугаар сарын байдлаар 88 орчим байгууллагын 1263, 21 аймгийн нутгийн захиргааны байгууллагын 1300 орчим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна.⁴ 2020 оноос хойш тус системээс 1.99 сая хэрэглэгч 71 сая удаагийн үйлчилгээг цахимаар авсан байна. Улаанбаатар хотын иргэдийн 57.3 хувь, орон нутгийн иргэдийн 55.1 хувь нь “e-Mongolia” системд бүртгэгджээ.⁵ Мөн 2024 оны байдлаар Монгол Улсаас 500 сая хандалт, гадаадад байгаа иргэдийн хувьд ОХУ-аас 2.1 сая, БНСУ-аас 8.8 сая, АНУ-аас 1.7 сая, Сингапур Улсаас 1 сая, Австрали Улсаас 870 мянган хандалт тус тус иржээ. Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Сүмбэр, Төв аймгуудаас хамгийн олон хэрэглэгч бүртгэлтэй бөгөөд (насанд хүрсэн хүн амын тоонд хувьчилснаар) 88-95 хувийн хандалттай байна.⁶ “e-Mongolia” системийг нэвтрүүлснээр нийт 1.4 их наяд төгрөг хэмнэсэн гэх тооцоолол гаргажээ.⁷ Түүнчлэн, “e-business.mn” дэд системийг хөгжүүлснээр компани байгуулах, тусгай зөвшөөрөл авах зэрэг бизнесийн эрхлэх үйл явцыг хялбаршуулж, “lavlagaa.e-mongolia.mn” дэд системийг бүтээн төрийн 17, хувийн хэвшлийн 24 байгууллагын 91 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг цахимаар авах боломж бүрдсэн байна.⁸

⁴ “И-Монгол Академи” УТУГ-аас 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахимаар авсан мэдээлэл.

⁵ Мөн тэнд.

⁶ ЦХИХХЯ-ны “e-Mongolia.mn” албан ёсны цахим хуудас, 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн мэдээлэл. (цахим хуудсанд 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар хандсан)

⁷ Эшлэл 1-ийг үзнэ үү. “Иргэн төрийн үйлчилгээ авахдаа үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу ирж, буцах унааны зардалд 87,5 тэрбум орчим, цаг хугацаанаас үүдэлтэй зардалд 1,3 гаруй их наяд, бичиг цаасны зардалд 6,2 гаруй тэрбум төгрөг хэмнэсэн.” гэж тооцоолжээ.

⁸ Мөн тэнд.

Шигтгээ 3.1

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын газар (ЮНЕСКО)-аас боловсролын салбарт цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй онцлох таван орны нэгээр Монгол Улсыг нэрлэсэн бөгөөд үүнд нөлөөлсөн хүчин зүйл нь “e-Mongolia” систем байв. Тэгш, хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэхэд цахим сургалт чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал:

- Суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэхийг боловсролын салбарын мэдээллийн цахим системээс олгодог.
- “Medle.mn” систем нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн бүх сурах бичгийн цахим хувилбар, цахим ур чадвар, хувь хүний хөгжлийн сургалт, дасгал ажил, багш, сурагчийн булан, зөвлөмж, хүүхдийн эрхийн хамгаалал, хүүхдийн насны онцлогт тохирсон цахим контент зэргийг агуулсан.
- Сонгон судлах хөтөлбөрийн цахим сургалт нь ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтын суурь хичээлийг багшлах хүний нөөц хангалтгүй, анги бүлэг бүрдээгүй гэдэг шалтгаанаар үзэх боломжгүй байсныг цахимаар судалдаг болсон.
- “Parent.edu.mn” систем нь улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн бүртгэлийг цахимаар зохион байгуулах, сурагчийн хичээлийн хуваарь, гэрийн даалгавар, дүн, ирцийн мэдээллийг авах, хүүхдийн сургалтын чанарт хяналт тавих боломж олгосон.
- “Parent.edu.mn” болон “ESIS” аппликейшнийг ашиглан боловсролын салбарын үдийн хоолны цахим хяналтыг нэвтрүүлсэн.

Боловсролын байгууллагууд цахим төсвийн төсөлд шилжсэнээр улсын хэмжээнд 2400 гаруй ажилтны томилолтын зардал болох 171 сая төгрөг, 125 мянган хуудас цаас болон хэвлэх хорны зардал хэмнэгдэж, нэг хүний 3-15 хоногийн ажлыг хөнгөөчилсөн.⁹

Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх Монгол Улсын чадавх нэмэгдсэнтэй холбоотой цахим засаглалын үзүүлэлт тогтвортой өсөж байна. НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс (ЦЗХИ)-ээр Монгол Улс 2020 онд 193 орноос 92 дугаарт орж байсан бол 2024 онд 46 дугаарт эрэмбэлэгджээ.¹⁰ Цахим үйлчилгээний индекс (ЦҮИ) 2020 онд 0.5294 пункт байсан бол 2024 онд 0.8222 болжээ.¹¹

Гэвч Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын өрсөлдөх чадвар дэлхийн дунджаас доогуур, мэдээллийн технологийн боловсрол, судалгаа, инновацын чадавх сул, цахим технологийн нэвтрүүлэлт, хэрэглээний түвшин хангалтгүй, өгөгдөлд шинжилгээ хийх, ашиглах чадавх хомс, Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул байгааг Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын 2024 оны тайланд илтгэжээ.¹² Цахим засаглалын бодлого, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, цахим дэд бүтцийн хөгжүүлэлтэд хүний эрх, эрх чөлөөг хангах бодлого, үйл ажиллагаа орхигдсон, иргэдийн цахим боловсрол, ур чадвар муу, цахим хуваагдал бодитой оршиж байна.

Цахимжилтын бодлого, эрх зүйн орчин

Цахим засаглалыг хөгжүүлэх бодлого Монгол Улсад 1990-ээд оноос хэлэлцэгдэж, 2000-аад оноос батлан хэрэгжүүлж, өнөөг хүртэл 70 орчим бодлогын баримт бичигт уг асуудлыг тусгажээ.¹³ УИХ-ын 2000 оны 21 дүгээр тогтоолоор “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”, Засгийн газрын 2002 оны 233 дугаар тогтоолоор “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”, 2005 оны 216 дугаар тогтоолоор “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, 2008 оны 78 дугаар тогтоолоор “Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”, 2010 оны 141 дүгээр тогтоолоор “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах

⁹Боловсролын яамны албан ёсны цахим хуудаст байршуулсан мэдээлэл, <https://moe.gov.mn/post/120563> (цахим хуудаст 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар хандсан.)

¹⁰ ЦЗХИ нь НҮБ-ын гишүүн орнуудын цахим засаглалын хөгжлийн төлөв байдлыг харуулдаг, цахим үйлчилгээ үзүүлэх, харилцаа холбооны дэд бүтэц, хүний чадавх гэсэн нийлмэл хэмжүүрийг нэгтгэсэн үзүүлэлт юм. <<https://publicadministration.un.org/egovkb/en-us/About/Overview/-E-Government-Development-Index>>.

¹¹ Мөн тэнд. ЦҮИ нь ЦЗХИ-ийн нэг үзүүлэлт бөгөөд байгууллагын тогтолцоо (10 хувь), үзүүлж буй үйлчилгээ (45 хувь), хамрах агуулга (5 хувь), технологи (5 хувь), цахим оролцоо (35 хувь) гэсэн 5 дэд индексийг багтаажээ.

¹² Олон улсын менежмент хөгжлийн институт/Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024. Цахим хуваагдал: Эрсдэл ба боломж, 147 дахь тал. Мөн тус бүлгийн “Иргэдийн цахим боловсрол, цахим ур чадвар” хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

¹³ Удирдлагын академи, “Цахим засаглалын хөгжлийн бодлого, зохицуулалтын шинжилгээ”, УБ, 2020 он, 10 дахь тал.

үндэсний хөтөлбөр”, 2011 оны 145 дугаар тогтоолоор “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр”, 2012 оны 101 дүгээр тогтоолоор “Цахим засаг” үндэсний хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, 2019 оны 73 дугаар тогтоолоор “Цахим засаглал” зэрэг тусгайлсан бодлогыг баримт бичгийг тус тус баталж, үндэсний аюулгүй байдал,¹⁴ гадаад бодлогын тулгуур баримт бичгүүдэд тусгасан байна.¹⁵ Энэ хүрээнд УИХ-аас 2011 онд Цахим гарын үсгийн тухай, 2014 онд Шилэн дансны тухай зэрэг хуулиудыг тус тус баталжээ.

Монгол Улсын цахим засаглалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчин боловсронгуй болж байна. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан цахим засаглалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2021 онд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай (НМИТБТХ), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай (шинэчилсэн найруулга) хуулиудыг баталж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, ашиглахад зориулсан дэд бүтцийг тодорхойлж, цахим ажил, үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах нарийвчилсан зохицуулалтыг бий болгосон.¹⁶ Түүнчлэн хүн амын бүлгүүдийн цахим хэрэглээ, ур чадварыг дэмжихэд чиглэсэн зохицуулалтууд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Ахмад настны тухай хуульд тусгагджээ.¹⁷

Гэвч цахим хөгжлийн бодлогын баримт бичгүүд цахим үйлчилгээг шуурхай хүргэх, дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим гарын үсгийг нэвтрүүлэх зэрэг техник, үйлчилгээг сайжруулах асуудалд төвлөрч, цахим технологийн хүний эрхийн эрсдэлийг хянан зохицуулах бодлогыг орхигдуулжээ. Тухайлбал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд “Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах” зорилтыг дэвшүүлж, “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, төр, иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл солилцох, олж авах дэд бүтцийг илүү сайжруулж, цахимаар авах боломжтой үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим хөгжлийн нэгдсэн бодлого, бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоог хангах, чиг үүргийн давхардлыг арилгах арга хэмжээг төлөвлөжээ. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жил бүрийн улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн тулгуур, экспортын тэргүүлэх чиглэл хүртэл дэмжих зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна.

Монгол Улсын Засгийн газраас харилцаа холбооны технологийг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэгээр зарлаж, нийгэм, эдийн засгийн бүх салбарт нэвтрүүлж, цахим

¹⁴ УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д цахим засаглалыг хөгжүүлж, төрийн алба, үйлчилгээг иргэндээ хандсан, үр нөлөөтэй, шуурхай, хэмнэлттэй болгох, цахим мэдээллийн дэд бүтэц, харилцаа холбоо, дамжуулалт, хандалтын нууцлал, хамгаалалтыг бүрдүүлэх, цахим өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засаглалын үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлэхээр заажээ.

¹⁵ УИХ-ын 2011 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д мэдээллийн технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт, орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаан-технологийн үндэсний мэдээллийн сүлжээг өргөтгөн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тусгажээ.

¹⁶ Эдгээр хуулиудын холбогдох зохицуулалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг тус бүлгийн Интернэт, цахим технологийн нэвтрэлт, хүртээмж, Кибер аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал, Цахим хуваагдал, тэгш бус байдал, ХХМХТХ-ийн хэрэгжилт сэдвээс дэлгэрүүлж үзнэ үү.

¹⁷ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх” тухай, Ахмад настны тухай хуулийн 7.2.1-т “аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, ахмадын байгууллага нь ахмад настан, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчид дэмжлэг, туслалцаа, үйлчилгээ үзүүлэх, ахмад настны эрхийг хамгаалах асуудлаарх мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр хүргэх, сургалт зохион байгуулах;”, 7.2.12-т “энэ хуулийн 4.1.7-д заасан үнэлгээнд “ахмад настан сайн дурын үндсэн дээр оролцох, шаардлагатай тохиолдолд цахимаар хийх;”, 13.9-д “Энэ хуулийн 7.1, 8.1.1, 8.1.2, 10.1.2, 10.2-т заасан үйлчилгээг цахимжуулах, давхардлыг арилгах, гэрээт байгууллагын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн бодитой олгох зорилгоор ахмад настны Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан мэдээллийг ашиглаж болно.” гэж тус тус заажээ.

үндэстнийг хөгжүүлэх зорилго бүхий “Цахим Үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027)-ийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/24 дүгээр тушаалаар баталсан. Уг баримтлах чиглэлд мэдээллийн технологи, харилцаа холбооны суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, цахим засаглалыг хөгжүүлэх, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах, бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, инновац, үйлдвэрлэлийг дэмжих замаар цахим эдийн засгийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээлэл технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлэх зургаан зорилтыг дэвшүүлсэн байна. Дээрх цахим хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хүний хувийн мэдээлэл, хувийн нууц, халдашгүй чөлөөтэй байх, ялгаварлан гадуурхалт, хүнлэг бус харьцаанаас ангид байх зэрэг хүний эрхийг хамгаалах, эрсдэлийг зохицуулах бодлого үгүйлэгдэж байна. Нөгөө талаас цахимжилт нь зөвхөн нэг удаагийн үйл явц биш, тасралтгүй хөгжүүлэх, аюулгүй, найдвартай байдлыг хангахад байнгын хөрөнгө оруулалт шаардлагатай үйл явц гэдгийг анхаарах шаардлагатай.

ХХМХТХ нь цахимжилтын үйл явцад хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалах хууль зүйн үндсэн баталгаа болно. Уг хуульд хүний хувийн мэдээллийн төрөл, ангиллыг тогтоож, хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг нарийвчлан тусгасан боловч зохицуулах харилцаа нь явцуу хүрээтэй, хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, албадлагын механизм сул байна.¹⁸ ХХМХТХ-д заасны дагуу ЦХИХХЯ хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай захиргааны хэм хэмжээний дөрвөн акт батлах үүрэгтэй. Харин ХХМХТХ-д 20 дугаар зүйлийн 20.2-т заасан “Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлага” өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Бодлого тогтворгүй, залгамж холбоогүй, баталсан бодлогыг хэрэгжүүлэхгүй явж ирсэн нь цахимжилтын бодлого боловсруулж, хэрэгжүүлсэн Монгол Улсын өнгөрсөн 20 жилийн туршлагаас анхаарч засах гол сургамж байна. Бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн хугацаа, хэрэгжилтийг шинжилж, “хөтөлбөр бүр залгамж чанар багатай, бүрэн хэрэгжиж дуусаагүй байхад дараагийн хөтөлбөрийг шинээр баталсан, цахим шилжилт хийх гол зорилгоо тодорхойлж чадаагүй, олон улсад шинээр гарч ирж буй санаачилга, хандлагыг дагаж тухай бүр “үсрэх” байдлаар явж ирсэн” болохыг судлаачид дүгнэж, одоо хэрэгжүүлж байгаа бодлогод ч энэ ужиг зүй тогтол ажиглагдаж байгааг анхааруулжээ.¹⁹ Мэдээлэл, харилцаа, холбооны технологид тулгуурласан төрийн үйлчилгээний платформыг хөгжүүлэх зорилт 2005 онд баталсан “Цахим Монгол”, 2012 онд баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрт тусч байсан боловч “e-Mongolia” системийг хэрэглээнд нэвтрүүлснээр энэ зорилт 15 жилийн дараа хэрэгжсэн юм. Цахим хөгжлийн бодлогыг боловсруулахдаа үр нөлөөг нь шууд хүртэх хүн ам, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг оролцоог хангахад дэмжлэг илүү шаардагдах нийгмийн бүлгийн оролцоог хангахгүй, саналыг тусгадаггүй болохыг судалгаа харуулжээ.²⁰

Цахимжилт тогтвортой, зохистой явагдахын нэг тулгуур нь хүний эрх, эрх чөлөөний хамгаалалт боловч Монгол Улсын бодлогод сул тусгагдсан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиас улбаатай байж болно. Уг хуулийн 5 дугаар зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах 17 зарчмыг тодорхойлсон боловч хүний эрх, эрх чөлөөг дээдлэх талаар зарчим тусгагдаагүй, 10 дугаар зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах үе шатыг тодорхойлж, холбогдох асуудлуудаар

¹⁸ Тус бүлгийн 3.4.2. “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хийдэл, хэрэгжилт” хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

¹⁹ Удирдлагын академи, “Цахим засаглалын бодлого, зохицуулалтын шинжилгээ”, УБ, 2020 он, 62 дахь тал.

²⁰ ММСГ, Азийн сан, “Цахим засаглалын бэлэн байдлын үнэлгээ” судалгааны тайлан, УБ, 2021 он, 39 дэх тал “Цахим үйлчилгээг орон нутгийн иргэд, тусгай хэрэгцээтэй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн хүргэх арга замыг тодорхойлоход иргэний нийгэм/ТББ, хувийн секторыг оролцуулдаг уу?” гэсэн асуултад 25 хувь нь тийм гэж хариулжээ.

урьдчилсан үнэлгээ хийхээр зохицуулсан ч хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлагыг хуульчлаагүй юм.²¹

Цахим хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн мөн чанарт хүний эрхийг хамгаалах бодлого, үзэл санаа шингээгүй, энэ асуудлыг ХХМХТХ-иар зохицуулах салбар асуудал гэж хандсанаас үндэсний цахим дэд бүтцийг бий болгож буй байгууллага, албан тушаалтнууд тухайн технологийн хүний эрхийн эрсдэлийг ойлгохгүй байх, үл тоомсорлох нь түгээмэл байна. Тухайлбал, тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ (RFID) төслийн үр дүнд бий болох цахим дэд бүтэц нь хүнийг мөрдөн мөшгөх зэргээр халдашгүй чөлөөтэй байх эрхийг хөндөх эрсдэлтэй боловч төслийг хэрэгжүүлж буй байгууллага, албан тушаалтнууд энэ эрсдэлийг тооцоолоогүй, ойлголт муутай байлаа.

Тохиолдол 3.1

Радио давтамж тодорхойлох бүртгэл, хяналтын RFID нь “Зам, тээврийн нэгдсэн систем”-ийн нэг модуль буюу дэд систем бөгөөд тээврийн хэрэгслийн зорчил, бүртгэл, эзэмшигчийн мэдээлэл, холбогдох татвар, хураамж, торгууль, оношилгооны мэдээллийг төрийн чиг үүргийн байгууллагуудад шууд хүргэх технологи юм. Тус технологийг нэвтрүүлэх төсөл 2023 оноос эхэлжээ.

RFID дээр суурилсан авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээний мэдээллээр тухайн тээврийн хэрэгслийн эзнийг тодорхойлох, бусад хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хөндөх эрсдэлтэй гэж үзэж, энэ асуудлаар Комиссоос холбогдох салбаруудын эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулсан сонсох ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан.²² Сонсох ажиллагаанд RFID чипийг хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэр гаргахад дараах асуудлыг анхаарсан эсэх талаар холбогдох талуудаас тодруулга авсан:

- УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.1.8-д “Мэдээллийн аюулгүй байдлын орчин үеийн дэвшилтэт, өртөг багатай шийдлийг зөвхөн эрсдэлийн үнэлгээний үндсэн дээр сонгон ашиглана” гэж заасныг хангасан эсэх,
- ХХМХТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан үнэлгээг хийсэн эсэх,
- Уг төхөөрөмж хүнийг мөрдөн мөшгөх зэрэг хууль бусаар ашиглахаас сэргийлсэн, хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар бодлого, арга хэмжээг тооцсон эсэх,
- Хүний эрхийн эрсдэлээс хамгаалах арга хэмжээний хүний нөөц, төсвийн шийдэл, тулгамдсан асуудалд хүний хувийн мэдээллийг аль болох бага цуглуулах талаар холбогдох шийдлүүдийг гаргасан эсэх,
- RFID чип суурилуулахаас бусад арга замаар шийдвэрлэх боломжтой эсэхийг судалсан эсэх,
- RFID технологийн үр ашиг, эрсдэлийг олон нийтэд таниулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх.

Сонсох ажиллагааны үр дүнд талууд ХХМХТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан үнэлгээг Комиссоос хүргүүлсэн маягтын дагуу хийж, уг төслийн техник, эдийн засгийн үндэслэл, холбогдох тооцооллыг Комисст 2023 оны 03 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх, үнэлгээнд үндэслэн Комиссоос зөвлөмж өгөх тухай шийдвэр гарсан.

Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ)-ны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Батболдод хүргүүлсэн Комиссын гишүүний 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 04/21 дүгээр Зөвлөмжөөр:

1. *RFID технологи дээр суурилсан авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээг ашиглахад хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах, устгах асуудлыг зохицуулсан захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуулийн 59-32, 65 дугаар зүйлд заасны дагуу баталж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхэлсэн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх. Захиргааны хэм хэмжээний актад ХМХТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т заасны дагуу хүний хувийн мэдээлэл ашиглахыг хязгаарлах, мэдээллийг устгах, мэдээллийн эзнийг*

²¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т “бодлогын хувилбаруудад хүний хөгжлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн урьдчилсан үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн урьдчилсан тооцоо хийх” гэж заажээ.

²² Дэлгэрэнгүй мэдээллийг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ХЭҮК-ын цахим хуудсанд тавигдсан видео бичлэгээс үзнэ үү.

тодорхойлох боломжгүй болгох, авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээний хүрээнд цугларсан мэдээлэлтэй ажиллах албан хаагчид хориглох зүйлийг тусгах.

2. ХХМХТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан үнэлгээг 6 сар тутам хийж мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөх аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах. Үнэлгээг ЗТХЯ-ны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлэхийг зөвлөсөн.

ЗТХЯ-аас 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр 03/3743 дугаар албан бичгээр “холбогдох журмын төслийг боловсруулж байна, үнэлгээг хийж, олон нийтэд нээлттэй ажиллах болно.” гэсэн хариу ирүүлж, Комиссын гишүүний зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Комиссын 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн ТГ-01/1159 дугаар албан бичгээр зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байгааг тэмдэглэж, зөвлөмжид заасан арга хэмжээг бүрэн хангаж мөн оны 10 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг шаардсан боловч уг хугацаанд хариу ирүүлээгүй, 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/1208 дугаар “Зөвлөмжийн талаар мэдээлэл өгөх тухай” албан бичгийг ирүүлсэн боловч дээр дурдсан хоёр арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэх мэдээлэл мөн хангалтгүй байна.

Тус зөвлөмжийн хэрэгжилттэй холбогдуулан Комиссоос 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ЗТХЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)-ын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. ЗТХЯ-ны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын эрх бүхий албан тушаалтан “...RFID технологи нь радио давтамжийн нөлөөллөөр буюу RFID уншигч төхөөрөмжийн доогуур өнгөрөх үед тухайн RFID кодыг уншаад зөвхөн кодоод өгөгдсөн нууцлалын кодыг л унших юм. Тэр код нь хувь хүний мэдээлэлтэй ямар нэгэн байдлаар холбогдоогүй зөвхөн тээврийн хэрэгслийн арлын дугаартай холбогдохоор анхны бүртгэлийг хийж өгсөн. Уг арлын дугаараар холбогдоод зөрчил хянан шалгах буюу Тээврийн цагдаагийн албаны мэргэжилтэн, Авто тээврийн хяналтын улсын байцаагч гэсэн хоёр эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл дамжуулахаар энэ бүртгэлийг хийсэн. Мөн энэхүү систем нь камерын системтэй хосолж ажиллаж болно...” гэж тайлбарласан. Харин НЗДТГ-ын Программ хангамжийн хэлтсийн эрх бүхий албан тушаалтан “...2023 оноос RFID нааж эхэлсэн, программ хангамжийг Засгийн газрын тогтоолоор ЗТХЯ хариуцна, ...ерөөсөө ажилладаггүй хэдэн шонтой, уншигчтай, программ хангамж байхгүй байдалтай хүлээж байна...” гэсэн тайлбар өгчээ.

(ХЭҮК-оос 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан сонсох ажиллагаанд оролцсон эрх бүхий албан тушаалтны ярилцлагаас)
(ХЭҮК-ын гишүүний 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 04/21 дүгээр зөвлөмжийн хэсгээс)

Цахим хөгжлийн удирдлага, зохион байгуулалт

Хурдацтай хөгжиж буй цахим технологийн эрин цаг үед хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад засаглал, зохион байгуулалтын чанар, чадавх тулгуур үүрэгтэй. Гэвч цахим хөгжил, харилцаа холбооны салбарын байгууллагын чиг үүрэг давхацсан, байгууллагуудын уялдаа холбоо сул, зохицуулалтын механизм тодорхой бус, хүний нөөц тогтворгүй байгаа нь бодлогын чанар, алсын хараа, хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.²³ ЦХИХХЯ нь Монгол Улсын цахим хөгжил, харилцаа холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, сансрын технологи, өргөн нэвтрүүлгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэгтэй. Эдгээр чиг үүргийн дагуу тус яамны харьяанд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв, “Үндэсний дата төв” УТҮГ, “Радио, телевизийн Үндэсний сүлжээ” УТҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, “И-Монгол академи” УТҮГ ажиллаж байна. Мөн харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр Харилцаа холбооны зохицуулах хороо, “Монгол шуудан” ХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК, “Мэдээлэл технологийн үндэсний парк” ААТҮҮГ ажиллаж байна. Эдгээр байгууллагууд цахим засаглалыг хөгжүүлэх, цахим дэд бүтцийг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зэрэг агуулга бүхий давхацсан стратегийн зорилтуудыг дэвшүүлжээ.

²³ УАГ, “Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит” хураангуй тайлан, УБ, 2023 он, 15 дахь тал. “Шинжлэх ухаан, технологийн салбарт нэгдсэн зохицуулалт муу, инновац, технологи шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих дэд бүтэц бүрдээгүй, бодлого, хүний нөөц тогтворгүй, дотоод хяналт үр нөлөөгүй байна.” гэж анхааруулжээ.

ХХМХтХ-иар мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллагаар ХЭҮК болон ЦХИХХЯ-ыг нэрлэн зааж, чиг үүрэг олгосон. Гэвч бусад төрийн байгууллагууд ямар чиг үүрэгтэй оролцох талаар нарийвчлан зохицуулаагүй, бодлогын түвшинд ажиллах яаманд хариуцсан бүтэцгүй байгаа тул хүний хувийн мэдээллийг хамгаалах Засгийн газрын үйл ажиллагаа хангалтгүй байхад хүргэж байна.

Шигтгээ 3.2

ХХМХтХ-ийн 25 дугаар зүйлд заасны дагуу ЦХИХХЯ нь цахим орчинд хүний хувийн мэдээллийг хамгаалах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- *Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, олон нийтэд сурталчлан таниулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;*
- *хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмыг батлах;*
- *мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн талаар мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авч бүртгэн, шаардлагатай арга хэмжээг даруй авах.*

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолоор баталсан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох шаардлагатай 166 байгууллагаас 2025 оны байдлаар 56 байгууллага холбогдсон нь бодлогын хэрэгжилт хангалтгүйг илтгэж байна.²⁴ Энэ нь Монгол Улсын цахим засаглалын суурь болох кибер орчны найдвартай байдал, уялдаа холбоог сайжруулах, хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд бэрхшээл үүсгэж, төрийн цахим шилжилтэд зохицуулалтгүй байдал бий болгож, нэгдсэн удирдлага, итгэлцэл, хамгаалалт сулрах эрсдэлийг бий болгож байна.

Салбарын байгууллагуудын зэрэгцээ төрийн бүх шатны байгууллагууд чиг үүргийн хүрээнд цахимжилтыг нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд салбар бүр, зарим тохиолдолд нэг салбарын байгууллагууд ижил зориулалттай программ хангамж хөгжүүлснээр төсвийн алдагдалд хүргэхээс гадна энэ мэт арга хэмжээ салбарын албан хаагчид, иргэдэд хүндрэл учруулж байна. Ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтаар хөгжүүлсэн боловч үр дүнд хүрээгүй, тогтвортой ажиллах байдлыг тооцоолоогүй цөөнгүй программ хангамж, систем эзэнгүйдэж, бусад байгууллагаас хөгжүүлж, үйл ажиллагаа нь доголдсон 10 систем, 45 веб хуудас “И-Монгол” Академид шилжиж иржээ.²⁵

Цахим хэрэгсэл, сүлжээ, программ хангамж, алгоритмын системийг найдвартай, хүний эрхийн эрсдэлгүй ажиллуулж, төрийн хэргийг хөтлөн явуулах, үйлчилгээ үзүүлэх нь нэг удаагийн худалдан авалт биш, байнгын хөрөнгө оруулалт, сайжруулалт, аюулгүй байдлыг хянах тасралтгүй үйл явц юм. Үр ашиг, аюулгүй байдал, урт хугацаанд хэрхэн ашиглахыг тооцохгүйгээр цахим технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн жишээ олон байгаа нь ихэнх төрийн албан хаагчдын цахим технологийн талаарх ойлголт муу, бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх чадавх хангалтгүйг илтгэж байна.

Төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа цахим нийгмийг бүтээхэд чухал боловч Монгол Улсад энэ хамтын ажиллагаа хангалтгүй түвшинд байна. Тухайлбал, энэ үзүүлэлтээр Монгол Улс Дэлхийн дижитал өрсөлдөх чадварын 2024 оны тайланд 67 улсаас 66 дугаар байранд эрэмбэлэгджээ.²⁶ Технологид суурилсан гарааны бизнесүүд өсөн нэмэгдэж, Монголын эдийн засгийн салшгүй хэсэг болох төлөвтэй байна. 2024 оны судалгаагаар Монгол Улс дэлхийн гарааны бизнесийн экосистемийн жагсаалтад 100 улсаас 81 дүгээрт орсон нь дэлхийн өрсөлдөх чадвартай гарааны бизнес экосистемтэй болохын тулд илүү их анхаарал, дэмжлэг хэрэгтэйг харуулж байна.²⁷

Мэдээллийн технологи, боловсролын технологи, эрүүл мэндийн технологийн салбарууд гарааны бизнес үүсгэн байгуулагчдын сонирхлыг татахын зэрэгцээ хөрөнгө

²⁴ ЦХИХХЯ, “Кибер аюулгүй байдлын чадамжийн үнэлгээ”, УБ, 2025 он, 33 дахь тал

²⁵ Эшлэл 1-ийг үзнэ үү.

²⁶ Олон улсын менежмент хөгжлийн институт/Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024 он, 147 дахь тал.

²⁷ Стартап блинк, “Стартап экосистемийн тайлан”, 2024 он, 52 дахь тал.

оруулагчдын анхаарлын төвд байсаар байна. Харин санхүүгийн технологи (финтек), зар сурталчилгааны технологи болон блокчэйн чиглэлийн гарааны бизнес орлогоор тэргүүлж байгаа нь Монгол Улсад харьцангуй эрх чөлөөтэй, инновацад ээлтэй бизнесийн орчин бүрэлдэж байгааг илтгэнэ.²⁸ Гэсэн хэдий ч эдгээр гарааны бизнесүүдийн дийлэнх нь дотоодын зах зээлд хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулж байгаа нь олон улсын түншлэл, санхүүгийн дэмжлэг, хууль эрх зүйн таатай орчин зэрэг хүчин зүйлсийн дутагдалтай холбоотой.²⁹

Цахим засаглалд иргэд итгэдэг, дэмжлэг байх, цахимаар харилцах нийгмийн соёл, хандлага төлөвшүүлэх нь цахим засаглалын амжилтын үндэс юм.³⁰ Гэвч нийгмийн энэ хөрс суурийг бий болгох талаар хангалтгүй ажиллаж байгаагаас цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр цахим баримт бичиг нь цаасан баримт бичигтэй адил хүчинтэй байхаар заасан ч төрийн байгууллагууд цахимаас илүүтэй уламжлалт байдлаар үйлчилж байна.³¹ Цахимаар үзүүлсэн үйлчилгээний материалыг хэвлэж архивладаг, түүнийгээ удирдах газартаа илгээдэг, цахим лавлагаа, тодорхойлолтыг банкнууд болон бусад үйлчилгээний байгууллагууд цаасаар шаардах нь цөөнгүй байна. Цахим үйлчилгээ үзүүлэхэд иргэдээс шаардаж буй бүрдүүлбэр бичиг баримтууд зарим салбар, аймгуудад өөр байдаг, мөн үйлчилгээ үзүүлэгч албан хаагч олон системд зэрэг хандаж ажиллах шаардлагатай болдог, энэ ачааллыг хэрэглэж буй цахим төхөөрөмж дийлэхгүй байх тохиолдол түгээмэл байна. Энэ мэт нөхцөл иргэд болон цахим засаглалыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй төрийн албан хаагчдын итгэл үнэмшлийг бууруулж байна.

Интернэт, цахим технологийн нэвтрэлт, хүртээмж

Монгол Улс технологийн үзүүлэлтээр дэлхийн цахим өрсөлдөх чадварын 2024 оны тайланд 67 орноос 55 дугаар байранд эрэмбэлэгдсэн нь тус салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой байна.³² Гэсэн хэдий ч ирээдүйд бэлэн байдлын үзүүлэлтээр 64 дүгээр байр эзэлсэн нь цахим технологийн нэвтрүүлэлт, хэрэглээний түвшин хангалтгүй байна.³³

Монгол Улсад мэдээллийн технологийн салбар эрчимтэй хөгжиж байна. 2025 оны байдлаар шилэн кабелийн сүлжээний нийт урт 51,939 км-д хүрч, улсын хэмжээнд бүх аймаг, сумын төв болон томоохон суурин газрууд хөдөлгөөнт болон суурин холбооны сүлжээнд бүрэн холбогдсон байна.³⁴ 4G LTE технологи 2016 онд нэвтэрснээс хойш хэрэглэгчдийн тоо тасралтгүй өсөж, 3.4 сая гаруй хэрэглэгч энэ үйлчилгээг ашиглаж байна.³⁵

Хүн амын 83 хувь нь интернэт ашиглаж, 4.12 сая идэвхтэй хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч бүртгэгдсэн нь ухаалаг төхөөрөмж, хөдөлгөөнт интернэтийн хэрэглээ тасралтгүй нэмэгдэж буйг илтгэнэ.³⁶ 5G технологийн туршилт 2022 оноос эхэлж, нийслэл хот болон бусад томоохон сууринд нэвтрүүлэх бэлтгэл хангагдаж байна. Интернэтийн гадаад гарцын урсгал 590,5 Гбит/сек-д хүрч, мэдээлэл дамжуулах чадвар эрс нэмэгдсэн байна.³⁷ 2023 оны байдлаар үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдийн тоо 4.8 саяд хүрсэн нь хүн амын тооноос

²⁸ JICA, KITE, MMCG. “Монгол Улсын стартап экосистемийн суурь судалгаа”, УБ, 2022 он, 10 дахь тал.

²⁹ Мөн тэнд 14 дэх тал.

³⁰ “Цахим боловсрол, иргэдийн цахим ур чадвар” хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

³¹ Төрийн цахим үйлчилгээ нь бодит үйлчилгээг бүрмөсөн халахгүй, ялангуяа, цахим үйлчилгээ авах боломжгүй хүн ам бодит үйлчилгээ авах боломжтой байхад анхаарч байна. Харин манай улсад цахимаар үзүүлэх бүрэн боломжтой үйлчилгээг төрийн байгууллагууд уламжлалт байдлаар үзүүлэх нь түгээмэл байна.

³² Олон улсын менежмент хөгжлийн институт, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024 он, 57 дахь тал. Дижитал технологи хөгжих боломжийг бүрдүүлдэг ерөнхий орчныг “Технологи” гэх үзүүлэлтээр үнэлдэг.

³³ Олон улсын менежмент хөгжлийн институт, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024 он, 58 дахь тал. Тухайн улсын эдийн засаг, цахим шилжилтийг үр ашигтай хэрэгжүүлэхэд бэлэн эсэхийг “Ирээдүйд бэлэн байдал” гэх үзүүлэлтээр үнэлдэг.

³⁴ ХХЗХ, “Харилцаа холбооны зах зээлийн 2023 оны статистик эмхэтгэл”, УБ, 2024 он, 2 дахь тал.

³⁵ Мөн тэнд 22 дахь тал.

³⁶ Олон улсын цахилгаан холбооны байгууллага, <https://datahub.itu.int/> (2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хандсан)

³⁷ ХХЗХ, “Харилцаа холбооны зах зээлийн 2023 оны статистик эмхэтгэл”, УБ, 2024 он, 2 дахь тал.

давсан үзүүлэлт болж байна. Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч 2023 оны жилийн эцсээр 4,841,935 болж өмнөх оноос 0,1 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ноогдох үзүүлэлт нь 138,2-болж өмнөх оноос 2.6 хувиар буурчээ. Монгол Улсыг бүс нутагтаа болон олон улсад харьцангуй өндөр хэрэглээтэй орны тоонд оруулж байна.³⁸ 2024 оны эхний хагас жилийн байдлаар мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого 1.2 их наяд төгрөгт хүрч, Монгол Улсын эдийн засагт гүйцэтгэх үүрэг улам нэмэгдэж байна.³⁹

Гэсэн хэдий ч цахим технологийн хөгжлийн үр шимийг Монгол Улсын иргэн бүр тэгш хүртэж чадахгүй байна.⁴⁰ Монгол Улсын 328 сум шилэн кабелийн сүлжээнд холбогдсон бөгөөд иргэдийн 97.6 хувь нь гар утас ашиглаж байгаа боловч тэдгээрийн 84.7 хувь нь ухаалаг гар утас хэрэглэдэг байна. “e-Mongolia” системийн техникийн шаардлага нь Android 5.0 болон iOS 10.0-аас дээш үйлдлийн системтэй ухаалаг утас, тогтвортой 3G/4G эсвэл Wi-Fi интернэтэд холбогдох шаардлагатай.⁴¹ Монгол Улсын нийт хүн амын 15.3 хувь буюу 644 мянга орчим хүн ухаалаг утасгүй цахим орчинд нэвтрэх боломжгүй, “e-Mongolia” системийг ашиглах нөхцөл хангагдаагүй байна.

Ялангуяа алслагдсан орон нутгийн болон бага орлоготой өрхүүд дээрх шаардлагыг хангасан ухаалаг утас худалдан авах, цахим үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал байна.⁴² 2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад суурин интернэт хэрэглэгчдийн тоо 498,889 байсан бөгөөд үүнээс 23.97 хувь нь хөдөө орон нутгийн хэрэглэгчид байна. Өөрөөр хэлбэл, хөдөө орон нутгийн өрхийн дөрөвний нэг нь суурин интернэтэд холбогджээ.⁴³

Ахмад настнууд гар утсыг бичлэг үзэх, дуудлага хийх зэрэг энгийн үйлдэлд ашиглаж байна. Харин банкны аппликейшн ашиглах, цахим төлбөр тооцоо хийх зэрэгт хүндрэлтэй байдаг тул уламжлалт үйлчилгээг илүүтэй авч байна. Монгол Улсад 65-аас дээш насны 187 мянга орчим иргэн байгаа бөгөөд тэдний дийлэнх нь цахим орчинд идэвхтэй оролцож чадахгүй байна.⁴⁴ Монгол Улсын нийт өрхийн 27.1 хувь нь амьжиргааны доод түвшинд амьдарч байгаа бөгөөд эдгээр өрхүүд ухаалаг утас, компьютер худалдан авах, интернэтийн сар бүрийн төлбөрийг тогтмол төлөх боломжгүй байна.⁴⁵

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд цахим шилжилтээс хоцрох эрсдэлтэй бүлгийн нэг юм. Монгол Улсад 2023 оны байдлаар 107,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэлтэй байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан дуу хоолойгоор ажилладаг төхөөрөмж, дохионы хэл дээрх мэдээлэл, хүртээмжтэй цахим орчин бүрдээгүй байна.⁴⁶

Эрчим хүчний найдвартай эх сурвалж бол цахим хөгжилд суурь дэд бүтэц юм. Монгол Улсын эрчим хүчний салбарын суурилагдсан нийт хүчин чадал нь 1130 МВт бөгөөд цахилгаан дамжуулах 41,726 км урт сүлжээгээр 330 сумаас 319 сумыг нь цахилгаанаар хангаж байна. Нэг сум сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй, бусад 10 сум нь ОХУ болон БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний системд холбогдсон байна. Харин хөдөөгийн олон айл

³⁸ ХХЗХ, “Харилцаа холбооны зах зээлийн 2023 оны статистик эмхэтгэл”, УБ, 2024 он, 1 дэх тал.

³⁹ ҮСХ, 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн Статистикийн мэдээ, 1 дэх тал.

⁴⁰ Энэ бүлгийн “Цахим хуваагдал, ялгаварлан гадуурхалт” хэсгээс дэлгэрүүлж үзнэ үү.

⁴¹ Эшлэл 1-ийг үзнэ үү. “e-Mongolia.mn” системийн техникийн шаардлага нь Android 5.0 болон iOS 10.0-аас дээш хувилбартай ухаалаг утас, тогтвортой 3G/4G эсвэл Wi-Fi интернэт холболт бөгөөд ухаалаг утасгүй болон, интернэтэд холбогдох боломжгүй иргэд www.e-Mongolia.mn системээр болон төрийн үйлчилгээний ХҮРДАН цэгүүдээр дамжин үйлчилгээ авах боломжтой байна. Нийт ухаалаг утас хэрэглэгчдийн 61.2 хувь нь android, 35.1 хувь IOS үйлдлийн систем бүхий утас хэрэглэж байна.

⁴² Үндэсний судалгааны нэгдсэн платформ, <https://sudalгаа.gov.mn/researches> цахим хуудаст 2025 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар хандсан. “Гар утас хэрэглэгчдийн дата хэрэглээний судалгаа” УБ, 2022 он, 7 дахь тал.

⁴³ ХХЗХ, “Харилцаа холбооны зах зээлийн 2023 оны статистик эмхэтгэл”, УБ, 2024 он, 3 дахь тал.

⁴⁴ НҮБХХ, “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”, УБ, 2021 он, 22–23 дахь тал.

⁴⁵ Монголын Үндэсний мэдээллийн агентлаг, <https://montsame.mn/mn/read/337173> (цахим хуудаст 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хандсан).

⁴⁶ НҮБХХ, “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”, УБ, 2021 он, 10 дахь тал.

өрх, ялангуяа малчин өрхүүд нар, салхины эрчим хүч ашиглаж буй нь цахим үйлчилгээнд хамрагдах боломжийг хязгаарлаж байна.⁴⁷

Иргэдийн цахим боловсрол, цахим ур чадвар

Иргэдийн цахим боловсрол нь мэдээлэл технологийн хэрэглээ, аюулгүй байдал, цахим ёс зүй, кибер гэмт хэргээс сэргийлэх мэдлэгийг хамарсан өргөн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн өргөн хэрэглээ болсон ухаалаг утсыг ашиглан энгийн хэрэглээнд бүх зүйлийг хялбараар шийдэх, орон зай, цаг хугацаанаас үл хамаарч хүссэн мэдээллийг авч ашиглахаас эхлээд цахим дээр суурилсан бүх зүйлийг ойлгох, хэрэглэх, цахим орчинд аюулгүй байдлаа хамгаалах чадварыг хэлнэ.

Монгол Улсын иргэдийн цахим мэдлэгийн түвшин сул байна. 2024 оны "Дэлхийн цахим өрсөлдөх чадварын тайлан"-д Монгол Улс 67 улсаас 64 дүгээр байранд, цахим мэдлэгийн индексээр 62 дугаарт эрэмбэлэгдсэн нь мэдээллийн технологийн боловсрол, судалгаа, инновацын чадавхын дутагдлыг харуулсан үзүүлэлт юм.⁴⁸ Энэ нь цахим боловсролын хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хөгжилд илүү анхаарах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн цахим мэдлэгийн шилжилт хангалтгүй байгаа нь дотоодын байгууллагууд технологийн шилжилт хийх, шинэ мэдлэг нэвтрүүлэхэд хоцрогдож байгааг илтгэнэ.

Засгийн газраас иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа ч Монгол Улсын цахим шилжилтийн үр нөлөө сул байна. Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Соёлын сайд нарын (хуучин нэрээр) 2022 оны А/260/391/1461/260 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2022-2026)"-нд "Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болно." гэж заасан байна. Мөн Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 46 дугаар хуралдааны тэмдэглэлд бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус үүрэг болгожээ.

Түүнчлэн, Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ"-г зургаан тэргүүлэх чиглэлтэй, мөн БШУ-ны сайдын (хуучин нэрээр) 2024 оны А/57 тушаалаар "Албан болон албан бус боловсролын сургалтаар иргэдийн эзэмшвэл зохих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн хүрээ"-г 12 чадамжтай байхаар баталсан байна. Ингэснээр төрийн албан хаагч, оюутан, залуус, сурагч, ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад гол баримтлах бичиг баримттай болсон байна.

Цахим ур чадвар эзэмших тэгш боломж бүрдээгүй, хүртээмжгүй, нас, хүйс, ажил мэргэжил, оршин суугаа газраас хамааран ялгаатай байна. Иймд цахим ур чадварыг дэмжих үйл ажиллагааг эдгээр нөхцөл байдал, онцлогт нийцүүлэн зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.⁴⁹

⁴⁷ Даян дэлхийн ногоон хөгжлийн институт, "Монгол Улсын ногоон эрчим хүчний систем, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн хөгжил", УБ, 2020 он, 14 дэх тал.

⁴⁸ ЕХХХМХЕЖ, Олон улсын менежмент хөгжлийн институт/Дэлхийн өрсөлдөх чадварын төв, Дэлхийн цахим өрсөлдөх чадварын эрэмбэ, 2024 он, 56 дахь тал. Дэлхийн улс орнуудын дижитал өрсөлдөх чадварыг үнэлдэг судалгаа бөгөөд нэг шалгуур нь цахим мэдлэгийн шалгуур юм. 67 улсын технологийн боловсрол, инновац, судалгаа хөгжүүлэлт, шинжлэх ухаан, технологийн талаар гарч буй мэдлэг, шинэчлэл зэрэг хүчин зүйлсийг үнэлдэг. Энэхүү тайланд Монгол Улс цахим мэдлэгийн индексээр 62 дугаарт, ирээдүйд бэлэн байдлын индексээр 64 дүгээрт, технологийн салбарын индексээр 55 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

⁴⁹ БШУЯ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, "Иргэдийн цахим ур чадварын хэрэгцээ тодорхойлох судалгаа", УБ, 2023 он, 24 дэх тал. "...судалгаанд оролцсон иргэдийн гүйцэтгэлийг чадамж, хүйсээр авч үзэхэд, асуудал шийдвэрлэх чадвар эрэгтэйчүүдийн хувьд 79 хувь, эмэгтэйчүүдийн хувьд 83.6 хувь байна. Харин аюулгүй байдал, харилцаа холбооны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй. ...оюутнуудын

Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадвар сул түвшинд байгаа нь хөгжлийн гадна хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимд нийцэхгүй байна.⁵⁰ Иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэхэд төрийн үйлчилгээг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн агуулгаар тэгш, хүртээмжтэй зохион байгуулах шаардлагатай. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан болон алслагдсан орон нутгийн иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд төрийн байгууллагуудын дэмжлэг чухал үүрэгтэй бөгөөд тэдний цахим үйлчилгээнд оролцох боломжийг хангасан салбарын бодлогын баримт бичгийн үр нөлөөг дээшлүүлэх нь чухал байна.

Төрөөс иргэдийн цахим ур чадварыг бие даан эзэмшихэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааны мэдээллийг хүргэх, сургалтын материал, видео хичээлүүдийг байршуулсан www.digital.edu.mn веб сайтыг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.⁵¹

Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг иж бүрэн үнэлээгүй, шаардлагатай сургалтуудын хүрээ хязгаарлагдмал бөгөөд цахим ур чадварыг сайжруулах төлөвлөгөө нь үр дүн багатай байгаагаас төрийн албан хаагчдын цахим ур чадвар хангалтгүй байна. ҮСХ, АХБ-тай хамтран хийсэн “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдал” судалгааны тайланд тус салбарын ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах хандлага бага, өгөгдөл нэгтгэхэд шаардлагатай ур чадвартай хүний нөөц байхгүй, төрийн албан хаагчид өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлан бичихэд бизнесийн ухаалаг мэдээллийн хэрэгслүүдийг ашиглах ач холбогдлын талаарх ойлголт хомс гэж дүгнэжээ.⁵²

Түүнчлэн ҮАГ-ын 2023 оны Монгол Улсын Засгийн газраас “Цахим Монгол” зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын хураангуй тайланд ЦХХХЯ (хуучин нэрээр) хүн амын цахим ур чадварыг төрөл бүрийн эх үүсвэрээр судалсан хэдий ч төрийн албан хаагчдын мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаарх мэдлэг, ур чадварын түвшнийг бүрэн тодорхойлж чадаагүй байна. Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах хүрээнд таван аймгийн 598 төрийн албан хаагчдыг хамруулсан судалгааг зохион байгуулсан хэдий ч судалгааны үр дүн нь нийт төрийн албан хаагчдын цахим ур чадварын түвшнийг илэрхийлж чадахгүй байна. Мөн төрийн тусгай албаны байгууллагад ажиллагсдын цахим ур чадвар түвшнийг үнэлж тодорхойлоогүй байна. Үндэсний зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх бодлого, стратегийг боловсруулахад төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг иж бүрэн үнэлээгүйгээс цахим

гүйцэтгэл хамгийн өндөр үзүүлэлттэй байгаагаас гадна төрийн албанд ажилладаг иргэдийн хувьд хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийнхээс дээгүүр байна. Хөдөлмөр эрхэлдэггүй гэсэн иргэдийн гүйцэтгэл 76.9 байгаа нь сурагч, малчин, тэтгэвэрт байдаг иргэдээс илүү болохыг илтгэж байна. Судалгаанд хөдөлмөр эрхэлдэггүй 434 хүн хамрагдсан ба 25-44 хүртэлх насныхан 71.0 хувийг эзэлж байна. Энэ насныхны хувьд цахим ур чадвар бусад насны иргэдийн ур чадвартай харьцуулахад илүү байгаа нь хөдөлмөр эрхлээгүй иргэдийн цахим ур чадвар гүйцэтгэлийн ерөнхий дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.” гэж дүгнэжээ.

⁵⁰ НҮБХХ, “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”, УБ, 2021 он, 9-31 дэх тал. “...хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг эрэмбэлэхэд төрийн үйлчилгээ авах (Цахим төлбөрийн баримтын систем/ebairmt, e-Mongolia систем) 5 дугаарт, ахмад настай иргэдийн цахим ур чадварт төрийн үйлчилгээ цахимаар авч сурах 4 дүгээрт, алслагдсан бүсэд суурьшдаг иргэд төрийн үйлчилгээ авах (Цахим төлбөрийн баримтын систем/ebairmt, e-Mongolia систем) ур чадварыг 5 дугаарт тус тус эрэмбэлсэн.” байна.

⁵¹ “И-Монгол академи” УТҮГ-ын үйл ажиллагааны тайлан, УБ, 2025 он. (“И-Монгол академи” УТҮГ-аас бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2022 оны гуравдугаар сараас эхлэн зохион байгуулж, нийтдээ 70,000 гаруй иргэнд танхим, цахим хосолсон байдлаар хүргэсэн байна. Үүний зэрэгцээ 816 цахим ур чадварын сургагч багшийг бэлтгэсэн. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлж, тоон хуваагдлыг бууруулан цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор “Цахим ур чадварын аян”-ыг зохион байгуулжээ. 2022-2024 оны хугацаанд хөдөө орон нутаг, алслагдсан бүсийн нийт 13 орчим иргэн, 17,5 мянга орчим төрийн албан хаагчдыг сургалтад хамруулжээ.”

⁵² ҮСХ, АХБ, “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн байдал” судалгааны тайлан, УБ, 2024 он, 13 дахь тал. “Мэдээллийн технологийн салбарын нийт батлагдсан ажлын байрны 20.7 хувийг сул орон тоо эзэлж байгаа бөгөөд энэ салбарын ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах хандлага бага байна. Байгууллагуудын 41.9 хувь нь өгөгдөл нэгтгэхэд шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцгүй байна. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх, тайлан бичихэд бизнесийн ухаалаг мэдээлэл (Business In-telligence)-ийн хэрэгслүүдийг ашиглах ач холбогдлын талаарх ойлголт төрийн албан хаагчдад бага байна.” гэж дүгнэжээ.

шилжилтийн үеийн суурь нөхцөлийг бэхжүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хугацаа алдах эрсдэлтэй байна гэж дүгнэжээ.⁵³

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим Монгол" зорилт нь цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүнд төрийн албан хаагчдын цахим ур чадвар нь гол бүрэлдэхүүн хэсэг юм. Иймд цахим ур чадварыг бүхэлд нь үнэлж, төрийн албан хаагчдад зориулсан тодорхой хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлснээр цахим шилжилтийг амжилттай, үр дүнтэй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх боломжтой болно.

Албан боловсрол

Сурагчдын цахим боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд техник, технологийн хүртээмж хангалтгүй байна. Нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын төрийн болон хувийн өмчийн бага, дунд, ахлах нийт 317 сургууль үйл ажиллагаа явуулж байна.⁵⁴ Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-иудад суралцагчдад цахим боловсрол, ур чадвар олгоход чиглэсэн анги танхим, техник, технологийн хүртээмж хангалтгүй байгаа талаар салбарын сайд мэдээлжээ.⁵⁵

БШУЯ-наас ЕБС-ийн 6-12 дугаар ангийн нийт 100 сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлэн, "Mozaik education" системд оруулсан бөгөөд интерактив 3D контент, видео контент, зураг, аудио, 170 гаруй хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн байна.⁵⁶ Сурах бичгүүд цахим хэлбэрт бүрэн шилжсэн нь сурагчид цахим системд суурилан интерактив хэлбэрээр ашиглах боломжийг бий болгожээ. Мөн ЕБС-иудад сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг сайжруулах зорилгоор цахим сургалтын орчныг үе шаттай бүрдүүлсэн нь суурь боловсрол олгохын зэрэгцээ цахим ур чадвар олгоход нөлөөлж байна.⁵⁷

Боловсролын үнэлгээний төвөөс 2024 оны 05 дугаар сард цахим системийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг үндэсний сургалтын хөтөлбөрт үндэслэн хийж, оношлох үнэлгээтэй харьцуулахад суралцагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувьд III анги 13.86 хувь, IV анги 16.15 хувийн ахицтай болохыг дүгнэсэн байна.⁵⁸ Энэ суралцагчдын цахим систем ашиглах чадвар сайжирч байгаа үзүүлэлт байж болох хэдий ч тэдний цахим орчинд аюулгүй байдлаа хамгаалах ур чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг судалгаа харуулжээ.⁵⁹

Олон улсын жишигт нийцсэн, хэрэглэхэд хялбар, багш, сурагчдад зориулсан олон төрлийн боломжийг хангасан платформыг нэвтрүүлэх, цахим анги танхимын тоог

⁵³ УАГ, "Монгол Улсын Засгийн газрын "Цахим монгол" зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудит" хураангуй тайлан, УБ, 2024 он, 6 дахь тал. "Иргэдийн цахим ур чадварын судалгааны 2023 оны үр дүнгээр цахим ур чадварын түвшин төрийн захиргааны байгууллагад ажиллагсдынх 83.7 хувь, төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагсдынх 81.6 хувьтай байна" гэж тайлагнажээ.

⁵⁴ УСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn, УБ, 2024 он.

⁵⁵ БШУ-ны сайд (хуучнаар) Л.Энх-Амгалангийн "Боловсролын шинэ сэргэлт" сэдэвт илтгэл, УБ, 2024 он. "Төрийн өмчийн ерөнхий боловсролын 108 сургууль 194 цахим ангитай, 55 сургууль огт цахим танхимгүй байна. БШУЯ-наас 2024-2025 оны хичээлийн жилд бүрэн цахимжуулахаар төлөвлөж, үүнээс гадна цахим технологид суурилсан Medle, Eduten, Pearson, Suraad.mn төслүүд хэрэгжиж байгаа бөгөөд цаашдаа багш, сурагчдын цахим ур чадварыг сайжруулах, сургалтын технологийг улам хөгжүүлж, сургалтын орчин, техник хангамжийг сайжруулахад анхаарч ажиллана. Цахим ангид нийт 1359 хромбүүк, 4371 таблет, 551 ухаалаг самбар байна. Дунджаар нэг сургуульд 3 ухаалаг самбар, нэг цахим ангид 30 хромбүүк, таблет байгаа нь зөвхөн цахим танхимд ашиглагдаж байна." гэжээ.

⁵⁶ Мөн тэнд.

⁵⁷ БЕГ-ын үйл ажиллагааны тайлан, УБ, 2025 он. "...672 сургуулийн бага ангийн 341,950 суралцагч 7 хоногт нэг удаа математикийн Eduten цахим систем дээр хичээллэж байна. БЕГ-аас 2024 онд бага боловсролын 6000 гаруй багшийг платформын үндсэн сургалтад цахим болон танхимын хэлбэрээр хамруулж, аймаг, нийслэлийн нийт 356 сургуульд мониторинг, зөвлөн туслах ажлыг мөн оны 5, 10, 12 дугаар саруудад орон нутгийн бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, Eduten системийн зөвлөхүүдтэй хамтран зохион байгуулж, платформын тусламж, чатбот, "Eduten Mongolia" групп, боловсролын байгууллагуудад дамжуулан, мэдээллийг хүргэж, дэмжлэг үзүүлэн ажилласан." гэж тайлагнажээ.

⁵⁸ БЕГ-ын үйл ажиллагааны тайлан, 2025 он. "...ЕБС-ын үйл ажиллагааг 2024 оны байдлаар аймаг, нийслэлээр харуулбал 89-100 хувь байгаа ба өмнөх сараас тодорхой ахицтай байна. Нийт суралцагчдын 98 хувь нь идэвхтэй суралцаж байгаа бөгөөд 7 хоног бүрийн зорилгодоо хүрсэн үзүүлэлт сар бүр ахицтай байна." гэжээ.

⁵⁹ ЮНЕСКО, Боловсролын хяналт-шинжилгээний дэлхийн тайлангийн баг, "Боловсрол ба технологи", УБ, 2023 он, 11 дэх тал. "2018 оны PISA-ийн судалгаагаар унших чадвар өндөртэй 15 настай хүүхдүүдийн 5 хувь, харин унших чадвар сул хүүхдүүдийн 24 хувь нь энгийн цахим залиланд өртөх эрсдэлтэй байна." гэж дүгнэжээ.

нэмэгдүүлэх, хиймэл дагуулын болон бусад технологийн шийдлийг ашиглан хөдөө орон нутгийн сургуулиудыг интернэтэд холбох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр боловсролын салбарт цахим шилжилт амжилттай хэрэгжиж, сургалтын чанар дээшлэх, хүртээмж нэмэгдэх, сурагчдын мэдээллийн технологийн ур чадвар хөгжих зэрэг олон эерэг үр дүн гарах болно.

Албан бус боловсрол

Цахим ур чадвар олгох сургалтууд нэг удаагийн шинжтэй, тогтмол биш, хязгаарлагдмал хүрээнд явагдаж байна. Асуудал хариуцсан яамд, төрийн холбогдох байгууллагуудаас зорилтот бүлэгт чиглэсэн цахим ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж байгаа ч нэгдсэн төлөвлөлтгүй, уялдаа холбоогүй байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг хэрхэн авах талаар заавар, зөвлөмж, Засгийн газраас цахим шилжилтийн хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээг таниулах контентуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж, зорилтот бүлгийн иргэдийг цахим ур чадвар олгох сургалтад хамруулжээ. Түүнчлэн БНСУ-ын NIA байгууллагын дэмжлэгээр Мэдээлэл технологийн үндэсний паркийн 1 дүгээр давхарт Монгол Улсын мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлэх зорилготой “Мэдээлэл хандалтын төв”-ийг байгуулсан байна.⁶⁰

Ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай өрхүүд, алслагдсан бүс нутгийн иргэд цахим хуваагдалд өртөж байна. Дэлхийн банкны санхүүжилтээр ЦХИХХЯ-аас хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг-2” төслийн хүрээнд иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, залуу үе, ахмад үеийн цахим хуваагдлын харилцан ойлголцлыг сайжруулах “Үндэсний цахим элч” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хэдий ч сургалтад хамрагдсан ахмад настнуудын тоо хангалтгүй байна.⁶¹ Ахмад настнууд олон нийтийн сүлжээ хэрэглэх нь нэмэгдэж, цахимаар бүтээгдэхүүн үйлчилгээ худалдан авалт хийх нь ихсэж байгаа ч цахим орчинд халдлагад өртөх, цахим залилангийн хохирогч болох тохиолдол өндөр байгаа нь цахим орчин дахь аюулгүй байдлын мэдлэг, мэдээллийг өгөх, цахим ур чадварыг сайжруулж, чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай.

НҮБХХ-ийн Хурдасгуур лаборатори⁶² нь Монгол Улсад технологийн дэвшлээс хоцрогдон үлдэж болзошгүй бүлгийн иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хэд хэдэн төслийг хэрэгжүүлсэн бөгөөд “үндэсний хэмжээнд цахим ур чадвар олгох олон контент боловсруулсан ч олон нийтэд хүргэх тал дээр анхаардаггүй, голдуу хаалттай эх сурвалж дээр тавьдаг нь ажиглагдсан.” гэж дүгнэжээ.⁶³

“Цахим Үндэстэн” бодлогын баримт бичигт иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх талаар холбогдох зорилт, арга хэмжээг тусгаж, 2022-2027 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хугацааны талаас илүү хувь нь өнгөрсөн байхад хэрэгжилт хангалтгүй байна. Төр, хувийн хэвшил, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулснаар иргэдийн цахим ур чадварыг хөгжүүлэх бодлого, зорилт үр дүнд хүрнэ.

⁶⁰ ЦХИХХЯ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын дэд зөвлөлийн үйл ажиллагааны тайлан”, УБ, 2024 он.

⁶¹ ЦХИХХЯ-ны цахим хуудас, <https://mddic.gov.mn/mn/2025/01/20825/>, 2025 он, “Хөтөлбөрийн хүрээнд “И-Монгол академи” УТҮГ-ын сургагч багш нар “Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх” хөтөлбөрт өөрийн сайн дурын үндсэн дээр оролцож, сургагч багш бэлтгэх 5 удаагийн 16 цагийн сургалтыг зохион байгуулж ахмад 30, 137 сайн дурын оюутан залуус, ахмадыг цахим ур чадварын сургагч багшаар бэлтгэж, 9 дүүрэг, 13 аймгийн 188 ахмад настнууд, нийт 1277 ахмадад цахим ур чадварыг олгожээ.

⁶² НҮБХХ-ийн Хурдасгуур Лаборатори нь хөгжлийн асуудлуудад шинэлэг шийдлүүдийг судлах, турших, хөгжүүлэх зорилгоор дэлхийн 116 орны 92 лабораторитойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

⁶³ НҮБХХ-ийн Хурдасгуур Лаборатори, “Цахим хүртээмж, цахим ур чадварыг инновацад түшиглэн турших замаар нэмэгдүүлэх нь” УБ, 2022 он. “Тус байгууллагаас шат дараалсан туршилт хийж, техник технологи гэрлийн хурдаар хөгжихийн хэрээр, цахим ур чадвар дутмаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ бүхний ард хоцорч байна” гэж дүгнэжээ.

Мэргэжлийн боловсрол

Мэдээллийн технологийн судалгаа, инновацын чадавх сул байна. Дэлхийн инновацын индексээр 133 орноос 67 дугаар байранд эрэмбэлэгдэж 2023 оны дүнгээс нэг байр урагшилсан нь ахицтай үзүүлэлт боловч дэлхийн түвшинд инновацын манлайллыг бий болгоход хангалтгүй хэвээр байна. Инновацын хөгжлийг авч үзэхэд боловсрол, шинжлэх ухааны судалгааны чанар, мэдээллийн технологийн хөгжил, хөдөө аж ахуйн инновац зэрэг салбарууд харьцангуй сайн гүйцэтгэлтэй гарсан байна.⁶⁴ Инженер, шинжлэх ухааны чиглэлээр суралцагчдын тоо нэмэгдэж, мэдээллийн технологийн гарааны бизнесүүд өсөлттэй байгаа нь ирээдүйд илүү өрсөлдөхүйц экосистем бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой байна.

Олон улсын түвшинд өрсөлдөхүйц инновацын орчин бүрдүүлэхэд мэдээллийн технологийн дэд бүтэц, инновацын төсөлд шаардлагатай санхүүжилт, мэдлэгт суурилсан хүний нөөцийн дутагдал зэрэг асуудлууд нь Монгол Улсын хувьд инновацын өрсөлдөх чадварт нөлөөлж байна.⁶⁵ Ялангуяа судалгаа, хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалт хангалтгүй, олон улсын оюуны өмчийн бүртгэл сул, инновацын гарааны бизнесүүдийн санхүүжилтийн орчин хязгаарлагдмал байдал нь хөгжлийн томоохон саад болж байна. Гэсэн хэдий ч цахим шилжилт, хиймэл оюун ухаан, ногоон технологийн салбарууд эрчимтэй хөгжиж буй нь шинээр инновацын дэвшлийг бий болгоход чухал нөлөө үзүүлж байна.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөцийн бодлогыг боловсронгуй болгож, мэргэжилтнүүдийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Тус салбарын хөгжилтэй уялдан энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэх хэрэгцээ нэмэгдсээр байгаа бөгөөд одоогоор төрийн болон хувийн хэвшлийн 39 их, дээд сургуульд 7,7 мянга гаруй оюутан суралцаж байна.⁶⁶ Тус салбарт программист, цахилгаан холбооны инженер, утасгүй холбооны инженер, техникч оператор, сүлжээний инженер зэрэг мэргэжлүүд өндөр эрэлттэй байгааг тодорхойлжээ.⁶⁷ Гэвч салбарын ажиллах хүчний тоо 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 хувиар буурсан нь хүний нөөцийн бодлогод анхаарал хандуулах шаардлагатай байгааг илэрхийлж байна.⁶⁸

Мэдээллийн технологийн хичээлийг бүх шатны боловсролын байгууллага, ялангуяа ерөнхий боловсролын болон энэ чиглэлийн мэргэжил эзэмшихээр суралцаж буй суралцагчдад зориулсан хөтөлбөрийн агуулга, хүртээмжийг илүү нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг сайжруулах шаардлагатай бөгөөд энэ нь цахим засаглалын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэх суурь нөхцөл болно.

Кибер аюулгүй байдлыг хангахад тулгамдсан асуудал

Кибер аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн орчин боловсронгуй болж, Монгол Улсын кибер орон зайг халдлагаас хамгаалах, зөрчлийг илрүүлэх тогтолцоог бүрдүүлжээ. Кибер аюулгүй байдлын тухай хуулийг 2021 онд баталж, хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор “Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги”, 2023 оны 42 дугаар тогтоолоор “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм”, “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны ажиллах журам”, 2023 оны 224 дүгээр тогтоолоор “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”, 2023 оны 318 дугаар тогтоолоор “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвийн дүрэм, төвийн ажиллах журам”, “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв, улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм,

⁶⁴ Дэлхийн инновацын индекс 2024 он, 18 дахь тал. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр дэлхийн 133 улс орнуудын инновацын индексийг гаргадаг бөгөөд байгууллага, хүний нөөц, судалгааны дэд бүтэц, зээл, хөрөнгө оруулалт, уялдаа холбоо, мэдлэг бүтээлч байдал гэсэн 7 шалгуурыг нэгтгэсэн үзүүлэлт.

⁶⁵ Дэлхийн инновацын индекс 2024 он, 193 дахь тал.

⁶⁶ ЦХХХЯ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, УБ, 2021 он, 13 дахь тал.

⁶⁷ ЦХХХЯ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаа, УБ, 2021 он, 67 дахь тал.

⁶⁸ УСХ, “Ажиллах хүчний судалгааны 2024 оны III улирлын товч танилцуулга” УБ, 2024 он, 10 дахь тал.

байгууллагын бүтэц”-ийг тус тус баталсан байна. Мөн хил дамнасан цахим гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагаагаа өргөтгөх зорилгоор Европын зөвлөлийн “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Будапештын конвенц”-д нэгдэн орох бэлтгэл хангаж байна.⁶⁹ Харин кибер аюулгүй байдлын бодлого, эрхзүйн орчны уялдаа холбоог сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хэрэгтэйг судалгаанд дүгнэснийг анхаарах шаардлагатай.⁷⁰

Кибер аюулгүй байдлын зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлж, дэд даргаар ЦХИХХЯ-ны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нар ажиллаж, үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг хэрэгжүүлэхээр тогтоожээ.⁷¹ Харин Монгол Улсын төрийн болон иргэний эсрэг чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, хамгаалах чиг үүргийн хүрээнд стратегийн түвшинд Кибер аюулгүй байдлын зөвлөл, Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлын командлал, Тагнуулын ерөнхий газар, ЦХИХХЯ, тактикийн түвшинд Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Зэвсэгт хүчний төв, Үндэсний төв, Нийтийн төв, үйл ажиллагааны түвшинд Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, батлан хамгаалах салбар, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй төрийн өмчит хуулийн этгээд, төрийн мэдээллийн нэгдсэн санд холбогдсон төрийн байгууллага, хувийн онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй иргэн, хуулийн этгээд тус тус ажиллаж байна.

Кибер аюулгүй байдлыг хангах бодлого, эрх зүйн орчин сайжирч, байгууллагуудын тогтолцоо бүрдсэн боловч хэрэгжүүлэх шатанд олон бэрхшээл тулгарч, хүний нөөцийн дутагдал, эрсдэл дагуулсаар байна. Олон улсын цахилгаан холбооны байгууллагын 2024 оны Кибер аюулгүй байдлын индексээр⁷² Монгол Улс 3 дахь түвшинд буюу “бэхжиж буй” ангилалд үнэлэгдсэн нь үүнийг илтгэнэ.⁷³ Тус үнэлгээнд хууль эрх зүйн зохицуулалт, байгууллагын арга хэмжээний үнэлгээгээр Монгол Улс Ази тивийн дунджаас дээгүүр үнэлгээ авч, техникийн арга хэмжээ, олон улсын хамтын ажиллагааны үнэлгээ харьцангуй доогуур гарчээ. Энэ нь бодлого, эрх зүйн орчин сайжирч буй ч түүний хэрэгжилт, техник технологийн чадавх, гадаад хамтын ажиллагааг сул байгааг харуулж байна.⁷⁴ Мөн төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хангалтгүй, салбар, байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын бэлэн байдал харилцан адилгүй түвшинд байна.

3.3.ЦАХИМ ТЕХНОЛОГИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРСДЭЛ

3.3.1.Нийтийн орон зай дахь хяналтын камерын ашиглалт, зохицуулалтын тулгамдсан асуудлууд

Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрт дэвшилтэт техник технологийг ашиглан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, "нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүний хувийн мэдээлэл, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах талаар тусгасан боловч хүний хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах, мэдээллийн аюулгүй байдал алдагдахаас сэргийлэх талаар ямар арга хэмжээг, аль байгууллага, албан

⁶⁹ Глобал Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Төв, Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Үнэлгээ, 2025 он, 81 дэх тал

⁷⁰ Глобал Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Төв, Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Үнэлгээ, 2025 он, 12 дахь тал

⁷¹ Кибер аюулгүй байдлын тухай хуулийн Гуравдугаар бүлэг “Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоо”, 10-19 дүгээр зүйл, Дөрөвдүгээр бүлэг “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх”, 20-23 дугаар зүйл.

⁷² Дэлхийн кибер аюулгүй байдлын индекс нь улс орнуудын кибер аюулгүй байдлыг хууль эрх зүйн арга хэмжээ, техникийн арга хэмжээ, зохион байгуулалтын арга хэмжээ, чадавх хөгжүүлэх, хамтын ажиллагаа гэсэн таван шалгуурыг нэгтгэн илэрхийлдэг үзүүлэлт.

⁷³ Олон улсын цахилгаан холбооны байгууллага, Дэлхийн кибер аюулгүй байдлын индекс, 2024 он, 5 дахь хэвлэл, 2024 он, 90 дэх тал.

⁷⁴ Глобал Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Төв, Кибер Аюулгүй Байдлын Чадамжийн Үнэлгээ, 2025 он, 23 дахь тал.

тушаалтан хэрхэн авч ажиллах талаар тодорхой тусгаагүй нь тунхгийн шинжтэй бодлого гаргаж ирсэн гэж үзэхээр байна.⁷⁵

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хувь хүний мэдээллийг хамгаалах нь үндэсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үзжээ. Тодруулбал, хуулиар зөвшөөрсөн болон тухайн хүний өөрийн зөвшөөрлөөс бусад тохиолдолд түүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглосон. Мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, задруулах, устгах зэрэг аливаа халдлагын эсрэг хамгаалагдсан байдал нь мэдээллийн нууцлалыг хангах үндсэн нөхцөл гэж заасан байдаг.⁷⁶ Мөн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод төр, хувийн хэвшил, иргэдийн мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжийг хангах замаар мэдээллийн технологийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилт дэвшүүлжээ.⁷⁷

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний эрхэд суурилсан олон талт түншлэлийг бий болгох зорилтыг тусгасан. Энэ хүрээнд хүний эрхэд нийцсэн хууль тогтоомжийг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих тогтолцоог сайжруулах чиглэл баримталж байна.⁷⁸

ЗГ-ын 2024 оны “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 86 дугаар тогтоолд “Теле камерын хяналтын төвүүдийн үйл ажиллагаанд Кибер аюулгүй байдлын тухай, ХХМХтХ, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, теле камераар цуглуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, эрсдэлээс хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахыг ЗГ-ын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, УИХ-аас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартыг шинэчлэн боловсруулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудад тус тус даалгасан байна.”⁷⁹

Монгол Улсад теле хяналтын камерын ашиглалт, хяналттай холбоотой бие даасан хууль байхгүй, теле хяналтын камерын тоног төхөөрөмж ашиглах, хяналт тавихтай холбоотой асуудлыг ХХМХтХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Барилгын тухай, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар тус тус зохицуулсан байна. Дээрх хууль, тогтоомжийн зохицуулалтуудаас үзэхэд нь тухайн хуулиуд нь өөр өөр харилцааг зохицуулж байгаа хэдий ч дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах, ашиглахтай холбоотой асуудлыг тус бүр зохицуулсан нь хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчих, ойлгомжгүй, тодорхой бус байдлыг бий болгох, үүнийг дагаад хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл байдлыг үүсгэх эрсдэлтэй байна.

Тухайлбал, Барилгын тухай хууль нь барилгын үйл ажиллагаа эрхлэх, барилгын материал үйлдвэрлэх, барилгын ажил гүйцэтгэх, түүнд хяналт тавих, ашиглалтад оруулахтай холбогдсон харилцааг зохицуулж байх боловч ашиглалттай холбоотойгоор

⁷⁵ ХЭҮК-ын захиалгаар хийсэн “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, УБ, 2025 он, 7 дахь тал.

⁷⁶ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.2.3-т “Хуулиар зөвшөөрсөн, өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд хувь хүний тухай мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, бусдад шилжүүлэхийг хориглоно.”, 3.6.3 /Мэдээллийн нууцлал/-д “3.6.3.1.Мэдээлэл, түүний бүрдэл хэсэгт хууль бусаар хандах, халдах, задрахаас хамгаалагдсанаар нууцлал хангагдана.” гэж тус тус заасан байна.

⁷⁷ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно.” гэж заасан байна.

⁷⁸ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт 5.5-д “Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ.” гэж заасан байна.

⁷⁹ Мөн тэнд.

өмчлөгч, эзэмшигчид дүрс бичлэгийн төхөөрөмж байршуулах талаар үүрэг хүлээлгэсэн нь зохицуулж буй харилцааны хүрээнээс хэтэрсэн байна.⁸⁰

Теле хяналтын камерын нэгдсэн системд холбогдож мэдээллийг ашиглах эрхийг Нийслэлийн засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар баталсан “Улаанбаатар хотын теле хяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-аар зохицуулсан нь зөвхөн хүчин төгөлдөр хуульд заасан үндэслэлийн дагуу хүний эрхэд халдах, хязгаарлах зарчмыг зөрчсөн байна.⁸¹

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэвшилтэд техник технологи, дуу, дүрс бичлэгийн төхөөрөмж ашиглах талаар тусгасан хэдий ч тухайн арга хэрэгслийг ашиглахдаа хүний хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ашиглах, дамжуулах талаар зохицуулалт тусгаагүй тул үүнээс үүдэлтэй хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлтэй байна.⁸²

Нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрх орох, гарах хэсэгтээ дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан нь хөрш айл өрхийн гишүүд болон бусад орж, гарч буй хүнийг хууль бусаар ажиглах, тандах эрсдэл үүсэж болзошгүй байна.

Тохиолдол 3.2.

...Манай гудамжны ... тоотод оршин суудаг айл хашааны үүдэндээ камер байрлуулсан бөгөөд тэр камер нь байнга манай хашаа руу тусдаг, өөр тийшээ эргэдэггүй, шөнө камераас нь гэрэл тусаад байдаг, гэрийн эзэнд нь камераа эргүүлэх талаар хэлтэл манайх камераа эргүүлэхгүй гээд миний хэлснийг тоохгүй байгаа, үүнийг би хүний орон зайд халдаж байна гэж үзэж байна.

(ХЭҮК-д ирүүлсэн гомдлоос...)

НМИТБТХ-иар нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэлд хамаарах мэдээллийг ангилан тусгасан хэдий ч иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлийг хаалттай мэдээлэлд хамруулж, харин хүний нүүр царай, нүдний солонгон бүрхэвч, биеийн хөдөлгөөний онцлог зэрэг хүний биометрик мэдээллийг аль ангилалд орохыг нь тодорхой зохицуулаагүй.⁸³

Теле хяналтын камер буюу дүрс бичлэгийн төхөөрөмж нь хүний нүүр, царай, хөдөлгөөний онцлог зэрэг биометрик мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах боломжтой программ, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг хангаж байгаа тул мэдээллийн системд хамаарна.⁸⁴

Теле хяналтын системээр дамжин цугларсан мэдээлэлд буй хүний хувийн нууцыг агуулсан, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хамгаалах, мэдээлэл алдагдахаас сэргийлэхэд анхаарах шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагын хяналтад байгаа теле хяналтын камерын системд зөвшөөрөлгүй этгээд хандсан тохиолдолд авах хариу арга хэмжээний төлөвлөгөө байхгүй. Улаанбаатар хотод камерын дэд төвүүд бүрэн ашиглалтад орохоор хариу арга хэмжээний

⁸⁰“Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т “Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх” гэж заажээ.

⁸¹ “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төрийн байгууллага дараах тохиолдолд мэдээллийг ашиглана”, 6.2.2-т “хуульд заасан үндэслэлээр” гэж тус тус заасан байна.

⁸² “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.5-т “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахтай холбогдсон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна” гэж заажээ.

⁸³ НМИТБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна” гэж заажээ.

⁸⁴ НМИТБТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-т “мэдээллийн систем гэж мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг”, 4.1.4-т “мэдээлэл ашиглах гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг” гэж тус тус заасан байна.

талаар зохицуулалт хийхээр төлөвлөж байна. Одоогийн байдлаар нууц үг, сүлжээний хаяг гэсэн хамгаалалт ашиглаж байна. Мөн хяналтын камерын систем бүгд шилэн кабелиар холбогдсон, интернэт сүлжээнд болон интернэт холболтоор холбогдоогүй⁸⁵, Хяналтын камерын бичлэгийг ямар нэгэн байдлаар хуулбарлаж авах боломжгүй, нууц үгээр хамгаалагдсан боловч шифрлэлт байхгүй.

Аюулгүй байдлын шинэ систем нэвтрүүлэхээр Мэдээлэл, шуурхай удирдлагын төвөөс төлөвлөсөн бөгөөд Нийслэлийн Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/755 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын теле хяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ын дагуу хяналтын камер суурилуулах, ашиглах үйл ажиллагааг зохион зохион байгуулан ажиллаж байна.

Теле камерын хяналтын нэгдсэн болон дэд төвүүдийг байгуулахдаа иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эрх зүйн баталгааг хангах, хүний нөөц, засвар үйлчилгээ, арчилгаа, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх төсөв, хөрөнгийг бүрэн шийдвэрлэж, үйл ажиллагааг улсын хэмжээнд эрх зүйн зохицуулалт, хариуцлага, хяналттайгаар зохион байгуулах шаардлагатай.

Улсын хэмжээнд нийт 14,084 аж ахуйн нэгж, байгууллагын 122,150 хяналтын камер байгаагийн 11,241-ийг нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр суурилуулжээ.⁸⁶ Гэвч улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр суурилуулсан камеруудын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг тодорхойгүй байгаагаас шалтгаалан суурилуулсан хяналтын камеруудын 4,509 нь эвдрэлтэй, 1,635 нь ашиглалтаас хасах шаардлагатай, нийслэлд 5,033 камераас 2,489 нь эвдрэлтэй, 953 нь хэрэглээнээс хасах шаардлагатай, аймгуудад 6208 камераас 2020 нь эвдрэлтэй, 682 нь хэрэглээнээс хасах шаардлагатай буюу бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байна.

Хүснэгт 3.1⁸⁷

№	Аймаг	Цэг	Хөдөлгөөний	Чиглэл	LPR	Хэвийн	Гэмтсэн	Ашиглалтаас хасах	Хариуцах эзэнтэй эсэх
1	Архангай	193	44	310	2	242	114	27	Үгүй
2	Баян-Өлгий	100	33	149	8	158	32	1	Үгүй
3	Баянхонгор	130	68	192	8	204	64	40	Үгүй
4	Булган	164	72	355	3	274	156	25	Үгүй
5	Говь-Алтай	99	21	260	0	190	91	8	"Сутай их өргөө" ХХК
6	Говь сүмбэр	69	11	160	0	148	26	3	Үгүй
7	Дархан-Уул	240	109	240	8	152	205	128	Үгүй
8	Дорноговь	151	55	235	2	185	107	12	Үгүй
9	Дорнод	187	6	507	24	331	206	95	Чойбалсан хөгжил ӨНӨҮГ
10	Дундговь	27	12	51	0	42	21	11	Үгүй
11	Завхан	134	30	232	4	217	49	28	Үгүй
12	Орхон	396	114	523	12	503	146	0	Аймгийн мэдээлэл шуурхай удирдлагын төв

⁸⁵ ХЭҮК-ын захиалгаар хийсэн “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, УБ, 2025 он, 36 дахь тал.

⁸⁶ Мөн тэнд, 20 дахь тал.

⁸⁷ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025 он, 18-19 дэх тал.

13	Өвөрхангай	176	69	304	7	215	165	10	Аймгийн мэдээлэл шуурхай удирдлагын төв
14	Өмнөговь	116	36	228	13	214	63	0	Үгүй
15	Сүхбаатар	52	38	149	6	114	79	19	Үгүй
16	Сэлэнгэ	70	27	208	5	195	45	0	Үгүй
17	Төв	94	20	125	4	56	93	21	Үгүй
18	Увс	109	14	257	1	153	119	61	Үгүй
19	Ховд	60	35	166	3	83	115	115	Үгүй
20	Хөвсгөл	202	117	251	6	327	47	0	Үгүй
21	Хэнтий	278	17	319	8	262	74	0	Үгүй
Нийт		3047	948	5142	118	4188	2020	682	-

Монгол Улсад теле хяналтын камерын системийг нэвтрүүлэх, ашиглахтай холбоотой байгууллагуудын чиг үүрэг давхацсан байдалтай буюу теле хяналтын системийн аюулгүй байдал, суурилуулалт, техник үйлчилгээний үүргийг өөр өөр байгууллагууд болох нийслэл, дүүргийн ЗДТГ, мэдээллийн технологийн газар, цагдаагийн байгууллага, ЦЕГ-ын Шуурхай удирдлагын төв зэрэг байгууллагууд хэсэгчлэн хариуцдаг нь хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг цогц байдлаар хангахад хүндрэл үүсгэж байна. Үүний улмаас зарим газар камерыг засварлах, хэвийн ажиллуулахад удаашрал гарах улмаар хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх зөрчигдөх, гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилго хангагдахгүй байх эрсдэлтэй байна.⁸⁸

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон “Улаанбаатар хотын теле хяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-д тухайн орон нутгийн засаг, захиргаа камерын бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангахаар заасан боловч бодит байдалд ихэнх аймаг, сум, дүүрэгт үүнийг зохион байгуулах тусгай нэгж болон төсөв байхгүй байна.

Тохиолдол 3.3

*...Хяналтын камерын системд гэмтэл гарсан тохиолдолд засварлах, сэлбэг хэрэгсэл худалдан авахдаа ашиглалт хариуцаж буй байгууллагаас тухайн орон нутгийн захиргааны байгууллагад хүсэлт өгч, тус байгууллагаас худалдан авах ажиллагааг явуулахын тулд тендер зарлах, нийлүүлэгч байгууллагыг сонгох зэргээр хугацаа их шаарддаг тул цаг алдахгүйгээр засвар үйлчилгээг хийхэд хүндрэлтэй байдаг. Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөц байхгүй учир гэмтсэн шилэн кабель болон хяналтын камерын шуурхай хэвийн ажиллагаанд оруулж чаддаггүй.*⁸⁹

(Теле хяналтын камерын төвийн алба хаагчийн ярианаас)

Цагдаагийн байгууллагаас дээрх зохицуулалтыг байгууллага, аж ахуйн нэгжийн гадна орныг камержуулах арга хэмжээний нэг үндэслэл болгон хэрэгжүүлж хяналтын камерын хэрэглээг өргөжүүлж буй боловч бодит үр дүн буюу гэмт хэрэг, зөрчлийн тоог буураагүй, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хэт хяналт тогтоох эрсдэлтэй байна.⁹⁰

Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлсэн “Ногоон бүс” арга хэмжээний дүнд гудамж, зам талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 37 хувиар буурсан, камерын тусламжтай илрүүлэлт 41.9 хувиар өссөн гэх мэдээллийг ЦЕГ цахим хуудсанд 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр

⁸⁸ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025 он, 18 дахь тал.

⁸⁹ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025 он, 33 дахь тал.

⁹⁰ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтад “үйл ажиллагаа явуулж байгаа байршил, түүний ойр орчимд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээг авах”, 30.1.5 дахь заалтад “барилга байгууламжийн гадна орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа стандартад нийцсэн дүрс бичлэгийн техник, хэрэгслийг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох, шаардлагатай техникийн нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хэвийн ажиллагаанд байнгын хяналт тавих” гэж нийтлэг үүргийг хуульчилсан.

нийтэлсэн боловч цагдаагийн байгууллагын 2023, 2024 оны эхний 8 сарын байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээ, тайланд дүн шинжилгээ хийхэд гэмт, хэрэг зөрчлийн тоо дээрх хувь хэмжээгээр буурсан үзүүлэлт байхгүй байна. Тухайлбал, улсын хэмжээнд 2023 оны эхний 8 сарын байдлаар нийт 25392, 2024 оны эхний 8 сарын байдлаар нийт 28219 гэмт хэрэг бүртгэгдсэн нь гэмт хэргийн тоо 11.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс гудамж зам талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 2023 оны эхний 8 сарын байдлаар 4845, 2024 оны эхний 8 сарын байдлаар 5948 бүртгэгдсэн нь урьд оноос 22.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийслэлийн хэмжээнд 2024 оны эхний 8 сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Баянгол дүүрэгт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 350 нэгжээр өссөн, зөрчил 598 нэгжээр буурсан үзүүлэлттэй байгаа бол гудамж талбайд бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоо өссөн үзүүлэлттэй байна.⁹¹

Хүний царай таних зориулалт бүхий хяналтын камерыг нэгдсэн дэлгэц дээр хянадаггүй, зөвхөн цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах мэдээллийн санг холбож зөвхөн бүртгэлтэй хүмүүсээс л хайлт хийдэг гэх боловч тусгайлан зохицуулсан хууль эрх зүйн зохицуулалтгүй, хяналт, ил тод байдал хангагдаагүйгээс нөхцөлд хүний хувийн нууц, халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчих эрсдэлтэй байна.

Нийслэлд 5, Орхон аймагт 15 байршилд тус тус суурилуулсан бөгөөд эдгээр камер нь хяналтын нэгдсэн дэлгэц дээр хянадаггүй, зөвхөн эрх бүхий албан тушаалтан тусгай эрхээр нэвтэрч хяналт тавьж, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ашиглаж байгаа талаар судалгаанд дурджээ.⁹²

Эрх бүхий байгууллагаас дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийн талаарх анхааруулгад тусгах мэдээллийг тогтоогоогүй тул байршуулж буй анхааруулах тэмдгүүд өөр өөр загвартай, байршуулсан цэгүүд оновчтой биш байна.⁹³

Одоогийн байдлаар эрх бүхий байгууллагаас дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийн талаарх анхааруулгад тусгах мэдээлэлд тавигдах стандарт, шаардлага тогтоогоогүй тул суурилуулсан хяналтын камерын ойр орчимд “Тайван хот, таны оролцоо, CCTV 24 цаг, хяналттай бүс” гэсэн агуулгатай, 40х60 хэмжээ бүхий мэдээлэлтэй анхааруулгыг байршуулж байна.

Зураг 3.1



⁹¹ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025, 30 дахь тал

⁹² ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025 он, 34 дэхь тал

⁹³ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025, 38 дахь тал

Монгол Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй хяналтын камерын гарал үүсэл, техник, программ хангамжийн аюулгүй байдалд нэгдсэн үнэлгээ хийх, төрийн худалдан авалтын шалгуур үзүүлэлтүүдэд хүний хувийн нууцыг хамгаалахтай холбоотой хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ хийх зохицуулалт шаардлагатай байна.

Үндсэн хууль, олон улсын гэрээнд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг тунхагласан байдаг ч хяналтын камерын системийн зохисгүй хэрэглээ нь хүний хувийн мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх, хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна.⁹⁴ Хяналтын камерын бичлэгийг бусад мэдээлэлтэй хослуулан ашиглах нь хувь хүнийг тодорхойлох, нэр төр, алдар хүндэд халдах, хүний эрхийн зөрчил үүсгэх, мэдээлэл хяналтгүй ашиглагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол Улсад ашиглагдаж буй хяналтын камерын 90 гаруй хувь нь БНХАУ-ын Hikvision, Dahua, ZKTeco зэрэг компаниудын бүтээгдэхүүн байна.⁹⁵ Hikvision компанийн бүтээгдэхүүнүүдийн хэрэглээтэй холбоотой олон улсын хүний эрхийн шүүмжлэлүүд гарч байсан.⁹⁶ Энэ нь Монгол Улс теле хяналтын камерын системийн хүний эрхэд үзүүлэх нөлөөлөлд анхаарах шаардлагатайг харуулж байна. Hikvision теле камерыг ашиглан, царай таних замаар БНХАУ-ын Шинжаан Уйгарын өөртөө засах оронд хүнийг хууль бусаар мөрдөн мөшгөсөн хүний эрхийн зөрчил гарч байсанд олон улсын байгууллагууд шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд зарим улс орнууд төрийн худалдан авалтад Hikvision-ийн бүтээгдэхүүнийг хориглох шийдвэр гаргасан байдаг.⁹⁷

3.3.2. Цахим гавын хүний эрхийн үнэлгээ

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад ялын олон сонголттой байх зарчмыг баримталж “зорчих эрхийг хязгаарлах ял”⁹⁸ гэх шинэ төрлийн ялыг өргөн хүрээнд хэрэглэх боломжтойгоор хуульчилж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж байна. Тус ялыг Эрүүгийн хуульд нийт 206 төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар хуульчилж, ялыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангахтай холбоотойгоор Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг ялыг 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жил хугацаанд хэрэгжүүлж байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь Монгол Улсын ялын шинэчлэлд хийсэн томоохон алхам болжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 18 дахь хэсэгт заасан “улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих” гэсэн иргэний эрхэд хязгаарлалт тогтоож байгаа нь уг ялын онцлог юм. Мөн зорчих эрхийг хязгаарлах ял нь ялын уламжлалт төрлүүдээс орчин үеийн техник технологийн ололтод тулгуурлан энэ ялыг хэрэглэх боломжтой болсноороо ялгаатай юм. Зорчих эрхийг хязгаарлах ял буюу цахим хяналт нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг албадан шоронд хорихоос илүүтэй хүмүүнлэг бөгөөд хорих ялыг орлох сонголттой хувилбар болохын зэрэгцээ нийгмийн дунд хүмүүжих боломжийг олгодгоороо⁹⁹ үр нөлөөтэй хувилбар гэж үздэг байна.

Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шууд оногдуулах, хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих гэх зэрэг хэлбэрээр оногдуулж иржээ. Тухайлбал, УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлан, мөн оны 7 дугаар

⁹⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.” гэж заасан байна.

⁹⁵ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025 он, 20 дахь тал.

⁹⁶ ХЭҮК, “Ди Эс майнд инвестмент консалтинг” ХХК, “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт суурилуулсан хяналтын камерын хэрэглээ, ашиглалт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн хүний эрхийн эрсдэлийн үнэлгээ, 2025, 22 дахь тал.

⁹⁷ Мөн тэнд, 21-22 дахь тал.

⁹⁸ ШУА. “Монгол хэлний их тайлбар толь”, УБ, 2019 он. “зорчих” гэдэг нь хүн нэг зүгийг чиглэн зорчих, ийш тийш зорчин явах, “эрхийг хязгаарлах” гэдэг нь эрхийг нь багасгах, хэмжээ тогтоох” гэж тайлбарлажээ.

⁹⁹ Кейт Вайсбурд нар, “Цахим шорон: Эрүүгийн эрх зүйн мөрдөн шалгах ажиллагаа дахь хөлийн цахим гав ашиглах нь” Жорж Вашингтоны их сургуулийн Хууль зүйн сургууль (2021 он), 4 дүгээр хуудас.

сарын 6-ны өдрөөс эхлэн даган мөрдсөн Өршөөл үзүүлэх тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольжээ.

Цахим хяналтын төхөөрөмжийг амжилттай хэрэгжүүлж буй АНУ-ын хувьд 20 жил судалгаа эрдэм шинжилгээний ажлын хүрээнд байсан ялын хэрэглээ 1980-аад оноос шүүхийн практикт нэвтэрсэн бөгөөд төхөөрөмжийн түрээс, ашиглалт, ажиллагааг хувийн секторт шилжүүлжээ.¹⁰⁰

Монгол Улсын хувьд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавих чиг үүргийг хүлээж байгаа бөгөөд төхөөрөмжийн ашиглалт, шинэчлэлт, хяналт, ажиллагааны бүрэн байдлыг ханган ажиллаж байна. Монгол Улсад энэ төрлийн ялыг хэрэглэж эхлээд удаагүй байгаа нь ололт, алдаа дутагдал зэрэг ялын үр нөлөөг бүрэн үнэлэх мэдээллийн сан, хэрэглээний практик хангалттай тогтоогүйг дурдах нь зүйтэй юм.

Зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжиж эхэлснээр хорих ялын хэрэглээ 10 гаруй хувиар буурсан, хорих ял эдлүүлэх ажиллагааны зардал багасаж, улсын төсөвт хэмнэлт бий болсноор эдийн засагт чухал ач холбогдолтой байна.¹⁰¹

Зорчих эрхийг хязгаарлах ял нь хорих ялын нэг өдрийн зардлыг 11 хүртэл хувиар бууруулдаг тухай олон улсын судалгаанд дурджээ.¹⁰²

Харин манай улсын хувьд, зөвхөн ажилтан, албан хаагчдын цалингаас гарч буй хэмнэлт нь сард 2 тэрбум орчим төгрөг болдог талаар ХЭҮК-ын захиалгаар хийгдсэн “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны багт мэдээлсэн байна. Үүний зэрэгцээ хорих ял эдэлж буй хүний хоол хүнс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хувцас, ахуйн хэрэглээний зардал болоод хорих ангийн дэд бүтцийн зардлыг нийтэд нь тооцвол өндөр дүн бүхий зардал хэмнэгдсэн байхаар харагдаж байна. Тухайлбал, улсын хэмжээнд хорих ял эдэлж буй хоригдол, хоригдолд хяналт тавих урсгал зардал 1 жилд дунджаар 36 тэрбум төгрөг байгаа бол зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд биечилсэн болон техникийн хяналт тавих урсгал зардал 1 жилд дунджаар 900 орчим сая төгрөг байхаар тооцоологдсон.¹⁰³

Тохиолдол 3.4

*...Ял эдлүүлэх ажиллагааны зардлын хувьд хорих ялтай харьцуулахад 10-15 хувиар, бусад урсгал зардал 25-30 дахин бага зардлаар хэрэгжүүлэх тооцоо гарсан. Энэ нь улс орны эдийн засгийн хүндрэлтэй байгаа өнөөгийн цаг үед төсвийн хэмнэлтийг бий болгоход маш чухал үүрэгтэй юм.*¹⁰⁴

(ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Ц.Очгэрэлийн ярилцлагаас)

¹⁰⁰ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 3 дахь тал.

¹⁰¹ Мөн тэнд, 9 дэх тал. “Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эхэлсэн 2021 оноос 2024 оны эхний хагас хүртэлх Шүүн таслан ажиллагааны тайлан мэдээнээс анхан шатны шүүхээс нийт 47271 хүнд ял шийтгэл оногдуулснаас 5513 хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулжээ. Энэ нь шүүхээс оногдуулж буй ялын 11.6 хувийг зорчих эрхийг хязгаарлах ял эзэлж байгаа бол хорих ял 19.6 хувь, торгох ял 57.2 хувь, нийтэд тустай ажил хийлгэх ял 11.2 хувь, бусад нь албадлагын арга хэмжээ хэрэглэсэн байна. Мөн энэ хугацаан дахь нийт гэм буруутайд тооцож буй хүнд оногдуулж буй хорих ялын эзлэх хувь 27 хувь байснаас 17.6 хувь хүртэл буурсан сайн үзүүлэлтэй байна.” гэж дүгнэжээ.

¹⁰² ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 5 дахь тал, “Цахим хяналтын төхөөрөмж ашиглах нь хорих ялын өдрийн 70-80 ам.долларын зардлыг 4-9 ам.долларын зардал болтол бууруулдаг.” гэжээ.

¹⁰³ ШШГЕГ-ын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 05/2040 дугаар албан бичиг.

¹⁰⁴ Эшлэл 8-ыг үзнэ үү.

Зорчих эрхийг хязгаарлах ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр, хамт олон, гэр бүлийнхээ орчинд суралцах, хөдөлмөрлөх эрхийг нь хангаж буйгаараа ач холбогдолтой байх бөгөөд энэхүү ажиллагаанд хянах, нийгэмшүүлэх ажлыг зөв хослуулж зохион байгуулснаар гэмт хэрэг дахин үйлдэх явдлыг бууруулахад нөлөөлөх боломжтой.

Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эхэлснээс хойш энэ төрлийн ялын хэрэгжилтийн талаарх тоон мэдээлэл эрх бүхий байгууллагууд дээр илт зөрүүтэй байна.¹⁰⁵ Шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад очихоос санаатайгаар зайлсхийх, оргон зугтаах зэрэг асуудлаас шалтгаалж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлэхгүй байх тохиолдол үүсэж, ШШГТХ-ийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан заалт хэрэгждэггүй байсантай холбоотойгоор шүүхээс ял шийтгэсэн болон шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэгдсэн ялтны тоон мэдээлэл зөрөх нэг нөхцөл болсон байж болзошгүй юм.¹⁰⁶ Хуулийн шинэчилсэн зохицуулалтыг нэр мөр хэрэгжүүлж, дээрх тоон мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай.

Цахим төхөөрөмжийн хэрэглээний доголдол нь зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих шийдвэр гаргах нөхцөл болсон байж болзошгүй байна.

ШШГТХ-д Зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд хяналт тавих, ял эдэлсэн хугацааг хэрхэн тооцох зохицуулалтыг тусгасан.¹⁰⁷ Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон шийдвэрийн эрх зүйн үндэслэлээс харахад нийт шийдвэрийн 68,5 хувь нь техникийн, эсхүл биечилсэн хяналтаас санаатайгаар зайлсхийсэн тохиолдол байна.¹⁰⁸

Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа цахим хяналтын нэгдсэн систем, түүний бүрэлдэхүүн, дэд бүтцэд зориулсан хүний эрх зөрчигдөхгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, ял эдлүүлэх ажиллагаа нь залхаан цээрлүүлэлт биш дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх, ялтныг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх ялын харьцангуй онолын үзэл баримтлалд нийцсэн байх шаардлагыг нарийвчлан боловсруулж, стандартчилах нь цаашид системийн хөгжүүлэлтэд чухал ач холбогдолтой болно.

Монгол Улс энэхүү ялыг хэрэгжүүлэх цахим хяналтын системийг хувьд шүүхийн практик, ял эдлүүлэх ажиллагаанд анх удаа авч хэрэгжүүлж буй шинэ зохицуулалт, практик бий болгож байхын зэрэгцээ хяналтын системийг боловсруулж, хөгжүүлэлт хийж төхөөрөмжүүдийг хэд хэдэн удаагийн худалдан авалтаар БНХАУ-д үйлдвэрлэсэн

¹⁰⁵ ШШГЕГ-ын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 05/2040 дугаар албан бичигт “2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 6136 ялтанд хяналт тавин ажилласан. Үүнээс шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлж хяналтад авсан 4971 ялтан, Өршөөл үзүүлэх тухай хуулиар хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаас сольсон 1165 ялтан, ялыг биеэр эдэлж дууссан 4960, тухайн өдрийн байдлаар 1176 (нийслэлд 608, орон нутагт 568) ялтанд хяналт тавин ажиллаж байна. Мөн хуульд зааснаар зорчих эрхийг хорих ялаар сольсон ялтны тоо 2021 онд 170, 2022 онд 496, 2023 онд 308, 2024 оны 7 сарын байдлаар 182, нийт ял солиулсан 1156 ялтан байна.” гэжээ. Харин УЕПГ-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 6/6232 дугаар албан бичигт “Зорчих эрх хязгаарлах ялаар 2021 онд 1690 хүн, 2022 онд 3079 хүн, 2023 онд 2934 хүн, 2024 оны эхний 7 сарын байдлаар 2068, нийт 9771 хүн ял шийтгүүлсэн. Үүнээс зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольж эдлүүлсэн ялтны тоог 2021 онд 182, 2022 онд 429, 2023 онд 291, 2024 оны 7 сарын байдлаар 168 нийт зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон 1070 байна.” гэжээ.

¹⁰⁶ ШШГТХ-ийн 153 дугаар зүйлийн 153.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн хүлээн авна. (хүчингүй болсон.) Тус хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан. 153.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хамт хүлээж авна. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй.

¹⁰⁷ ШШГТХ-ийн 167 дугаар зүйлийн 167.1-д “Шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны байнга оршин суугаа болон хөдөлмөр эрхэлж байгаа, эсхүл суралцаж байгаа газрын хаягаар шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг биелүүлж байгаа эсэхэд техникийн болон биечлэн хяналт тавина.”, 167.2-т “Зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болж, ялтанд цахим бугуйвч зүүлгэсэн өдрөөс эхлэн тоолно.” гэж тус тус заажээ.

¹⁰⁸ УЕПГ-ын 2024.08.18-ны өдрийн 6/6232 дугаар албан бичиг. “Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон нийт 1070 ялтан байгаагийн 733 буюу нийт тохиолдлын 68,5 хувь нь техникийн, эсхүл биечилсэн хяналтаас санаатайгаар зайлсхийсэн байна.” гэж дурджээ.

төхөөрөмжүүдийг хяналтын системтэй холбон үүрэн телефоны операторын сүлжээг ашиглан хэрэгжүүлж байгаа ажээ. Харин АНУ энэ ялыг практикт нэвтрүүлснээс хойш даруй 40 орчим жил болж байгаа ч цахим хяналтыг хэрэгжүүлэх систем, программ хангамж, төхөөрөмжид тавигдах нийтлэг стандарт байхгүй байгаа нь хүний эрхийн зөрчил бий болгож болзошгүй гэж үзэж 2016 онд систем, түүний бүрэлдэхүүн хэсэгт зориулсан стандартыг баталсан байна.¹⁰⁹

Дэлхийн нийтийн технологийн ололт, туршлагаас харвал хүний биеэс зориулалтын түлхүүрийн тусламжгүйгээр салгах, тайлах боломжгүйгээр хэрэглэж болох хамгийн тохиромжтой төхөөрөмжүүд нь гарын бугуйнд болон хөлийн шилбэ, шагайнд оосор байдлаар бүслэн зүүх зориулалт бүхий төхөөрөмжүүд байдаг байна.

Харин манай улсын хувьд БНХАУ-д үйлдвэрлэсэн GPS төхөөрөмжүүдийг ашиглан цахим хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь дэлхийн тойрог замд байгаа хиймэл дагуулуудаас байршлын мэдээг хүлээн авч өөрийн байршлыг операторын сигналын тусламжтайгаар төв серверт мэдэгдэх зарчмаар ажилладаг ялтныг биеэс салгаж, унтрааж болохгүй зэрэг онцгой нөхцөлүүдтэй. Эрс тэс уур амьсгалтай газар нутагтай манай улсын хувьд тухайн ашиглагдаж буй газар нутгийн цаг уур, орчны нөхцөл байдалд нөлөөлөлд найдвартай хэвийн ажиллах ажиллагааг хангах нь чухал юм.

Мөн GPS төхөөрөмж нь RF төхөөрөмжөөс давуу тал нь ял эдэлж буй этгээдийн жишээлбэл гэрт нь байрлуулсан үндсэн төхөөрөмжөөс тохируулагдсан зайд холдох боломжгүй байх хязгаарлагдмал боломжийг арилгаж зорчих бүсчлэлийг илүү өргөн хүрээтэй тогтоох, тогтсон зам маршрутын дагуу зорчих зохицуулалт хийх зэргээр ял эдлүүлэх ажиллагааг үр дүнтэй байх үүднээс ач холбогдолтой юм. Гэсэн хэдий ч тус төхөөрөмжийг гарын бугуй, хөлийн шилбэнд авах боломжгүйгээр бэхэлж байгаа нь материалын хувьд хүний биед наад зах нь харшил зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлдэг байна.

Түүнчлэн бугуйнд ашиглахад богино ханцуйтай хувцас өмссөн тохиолдолд ил харагдах тухайн хүнийг ялтан, гэмт хэрэгтэн гэдгийг илт харагдуулах, ялгаварлан гадуурхалтад өртөх магадлал өндөр байх боломжтой талаар судалгаанд дурджээ. Харин Шилбэ, шагайнд зүүж хэрэглэдэг төхөөрөмж нь бугуйны төхөөрөмжтэй харьцуулахад тэр бүр ил харагдаад байхгүй, арай илүү жин, хэмжээтэй байх тул үүнийг дагаад тэжээлийн багтаамж сайжрах боломжтой ч хүмүүс түрийтэй, өвлийн гутал өмсөх шаардлага бий болоход шагайнд зүүж буй төхөөрөмж нь гутлын түрийнд багтахгүй байх зэрэг асуудал үүсдэг байна. Тиймээс энгийн ухаалаг цагнаас төдийлөн ялгаагүй загварын, эсхүл хөлийн шилбэнд оосорлож зүүдэг төхөөрөмжүүдийг сонгон авах нь энэ төрлийн эрсдэл бий болохоос сэргийлэх давуу талтай.

Насанд хүрсэн хүн хоногт 8 цаг унтахыг эмч, мэргэжилтнүүд зөвлөдөг. Гэтэл төхөөрөмж нь 4-6 цаг цэнэгээ барьдаг давтамжтай байх нь тухайн хүн шөнө сэрж төхөөрөмжөө цэнэглэх, эсхүл төхөөрөмжийг цэнэглэж хонуулах зэрэг асуудал тулгарахаас гадна цахилгааны хязгаарлалт, суралцах, хөдөлмөр эрхлэх зэрэгт төхөөрөмжийг тогтмол богино хугацаанд цэнэглэх нь эргээд ял эдэлж буй ялтны хувьд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.¹¹⁰ Иймд төхөөрөмжийг цэнэглэх хугацаа нь богино буюу түргэн цэнэглэх горимтой, цэнэгээ удаан барьдаг байх нь чухал байна.

Үүний зэрэгцээ ялтны хувьд усанд орох, ариун цэвэр хангах, гар, нүүрээ угаах зэрэг хүний наад захын зайлшгүй хэрэгцээ, орчны нөхцөл байдал, ус чийг ихтэй ажлын байрны орчин, байгаль цаг уурын нөхцөлд хэвийн ажиллах боломжоор хангагдсан ус, чийг, тоосны хамгаалалттай байх нөхцөл тавигдаж байна.

Үүрэн холбооны оператор компаниудын хувьд хүн ам төвлөрсөн газрууд болон тэдгээрийн хооронд холбогдсон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим ихтэй зам дагуу

¹⁰⁹ Хууль сахиулах байгууллагын стандартын үндэсний хүрээлэн, Гэмт хэрэгтний хяналтын систем, NIJ стандарт-1004.00, 2016 оны 7 дугаар сар.

¹¹⁰ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 82 дахь тал.

үүрэн холбооны сүлжээг бий болгож ажилладаг. Монгол Улсын хэмжээнд нийт газар нутгийн хувьд суурьшлын бүсүүдээс бусад газар хүн ам сийрэг суурьшсан тул үүрэн холбооны сүлжээний тархац (coverage)-ын талбайн хэмжээ нь нийт газар нутгийн талбайн хэмжээтэй харьцуулахад бага хэмжээтэй байдаг. Дээрх хүчин зүйлүүдээс авч үзэхэд зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх системд ашиглаж байгаа GPS хяналтын төхөөрөмжийн сервер системд холбогдох боломж нь үүрэн холбооны сүлжээний одоогийн болон ирээдүйн боломж нөхцөлөөс хамаарна.

Түүнчлэн цахим хяналтын систем, түүний бүрэлдэхүүн нь хувь хүний нууцад хамаарах мэдээлэл дамжуулж, хадгалдаг технологи тул найдвартай, тасалдалгүй ажиллагаатай, хариу үйлдэл хийх хурдтай байх зэрэг үзүүлэлтүүдийг хангасан, нууцлал, хандалт, эрхийн түвшний зохицуулалт хамгаалалтын технологийн аргачлалуудыг багтаасан стандартыг батлан хэрэгжүүлэх шаардлагатай.

Гар утас, үүрэн телефон, хөдөлгөөнт интернэтийн сүлжээний тархац нь зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэх үндэслэл болохгүй гэж үзлээ.

Манай улсад дэд бүтцийн хөгжил, хүн амын тархац, хэрэглэгчийн тоо зэргээс хамаарч үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч компаниуд сүлжээний тархцаа нэмж, интернэтийн хурд, хэрэглээний боломжууд хэрхэн нэмэгдэж байгаа нь амьдралд харагдаж, нийтээр хэрэглэж байна. Энэ нь зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналтын төхөөрөмж хэрэглэхэд төв суурийн газрын хувьд хэрэгжүүлэх бүрэн боломжтой байгааг харуулж байна.

Мөн аль ч улс оронд интернэт, үүрэн телефоны сүлжээгүй бүс байдаг болохыг дурдах нь зүйтэй. Дохио дамжуулалтын хувьд манай улсад ашиглаж буй төхөөрөмжүүдэд тулгамдсан асуудал нь харьцангуй бага, зарим тохиолдолд хиймэл дагуулын зураглал зэргээс хамаарч байршил үсэрч өөр хэсэгт заах тохиолдол байдаг хэдий ч албаны байгууллагын өгсөн мэдээллээр ийм тохиолдолд зөрчилд тооцож хорих ялаар сольсон тохиолдол байхгүй талаар мэдэгдсэн юм.¹¹¹ Харин үсрэлт бий болж болзошгүй бүсчлэл нь саадгүй орчинд 10 метр, саадтай орчинд 30 метр радиусаар тогтоогдох боломжит хугарлыг тооцоолдог бол манай улсад 50-200 метр хүрээнд энэ хугарлыг тооцоолж алдаа гарахаас сэргийлж байгаа нь бас хэт өргөн хүрээтэй байгааг анхаарах шаардлагатай.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг зөвхөн нэг үүрэн телефоны операторын сүлжээг ашиглах хэлбэрээр зохион байгуулах нь учир дутагдалтай тул өөр бусад боломжуудыг эрэлхийлэх нь зүйтэй.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэж буй бугуй, шилбэ, шагайны цахим гав зөвхөн Юнител ХХК-ийн сүлжээнд ажилладаг байгаа нь энэ ялаар шийтгүүлсэн бусад үүрэн холбооны сүлжээний хэрэглэгчдэд бэрхшээл үүсгэж байна.¹¹² Энэ нь манай улсад үйл ажиллагаа явуулж буй үүрэн телефон, хөдөлгөөнт интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын сүлжээний тархац нь нэг нь нөгөөгөө нөхөх байдлаар авагдсан тохиолдолд найдвартай дохио дамжуулах болоод дохио дамжуулах боломжтой бидний хэлж заншсанаар сүлжээтэй бүс нутгийн хэмжээ нэмэгдэх, илүү өндөр хурдтай интернэтийг ашиглан дохио дамжуулах зэрэг өргөн боломжууд нээгдэнэ гэж үзэж байгааг дүгнэн тэмдэглэх нь зүйтэй.

Иймд цахим гав бусад үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч компаниудын сүлжээнд ажиллах боломжийг нээлттэй болгох шаардлагатай. Ингэснээр сүлжээний тархац нь нэг үүрэн холбооны сүлжээнээс нөгөө сүлжээг нөхөх байдлаар өргөжиж байгаа учраас, цахим гав нь бүх үүрэн сүлжээнд ашиглагдаж, харилцан хамааралтай байх нь хамаарсан бүс нутагт ашиглагдах боломжийг нэмэгдүүлнэ. Энэ нь хэрэглэгчдэд илүү олон боломж, сонголт олгох бөгөөд хязгаарлалтыг өргөжүүлж, цахим гавыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

¹¹¹ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 80 дахь тал.

¹¹² Мөнх тэнд, 27-29 дэх тал.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хэрэглэж буй цахим төхөөрөмж хэрэглээний нөхцөл шаардлагыг хангахгүйгээс хүний эрхийг зөрчих нөхцөл болж болзошгүй байна. Одоогийн ашиглаж байгаа GPS хяналтын төхөөрөмжүүдийн хувьд тэжээл, тэжээлийн цэнэгтэй холбоотой асуудал их үүсдэг талаар ял эдэлж буй хүмүүс болоод албаны хүмүүс ч их дурдаж байна. Энэ нь нэг талаасаа тухайн хүний хариуцлагатай холбон авч үзэх боловч мөн техникийн талаас стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд дүгнэлт хийх нь зүйтэй.

Шүүхийн практик, ял эдлүүлэх ажиллагаанд ашиглаж байгаа GPS хяналтын төхөөрөмжүүдийг дэлхийн бусад улс оронд хэрэглэж буй төхөөрөмжтэй тэжээлийн үзүүлэлтүүдийг харьцуулсан байдлаар судлахад манай улсад одоогийн ашиглаж байгаа GPS хяналтын төхөөрөмжийн тэжээлийн цэнэгээ барих хугацаа нь бусад ижил зориулалт бүхий төхөөрөмжүүдээс бага байна.¹¹³ Төхөөрөмжийг биеэс салгалгүйгээр цэнэглэх нь хялбар биш, хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй тул энэ нөхцөлийг сайжруулах, цэнэг барих хугацаа нь илүү сайн төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Комиссын захиалгаар хийсэн “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны хүрээнд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Архангай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Увс, Өмнөговь, Говьсүмбэр аймагт зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байгаа 10 ялтанг тохиолдлын байдлаар сонгон биечлэн болон харилцаа холбооны хэрэгслээр дамжуулж хорих ял эдлэх хугацаа, бүсчлэл, хүйс, хөдөлмөр эрхлэлт, цахим бугуйвчны хэрэглээний талаар тодруулсан.¹¹⁴ Судалгаанаас цахим төхөөрөмжийн хэрэглээтэй холбоотой тулгарч буй бэрхшээлүүдийн талаар цөөнгүй асуудал хөндөгдөж байв.¹¹⁵

Зорчих эрхийг хязгаарлах ялыг амжилттай хэрэглэж буй орнууд нь ял эдэлж буй ялтнуудын сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд ихээхэн анхаарал хандуулдаг нь хүний сэтгэл зүйд байнгын хяналтад байх мэдрэмж нь сөрөг сэтгэл хөдлөл, стресс, депрессийн түвшнийг нэмэгдүүлдэг болохыг судалгаа харуулжээ.¹¹⁶ Иймд төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүдийг сайжруулахад анхаарахын зэрэгцээ түүнээс үүдэлтэй санаа зовнил, сэтгэлийн түгшүүрээс сэтгэл гутрал, дарамт, стресс үүсэх эрсдэлийг тооцоолж үзэх шаардлагатай.

Шүүхийн практикт ихэвчлэн оршин суух хороо, дүүргээс гарч явахыг хориглох байдлаар ялын нөхцөлийг тодорхойлон зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж байгаа үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхэд нэлээдгүй хязгаарлалт бий болж байна.

Европын орнуудад цахим хяналтыг хэрэгжүүлж буй нөхцөл байдлыг сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, хүний эрхийн олон улсын баримт бичгүүд, түүний дотор Европын хүний эрхийн конвенцын хүрээнд судлан авч үзсэн байна. Манай улсад энэ чиглэлээр хийсэн

¹¹³ Мөн тэнд, 79 дэх тал.

¹¹⁴ “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгаанд оролцогчдыг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 2, эрэгтэй 8, ял эдлэх хугацаагаар авч үзвэл хамгийн бага нь 6 сартай, хамгийн их нь 4 жил 2 сар (2021 оны Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар хорих ялыг сольсон), бүсчлэлээр нь авч үзвэл аймгийн төвөөс гарахыг хориглосон 4 тохиолдол, сумаас гарахыг хориглосон 4 тохиолдол, дүүргээс гарахыг хориглосон 2 тохиолдол байна. Өөрийн хүсэлтээр бүсчлэлээ өөрчлүүлсэн 3 тохиолдол байна.

¹¹⁵ “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгаанд оролцогчид “...цахим бугуйвч цэнэгээ 8-10 цаг хадгалдаг, өвлийн улиралд гадаа ажил хийдэг 1 хүний хувьд цэнэг хурдан дуусаж, ойр ойрхон цэнэглэх шаардлага үүсдэг, хөлийн цахим бугуйвч хүйтний улиралд түрүүтэй гутал өмсөхөд хүндрэл үүсдэг, биеэсээ салгахыг хориглодог тул түүнийг цэнэглэх процесс нь хүндрэл учруулдаг, бүрэн цэнэглэгдэх хүртэл барьж суудаг, бугуйвч цэнэглэхэд халаад гар түлчих гээд байсан тул солиулсан, батарей нь нурсан учир солиулсан... Ярилцлага хийх үед төхөөрөмжийн төмөр хийц нь төмрийн харшил үзүүлсний улмаас хэрэглэх боломжгүй болж бугуйвчийг солиулсан, усанд норгосноос болж гэмтсэн, усанд норгохгүй байх зорилгоор хүнсний гялгар цаасаар ороож усанд ордог, бугуйвчны сүлжээ унадаг тохиолдол гардаг ба гар утасны сүлжээ хэвийн байхад цахим бугуйвчны сүлжээ унах тохиолдол гардаг, шүүхээс зорчихыг хязгаарласан бүсийг өргөн хүрээгээр тухайлбал аймгийн нутаг дэвсгэрээр тогтоосон байхад тухайн аймгийн сумдын нутгаар явах гэхэд сүлжээтэй газар бай гэсэн шаардлага тавьдаг, сүлжээгүй газраар явах тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчид энэ талаар мэдэгддэг” талаар ярьсан.

¹¹⁶ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 82 дахь тал.

судалгаа, ялтны сэтгэл зүйн байдлыг судалсан судалгаа байхгүйгээс гадна эрүүл мэндийн талаарх хууль, тогтоомжуудад холбогдох зохицуулалт байхгүй байгаа юм.

Тохиолдол 3.5

...Зорчих эрхийг хязгаарлаж бүсчлэл тогтоосон Хөтөл сум нь Орхон аймгийн нутаг дэвсгэртэй хиллэдэг, манай эмнэлэг Орхон аймгийн бүс нутагт байрладаг, бага насны хүүхдүүдтэй эмнэлэг орох шаардлага гарвал яахаа мэдэхгүй байгаа...

...Зорчих эрхийг хязгаарлах ял биелүүлж зорчих бүсээ хязгаарлуулсантай холбоотойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад тухайлбал MRI шинжилгээ өгөх гэхэд бугуйвчтай учраас өгч болохгүй, энэ талаар шийдвэр гүйцэтгэгч, прокурорын зөвшөөрлөөр түр салгах боломжтой, мөн хязгаарлуулсан бүсээс өөр газраас эмнэлгийн тусламж авах шаардлага үүсэхэд хүндрэл үүсдэг...

(Судалгаанд хамрагдсан ялтантай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацаанд хөдөлмөр эрхлэх нь нийгэм, хөдөлмөрийн хамт олны дунд засан хүмүүжих боломж олгох, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх тухайд ялын зорилгыг биелүүлэхэд ач холбогдолтой мөн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд төхөөрөмжийн ашиглалтын зардлыг ялтан өөрөө төлөх үүрэг хүлээдэг тул ажил хөдөлмөр эрхлэх, цалин орлоготой байх нь уг ялыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой боловч хөдөлмөр эрхлэх нөхцөл байдал хязгаартай байж болзошгүй байна. Гэхдээ судалгаанд 10 ялтны тохиолдлын аргаар сонгож хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлахад нэгээс бусад нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн сайн үзүүлэлттэй байсныг дурдах нь зүйтэй.

Мөрдөн шалгах ажиллагааны үед гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг тогтоох ажиллагаа түүний дотор оршин суух газар болон хөдөлмөр эрхлэлтийн талаар хангалттай мэдээлэл, баримтууд авагдаагүйн улмаас шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа хөдөлмөр эрхлэх боломжийн талаар тодорхойгүй нөхцөлд шийдвэр гаргадаг.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүхээс тогтоосон чиглэлээр зорчин явахаар хязгаарлалт тогтоох боломжтой атал ийнхүү тогтоон шийдвэрлэх тохиолдол маш бага байна.¹¹⁷ Үүний улмаас оршин суух баг, сум, аймаг, дүүргээсээ гарч явахыг хориглосон тохиолдолд өөр газарт байрлах ажлын байр луугаа зорчин очиж хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагддаг байна. Мөн ажлын байр, байршил тогтмол бус тухайлбал барилга дээр ажиллаж буй тохиолдол байршил тогтмол өөрчлөгдөх нөхцөл байдлууд үүсдэг ажээ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах оногдуулах нь тухайн хүүхдийн сурч боловсрох эрхийг хөндөхгүй байхад ач холбогдолтой бөгөөд өсвөр насны хүнийг энэ төрлийн ялаар шийтгэсэн тоо жил бүр нэмэгдэж байна.¹¹⁸

Энэ төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чухал зорилт нь өмнө дурдсанчлан ялтныг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөв дадал зан үйл төлөвшүүлэхэд эерэг нөлөөтэй. Гэсэн хэдий ч ял эдлэх хугацаанд сурч боловсрох эрхийн хэрэгжилт хязгаарлагдмал байгаа бөгөөд үүнд төхөөрөмжийн цэнэг барих хугацаа, цэнэглэх боломж нөхцөл нь хэвийн суралцах нөхцөлийг хангахад бэрхшээлтэй, сургуулийн орчинд зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн хүүхдийг ялгаварлан гадуурхах зэрэг сөрөг асуудлууд байсаар байна. Иймд энэ төрлийн ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүний мэргэжлийн боловсрол эзэмших, их, дээд сургууль, коллежид суралцах, мэргэжил дээшлүүлэх зэргээр суралцах боломжийг олгоход анхаарч зорчих эрхийг хязгаарлах ял

¹¹⁷ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.”

¹¹⁸ ШЕЗ-ийн 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн №03/1456 албан бичиг. “2021 онд 21, 2022 онд 44, 2023 онд 77 өсвөр насны хүүхдэд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан.” гэжээ.

эдлүүлэх нөхцөлийг шүүхээс тодорхойлон тогтоох, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад энэхүү эрхийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах шаардлагатай.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх хугацаанд хувь хүний нууцыг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн эсэх нь эргэлзээтэй байна.

Цахим хяналтын хувьд хүний хувийн мэдээлэлд халдах эрсдэл үргэлжид байдаг нь үүнийг шүүмжлэх нэг өнцөг болжээ. Тухайлбал GPS төхөөрөмж нь тухайн хүний байршлын талаарх мэдээллийг тогтмол илгээж байдаг нь тухайн цаг мөчид хяналтад буй хүний байршлын талаарх мэдээлэл олж авахын зэрэгцээ тодорхой хугацаанд үргэлжилсэн GPS байршил тогтоох хяналтын тусламжтайгаар тухайн хүний амьдралын хэв маяг, түүхийг бүтээх боломжтойгоос гадна мөн хувийн, эмзэг, нэр төр, алдар хүндэд харш мэдээллүүдийг ч олж авах зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгох боломжтой. Тухайлбал, хяналтын төхөөрөмж нь дуу авиа болон согтуурал шалгах мэдрэгчтэйгээр бүтээгдэх болсон нь энэхүү асуудалд илүү ул суурьтайгаар хандах шаардлагатай болохыг харуулж байна.

Мөрдөн байцаалтын шатанд яллагдагчийн хувийн байдлыг сайтар тогтоох, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотойгоор зорчих чиглэл нэмж тогтоолгох хүсэлт гаргах боломж олгох талаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээдийн хувьд үр хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Энэ тохиолдолд үр хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, эмнэлэгт үзүүлэх, эмчилгээ хийлгэх зэрэг амьдралын наад захын хэрэгцээ үүсдэг. Мөн үр хүүхэд, гэр бүлийн гишүүд нь эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувьд зайлшгүй эмнэлэгт хамт очих, сахиураар хамт байх шаардлага үүснэ.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтны шашин шүтэх, эс шүтэх эрх, эвлэлдэн нэгдэх болон улс төрийн бусад эрхийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

АНУ зэрэг христийн шашинтай орнуудын хувьд 7 хоног бүрийн тогтмол өдөр шашны цуглаанд очих амьдралын хэв маяг бий. Энэхүү амьдралын хэв маягийг ял эдлүүлэх ажиллагаанд тусгаж боломжоор нь хангадаг байна. Хүний шашин шүтэх, эс шүтэх эрх нь ямар ч тохиолдолд хязгаарлаж үл болох туйлын эрх болохын хувьд ял эдэлж буй ялтны хувьд энэхүү эрхээ эдлэх боломжоор хангах нь чухал. Шашин нь нэг талаас итгэл үнэмшилтэй байх эрхийн хэлбэр бол нөгөө талаас бас хүнийг зөв дадал зан үйлд сургах ач холбогдолтойг бас ял эдлүүлэх ажиллагаанд анхаарч үзэн боломжит байдлаар эрхийг нь эдлүүлэх нь зүйтэй.

Манай улсад хуулиар гагцхүү хорих ял эдэлж буй ялтны улс төрийн буюу сонгох, сонгогдох эрхийг хязгаарладаг. Иймээс зорчих эрхийг хязгаарах ял шийтгүүлсэн ялтны хувьд түүний сонгох эрх наад зах нь хэрэгжих учиртай. Гэтэл гэрээсээ гарч болохгүй гэх хязгаарлалт тогтоосон тохиолдолд энэхүү эрхийн хэрэгжилт хязгаарлагдах учир мөн энэ талаар анхаарах шаардлагатай.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг урамшуулах эрх зүйн зохицуулалт байгаа нь сайшаалтай байна.¹¹⁹ Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хоригдлын ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн дүрэм болон зөвлөлийн ажиллах журамд зааснаар “арга зүйн зөвлөл” сар бүрийн эхний 7 хоногт багтаан зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр зааж, ялтанд зөрчил гаргаагүй байх шаардлага тавигдаж байна.

¹¹⁹ ШШГТХ-ийн 175 дугаар зүйлийн 175.1-д “Ялтан ял эдлүүлэх журмыг зөрчөөгүй, өөрийн зан үйл, хувийн байдлаараа ял эдлүүлэх ажиллагаанд саад учруулаагүй бол түүнд 1 сард 5 хүртэл хоногийн шагналын хоног олгож болно”, 175.2-т “Шагналын хоногийг энэ хуулийн 224 дүгээр зүйлд заасан журмын дагуу олгоно” гэж тус тус заасан.

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд төлбөрийн нөхцөл хүндрэл үүсгэж, зөрчил болдоггүй байна. Судалгаанд хамрагдсан ял эдэлж буй хүмүүс цахим бугуйвчны төлбөрийн талаар асуудал дурдаагүй, тэдний хувьд өдөрт 1500 орчим төгрөгийн төлбөр төлж байгаа нь санхүүгийн хүндрэл үүсгэхгүй гэж үзжээ.¹²⁰

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд техникийн хяналт тавихдаа гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглаж байгаа бөгөөд төлбөрийн асуудлыг холбогдох журамд заасан байна.¹²¹ Түүнчлэн, уг журамд зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд гар болон хөлийн 4 төрлийн цахим бугуйвчийг ашиглаж байна. Эдгээр нь үнийн болон баталгаат хугацаагаараа ялгаатай байхыг тогтоосон талаар эрх бүхий байгууллагаас мэдээлжээ.¹²²

Дээрх журамд шийдвэр гүйцэтгэгч ашиглалтын зардлыг тооцохдоо тоног төхөөрөмж ашиглах хугацааны зардлыг хоногоор, хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг тухайн тоног, төхөөрөмжийн ашиглалтын хугацаанд харьцуулж, сүлжээний хоногийн зардлыг нэмж, ял эдлэх хоногт үржүүлэн тооцохоор заасан байна.

Тохиолдол 3.6

...Цахим бугуйвчны хэрэглээнд 1 сард 39,000-42,500 төгрөгийн ашиглалтын зардал төлдөг. Өдрөөр нь тооцвол 1300-1500 төгрөгийн зардал төлдөг. Энэхүү төлбөрт цахим бугуйвчны болон үүрэн холбооны сүлжээний ашиглалтын зардал багтана.

(Судалгаанд хамрагдсан ялтантай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Мөн журамд асран хамгаалах хүнгүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 60 ба түүнээс дээш насны хүн, эрх бүхий байгууллагаас хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан нь тогтоогдсон хүн, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, гурав хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, бүтэн өнчин хүүхдийг зардлаас чөлөөлөхөөр заасан нь хүний тухайн ялаар шийтгүүлсэн хүний амьжиргааны түвшин, амьдралын нөхцөл байдлыг харгалзсан сайшаалтай зохицуулалт болжээ.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааг илүү үр дүнтэй болгоход хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ял шийтгүүлж буй хүмүүст энэ ялын талаарх ойлголтыг бүрэн өгөх, шүүхийн практикт ялыг ялгамжтай хэрэглэж буй байдалд дүн шинжилгээ хийж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох, технологийн хувьд орчин үеийн дэвшилтэт техник технологийн ололтод суурилсан төхөөрөмж хэрэглэх тал дээр түлхүү анхаарах зэрэг асуудлууд урган гарч ирж буйг багцлан дурдах нь зүйтэй.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах нийтлэг шаардлага, бүсчлэл тогтоох зохицуулалтыг хэт ерөнхий байдлаар хуульчилснаас зорчих эрхийг хязгаарлаж буй бүсчлэл нь хэт өргөн эсхүл явцуу байдлаар ялгамжтай хэрэглэгдэж байгааг шүүхийн түүвэр шийдвэрүүд болоод ШШГЕГ-аас ирүүлсэн мэдээллээс харагдаж байна.

Гэтэл өмнө дурдсанчлан шүүхийн шийдвэр, хууль хэрэглээ нэгдмэл байх учиртай. Зорчих эрхийг хязгаарлах ялын хувьд нийслэлээс, тодорхой дүүргээс, хорооноос гарч явахыг хориглох зэрэг байдлаар бүсчлэлийг хэрхэн тогтоосноос энэхүү ялын үр нөлөө хол

¹²⁰ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 30 дахь тал.

¹²¹ Засгийн газрын 2021 оны 94 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх” тухай журам. “зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд техникийн хяналт тавихдаа гэрээнд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглаж байгаа тул холбооны сүлжээний ашиглалтын зардал, гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг төлөхөөр тусгажээ.

¹²² ШШГЕГ-ын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 05/2040 дугаар албан бичиг. “DDX-04 загварын гарын цахим бугуйвч 420,000 төгрөг, баталгаат хугацаа 1 жил, R12W загварын гарын цахим бугуйвч 780,000 төгрөг, баталгаат хугацаа 2 жил, DDX-14 загварын хөлийн цахим бугуйвч 640,000 төгрөг, баталгаат хугацаа 1 жил, MTX-60 загварын хөлийн цахим бугуйвч 780,000 төгрөг, баталгаат хугацаа 2 жил” гэж мэдээлсэн.

зөрүүтэй байгааг анхаарч зорчих эрхийг хязгаарлах ялын бүсчлэлийг тогтооход илүү объектив шалгуур тогтоож Эрүүгийн хуулийн ерөнхий ангид холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах нь зүйтэй байна.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялыг тав хүртэл жилийн хугацаагаар оногдуулахаар заасан байгаа нь дэлхий нийтийн жишиг хандлагаас хэд дахин урт хугацаа болжээ. Дэлхий нийтийн нийтлэг жишиг хандлага нь богино хугацаагаар буюу хэдэн долоо хоног, дунд хугацаагаар буюу хэдэн сараас нэг жил хүртэл, урт хугацаагаар буюу ерөөс нийтлэг 2 жил хүртэл л хугацаагаар тогтоон хуульчилдаг байна.¹²³ Нөгөө талаас наад захын түгээмэл хэрэглэдэг ямар ч хяналтын төхөөрөмжид үйлдвэрлэгч таван жилийн баталгаат хугацаа амладаггүй болохыг дурдах нь зүйтэй.

УИХ-аас 2021 онд баталсан Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар зарим төрлийн гэмт хэрэгт оногдуулсан хорих ялаас эдлээгүй үлдсэн ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж шийдвэрлэсэнтэй холбоотой хоёр жилээс их хугацаагаар ял эдэлж буй ялтнууд байгаа бөгөөд харин шүүхээс зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахдаа дэлхий нийтийн жишиг хандлага болох 6-12 сар хүртэлх хугацааг шүүхийн практикт түлхүү хэрэглэж байгаа нь судалгааны явцад илэрсэн. Мөн ял эдлүүлэх ажиллагааны шатанд ялтны ял эдлүүлэх нөхцөл журмыг түр өөрчлөхөөс бусад тохиолдол болох оршин суугаа газар өөрчлөгдсөнтэй холбоотой бүсчлэл өөрчлөх, хөдөлмөр эрхлэх, сурч боловсрохгүй холбоотой зорчих чиглэл нэмэх өөрчлөх зэргээр ялтанд шинээр үүрэг хүлээлгэх асуудлыг шүүхийн хяналтад оруулах нь Эрүүгийн хуулиар зорчих эрхийг хязгаарлахдаа ялтанд шүүхээс үүрэг хүлээлгэдэг үндсэн зарчимд нийцүүлэх, мөн шүүхийн хяналтад орсноор эрхийн зөрчил гаргахгүй байхад ач холбогдолтой гэж судалгаанд дурджээ.¹²⁴

Зорчих эрхийг хязгаарлах ялыг амжилттай хэрэгжүүлж буй орнуудад тулгамдсан асуудал нь хяналтын төхөөрөмж зүүсэн ялтны төхөөрөмжийг харсан бусад хүмүүс тэднийг гадуурхах, сургууль, ажилд авахгүй байх, нийгмээс ялгаварлах хандлага түгээмэл байгааг тэмдэглэсэн байна.¹²⁵ Харин манай улсын хувьд ийм төрлийн ялгаварлал харьцангуй бага, тулгамдсан асуудлын хэмжээнд очоогүй болохыг онцлох нь зүйтэй.

Монгол Улсад зорчих эрхийг хязгаарлах ялыг шүүхийн практикт зохих түвшинд хэрэглэж байгаа бөгөөд цаашид сайжруулах, боловсронгуй болгох ажиллагааг цаг тухайд нь үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатайг дүгнэж байна. Түүнчлэн манай улсын хувьд цахим хяналтын систем, эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар олон улсын чиг хандлагад нийцсэн хяналтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой юм.

3.3.3. Тагнах төхөөрөмжийн эрх зүйн зохицуулалт

Техник, технологийн хөгжил нийгэм, эдийн засаг, хувь хүний амьдралд олон эерэг өөрчлөлтүүдийг бий болгож байгаа хэдий ч зарим талаар хүний эрхэд сөргөөр нөлөөлж байгааг энэ бүлгийн өмнөх хэсгүүдэд тодорхой дурдсан билээ. Эдгээрийн нэг нь технологийн дэвшлийг даган хөгжиж буй гүйцэтгэх ажиллагаанд ашигладаг, тагнах, чагнах техник, технологи юм. Энэ чиглэлийн төхөөрөмж хөгжихийн сацуу түүнийг илрүүлэх боломжтой техник, технологи хөгжиж, тусгай ажиллагаанд ашиглагддагаас гадна энгийн хэрэглээний техник хэрэгслүүд ч бусдыг тагнаж, чагнах боломжтой болсноор хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн баталгаа алдагдахад хүрч болзошгүй байна.

Монгол Улсад гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлтэй холбогдох харилцааг 1997 онд батлагдсан Гүйцэтгэх ажлын тухай хууль (ГАТХ)-иар зохицуулж байна. Тус хуульд гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд хамаарах техник технологийг маш ерөнхий

¹²³ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 83 дахь тал.

¹²⁴ ХЭҮК, С.Галбадар нар, “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлж буй технологи ба хүний эрх” судалгааны тайлан, УБ, 2025 он, 83 дахь тал.

¹²⁵ Мөн тэнд.

байдлаар тусгасан нь эрх зүйн тодорхой байх зарчимд нийцээгүй байна¹²⁶. Түүнчлэн тус хуульд эдгээр хэрэгслийг ямар субъект хэрхэн тодорхойлохыг зохицуулаагүй, практикт хэрэглэж байгаа энгийн хэрэглээний эд зүйлс хамаарах эсэхийг тодорхойлоогүй байхад Тагнуулын ерөнхий газар (ТЕГ) шийдэж байгаа нь хуулиас давсан эрх хэмжээ болохыг судлаач дүгнэжээ¹²⁷.

Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба, Авлигатай тэмцэх газар, цэргийн тагнуулын байгууллага ашиглах эрхтэй.¹²⁸ Хуульд заасны дагуу эдгээр гүйцэтгэх байгууллагууд өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийг хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгуулж ажиллуулах үүрэгтэй. Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн талаарх удирдлагын нэгдсэн асуудлыг тагнуулын байгууллага, тэр дундаа ТЕГ хариуцан ажилладаг байна.

Харин дээрхээс бусад байгууллага, албан тушаалтан, хувь хүн гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг ашиглахыг хориглодог бөгөөд гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулиар зохицуулжээ.¹²⁹

Хүснэгт 3.2 Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлтэй холбогдох бүрэн эрх, тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллагууд

Холбогдох бүрэн эрх	Холбогдох бүрэн эрхийн тайлбар	Холбогдох байгууллага	Нэмэлт мэдээлэл
Ашиглах	Тухайлсан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг ашиглах	• Тагнуулын байгууллага, • Цагдаагийн байгууллага, • Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба, • Авлигатай тэмцэх газар, • Цэргийн тагнуулын байгууллага	Эдгээр байгууллагууд өөрийн мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тоо бүртгэл хөтөлж, энэ талаар мэдээллийн сан байгуулж ажиллуулах үүрэгтэй.
Зөвшөөрөл олгох	Гүйцэтгэх байгууллагаас гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл олж авах, улсын хилээр нэвтрүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгох	ТЕГ	Улсын ерөнхий прокурорын оролцоо: - ТЕГ-ын дарга нь нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, тэдгээрийн ашиглалтад хяналт тавих журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах - Улсын ерөнхий прокурор буюу түүний тусгайлан эрх олгосон прокурорын
Ашиглалтад хяналт тавих	Гүйцэтгэх байгууллагын мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавих, хуулиар эрх олгоогүй байгууллага, албан тушаалтан, иргэний хувийн зорилгоор хэрэглэсэн гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг тэмдэглэл үйлдэн хураан авч,		

¹²⁶ ГАТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасан.

¹²⁷ ХЭҮК, судлаач С.Бат-Орших, “Хүнийг тагнаж, чагнах боломжтой техник хэрэгсэл ба хүний эрх” судалгаа, УБ хот, 2025 он, 3 дахь тал.

¹²⁸ ГАТХ-ийн 9 дүгээр зүйлд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагууд, гүйцэтгэх ажлыг зорилгыг тус тус заасан. Хүснэгт 3.2-оос дэлгэрүүлж үзнэ үү.

¹²⁹ Эрүүгийн хуулийн 21.13.2-т “Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж заажээ.

	улсын орлого болгох, шилжүүлэх, устгах		хувьд гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэлд хяналт тавих
Нэгдсэн тоо бүртгэл хөтлөх	Гүйцэтгэх байгууллагын мэдэлд байгаа гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх		
Нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл зохион бүтээх, олж авах, ашиглах талаар нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх		

ГАТХ-иар тодорхойлсон гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэдгийг ТЕГ хэрхэн ойлгож, холбогдох харилцааг зохицуулж байгааг дараах тохиолдлоос харах боломжтой байна.

Тохиолдол 3.7.

МҮОНРТ-ийн ажилчдын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос “Биднийг тагнаж байна. Шалгуулж өгнө үү.” гэсэн хүсэлтийг тус телевизийн Үндэсний зөвлөлдөө хүргүүлжээ. Улмаар, 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл энэ асуудлаар ТЕГ-т хандсан байна. 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдөр шалгалтын дүн гарсан бөгөөд ТЕГ-аас дараах агуулга бүхий албан бичгийг хүргүүлжээ: МҮОНРТ-ийн эфир, программын өрөө, нэвтрүүлгийн зөвлөлийн өрөө болон студид суурилуулсан дуу дүрс бичдэг камер нь “Hikvision брэндийн DS-2CD2143GO-IU” загварын камер байх бөгөөд энэ нь дуу, дүрс бичих зориулалттай энгийн хэрэглээнд ашиглагддаг хяналтын камер байна. Тус камер нь ГАТХ-ийн 6.3-т заасан гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд хамаарахгүй болно.

(www.ikon.mn цахим сайтад нийтлэгдсэн мэдээллээс)¹³⁰

Дээрх тохиолдлоос харахад холбогдох техник хэрэгсэл нь энгийн хэрэглээнд ашиглагддаг бол гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд хамаарахгүй гэж ойлгогдохоор байна.

Тохиолдол 3.8

ТЕГ 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдөр, өөрийн цахим хуудсаараа дамжуулан ГАТХ-ийн 6.3-т хамаарах гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслүүдийн талаар холбогдох сэрэмжлүүлгийг гаргасан байна.¹³¹ Олон улсын интернэт худалдааны сайтаар худалдаалагддаг нууц камер, нууц камер болон долгион илрүүлэгч, яриа болон GPS байрлал дамжуулах төхөөрөмж, үзгэн камер гэх мэт төхөөрөмжүүд нь Монгол Улсын ГАТХ-ийн 6.3-т хамаарах Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслүүд болно. Тус төхөөрөмжүүдийг хуулиар эрх олгоогүй байгууллага, албан тушаалтан болон иргэн зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн, бусдад зарж борлуулсан, худалдан авсан, ашигласан тохиолдолд ГАТХ-ийн 8.1-т заасныг зөрчсөн¹³² гэж үзэж Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12.1.3-т¹³³ болон Эрүүгийн хуулийн 21.13.2-т заасны дагуу хариуцлага тооцдог болно.

(ТЕГ-ын сэрэмжлүүлгээс)

Нууцаар ажиллах шинжийг өөртөө агуулдаггүй эд зүйл болох нууц камер болон долгион илрүүлэгч төхөөрөмжийг гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд ийнхүү хамааруулсан нь хуульд нийцэхгүй байна.¹³⁴ ГАТХ-ийн 6.3 дахь заалт хэт ерөнхий учир, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч зэрэг төрийн гүйцэтгэх болон шүүх эрх

¹³⁰ www.ikon.mn цахим сайтад 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нийтлэгдсэн “ТЕГ: МҮОНРТ-д ашигладаг камер нь гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд хамаарахгүй” сэдэвт мэдээлэл, (Сүүлд үзсэн 2025 оны 03 дугаар сарын 25).

¹³¹ ТЕГ нь Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.15-т заасны дагуу, “хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид заавал биелүүлэх шаардлага, иргэнд сэрэмжлүүлэг өгөх” бүрэн эрхийг эдэлдэг.

¹³² ГАТХ-ийн 8.Гүйцэтгэх ажилд хориглох зүйл. 8.1.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтан, хувь хүн гүйцэтгэх ажил явуулах, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл ашиглах, аливаа техник хэрэгслийг гүйцэтгэх ажлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно.

¹³³ Эшлэл 4-ийг үзнэ үү.

¹³⁴ Эшлэл 1-ийг үзнэ үү.

мэдлийг хэрэгжүүлэгч албан хаагчид гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд юуг хамаарахыг өөрсдийн үзэмжээр буюу дур мэдэн шийдэх нөхцөл байдлыг бий болж байна.¹³⁵

Тухайлбал, "Илрүүлэх" зориулалт бүхий техник хэрэгсэл нь нууцаар мэдээлэл цуглуулах, олж авах зориулалттай биш бөгөөд харин нууц техник хэрэгслийг таньж олох, илрүүлэх зориулалттай тул цэвэр хамгаалалтын хэрэгсэл тул ГАТХ-ийн 6.3 дахь заалт нь Үндсэн хуулиар олгосон халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэх агуулга бүхий гомдлыг нэр бүхий иргэдээс Үндсэн хуулийн цэцэд гаргажээ. 2023 оны 5 дугаар сарын 17-ний өдрийн байдлаар, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.13.2-т заасан гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсантай холбоотой 10 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна. Үүнээс 8 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 4 хэргийг "гэмт хэргийн шинжгүй", 1 хэргийг "хөөн хэлэлцэх хугацаа дууссан" үндэслэлээр тус тус хааж шийдвэрлэсэн бөгөөд одоо 3 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна. Түүнчлэн эрүүгийн 2 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан, яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд шүүхээс 1 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бол 1 хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.17.4-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн¹³⁶ байна.

Дээрх асуудлаар 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаас маргаан бүхий хэм хэмжээ нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн тухай дүгнэлт гаргасан.¹³⁷ Гэвч тус оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаас дээрх дүгнэлтийг хүчингүй болгож, маргаан бүхий хэм хэмжээ нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчөөгүй байна гэж эцэслэн шийдвэрлэсэн байна.¹³⁸

Хууль тогтоох байгууллагаас ГАТХ-д заасан гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэж юу болох, түүнд яг ямар эд зүйлс хамаардаг талаарх асуудлыг тодорхой байдлаар шийдвэрлэж чадаагүй байна. Хууль тогтоомжийн тодорхойгүй байдал нь төрийн шүүх, ялангуяа гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын бүрэн эрхийн хүрээ хязгаарыг бүдгэрүүлж, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэлд ямар эд зүйлс хамаарах вэ гэх асуудлыг өөрсдийн үзэмжээр буюу дур зоргоороо шийдэх нөхцөл байдлыг бий болгожээ. Үүний үр дүнд, хүн өөрийн эд хөрөнгө, өмчийн эрхээр хохирох, бүр цаашлаад эрүүгийн хариуцлага хүлээж эрх чөлөөгөө хязгаарлуулах ноцтой нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Монгол Улсын хувьд "Нууц камер болон долгион илрүүлэгч төхөөрөмж" нь ТЕГ-ын үзэж буйгаар гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл, тэр дундаа "илрүүлэхэд" зориулагдсан техник хэрэгсэлд хамаарч байгаа юм. ГАТХ-ийн 6.3-т, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12.1.3-т болон Эрүүгийн хуулийн 21.13.2-т заасны дагуу, хуулиар эрх олгоогүй байгууллага, албан тушаалтан, иргэн "Нууц камер болон долгион илрүүлэгч төхөөрөмж"-ийг ашигласан тохиолдолд тус төхөөрөмжийг хураалгахаас гадна, эрүүгийн хариуцлага хүлээхээр байна. "Нууц камер болон долгион илрүүлэгч төхөөрөмж" нь бусдыг нууцаар тагнаж, чагнах замаар бусдын эрх, эрх чөлөөнд халдах гэхээс илүүтэй, бусдын нууцаар тагнах, чагнах халдах оролдлогоос өөрийгөө хамгаалах зориулалттай техник хэрэгсэл юм.

Хүнийг тагнаж, чагнах боломжтой төхөөрөмжийг "илрүүлэхэд" зориулагдсан техник хэрэгслийг ашиглахыг ийнхүү хориглож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлийн 16.13-т "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална",

¹³⁵ ХЭҮК, судлаач С.Бат-Орших, "Хүнийг тагнаж, чагнах боломжтой техник хэрэгсэл ба хүний эрх" судалгаа, УБ хот, 2025 он, 3 дахь тал

¹³⁶ "Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай" Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны маргаанд холбогдуулан Монгол Улсын ерөнхий прокурорын газраас ирүүлсэн тайлбар, нэмэлт мэдээлэл, 5 дугаар цогцолбор, <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759283902651>>

¹³⁷ Дүгнэлтийг дараах холбоосоор үзэх боломжтой: <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759283902651>> Сүүлд үзсэн, 2025.02.27.

¹³⁸ Тогтоолыг дараах холбоосоор үзэх боломжтой: <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960262179051>> Сүүлд үзсэн, 2025.02.27.

Арван есдүгээр зүйлийн 19.1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байж болзошгүй юм.

3.3.4.Цахим хуваагдал, тэгш бус байдал

Цахим эриний тулгамдсан асуудал бол цахим хуваагдал, тэгш бус байдал юм. Цахим технологийг өндөр хөгжилтэй улс орнууд хөгжүүлж, дэлхийн улс орнуудад эдийн засаг, мэдлэг, оюуны өмчийн тэгш бус байдал үүсэж байна. Төрийн үйлчилгээ цахимжих нь зарим тохиолдолд хүнд ойртох биш, нийгмийн зарим бүлгээс “алсарч” байгааг цөөнгүй судалгаа анхааруулж байна. Цахим технологиос үүдэлтэй дэлхий нийтэд үүссэн тэгш бус байдалд технологи бүтээгч бус хэрэглэгч Монгол Улсын нөхцөл байдал нэн эмзэг билээ. Үүний хамт, Монгол Улсын иргэдийн зарим хэсэг нь “цахим” төрийнхөө гадна үлдэж болзошгүй байгааг анхааруулж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим оролцоо, хүртээмж болон цахим хөгжлийн үр өгөөжийг эдгээр бүлгийн хүмүүст хүргэх төрийн бодлогыг дүгнэлээ.¹³⁹

Цахимжилтийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй явуулах зорилт Монгол Улсын бодлого, хууль тогтоомжид өргөн хүрээтэй туссан боловч ахмад настанууд орхигдсон байна. “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2 дугаар зүйлийн 2.6.14, Цахим хөгжлийн бодлогын 4 дүгээр зүйлийн 4.1.4, 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх заалтад хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад зорилтот бүлгүүдийн цахим оролцоо, ур чадварыг нэмэгдүүлэх зорилтууд тусгагджээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйл,¹⁴⁰ Өргөн нэвтрүүлгийн тухай, Харилцаа холбооны тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Нийгмийн халамжийн тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх зохицуулалтыг мөн тусгажээ.¹⁴¹ Харин эдгээр бодлого, хууль тогтоомжид ахмад насны цахим оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар тусгайлан заагаагүй, энэ асуудлыг “бусад зорилтот бүлэг” гэх байдлаар багцалжээ. Ахмад настны тухай хуульд тэдний хөгжил, оролцоог дэмжих, үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах,

¹³⁹ НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо Монгол Улсын Засгийн газрын хоёр болон гуравдугаар тайланг хэлэлцээд “мэдээлэл, харилцаа холбооны технологийн тусламжтайгаар хүртээмжтэй мэдээллээр хангах байдал, үндэстний цөөнхийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмж хангалтгүй” болохыг дүгнэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг төрийн цахим үйлчилгээ, веб хуудас, аппликейшн рүү нэвтрэх боломжоор хангахыг зөвлөсөн. (CRPD /C/MNG/CO/2-3) -43

¹⁴⁰ Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх асуудлын хүрээнд төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, дэлгэц уншигч программ хангамж болон шинэ технологи, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй ашиглахад зориулан бар кодтой хэвлэх, сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессеж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр тусгасан.

¹⁴¹ Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4 дэх заалт “хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлэг”, Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.15.а дэх хэсэг “харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх талаарх мэдлэг, боловсролыг бүх нийтэд эзэмшүүлэх”, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дэх хэсэг “Олон нийтийн радио, телевизийн мэдээллийн болон сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нь дохионы хэлний орчуулгатай гарах ба урсгал мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй иргэнд зориулан нэвтрүүлж байна.” Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг “Энэ хуулийн зорилго нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.” ИХШХШТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг “Хэргийн оролцогч монгол хэл мэддэггүй, эсхүл хэлгүй, дүлий бол түүний хүсэлтээр орчуулагч, хэлмэрчийг шүүгч захирамж гарган томилно. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч орчуулагч, хэлмэрчийн үүргийг гүйцэтгэхийг хориглоно.” ЭХШХШТХ-ийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Яллагдагч монгол хэл, бичиг мэдэхгүй бол өөрийн эх хэл, эсхүл мэдэх хэл, бичгээр, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг авах эрхтэй.”

сурч хөгжихийг дэмжих зарчмын шинжтэй, үүрэг хүлээгчийг тогтоогоогүй заалт оржээ.¹⁴² Нийт хүн амд ахмад настны эзлэх хувь нэмэгдэж,¹⁴³ тэдэнд чиглэсэн тусламж, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодит шаардлага үүсэж байгаа боловч ахмадууд цахим бодлогоос орхигдсон байна. Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим оролцоо, хүртээмжийг дэмжих бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай, батлахаар хуульчилсан журмууд батлагдаагүй байна.. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 онд батлагдсанаас хойш 10 шахам жил өнгөрч буй хэдий ч тус хуульд нийтээр дагаж мөрдөх нийт 25 журам, стандарт батлахаар хуульчилснаас 14 журам, стандарт батлагджээ.¹⁴⁴

Монгол Улсад цахим хуваагдал бодитой оршиж байна. ХЭҮК-ын судалгаагаар төрийн цахим үйлчилгээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжгүй, нийцгүй байна.¹⁴⁵ Тухайлбал, ахмад настны 69 хувь, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 80.3 хувь нь төрийн цахим үйлчилгээг авах хэрэгцээ байдаг ч веб хуудас, аппликейшны харагдах байдал, үсэг томруулах тохиргоогүй, сонгосон текстийг дуу хоолойгоор унших үйлдлийн систем байхгүйн улмаас цахим үйлчилгээг авч чадахгүй байна.¹⁴⁶

Мөн ахмад настан, боловсролгүй, бага боловсролтой хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим ур чадвар дутмагаас цахимаар бүртгүүлэх, хүсэлт илгээх зэрэг энгийн үйлдлийг хийж чадахгүй, төрийн цахим үйлчилгээний гадуур үлдэж байна. Тухайлбал, 2023 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд 92,988 хөгжлийн бэрхшээлтэй хүн шинээр хамрагдсанаас 79 иргэн л цахимаар хүсэлт гаргаж,¹⁴⁷ үлдсэн 92,909 иргэн биечлэн үйлчилгээ авсан байна. Мөн онд 36,490 ахмад настан шинээр үйлчилгээнд хамрагдсаны 775 нь цахимаар үйлчилгээ авсан нь төрийн үйлчилгээний цахимжилт хүртээмжгүй байгааг харуулж байна.

Тохиолдол 3.8

...“Ахмад настан, боловсролгүй, бага боловсролтой цахим технологийн мэдлэг, чадвар дутмаг хүмүүс хохироод үлдэж байна. Тухайлбал, Газрын тухай хуулиар цахимаар газар олгох зохицуулалт шинээр орсны улмаас цахим технологийн мэдлэгтэй, мэдээлэл авах боломжтой хүмүүст давуу тал болж үйлчилгээг авч байна. Харин ахмад настан, өрх толгойлсон, алслагдмал газар болон хөдөө амьдардаг, ухаалаг утас хэрэглэж чадахгүй хүмүүсийн хувьд тэрхүү үйлчилгээнээс хоцорч, хуулиар олгосон эрхээ эдэлж чадахгүй байна..”

(Ахмад настантай хийсэн ярилцлагаас)

Засгийн газрын 2023 оны 238 дугаар “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг шинэчлэн тогтоосон нь хуульд нийцээгүй, тэтгэврийн шинэчлэлийг гажуудуулж, ахмад настны хооронд ялгаварлал үүсгэсэн гэж үзэж тогтоолын уг заалтыг цуцлуулахаар “цахим өргөдөл” үүсгэхэд 2094 ахмад гарын үсэг зурж, нийтийн өргөдлийн системд 70,000 хүний гарын үсэг зурснаар тухайн асуудлыг хэлэлцэх шаардлагыг хангаагүй байна. Цахимаар

¹⁴² Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.13 дэх заалт “Ахмад настныг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах, соёл, урлаг, спорт, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, сурч хөгжихөд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах”.

¹⁴³ Ахмад настны нийт хүн амд эзлэх хувь 2021 оны байдлаар 9.7 хувь байгаа бол 2030 онд 11.9, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолсон байна.

¹⁴⁴ ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн үнэлгээний тайлан”, УБ, 2023 он.

¹⁴⁵ ХЭҮК-ын захилгаар “Тэгш нийгэм холбоо” ТББ-ын хийсэн “Цахим хөгжлийн хүртээмж, зорилтот бүлэгт чиглэсэн туслах цахим технологийн бодлого, зохицуулалт” судалгаанд 405 хүн хамруулснаас ахмад настан 195, хөгжлийн бэрхшээлтэй 195 хүн оролцсон болно.

¹⁴⁶ Судалгаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 54 хувь нь веб хуудас, аппликейшны дэлгэцийн харагдах байдал нь ойлгомжгүй, 24 хувь нь сонгосон үгийг дуу хоолойгоор ярих боломжгүй, 12 хувь нь үсэг томруулах тохиргоогүй, 10 хувь нь дэлгэцийн хулгана жижиг харагдахгүй гэсэн бол ахмад настны 27,6 хувь нь веб хуудас, аппликейшны дэлгэцийн харагдах байдал ойлгомжгүй, 34 хувь нь үсэг томруулах тохиргоогүй, 33 хувь нь сонгосон текстийг дуу хоолойгоор унших боломжгүй, 33 хувь нь бичвэрийг томруулах тохиргоогүй гэжээ.

¹⁴⁷ ГБХНХЯ-ны Нийгмийн халамжийн хэлтсээс авсан статистик “2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн хооронд үйлчилгээ авсан хүний тоо.”

гарын үсэг зурж оролцох нь ахмад настнууд хүндрэлтэй байснаас эрх ашгаа хамгаалж чадаагүй болохыг ахмадын эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага мэдээлжээ.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цахим үйлчилгээ авахад технологи ашиглах мэдлэг, ур чадвар дутагдалтай, гадаад хэлний бэрхшээлтэй, интернэт, тоног төхөөрөмж байхгүй байгаа нь бэрхшээл болж байна.¹⁴⁸ ХЭҮК-ын судалгаанд оролцсон нийт ахмад настны 86.2 хувь нь тэтгэврийн орлоготой, 41 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх өрхийн орлоготойгоос 64 хувь нь өөрийн сарын орлогоос интернэтийн төлбөр төлдөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 33 хувь нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх орлоготой ба 68 хувь нь өөрийн сарын орлогоос интернэтийн төлбөр төлж байна. Монгол Улсын үүрэн холбоо болон өргөн зурвасын интернэтийн нэг сарын хэрэглээний дундаж үнэ жил ирэх тутам буурч¹⁴⁹, интернэтийн өртөг харьцангуй хямд болж буй боловч орлого багатай өрхийн хувьд саад бэрхшээл хэвээр байна.

Тохиолдол 3.9

...Цахимжилтын хүртээмж хөгжлийн бэрхшээлээс хамаарч, харилцан адилгүй байна. Тухайлбал, ахмад настан болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст цахимжилт саад болж байгаа бол хөдөлгөөний болон харааны бэрхшээлтэй хүмүүст давуу талтай. “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэрхшээлийн хэлбэрт нь тохируулан илүү хялбаршуулсан хэрэгслээг үүсгэвэл давуу тал болно. “Сонсголын бэрхшээлтэй хүмүүст санхүүгийн байнга дарамт учруулдаг. Нийгмийн халамжаас хямдхан, үйлдэл багатай сонсголын аппаратыг 3 жилд 1 удаа олгодог ч олон дуу авиа ялгах чадваргүй байдаг. Япон, Солонгос, АНУ-ын сайн чанарын аппаратууд дунджаар 4 сая төгрөг байна. Мөн сонсголын бэрхшээлтэй хүмүүс энгийн үйлдэлтэй утсыг илүү ашиглах сонирхолтой ч цахимаар мэдээлэл авахын тулд заавал ухаалаг утас хэрэглэх шаардлага гардаг ч утасны үйлдлийг мэдэхгүй, тиймээс нийгмийн оролцоо нэмэгдсэн гэж үзэхэд боломжгүй юм.

(Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хийсэн ярилцлагаас)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн цахим оролцоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийг технологийг тэдэнд ээлтэй болгох бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт сул, энэ чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа нэгдсэн зохион байгуулалтгүй, бодитой үр дүн тааруу байна. Төр, хувийн хэвшлийн цахим үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настанд хүртээмжтэй болгох технологийн шийдлүүд e-Mongolia¹⁵⁰, E-PUB¹⁵¹, e-hurteemj, Handpro¹⁵², "TUSLAMJ"¹⁵³, виртуал дохионы хэлмэрч платформ¹⁵⁴ “Чимэгэ”¹⁵⁵, e-job зэрэг системд нэвтэрсэн байна. Сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх арга

¹⁴⁸ Цахим үйлчилгээнд нэвтрэхэд 37.2 хувийг цахим технологи ашиглах мэдлэг, чадвар дутмаг, 22.5 хувийг гадаад хэлний бэрхшээл, 20.6 хувийг дата худалдаж авахад санхүүгийн хүндрэл ордог, 11.6 хувийг уншихад бэрхшээлтэй буюу үсэг нь томордоггүй, 7.5 хувийг сүлжээтэй газар хайж, цаг заваа үрдэг, 0.2 хувийг мэдлэг дутуу зэрэг бэрхшээлүүдийг үүсэж байна.

¹⁴⁹ ХХЗХ, “Үүрэн холбоо, өргөн зурвасын интернэтийн үнэ тарифын харьцуулсан мэдээлэл”, УБ, 2022 он, 4-5-р тал.

¹⁵⁰ “И-Монгол академи” УТУГ нь WCAG аргачлалыг нэвтрүүлж 86 байгууллагын 1437 үйлчилгээг үзүүлж байгаагаас харааны бэрхшээлтэй иргэд дэлгэц унших программын тусламжтайгаар төрийн үйлчилгээ авах боломж бүрдүүлж, 12,892 үйлчилгээ авчээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэх, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас /Монгол-Англи/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт авах үйлчилгээг нэвтрүүлсэн.

¹⁵¹ Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан бүтээсэн (Daisy) стандартад нийцсэн цахим номын сан бөгөөд 18 нэр төрлийн ном багтжээ.

¹⁵² Дохионы хэлийг бичвэр эсвэл дуут мессеж рүү хөрвүүлэх программ.

¹⁵³ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, цахим дохионы хэлмэрч, мэдээлэл хүлээн авагч гэсэн гуравласан холболт бүхий дуудлага хүлээн авах аппликейшн.

¹⁵⁴ Хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст зориулсан платформ.

¹⁵⁵ Дуу хоолойг бичвэр болгох технологи бөгөөд сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан видео дуудлагын үйлчилгээг e-Mongolia системд байршуулж, зайнаас зөвлөн туслах төвийн шууд мэдээлэл шуурхай удирдлага руу шилжүүлэх юм.

хэрэгсэл сайжирч байна.¹⁵⁶ Харин ахмад настны цахим ур чадварыг нэмэгдүүлэх, мэдлэг олгох үйл ажиллагаа, санаачилга ховор байна.¹⁵⁷

Зорилтот бүлгийн цахим оролцоо, хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх дээрх мэт арга хэмжээний бодитой үр дүн хангалтгүй байгааг цөөнгүй судалгаа илтгэжээ. Тухайлбал, НҮБХХ-ийн судалгаагаар зорилтот таван бүлгээс ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадвар хамгийн бага байна.¹⁵⁸ Ахмад настны цахим орчинд аюулгүй байдлаа хангах ур чадвар 40 хувь буюу хамгийн муу, мэдээлэл хайж, олж авах чадвар 45 хувь, бусадтай хамтран ажиллах, харилцах ур чадвар 52.5 хувь байгаа нь бусад бүлгээс хамгийн бага байв.¹⁵⁹ Судалгаанд оролцсон нийт ахмадуудын 70 гаруй хувь нь гар утас хэрэглэх болон интернэтээр дамжуулж үйлчилгээ авахад бусдын туслалцаа шаардлагатай, туслалцаа авах нь тэдний 50 гаруй хувьд хүндрэл учруулж байна. Тэдний 7 орчим хувь нь e-Mongolia системийг гар утсаар ашигладаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл хайх, олж авах ур чадвар 52.5 хувь, цахим аюулгүй байдлаа хангах ур чадвар 55 хувьтай үнэлэгдсэн нь тэдний бусад ур чадвараас бага юм.¹⁶⁰

ХЭҮК-ын судалгаанд оролцсон ахмад настны 91 хувь нь ухаалаг утас ашигладаг хэдий ч 28 хувь нь асаах, унтраах үйлдлийг л бие даан хийдэг, бусад тохиолдолд тусламж авдаг гэжээ.¹⁶¹ Эдгээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төрийн цахим үйлчилгээг хэрхэн авах талаар сургалт, мэдээлэл хүрдэггүй, хэрхэн мэдээлэл авах, сургалтад хамрагдах талаар мэддэггүй байна.¹⁶² Судалгаанд оролцсон ахмад настны 51 хувь нь тэдний хэрэглэдэг хамгийн түгээмэл үйлчилгээ болох банкны цахим шилжүүлэг хийхэд бусдаас тусламж авдаг байна.¹⁶³

Тохиолдол 3.10

...Цахим хуудас, аппликейшн ашиглах үед хадмал тайлбаргүй, дохионы хэлмэрчтэй зааварчилгаа байдаггүй, яаралтай тусламж авах үед видео дуудлага хийх шаардлага гардаг. Хэлмэрч байхгүйн улмаас хүн нас барсан тохиолдол ч гарсан. Төрийн үйлчилгээний талаар санал гомдол их байдаг ч бичиг үсэг тайлагдалт бага учраас хүсэлтээ бичлэг хэлбэрээр илгээх хэрэгцээ байгаа боловч хүлээж авах нөхцөл нь бүрдээгүй. Цахим үйлчилгээг утсаар авах үед заавал видео дуудлага хийх шаардлага гардаг. Ингэж ярих нь энгийн утсаар ярихаас илүү дата шаарддаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан үйлчилгээ үүрэн телефоны компаниудад байдаггүй, хүртээмжгүй байна. Хувиараа бизнес эрхэлдэг хүмүүст цахим татварын систем, Цахим төлбөрийн баримтын систем ашиглах шаардлага гардаг ч ажиллахад бэрхшээлтэй, тайлан явуулахад хүндрэлтэй байна. Хөдөлмөр эрхлэхэд тухайн байгууллагад дохионы хэлмэрч байдаггүй, хүмүүстэй харилцах, ажил хийх явцдаа хувийн зардлаараа хэлмэрч авдаг нь санхүүгийн бэрхшээл үүсгэдэг, улмаар ажил хийхэд хүндрэлтэй байдаг. Түүнчлэн сурч боловсроход ч хэлмэрчгүй учраас хичээлээ ойлгодоггүй, хувиараа хэлмэрчтэй суралцахад

¹⁵⁶ 2024 онд 54 телевиз 7851 цагийн дохионы хэлтэй нэвтрүүлгийг нэвтрүүлснээс 67,5 хувь нь мэдээ, мэдээллийн хөтөлбөр, 8.4 хувь нь танин мэдэхүй, 16,2 хувь нь хүүхдийн нэвтрүүлгийг хүргэжээ. Мөн олон улсын цахилгаан холбооны байгууллагаас хүүхдэд зориулан гаргасан “Санготай хамтдаа цахим аюулгүй байдлаа хамгаалъя” 5 ангит цуврал видео хичээлийг монгол хэл дээр хөрвүүлэн, дохионы хэлний болон хадмал тайлбартайгаар бэлтгэн цахим болон телевизээр түгээжээ.

¹⁵⁷ ГБХНХЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж, үйлчилгээг хөгжүүлэх нь техникийн туслалцааны төслийн хүрээнд ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загвар”-ыг туршин нэвтрүүлэхээр идэвхтэй насжилтыг дэмжих гурван төвийг байгуулсан байгаа нь одоогоор хамгийн шилдэг арга хэмжээ байна.

¹⁵⁸ НҮБХХ, “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”, УБ, 2021 он.

¹⁵⁹ Мөн тэнд.

¹⁶⁰ НҮБХХ, “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”, УБ, 2021 он.

¹⁶¹ Судалгаагаар цахим үйлчилгээ авахад веб хуудас, аппликейшны дэлгэцийн харагдах байдал, дизайн ойлгомжгүйгээс 20 хувь, үсэг томруулах тохиргоо, хулгана байхгүйн улмаас 50 хувьд маш их хязгаарладаг, сонгосон текстийг дуу хоолойгоор унших боломжгүйн улмаас 20 хувьд нь хязгаарладгаас цахим хүртээмж бага байна.

¹⁶² ХБИ-дийн 82.8, ахмад настны 70.6 хувь нь төрийн цахим үйлчилгээнүүдийг хэрхэн ашиглах талаарх сургалтад хамрагдаагүй, ямар сургалтад хамрагдаж үзэхийг хүсэж байгааг тодруулахад ихэнх нь мэдэхгүй, e-Mongolia системд хараагүй хүнд зориулсан тусгай сургалт, дохионы хэлний хэлмэрчтэй сургалт, цахим орчинд ажиллах сургалтад хамрагдаж гэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цаашдаа сургалт орох зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

¹⁶³ ХЭҮК, Тэгш нийгэм холбоо ТББ, “Цахим хөгжлийн хүртээмж, зорилтот бүлэгт чиглэсэн туслах цахим технологийн бодлого, зохицуулалт” судалгаа, УБ, 2024 он.

санхүүгийн дарамт бий болдог.

(Сонсголын бэрхшээлтэй хүмүүстэй хийсэн ярилцлагаас)

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст төр, хувийн хэвшлийн байгууллагын цахим хуудас, аппликейшн хүртээмжгүй байна. Цахим хуудас, веб контентын хүртээмжийн талаарх дэлхийн стандарт гэж тооцогдож буй Дэлхийн вебийн консорциум (W3C)-аас батлан гаргасан “Веб контентын хүртээмжийн удирдамж (WCAG)”-ийг 2019 онд Монгол хэлээр орчуулж, веб контент бүтээхдээ энэхүү аргачлалыг баримтлахыг Харилцаа холбооны зохицуулах хороо зөвлөсөн байдаг. Гэвч Монгол Улсын төрийн, хувийн хэвшлийн байгууллагуудын уг зөвлөмж, баримт бичгийг мөрдөөгүй, мэдээллийн технологи хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнуудад эс хүртэж байна. 2016 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн үнэлгээгээр мэдээллийн хүртээмжийн үнэлгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээ, мэдээлэл түгээдэг сувгуудын 97 хувь нь хүртээмжгүй,¹⁶⁴ ... онд Монголын хараагүйчүүдийн холбооноос “веб контентын хүртээмжийн удирдамж” (WCAG 2.1)-ийн дагуу 48 шалгуур үзүүлэлтээр төрийн болон хувийн хэвшлийн веб хуудсыг шинжлэхэд бүгд шалгуур үзүүлэлтэд үл нийцсэн байна гэжээ.¹⁶⁵ ХНХЯ-наас ... онд хийсэн үнэлгээнд хамрагдсан 9 цахим хуудас нь бүгд хүртээмжтэй байдлын шаардлагад нийцээгүй байжээ.¹⁶⁶

Комиссын судалгаагаар e-Mongolia систем, халамжийн нэгдсэн систем (e-halamj), Төрийн банк, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн веб хуудсыг үнэлэхэд зорилтот бүлгийн иргэдэд мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлтийг хангаагүй, ХХЗХ-оос зөвлөсөн (WCAG)-ийн зөвлөмжийн дагуу хөгжүүлэлт хийгдээгүй байна. Мөн ахмад настанд ээлтэй утасны загварын 14 шалгуур үзүүлэлтээр e-Mongolia систем, Хаан, Төрийн банкны 3 аппликейшнд үнэлгээ хийхэд 9 үзүүлэлтийг бүрэн хангасан бол “текстийн хэмжээг томруулах”, “олон цонхыг хаах”, “хэрэглэгчдэд функцийг цогцоор нь ажиллуулах өөр арга хэрэгслээр хангах”, “алдаатай, буруу шилжүүлгээс урьдчилан сэргийлэх” үзүүлэлт огт хангагдахгүй, түүнчлэн “Ахмад настанд ээлтэй загварыг гаргах” шалгуур үзүүлэлт 3 аппликейшнд байхгүй байна.¹⁶⁷

ЗГ-ын 2022 оны 201 дүгээр тогтоолоор “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ыг баталж, мэдээлэл хариуцагчдад өөрт хамаарах нээлттэй мэдээллийг агуулсан мэдээллийн сан үүсгэж, “Төрийн байгууллагын веб сайтад тавих шаардлага” Монгол Улсын MNS 6285:2017” стандартыг хангасан, веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG 2.1 зөвлөмж)-д нийцсэн мэдээллийг өөрийн цахим хуудаст байршуулж нийтлэхийг үүрэг болгож, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Цахим хөгжлийн сайдуудад үүрэг болгосон байдаг ч журмын хэрэгжилтийн талаарх мэдээлэл байхгүй байна. Мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэж чадаж байгаа болон эс чадаж буй хүмүүсийн ялгааг цахим хуваагдал гэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, орлого багатай болон төвөөс алслагдсан хүмүүсийг цахим хуваагдлаас хамгаалах үр дүнтэй арга хэмжээ шаардлагатай байна.

Орчин үеийн цахим технологи хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настны амьдралын чанарыг дээшлүүлж, амьдралын өдөр тутмын харилцаанд бусдаас хамааралт байдлыг бууруулж, бие даан, илүү эрх чөлөөтэй амьдрах боломжийг нэмэгдүүлж байна. Жишээлбэл, орчныг мэдрэгч бүхий ухаалаг тэргэнцэр өөрөө явах, саад тотгорыг тойрон гарах боломжтой бол харааны бэрхшээлтэй хүний цагаан таягт аудио болон аюулгүй хөдөлгөөн хийхэд нь туслах аудио болон мэдрэгчийг суурилуулж, аюулгүй зорчих, чөлөөтэй хөдлөх боломжийг нэмэгдүүлж болно. Хиймэл оюунд суурилсан ухаалаг туслах, гэрийн

¹⁶⁴ Мэдээллийн шуурхай удирдлагын төвийн 101,102,103 тусгай дугаар, сурах бичиг, хэвлэмэл бүтээгдэхүүн, телевизийн өргөн нэвтрүүлэг, IPTV-д, 29 дүгээр тусгай сургууль, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, байгууллагуудын хаягжилт, мэдээллийн самбарт үнэлгээ хийжээ.

¹⁶⁵ “Монголын хараагүйчүүдийн холбоо”-ноос хийсэн мэдээллийн хүртээмжийн үнэлгээний тайлангаас.

¹⁶⁶ ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, УБ, 2023 он.

¹⁶⁷ ХЭҮК, “Тэгш нийгэм холбоо” ТББ, “Цахим хөгжлийн хүртээмж, зорилтот бүлэгт чиглэсэн туслах цахим технологийн бодлого, зохицуулалт” судалгаа, УБ, 2024 он.

ухаалаг төхөөрөмж, ухаалаг нүдний шил зэрэг цахим технологи нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бие даан, чанартай, идэвхтэй амьдрах боломжийг бүрдүүлдэг.¹⁶⁸ Нөгөө талаас шинжлэх ухааны үр шимээс хүртэх,¹⁶⁹ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах тохиолдолд төрөөс эд, мөнгөний тусламж авах нь Монгол Улсын иргэний Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрх билээ.¹⁷⁰ Харин ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгмийн халамжаас олгож буй туслах бүтээгдэхүүн, хэрэгслийн жагсаалтад цөөн тооны, наад захын цахим туслах технологи орсон байгаа¹⁷¹ нь цахим хөгжлийн үр шимээс Монгол Улсын иргэдэд хүртээх бодлого үгүйлэгдэж байгааг илтгэж байна. Монгол Улс үндэсний хэмжээнд туслах технологийн хэрэгцээгээ судалсан 35 орны нэг бөгөөд ДЭМБ-ын зайлшгүй шаардлагатай “Туслах бүтээгдэхүүн”-ний жагсаалтын¹⁷² дагуу үнэлгээг хийж, туслах технологийн хангагдсан болон хангагдаагүй хэрэгцээг тодорхойлоход нийт хүн амын 15.1 хувьд¹⁷³ нь туслах бүтээгдэхүүн (харааны шилийг оролцуулаад) хэрэгцээтэйгээс 7.4 хувь нь хангагдсан бол хангагдаагүй хэрэгцээ 7.7 хувь байна.

Цахим туслах төхөөрөмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настнууд хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх, үүнд чиглэсэн судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих, импорт, татварын эерэг нөхцөлийг бүрдүүлэх нь хүнд ээлтэй, хүртээмжтэй цахим хөгжлийн чухал нэг “орц” болохыг хүний эрхийн байгууллагууд анхааруулж байна.¹⁷⁴ 2024 оны эхээр хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээр туршиж эхэлсэн Нейролинк зэрэг нейротехнологийн хөгжил эрх зүй, хүний эрхийн тулгамдсан асуудал болж байна. Хүний тархийг цахим сүлжээнд холбож, хүний мэдрэлийн тогтолцоонд нэвтрэх, хянах, өөрчлөх боломжийг олгож буй нейротехнологи нь альцгеймер, шизофрени, паркинсон, эпилепси, цус харвалт, сэтгэл гутрал зэрэг өвчтэй хүмүүсийг анагаах, хэвийн амьдрах боломжийг олгох боловч хүний тархины үйл ажиллагааг унших, үзэл бодол, итгэл үнэмшлийг өөрчлөх боломжтой, өөрөөр хэлбэл, хүн гэх ойлголтыг өөрчлөх үр дагавартай юм.¹⁷⁵ Цахим технологийн хөгжлөөс үл хоцрох, хүний эрхийн эрсдэлтэй байж болох энэ мэт технологийн хэрэглээг зохицуулах, эрсдэлээс хамгаалах бодлого, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх Монгол Улсын чадавхыг бий болгох асуудал тулгамдаж байна.

3.3.5.Хиймэл оюуны бодлого, эрх зүйн зохицуулалт

Хиймэл оюун нь орчин үеийн технологийн хөгжлийн гол чиглэл болж, дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгэм, төрийн үйлчилгээ, хүний эрхийн салбарт томоохон өөрчлөлт авчирч байна. Энэхүү технологийн хурдацтай хөгжил нь улс орнуудад шинэ боломжуудыг бий болгож байгаа боловч үүнийг хэрхэн зохицуулах, сөрөг үр дагавраас хэрхэн урьдчилан

¹⁶⁸ НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын А/HRC/58/33 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба туслах хэрэгсэл болон цахим технологи”, 2025 он.

¹⁶⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, 16.8 дэх заалт “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална”.

¹⁷⁰ ¹⁷⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, 16.5 дахь заалт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”.

¹⁷¹ ЗГ-ын 2021 оны 363 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалтыг баталж, 65 нэр төрлийн туслах хэрэглэгдэхүүний жишиг үнийг тогтоож, зарим туслах цахим технологийг оруулжээ. Тухайлбал, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хэл засал, харилцаа, мэдрэхүйг хөгжүүлэх туслах хэрэглэгдэхүүн, тайвшруулах хэрэгсэл, Дизи тоглуулагч (хараагүй хүний ярьдаг ном унших), Компьютерын ярьдаг программ хангамж, нэмэгдэл төхөөрөмж, Бүрэн хараагүй, сонсголгүй хүний харилцаа холбооны хэрэгсэл (ухаалаг гар утас)

¹⁷² ДЭМБ зайлшгүй шаардлагатай 50 нэр төрлийн туслах бүтээгдэхүүнийг 2016 онд баталж, тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамаараад эдгээр нэр төрлийн туслах бүтээгдэхүүнийг Гишүүн орнуудыг олгохыг зөвлөсөн байдаг.

¹⁷³ Судалгаагаар 490,000 хүнд туслах бүтээгдэхүүн шаардлагатай байгаагаас 243,000 хүнд туслах бүтээгдэхүүний хэрэгцээ хангагдсан бол ойролцоогоор 247,000 хүнд туслах бүтээгдэхүүний хэрэгцээ хангагдаагүй байна гэжээ.

¹⁷⁴ НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын А/HRC/58/33 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ба туслах хэрэгсэл болон цахим технологи”, 2025 он.

¹⁷⁵ НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын А/HRC/58/58 дугаартай “Хүний хувийн нууцыг хамгаалах нейротехнологийн зохицуулалт болон мэдрэлийн өгөгдлийг боловсруулах үндэслэл, зарчим”, 2025 он.

сэргийлэх, хүний эрхийг хэрхэн хамгаалах зэрэг асуудлуудыг бодлого боловсруулагчдын өмнө тавьж байна¹⁷⁶.

Монгол Улсад ч мөн адил хиймэл оюуны технологийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд өргөнөөр нэвтрүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хөгжүүлж байна. Гэвч хиймэл оюуны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хүний эрхийн эрсдэл үүсэх нь зайлшгүй асуудал болж байна. Тодруулбал, хүний хувийн нууцад халдах, алгоритмын хазайлт ба ялгаварлан гадуурхах, ил тод бус байдал ба хариуцлагын зохицуулалт сул зэрэг асуудлууд үүсэж байна.¹⁷⁷

Хиймэл оюуны загварууд ихэвчлэн их хэмжээний өгөгдөл дээр суурилдаг тул ялгаварлан гадуурхах эрсдэлтэй. Хиймэл оюун хөгжүүлэгчдийн хувьд одоогоор хиймэл оюуныг сургаж, хөгжүүлэхдээ хүнийг ялгаварлан гадуурхахгүй байх, хүний эрхийг зөрчихгүй байх гэдэг тухайлан шаардлага оруулдаггүй. Гэхдээ хүний эрхэд шууд халдах, тохиромжгүй хариулт өгөхгүй байхад хиймэл оюун хөгжүүлэгчид анхааран сургаж байна. Тухайлбал, иргэний зээлийн оноог тогтооход нас, хүйс, орлого гэх мэт хувь хүний онцлог мэдээллийг ашигладаггүй. Blind score буюу тухайн хувь хүн ямар байхаас үл хамааран цэвэр зээлийн харилцаанд хэрхэн ордгоос хамаарч оноог эрх тэгш тогтоодог байна. Цаашлаад гадаад улсад хөгжүүлж, сургасан хиймэл оюуныг ашиглаж буй компаниудын хувьд ёс зүйн болон хүний эрхийн шаардлагуудыг өөрсдөө тодорхойлдоггүй, нээлттэй модель (openai) санал болгож буй тал нь эдгээр шаардлагыг тодорхойлж байна.

Гэхдээ өгөгдөл нь өөрөө түүхэн хуучирсан, эсвэл аль нэг бүлэгт давамгайлсан мэдээлэл агуулсан бол хиймэл оюун ялгаварлан гадуурхсан шийдвэр гаргах магадлалтай. Жишээ нь, хиймэл оюун ашиглан ажил горилогчдыг шүүх системийг олон улсад нэвтрүүлж байсан ч эмэгтэйчүүд, цөөнхийн бүлгийн хүмүүсийг бага оноогоор үнэлэх алгоритмын алдаа(bias) гарч байсан. Монгол Улсын хувьд хиймэл оюунд суурилсан банк санхүүгийн зээлийн оноо тогтоох систем хөгжиж байгаа бөгөөд хэрэв энэ систем нас, хүйс, орлогын түвшин, боловсролын байдал дээр үндэслэн ялгавартай шийдвэр гаргавал хүний эрх зөрчигдөх магадлалтай.

Хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж буй хэрэглэгчид хариултыг нягтлах сануулга өгөх, компаниас татгалзал (disclaimer) гаргах байдлаар үүсэж болзошгүй эрсдэлүүдийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгддэг байх ёстой.

Хиймэл оюуныг ашиглан гаргасан шийдвэр, хариулт тайлбарлагдах чадвараа алддаг сул талтай. Тодруулбал, хөгжүүлэгч компанийн хувьд хиймэл оюуны системийн ажиллагаа буюу энэ асуултад яагаад ийм хариулт өгсөн гэдгийг тайлбарлах боломжгүй бөгөөд энэ нь хиймэл оюуны хий үзэгдэл (AI hallucination) гэх ойлголттой холбогддог.

Харин зээлийн оноог ХО ашиглан тооцоолох үйлчилгээнд статистик аргачлал ашигладаг учраас тайлбарлах чадвартай бөгөөд оноонд нөлөөлөх 4 хүчин зүйлийг тайлбарладаг. Зээлжих зэрэглэлийн оноо учраас зээлдэгч иргэн хэрхэн сайжруулах, яагаад ийм оноо авснаа мэддэг байх нь иргэдийн санхүүгийн боловсрол талаасаа ихээхэн ач холбогдолтой.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүднээс аюулгүй байдлын хяналтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Төрийн байгууллагуудын хувьд Мэдээллийн аюулгүй байдлын газар болон Үндэсний дата төв мэдээллийн системийн аюулгүй байдал, бүх төрлийн хөгжүүлэлт, сайжруулалтыг хариуцан ажилладаг байна. Харин санхүү, харилцаа холбоо, технологийн салбарт үйлчилгээ үзүүлж буй компаниуд ихэвчлэн Кибер аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөх, Мэдээллийн аюулгүй байдлын ISO стандарт нэвтрүүлэх, ирээдүйд

¹⁷⁶НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын А/HRC/48/31 дугаартай “Дижитал эрин зуун дахь хувь хүний нууцын эрхийн тайлан”

¹⁷⁷ ХҮЭК-ын захиалгаар “Өмгөөллийн Фиделитас партнерс” ХХН-с хийсэн “Хиймэл оюуны бодлого, эрх зүйн зохицуулалт” судалгаа, 2025 он.

нэвтрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Улмаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гадна хэрэглэгч байгууллагууд энэ төрлийн стандартыг нэвтрүүлэхийг шаардлага үүсэж байна.

Мэдээлэл хамгаалалтын асуудал нь зөвхөн хиймэл оюунаар хязгаарлагдахгүй байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын асуудал болж байна. Хүний хувийн мэдээлэл нь зөвхөн хиймэл оюун ашиглахтай холбоотойгоор боловсруулагдахаас гадна байгууллагуудын дотоод үйл ажиллагаа, өгөгдөл хадгалах, дамжуулах, ашиглах бүхий л процесст хамааралтай. Хиймэл оюун нь зөвхөн технологи бөгөөд мэдээлэл хамгаалалт нь сүлжээний аюулгүй байдал, өгөгдлийн шифрлэлт, хандалтын хяналт зэрэг олон асуудлыг хамардаг. Иймд мэдээлэл хамгаалах асуудал зөвхөн хиймэл оюунаар хязгаарлагдахгүй, байгууллагын ерөнхий мэдээллийн аюулгүй байдлын нэг хэсэг болж байна.

Энэ нь зөвхөн хиймэл оюун хөгжүүлэгч, ашиглагч байгууллагуудын асуудал биш бөгөөд бүх төрлийн мэдээлэл боловсруулж, хадгалж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хамааралтай өргөн хүрээний зохицуулалт, хяналтын механизмтай байх шаардлага үүсэж байна.

Хиймэл оюуны тухай нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт, томъёолол байхгүй байна. Хиймэл оюуныг тодорхойлохдоо технологийн онцлог, ур чадварт үндэслэн хиймэл оюуны гүйцэтгэх үйлдлүүдийг тоочих байдлаар тодорхойлбол оновчтой юм. Хиймэл оюунд хамаарах харилцааг зохицуулж буй олон улсын soft law эх сурвалжууд, Европын Холбоо, АНУ-ын заавал биелэгдэх шинжтэй хууль тогтоомж, Их Британи, Австрали, БНСУ-ын бодлого, стратегийн баримт бичгүүдийг судалж үзэхэд одоо байгаа технологийн үйлдэлд үндэслэн “ХО”-ны эрх зүйн тодорхойлолтыг бий болгожээ.

Хүснэгт 3.3. Хиймэл оюуныг тодорхойлсон байдал

Хиймэл оюуны ёс зүйн тухай зөвлөмж ¹⁷⁸	Хиймэл оюуны үндэсний стратеги ¹⁷⁹	Компаниудад зориулсан хиймэл оюун ба хүний эрхийн зөвлөмж ¹⁸⁰
Ухамсарт зан үйлийг санагдуулахуйц байдлаар өгөгдөл мэдээлэл боловсруулах чадамжтай бөгөөд эргэцүүлэн бодох, суралцах, хүлээн авах, урьдчилан таамаглах, төлөвлөх, хянах үйлдлийг агуулсан систем	Алгоритмын шийдвэр гаргалт ба хиймэл оюун хоёрын ялгааг тодорхой зааж өгдөггүй. Алгоритм гэдэг нь машинд тооцоо хийх, шийдвэр гаргах эсвэл асуудлыг шийдвэрлэхэд дагаж мөрдөх үйл явц буюу дүрэм журам юм. Харин хиймэл оюун нь хүн төрөлхтний оюун ухааны үйл ажиллагааг гүйцэтгэх чадвартай таамаглалын хэлбэр юм.	Хиймэл оюуны тогтмол тодорхойлолт байхгүй. Хиймэл оюун нь компьютерын системүүд эсвэл алгоритмуудын хүний оюун ухаант үйл ажиллагааг дуурайх чадварыг илэрхийлдэг.

Дээрх эх сурвалжуудад, хиймэл оюуныг тодорхойлоход тухайн технологийн гүйцэтгэх боломжит чадваруудыг тодорхойлон тоочих байдлаар тодорхойлсон. Хиймэл оюуны систем нь материаллаг болон виртуал орчинд урьдчилан таамаглах, шийдвэр гаргах зэрэг үр дүнд хүргэдэг, танин мэдэхүйн даалгавруудыг хийж гүйцэтгэх, суралцах чадавх бүрдүүлдэг загвар, алгоритмыг нэгтгэдэг мэдээлэл боловсруулах технологи бөгөөд хэд хэдэн аргуудыг агуулдаг.¹⁸¹ Тухайлбал, (1) Машин сургалт /machine learning/-д хамаарах гүн сургалт /deep learning/, урамшуулалд суурилсан сургалт /reinforcement learning/, (2) Машин сэтгэлгээ

¹⁷⁸ Тус зөвлөмжийг Парис хотноо 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр болсон НҮБ-ийн ЮНЕСКО-ийн 41 дүгээр чуулганаар баталсан.

¹⁷⁹ “Үндэсний хиймэл оюуны стратеги ба хүний эрх: Шүүмж тайлан”, <https://www.gp-digital.org/wp-content/uploads/2021/05/NAS-and-human-rights_2nd_ed.pdf> (2025 оны 03 дугаар сарын 24-ний байдлаар хандсан.)

¹⁸⁰ Компаниудад зориулсан хиймэл оюун ухаан ба хүний эрхийн зөвлөмж, <https://www.globalcompact.de/fileadmin/user_upload/Dokumente_PDFs/artificial_intelligence_and_human_rights_E_N.pdf> (2025 оны 03 дугаар сарын 11-ний байдлаар хандсан.)

¹⁸¹ ЮНЕСКО, “Хиймэл оюуны ёс зүйн тухай зөвлөмж”, 2021 он, 10 дахь тал.

/machine reasoninhg/-т төлөвлөлт, бүрдүүлэлт, мэдлэг дүрслэх, сэтгэлгээ, хайлт хамаарна.¹⁸²

Монгол Улсад хиймэл оюун нь голчлон тусгай хиймэл оюуны (Narrow AI) түвшинд хөгжиж, тодорхой нэг үүрэг даалгаврыг гүйцэтгэх зориулалттайгаар ашиглагдаж байна. Төрийн болон хувийн байгууллагуудын ашиглаж буй хиймэл оюуны моделийн хувьд (1) Монгол Улсад өөрсдөө сурган, хөгжүүлж буй, (2) олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хиймэл оюуны моделийг ашиглан, холболт хийн, Монгол хэл дээрх дата дээр сурган хэрэглээнд нэвтрүүлж буй, (3) гадаад улсын хиймэл оюуны моделийг тодорхой зөвшөөрөл, эрхтэйгээр ашиглаж байна.

Хиймэл оюуныг төрийн байгууллагууд төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хялбар байлгах зорилгоор ашиглаж байгаа бол, бизнесийн байгууллагууд бүтээмжийг нэмэгдүүлэх, хүмүүст туслах хэрэгсэл гэж үзэж, ашиглаж байна. Бизнесийн байгууллагууд ихэвчлэн цугларсан байгаа өгөгдөл, хэрэглэгчийн үйлдэл, зан төлөвт дүн шинжилгээ хийх замаар хэрэглэгчид тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг тодорхойлох, чанарыг сайжруулахад ашиглаж байна. Түүнчлэн байгууллагууд ихэвчлэн гадаад улсын болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ХО-ы моделийг шууд сурган ашиглаж байгаа бөгөөд өөрсдийн хөгжүүлж, сургасан ХО-ы технологийг зөвхөн дотоод үйл ажиллагаандаа, эсхүл туршилтаар ашиглаж байна.

Хүснэгт 1.4. Монгол Улсад ашиглаж буй хиймэл оюуны төрөл

Монгол Улсад сурган хөгжүүлж буй хиймэл оюун	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хиймэл оюуны моделийг ашиглан, Монгол хэл дээрх өгөгдөлд сурган хэрэглээнд нэвтрүүлж буй хиймэл оюун	Гадаад улсын хиймэл оюуны моделийг тодорхой зөвшөөрөл, эрхтэйгээр ашиглаж буй хиймэл оюун
Өөрсдөө сурган, хөгжүүлж буй хиймэл оюун нь Монгол улсын хувьд санхүүжилт, дата сангийн хүртээмж, дэд бүтэц, боловсон хүчин зэрэг хязгаарлагдмал нөөцөөс үүдэлтэйгээр цөөн боловч тодорхой салбаруудад хөгжиж байна. Эдгээр нь ихэвчлэн хэлний боловсруулалт (NLP), дуу хоолой таних, өгөгдөл боловсруулах чиглэлд төвлөрсөн.	Байгууллагууд өөрсдөө хиймэл оюуны загвар хөгжүүлэхээс илүүтэйгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн моделийг сурган ашиглах чиглэлд түлхүү ажиллаж байна.	Байгууллагуудад гадаад улсын хиймэл оюуны моделийг тодорхой зөвшөөрөл, лицензтэйгээр төлбөр төлж ашиглах нь цөөнгүй байна.
Тухайлбал, - Чимэгээ систем: NLP, дуу хоолой таних, текст хувиргах - Эгүнэ AI: NLP, автомат хариулагч систем - Worki: AI тусламжтайгаар ажил горилогчийг үнэлэх систем - Lime: Хэрэглэгчийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх, хэрэглэгчийн дуудлагаар ирүүлсэн асуултад тохирсон хариулт өгөх	Тухайлбал, - И Монголиа: K-Nearest Neighbor алгоритмд суурилсан модель ашиглан төрийн үйлчилгээг хэрэглэгчдэд илүү хялбар, оновчтой хүргэх системийг хөгжүүлсэн. - Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч: NLP болон олон улсын санхүүгийн AI загваруудыг хослуулан санхүүгийн салбарт нэвтрүүлсэн.	Тухайлбал, - NURA AI: Япон улсын FUJIFILM корпорацийн ХО-д суурилсан КТГ, дүрс оношилгоо

Бизнесийн байгууллагууд мэдээллийн санг бий болгохдоо интернэт дэх нээлттэй мэдээлэл болон байгууллагын өөрийн мэдээллийн санд үндэслэдэг. Мөн их сургуулийн хиймэл оюунд суурилсан судалгаа, хөгжүүлэлт судалгааны зориулалтаар ашиглах боломжтой нээлттэй мэдээллийг сангууд дээр хийгддэг байна. Интернэт дэх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал хангалтгүй тул хиймэл оюуныг сургах шатанд хүний оролцоотойгоор давхар хяналт хийгдэж байна. Харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээтэй

¹⁸² ЮНЕСКО, “Хиймэл оюуны ёс зүйн тухай зөвлөмж”, 2021 он, 10 дахь тал.

холбоотой эрсдэлийг сануулах, харилцагчийн зөвшөөрөл, сонголтоор үйлдэл хийх байдлаар хөгжүүлсэн байна.

Монгол улсад хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад баримтлах хиймэл оюуны ёс зүйн зөвлөмж, хиймэл оюуны үндэсний стратеги эсхүл хиймэл оюуны тухай хууль батлагдаагүй байна. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан.¹⁸³ Тус тогтоолын 2 дугаар хавсралтаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа¹⁸⁴-г тодорхойлсон. Засгийн газраас баталсан "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийн¹⁸⁵ мэдээллийн технологийн чиглэлд *"Хүн, амьтны байгалийн оюун ухааныг мэдээллийн технологийн тусламжаар дуурайлган хийсэн хиймэл оюуныг хөгжүүлэх, хиймэл оюунд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх тухай"* тусгасан.¹⁸⁶ Засгийн газраас тодорхой салбарт хиймэл оюуны хөгжүүлэлтийн үндэсний компаниудыг бий болгох, хиймэл оюуныг хөгжүүлэхэд тусгайлсан бодлогоор дэмжлэг үзүүлэх зэргээр инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон боловч хиймэл оюунд хамаарах бусад хүний эрхийн асуудлууд болох хүн төвтэй байх, тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхалтаас анги байх, алгоритм болон шийдвэр гаргалтын ил тод байдлыг хангах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлаас баталсан "Цахим хөгжлийн багц хууль" хиймэл оюунд хамаарах харилцааг зохицуулах суурь эх сурвалж болж байна. Энэхүү зохицуулалтын хүрээнд төрийн болон хувийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Мөн гадаад улсад хөгжүүлсэн хиймэл оюуныг холболт хийх, эрх авах замаар ашиглаж буй зарим байгууллагууд хувийн мэдээллийг дамжуулахгүй, задруулахгүй байхад анхаарч ажиллаж байна.

Хиймэл оюуны хууль, дотоод дүрэм, журам, стандартыг бий болгохоос илүүтэй ёс зүйн ухамсар, шаардлагыг тодорхойлох чухал юм. Хиймэл оюуныг ашиглахад баримтлах Үндэсний стратегийг батлахаар ажиллаж байгаа талаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас дурдсан нь хиймэл оюуны эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Харин бизнесийн байгууллагын төлөөллүүд хиймэл оюуны зохицуулалтад анхаарлаа хандуулж эхлээгүй, дотооддоо тухайлсан зохицуулалтыг бий болгоогүй байна. Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээнд хиймэл оюуныг ашиглах нь эхэн үе шатандаа явж байгаа бөгөөд нэвтрэлт, хэрэглээний эхэн үе шатанд зохицуулалт бий болгохоос илүү хэрэглээ, ашиглалтын хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал чухал гэж үзсэнтэй холбоотойгоор зохицуулалтыг тодорхойлоогүй байна. Мөн эхэн үе шатад зохицуулалт бий болгох нь инновацийн хөгжлийг удаашруулах магадлалтайг хувийн байгууллагын зүгээс онцолж байна.

Хувийн хэвшлийн байгууллагуудад одоогоор хиймэл оюуныг хөгжүүлэх, ашиглах явцад хариуцлага хүлээлгэх этгээдийг тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг тухайлан заасан бодлогын болон үйл ажиллагааны баримт бичиг, журам заавар батлагдаагүй байна. Байгууллагууд хариуцлага, хохирлын асуудлыг Хөдөлмөрийн дотоод журам, Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам (байгаа бол)-д заасан хүрээнд зохицуулж байна.

Улс орнуудад хиймэл оюуныг хөгжүүлэх, ашиглахад баримтлах ёс зүйн зарчмыг хэрэгжүүлэх замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх механизмыг бүрдүүлэх шаардлагыг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байна. Хиймэл оюун ашиглахад удирдлага болговол зохих зарчмууд нь ардчилсан үнэт зүйлс болох хүмүүнлэг байх, хүн төвтэй байх, шударга ёс, тэгш байдалд үндэслэгдэх бөгөөд үндсэн эрхийг хамгаалахад шууд чиглэгддэг.

¹⁸³ 2020 оны "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах" тухай 52 дугаар тогтоол, <<https://legalinfo.mn/mn/detail/15406>>.

¹⁸⁴ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=211058&showType=1>>

¹⁸⁵ ЗГ-ын 2020 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл" <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=210926&showType=1>>.

¹⁸⁶ ЗГ-ын 2020 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл"-ийн 1 дүгээр зүйл, <<https://legalinfo.mn/mn/detail?lawId=210926&showType=1>>

Тухайлбал, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хувийн халдашгүй байдлыг хангах, мэдээлэл авах, хүлээн авах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчигдөөс урьдчилан сэргийлэх нь хиймэл оюуны хөгжүүлэх, ашиглалтад нэн тэргүүнд тавигдаж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хиймэл оюунд хамаарах эрх зүйн баримт бичгүүдээс, ЮНЕСКО-ийн баталсан Хиймэл оюуны ёс зүйн зөвлөмж, Үндэсний хиймэл оюуны стратеги, Европын Холбооны Хиймэл оюуны тухай хууль нь бусад улс орнуудад жишиг болохуйц баримт болж байгаа нь АНУ, Их Британи, Австрали, БНСУ-ын хиймэл оюунд хамаарах зохицуулалтуудаас харж болохоор байна.

Энэхүү баримт бичгүүдэд хүний эрхийг хангах хүрээнд дараах агуулгыг заавал зохицуулсан буюу улс орнуудын зохицуулалтын агуулга давхцаж байна. Үүнд:

1. Хүний эрхэм чанарыг хүндэтгэх. Нэг талаас, хувийн халдашгүй байдлыг хамгаалах, хувийн нууцыг хадгалах бүхий л механизм бүрдүүлэх, нөгөө талаас, хиймэл оюуны гаргасан шийдвэрийг хүн оюун дүгнэлтээрээ баталгаажуулах, гаргасан шийдвэрүүдээс сонголт хийх боломжтой байдлыг хангасан байна.
2. Тэгш байдлыг хангах. Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтаас ангид байх шаардлагыг хуулиар бэхжүүлж, хэрэгжилтийг хангавал зохино. Хүний эрхэд суурилсан үйл ажиллагааг дэмжих бодлогыг тодорхойлох нь оновчтой байна.
3. Шударга ёсыг тогтоох. Аливаа асуудалд үр дүнтэй арга хэмжээ авах буюу хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад хамаарах харилцааг олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэх зохицуулах, түүнийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтын явцад хууль дээдлэх зарчмыг баримтална.
4. Мэдээлэлд хандах эрхийг хэрэгжүүлэх. Хиймэл оюуны шийдвэр гаргалтын үйл явцын талаарх мэдээлэлд хандах эрх нээлттэй байх, шаардлагатай тохиолдолд системийг хэрхэн ажилладаг талаар урьдчилсан мэдээлэл өгөх механизмтай байх. Системийн үйл ажиллагаа, алгоритмын ил тод байдлыг хангах нь тус эрхийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
5. Хөдөлмөрлөх эрхийг бэхжүүлэх. Систем нь хүмүүсийг хувийн шинж чанараар ялгаварлах асуудлаас үүдэж ажлаас халах, цалинг бууруулах шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.
6. Хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол гаргах, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааны явц тодорхой байх. Систем нь аливаа гомдлыг шийдвэрлэх энгийн, ойлгомжтой механизмтай байх шаардлагатай.
7. Аюулгүй байдлыг хангах. Аюулгүй байдлыг систем нь мэдээллийн аюулгүй байдлыг хангаж буй эсэхэд анхаарч, эрсдэлийг байнга тодорхойлж, удирдах шаардлагатай.

Үндэсний хиймэл оюуны стратегид хүний эрхийг тусгахгүйгээс хүний эрхийн хамгаалалт янз бүрийн салбаруудад жигд бус болох эрсдэл үүсэж болзошгүй. Хиймэл оюуны сургалтыг сайжруулах, эсвэл шинэ технологи хөгжүүлэх явцад хүний эрхийг зөрчихтэй холбоотой эрсдэлүүдийг бүрэн шийдвэрлэхгүйгээр урагшлах магадлалтай учир стратегид хүний эрхийг хэрхэн хамгаалах талаар тусгасан байх шаардлагыг тусгасан байна.¹⁸⁷

Хиймэл оюуны зарим үйл ажиллагааг хориглох шаардлагатай. Хиймэл оюуны зарим үйл ажиллагааг хориглох шаардлага нь хүний эрхийг хамгаалж, нийгмийн шударга ёсыг ханган, хувийн нууцад халдах эрсдэлийг бууруулахад чиглэнэ. Тухайлбал, Нүүр царай таних систем, нийгмийн онооны үнэлгээ, хиймэл оюунд суурилсан хяналтын технологиуд зэрэг нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, хууль ёсны үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах, хэт хяналт тавих, шударга бус шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлдэг. Ийм төрлийн хиймэл оюуны

¹⁸⁷ Үндэсний хиймэл оюуны стратеги ба хүний эрх: тойм, 2020 он, 2 дахь тал, <https://www.gp-digital.org/wp-content/uploads/2020/04/National-Artificial-Intelligence-Strategies-and-Human-Rights%E2%80%94Review_.pdf> (2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хандсан.)

хэрэглээ нь нийгэмд айдас, түгшүүр төрүүлж, ардчиллын үнэт зүйлсийг сулруулах аюултай тул хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт хийхээс гадна, зарим тохиолдолд бүрэн хориглох нь зүйтэй. Тухайлбал, Европын холбооны “Хиймэл оюуны тухай хууль”-иар дараах үйл ажиллагааг хориглосон байна¹⁸⁸. Үүнд:

1. Хүний ухамсраас давсан далд арга техникийг ашиглах буюу зориудаар хууран мэхлэх зорилготой бүтээгдсэн, эсвэл тухайн хүн, эсвэл бүлэг хүмүүсийн хэзээ ч гаргахгүй байсан шийдвэрийг гаргах нөхцөлийг бүрдүүлэх замаар тэдэнд эсвэл бусдад их хэмжээний хохирол учруулах хиймэл оюун ухааны системийг үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах;
2. Хувь хүн, эсвэл тодорхой бүлэг хүмүүсийн нас, хөгжлийн бэрхшээл эсвэл нийгэм, эдийн засгийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан үүссэн аливаа сул талыг ашиглаж, тэдний зан байдлыг гажуудуулах зорилготой хиймэл оюун ухааны системийг үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах;
3. Анхдагч цуглуулсан өгөгдөл нь нийгмийн хандлагад үндэслэсэн бөгөөд цуглуулсан мэдээлэлтэй холбоогүй хувь хүн, эсвэл бүлэг хүмүүсийг сөрөг буюу тааламжгүй байдлаар үнэлж, шударга бус байдлыг бий болгох хиймэл оюун ухааны системийг үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах;
4. Хүний царайны дүрслэлийг интернэт, эсвэл хяналтын камерын бичлэгээс ямар нэгэн зорилгогүйгээр татан авах замаар нүүр таних өгөгдлийн санг үүсгэх, өргөжүүлэх зорилготой хиймэл оюун ухааны системийг үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах;
5. Хүний биометрийн өгөгдөлд суурилж, түүний улс төрийн үзэл бодол, гишүүнчлэл, шашин шүтлэг эсвэл философийн итгэл үнэмшил, бэлгийн чиг баримжаа зэргийг таамаглах, үнэлэх зорилгоор бүтээгдсэн хиймэл оюун ухааны системийг үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах гэх мэт.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хиймэл оюуны технологийг төрийн үйлчилгээ, санхүү, эрүүл мэнд, хүний нөөцийн удирдлага, хэл шинжлэл зэрэг олон салбарт нэвтрүүлж байгаа боловч хууль эрх зүйн орчин, ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, өгөгдөл хамгаалах бодлого хязгаарлагдмал буюу байхгүйгээс үүдэн эдгээр технологиуд хүний эрхийг зөрчих эрсдэлийг үүсгэж болзошгүй эсэхэд үнэлгээ хийх шаардлагатай.

Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой харилцааг ХХМХтХ-иар зохицуулж байна. Тус хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж буй аливаа этгээд (цаашид “Мэдээлэл хариуцагч” гэх) нь хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан (1) мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах, (2) хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах нөхцөлд үнэлгээ хийх зохицуулалттай.

Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/81 дүгээр тушаалаар баталсан. Тус журамд Мэдээлэл хариуцагч нь өөрөө, эсхүл хөндлөнгийн этгээдээр тодорхой аргачлалын дагуу үнэлгээ хийлгүүлэхээр заасан боловч холбогдох аргачлалыг журамлаагүй байна. Харин журмын хавсралтаар “Хувийн мэдээллийг хүний оролцоогүй боловсруулах технологийн хүний эрхийн нөлөөллийг үнэлэх маягт” батлагджээ. Мэдээлэл хариуцагч нь үнэлгээ хийх үйл ажиллагааг тогтмол хийхгүй байгаад журмын процессын зохицуулалт хэт ерөнхий, үнэлгээ нь зөвхөн маягтад тулгуурласан, ямар аргачлалаар үнэлгээг хийх талаар зохицуулаагүй байгаа зэрэг нь сөргөөр нөлөөлж байна.

Тодруулбал, ХХМХтХ-ийн 23 дугаар зүйл болон үнэлгээ хийх журамд “Хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулах хийх технологи” гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь олон нийтэд хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хамрах эсэх нь

¹⁸⁸ Хиймэл оюуны тухай хууль, <<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32024R1689>>, (2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хандсан.)

тодорхойгүй байдлыг үүсгэжээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй журамд Мэдээлэл хариуцагч нь маягтыг бөглөөд Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлж, зөвлөмж гаргуулах талаар зохицуулсан.

Үүнээс үзвэл, хүний эрхийн нөлөөллийн үнэлгээний үр дүнг гаргах, эрсдэлийн түвшнийг эцсийн байдлаар тодорхойлох эрх бүхий этгээд тодорхойгүй байгаагаас гадна Хүний эрхийн үндэсний комисс үнэлгээг хүлээн аваад хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх эсэх, хүний эрхийн зөрчил үүсэж болзошгүй тохиолдолд тухайн технологийг ашиглуулахгүй байх шийдвэр гаргах бүрэн эрхтэй этгээд мөн эсэх, эсхүл хэлбэрийн төдий зөвлөмж өгч, технологийн ямар ч тохиолдолд ашиглуулахыг зөвшөөрөх эсэх нь холбогдох хууль, журмаар тодорхой зохицуулаагүй байна.

3.4. ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХИЙДЭЛ, ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, 17 дахь хэсэгт “...Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж хуульчилсан. Монгол Улсын олон улсын гэрээ болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл,¹⁸⁹ Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйл,¹⁹⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 22 дугаар зүйлд¹⁹¹ мөн энэхүү эрхийг баталгаажуулсан.¹⁹²

Хүний халдашгүй чөлөөтэй байх, хувийн мэдээллээ хамгаалуулах эрхийг хангах зорилгоор Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, 1995 онд баталсан Хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болгосон.¹⁹³ Хувь хүний нууцын тухай хуулиар “хувийн нууц” гэх ойлголтыг “хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйл” хэмээн тодорхойлж, хууль бусаар задруулсан бол шүүхэд гомдол гаргах эрхийг баталгаажуулсан байв.

Мэдээлэл, өгөгдөл нь хувийн нууцын хэсэг бөгөөд орон байр, гэр бүл, эд хөрөнгө, захидал харилцаа зэрэг биет зүйлс ХХМХТХ-иар хамгаалагдаагүй болно. Өөрөөр хэлбэл, хувийн нууц нь мэдээлэл, захидал харилцаа, биет зүйлийг багтаасан өргөн ойлголт тул Хувь хүний нууцын тухай хуулийг хүчингүй болгосон нь Монгол Улсын иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн баталгааг сулруулсан эсэхийг нухацтай тодорхойлох нь зүйтэй. Халдашгүй байх эрхийн баталгаа суларсан эсэх нь Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор хувийн нууцад хамаарч болох мэдээллээс бусад эд зүйлсийг хэрхэн хамгаалсан байгаагаас хамаарах юм.

ХХМХТХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар тус хуулийн зорилго нь “хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулах” бөгөөд 5 дугаар зүйлд мэдээллийг “хуульд заасан үндэслэлээр

¹⁸⁹ ИБУТЭТОУП-ын 17.1 дэх хэсэгт “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.” гэж, 17.2 дахь хэсэгт “Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй”.

¹⁹⁰ ХЭТК-ийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй”.

¹⁹¹ ХБХЭТК-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг “Амьдран буй газар, орон байрны нөхцөл байдлаас нь үл шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох орон байр буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд халдлага буюу өртөлтөөс хуулийн дагуу хамгаалагдана”.

¹⁹² 2013 онд байгуулсан Европын Холбоо-Монгол Улсын ерөнхий хэлэлцээрт Монгол Улс Европын Холбоотой өгөгдөл хамгааллыг хамгийн өндөр түвшинд хүргэх чиглэлээр хамтран ажиллах үүрэг хүлээсэн байна.

¹⁹³ 2005 онд баталсан Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлд захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн нууц болон бусад нууц гэж ангилж, хамгаалж байсан.

эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах” зарчмыг хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, ХХМХТХ мэдээллийн эзэн ба мэдээлэл хариуцагч, мэдээлэл боловсруулагч нарын хооронд үүссэн хүний хувийн мэдээлэлтэй холбоотой харилцааг зохицуулна. Харин хүний хувийн мэдээллийг уг хуулийн хүрээнд үл хамаарах байдлаар, тухайлбал, мэдээллийг хууль бусаар олж авах, задруулах, дамжуулах, олон нийтийн сүлжээнд нийтлэх зэргээр хүний мэдээллийг “ашигласан” тохиолдолд ХХМХТХ үйлчлэхгүй.

3.4.1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хийдэл

ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизм сул байгаа нь уг хуулийн үндсэн хийдэл юм. ХХМХТХ-иар мэдээллийн эзэн нь өөрийн хувийн мэдээлэлтэй холбоотой хорь гаруй субьектив эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан боловч эдгээр эрхийг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар бүрэн дүүрэн тогтоогүйгээс мэдээллийн эзэнд их хэмжээний хохирол учруулж болзошгүй цөөнгүй эрхийн зөрчилд хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.¹⁹⁴

Мэдээллийн эзэн гэж ХХМХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад заасан мэдээллээр тодорхойлогдох хүн¹⁹⁵ бөгөөд түүний хууль ёсны төлөөлөгч нь уг хуулийн дагуу хорь гаруй төрлийн субьектив эрх хэрэгжүүлнэ.¹⁹⁶ Мэдээлэл хариуцагч гэж мэдээллийг анх цуглуулах зорилгыг тодорхойлж буй этгээд бөгөөд төрийн байгууллага, хуулийн этгээд, хувь хүн байж болно.¹⁹⁷ Мэдээллийн эзэн ХХМХТХ-иар тогтоосон эрхээ мэдээлэл хариуцагч, боловсруулагч нараас шаардах эрхтэй, зөрчигдсөн тохиолдолд эрхээ сэргээлгэхээр цагдаагийн байгууллага, иргэний хэргийн шүүх, төрийн захиргааны байгууллага, ХЭҮК-т гомдол, мэдээлэл, нэхэмжлэл гаргахаар хуульчилсан юм. Гэвч эдгээр механизмууд тус бүрдээ тулгамдсан дараах асуудалтай тул ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх үр дүнтэй хэрэгсэл болж чадахгүй байна.

Эрүүгийн хууль

Эрүүгийн хуульд ХХМХТХ-иар хамгаалагдах объектод холбоотой зургаан төрлийн гэмт хэргийг хуульчилсан боловч тэдгээр гэмт хэрэг ХХМХТХ-тай уялдаагүй, мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагч, боловсруулагчийн үүрэг ноцтой зөрчигдсөн зарим тохиолдлыг гэмт хэрэгт тооцоогүй байна. Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйл (зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах), 13.10 дугаар зүйл (хувь хүний нууцад халдах), 13.11 дүгээр зүйл (хувь хүний нууцыг задруулах), 13.12 дугаар зүйл (хууль бусаар мөрдөж мөшгөх), 13.14 дүгээр зүйлд (худал мэдээлэл тараах), 14.8 дугаар зүйл (сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах)-ээр тогтоосон гэмт хэрэг нь хүний хувийн халдашгүй байдлыг хамгаалах зорилготой.¹⁹⁸

¹⁹⁴ Зөрчлийн тухай хуулийн 6.22 дугаар зүйл “Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны дүрсний бичлэг хийх”, 6.27 дугаар зүйлд “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих” гэсэн 2 төрлийн зөрчлийг тусгасан байна.

¹⁹⁵ ХХМХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “Мэдээллийн эзэн” гэж энэ хуулийн 4.1.11 дахь заалтад заасан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүнийг, Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд заасан, хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд заасан иргэн бол түүний хууль ёсны төлөөлөгчийг мэдээллийн эзэн гэж тодорхойлно.

¹⁹⁶ “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизмын үнэлгээ” сэдэвт судалгаа, УБ, 2025 он. Субьектив эрх нь нэгэнт олгогдсон бол тухайн эрх бүхий этгээд уг эрхээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд хэрвээ уг эрхээ хэрэгжүүлж чадаагүй эсхүл уг эрхийг нь зөрчсөн бол хариуцлагын арга хэмжээ мэдээлэл хариуцагч болон боловсруулагчид оногдоно. Жишээ нь мэдээлэл өгөхөөс татгалзах, мэдээлэл ашиглах талаар зөвшөөрөл өгөх, мэдээлэл устгуулах мэдээлэл дамжуулж буй зорилгыг мэдэх, алдаатай мэдээллийг засуулах, өөртэй нь холбогдолтой мэдээллийг хуулбарлах авах гэх мэт.

¹⁹⁷ ХХМХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад “мэдээлэл хариуцагч” гэж хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хэлнэ.

¹⁹⁸ Эрүүгийн хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг нь хүний цахим мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт мөн боловч хүний хувийн мэдээллийн харилцаа бус кибер орчинд хууль бусаар халдсан гуравдагч этгээдийн үйлдэлд хамаарч байх тул энэхүү дүн шинжилгээнд тусгаагүй. Мэдээллийн эзэн ба мэдээлэл хариуцагч, мэдээлэл боловсруулагч нарын хооронд ХХМХТХ-ийн дагуу үүссэн харилцааг хүний хувийн мэдээллийг хамгаалах харилцаа гэж тодорхойлоо.

Гэвч ХХМХтХ батлагдсантай холбоотой Эрүүгийн хуульд цөөн тооны нэмэлт, өөрчлөлт орж, хувь хүний нууцыг задруулах зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг найруулсан. Гэвч Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлгийн заалтууд ХХМХтХ-ийг хэрэгжиж эхлэхээс өмнө үйлчилж байсан тул уг хуулийн үзэл санаа, хамгаалагдсан хууль ёсны эрх ашгийг гүйцэд тусгаж чадаагүй юм. Жишээлбэл, зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах гэмт хэрэг нь хэдийгээр мэдээллийн эзний нүүр царай, дуу хоолой зэрэг биометрик мэдээллийг хамгаалж буй мэт боловч уг гэмт хэргийн нөхцөл нь оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны дүрсийг авч, олон нийтэд тараах тул юуны түрүүнд орон байрны халдашгүй байдлыг хамгаалах зорилготой.

Түүнчлэн, худал мэдээлэл тараах гэмт хэргийн хамгаалах объект нь хүний халдашгүй байдал, нэр төр, ажил хэргийн нэр төр, тэдгээртэй холбоотой мэдээлэл боловч худал мэдээлэл тараасан этгээд (хүн, хуулийн этгээд) эх сурвалжаа нотолсон тохиолдолд тараагдсан мэдээлэл хувийн нууц эсэхээс үл хамаарч, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангахгүй, гэмт этгээд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөлийг бий болгож байна. Энэ нь ХХМХтХ-иар хамгаалсан мэдээллийн эзний эрхийг хамгаалах бус, иргэн болон хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндэд хохирол учруулахаас сэргийлэх зорилготой тул хүний хувийн мэдээллийг хамгаалах үр дүнтэй механизм биш болно.

ХХМХтХ-иар үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, ял шийтгэл, эд хөрөнгийн талаарх мэдээллийг хувийн нууцад тооцогдоогүй тул эдгээр эмзэг мэдээллийг задруулсан, халдсан үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Эрүүгийн хуулиар тогтоосон хувь хүний нууцад халдах, хувь хүний нууцыг задруулах гэмт хэргийн “хувийн нууц” гэх ойлголтыг ХХМХтХ-ийг баримтлан тодорхойлно. Тодруулбал, Хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн болон хуулиар тогтоосон бусад нууц гэсэн таван агуулгын хүрээнд тодорхойлж байсан энэ ойлголтыг 2022 оноос хойш ХХМХтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг баримтлан “эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээллийг гэж тодорхойлох болсон. Харин үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх мэдээлэл буюу ХХМХтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаас бусад эмзэг мэдээллийг хувь хүний нууцад хамааруулахгүй, Эрүүгийн хуулиар хамгаалаагүй болно.

“Хувь хүний нууц” гэх ойлголтыг ХХМХтХ-д тодорхойлсноор тайлбарлаж, гэмт хэргийг мөрдөх, зүйлчлэх боловч энэ тодорхойлолтыг мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэхгүй байх, мөн “хувийн нууц” гэх ойлголтыг ХХМХтХ-иар хуульчилсан хүрээ нь хувь хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй бүх мэдээлэл, баримт бичиг, биет зүйлсийг хамруулж чадаагүй учраас хувь хүний нууцад халдах, задруулах гэмт хэргийн зүйлчлэл оновчгүй байх, гэмт этгээд хариуцлагаас мултрах үндэслэл болж болзошгүй байна.

Тохиолдол 3.10

...Эрүүгийн хуульд тусгагдсан 6 төрлийн гэмт хэрэг практикт харьцангуй бага хянан шалгаагдаж байгаа ба зарим нэг тодорхойгүй ойлголт, ХХМХтХ-ийн тайлбар хангалтгүйгээс хэрхэн яаж зүйлчлэх нь нэг мөр шийдэгдээгүй тохиолдлууд байдаг. Тухайлбал, ХХМХтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт нууц мэдээлэл дунд бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийллийг дурдсан байдаг. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аль ч хуульд бэлгийн болон хүйсийн чиг баримжааг тайлбарласан зохицуулалт байхгүй.¹⁹⁹

(УЕПГ-ын прокуроруудтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Хүний хувийн мэдээлэлд хамаарах гэмт хэрэгт оногдуулах ялыг харьцангуй багаар тогтоосон нь ХХМХтХ-ийн хэрэгжилтийг хангах Эрүүгийн хуулийн арга хэрэгслийн үр нөлөөг бууруулж болзошгүй. Тодруулбал, эдгээр гэмт хэрэгт үйлдлийн хор уршгаас хамаарч 450-27000 нэгжээр торгох, 1 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрх хязгаарлах, 240 цагаас

¹⁹⁹ “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизмын үнэлгээ” сэдэвт судалгаа, 2025 он.

2 жил хүртэл нийтэд тустай ажил хийлгэх, 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих, нийтийн албанд ажиллах эрхийг 1-3 жил хүртэл хасаж 1350-10000 нэгжээр торгох ял оногдуулж байна. Харин бусад улс орнууд хүний хувийн мэдээллийн эрхийг ноцтой зөрчсөн бүх үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож, гэмт үйлдэлд харьцангуй өндөр хариуцлага тогтоожээ. 2016 онд Европын Парламентаас баталсан ЕХХХМХЕЖ-ын 83 дугаар зүйлд заасан зөрчлүүдэд (хувийн мэдээллийг гуравдагч улс эсвэл олон улсын байгууллагад дамжуулсан, хяналтын байгууллагын шийдвэрийг биелүүлээгүй, мэдээллийг анх авсан зорилгоос өөрөөр ашигласан, мэдээлэл алдагдсан задарсан хүний тоо, учирсан хор хохирлын хэмжээ, зөрчлийн шинж чанар, хүндийн зэрэг, хохирсон хугацаа, зөрчлийн санаатай буюу болгоомжгүй байдлаар үйлдсэний улмаас хүний эрх зөрчигдсөн) хуулийн этгээдэд 10 сая хүртэлх евро эсхүл дэлхий даяарх жилийн орлогынх нь хоёр хувьтай тэнцэх хэмжээний евро, илүү ноцтой зөрчлүүдэд 20 хүртэлх сая евро, дэлхий даяарх жилийн орлогынх нь дөрвөн хувьтай тэнцэх еврогийн аль өндрөөр нь торгох зохицуулалттай байна.²⁰⁰

ХБНГУ, Итали зэрэг улсуудад хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй гуравдагч этгээдэд дамжуулах, хууль зүйн үндэслэлгүй, мэдээллийн эзний зөвшөөрөлгүй ашиг олох зорилгоор ашигласан бол хорих ял оногдуулахаар зохицуулжээ.²⁰¹ Энэ мэтчилэн хувийн мэдээллийг хууль бусаар, өөртөө ашиг олох зорилгоор бусдад дамжуулсан, шилжүүлсэн, худалдсан, гадаад улс руу дамжуулсан, цугларсан, боловсруулсан хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах үүргээ зөрчсөний улмаас хохирол учирсан тохиолдолд хүлээлгэх зохицуулалтыг Эрүүгийн хуульд тусгах боломжтой.

Хувийн нууцад халдсан, задруулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, мөрдөн шалгасан, шүүхээр шийдвэрлэсэн тохиолдол харьцангуй цөөн байгаа нь хувийн нууц, хувийн мэдээллийн зөрчил, зөрчигдсөн эрхээ сэргээх талаар олон нийтийн ойлголт муу байгаатай холбоотой. Түүнчлэн, энэ байдал нь Эрүүгийн хуулиар хамгаалбал зохих мэдээллийн эзний эрх хамгаалагдаагүй учраас хариуцлагын бодит үр нөлөө хангалтгүй байгааг илтгэж байна. Тухайлбал, сүүлийн 4 жилд хувь хүний нууцад халдсан талаар нийт 33 гомдол цагдаагийн байгууллагад ирснээс 27 гомдлыг хаасан, 6 гомдолд яллагдагчаар татсан, “хувь хүний нууцыг задруулах” гэмт хэргийн талаар 39 гомдол хүлээн авснаас 31-ийг хааж, 8 гомдолд яллагдагчаар татсан байна.²⁰² Эдгээр гэмт хэргийн талаарх нийт гомдлын 90 хувь нь мөрдөх ажиллагааны явцад хаагдаж байгаа бөгөөд захидал харилцааны нууц задруулсан хэргийг шүүх зонхилон шийдвэрлэсэн байна. Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлэгт²⁰³ заасан гэмт хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд гэмт үйлдлийн улмаас учирсан эдийн болон эдийн бус хохирлыг тооцож, гэм хорыг арилгуулах асуудлыг анх гомдол гаргахдаа тавьсан тохиолдол цөөн байна.

²⁰⁰ ЕХХХМХЕЖ, Европын холбооны хүний хувийн мэдээлэл хамгаалах ерөнхий журам 2016/679. <https://gdpr-info.eu/>

²⁰¹ Итали Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн 167 дугаар зүйлд “Хувийн мэдээллийг хууль бусаар боловсруулах” гэмт хэргийг “хэрвээ аль нэг этгээд бусдын хувийн мэдээллийг өөртөө ашиг олох зорилгоор, санаатайгаар хуульд заасан хувийн мэдээлэл боловсруулах үндэслэлийг зөрчиж буюу хууль бусаар боловсруулсны улмаас хохирол учирсан бол хүндрүүлэх нөхцөлийг тооцвол 6 сараас 24 сар хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэхээр хуульчилжээ. Мөн тус хуулийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжит арга хэмжээ авах үүргийг мэдээлэл хариуцагч зөрчсөн бол 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял эсхүл 10,000-аас 50,000 еврогоор торгох шийтгэлийг хуульчилсан байна. <<https://www.privacy.it/archivio/privacycode-en.html#sect167>>. ХБНГУ-ын хувийн мэдээлэл хамгаалах хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар санаатайгаар болон аливаа зөвшөөрөлгүйгээр их хэмжээний хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд шилжүүлсэн болон арилжааны зорилгоор бусад байдлаар ил болгосон бол буруутай этгээдийг 3 жил хүртэлх хугацаагаар хорих ял онооно. Мөн бусдад ил болоогүй хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр боловсруулсан эсхүл хууль бусаар олж авсан бол хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял оноох ял шийтгэлийг хуульчилсан байна. Холбооны мэдээлэл хамгаалах тухай хууль, Холбооны хууль эрх зүйн мэдээллийн сан, р. 2097, р. 1858; р. 1045.

²⁰² ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 11/8985 тоот албан бичиг.

²⁰³ Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйл (зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах), 13.10 дугаар зүйл (хувь хүний нууцад халдах), 13.11 дүгээр зүйл (хувь хүний нууцыг задруулах), 13.12 дугаар зүйл (хууль бусаар мөрдөж мөшгөх), 13.14 дүгээр зүйлд (худал мэдээлэл тараах), 14.8 дугаар зүйл (сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах).

Зөрчлийн тухай хууль

ХХМХтХ-ийн хэрэгжилтийг хангуулах Зөрчлийн тухай хуулийн арга хэрэгсэл хангалтгүй байна. ХХМХтХ батлагдахын хамт “хүний хувийн мэдээллийг мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авсан зорилгоос өөр зорилгоор ашигласан”, “мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлсэн”, “хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан” зэрэг үйлдлийг зөрчлөөр тооцон тус хуулийн 6.27 дугаар зүйлийг нэмсэн.²⁰⁴ Мөн уг хуулийн “зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх” гэх 6.22 дугаар зүйлд “оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа айл, өрхийн орох, гарах хэсгийг хамруулан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн”, “дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад үзүүлсэн, эсхүл хуулбарлаж өгсөн”, “хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулж, бичлэг хийсэн” үйлдлийг нэмсэн болно.

Гэвч Зөрчлийн тухай хуулийн эдгээр заалтууд ХХМХтХ-иар тогтоосон мэдээллийн эзний хорь гаруй эрхийн хэрэгжилтийг хангахад хязгаарлагдмал юм. Тухайлбал, бодит байдалд түгээмэл гардаг дараах үйлдлүүдийг Зөрчлийн тухай хуульд тусгах шаардлагатай. Үүнд:

- Шаардлагад нийцээгүй зөвшөөрлийн маягтаар зөвшөөрөл авсан (ХХМХтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалт);
- Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзний хуульд заасан хүсэлтийг санаатайгаар хангаагүй (ХХМХтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт);
- Мэдээлэл хариуцагч хуульд заасан үүргээ зөрчсөн (18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг);
- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашигласан, мэдээллийн эзэн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн (ХХМХтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 болон 12.3 дахь хэсэг);
- Хуульд заасан нөхцөл бүрдсэн байхад мэдээллийн эзний мэдээллээ устгуулах хүсэлтийг хангаагүй (ХХМХтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт);
- Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд мэдэгдэл өгөх үүргээ зөрчсөн (ХХМХтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг);
- Мэдээлэл боловсруулагч мэдээлэл цуглуулах, боловсруулахад илэрсэн зөрчлийг мэдсэн даруйд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлэл хариуцагчид мэдэгдэх үүргээ зөрчсөн (ХХМХтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг);
- Мэдээллийг хуульд заасны дагуу олж мэдсэн этгээд бусдад задруулсан бол зөрчилд тооцох (ХХМХтХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг).

Ихэнх тохиолдолд ХХМХтХ-ийг хуулийн этгээд зөрчиж байгаа тул Зөрчлийн тухай хуулийн 6.22, 6.27 дугаар зүйлээр тогтоосон хоёроос хорин сая төгрөгөөр торгох шийтгэл нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад үр нөлөөтэй байж чадахгүй байна. Гэтэл дэлхийн улс орнуудын жишгээр хувийн мэдээлэл хамгаалах хуулийг хэрэгжүүлэх хариуцлагын үндсэн механизм нь өндөр хэмжээний торгууль байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.27 дугаар зүйлд заасан зөрчлийн талаар гаргасан гомдлын тоо нэмэгдэж байна. ЦЕГ-ын мэдээлснээр 2022, 2023 онд хялбаршуулсан журмаар тус бүр хоёр гомдол шийдвэрлэсэн бол 2024 оны эхний 10 сарын байдлаар зөрчлийн хэрэг нээж шалгасан 10 зөрчлөөс 5 зөрчлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.²⁰⁵ Шийтгэл

²⁰⁴ Зөрчлийн тухай хуулийн 6.27 дугаар зүйл “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих”.

²⁰⁵ ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 11/8985 тоот албан бичиг.

оногдуулсан зөрчилд 1,000,000-2,500,000 төгрөгөөр торгох арга хэмжээ авсан байна. УЕПГ-ын мэдээллээр 2022 оноос 2024 оны 10 сарын байдлаар Зөрчлийн тухай хуулийн 6.27 дугаар зүйлд заасан зөрчлийн хэрэг 54, түүнээс хэрэгсэхгүй болгосон 20, шийтгэл оногдуулсан 31 тохиолдол байгаагаас 2024 онд хамгийн их буюу 20 зөрчлийг шийдвэрлэжээ.²⁰⁶

Төрийн албаны тухай хууль

ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангах удаах механизм нь Төрийн албаны тухай хууль (ТАТХ) боловч зохицуулалт нь тодорхой биш байгаагаас бодитой үр дүн гарахгүй байна. Төрийн албан хаагчийн гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй, ХХМХТХ-ийг зөрчсөн үйлдэлд ТАТХ-д заасны дагуу хариуцлага оногдуулахаар ХХМХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгээр хуульчилсан юм.²⁰⁷

ХХМХТХ батлагдсанаар ТАТХ-д хүний хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтууд тусгагдаагүй болно. Харин ТАТХ-ийн төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг зохицуулсан 37 дугаар зүйлийн 37.1.9 дэх заалтад “албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойших хугацаанд төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг чандлан хадгалах, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх” гэсэн өөрчлөлт орсон. Энэ үүргийг зөрчсөн тохиолдолд зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэн эсэхийг нь харгалзан төрийн албан хаагчид ТАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан өөрт нь ганцаарчлан сануулах, нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, төрийн албанаас халах, төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах болон хуульд заасан бусад төрлийн сахилгын шийтгэл оногдуулдаг. Эдгээр сахилгын шийтгэлийг төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтан, хамтын удирдлага бүхий байгууллага томилсон бол тухайн байгууллагын дарга хүлээлгэхээр хуульчилсан байна.²⁰⁸

Харин ТАТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1.9 болон ХХМХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгээр Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас түлхүүр үгийн хайлт хийхэд шийдвэрлэгдсэн хэрэг маргаан 2025 оны 01 дүгээр сарын байдлаар байхгүй байна. Төрийн албаны тухай хуульд хүний хувийн мэдээллийг хамгаалах, тус хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусгаагүйгээс энэ төрлийн маргаан үүсэхгүй байх магадлалтай.

Хөдөлмөрийн тухай хууль

ХХМХТХ-тай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд цөөнгүй нэмэлт өөрчлөлт орж, хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтуудыг тусгажээ. Тухайлбал, ажил олгогч ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглахад тавигдах нийтлэг шаардлага, ажилтны мэдээллийг авах, боловсруулах, хадгалах, ашиглах журам батлах үүргийг хуульчилж, ажилтны мэдээллээ хамгаалуулах эрхийг баталгаажуулсан. Мөн хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглож, хөдөлмөрийн харилцаа үүсэх, үргэлжлэх явцад ажил олгогч ажилтнаас ажил үүрэгтэй нь холбогдолгүй аливаа асуулт асуух, мэдээлэл цуглуулах, хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд эрүүл мэндийн болон сэтгэцийн эмгэг, хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгүүлэх, жирэмсэн эсэхийг тодруулахыг Хөдөлмөрийн тухай хуулиар хориглосон.²⁰⁹ Өөрөөр хэлбэл, эдгээр зохицуулалтын дагуу ажил олгогч ажилтны хувийн болон эмзэг

²⁰⁶ УЕПГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/7458 тоот албан бичиг.

²⁰⁷ ТАТХ-иар төрийн жинхэнэ албан хаагч, үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоосон. Хуульд өөрөөр заагаагүй бол ТАТХ нь улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид мөн хамаарна. Харин үйлчилгээний ажил, албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг.

²⁰⁸ Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 2017 он.

²⁰⁹ Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг.

мэдээллийг шаардах эрхгүй болсон юм. Мөн ажил олгогчид ажилтны эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах,²¹⁰ ажилтны хувийн нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээлгэж,²¹¹ ажил олгогчид байгаа мэдээллээ үнэ төлбөргүй, бүрэн авах, өөрийн талаарх буруу, эсхүл дутуу мэдээллийг залруулахыг ажил олгогчоос шаардах, мэдээллийг нь хууль бусаар авсан, боловсруулсан, хадгалсан, ашигласан, дамжуулсан бол эрх бүхий байгууллагад гомдол гаргах ажилтны эрхийг баталгаажуулсан болно.²¹²

ХХМХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалтын дагуу уг хуулийг зөрчсөн төрийн үйлчилгээний алба хаагч, бусад ажилтны гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй үйлдэлд Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэж болно. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээ, дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцож,²¹³ ганцаарчлан сануулах, нийт ажилтанд нь зарлах хэлбэрээр нээлттэй сануулах, үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, албан тушаал бууруулах, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах зэрэг сахилгын шийтгэл хүлээлгэхээр Хөдөлмөрийн тухай хуульд заажээ.²¹⁴ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд авагдсан мэдээллийн хүрээнд ХХМХТХ зөрчсөнтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулсантай холбоотой хэрэг маргаан 2025 оны 01 дүгээр сарын байдлаар шийдвэрлэгдээгүй байна.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь ажилтан, ажил олгогчийн байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хариуцлага тооцох нөхцөлүүдийг тодорхойлох боломжтой өвөрмөц харилцаа юм. Иймээс ажил олгогчид байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон бусад баримт бичигт ХХМХТХ-ийн зөрчлийг сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болгох боломжтой. Энэ хүрээнд Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.4 дэх заалтад заасны дагуу ХХМХТХ-д заасан үүргүүдийг зөрчсөн тохиолдолд хөдөлмөрийн харилцааг цуцлах ноцтой зөрчил болгон хөдөлмөрийн гэрээнд тусгах замаар хариуцлага хүлээлгэх боломжтой. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хугацаанд ХХМХТХ-д заасан үүргээ зөрчсөний улмаас хөдөлмөрийн харилцааг цуцалсан талаарх нэг маргаан байв.

Тохиолдол 3.11

...Х байгууллагын ажилтан нь сонгон шалгаруулалтад орсон иргэний CV, боловсролын мэдээлэл, англи хэл дээр бичигдсэн судалгааны багийн гишүүний туршлагын талаарх мэдээллийг нэрийг нь оруулалгүй өөрийн facebook хаягт байршуулж, үзэл бодлоо илэрхийлсэн. Тус мэдээллийг мэдээллийн эзэн мэдсэнээр ажил олгогчид өөрийнх нь нэр хүндэд нь халдсан тухай гомдол гаргасан.

Гомдлын дагуу ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, мөн хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.4, ХХМХТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг үндэслэсэн тухайн ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалсан. Уг шийдвэрийг ажилтан үндэслэлгүй гэж үзэн шүүхэд ханджээ. Шүүх тухайн мэдээлэл нь байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон, мөн мэдээлэлд хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг нэрлэн зааж, шууд тодорхойлж, хүний хувийн мэдээллийг тараасан гэх үйлдлийг нотолсон баримт авагдаагүй байна гэж дүгнэжээ. Зөвлөх үйлчилгээний зарын дагуу ирүүлсэн материал, гэрээ байгуулсан талаарх мэдээллийг ажил олгогч нууцлаагүй, ажилтнууд үзэх боломжтой байсан тул ажилтан уг мэдээллийг нууц болохыг мэдэх боломжгүй байсан гэж шүүх дүгнэсэн байна. Ажилтныг ажилд нь эргүүлэн тогтоож, хариуцагчаас ажилгүй байсан хугацааны цалин, хөлстэй тэнцэх олговор гаргуулж, эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлж, төлснийг баталгаажуулахыг хариуцагчид даалгаж шийдвэрлэжээ.

(Шүүхийн шийдвэрийн цахим сангаас)

²¹⁰ ХХМХТХ-ийн 43 дугаар зүйлийн 43.2.4 дэх заалт.

²¹¹ ХХМХТХ-ийн мөн зүйлийн 43.2.5 дахь заалт.

²¹² ХХМХТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-46.3 дахь хэсэг.

²¹³ Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 дэх хэсэг.

²¹⁴ Мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.3 дахь хэсэг.

Энэ шийдвэрээс шүүх хүний хувийн мэдээлэл мөн эсэхийг дүгнэхдээ хүнийг нэрлэн зааж, шууд тодорхойлж буй эсэхээр тайлбарласан байна. Харин ХХМХтХ-д "хүний хувийн мэдээлэл" гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг ойлгохоор хуульчилсан билээ.²¹⁵ ХХМХтХ-иар тодорхойлсон нэр томъёо, ойлголтыг зөв тайлбарлаж, хэргийг шийдвэрлэх шүүхийн практик тогтоох нь халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангахад ач холбогдолтой юм.

Иргэний хууль

Мэдээллийн эзэн өөрийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, бусдын хууль бусаар учруулсан хохирол болон эдийн бус гэм хорыг арилгуулах эрхийг ХХМХтХ-ийн 16 дугаар зүйлд хуульчилсан бөгөөд энэ эрхийг Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж замаар хэрэгжүүлэх боломжтой. Иргэний хуулийн мөн зүйл²¹⁶-ээр хувийн нууцад хамааралтай мэдээг эзний зөвшөөрөлгүйгээр тараасан, хүний дүрсийг гэрэл зураг, дүрс бичлэг, хөрөг зураг зэрэг хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс учирсан гэм хорыг шаардах эрхийг хуульчилжээ.²¹⁷ Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хооронд эдийн бус гэм хорыг арилгах агуулгатай 116 хэрэг шийдвэрлэсэн байх бөгөөд ХХМХтХ-ийн дагуу мэдээллийн эзэн өөрийн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзэж бусдын хууль бусаар учруулсан хохирол болон эдийн бус гэм хорыг нэхэмжилсэн маргаан байхгүй байна. Энэ нь хүний хувийн мэдээллийг хамгаалах Иргэний хуулийн механизмын талаар олон нийтийн мэдэхгүй байгаатай холбоотой.

Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага

Хувийн мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага (МХБ)-ыг нэг мөр тогтоогоогүй нь ХХМХтХ-ийн дараах үндсэн хийдэл болно.²¹⁸ ХХМХтХ-ийн "Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага" гэх зургадугаар бүлэгт ХЭҮК, ЦХИХХЯ, төрийн бусад байгууллагын хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийг заасан бөгөөд аль нэг байгууллагыг МХБ гэж нэрлэн хуульчлаагүй юм.

ХХМХтХ-ийн 26 дугаар зүйлийн дагуу төрийн байгууллагууд нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавих үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, прокурорын байгууллага, Монополын эсрэг газар, ТЦҮЗГ, ХХЗХ зэрэг байгууллагууд өөрсдийн чиг үүргийн хүрээнд хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.²¹⁹ ЦХИХХЯ нь ХХМХтХ-д заасан МХБ мөн боловч уг асуудлыг хариуцсан бүтэц, ажилтан байхгүй, үйл ажиллагаа хангалтгүй байгааг өмнөх хэсэгт тайлбарласан.²²⁰

²¹⁵ ХХМХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт.

²¹⁶ Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг.

²¹⁷ Мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, (дээрх эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан журмын дагуу шаардахаар зохицуулсан. Иргэний хуулийн 497 дугаар зүйл нь гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл буюу гэм хорын ерөнхий шаардах эрх, 511 дүгээр зүйл нь эдийн бус гэм хорыг арилгах тусгай зохицуулалт болно. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хохирол учруулах мэдээ, мэдээлэл тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлох үүрэгтэй).

²¹⁸ Хүний хувийн мэдээлэл хамгаалах чиг үүрэгтэй байгууллагуудыг нийтлэгээр data protection authority хэмээн нэрлэж байна.

²¹⁹ Мөн ХХМХтХ-д төрийн бусад байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг шууд нарийвчлан заагаагүй боловч хуулийн хэрэгжилтийг хангах талаар зохицуулсан байдаг. Гэвч төрийн байгууллагууд хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед бусдад дамжуулахгүй, задруулахгүй байх мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар нийтлэг үүрэг хүлээсэн ба бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавина гэж заасан.

²²⁰ Засгийн газар болон түүний харьяа яам агентлагууд нь УИХ-аас баталсан хуулийг биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд салбарын хүрээнд иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шууд хамаарах шийдвэр гаргаж хүний эрх,

ХХМХтХ-иар ХЭҮК-ын чиг үүргийг дараах байдлаар тогтоосон нь үндсэндээ Комисс Монгол Улсын хувьд МХБ болохыг илтгэж байна.

Шигтгээ 3.3

ХХМХтХ-ийн 9, 22, 23, 24, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу ХЭҮК дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна:

- Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл хариуцагчид зөвлөмж өгөх;
- Мэдээлэл хариуцагч зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэлийг хүлээн авах;
- Хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах тохиолдолд зөвлөмж гаргах;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн талаар олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн талаар холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж хүргүүлэх;
- Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан, мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлага, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага, анхааруулгад тусгах мэдээлэлд санал өгөх;
- Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах явцад хүний эрхэд халдсан, халдаж болзошгүй нөхцөл бүрдсэн бол гомдол, мэдээллийн үндсэн дээр эсвэл өөрийн санаачилгаар шалгаж шийдвэрлэх, шаардлага зөвлөмж хүргүүлэх;
- Хүний эмзэг мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагад шаардлага, зөвлөмж өгөх;
- мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний талаар ирүүлсэн бүртгэлийг хүлээн авч хянан, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөмж өгөх;
- Мэдээлэл хариуцагчийн хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж өгөх;
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлд мэдээлэл хамгаалах үйл ажиллагаа, гарсан зөрчил, мэдээллийн эзний эрхийн хэрэгжилтийн талаар тусгах;
- Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийх;

Мэдээлэл хариуцагчийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд холбогдох гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

Орчин үеийн улсуудын нийгэм, эдийн засгийн тогтолцооны мөн чанарыг өөрчилж, өгөгдөл мэдээллийг үнэт “түүхий эд” болгож буй цахим технологийн эрин үед хүний халдашгүй байх эрх, хувийн нууцыг хамгаалахад МХБ-ын гүйцэтгэх үүрэг улам өсөн нэмэгдэх нь ойлгомжтой. МХБ-ын хэлбэр, бүрэн эрхийг улс орнууд төрийн байгууллагын бүтэц, эрх зүйн тогтолцооны онцлогтоо тохируулан харилцан адилгүй тогтоосон боловч ихэнхдээ тусгай байгууллагууд энэ чиг үүргийг эрхэлж байна.²²¹ МХБ нь хууль тогтоох байгууллага эсхүл Засгийн газраас байгуулагддаг, гүйцэтгэх засаглалд хамаарах захиргааны тохируулах чиг үүрэгтэй, харьцангуй бие даасан байгууллага байх бөгөөд

эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, соёл, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэгтэй захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргах үйл ажиллагаанд шууд оролцдог.

²²¹ Дэлхийн ихэнх улсын хувьд хүний хувийн мэдээлэл хамгаалах асуудлыг тусгайлан хариуцсан байгууллага, хэлтэстэй байдаг. Эдгээр байгууллага зарим тохиолдолд Data Protection Commissioner, Information officer, Ombudsman зэрэг харьцангуй ялгаатай бүтэц зохион байгуулалтын хэлбэрээр ажиллаж байна. Япон, Солонгос, Франц зэрэг зарим улсын хувьд комисс гэсэн нэршилтэй ХХМХЭББ-тай байдаг. Өмнөд африк, Нигер, Европын холбоо, Герман, ИБУИНВУ, Швейцар, Эстони, Австрали зэрэг орнууд бие даасан байгууллага ажиллаж байна.

торгох шийтгэл оногдуулах эрх бүхий хувийн мэдээллийн байцаагчдаас бүрдэж, хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч байна. МХБ-ын чиг үүргийг тодорхойлоход Европын Холбооны Хүний Хувийн Мэдээллийг Хамгаалах Ерөнхий Журам (ЕХХХМХЕЖ) жишиг зохицуулалт болно. ЕХХХМХЕЖ-ын 58 дугаар зүйлд зааснаар МХБ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Шигтгээ 3.4

МХБ-ууд сануулах, хязгаарлалт тавих, торгууль ногдуулах, магадлан итгэмжлэх, тусгай зөвшөөрөл олгох гэх мэт арга хэмжээ авч, хуулийн хэрэгжилтийг хангуулж байна.

Хянан шалгах:

- Мэдээлэл боловсруулагч, мэдээлэл хариуцагчид болзошгүй зөрчлийг мэдэгдэх;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- Хүний хувийн мэдээлэлтэй холбоотой олгосон зөвшөөрлийг хянах;
- Мэдээлэл боловсруулагч, мэдээлэл хариуцагчид байгаа хувийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг гаргуулан авах;
- Мэдээлэл боловсруулагч, мэдээлэл хариуцагчийн байршилд нэвтрэн орох, мэдээлэл боловсруулахад ашиглаж буй тоног төхөөрөмж, эд зүйлийг шалгах;

Албадлагын арга хэмжээ авах:

- Журмыг зөрчиж болзошгүй үйл ажиллагааны талаар мэдээлэл хариуцагч, боловсруулагчид анхааруулах;
- Журмыг зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдээлэл хариуцагч, боловсруулагчид сануулах;
- Мэдээллийн эзнээс гаргасан хүсэлтийг биелүүлэхийг хариуцагч эсвэл боловсруулагчид тушаах;
- Мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг тодорхой хугацаанд багтаан журамд нийцүүлэхийг мэдээлэл хариуцагч, боловсруулагчид тушаах;
- Хувийн мэдээллийн зөрчлийг талаар мэдээллийн эзэнд мэдэгдэхийг хариуцагчид тушаах;
- Мэдээлэл боловсруулах ажиллагааг түр эсвэл бүрмөсөн хязгаарлах, хориглох;
- Хувийн мэдээллийг засварлах, устгах эсвэл боловсруулах, мэдээллийн эзэнд эдгээр үйл ажиллагааны талаар мэдээлэхийг тушаах;
- Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эсвэл зөвшөөрөл олгох байгууллагад хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийг олгох шаардлага хангаагүй тохиолдолд олгохгүй байхыг тушаах;
- Торгох;
- Гадаад улс, олон улсын байгууллагад хувийн мэдээлэл дамжуулахыг хориглох.

Зөвлөх, тусгай зөвшөөрөл олгох:

- Журмыг хэрэгжүүлэх зөвлөгөө өгөх;
- Өөрийн санаачилгаар эсвэл хүсэлтээр хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой аливаа асуудлаар санал дүгнэлт гаргах;
- Гишүүн улсын хуулийн дагуу шаардлагатай тохиолдолд 36(5) дугаар зүйлд заасан боловсруулалтыг зөвшөөрөх;
- 40(5) дугаар зүйлд заасны дагуу үйл ажиллагааны дүрмийн төсөлд санал өгөх, батлах;
- 43 дугаар зүйлд заасны дагуу байгууллагуудыг магадлан итгэмжлэх;
- 42(5) дугаар зүйлд заасны дагуу гэрчилгээ олгох, гэрчилгээний шалгуурыг батлах;
- 28(8) дугаар зүйл болон 46(2) дугаар зүйлийн (d) хэсэгт заасан стандарт мэдээлэл хамгаалах заалтуудыг батлах;
- 46(3) дугаар зүйлийн (a) хэсэгт заасан гэрээний заалтуудыг зөвшөөрөх;
- 46(3) дугаар зүйлийн (b) хэсэгт заасан хувийн мэдээлэл дамжуулахтай холбоотой зөвшөөрөл олгох;
- 47 дугаар зүйлд заасны дагуу групп компанийн мэдээлэл хамгаалах дүрмийг батлах.

Монгол Улсын хувьд цахим хөгжлийн багц хуулийг шуурхай батлах, төсөв хэмнэхээс гадна хүний эрхийн асуудлаар мэргэшсэн, хараат бус, бие даасан байдлыг харгалзаж, ХЭҮК-ыг ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангахад оролцуулахаар хуульчилсан. Монгол Улсад хүний хувийн мэдээллийг хамгаалах эрх зүйн харилцаа бий болж буй эхэн үед ХЭҮК манлайлж, МХБ-ын чиг үүргийг хэрэгжүүлэх нь хувийн мэдээлэл хамгаалах үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөний өргөн хүрээтэй үзэл санаанд суурилж явуулах институцын соёл,

уламжлалыг төлөвшүүлэх ач холбогдолтой байж болно.²²² Гэвч цахим технологи төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд нэвтэрч, харилцаа хөгжихийн хэрээр Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулах, аудит хийх, магадлан итгэмжлэх, гадаад улсад мэдээлэл дамжуулахад зөвшөөрөл олгох зэрэг захиргааны үйл ажиллагаа явуулдаг МХБ шаардлагатай болох юм.

МХБ-ын үүргийг ХЭҮК хэрэгжүүлэх нь Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллагын мөн чанар, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хараат бус хяналт тавих хүний эрхийн үндэсний байгууллагын үндсэн зорилгод нийцэхгүй төдийгүй Монгол Улсад ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангах үр дүнтэй механизмыг бий болгоход оновчгүй, ойрын хугацааны шийдэл билээ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад зааснаар ХЭҮК-ыг “Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг хамгаалах, дэмжих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан үндэсний байгууллага” хэмээн тодорхойлж, ХХМХТХ-ийг батлах үед мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтад “хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих” чиг үүргийг нэмж хуульчилсан. ХХМХТХ-ийн дагуу уг асуудлыг Комиссын нэг гишүүн хүний эрх, эрх чөлөөний бүх асуудалд хяналт тавих ерөнхий бүрэн эрхийн зэрэгцээ хавсран хариуцаж байна. Комисст 2022 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийг байгуулж, одоогоор зургаан алба хаагчийн бүрэлдэхүүнтэй дээрх чиг үүргийг хариуцан гүйцэтгэж байна.

Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний бүх эрх, эрх чөлөөний нөхцөл байдалд улс төрөөс хараат бус хяналт тавьж, гаргасан дүгнэлтдээ тулгуурлан асуудлыг шууд хариуцах эрх бүхий албан тушаалтанд зөвлөмж, санал гаргах замаар хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зориулалттай байгууллага болно.²²³ Өөрөөр хэлбэл, ХЭҮК нь төрийн аливаа механизмын нэг хэсэг болдоггүй, харин хүний эрхийн талаар хүлээсэн үүргээ төр хэрхэн биелүүлж байгааг хөндлөнгөөс хянадаг. Тиймээс ХЭҮК нь Монгол Улсын МХБ болж, ХХМХТХ-ийн хэрэгжилтийг шууд хангуулж, торгох зэрэг албадлагын арга хэмжээ авах нь төр иргэнийхээ халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцаа хамгаалуулах зэрэг эрхийг хангаж буй байдалд хөндлөнгийн дүгнэлт хийх учиртай үндэсний байгууллагын үүрэг, мөн чанарт үл нийцнэ.

Түүнчлэн, Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээний дагуу хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах нь төрийн үүрэг юм. Энэ үүргийн хэрэгжилтэд хяналт тавих ХЭҮК-ын үйл ажиллагаа нь үндсэндээ төрийн байгууллага, албан тушаалтанд чиглэнэ. Харин ХХМХТХ-ийн дагуу үүрэг хүлээх этгээд нь төрийн байгууллага, албан тушаалтнаас гадна ихэнх тохиолдолд хувь хүн, хувийн хэвшлийн хуулийн этгээд байх юм. Иймд зөрчлийн шийтгэл оногдуулах эрх мэдэлгүйгээр, зөвхөн Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжөөр ХХМХТХ-ийг хэрэгжүүлэх нь бодит үр дүн багатай байх юм. Нөгөө талаас, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” хэмээн хуульчилж,²²⁴ Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж захиргааны хэргийн шүүхийн хяналтад үл хамаарах зарчмыг

²²² Ихэнх МХБ хувийн мэдээлэл хамгаалах захиргааны үйл ажиллагаанд төвлөрсөн, халдашгүй чөлөөтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг хүний эрхийн асуудлыг үйл ажиллагаандаа тэр бүр тооцож ажилладаггүй.

²²³ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/134 тогтоолоор “Парисын зарчмууд”-ыг баталж Хүний эрхийг дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын эрх зүйн зарчмууд баталгаажуулсан. Монгол Улсын тухайд УИХ, Засгийн газар нь сонгуулийн үр дүнд байгуулагддаг улс төрийн байгууллагууд болно. ХЭҮК-ын гишүүдийг УИХ-аас томилох боловч хууль тогтоомж хүний эрхийн зарчимд нийцсэн эсэхэд хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлдэг, төрийн өндөр албан тушаалтан, улс төрч хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн эсэх талаарх гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэдэг учраас УИХ-аас хараат бус үйл ажиллагаа явуулдаг.

²²⁴ Мэдээллийн эзэн, мэдээлэл хариуцагчийн хооронд үүсэх хувийн мэдээллийн харилцааны зөрчил нь ихэнх тохиолдолд их хэмжээний мөнгөн дүнгээр ашиг орлого олсон, хохирол учирсан асуудалд хамаарах тул торгох, тодорхой дүнгээр нөхөн төлбөр гаргуулах зэрэг шийдвэр гаргах боломжгүй Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж нь ХХМХТХ-ийг хэрэгжүүлэх үр дүнтэй хэрэгсэл биш юм.

тогтоосон.²²⁵ Харин ХХМХтХ-ийн 28 дугаар зүйлд уг хуулийн дагуу гаргасан гомдол, мэдээлэлд холбогдох Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн талаар шүүхэд гомдол гаргахаар зохицуулсан нь эдгээр эрх зүйн актын талаарх Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж, асуудал хариуцсан гишүүн эрх зүйн байдлын хувьд ялгаатай шаардлага, зөвлөмж гаргахад хүргэж байна.

Дэлхийн улс орнуудын жишгээр МХБ нь захиргааны хяналтын байгууллага байх бөгөөд сануулах, хязгаарлалт тавих, торгууль ногдуулах, магадлан итгэмжлэх, тусгай зөвшөөрөл олгох зэрэг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг болохыг өмнө тайлбарласан. Хуулийн хэрэгжилтийг албадах, зохицуулах эдгээр үйл ажиллагааг явуулахгүйгээр МХБ үр дүнтэй ажиллахгүй, ХЭҮК эдгээр чиг үүрэг хэрэгжүүлдэг байх нь мөн чанар, үндсэн зориулалтад нь нийцэхгүй.²²⁶ Үүний зэрэгцээ, ХХМХтХ-ийн хэрэгжилтийг хангуулахад мэдээллийн технологи, биометрик болон генетик мэдээлэл зэрэг хүний бүх төрийн мэдээлэл, кибер аюулгүй байдлын асуудлаар мэргэшсэн хүний нөөц шаардлагатай. Засгийн газрын байгууллагуудаас тусдаа ажилладаг ХЭҮК-т энэ чадавх ойрын хугацаанд бүрдэх боломжгүй. Түүнчлэн, ХХМХтХ-ийн хэрэгжилтийг Монгол Улсын хэмжээнд хангуулахад зургаан алба хаагч гүйцэтгэн явуулж буй Комиссын хүний нөөц олон дахин нэмэгдүүлэх ёстой нь ойлгомжтой.

Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн дагуу “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах” нь Засгийн газрын үндсэн чиг болно. Монгол Улсын МХБ-ыг цаашдаа Засгийн газрын нөөц, боломж, ялангуяа төрийн захиргааны байгууллагуудыг үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чадавхад үндэслэн бий болгож, бэхжүүлэх нь ХХМХтХ-ийг үр дүнтэй хэрэгжүүлэх, цахим эринд хүний халдашгүй байх эрх, хувийн нууцыг хамгаалахад чухал алхам болно.

Засгийн газрын хэд хэдэн байгууллагууд ХХМХтХ-ийг хэрэгжүүлэхэд үүрэг гүйцэтгэх боломжтой ч үйл ажиллагаа нь уялдаагүй, энэ чиглэлд ажилладаггүй, төрийн албан хаагчдын ХХМХтХ-ийн талаарх мэдлэг муу байгааг анхаарах шаардлагатай.

Тохиолдол 3.12

... Төрийн байгууллагын албан хаагчид ХХМХтХ талаар ерөнхий ойлголттой, хүний хувийн мэдээлэлтэй холбоотой асуудал хариуцсан мэргэжилтэн, бүтэц нэгж байхгүй, хувийн мэдээлэл алдагдах нь хэвийн зүйл мэт ойлгох, энэ талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байдгаас хуулиар хориглосон алдаа дутагдал гаргах боломжтой байдаг. Үүнээс сэргийлж төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад хүний хувийн мэдээлэл боловсруулах, хадгалах, ашиглах тусгай мэргэжилтнийг бэлдэж, энэ талаарх сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай явуулж, хүний хувийн мэдээллийг хамгаалах үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай.

(Төрийн 6 байгууллагын албан хаагчидтай хийсэн ярилцлагаас)

Хүний биометрик мэдээллийн зохицуулалт, хамгаалалт

Хиймэл оюун зэрэг цахим технологи хөгжихийн хэрээр гарын хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүр царай, дуу хоолой, биеийн хөдөлгөөний онцлог шинж зэрэг хүний бие махбодтой холбоотой биеийн давхцахгүй өгөгдөл буюу биометрик мэдээллээр хүнийг хэн болохыг тогтоох, танин баталгаажуулах, хянах үйл ажиллагаа улам түгээмэл болж буй боловч биометрик мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах талаарх Монгол Улсын

²²⁵ Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг шийдвэрлэх ажиллагаа”-аас үүссэн маргаанд тус хууль үйлчлэхгүй байхаар заасан.

²²⁶ “ХХМХтХ-ийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын механизмын үнэлгээ” судалгаагаар хүний эрхийн үндэсний байгууллага нь МХБ-ын чиг үүргийг хэрэгжүүлж Монгол Улстай ижил институцын зохион байгуулалт бүхий улс байхгүй байна. Мөн тэнд 28 дугаар хуудас, 2024 он, ХХМХтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэгт “Хүний эрхийн Үндэсний Комисс энэ хуулийн 27.3, 27.4-т заасан үйл ажиллагаа, бусад хуулийн хүрээнд ашиглаж байгаа дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор хууль хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно” гэж заасан нь ХЭҮК-ын хараат бус ажиллах шаардлагад нийцэхгүй болно.

эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий байгаа нь эмзэг мэдээллийг эрсдэлд оруулж, хууль дээдлэх ёсны зарчмыг зөрчиж байна.²²⁷

ХХМХТХ баталснаар бий болсон шинэ ойлголт болох биометрик мэдээллийг уг хуулийн 10 дугаар зүйлээр зохицуулж, хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс “Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам”, тус оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс “Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам” тус тус баталсан.²²⁸

Уг журмуудаар хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээллийг боловсруулахдаа баримтлах зарчим, мэдээлэл хариуцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журмыг батлах, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, аудит хийх, зөвшөөрөгдсөн программ хангамж ашиглах зэрэг зохицуулалтыг тусгасан. ХХМХТХ-ийн дагуу Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэхээр, улсын бүртгэлийн байгууллага, хил хамгаалах байгууллага, шүүхийн шинжилгээний байгууллага, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд хүнийг танин баталгаажуулахад биометрик мэдээллийг ашиглах эрхтэй.²²⁹ Гэвч хуулиар эрх олгогдоогүй эрүүл мэндийн, нотариатын зэрэг байгууллагууд гарын хурууны хээгээр хүнийг танин баталгаажуулсан хэвээр байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг илтгэнэ. Эрүүл мэндийн салбарт хурууны хээгээр хүнийг танин баталгаажуулах нь найдвартай, үр дүнтэй арга бөгөөд цаашид ашиглах шаардлагатай бол ХХМХТХ-д өөрчлөлт оруулж, уг эрхийг хуульчлах нь зүйтэй.

ХХМХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтад “Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтныг таньж, баталгаажуулах үйлдлийг хялбарчлах зорилгоор ажилтны зөвшөөрлөөр биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-с бусад биометрик мэдээллийг ашиглаж болно” гэж заасан. ХХМХТХ батлагдахаас өмнө төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажилтан, алба хаагчийн ажлын цагийг гарын хурууны хээгээр бүртгэх нь түгээмэл байсан боловч батлагдсанаас хойш нүүр царай, нүдний солонгон бүрхэвчээр танин баталгаажуулалт хийж байна. Бусад төрлийн биометрик мэдээлэл ашиглах нь гарын хурууны хээ ашиглахаас эрсдэл багатай тул ийнхүү хуульчилсан талаараа ХХМХТХ-ийг боловсруулсан Ажлын хэсгийн гишүүд тайлбарлаж байна. Монгол Улсад хүний биометрик мэдээлэл, ялангуяа гарын хурууны хээ ашиглах эрх зүйн зохицуулалт тодорхой боловч бусад төрлийн биометрик мэдээллийн талаар нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна. Түүнчлэн, уг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах технологийн шаардлагыг тогтоогоогүй нь цахим технологийн хөгжлийн өнөөгийн түвшинтэй харьцуулахад хангалтгүй байна.

Тохiolдол 3.13

ХХМХТХ-ийн 31 дүгээр зүйлд заасны дагуу уг хуулийг дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцалгүй өгөгдлийг устгах арга хэмжээ зохион байгуулагдсан юм. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Ажлын хэсэг байгуулж, гарын хурууны хээгээр танин баталгаажуулах үйл ажиллагааг зогсоох, мэдээллийг устгах ажлыг 14 хоногийн дотор улсын хэмжээнд зохион байгуулсан.

...Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 55 дугаар захирамжаар хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцалгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, ажиллуулсан.

²²⁷ Биометрик мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий байгаа нь иргэдийн хувийн мэдээллийг хамгаалах тодорхой механизмыг бүрдүүлээгүй, байгууллагуудад дур зоргоор үйл ажиллагаа явуулах боломжийг нээж, эрх зүйн тодорхойгүй байдал үүсгэн, улмаар хууль дээдлэх ёсны зарчмын хууль ойлгомжтой, урьдчилан таамаглах боломжтой байх шаардлагыг зөрчиж байна.

²²⁸ Биометрик мэдээлэл нь ХХМХХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.12, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу “хүний эмзэг мэдээлэл”, “хувь хүний нууц” болно.

²²⁹ ХХМХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт.

ХХМХтХ-ийн дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн сайд 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хурууны хээ устгах үйл ажиллагааг зохион байгуулах тухай 04 дүгээр албан даалгаврыг гаргажээ.

Энэхүү тооцоотой, нухацтай хандах шаардлагатай ажлыг 14 хоногт явуулах нь иргэд төрийн үйлчилгээг авч чадахгүйд хүргэх эрсдэлтэй талаар ХЭҮК-ыг төлөөлж Ажлын хэсэгт орсон гишүүн сануулж байсан. ХХМХтХ-ийн зохицуулалт Монгол Улсын бодит нөхцөл байдалд нийцээгүй тул гарын хурууны хээг өрхийн эмнэлгээс эхлээд эрүүл мэндийн байгууллагууд бүхэлдээ хууль зөрчин хэрэглэж байна.

Монгол Улсад нэр бүхий 25 байгууллагад ISO/IEC 27001:2022 стандартын²³⁰ хүрээнд аудит явуулахад бүгд хүний хувийн мэдээллийг байгууллагын нууцын зэрэглэлд хамааруулан баталж, холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллаж байна. Гэсэн хэдий ч тухайн байгууллагууд гарын хурууны хээ ашиглахаа зогсоосон боловч бүртгэлээс устгасан талаар нотолгоо байхгүй, баталсан журамдаа хүний хувийн мэдээллийн хадгалалт, устгал, ашиглалтыг хэрхэн хийх тухай тодорхой зохицуулаагүй зэрэг нөхцөл байдал тогтоогдсон нь хүний биометрик мэдээлэл хангалттай хамгаалагдаагүй, эрсдэлтэй байгааг илтгэж байна.²³¹

Биометрик мэдээллийн төрлүүд, тэдгээрийг цуглуулах, боловсруулах, ашиглах цахим технологиудын талаарх хангалттай мэдлэггүй, биометрик мэдээллийг ашиглах улс орныхоо хэрэглээ, шаардлагыг сайтар судлаагүй бий болгосон эрх зүйн зохицуулалт, хуулийг хэрэгжүүлэхээр цөөн хоногт авсан “цочир” арга хэмжээ нь Монгол Улсын цахим засаглалд гарч буй түгээмэл алдааны жишээ юм. Биометрик мэдээллийг сольж, өөрчлөх боломжгүй, алдагдсан тохиолдолд хувь хүн ноцтой эрсдэлд орж болзошгүй эмзэг өгөгдөл юм. Хамгаалалт муутай, хэт их хэмжээгээр цуглуулсан биометрик мэдээллийн улмаас хүн гэмт хэргийн хохирогч болох, ялгаварлан гадуурхагдах, хэлмэгдэх зэргээр эрх нь зөрчигдөх эрсдэлтэй.²³²

3.4.2. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Нэг талаас өмнөх хэсэгт тайлбарласан хуулийн хэрэгжилтийг хангах, хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын механизм сул, нөгөө талаас ХХМХтХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг муу байгаагаас уг хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ хэсэгт ХХМХтХ-ийн түгээмэл гарч буй зөрчлийг ХЭҮК-ын шийдвэрлэсэн гомдол, дүн шинжилгээ, бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн танилцуулж байна. ХХМХтХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш Комисс уг хуулийг зөрчсөнтэй холбоотой 78 гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэжээ.²³³

ХХМХтХ-ийн 5 дугаар зүйлд “хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх” гэх хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах таван зарчмыг тодорхойлжээ. Харин эдгээр зарчимд олон улсад нийтлэг мөрддөг хүний хувийн мэдээллийг хамгийн багаар цуглуулах зарчмыг хуульчлаагүй юм.²³⁴ Гэтэл хувийн мэдээллийг шаардлагатайгаас илүү хэмжээгээр цуглуулах явдал түгээмэл гарч байна. Жишээлбэл, төрийн албанд ажиллах сонирхолтой иргэд Төрийн албаны зөвлөл 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкетад заасан мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд уг анкет нь А, Б хэсгээс бүрдсэн, анкетын А хэсэгт

²³⁰ ISO/IEC 27001:2022 хувилбарын хавсрал А.5.34-т PII (Personally Identifiable Information–Хувь хүнийг таних боломжтой мэдээлэл)-тэй холбоотой нэмэлт шаардлагууд тусгагдсан байдаг.

²³¹ “ДИА” ХХК, “Мэдээллийн аюулгүй байдалд хийсэн аудитын тайлан, дүгнэлт”, 1 дэх тал.

²³² НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Тамгын газрын А/HRC/51/17 дугаартай Дижитал эрин зуун дахь хувь хүний нууцын эрхийн тайлан, 48 дахь тал.

²³³ Нийт гомдлын 14 нь төрийн байгууллага, албан тушаалтанд, 25 нь хувийн хэвшлийн байгууллагад, 14 нь хувь хүнтэй холбоотой байна. Гомдлыг дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд: зөвлөмж, шаардлага хүргүүлсэн 18, зөвлөгөө өгсөн 12, зөрчил үүсгэсэн нөхцөл байдлыг арилгасан 6, зөрчил илрээгүй талаар мэдэгдсэн 1, шийдвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлсэн 12, эвлэрүүлсэн 1 гомдол байна. Хүний хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой асуудлаар тодруулга, зөвлөгөө авахаар 14 хүсэлт ирсэн байна.

²³⁴

“регистрийн дугаар, үндэс угсаа, төрсөн газар, садан төрлийн хүмүүсийн төрсөн огноо, аймаг, хот, эрхэлж буй ажлын мэдээлэл”-ийг авч байна. Харин ажилд томилогдсон төрийн албан хаагчаас хувь хүний намтар буюу өөрийн, өөрийн эцгийн, өвөг эцгийн үндэс угсаа, төрсөн огноо, харъяалал, боловсрол, ажил, мэргэжлийн түүх, гавъяа шагнал, бүтээл туурвил, ял шийтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэмэлтээр гаргуулж авахаар заажээ. Төрийн албан хаагчийн анкет нь удирдах, гүйцэтгэх, туслах зэрэг ямар албан тушаал горилж байгаа, тухайн албан тушаалд томилогдох, эс томилогдохоос үл хамаарч ижил агуулгатай, тухайн албан тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагагүй хувийн болон эмзэг мэдээллийг агуулж байж болзошгүй.

Төрийн албан хаагчийн анкет нь бусад байгууллага, хувийн хэвшилд жишиг болж байгаа тул ажил горилогчийн их хэмжээний хувийн мэдээллийг цуглуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны хувийн нууцад хамаарах, ... мэдээлэл авах, боловсруулах, хадгалахыг хориглоно” гэх заалт түгээмэл зөрчигдөж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Энержи ресурс ХХК, Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Мобиком корпораци, Алтан жолоо групп, Скайтел ХХК зэрэг хувийн хэвшлийн зарим байгууллагуудын ажилд авах анкетэд дүн шинжилгээ хийхэд ажил гүйцэтгэхэд шаардлагагүй, ажил горилогчийн гэр бүл, өмч хөрөнгийн, хувийн болон эмзэг мэдээллийг мэдүүлэхээр тусгасан байна. Жишээлбэл, “Монгол Билиг Оюун” цогцолбор сургууль нь ажил горилогчийн гэр бүл, садан төрлийн хүмүүсийн талаарх мэдээлэл, орон байрны нөхцөл, өмчлөл, фэйсбүүк зэрэг олон нийтийн сүлжээний хаяг, ял шийтгэл, сахилгын арга хэмжээ авагдсан талаарх мэдээлэл, биеийн өндөр, харшил, групп тогтоолгож байсан эсэх зэрэг эрүүл мэндийн мэдээллийг заавал бөглөхөөр заасан байна.

Тохиолдол 3.14

Иргэн А.Б-ээс 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр “МУБИС-ийн харьяа Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эмзэг мэдээллийг google docs-оор дамжуулан цуглуулж байгаа нь хүний эмзэг мэдээлэл алдагдах эрсдэл гарч байна” гэх гомдлыг Комисст гаргасан. 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр МУБИС-ийн харьяа ЕБС-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч нар суралцагчдын дунд аутизм, хэл ярианы хөгжил сул байгаа эсэхийг судалж мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор Фейсбүүк чат группт судалгааны асуулга байршуулан, эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авалгүйгээр суралцагчдын овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаар, эцэг эхийн мэдээлэл, ар гэртэй холбоо барих мэдээлэл, гэр бүлийн байдал /гэр бүл салалт, эмээ өвөө дээрээ амьдардаг, эцэг эх нь нас барсан/ хагас болон бүтэн өнчин эсэх, оношлогдсон сэтгэл зүйн асуудалтай эсэх, оношлогдоогүй ч анхаарал татахуйц онцлог байгаа эсэх, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, хууч өвчин байгаа эсэх” талаарх мэдээллийг google docs програмд шивж оруулах тохиргоотой тавигдсан байв.

Мэдээлэл хариуцагч болох сургуулиас нь суралцагчдын хувийн мэдээлэл, эмзэг мэдээллийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу мэдээллийн эзний зөвшөөрөлгүй цуглуулсан үйлдэл нь Монгол Улсын иргэний халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцаа хамгаалуулах эрхийг зөрчсөн тул уг мэдээллийг устгуулах, суралцагчдаас авах аливаа мэдээллийг аюулгүй байдлыг илүү хангасан арга зам, хэлбэрээр мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулах, боловсруулах, ашиглах болон мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журмыг баталж, мөрдүүлэхийг шаардаж, Комиссын гишүүний 04/20 дугаар шаардлагыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлсэн. Зөрчлийг таслан зогсоож, зохих арга хэмжээ авсан талаараа МУБИС-ийн харьяа ЕБС-аас Комисст 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн албан бичгээр хариу ирүүлжээ.

(Комиссын гишүүний 2023.10.23-ны өдрийн 04/20 дугаар шаардлагаас)

Хүний хувийн мэдээллийг хамгаалахын ач холбогдлыг мэдээлэл хариуцагчид мэдэхгүй байх, хувийн нууц, хувийн мэдээллийг байгууллага, салбарын хэмжээнд төдийгүй олон нийтэд задруулах тохиолдол гарсаар байна.

Тохиолдол 3.15

Иргэн Б. Э 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан эмч нарын нарийн мэргэшил олгох, дээшлүүлэх сургалтад элсэхээр 2022 оны 09 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд шалгалт өгсөн. Гэтэл тус байгууллага нь цахим хуудсандаа шалгалт өгсөн эмч, мэргэжилтнүүдийг овог, нэртэй нь орон даяар ил тод тавьсан. (Өмнө шалгуулагчид код өгөөд кодоор нь үнэлгээ, оноо тавьдаг байсан) Хүний нэрсийг ил тавьснаас ажлын байран дээр дарга нар “тэр төдөн оноо авсан, шалгалтдаа унасан гэж зарлах,

загнах зэргээр хүнийг эвгүй байдалд оруулж, эрх зөрчиж байгаад гомдолтой байна гэх гомдлыг Комисст гаргасан байна. Гомдлыг шалгахад ЭМС-ын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/337 тушаалаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох” журмын 15.4.12-т зааснаар “шалгалтын дүнг мэргэжилтэн болон олон нийтэд шалгалт авсны дараах өдрийн 12 цагт багтаан үнэг зөв мэдээлнэ” гэсний дагуу шалгуулагчдын нэр, дүнг ил байршуулсан байв. Тус төвийн www.hdc.gov.mn цахим хуудаст байршуулсан мэдээллийг санамсаргүй байдлаар түүвэрлэн үзэхэд эмч, мэргэжилтнүүдийн регистрийн болон лицензийн дугаар гэрийн хаяг зэрэг мэдээллийг ил байршуулсан нь тогтоогдсон.

Уг үйлдлийг таслан зогсоох, зөрчил гаргасан алба хаагчид хариуцлага тооцуулах, ХХМХтХ-д заасны дагуу Хүний хувийн мэдээллийг хамгаалах журам баталж мөрдүүлэх талаар Комиссын гишүүний 04/21 дүгээр шаардлагыг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хүргүүлсэн ба мэдээлэл хариуцагч шаардлагыг биелүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 951 дугаар албан бичгээр Комисст мэдэгдсэн.

(Комиссын гишүүний 2022.09.30-ны өдрийн 04/21 дүгээр шаардлагаас)

ХХМХтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтад заасны дагуу мэдээлэл хариуцагч мэдээллийн эзнээс мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зөвшөөрөл авахдаа тухайн мэдээллийг боловсруулах, ашиглах үндэслэл, зорилгоо ойлгомжтой, тодорхой танилцуулах, мэдээллийг зөвхөн анх цуглуулсан зорилгын хүрээнд ашиглаж, боловсруулах шаардлага мөрдөгдөхгүй байна. Тухайлбал, сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ) оршин суугчдын нэр, утасны дугаар, гэрийн хаяг, СӨХ, ус, дулаан, цахилгааны өр төлбөрийн мэдээллийг орцонд байх мэдээллийн самбарт эсхүл тухайн байрны оршин суугчдын үүсгэсэн олон нийтийн сүлжээний чатад ил тавьж, анхааруулах буюу албадлагын шинж чанартай үйлдэлд ашигласан тохиолдол гарч байна.

Тохиолдол 3.16

Иргэн Б.Э-ээс 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Х. ББСБ ХХК-аас зээл авч, хугацаандаа төлж чадалгүй хугацаа хоцроож байгаа. Хэдийгээр хугацаа хоцроосон нь миний буруу боловч 9811... дугаараас удаа дараа залгаж, ажлын газрын удирдлагуудтай чинь уулзаж чиний тухай хэлнэ гэх зэргээр мессеж бичиж, зүй бусаар харьцаж, миний хувийн мэдээллийг анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор ашиглаж байгаа хууль бус үйлдлийг зогсоож, хариуцлага тооцож өгнө үү” гэх гомдлыг Комисст гаргасан.

Банк бус санхүүгийн байгууллагаас Зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг зээлдэгчээс шаардах нь хуульд нийцэх боловч уг арга хэмжээг хууль, гэрээнд заасан арга хэрэгслээр аваагүй, хүний хувийн мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөс гадуур, хүний дарамтлах, сүрдүүлэх зорилгоор ашиглаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалт, ХХМХтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Комиссын гишүүний 04/25 дугаар шаардлагыг хүргүүлсэн. Шаардлагыг биелүүлж, ийм зөрчлийг дахин гаргуулахгүй байх үүднээс авсан арга хэмжээний талаар шаардлага хүлээн авсан ББСБ-аас 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 23/252 дугаар албан бичгээр хариу мэдэгджээ.

(Комиссын гишүүний 2023 оны 11 дүгээр сарын 08 өдрийн 04/25 дугаар шаардлагаас)

Мэдээллийн эзний зөвшөөрөлгүй, хуульд заасан үндэслэлгүйгээр хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах зөрчлийг төрийн болон бусад байгууллагаас гаргаж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хуулиар олгогдоогүй төрийн тусгай хамгаалалтын байгууллага иргэний хувийн мэдээлэл болох утасны дугаарыг олж авч, жагсаал, цуглаанд оролцсон тухай нь тодруулан асууж, анхааруулга өгсөн нь ХХМХтХ-ийг зөрчсөн, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шинжтэй үйлдэл болно.

Тохиолдол 3.17

Иргэн М.Э-ээс “2022 оны 04 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд болсон “Монголдоо сайхан амьдаръя” уриатай цуглаанд оролцсон эсэхийг Төрийн тусгай хамгаалалтын газраас тодруулж, надад Жагсаал, цуглааны тухай хуулийн талаар мэдээлэл өгөхдөө миний гар утасны дугаарыг ааваас авч холбогдсон нь хувийн мэдээллийг хууль бусаар цуглуулж, хувийн нууцаа хамгаалуулах, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд халдсан” гэсэн гомдлыг ХЭҮК-т гаргажээ. Гомдлыг шалгахад Төрийн тусгай хамгаалалтын газрын ажилтан нь хуулиар бүрэн

эрх олгогдоогүй, иргэн М.Э-ээс тайлбар авах хууль ёсны үндэслэл үүсээгүй байхад түүний гар утасны дугаарыг олж авч, цуглаанд оролцсон үйлдэлтэй нь холбогдуулан харилцаж, анхааруулга өгсөн нь тогтоогдсон тул хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцуулахаар 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 04/20 дугаар шаардлагыг хүргүүлсэн.

Шаардлагын дагуу хурандаа Т-д албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан болохыг Төрийн тусгай хамгаалалтын газрын 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 963 дугаар албан бичгээр Комисст мэдэгджээ.

(Комиссын гишүүний 2022.09.19-ний өдрийн 04/20 дугаар шаардлагаас)

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, энэ зорилгоор цахим сүлжээ, системд хөрөнгө оруулал хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журмыг баталж, мөрдүүлэх талаар ХХМХтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлд заасан үүргээ мэдээлэл хариуцагчид хангалтгүй биелүүлж байна. Энэ зөрчил Комиссоос шалгалт хийсэн ихэнх байгууллагуудад илэрч байлаа. Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах журмыг баталж, мөрдүүлэх үүргээ мэдээлэл хариуцагчид мэдэхгүй байх, хувийн мэдээллийг хамгаалах тухай журамтай байсан ч ХХМХтХ-иас өмнө баталсан, нарийвчилсан зохицуулалтыг тусгаж чадаагүй байх нь нийтлэг байна. Хувийн өмчит, лавлагаа шатлалын эмнэлгийн цахим систем кибер халдлагад өртөж, 200 орчим мянган үйлчлүүлэгч иргэний регистрийн болон утасны дугаар, зарим төлбөрийн мэдээлэл цахим орчинд тараагдсан явдал 2024 оны 10 дугаар сард болсон. Тус эмнэлгийн кибер аюулгүй байдлын нөхцөл хангалтгүй байсны дээр хувийн мэдээллийг хамгаалах арга хэмжээг төлөвлөөгүй, мэдээлэл алдагдсанаас учирч болох үр дагавар, хохирлыг бууруулах арга хэмжээг шуурхай аваагүй байлаа.

Тохиолдол 3.17

Хэвлэл мэдээлэл, цахим орчинд 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр "...Интермед" эмнэлгийн цахим сүлжээ кибер халдлагад өртөж, 230 000 орчим үйлчлүүлэгч, өвчтөний хувийн мэдээлэл алдагдсан, уг мэдээллийг цахим орчинд 50,000.00 ам. доллароор худалдан борлуулах, мэдээллийг задруулахгүйгээр буцаан авах тохиолдолд барьцаа төлбөр төлөх шаардлагыг тус эмнэлэгт тавьсан" гэх мэдээлэл цацагдаж, Монгол Улсын иргэдийн овог, нэр, регистрийн болон утасны дугаар бүхий мэдээлэл <https://crackingx.com> цахим хуудаст 11 сарын 07, 9, 13, 14 -ны өдрүүдэд тавигдсан. Мөн хувийн мэдээлэл нь алдагдсан тул хамгаалах арга хэмжээ авч өгөхийг хүсэж, иргэн Б.Э Комисст гомдол гаргасан.

Хүний хувийн мэдээлэл ихээр алдагдсантай холбоотойгоор зохих хяналт шалгалтыг хийхэд "Интермед" эмнэлгийн кибер аюулгүй байдлыг хангах арга хэмжээ хангалтгүй байлаа. ЗГ-ын 2024 оны 100 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах" журамд зааснаар эрүүл мэндийн мэдээллийн систем нь НМИТБтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтад заасан төрөлжсөн мэдээллийн санд хамаарах бөгөөд программ хангамж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангахад ЗГ-ын 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ыг мөрдөх үүрэгтэй байдаг. Гэвч уг журмыг мөрдөх, түүнд нийцүүлэн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журмыг шинэчлэн, хэрэгжүүлээгүй байна. Мөн тус эмнэлэгт ХХМХтХ-ийн хэрэгжилт муу, үйлчлүүлэгчдийн хувийн нууц, хувийн мэдээллийг хамгаалах арга хэмжээг хангалтгүй байлаа. Эмнэлгийн холбогдох дотоод журмууд нь цахим систем, цахим сүлжээний кибер аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хэдий ч эдгээр журмуудад хүний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалт ХХМХтХ хуульд заасан шаардлагыг хангаагүй байлаа. ХХМХтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтад заасан мэдээлэл, цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдөөгүй, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтад заасан мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг батлаагүй нь кибер халдлагын үеэр шуурхай, оновчтой хариу арга хэмжээ авч чадахгүй байх нөхцөл болсон гэж үзсэн.

Мэдээлэл хариуцагч болох эмнэлгээс хүний хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авахыг шаардсан Комиссын гишүүний 04/30 дугаар шаардлагыг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн. Үүнд:

1. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтад заасны дагуу онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага болохын хувьд мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7 дахь заалтад заасан дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн

аюулгүй байдлын аудитыг хийлгэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодитой арга хэмжээ авах;

2. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад заасны дагуу кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах;

3. ХХМХтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалтад заасан журам, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтад заасан мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг боловсруулж, батлах;

4. 2024 оны 10 сард болсон кибер халдлагын улмаас үүссэн хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн бүртгэлийг хөтөлж, ХХМХтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт заасан хугацаанд Комисст ирүүлэх;

Кибер халдлагыг таслан зогсоож, зохих арга хэмжээ авсан талаараа Интермед эмнэлгээс Комисст 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн албан бичгээр хариу ирүүлжээ.

(Комиссын гишүүний 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 04/30 дугаар шаардлагаас)

ХХМХтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтад “Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах шаардлага, үнэлгээ хийх зааварчилгаа, хадгалах технологид тавигдах шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно” гэж хуульчилсан ч эдгээр шаардлага, зааварчилгааг 2025 оны 3 дугаар сарын байдлаар батлаагүй байгаа нь мэдээлэл хариуцагчид мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам боловсруулахад сөргөөр нөлөөлж байж болзошгүй.

ХХМХтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн байгууллага хүнийг тодорхойлох боломжгүй болгож мэдээллийн эзний мэдээллийг нээлттэй өгөгдөл болгох зохицуулалтыг зарим байгууллага хангаж ажиллахгүй байна. Тухайлбал, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс судалгааны ажил хийх, оюутан, сурагчдад гарын авлага болгох, хуулийг нэг мөр хэрэглэх жишиг тогтоох зорилгоор нийтийн мэдээллийг сан болгон хөтөлж байгаа shuukh.mn цахим хуудсанд хүний хувийн мэдээллийг шаардлагатайгаар илүү хэмжээнд, журмыг зөрчиж нийтлэх тохиолдол давтагдсаар байна.

Тохиолдол 3.18

“Хөөрхөн Зүрхнүүдийн аян” Төрийн бус байгууллагаас 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр “...Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 2024/ШЦТ/60 дугаартай шийтгэх тогтоолыг Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулахдаа хохирогч С.Н-ийн нэр, төрсөн он, сар, өдөр, гэрийн хаяг зэрэг хувийн мэдээллүүдийг оруулсан байна. Уг шийтгэх тогтоолыг “Сэтгэл зүйн хараал” гэх YouTube сувагт эх сурвалж болгон, хэргийн талаарх подкастыг 2024 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр бэлтгэхдээ бэлгийн хүчирхийллийн үйл явцыг он цагийн дарааллаар тодорхой ярьсан нь хохирогчийн сэтгэцийн гэмтлийг сэдрээх, дахин хохирох нөхцөл байдлыг үүсгэж байна” гэх гомдлыг Комисст гаргажээ. Гомдлыг шалгахад тухайн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулахдаа хохирогч С.Н-ийн нэр, төрсөн он, сар, өдөр, гэрийн хаяг зэрэг хувийн мэдээллийг нээлттэй нийтэлсэн, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн талаарх шүүхийн шийдвэрүүдийг шүүхийн цахим санд нээлттэй байршуулсан нь тогтоогдсон тул хууль зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцуулахаар Комиссын гишүүний 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04/26 дугаар шаардлагыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн.

Шаардлагын дагуу шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан нийт шүүхийн шийдвэрийн 36 хувь буюу 96979 шүүхийн шийдвэрийг холбогдох хууль, журамд нийцүүлж, хууль зөрчсөн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан болохыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04/26 дугаар албан бичгээр Комисст мэдэгджээ.

(Комиссын гишүүний 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04/26 дугаар шаардлагаас)

ХХМХтХ-ийн 12 дугаар зүйлд заасан мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг цуглуулахыг хориглох түүнчлэн сэтгүүл

зүйн зорилгоор мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахдаа мэдээллийн эзэн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй гэсэн хуулийн шаардлагыг зарим хэвлэл мэдээллийн байгууллага хангахгүй байна.

Тохиолдол 3.19

Иргэн С.Н.-ээс “...Миний дүү У.Т. 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр найз, нөхдийн хамт баяр тэмдэглэн явж байгаад золгүй байдлаар тархиндаа хүнд гэмтэл авч эмнэлэгт эмчлүүлж байна. Х инфо сайтын сэтгүүлч Т.О. үйл явдлын талаар боловсролын салбарын архидалтаас болж нэгэн цэцэрлэгийн ажилтан, 4 хүүхдийн эх Т амь насаараа хохирох аюулд орсон хэмээн эмнэлгийн даргаас яриа авсан үйлдэл нь хэн болохыг шууд тодорхойлсон. Сэтгүүлч Т.О. дээрх мэдээллийг хэн өгсөн талаар олж, тогтоон, хариуцлага тооцож өгнө үү” гэх гомдол гаргажээ.

Гомдолд дурдсан асуудал нь ХХМХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад заасан “...хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой мэдээллийг”, 4.1.12-т заасан “...эрүүл мэндийн талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Сэтгүүл зүйн, эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж болно”, 12 дугаар зүйлийн 12.2-т “Мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр эрүүл мэнд ... талаарх мэдээллийг энэ хуулийн 12.1-д заасан зорилгоор цуглуулж, боловсруулж, ашиглахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.3-т “Сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахдаа мэдээллийн эзэн болон бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болохгүй” гэж заасныг шууд зөрчсөн үйлдэл болжээ.

Гомдлыг шалгах явцад сэтгүүлч Т.О. “нэрээ нуусан эх сурвалж надад боловсролын салбарт архидалт их байна. Хамт олноороо цуглаж архидаж байгаад нэг эмэгтэй хүнд гэмтэл авч эмнэлэгт хүргэгдсэн” гэсэн мэдээлэл өгсний дагуу эмнэлгийн дарга Д.А.-аас Live байдлаар яриа авахад “нэгэн цэцэрлэгийн ажилтан тэр гэж нэрийн эхний үсгийн хэлээд, бааранд архидан согтуурч тасарч унахдаа тархиндаа хүнд гэмтэл авсан” гэх зэрэг эрүүл мэндийн мэдээллийг өгсөн гэх тайлбарыг өгч байсан. Сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл ашиглахдаа хувь хүний нууцыг задруулсан эмнэлгийн дарга утсаар мэдэгдэж анхааруулга өгсөн ба сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн асуудлыг шалгуулахаар Хэвлэл мэдээллийн зөвлөлд албан бичиг хүргүүлснийг тус Зөвлөл хэлэлцээд 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр 01/120 дугаар албан бичгээр дүгнэлтийнхээ талаар мэдээлжээ.

(Комисст гаргасан иргэний гомдлоос)

Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад илэрсэн зөрчлийн талаар мэдэгдэх, зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтлөх, уг бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн үүргийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна гэж үзэж байна. ХХМХтХ мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд ердөө нийтдээ дөрвөн мэдээлэл хариуцагчаас энэ талаарх мэдээллийг ирүүлсэн бөгөөд бүгд ямар нэгэн зөрчил гараагүй гэсэн агуулгатай байсан ба эдгээр мэдээлэл хариуцагчдын нэг нь зээлийн мэдээллийн сан хөтлөх чиг үүрэг бүхий ХХК бол бусад төрийн бус байгууллага байсан болно.

Мэдээллийн буюу цахим хөгжлийн ололтод суурилсан хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах түүнчлэн хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах тохиолдолд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлал, журмын дагуу үнэлгээ хийн, уг үнэлгээг ХЭҮК-т зөвлөмж авсны үндсэн дээр мэдээллийг ашиглах тухай ХХМХтХ-ийн 23 дугаар зүйлд заасан зохицуулалт хангагдахгүй байна.

Тухайлбал Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (клиник) эрхлэх тусгай зөвшөөрлийг авч өнгөрсөн оны 4 дүгээр сараас эхлэн хиймэл оюунд суурилсан оношилгооны тоног төхөөрөмжүүдийг ашиглан эрүүл мэндийн шинжилгээ хийх үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаа “Таван богд Нура” ХХК холбогдох зөвлөмжийг гаргуулалгүйгээр үйл ажиллагаагаа явуулсаар байна. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, олон нийтийн газарт, эсхүл замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглаж байгаа зарим дүрсний бичлэгийн

төхөөрөмж нь хиймэл оюун ашиглах технологи дээр суурилан хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийж байгаа ч эрх бүхий байгууллагаас баталсан аргачлал, журмын дагуу үнэлгээ хийн, уг үнэлгээг Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлэн зөвлөмж аваагүй байгаа нь мэдээллийг хуульд заасан үндэслэлээр цуглуулах, боловсруулах, ашиглах зарчмыг мөн зөрчиж байгаагийн хэлбэр гэж үзнэ.

ХХМХТХ-ийн 31 дүгээр зүйлээр зүйлээр өгсөн, уг хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцалгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах хуулийн шаардлага зарим талаар хангалтгүй хэрэгжиж байна. ХХМХТХ-ийн дээрх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн сайд 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Биеийн давхцалгүй өгөгдөл (хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах тухай 04 дүгээр албан даалгаврыг гаргасан ба уг даалгавраар эрүүл мэндийн байгууллагын хуулиар зөвшөөрснөөс бусад аргаар цуглуулсан, хадгалсан биеийн давхцалгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийн мэдээллийг устгах, биеийн давхцалгүй өгөгдлийг ашиглах үйл ажиллагааг зогсоосон хэдий ч өрхийн эмнэлэгт очиж цахим жор бичүүлэх бүрд тухайн үйлчлүүлэгчийг хурууны хээгээр нь таньж байна.

ХХМХТХ-ийн 15 дугаар зүйлд заасан хувийн мэдээллээ устгуулах эрхийг хуульчилсан. Банк болон ББСБ-д авагдсан хувийн мэдээллээ устгуулах гомдол, хүсэлтийг Комисст иргэдээс цөөн боловч гаргаж байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар зээлдэгчийн сүүлийн зургаан жилийн зээлийн мэдээллийг хадгалахаар зохицуулсан тул тус мэдээлэл энэ хугацааны дараа устгагдах боломжтой, харин төрийн байгууллагын тухайд хуульд хүний хувийн мэдээллийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд зааснаар хадгалж, устгаж байна.

Эрүүгийн хариуцлага хүлээсэн тухай мэдээлэл нь хүний эмзэг мэдээлэл бөгөөд энэ мэдээллийг задруулах, улмаар ажил, хөдөлмөр эрхлэх, төрийн алба хаших, аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрхийг хэтрүүлэн буюу хууль зөрчиж хязгаарласан талаарх гомдол Комисст цөөнгүй ирж байна.

Гэмт хэргийн мэдээллийн санд хийсэн үнэлгээ

Хүний хувийн мэдээллийг төрийн байгууллагаас цуглуулан, боловсруулж, ашиглаж байгаа нэг тохиолдол нь Цагдаагийн албаны тухай хууль (цаашид “ЦАТХ” гэх)-ийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.1.10 заалтуудад заасан ял шийтгүүлсэн хүний талаар болон эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаарх тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа явдал юм.

ХХМХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад зааснаар ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх тухай мэдээлэл нь хүний хүний эмзэг мэдээлэл бөгөөд зөвхөн хуульд заасан тохиолдолд уг мэдээллийг үндэслэн хүний зарим эрхийг хязгаарлах боломж бий болдог түүнчлэн хүний нэр төр, алдар хүндэд нь халдах боломжийг хамгийн ихээр агуулдаг тул уг асуудалд Комиссоос онцгой ач холбогдол өгөн холбогдох мониторингийн ажлыг хийлгүүлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт Монгол Улсын иргэн нь “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй” гэж заасан бол Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 12 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлийн 1 болон 2 дугаар хэсэгт “... Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй” гэж хүний нэр төр, алдар хүндийг эрхэмлэн хамгаалах үүргийг төрийн байгууллагад оногдуулсан байна.

2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн ХХМХтХ болон НМИТБтХ-иудтай уялдуулан ЦАтХ-ийн 38 дугаар зүйлд холбогдох өөрчлөлтийг оруулсан нь төрийн байгууллагаас иргэний эмзэг мэдээлэл болох ял эдэлж байгаа болон ял эдэлсэн тухай мэдээллийг хамгаалах, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах чухал алхам болсон.

ЦАтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтад “Цагдаагийн төв байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийнхээ хүрээнд тус хуулийн 61.1-д заасан мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах чиг үүрэг гүйцэтгэнэ” гэж заасан бол 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт “Цагдаагийн байгууллага дараах тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сүлжээ, сан үүсгэн үйл ажиллагаандаа ашиглана” гээд 20 төрлийн санг шууд нэрлэн заажээ. Харин ганцаарчилсан ярилцлагын судалгааны оролцогчоос энэ талаар асуухад цагдаагийн байгууллагын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулан ашигладаг сангийн нийт тоог 24 гэж үздэг бөгөөд ЦАтХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.1.21-т “бусад” хэмээн тодорхойлсон болон 61.7 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага өөрийн өдөр тутмын үйл ажиллагааны шуурхай, үр дүнтэй байдлыг хангах зорилгоор өөрийн дотоод хэрэгцээнд бусад төрлийн мэдээллийн санг байгуулж болно” гэж заасны дагуу байгуулсан Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сан зэрэг 4 сан байдаг гэсэн мэдээллийг өгсөн. Үүнээс үзвэл Цагдаагийн байгууллагын ашиглаж байгаа сангуудыг тогтмол үйл ажиллагаатай болон түр хэрэглээний гэж ангилж болох бөгөөд одоогоор 24 санг тогтмол үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ХХМХтХ-ийн 5 дугаар зүйлд мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад баримтлах зарчмыг хуульчилсан бөгөөд уг зүйлийн 5.1.4 дэх заалтад “мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулж, боловсруулж, ашиглана” гэж заасан. ЦАтХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт “Хүнийг эрэн сурвалжлах тохиолдолд түүний ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, үндсэн захиргаа, гэрэл зураг, биеийн өндөр, жин, онцлох содон тэмдэг, эрэн сурвалжлах үндэслэл зэрэг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийтэд мэдээлж болно” гэж заасныг эрэн сурвалжлах ажиллагаанд сурвалжлагдаж байгаа хүний хувийн зарим мэдээллийг бусдад түгээх боломжтой гэж ойлгох хууль зүйн үндэслэл болохгүй.

Оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн болон зөрчил үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаанд тухайн этгээдийн талаарх мэдээллийг Цагдаагийн байгууллага ихэвчлэн гомдол шалгах, гэмт хэргийн талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд эсвэл зөрчлийн хэрэг шийдвэрлэх явцад хууль, журмын дагуу урьдчилан цуглуулж авсан байдаг бөгөөд ийнхүү цуглуулсан мэдээлэлдээ үндэслэн Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санд хүний мэдээллийг эрэн сурвалжлахаар байршуулдаг байна.

Ингэхдээ ХХМХтХ-ийн 4.1.11 дэх заалтад заасан хувийн мэдээллийг ил болгохгүй байхад анхаарч, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх бодлого баримтлахаар Монгол Улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (цаашид “ЦБҮАЖ” гэх)-д заажээ. Харин тээврийн хэрэгсэл, ухаалаг төхөөрөмж, мал амьтан, эд зүйл зэрэг эд хөрөнгө нь мөн л “хүний хувийн мэдээлэл”-д хамаарах боловч эдгээрийг эрэн сурвалжлуулах этгээд нь эрэн сурвалжлуулахаар гаргаж байгаа хүсэлтдээ өөрөө эдгээр мэдээллийг бусдад задруулах, түгээхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлдэг учир тухайн этгээдийн зөвшөөрлөөр цуглуулсан, дамжуулсан, түгээсэн мэдээлэл гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Цагдаагийн байгууллагын сангуудад ашиглагдаж байгаа мэдээллийн хэмжээг нарийвчлан тооцоолох боломжгүй боловч нийтэд нээлттэй эх сурвалжийг судалж үзэхэд улсын хэмжээнд 2023 онд нийт 22,980 гэмт этгээд нийт 33,477 гэмт хэрэг үйлдсэн, 2024 онд нийт 24,282 гэмт этгээд 39,802 гэмт хэрэг хэрэг үйлдсэн нь тус тус бүртгэгдэж гэмт хэргийн тоо 18.9 хувиар өссөнийг цагдаагийн байгууллагад тус тус бүртгэж²³⁵, хэрэг тус бүрийн холбогдох мэдээллийг цуглуулан бэхжүүлж, цахим хэлбэрт хувирган холбогдох сангуудад

²³⁵ ЦЕГ-ын албан ёсны вэбсайт, “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ”, дэлгэрэнгүйг дараах холбоосоор хандаж үзнэ үү: <https://information.police.gov.mn/a/5554> (2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар хандсан.)

хадгалж, ашиглаж байгаа нь цагдаагийн байгууллагын санд байгаа мэдээллийн зөвхөн нэг хэсэг юм.

Цагдаагийн байгууллага нийт 13 төрлийн эрэн сурвалжлах ажиллагаанд ASAP санг ашиглаж байна. Энэ нь нийтэд ил тод сан биш харин Цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд зөвхөн алба хаагчдын хүрээнд ашиглагддаг сан болно. Эдгээрээс шууд хүнтэй холбоотой дараах 5 төрлийн сангийн 2024 оны жилийн эцсийн байдлаар статистик мэдээллийг дараах байдлаар өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 3.5. Эрэн сурвалжлах үйл ажиллагааны тоон мэдээ, 2024 оны байдлаар

Д/д	Эрэн сурвалжлалтын чиглэл	Ажиллагаа а зарласан	Ажиллагаа зогсоосон	Ажиллагаан д байгаа	Гүйцэтгэл /хувь/
1	Сураггүй алга болсон хүн	4,729	4,544	185	96.0
2	Оргодол	1,530	1,344	186	87.8
3	Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд	6,610	5,819	791	88.0
4	Цогцос	144	131	13	90.9
5	Шүүхээс даалгасан бусад хүн	8,120	6,189	1,931	76.2

ЦАТХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 61.1.19-д зааснаас бусад мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж зохицуулсны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/410 дугаар тушаалаар Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам, Иргэн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон хүлээж байсан эсэх лавлагааг авах эрх бүхий байгууллагын жагсаалт, Эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон хүлээж байсан эсэхийг шалгах хуудас болон Мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудасны загварыг тус тус баталсан байна.

НМИТБТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад ““мэдээлэл ашиглах” гэж мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцахыг” гэж тодорхойлсны дагуу мэдээлэл дамжуулж байгаа нь мэдээлэл ашиглах нэг хэлбэр тул уг журмын дагуу ял эдэлж байсан тухай мэдээллийг төрийн байгууллага руу дамжуулах нь хуульд заасны дагуу мэдээлэл ашиглаж байгаа хэлбэр болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/410 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан Иргэн, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон хүлээж байсан эсэх лавлагааг авах эрх бүхий байгууллагын жагсаалтад “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.36-д заасан “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны шатанд дээрх төрлийн лавлагаа, мэдээллийг шууд авах эрх бүхий байгууллага”-аар шүүх, прокурор, АТГ, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг тогтоосон байна. Энэхүү хавсралтад зааснаар холбогдох хууль хяналтын байгууллагууд хүний эмзэг мэдээллийг зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд л авч ашиглахаар зохицуулсан нь хүний эрхийг хангах үүднээс зүйтэй алхам болсон гэж үзнэ. Ингэснээр e-Mongolia системд байршуулсан ял эдэлж байгаа болон ял эдэлсэн мэдээллийг зөвхөн мэдээллийн эзэн өөрөө зөвшөөрсөн тохиолдолд дамжуулах зохицуулалт улам “батажсан” гэж үзнэ.

ХХМХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт мэдээлэл хариуцагчийн үүргийг, 20 дугаар зүйлд мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хуульчилсан байна. Хүний эмзэг мэдээллийг ашиглаж байгаа мэдээлэл хариуцагч болох цагдаагийн байгууллага эдгээр үүрэг, арга хэмжээг ЦАТХ, ЦБҮАЖ-д хэрхэн тусган, биелүүлж байгааг судалгаагаар тогтоожээ. Тухайлбал, ХХМХТХ-ийн дээрх зохицуулалтуудыг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангуудын эрх зүйн зохицуулалттай харьцуулан дүгнэж үзвэл цагдаагийн байгууллага нь үндсэндээ доор дурдсан 9 үүргийг хүлээхээр зохицуулсан үзэж болохоор байна. Үүнд:

1. Хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдүүлэх;
2. Мэдээллийн эзнээс хувийн мэдээллийг нь өөрийнх нь зөвшөөрөлд үндэслэн, гарч болох үр дүнг тодорхой тайлбарлан цуглуулах;
3. Шаардлагатай тохиолдолд мэдээлэл өгөхгүй байх эрхийг нь хүндэтгэх;
4. Цуглуулсан мэдээллийг баталгаажуулах, бүртгэх, хадгалах;
5. Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгдэх мэдээллийн системийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангах;
6. Хүний хувийн мэдээллийг зориулалтын дагуу хууль ёсоор ашиглах, өөрт нь үнэ төлбөргүй өгөх, хууль зөрчин задруулахгүй байх;
7. Мэдээлэл алдагдсан үед хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж бэлэн байдлыг хангах;
8. Мэдээллийн аюулгүй байдлыг алдагдуулсан зөрчилд хариуцлага хүлээлгэх;
9. Мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаанд үнэлгээ хийж тайлагнах.

Хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдүүлэх хүрээнд тодорхой мэдээллийн сангуудыг ашиглах журмыг ЦБҮАЖ-д дэлгэрэнгүй зохицуулсан байна. Тухайлбал, ЦБҮАЖ-ын код 229-д Хүний эрэн сурвалжлах үйл ажиллагааны талаарх журмыг тогтоосон бөгөөд энэ журамд ХХМХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад заасан хувийн мэдээллийг ил болгохгүй байхад анхаарч, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх бодлого баримтлахаар заажээ.²³⁶

Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээллийн сан бүрдүүлэх, лавлагаа олгох үйл ажиллагааг ЦБҮАЖ-ын код 706-аар зохицуулсан бөгөөд анхан шатны шүүхээс ирүүлсэн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл”, “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хуулийн этгээдийн тухай тэмдэглэл”, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ирүүлсэн “Шүүхийн мэдэгдэх хуудас”, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн ялтны хувийн хэрэгт буй “Ялтны судалгааны карт” болон холбогдох бусад материал, шүүхийн шийдвэр түүнийг гүйцэтгэсэн тухай тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн уучлал үзүүлсэн зарлиг, прокурорын тогтоолын эх хувь болон хуулбар, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим мэдээллийн сан дахь мэдээллийг программ хангамжийн дагуу цахим санд цуглуулан оруулж бүрдүүлдэг байна.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах асуудлыг ерөнхийд нь ЦАтХ болон ЦБҮАЖ-ын Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагааг зохицуулах тухай код 700-аар зохицуулсан бөгөөд тодорхой үйл ажиллагааг зохицуулсан холбогдох журам, код тус бүрд нь аюулгүй байдлыг хангах, мэдээлэл задруулахыг хориглох асуудлыг зааж зохицуулсан байна.

ЦАтХ тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.8 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол цагдаагийн байгууллага, алба хаагч үүргээ гүйцэтгэх үедээ төрийн байгууллагын төвлөрсөн мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах эрхтэй” гэж заасан бол, мөн хуулийн 61.9 дэх заалтад “Цагдаагийн алба хаагчийн энэ хуулийн 61.1, 61.8-д заасан мэдээллийн санд нэвтэрсэн, ашигласан үйлдэл нь мэдээлэл боловсруулах нэгдсэн сүлжээнд бүртгэгдэн хадгалагдах бөгөөд энэ чиг үүргийг цагдаагийн төв байгууллагын мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгж гүйцэтгэнэ” гэж заасан байгаа зохицуулалтыг эргэж харах шаардлагатай. 2017 онд ЦАтХ-ийг баталж байхад тус улсад хэрэгжүүлж байсан төрийн цахим засаглалын бодлого, хууль эрх зүйн орчин үндсэндээ өөрчлөгдсөн бөгөөд 2022 оноос эхлэн дагаж мөрдөгдөж байгаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, ХХМХтХ зэрэг цахим хөгжлийг дэмжихэд чиглэсэн хуулиуд батлагдан гарснаар суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих системд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцохтой холбоотой харилцааны зохицуулалт өөр түвшинд гарсан. “Хуульд заасан”-ыг

²³⁶ ЦБҮАЖ-ын код 229-ийн 229.2 дахь зүйлийн 2.2 дахь заалт.

ёсчлон хэрэгжүүлэх төрийн, иргэний байгууллага болох цагдаагийн байгууллага нь "хуульд өөрөөр заагаагүй бол" гэсэн үндэслэлээр төрийн байгууллагын мэдээллийн санд шуурхай нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах эрхтэй" гэсэн зохицуулалт нь хэрвээ хэрэгжвэл эсхүл хэрэгжиж байгаа бол цагдаагийн алба хаагчдад дураар авирлах боломжийг олгосон зохицуулалт гэж үзнэ.

ЦБҮАЖ-ын журмын 717.4.2-717.4.4 дэх заалтуудад "Мэдээлэл, танилцуулгын сан, программ хангамж нь гаднын зөвшөөрөгдөөгүй хандалтаас хамгаалагдсан байх бөгөөд цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан нь "Цагдаагийн байгууллагын мэдээлэл, холбоо, технологийн бодлого, журам"-д заасан шаардлагыг хангасан мэдээллийн сүлжээ, компьютер, түүнтэй адилтгах тоног төхөөрөмж ашиглан тусгайлсан нууц кодоор мэдээллийн санд нэвтрэнэ, мэдээлэл, танилцуулгын санд нэвтрэх эрхийг олгосон албан тушаалын жагсаалтыг тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор Цагдаагийн төв байгууллагын дарга баталж, энэ нь нэг жилийн хугацаанд хүчинтэй байна, мэдээллийн сангаас холбогдох мэдээллийг авсан бол "log" буюу хэрэглэгчийн эрхээр хандсан тухай мэдээлэл нь хувийн "PV" кодоороо бүртгэгдээд хадгалагддаг зэргээр мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хэрэглэгдэх мэдээллийн системийн бүрэн бүтэн, нууцлагдсан байдлыг зохицуулсан бол ЦАТХ тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.5 дахь хэсэгт "Хуульд зааснаас бусад тохиолдолд цагдаагийн алба хаагч хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой мэдээллийг хайх, цуглуулах, хэрэглэх, тараахыг хориглоно" гэж мэдээллийн санг хууль зөрчин ашиглахгүй, задруулахгүй байх эрх зүйн үндэслэлийг давхар баталгаажсан байна.

ЦБҮАЖ-ын код 229-д Хүний эрэн сурвалжлах үйл ажиллагааны талаарх журмыг тогтоохдоо Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11-д заасан хувийн мэдээллийг ил болгохгүй байхад анхаарч, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх бодлого баримтлахаар заасан нь хэт ерөнхий зохицуулалт гэж үзэж байна. Тодруулбал, хүнийг эрэн сурвалжлах ажиллагаанд тухайн хүний гэр бүлийн байдал буюу эхнэр, нөхөр, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, үр хүүхэд, найз нөхөд, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн талаарх мэдээлэл, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж зэрэг төрөөс авдаг халамж, үйлчилгээний талаарх мэдээлэл, банк, харилцах данс, хадгаламж, төлбөр тооцоо, зээл зэрэг санхүүгийн талаарх мэдээлэл, харилцаа, холбооны талаар суурин болон үүрэг холбооны үйлчилгээ, олон нийтийн сүлжээ зэрэг мэдээлэл, татвар төлөлт, хөнгөлөлт, эмнэлэг, сувилал, асрамж, эрүүл мэнд бусад даатгал, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг ашиглаж болохоор заасан байх бөгөөд эдгээр мэдээллийг зөвхөн цагдаагийн бие бүрэлдэхүүнд мэдэгдэх эсвэл олон нийтэд зарлан мэдээлэх эсэх талаар зохицуулсан тодорхой журам байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Эрэн сурвалжлагдаж байгаа хүний хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн талаарх мэдээлэл, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж зэрэг төрөөс авдаг халамж, үйлчилгээний талаарх мэдээлэл, банк, харилцах данс, хадгаламж, төлбөр тооцоо, зээл зэрэг санхүүгийн талаарх мэдээлэл, харилцаа, холбооны талаар суурин болон үүрэг холбооны үйлчилгээ, олон нийтийн сүлжээ зэрэг мэдээлэл, татвар төлөлт, хөнгөлөлт, эмнэлэг, сувилал, асрамж, эрүүл мэнд бусад даатгалтай холбоотой мэдээллийг ямар ч тохиолдолд цуглуулах, боловсруулах, ашиглах ялангуяа дамжуулах нь ХХМХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад заасан "мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах зарчимтай зөрчилдөнө. Учир нь ЦАТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт "Хүнийг эрэн сурвалжлах тохиолдолд түүний ургийн овог, эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, үндсэн захиргаа, гэрэл зураг, биеийн өндөр, жин, онцлох содон тэмдэг, эрэн сурвалжлах үндэслэл зэрэг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийтэд мэдээлж болно" гэж зохицуулсан бол уг хэсэг дэх "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар хориглоогүй мэдээлэл" нь хуульд заасан үндэслэлээр болон мэдээллийн эзний зөвшөөрлөөр цуглуулагдаж байгаа мэдээллийн хүрээгээр хязгаарлагдана.

ЦАТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар

- гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүн, эсхүл оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, ял оногдуулахыг тэнсэж албадлагын арга хэмжээ авагдсан хүн;
- хулгайлагдсан, барьцаалагдсан хүн;
- оршин суугаа газраасаа алга болсон хүн;
- сураггүй алга болсон хүн;
- эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;
- шүүхээс даалгасан бусад этгээд;
- хэн болох нь тодорхойгүй цогцыг тогтоох зорилгоор хүнтэй холбоотой эрэн сурвалжлах ажиллагааг явуулж байна.

Барьцаалагдсан, алга болсон, сэтгэцийн эмгэгтэй хүн болон цогцостой холбоотойгоор эрүүл мэндийн, хөрөнгийн зэрэг маш олон төрлийн мэдээллийг цуглуулж байгаа нь ХХМХТХ-д заасан мэдээллийг хуульд заасан үндэслэлээр цуглуулах, ашиглах болон хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг зөрчихөөр байгаагаас гадна мэдээлэл цуглуулах зорилго нь эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн ялгаатай байдлыг харгалзахгүйгээр тогтоож байгаа нь мэдээлэл цуглуулах зорилго тодорхой байх хуулийн шаардлагыг хангахгүй байна гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагаас хүнийг эрэн сурвалжилж байгаа талаарх мэдээллийг өөрт нь гар утасны мессежээр болон e-Mongolia систем бусад хэрэгслээр мэдээлдэг талаар ганцаарчилсан ярилцлагын судалгааны оролцогч хэлж байсан байна. Мэдээллийг ийнхүү шуурхай өгч байгаа нь сайн талтай боловч гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг зөрчсөн зэрэг зарим тодорхой тохиолдолд ийнхүү эрэн сурвалжилж байгаа талаарх мэдээллийг хэрэгт холбогдсон этгээдэд өгөх нь хохирогчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой байдаг тул зарим тохиолдолд эрэн сурвалжилж байгаа талаарх мэдээллийг өөрт нь өгөхгүй байх боломжтой зохицуулалтын бий болгох эсэх талаар судлах нь зүйтэй юм.

Ял эдэлж байсан лавлагаа нь Цагдаагийн байгууллагад ямар нэгэн боловсруулалт хийгдэхгүйгээр хадгалагдаж байгаагаас шалтгаалан олон жилийг өмнө гэмт хэрэгт шийтгүүлсэн, тухайн шийтгүүлсэн гэмт хэрэг нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон тохиолдолд уг лавлагаанаас үүдэлтэйгээр иргэн зарим төрлийн эрхээ хязгаарлуулах боломжтой байгаа зохицуулалтыг залруулах нь хүний эрхийн зарчимд нийцнэ гэж Комисс үзэж байна.

Тохиолдол 3.20

Иргэн В.Б нь 1998 онд тухайн үеийн Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 131 дүгээр зүйлд заасан “бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах” гэмт хэрэгт шийтгүүлж, 25,000.00 (Хорин таван мянган) төгрөгөөр торгуулсан байна. Иргэн В.Б нь өөрийн үүсгэн байгуулсан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирлаар ажилладаг ХХК-даа Төлбөрийн карт хүлээн авах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Монголбанканд хүсэлт гаргасан байна. Тэрээр зөвшөөрөл хүсэх өргөдөлдөө Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны А/91 дүгээр тушаалаар баталсан Төлбөрийн системийн журмын 2 дугаар зүйлийн 2.1.13-т “Хүсэлт гаргаагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, шийдвэр гаргах түвшний ажилтнууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн эсрэг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээгээгүй болохыг нотлох холбогдох байгууллагын тодорхойлолт” гэж заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолтоо e-Mongolia системээс авч, хавсаргажээ.

Төлбөрийн системийн журамд хүсэлт гаргаагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага нь “эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байх” шаардлагыг ерөнхий байдлаар тогтоосон нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон, нийгмийн аюулын хэр хэмжээ, хор уршгийн

хувьд ялимгүй гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүсэлт гаргаагчийн эрх ашиг хөндөгдөх, хүний эрх зөрчигдөх нөхцөл үүсгэж байна.

Иргэн В.Б-ийн бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, булаах, далайлган сүрдүүлэхээс бусад аргаар бага хэмжээтэй ашиглан шамшигдуулсан үйлдэл нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан 1986 онд баталсан Эрүүгийн хуулийн дагуу хөнгөн гэмт хэрэг. 2015 онд баталсан, одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Эрүүгийн хуульд “бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлаагүй. Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлд “хөрөнгө завших” гэмт хэргийг зохицуулахдаа “энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй” гэсэн тайлбар хийжээ. Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасан.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим нь Эрүүгийн хууль, Монгол Улсын олон улсын хүний эрхийн гэрээний суурь зарчим болно. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ” гэж, 2 дах хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан. Энэ зарчмыг мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 11 дүгээр зүйлийн 2, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 15 дугаар зүйлд баталгаажуулсан болно.

Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх хууль ёсны байх зарчим нь эрүүгийн эрх зүйн суурь зарчим болно. Энэ зарчмыг Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хуульчилжээ. Иймд Төлбөрийн системийн журамд тусгасан эдийн засаг, өмчлөх эрхийн агуулгыг хүчин төгөлдөр мөрдөж буй Эрүүгийн хуулиар гэмт хэрэг гэж тогтоосон үйлдэл, эс үйлдлийн хүрээнд авч үзэх нь шаардлагатай.

Тодорхой төрлийн албан тушаал хаших, зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгоход шалгуур, хязгаарлалт тогтоох нь нийтийн эрх ашгийг хамгаалах чухал арга хэмжээ боловч ийнхүү тогтоосон шалгуур зохистой, тэнцвэртэй байх нь хүний эрхийн зарчим юм. Карт хүлээн авах зорилгоор төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгоход хүсэлт гаргаагч эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нягтлах нь нийтийн эрх ашигт нийцнэ. Харин иргэн В.Б-ийн 28 жилийн өмнө гаргасан үйлдэл нь 1986 оны Эрүүгийн хуулиар хөнгөн гэмт хэрэг боловч одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцохгүй болсон нөхцөл байдлын улмаас тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хянан үзэхгүй байх шийдвэр гаргах нь хүний эрхийн хязгаарлалт тохирсон байх зарчимд нийцэхгүй гэж үзэж 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Комиссын гишүүний 04/14 дүгээр Зөвлөмжийг Монголбанкны Ерөнхийлөгчид хүргүүлсэн боловч өнөөдрийн хүртэл иргэн В.Б-ийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоогоогүй байна.

Цагдаагийн байгууллагын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн холбогдох албан тушаалтнаас тодруулахад, цагдаагийн байгууллага нь анхан шатны шүүхээс ирүүлсэн “Эрүүгийн хариуцлага хүлээсэн хүний тухай тэмдэглэл” давж заалдах болон хяналтын шатны шүүхээс ирүүлсэн “Шүүхийн мэдэгдэх хуудас”-ыг үндэслэн зохих мэдээллийг санд тусган уг мэдээллээр үйлчилдэг, ямар ч өөрчлөлтийг оруулж боловсруулалт хийх боломжгүй гэх тайлбарыг өгч байгаа нь хууль дээдлэх зарчмын хүрээнд зөв юм. Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ сонгох, аж ахуй эрхлэх эрхийг бүрэн, шударгаар хангах хүрээнд зайлшгүй Зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хуулийн үзэл санааг зөв баримтлан, “хууль давсан” захиргааны хэм хэмжээний актыг батлахгүй байх эрх зүйн соёлыг төлөвшүүлэхэд бүх шатны төрийн байгууллага анхаарах нь зүйтэй.

Ковид-19 цар тахлын үеэр цугларсан хувийн мэдээллийн нөхцөл байдал

Ковид-19 цар тахлын үеэр халдвар тархахаас сэргийлэх, илрүүлэх, хянах зорилгоор ЗГ-аас иргэн халдвар авсан эсэх, эмнэлзүйн онош, шинжилгээний хариу, эмчилгээний мэдээлэл, вакцинжуулалт, хувь хүний бусад мэдээлэл (овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, утасны дугаар, гэрийн хаяг, ажил эрхлэлт, халдвар авсан иргэний байршлын мэдээлэл, бусад иргэдтэй харилцсан харилцааны мэдээлэл)-ийг цаасан болон цахим

технологи ашиглаж их хэмжээгээр цуглуулсан. Энэ арга хэмжээний талаар ХЭҮК илтгэж,²³⁷ цахим технологи ашиглаж хувийн мэдээллийг цуглуулахад анхаарах хүний эрхийн асуудлыг сануулж байсан билээ.²³⁸ Цар тахлын үеэр цугларсан хувийн мэдээллийг устгасан, эсхүл Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагууд хадгалсан эсэх нь тодорхойгүйгээс гадна зарим санд цугларсан мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөрөөр байдлаар, өнөөг хүртэл ашиглаж байж болзошгүй байна.

Цар тахлын үеэр баталсан “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам,”²³⁹ Эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабын ажиллах журмын²⁴⁰ дагуу иргэн, хуулийн этгээдээс цугларсан баримт бичиг, мэдээллийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжид зааснаар хадгалахаар зохицуулжээ.²⁴¹ Эдгээр журмын дагуу цар тахлын үеэр цугларсан хүний хувийн мэдээллийг Улсын онцгой комиссын Шуурхай штаб,²⁴² эрүүл мэндийн байгууллагуудад, хамгаалах үүрэгтэй.²⁴³ Цар тахлын үеэр цугларсан хүний хувийн мэдээллийн байдалд ХЭҮК хяналт тавихад Улсын онцгой комиссын Шуурхай штаб “...цар тахлын үеэр цугларсан хүний хувийн мэдээлэлтэй холбоотой асуудлаар цугларсан мэдээлэл, программ, өгөгдлийн сан байхгүй, ийм чиг хүлээгээгүй” гэх мэдээллийг өгчээ.²⁴⁴ Харин ЭМЯ-аас “...хүний хувийн мэдээллийг Халдварт өвчин судлалын төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын архивд хадгалагдаж байна” гэж мэдээлжээ.²⁴⁵

Цар тахлын үеэр хувийн мэдээллийг цахим технологи ашиглаж, бүртгэх, цуглуулах үйл ажиллагаанд Комисс хяналт тавьж ажилласан. Энэ хүрээнд “E-barimt системд суурилсан бүртгэлийн аппликэйшн”, “Гэрэгэ Системс ХХК-ийн хийсэн tandalt.gov.mn цахим систем”, Эрүүл мэндийн байгууллага, Онцгой байдлын байгууллагын мэдээлэл солилцох 119.mn бүртгэлийн систем, Өвөрхангай аймагт регистрийн дугаараар хөдөлгөөн хянах аппликэйшн, Орхон аймагт байршил тогтоогч бүхий аппликэйшныг ашиглаж байсныг илтгэсэн билээ. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд зааснаар харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага иргэний байршил, хөдөлгөөнийг тэмдэглэх, бүртгэх зорилгоор ашиглаж буй аливаа программ болон техник хангамжийн өгөгдлийн санд цугларсан мэдээллийн ашиглалт, хадгалалт, хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.²⁴⁶ Гэвч Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрыг 2022 онд татан буулгаж, Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг байгуулсан бөгөөд КОВИД-19 цар тахлын үер цахим технологи

²³⁷ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20, 21 дүгээр илтгэлээс дэлгэрүүлж үзнэ үү.

²³⁸ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1/515 дугаартай зөвлөмж.

²³⁹ Улсын ерөнхий прокурор, Тагнуулын Ерөнхий Газрын дарга, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/72, А/63, А/151 дугаартай хамтарсан тушаалаар баталсан.

²⁴⁰ Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 137 дугаартай тушаалын 2 дугаар хавсралт.

²⁴¹ Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журмын 9.2 дах заалт. Эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабын ажиллах журмын 4.9.14 дэх заалтын дагуу Ковид-19 цар тахлын үеийн гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штабын ажиллах журамд штабын үйл ажиллагааг баримтжуулах, хариу арга хэмжээний багуудын мэдээ, судалгаа, баримт материалыг архивлах үүрэгтэй.

²⁴² Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтын 1675 дугаар зүйл. “Цар тахлын халдварын мэдээ, мэдээлэл, тайлан, бүртгэлийг цаасан хэлбэрээр 10 жил, цахим хэлбэрээр 10 жил, хэрэв хүний амь нас хохирсон бол байнга хадгалах зохицуулалттай.

²⁴³ Архивын Ерөнхий газрын даргын 2023 оны А/91-р тушаалын нэгдүгээр хавсралт Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтын 522 дугаар зүйлд “Өвчний түүх” 50 жил хадгалах зохицуулалттай.

²⁴⁴ ЭМЯ-ны 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 2/1289 дугаар албан бичиг.

²⁴⁵ Улсын онцгой комиссын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 64 дугаар албан бичиг.

²⁴⁶ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг.

ашиглаж цуглуулсан Монгол Улсын иргэдийн хувийн мэдээлэл хэрхсэн талаарх мэдээлэл тус яаманд байхгүй байна.²⁴⁷

КОВИД-19 цар тахлын тархалтыг хянаж зорилгоор Улсын Онцгой Комисс, ЭМЯ Харилцаа холбоо мэдээллийн технологийн газар “Гэрэгэ Системс” ХХК-тай гэрээ байгуулж, “tandalt.gov.mn” цахим системийг 2021 онд хэрэглээнд нэвтрүүлсэн юм. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/36 дугаар тушаалаар тархвар судлалын мэдээллийг цуглуулж, уг цахим системд оруулах зааварчилгааг баталжээ.²⁴⁸ Энэ хүрээнд батлагдсан тохиолдлын мэдээлэл ПГУ шинжилгээ, түргэвчилсэн оношлуураар эерэг короновируст халдварын мэдээлэл, батлагдсан тохиолдлоос судалгааны асуумжийн дагуу цуглуулсан мэдээлэл, тохиолдлын хавьтлын ажиглалтын мэдээлэл²⁴⁹ зэргийг цуглуулж tandalt.gov.mn цахим системд оруулсан байна.

“Гэрэгэ Системс” ХХК-тай байгуулсан гэрээнд цахим системд цугларсан хувийн мэдээллийг хамгаалах талаар үүрэг хүлээсэн эсэх нь тодорхойгүй байна. Энэ талаар ЭМЯ-аас “...tandalt.gov.mn цахим системийн үндсэн өгөгдлийн сан “Үндэсний Дата Төв”-д хадгалагдаж байгаа. Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв хэрэглэгчийн нэг эрхтэй, түүнийгээ дамжуулж ашигласан байсан. Харин энэ эрх одоо хаагдсан тул КОВИД-19 цар тахлын шинжилгээний өгөгдлийн санд нэвтрэх эрхийг мөн Үндэсний Дата Төвд шилжүүлж өгсөн”²⁵⁰ гэх тайлбарыг Комисст өгсөн болно. Уг цахим системд цуглуулсан хүний хувийн мэдээллийг зөвхөн цар тахалтай тэмцэх, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад ашиглах ёстой. Гэвч энэхүү мэдээллийн системийг анх цуглуулснаас өөр зорилгоор, өнөөг хүртэл хяналтгүй ашиглагдаж байж болзошгүй талаарх мэдээллийг иргэнээс Комисст гаргаж байна.

Тохиолдол 3.21

Нэрээ нууцлахыг хүссэн иргэнээс “Цар тахлын үед ашиглаж байсан tandalt.gov.mn цахим программд утасны дугаараар нэвтэрч, хүний хувийн мэдээлэлтэй танилцаж байна...” гэх мэдээллийг Комисст ирүүлсэн. Тэрээр tandalt.gov.mn-нд найзынхаа эрхээр орж, утасны дугаараар нэвтрэхэд утасны дугаар, эзэмшигчийн регистрийн дугаар, гэрийн хаяг, вакцинжуулалтын мэдээ, КОВИД-19-ын халдвар авсан эсэх тухай мэдээлэл авах боломжтой. Энэ санг эрүүл мэндийн салбарын зарим ажилтнууд эрх зүйн зохицуулалт, хязгаарлалтгүй ашиглаж байна” гэх мэдээллийг 2025 оны 3 дугаар сард гаргажээ.

Цар тахлын үеэр цугларсан хүний хувийн мэдээллийг задруулснаас хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн, хохирол учирсан бол иргэн ХЭҮК болон шүүхэд гомдол гаргах эрхтэй.²⁵¹ ЭМЯ, Улсын Онцгой Комисс, ХЭҮК-т энэ талаар гаргасан гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна. КОВИД-19 цар тахлын үеэр цугларсан хүний хувийн мэдээлэл аюулгүй, найдвартай хадгалагдаж буйг баталгаажуулах нь иргэдийн цахим төрд итгэх итгэлийг бэхжүүлж, хүний хувийн мэдээллийн талаарх төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, улмаар төрийн цахимжилтад дэмжлэг үзүүлэх жишиг болох тул энэ асуудлыг ЗГ дотоод хяналтын хүрээнд шалгах нь ач холбогдолтой юм.

САНАЛ

1. Цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах, уг аргачлалаар нэн тэргүүнд төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлж буй аливаа технологи, систем, платформ, алгоритмыг үнэлэх зохицуулалтыг ХХМХТХ-д тусгах;
2. ХХМХТХ-иар тогтоосон мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн үүргийн зөрчлийг Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд бүрэн тусгаж, гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх;

²⁴⁷ Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 14 дугаар тогтоол.

²⁴⁸ Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/36-р тушаал.

²⁴⁹ Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/36 дугаартай тушаалын хоёрдугаар хавсралтын 1.6, 1.7, 2.2 дахь тус тус заалт.

²⁵⁰ ЭМЯ-ны 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 2/1289 дугаартай албан бичиг

²⁵¹ Коронавируст халдвар (КОВИД-19/-)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3. дахь заалт.

3. Улам бүр нэмэгдэх үүрэг, хариуцлагыг нь тооцоолж, дэлхий нийтийн түгээмэл чиг хандлагын дагуу ХХМХтХ-ийн хэрэгжилтийг хангах мэдээлэл хамгаалах эрх бүхий, бие даасан байгууллагыг Засгийн газрын бүтцэд байгуулж, бэхжүүлэх талаар үе шаттай хэрэгжүүлэх бодлогыг тогтоох;
4. Хүнийг тагнах, мөрдөн мөшгөх боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмж, нийтийн болон хувийн орон зайд байрших дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем, хүний биометрик мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, халдашгүй чөлөөтэй байх эрх чөлөөг хамгаалах;
5. Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалт хүн төвтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг энэхүү илтгэлд тайлбарласан агуулгаар “Үндэсний хиймэл оюуны стратеги”-д тусгах, улмаар Монгол Улсад хөгжүүлэх, ашиглахыг хориглох хиймэл оюуны төрөл, зорилгыг тогтоосон, “Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад хүний эрхийг хангах удирдамж” батлах;
6. Нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, нөгөө талаас худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэх илэрхийлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хоруу контентыг хязгаарлах зохист тэнцвэрийг хангасан байдлаар олон нийтийн сүлжээг зохицуулах бодлогыг тодорхойлох;
7. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай болон хөдөөгийн өрх, Монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн практик ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг сөрөх бодлогыг баталж, хэрэгжүүлэх;
8. “Ковид-19” цар тахлын үед цугларсан хувийн мэдээллийн сан, түүний ашиглалтыг Засгийн газрын дотоод хяналтын хүрээнд хянаж, үр дүнг УИХ-д танилцуулах.

IV БҮЛЭГ

ЦАХИМ ТЕХНОЛОГИ АШИГЛАН ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЖЕНДЭРТ
СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй...”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт)

“...Хүн бүр ..эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй..”

(Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, 21 дүгээр зүйлийн 1,3 дах хэсэг)

“Энэхүү пактад оролцогч улсууд түүнд заасан эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй эмэгтэйчүүдэд тэгш эдлэх нөхцөлийг хангах...үүрэгтэй.”

(Эдийн засаг , нийгэм соёлын эрхийн тухай пактын 3 дугаар зүйл)

“Эрэгтэйчүүдтэй тэгш байх үндсэн дээр эмэгтэйчүүдийн эрхийг хуулиар хамгаалах, тухайн улсын эрх бүхий шүүх, төрийн бусад байгууллагаар дамжуулан алагчлах аливаа үйлдлээс эмэгтэйчүүдийг үр нөлөөтэй хамгаалахыг хангах арга хэмжээ авна”

(Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 2 дугаар зүйлийн с хэсэг)

4.1 ТАНИЛЦУУЛГА

Цахим хөгжлийн нэг “сүүдэр” нь цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл (цаашид ЦЖСХ гэж товчлох) юм. Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхгүйг жендэрт суурилсан хүчирхийлэл¹ (ЖСХ) гэх бөгөөд “мэдээлэл, харилцаа холбооны технологи болон бусад дижитал хэрэгсэл ашиглан бусдад бие махбод, бэлгийн, сэтгэл зүйн, нийгэм-улс төр, эдийн засгийн хор хохирол учруулах эсвэл хүний эрх, эрх чөлөөг зөрчих үйлдэл хийх, эсвэл ийм үйлдэл хийхэд туслах, хүндрүүлэх, нэмэгдүүлэхэд чиглэсэн бүх үйлдлийг” ЦЖСХ гэж тодорхойлжээ.²

Олон нийтийн сүлжээ, цахим орчинд цахим технологи ашиглан хүний нэр төрд халдах буюу гүтгэх, доромжлох, өдөөн хатгах, ялгаварлан гадуурхах, үзэн ядсан бичвэр нийтлэх, мөрдөж мөшгөх, садар самуун зураг бичлэг илгээх, дарамтлах, дээрэлхэх, урхидах зэрэг үйлдлүүд түгээмэл гарах болж, ЖСХ-ийг дэвэргэж, агуулга, хэлбэрийг нь өөрчилж байна.

Харин энэ шинэ нөхцөл байдалд Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон гэмт хэргийг мөрдөн шалгах, хохирогчийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх тогтолцоо бэлэн биш байгааг анхааруулж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд уг асуудлыг илтгэж байна. Энэхүү бүлгийг ЦЖСХ-ийн өнөөгийн байдал, хууль эрх зүйн орчин, мөрдөн шалгах ажиллагаа, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх гэсэн агуулгын хүрээнд холбогдох саналын хамт боловсруулав.

4.2 ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

НҮБ-ын хүний эрхийн механизмаас цахим технологи ашиглан жендэрт суурилсан хүчирхийллийн хор уршиг өсөн нэмэгдэж байгаад онцгой анхаарал хандуулж, улс орнуудыг хууль эрх зүйн орчноо сайжруулах, соён гэгээрүүлэх арга хэмжээгээ өргөжүүлэх, хохирогчдод үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхийг зөвлөж байна.

Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг анх 2006 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга “Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа”-ндаа гарган тавьж, технологийн хэрэглээтэй холбоотой нарийвчилсан судалгаа хийх нь энэ төрлийн хүчирхийллийг таньж, илүү үр дүнтэй тэмцэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэсэн.³ Үүнээс хойш дэлхий нийтээр уг асуудалд анхаарал хандуулж, НҮБ-аас хэд хэдэн тогтоол гаргасан.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 20/8 тогтоолд хүний бодит орчинд эдэлж буй эрхүүд цахим орчинд ч ижил түвшинд хамгаалагдах ёстойг баталгаажуулсан. Мөн зөвлөлийн 29/14 тогтоолд кибер дээрэлхэлт (cyberbullying), кибер мөшгөлт (cyberstalking) зэрэг цахим орчин дахь үйлдлүүдийг гэр бүлийн хүчирхийллийн төрөлд багтаасан бол зөвлөлийн 34/7 болон Ерөнхий Ассамблейн 71/119 тогтоолд цахим эрин үед хувь хүний нууцын халдашгүй байдал зөрчигдөхөд эмэгтэйчүүд, хүүхдүүд илүү өртөмтгий байгааг онцлон тэмдэглэжээ.⁴

¹ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.8 дахь заалт

² Уг тодорхойлолтыг НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагаас 2022 онд гаргасан бөгөөд уг тодорхойлолтын агуулгыг илтгэлд ЦЖСХ гэж товчилсон болно. <https://www.unwomen.org/sites/default/files/2023-03/Expert-Group-Meeting-report-Technology-facilitated-violence-against-women-en.pdf>

³ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгчийн A/HRC/38/47 дугаартай “Эмэгтэйчүүд, охидын эсрэг цахим хүчирхийллийг хүний эрхийн өнцгөөс судалсан нь” тайлангийн 10-44

⁴ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгчийн A/HRC/38/47 дугаартай “Эмэгтэйчүүд, охидын эсрэг цахим хүчирхийллийг хүний эрхийн өнцгөөс судалсан нь” тайлангийн 10-45, 10-48, 10-49

Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенц (CEDAW)-ын хороо нь эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл цахим хэлбэрээр шинэчлэгдэн гарч ирж буйг анхааралдаа авах ёстойг⁵ мөн онцолсон.

Түүнчлэн, Хүний эрхийн зөвлөлөөс 2024 оны 7 дугаар сард баталсан “Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” A/HRC/56/L.15 тогтоолд Хүний эрхийн зөвлөхүүдийн хороог “цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэл, охид, эмэгтэйчүүдэд үзүүлж байгаа нөлөөллийг судлах, асуудлыг нухацтай ойлгож, түүний эсрэг арга хэмжээ авах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, зөвлөмж, шийдлийг санал болгох, танилцуулах”-ыг даалгажээ. Энэхүү тогтоол нь хохирогч, даван туулагч, эмэгтэйчүүд, залуучуудын төрийн бус байгууллага, хувийн хэвшил, төрийн байгууллага, олон улсын байгууллага, бүх оролцогч талын хамтын ажиллагаа чухал болохыг онцолсон юм.⁶

НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгч 2021 онд Монгол Улсад ажиллаад ЖСХ-тэй тэмцэх, хариу арга хэмжээг сайжруулах, цахим орчин дахь хүчирхийлэлтэй үр нөлөөтэй тэмцэх хууль, тогтоомжийг боловсронгуй болгохыг зөвлөсөн.⁷

Цахим технологийн хөгжил нь охид, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн цахим орон зайг улам бүр аюултай болгож, хүчирхийлэлд өртөх талбар болж байна. “Экономист интеллиженс юнит” судалгааны байгууллагаас дэлхийн 45 улсыг хамруулан хийсэн эмэгтэйчүүдийн эсрэг цахим хүчирхийллийн судалгаанд⁸ хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн 38 хувь нь цахим орчинд хүчирхийлэлд өртөж, 85 хувь нь энэ төрлийн хүчирхийлэлд өртсөн хэн нэгнийг мэддэг гэжээ. Уг судалгаанд ЦЖСХ-д өртөж буй охид эмэгтэйчүүдийн тоо буурахгүй улам бүр өсөн нэмэгдэж байгааг онцлохын сацуу дахинаа дараах хэлбэрүүд нийтлэг үйлдэгдэж байна гэжээ. Үүнд:

Бусдын талаар хуурамч мэдээлэл түгээж, хилсээр гүтгэх 67 хувь, цахимаар дээрэлхэх 66 хувь, бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх 65 хувь, бусдын хувийн мэдээллийг хулгайлан янз бүрийн зорилготойгоор хууран мэхлэх 63 хувь, өөрт ашигтай мэдээлэл олж авах зорилгоор хэн нэгний компьютерын системд зөвшөөрөлгүй халдах, дагаж мөшгөх 63 хувь, зохион байгуулалттайгаар хор хөнөөлтэй агуулгыг нэгэн зэрэг хуваалцах 58 хувь, видео болон зураг дүрс ашиглан дарамтлах, заналхийлэх 57 хувь, өш хонзонгийн сэдлээр бусдын хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлэх 55 хувь, хүчирхийллийн заналхийлэл 52 хувь, бусдын зөвшөөрөлгүй бэлгийн сэдэлтэй контент агуулга илгээх 43 хувь тус тус байна гэжээ.

ЦЖСХ-д технологи ашигладаг, цахим орчинд идэвхтэй байдаг хэн ч өртөх эрсдэлтэй бөгөөд дэлхий дахинд хийсэн судалгаанаас харахад, охид, эмэгтэйчүүд, ялангуяа залуу эмэгтэйчүүд илүү ихээр өртөж байна. Тиймээс Монгол улс энэ төрлийн хүний эрхийн зөрчилд анхаарах шаардлагатай байна.

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос 2021 онд хийсэн “Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа”-гаар цахим гэмт хэрэгт 18-24 насныхан илүү өртсөн байх бөгөөд ялангуяа цахим орчинд оруулсан мэдээлэлдээ сөрөг сэтгэгдэл авах, айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас хүлээж авч байсан гэсэн байна.⁹ “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгаа”-гаар эцэг, эхчүүдийн 73 хувь нь хүүхдийнхээ цахим хэрэглээг хянадаг, 91 хувь нь өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй гэж боддог боловч хүүхдүүдийн судалгаанаас харахад, тэдний 87 хувь нь

⁵ НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгчийн A/HRC/38/47 дугаартай “Эмэгтэйчүүд, охидын эсрэг цахим хүчирхийллийг хүний эрхийн өнцгөөс судалсан нь” тайлангийн 11-50

⁶ <https://documents.un.org/doc/undoc/ltid/g24/109/55/pdf/g2410955.pdf>

⁷ Монгол Улс дахь НҮБ, “Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээ” УБ, 2022 он, 24 дэх тал, https://mongolia.un.org/sites/default/files/2023-08/CCA_update_MNG-24-July_final_0.pdf

⁸ The Economist Intelligence Unit, “Эмэгтэйчүүдийн эсрэг онлайн хүчирхийллийн тархалтыг хэмжих нь”, 2021 он, 51 орны мэдээллийг судалж, 45 улсын 18-74 насны 4,561 эмэгтэйг хамруулсан цахим судалгаа, <https://onlineviolencewomen.eiu.com/>

⁹ ХХЗХ, “Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа”, 2021 он, 58 дах тал.

цахим орчны халдлагад өртөж байсан бөгөөд цахим халдлагыг үе тэнгийнхэн нь нэг нэгэндээ үзүүлэх байдал өндөр буюу 57 хувь байна гэсэн үр дүн гарчээ.¹⁰

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2024 онд хийсэн “Монгол залуучуудын дундах цахим орчны дарамт судалгаа”-гаар¹¹ хүүхдүүдийн 51.3 хувь нь цахим орчинд доромжлол, гүтгэлэг зэрэг цахим дээрэлхэлтэд, 5 хувь нь цахим бэлгийн дарамтад өртсөн гэжээ.

Мөн Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр¹² 2023 онд цахим орчинд хүүхэд хохирсон гэмт хэрэг 113 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 29 буюу 34.5 хувиар өссөн байна. Дээрх бүгдээс үзэхэд, хүүхдүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр хэвээр байгаа нь энэ асуудалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Тохиолдол 4.1

...Иргэн А нь фейсбүүкийн хуурамч аккаунт үүсгэн, өсвөр насны 84 охинтой танилцан харилцаа тогтоож, тухайн охидыг сүрдүүлэх, ятгах, гуйх зэрэг байдлаар өөрсдөөр нь нүцгэн зураг, бичлэгийг нь хийлгүүлэн авч улмаар уулзаж, тухайн дүрс бичлэгийг нь олон нийтэд түгээнэ гэж сүрдүүлж, барьцаалж бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2023 онд илрүүлэн шалгасан байна.

(Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл)¹³

Дэлхий дахинд түгээмэл үйлдэгдэж буй ЦЖСХ-ийн хэлбэрүүдээс Монгол Улсад садар самуун зураг, бичлэг илгээх үйлдэл /Cyberflashing/, цахим орчинд мөшгөх үйлдэл /Cyberstalking/, бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх /Hate speech/, хуурмаг дүр эсгэж бусдыг мэхлэх, залилах үйлдэл /Catfishing/, цахим дээрэлхэл /Cyber-bullying/, бусдын байр суурь, нэр хүндэд санаатайгаар халдах, гүтгэх үйлдэл /Flaming/, гүтгэлэг, бусдыг гүтгэх, бусдын талаар хуурамч мэдээлэл түгээх, хилсээр гүтгэх /Defamation/ зэрэг 7 хэлбэр оюутан залуусын дунд илүүтэйгээр илэрч байгаа нь тогтоогджээ.¹⁴ Харин сурагчдын дунд хийсэн судалгааны үр дүнгээс харахад дээрх төрлүүдээс гадна зөвшөөрөлгүй хүний хувийн нууцыг илчлэх (Deadnaming), хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээлэх (Doxing), цахимаар өдөөн хатгах доромжлох (Trolling), өөрчилсөн дүрс бичлэг түгээх (Deepfakes: Synthetic sexual media)¹⁵ гэсэн хэлбэрүүд хамгийн их давтамжтай үйлдэгдэж байна гэжээ.

Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгааны дүнгээс үзэхэд, 18-64 насны иргэдийн 17 хувь нь айлган сүрдүүлсэн, заналхийлсэн утга бүхий зурвас танихгүй хүнээс авч байжээ.¹⁶

Тохиолдол 4.2

.. аймгийн Прокурорын газраас шүүгдэгч ... нь 2024 оны 09 дүгээр сарын 09-нөөс 10-нд шилжих шөнө гэртээ өөрийн гар утсаар нэрээ нууцалсан фейсбүүк цахим хаягаас хохирогч ...-ийн зураг бүхий “Энэ хөгшин ...авгайг таньж мэдэх нь ичтэл нь share хийгээд өгөөрэй!!! Хангалтгүй байвал өөр зураг, чатуудыг нь ил болгож болно... Айлын амьдрал үймүүлсэн бузар эм” гэх сэтгэгдлийг “Аймгийн хамгийн том зарын групп” нэртэй фейсбүүк хуудсанд нийтэлж, хүний нэр төр, алдар хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцуулахаар яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлжээ.

(Д аймгийн сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоос...)¹⁷

¹⁰ ХХЗХ, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”, 2020 он, 35 дахь тал, Улаанбаатар хот, 6 аймгийн 13-18 насны 705 хүүхдийг хамруулсан.

¹¹ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, “Монгол залуучуудын дундах цахим орчны дарамт судалгаа”, 2024 он, 9-17 насны 3620 сурагч, 1610 эцэг эхийг хамруулан хийсэн байна.

¹² ЦЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/290 дугаар албан бичгийн хавсралт.

¹³ ХЗДХЯ, ДХИС, АХБ, “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн виктимологи судалгааны тайлан” 2023 он.

¹⁴ Монгол улсын их сургууль болон Сити их сургууль, “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрийн хүчирхийлэл: оюутнуудын хүйсийн ялгаатай байдлын жишээн дээр” судалгаа, 2024 он, МУИС, АШУУИС, ШУТИС, МУБИС, СУИС, ХААИС, ХУИС, СЭЗИС, СИТИ сургуулийн 288 оюутан хамрагдсан.

¹⁵ Монгол Улсын Их Сургуулийн Жендэр судлалын төв, “ТАҮБЖСХ: Сурагчдын жишээн дээр” судалгаа, 2024 он, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийт 18,044 сурагч оролцсон бөгөөд 6,439 буюу 35.7 хувь нь эрэгтэй сурагчид, 11,605 буюу 64.3 хувь нь эмэгтэй сурагчид байв.

¹⁶ ХХЗХ, “Иргэдийн интернэтийн хэрэглээний талаарх суурь судалгаа”, 2021 он, 25 дахь тал.

¹⁷ https://shuukh.mn/single_case/114176?daterange=2024-01-01%20-%202025-02-26&id=1&court_cat=2&bb=1

ЖСХ-ийн талаарх дуудлага, мэдээллийг ЦЕГ, ХНХЯ зэрэг төрийн байгууллагууд болон энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд хэд хэдэн тусгай дугаар, чатбот сувгуудаар хүлээн авч зөвлөмж, тусламж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байна.¹⁸

ЦЖСХ-ийн шинжтэй дуудлага мэдээлэл Хүүхдийн тусламжийн 108, Цагдаагийн ерөнхий газрын 107, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн зөвлөгөө өгөх утсанд бүртгэгдэж буй хэдий ч гэмт хэргийн статистик бүртгэлд бүртгэгдсэн хэргүүдийн тухайлбал, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн хэд нь цахим орчинд үйлдэгдсэн талаарх мэдээлэл гарахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн талаар дүгнэлт, судалгаа хийхэд хүндрэл учруулж байна.

Хүүхдийн тусламжийн 108 дугаарт бүртгэгдсэн тоон мэдээллээс харахад¹⁹ 18 хүртэлх насны хүүхдүүдийн цахим орчны дарамттай холбоотой ирсэн дуудлага мэдээлэл 2023 онд 448 болж огцом өссөн байх бөгөөд энэ нь цахим дээрэлхэлт, цахим орчинд нэр төрд халдах, зураг бичлэгээр сүрдүүлэх, дарамтлах дуудлага мэдээлэл олноор бүртгэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 4.1 Хүүхдийн тусламжийн 108 дугаарт ирсэн цахим дарамтын талаарх дуудлага, мэдээллийн тоо

№	Дуудлагын төрөл	2022	2023	2024	Нийт
1.	Цахим орчинд нэр төрд халдах	26	147	23	196
2.	Зураг бичлэгээр сүрдүүлэх дарамтлах	26	75	25	126
3.	Утсаар дарамтлах	18	39	10	67
4.	Цахим дээрэлхэлт	-	118	-	118
5.	Бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох	-	13	-	13
6.	Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлэх	-	29	-	29
7.	Бусад	13	27	5	45
8.	Нийт	83	448	63	594

Тус төв нь цахим гэмт хэргийн шинжтэй дуудлага, мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт шилжүүлдэг бөгөөд 2021-2024 онд цахим орчинд бусадтай танилцаж чаталсан, нүцгэн зургаа явуулсан, “Дахин зураг бичлэг хийж явуул” гэх дарамтад өртсөн, бэлгийн мөлжлөгт өртсөн, явуулсан зураг чат ашиглаж нэр төрд халдсан, дарамталсан агуулга бүхий 235 мэдээллийг шилжүүлсэн байна.²⁰

Цагдаагийн ерөнхий газрын 107 тусгай дугаараас цахим орчинд үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг гаргуулан авахад 2022 онд 18, 2023 онд 21, 2024 онд 25 тус тус гарсан байна. Үүнээс цахим орчинд мөрдөн мөшгөх, заналхийлэх, дарамтлах, нэр төрд халдах дуудлага, мэдээлэл дийлэнх хувийг эзэлж байна.²¹ Харин ХЭҮТ-д цахим орчинд үйлдэгдсэн жендэрт суурилсан хүчирхийллийн дуудлага 2020 онд 7, 2023 онд энэ тоо хоёр дахин өсч 14 болжээ.²²

Иймд гэмт хэрэг зөрчлийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог сайжруулж, үр дүнтэй тэмцэх, хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсад ЖСХ-ийн гаралт буурахгүй, өсөх хандлагатай байна. Тухайлбал ЦЕГ-ын мэдээллээр 2024 оны эхний 9 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй хүнд гэмт хэрэг 20.2 хувь (109 байсан бол 131 болсон),

¹⁸ Бүлгийн Хохирогчид үзүүлэх хариу үйлчилгээ хэсгээс дэлгэрүүлж уншина уу.
¹⁹ Комисст ГБХНХЯ-аас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн албан цахим захидлаас.
²⁰ Хүүхдийн тусламжийн 108 утасны төвөөс 2025.03.26-ны өдөр цахимаар авсан мэдээлэл.
²¹ ЦЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/290 албан бичгийн хавсралт.
²² ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээ, 2024 он.

зөрчлийн тоо 24.3 хувиар (7,517 байсан бол 9,343 болсон) тус тус өссөн үзүүлэлттэй байна.²³

ЦЕГ-аас ирүүлсэн мэдээллээс үзэхэд, олон нийтийн сүлжээнд хуурамч хаяг үүсгэн насанд хүрээгүй охидтой танилцах, хуурч мэхлэх, өөртөө дасгах, заналхийлэх, сүрдүүлэх зэрэг арга, заль хэрэглэж, бэлгийн харьцаанд орох, интернэт орчинд эмэгтэйчүүдийн зургийг зөвшөөрөлгүй ашиглан хуурамч хаяг үүсгэж, садар самуун контент борлуулах замаар нэр хүндэд нь халдах зэрэг үйлдэл олноор бүртгэгдсэн байна.

ЦЖСХ-д технологи ашигладаг, цахим орчинд идэвхтэй байдаг хэн ч өртөх эрсдэлтэй бөгөөд охид, эмэгтэйчүүд, ялангуяа залуу эмэгтэйчүүд илүү ихээр өртдөг бөгөөд ген Зи (Gen Z буюу 1997-2012 онд төрөгсөд) болон миллениалууд (1981-1996 онд төрөгсөд) ихэвчлэн хохирогч болдог нь тогтоогджээ.²⁴

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 37 нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байруудаас 2024 оны 1 сараас 9 сар хүртэлх хугацаанд эрүүл мэнд, хамгаалал, нийгэм, сэтгэлзүйн зэрэг нэн шаардлагатай тусламж үйлчилгээг 3041 үйлчлүүлэгч авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12 хувиар (2,730 байсан) өссөн байна. Эдгээрээс насанд хүрсэн эмэгтэйчүүд 736, насанд хүрсэн эрэгтэйчүүд 145, охид 1231, хөвгүүд 929 байна.²⁵

Зарим бүлгийн эмэгтэйчүүд ажил үүргийн онцлогоос шалтгаалан цахим хүчирхийлэлд өртөх эрсдэл илүү өндөр байдаг. Үүнд, цахим орчинд олон нийтийн өмнө хамгийн идэвхтэй байдаг эмэгтэйчүүд, сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчид, улстөрчид, феминистүүд, залуу эмэгтэйчүүд байна. Түүнчлэн, бэлгийн цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ч цахимаар дайрч доромжлох явдал цөөнгүй байна.

Монгол Улсад нийгмийн сүлжээнд эмэгтэй улстөрчид, сэтгүүлчдийг илүү хатуу бөгөөд шударга бусаар шүүж, илэрхий ялгаварлан гадуурхаж, дарамталж байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллагын (ЮНЕСКО) 2021 оны тайланд ярилцлага өгсөн эмэгтэй сэтгүүлчдийн 73 хувь нь цахим хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлсэн бөгөөд сонгуулийн үеэр эмэгтэй сэтгүүлчид болон улстөрчдийн эсрэг хүчирхийлэл улам бүр нэмэгдсэн байна.²⁶

Эмэгтэйчүүдийг улс төрийн ажилд тохирохгүй гэж бусдад итгүүлэх, авч хэрэгжүүлсэн үйл хэрэг, бодлого зэргийн талаар ярихаас илүүтэй гадаад төрх байдлаар нь доромжлох, эмэгтэйчүүдийн үнэт зүйлсийг нь шүүмжлэх зэргээр тэдэн рүү чиглэсэн дайралт түгээмэл байна.

Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээний платформ ашиглаж буй байдалд хийсэн мониторингоос²⁷ үзэхэд сонгуулийн сурталчилгааны үеэр фейсбүүкийн 11 хувь, твиттерийн мэдээллийн 13 хувь нь эмэгтэй нэр дэвшигчид рүү халдсан, зүй бусаар доромжилсон, боловсрол, хүйсээр нь дорд үзсэн, худал мэдээлэл тараах, гүтгэх, ижил нэрээр хуурамч хаяг нээсэн байна.

Тохиолдол 4.3

2023 оны 03 сарын 21-ны өдрөөс эхлэн “Glory Glory” гэх цахим хаягаар “бэлгийн болон хүйсийн цөөнх олон нийтийг илчилж байна” гэж 900 гаруй хүний зургийг зөвшөөрөлгүй олон нийтийн

²³ ЖҮХ “ЖСХ-тэй тэмцэх нь 16 хоногийн аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулна. мэдээ, <https://www.ncge.gov.mn/3123>

²³ НҮБ-ын Ерөнхий Ассамблей,

²⁴ НҮБ-ын Ерөнхий Ассамблей, “Эмэгтэйчүүд, охидын эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг устгах хүчин чармайлтыг эрчимжүүлэх нь: Технологийн дэмжлэгтэй эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл” (A/79/500), 2024 он, <https://undocs.org/en/A/79/500>

²⁵ ЖҮХ “ЖСХ-тэй тэмцэх нь 16 хоногийн аян” -ыг үндэсний хэмжээнд зохион байгуулна. мэдээ, <https://www.ncge.gov.mn/3123>

²⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблей, “Эмэгтэйчүүд, охидын эсрэг бүх хэлбэрийн хүчирхийллийг устгах хүчин чармайлтыг эрчимжүүлэх нь: Технологийн дэмжлэгтэй эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэл”, 2024 он.

²⁷ “Хүний эрх хамгаалагч хүчирхэг залуус” ТББ, УИХ-ын 2024 оны сонгуулийн үйл ажиллагаанд олон нийтийн сүлжээний платформ ашиглаж байгаа байдалд хийсэн мониторинг.

сүлжээнд байршуулж, хүний эмзэг мэдээллийг задруулсан үйлдэл гарч байсан. Цахим орчинд хүний дүрсийг зөвшөөрөлгүй тараасны улмаас маш олон ЛГБТИК+ хүмүүс сэтгэл зүйн дарамтад орж, ялгаарлан гадуурхалт, заналхийллийн хохирогч болсон. Тус хүний эрхийн зөрчлийг баримтжуулан Цагдаагийн байгууллага болон ХЭҮК-т гомдол гаргасан боловч IP хаягийг тогтоох боломжгүй буюу цахим орчинд технологи ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн хариуцагчийг олж чадахгүй байсаар байна.

ЛГБТ төвөөс ирүүлсэн мэдээлэл²⁸

Монгол Улсад ЦЖСХ нь үйлдэгдэж байгаа боловч нарийвчилсан статистик судалгаа ховор байна. Хууль зүйн хүрээлэнгээс 2022 онд хийсэн “Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах тухай судалгаа”-нд худал мэдээлэл тараах, хувийн нууцад халдах, задруулах, садар самууныг сурталчлах зэрэг цахим орчинд үйлдэгддэг хүний эрхийн зөрчил нь хүйсээс ялгаатай байгаа эсэхийг нарийвчилж судлаагүй. Түүнчлэн, “Монгол Улсын интернэтийн хөгжлийг ROAM-X шалгуураар үнэлэх нь” судалгаагаар Монгол Улсын интернэтийн бодлого, хөгжил, орчин, үйлчилгээ нь эмэгтэйчүүдэд ямар байгааг үнэлэхэд хүйсээр цуглуулсан өгөгдөл мэдээлэл хомс байгаа тул хүйсээр ялгасан мэдээлэл цуглуулах шаардлагатай гэж дүгнэжээ.²⁹

Цахим технологийн хэрэглээ нь хохирогчийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Учир нь энэ төрлийн хүчирхийлэл нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран үйлдэгдэж, хохирогчийн мэдээлэл нь маш хурдан хугацаанд өргөн хүрээнд тархаж, айдас, түгшүүрт автах, сэтгэл зүйн дарамтад орох, улмаар амиа хорлох сэдлийг төрүүлдэг байна.

“Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”-нд хамрагдсан хүүхдүүдийн 43 хувь нь цахим орчны халдлагын улмаас амиа егүүтгэх талаар үе тэнгийн хүүхдүүддээ ярьж байхыг сонссон³⁰ гэх хариултыг өгсөн нь ЦЖСХ-ийн хохирогчийн сэтгэл зүйд учруулах хор хохирлын хэмжээ төдийн чинээ өндөр түвшинд байгааг илтгэж байна.

Мөн хувийн эмзэг мэдээлэл нь үүлэн системд хадгалагдсанаар хохирогчид сэтгэл зүйн дарамтад давхар орох, нийгмээс тусгаарлагдах, нийгмийн амьдралд оролцох, сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх зөрчигдөхөд хүргэдэг.

Европын Холбооны Шүүхийн шийдвэрээр “мартагдах эрх” буюу хувь хүмүүс өөрийн нэртэй холбоотой мэдээллийг хайлтын системээс устгуулах эрхтэйг тогтоосон байна.³¹ Ингэснээр зөвшөөрөлгүй тараагдсан хувийн мэдээллээ интернэтээс устгуулах эрхийг баталгаажуулсан.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь хэсэгт мэдээллийн эзэн “алдаатай мэдээллийг залруулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж өөрчлөлт оруулах, нэмэлт мэдээлэл өгч тусгуулах” гэж, 16.1.6 дахь хэсэгт “хуульд заасны дагуу өөрийн мэдээллийг устгуулах талаар мэдээлэл хариуцагчид мэдэгдэж устгуулах” эрхтэй гэж заасан. Гэвч иргэдийн энэ талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй, үүрэг хүлээгчээс хэрхэн яаж хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байна.

Гэмт этгээдүүд виртуал хувийн сүлжээ (VPN) ашиглан нэрээ нууцлах, хуурамч хаяг үүсгэх, хаяг, байршлаа өөрчлөх зэргээр ул мөрөө устгадаг, улс орнуудын эрх зүйн зохицуулалтын ялгаатай байдал зэргээс гэмт хэрэгтнийг олж илрүүлэх, мөрдөн шалгах, таслан зогсооход хүндрэл үүсэж, энэ нь хохирогчийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна.

²⁸ ЛГБТ төвөөс Комисст ирүүлсэн 2025.03.27-ны өдрийн 25/34 тоот албан бичиг

²⁹ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал түргэвчилсэн үнэлгээний тайлан” 2024 он.

³⁰ ХХЗХ, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”, 2020 он, Улаанбаатар хот, 6 аймгийн 13-18 насны 705 хүүхдийг хамруулжээ.

³¹ Краненбург, Х. Гүүглэ (Google) болон Мартагдах Эрхийн Тухай (Кейс C-131/12, Гүүглэ Испани) Европын Өгөгдөл Хамгаалах Эрхзүйн Тойм, Боть 1, Дугаар 1, 2015 он, <https://doi.org/10.21552/EDPL/2015/1/13>

4.3 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенцод заасны дагуу улс орнууд цахим хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөрдөн шалгах, хариуцлага тооцох буюу хохирогчийн эрхийг хамгаалах механизмыг бэхжүүлэх үүрэг хүлээдэг.

Монгол Улс ЦЖСХ-тэй тэмцэх, хариу арга хэмжээ авах асуудлыг Жендэрийн тэгш байдлыг хангах тухай, Эрүүгийн, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Садар самуунтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа ч шинэ тутам үүсч байгаа цахим орчинд үйлдэгдэж буй хүчирхийллийн төрөл хэлбэрийг хууль тогтоомжид нэмж тусган боловсронгуй болгох шаардлага бий болоод байна.

ЦЖСХ-тэй холбоотойгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүднээс ЖСХ-ийн үйлдлийн хамрах хүрээг тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрөгдөх нэр томьёог зөвшилцөх явдал гэдгийг олон улсын хүний эрхийн байгууллагууд чухалчилж байна.³² НҮБ түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан тайлбар, толь бичиг, эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн хэл шинжээч Т.Мөнхцэцэг 2024 онд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн 36 төрлийн “нэр томьёо” түүний агуулгын хувилбаруудыг орчуулан гаргасан байна.³³

Эдгээр нэр томьёог агуулгын хувьд ангилан үзвэл:

1. Технологи ашиглан хүний хувийн болон эмзэг мэдээллээр бусдыг цахимаар дарамтлах, дээрэлхэх, урхидах;
2. Цахим орчин дахь зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг буюу садар самуун зураг, бичлэг илгээж дарамтлах, бэлгийн сэдлээр сүрдүүлэх;
3. Цахим орчинд бусдын нэр төрд халдах, гүтгэх, доромжлох;
4. Цахим орчинд мөрдөж, мөшгөх;
5. Цахим орчинд хувийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олон нийтэд нийтлэх буюу задруулах;
6. Цахим орчинд бусдыг өдөөн хатгах зорилготой доромжилсон агуулгаар бичвэр нийтлэх эсвэл ялгаварлан гадуурхах, үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх гэх мэт.

Эдгээр нэр томьёоны агуулгаас харвал, ЦЖСХ-тэй холбоотой зарим үйлдэл Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Садар самуунтай тэмцэх тухай хууль, Кибер гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай зэрэг хууль тогтоомжид тодорхой хэмжээнд тусгагдсан байна. Харин цахим орчинд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох буюу “Online grooming”, бусдын зураг бичлэгийг өөрчилж түгээх буюу “Deepfakes”, цахимаар өдөөн хатгах доромжлох буюу “Trolling” гэх нэр томьёонд хамаарах үйлдлүүд нь холбогдох хуульд тусгагдаагүй байна. Тухайлбал,

1. Бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох буюу “Online grooming” нь интернэт болон бусад технологи ашиглан хүүхэдтэй харилцаа холбоо үүсгэж, бэлгийн харьцаа тогтоох, хүчирхийлэхэд бэлтгэх үйл явц.

Цахим орчинд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох үйлдэл Монгол Улсад цөөнгүй гарч байна. Тухайлбал, цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаанд хамрагдсан 705 хүүхдүүдийн 38 хувь нь “Манай найзууд интернэт, нийгмийн сүлжээгээр огт танихгүй хүнтэй танилцаж, хэсэг хугацаанд харилцсаны

³² НҮБХАС(2021)Бүх орон зайг аюулгүй болгох нь: Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэх дэлхийн хөтөлбөр.

³³ Т.Мөнхцэцэг, Технологи ашиглан үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийн нэр томьёо, тайлбарын хувилбарууд, 2024 он.

дараа уулзаж байсан”, 29 хувь нь “Чи хөөрхөн юм аа. Уулзах уу. Санхүү хэрэгтэй бол холбогдоорой” гэсэн агуулга бүхий мессеж, чат манай найзуудад ирж байсан, 18 хувь нь “үл таних хаягаас интернэт, чатаар найзуудтай холбогдож, бэлгийн харилцааны талаар ярилцахыг оролдож байсан”, “Хэрвээ нүцгэн зураг, хувийн мэдээллээ явуулбал мөнгө өгье” гэсэн агуулгатай мессеж найзуудад ирж байсан³⁴ гэж хариулжээ.

Түүнчлэн МУИС-ийн Жендэр судлалын төвөөс хийсэн “ЦЖСХ:Сурагчдын жишээн дээр” судалгаанд хамрагдсан ЕБС-ийн 18044 сурагчдын 6.8 хувь нь буюу 1226 хүүхэд цахим орчинд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох буюу “Online grooming”-т ямар нэгэн байдлаар өртөж байсан гэжээ³⁵

Тохиолдол 4.4

...15 настай Э нь 2023 оны 8 дугаар сараас фейсбүүкээр М гэх хүнтэй танилцаж, байнга чатладаг болж, цахимаар дотно харилцаатай болсон. нэг удаа Instagram хаягийг нь авч нүцгэн зургаа явуул гэхээр нүцгэн зургаа явуулсан. Улмаар 9 дүгээр сард хичээл эхлэх үед Э-гийн сургуулийнх нь хажууд байдаг найзындаа хүрээд гэж дуудсан. “Ирэхгүй бол нүцгэн зургийг чинь сургуулиар чинь тараана” гэж сүрдүүлсэн, айгаад очсон. Ингээд М нь 30 гаруй насны, гэр бүлтэй хүн байна гэдгийг мэдсэн. Э-тэй уулзахад согтууруулах ундаа уулгаж, хүчээр бэлгийн харилцаанд оруулсан.

Үүнээс хойш өөрийн гэртээ дуудаж аваачин нийт 3 удаа бэлгийн харьцаанд орсон. Бэлгийн харилцаанд орох үедээ согтууруулах ундаа хэрэглүүлдэг байсан. Сүүлдээ “Эмэгтэй найзыгаа дагуулж ир” гэсэн шаардлага тавьдаг болсон. Хохирогч Э нь ээжтэйгээ хамт амьдардаг байсан бөгөөд тухайн үед ээж нь гадаадад байсан. Ээж нь ирээд байдлыг гадарлаж, хэрэг илэрсэн.

(Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажилтантай хийсэн ярилцлагаас)

Үүнээс үзэхэд, гэмт этгээд бэлгийн сэдлээр хохирогчтой технологи ашиглан холбоо тогтоож, хохирогчийн итгэлтийг олох замаар өөртөө дасгаж, өөрийнхөө бэлгийн сэдэл, зорилгыг халхавчилж, дотно харилцаатай мэт дүр эсгэж улмаар бэлгийн харилцаанд хүчээр орох байдлаар илэрч байна. Гэтэл практикт энэ үйлдэл нь хохирогч өөрөө зөвшөөрсөн гэдгээр хэрэг үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох, хөнгөн ял оногдуулах, улмаар гэмт этгээд ял завших зэрэг асуудлыг үүсгэж байна. Иймд бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцож хариуцлага тооцох асуудлыг судлах шаардлагатай байна. Ингэснээр гэмт этгээдүүдийг хэрэг үйлдэхээс нь өмнө таслан зогсоох ач холбогдолтой юм.

2. Цахимаар өдөөн хатгах, доромжлох буюу “Trolling” гэж бусдыг өдөөн хатгах, залхаах зорилгоор цахим орчинд доромжилсон агуулгатай бичвэр нийтлэх үйлдэл.

“Troll”-ууд нь ихэвчлэн нэргүй, нийгмийн сүлжээнд хуурамч хаяг нээж, өөр хүний зураг, дүрс ашиглан олон янзын амьдралын түүх, туршлага, ажил төрөл, найз нөхдийн талаар хуурамч мэдээлэл үүсгэн бусдын дүр эсгэж, цахим орчны олон сувгаар нэг эсвэл бүлэг этгээд зохион байгуулалттайгаар хэн нэгнийг харлуулах байдлаар нийгмийн сүлжээнд ихээхэн илэрч байна. Гэвч энэ асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй нь ЖСХ-ийг улам дэвэргэх, хүчирхийллийг хэвийн үзэгдэл мэт хүлээн авах нийгмийг сэтгэлгээг бэхжүүлэх зэрэг хүний эрхийн олон сөрөг үр дагавар, эрсдэлийг бий болгож байна.

3. Бусдын зураг, бичлэгийг өөрчилж түгээх “Deepfakes” гэж хүний зураг болон аудио материалыг хиймэл оюун ухаанд суурилсан технологийг ашиглан өөрчилж, нэр хүндэд нь халдах үйлдэл.

Сүүлийн үед бусдын нэр хүндэд халдах зорилгоор “MioCreate”, “ElevenLabs” болон “Vindoz” гэх мэт хиймэл оюун ухааныг ашиглан бусдыг зураг, бичлэгийг өөрчлөн түгээх тохиолдол гарч, үүнд олны танил, улстөрч, сэтгүүлч, нийгмийн сүлжээнд идэвхтэй хүмүүс түлхүү өртөж байна.

³⁴ ХХЗХ, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”, 2020 он, 58 дахь тал.

³⁵ Монгол Улсын Их Сургуулийн Жендэр судлалын төв, “ТАҮБЖСХ:Сурагчдын жишээн дээр” судалгаа, 2024 он.

Тохиолдол 4.5

...Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн сурталчилгааны үеэр ... намаас нэр дэвшигчболон УИХ-ын гишүүннарын гэр бүлээс гадуурх амрагийн харилцаа ил болсон гэх зургийг “...” фэйсбүүк хуудаснаас хэд хэдэн зургийг хавсарган нийтлэгдсэн бөгөөд энэ нь 75 риакшин, 60 сэтгэгдэл, 130 шейр хийгдсэн байна. Мөнөдөрфэйсбүүк хуудаснаас ...Монголын газрыг зарсан мөнгөөрөө улс төрд орох санаатай... гэх тайлбартайгаар хоолонд орж буй хүмүүсийн зургийг түгээжээ. Уг хиймэл оюун ухаан ашиглан бүтээсэн хорёуу контентыг “Mongolian fact checking center”-ээс шалгаж, эвлүүлэг болохыг баталжээ.³⁶

Дээр дурдсан 3 үйлдлийг холбогдох хуульд бүрэн тусгаагүй нь ЦЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй хариу арга хэмжээ авах, гэмт этгээдэд хариуцлага шударгаар хүлээлгэх боломжгүйд хүргэж байна.

Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан үндсэн гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон тусгах шаардлагатай дараах гэмт хэргүүд байна. Тухайлбал, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, ялгаварлан гадуурхах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх, хууль бусаар мөрдөж, мөшгөх зэрэг гэмт хэрэг нь цахим орчинд, технологи ашиглан үйлдэгдэж байна. Эдгээр гэмт хэргүүдийг технологийн тусламжтайгаар үйлдэх нь хохирогчид эмзэг байдал, айдас, түгшүүр төрүүлэх зэргээр эрсдэлийг улам бүр нэмэгдүүлдэг. Тухайлбал, ялгаварлан гадуурхах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэж, үзэн ядсан, хүчирхийллийн шинжтэй, доромжилсон агуулгатай бүдүүлэг үг хэллэг, бичвэр илгээх, нийтлэх үйлдлээр илэрч болох бөгөөд ингэснээр олон нийтэд мэдээлэл хурдан түгээгдэж бодит орчинд үйлдэгдэх гэмт хэргээс илүү хорюу чанартай буюу урт хугацаанд сэтгэл санааны дарамт, зовуурь шаналлыг төрүүлдэг хор уршигтай. Иймд дээрх хэрэг үйлдсэн хүн, халдлагад өртсөн хохирогчийн хүн ам зүйн шинж, гэмт хэрэг үйлдсэн орчин нөхцөл, үйлдлийн арга зэргийг бүрэн хамруулсан судалгааг хийж, Эрүүгийн хуульд заасан үндсэн гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон тусгах нь зүйтэй байна.

Олон улсын түвшинд тодорхойлсон 36 төрлийн цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн “нэр томьёо”-нд хамаарах үйлдлийн 14 нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тодорхой хэмжээнд тусгасан ч эдгээр үйлдлийн арга хэлбэр, сэдэл зорилго, нийгмийн хор аюулын шинж зэргийг эргэн харж, анхаарах шаардлагатай байна. Тухайлбал:

1. Бусдыг үзэн ядсан үг хэллэг бүхий бичвэр нийтлэх (Hate speech) гэдэгт арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа зэргээр хувь хүн, бүлэг этгээдийг ялгаварлан, үзэн ядсан, доромжилсон агуулгатай бүдүүлэг үг хэллэг, бичвэр нийтлэх үйлдлийг хамааруулжээ.

Энэ үйлдэл нэг талаар Эрүүгийн хуульд заасан “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн шинжийг агуулж байх хэдий ч нийгмийн сүлжээнд хэн нэгэн хүнийг онилсон байдлаар бус бэлгийн цөөнх, үндэсний цөөнх гэх мэт нийгмийн бүлэг рүү чиглэсэн үзэн ядсан, доромжилсон үг хэллэгийг санаатайгаар нийтэлж, олон нийтийн үзэл, хандлагыг өөрчлөх, сөргөлдүүлэх, өдөөн турхирах байдлаар илэрч байгааг дараах тохиолдлууд харуулж байна.

Тохиолдол 4.6

...Улаанбаатар хотын орлогч..... нь өөрийн фэйсбүүк цахим хуудсаараа ЛГБТ Төвийн гэрээлэн байршуулсан автобус дээрх мэдээллийн материалыг хуулж буй зургуудыг оруулсан... тус зургийн тайлбар хэсэгт “Хүүхдэдээ ийм тоглоом авч өгсөн байсан юм. Гэтэл ижил хүйсийг дэмжсэн, өдөөсөн өнгө, логоо, туг, яриа байдгийг олж мэдлээ. Онцгүй сэтгэгдэл төрлөө, тоглоомыг хогны саванд хийсэн, мөн нийтийн тээвэрт мөнгө төлж рекламаа байршуулсан байсныг нь бас хуулуллаа.” хэмээн бичсэн.

...-ийн гаргасан мэдээгдэл, шийдвэр нь цахим орчинд үйлдэгдсэн жендэрийн ялгаварлан гадуурхалт хэмээн үзэж ХЭҮК, Цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч цагдаагийн байгууллага арга хэмжээ аваагүй. Харин ХЭҮК-ын гишүүн шаардлага хүргүүлсэн.

(“ЛГБТ” Төвөөс 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 25/34 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл)

³⁶ <https://mfcc.mn/factcheck-998/>

Тохиолдол 4.7

...2021 оны 09 дүгээр сараас эхлэнФейсбүүк цахим орчинд “Монголын Homophobic лалрууд” нэртэй групп зохион байгуулалттайгаар ЛГБТИК+ хүмүүсийг алах, зодох, хүчиндэх, хүчирхийлэх, террорист агууламж бүхий зураг, видео, пост оруулахаас гадна тухайн үеийн ЛГБТ төвийн ажилтнуудын зургийг олон нийтийн сүлжээнд байрлуулж, амь нас, эрүүл мэндэд нь халдахаар заналхийлсэн. Манай байгууллагаас цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч хариуцагчийг “хүнийг ялгаварлан гадуурхах үйлдэл нь хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн” гэж үзэх үйл баримт тогтоогдоогүй тул хэрэг бүртгэлийн хэргийг хаах тогтоол гаргасан.

(“ЛГБТ” Төвөөс 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 25/34 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл)

2. Олон улсад хэрэглэгдэж буй “мөрдөн мөшгөх” үйлдлийн агуулга нь Эрүүгийн хуульд заасан “Хууль бусаар мөрдөн мөшгөх” гэмт хэргээс илүү өргөн хүрээг хамруулсан байна. Үүнд:
 - “Cyberstalking” нь технологи ашиглан бусдын өнгөрсөн болоод одоогийн амьдрал, үйлдэл, зан байдлыг хянах, мөрдөх, хүсээгүй байхад нь холбоо тогтоох гэж оролдох, заналхийлэх;
 - “Cyberobsessional pursuit” нь бусдыг хүсээгүй байхад дотносох, бэлгийн дур таашаал авах зорилгоор мөшгөх, хөөцөлдөх, дарамтлах үйлдлийг хамааруулжээ.

Эрүүгийн хуульд “хууль бусаар мөрдөж мөшгөх гэмт хэрэг”³⁷ нь мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй этгээд бусдыг мөрдөн мөшгөсөн, эрх бүхий албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байхаар тусгасан нь бэлгийн сэдлээр болон цахим орчинд мөрдөх, мөшгөх үйлдэл хамаарах эсэх нь тодорхойгүй байна.

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг технологи ашиглан, гэр бүлийн хамаарал бүхий хүнийг төрөл бүрийн аппликэйшн ашиглан мөрдөн мөшгөх явдал ихээр гарч байгаа нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харагдаж байна.

Тохиолдол 4.8

...Манай байгууллагад хандсан эмэгтэй: “Манай нөхөр миний хаа явсан газрыг онлайнаар мөшгөж мөрдөөд байна, удахгүй намайг мөшгөөд энд ч гэсэн ороод ирэх байх аа” гээд яриад сууж байтал нөхөр нь араас нь орж ирсэн нь аюулын эрсдэл өндөр байгааг харуулж байна.. Бидний хувьд ийм төрлийн хохирогчдод хэрхэн, яаж туслах, ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байсан.

(Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ажилтантай хийсэн ярилцлагаас³⁸)

3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “цахим дээрэлхэлт”, “цахимаар дарамтлах”, “цахимаар урхидах” үйлдлүүдийг тусгасан нь сайшаалтай ч энэ төрлийн хүчирхийлэл нь нас, хүйс харгалзахгүйгээр хэнд ч тохиолдож болохыг анхаарах нь зүйтэй байна.

³⁷ Эрүүгийн хуулийн 13.12 дугаар зүйл.

³⁸ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2024 он.

Хүснэгт 4.2 Цахим дарамт, хүчирхийллийн төрөл хэлбэр

Төрөл хэлбэр	Олон улсад хэрэглэж буй нэр томъёоны агуулга	Хүүхэд хамгааллын тухай хуульд
Цахим дээрэлхэлт (Cyber-bullying)	Нэг эсхүл бүлэг хүн хохирогчид чиглэсэн балмад үйлдэл, үг хэллэгийг санаатайгаар давтамжтай цахимаар илгээх.	“Цахимаар дээрэлхэх” гэж цахим орчинд хүүхдийг дээрэлхэж, гадуурхсан, айлган сүрдүүлсэн, доромжилсон зүй бус агуулга бүхий мэдээ, мэдээллийг өөрт нь болон бусдад түгээхийг ойлгоно ³⁹ гэж тайлбарлажээ
Цахимаар дарамтлах (Online harassment)	Технологи ашиглан хүний хувийн болон эмзэг мэдээллээр бусдыг доромжлох, айлган сүрдүүлэх, заналхийлэх, бүдүүлэг үг хэллэг, зохисгүй зураг нийтлэх, дарамтлах.	“Цахимаар дарамтлах” гэж хүний хувийн болон эмзэг мэдээллийг ашиглан цахим орчинд хүүхдэд түгшүүр төрүүлэх, шахалт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно ⁴⁰ гэж тайлбарлажээ.
Цахимаар урхихах (Recruitment)	Гэмт этгээдүүд, хүний наймаачид технологи ашиглан болзох сайт, гэрлэлт зуучлалын агентлагуудын нэрээр хуурамч ажилд авах, суралцуулах агуулга бүхий зар нийтэлж, түүгээр дамжуулан холбоо тогтоох замаар хохирогчийг урхидан хүчирхийллийн нөхцөл байдалд татан оруулах, улмаар бэлгийн хүчирхийлэл үйлдэх.	“Цахимаар урхихах хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгоор цахим сүлжээ ашиглан хүүхэдтэй харилцаа тогтоохыг ойлгоно ⁴¹ гэж тайлбарлажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд цахимаар урхихах нь хүүхдийг зөвхөн гэмт хэрэг, зөрчилд уруу татах зорилгыг онцолсон бол олон улсад хэрэглэж буй нэр томъёоны агуулгаас харахад бэлгийн сэдэл, зорилгыг мөн хамруулсан байна.

- Цахим орчин дахь зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг буюу садар самуун зураг, бичлэг илгээж дарамтлах, бэлгийн сэдлээр сүрдүүлэх зэрэг үйлдлийг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Садар самуунтай тэмцэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Хүснэгт 4.3 Цахим орчин дахь зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг⁴²

Төрөл хэлбэр	Олон улсад хэрэглэж буй нэр томъёоны агуулга
Бэлгийн сэдэлтэй зураг, бичлэг илгээх (Cyberflashing)	Хэн нэгэн этгээд бэлэг эрхтний зураг эсвэл сексийн дүрслэл бүхий материалыг өөр хүнд зөвшөөрөлгүйгээр илгээх, хүнийг хүсээгүй байхад порнограф, эсвэл хүчирхийллийн шинжтэй садар самуун хөдөлгөөнт зураг эсвэл тухайн хүний зургийг бэлгийн харилцаанд оруулж байгаа мэтээр дүрсэлж илгээх үйлдлийг хэлнэ.
Бэлгийн сэдлээр зураг ашиглан дарамтлах, заналхийлэх (Image-based Abuse)	Хохирогчийг хүчирхийлэх, дарамтлах зорилгоор зөвшөөрөлгүй, нууцаар бэлгийн сэдэлтэй гэрэл зураг авах, зургийг бусадтай хуваалцах, хуваалцахаар заналхийлэх, сүрдүүлэх үйлдлийг хэлнэ.
Бусдыг дарамтлах зорилгоор садар самуун зураг бичлэг тараах (Revenge porn)	Бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах, өс хонзон авах зорилгоор нүцгэн зураг, бичлэгийг нь зөвшөөрөлгүй нийтлэх үйлдлийг хэлнэ.
Олон нийтэд хүчирхийллийн бичлэг түгээх, нийтлэх	Хохирогчийг айлган сүрдүүлэх зорилгоор хүчирхийлсэн, доромжилсон бичлэг хийж олон нийтэд түгээх, садар самуун

³⁹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл.

⁴⁰ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл.

⁴¹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл.

⁴² Т.Мөнхцэцэг, Технологи ашиглан үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийн нэр томъёо, тайлбарын хувилбарууд, 2024 он.

Documenting or broadcasting sexual assault (rape videos),	сурталчилдаг байгууллагад зарж, борлуулах үйлдлийг хэлнэ.
Секс илэрхийлэл бүхий бичвэр, дүрс бичлэг хийх, түгээх (Sexting and abusive sexting)	Харилцан зөвшилцөж секс хийж байгаа бичлэг хийх, нүцгэн зургаа авч бие биедээ илгээх, хэн нэгнийхээ зөвшөөрөлгүй бусдад үзүүлэх, илгээх үйлдлийг хэлнэ.
Бэлгийн дур таашаал авах зорилгоор нууцаар зураг авах, бичлэг хийх (Upskirting, creepshots and digital voyeurism)	Бэлгийн дур хүслээ өдөөх, таашаал авах сэдлээр бусдын эмзэг нууц хэсгийн гэрэл зураг авах, дуу-дүрсний бичлэг хийж, зөвшөөрөлгүй цахим орчинд нийтлэх, нийтлэхээр заналхийлэх үйлдлийг хэлнэ.

Дээрх нэр томъёоноос харахад, цахим орчин дахь зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг буюу садар самуун зураг, бичлэг илгээж дарамтлах, бэлгийн сэдлээр сүрдүүлэх үйлдлүүдийг өргөн хүрээнд тодорхойлсон байгааг анхаарч судлах нь зүйтэй юм. Учир нь сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэг технологийн тусламжтайгаар үйлдэгдэж буй арга хэлбэрүүд нь улам өргөжиж, гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгааг дараах статистик⁴³ мэдээлэл харуулж байна.

Бүдүүвч 4.1 ЦЕГ-т бүртгэгдсэн хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэргийн тоо



Тохиолдол 4.9

...Шүүгдэгч ... нь 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хугацаанд “...” гэсэн цахим хаягаас 15 настай насанд хүрээгүй хохирогч “...”-тай “...” цахим хаягаар танилцан харилцах явцдаа түүнээр нүцгэн зураг, бичлэг хийлгэн өөртөө авч, уг эмзэг мэдээллийг олон нийтэд тараана гэж бэлгийн харьцаанд орохыг шаардаж заналхийлсэн байна.

(Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоос...) ⁴⁴

Эрүүгийн хуулийн 16.8-д хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгохоор хязгаарласан байна. Энэ гэмт хэрэгт тухайн хүний зургийг бэлгийн харилцаанд оруулж байгаа мэтээр дүрсэлж илгээх, зөвшөөрөлгүй, нууцаар бэлгийн сэдэлтэй гэрэл зураг авах, зургийг бусадтай хуваалцах зэрэг үйлдлүүд хамаарах эсэх нь тодорхойгүй байна.

- Бэлгийн сэдлээр сүрдүүлэх буюу “Sextortion”, болон заналхийлэх, дарамтлах буюу “Retaliations against supporters of survivors” үйлдэлд заналхийлэх болон хувийн нууцад халдах гэмт хэргээр зүйлчилж ял оногдуулж байна.

⁴³ ЦЕГ-ын 2025 оны 02 сарын 26-ны өдрийн 01/290 тоот албан бичгийн хавсралт.

⁴⁴ https://shuukh.mn/single_case/96663?daterange=2023-01-01%20-%202023-12-25&id=1&court_cat=2&bb=1

Хүснэгт 4.4 Бэлгийн сэдлээр сүрдүүлэх, заналхийлэх

Төрөл хэлбэр	Олон улсад хэрэглэж буй нэр томьёоны агуулга	Холбогдох хууль тогтоомж
Бэлгийн сэдлээр сүрдүүлэх (Sextortion)	Бэлгийн сэдлээр сүрдүүлэх буюу бусдыг эрхшээлдээ байлгах нүцгэн зураг бичлэгийг олон нийтэд хуваалцах, нийтлэхээр сүрдүүлж, илүү олон зураг, бичлэг явуулахыг шаардах, эсвэл бэлгийн харилцаанд орохыг тулгах зорилгоор хувийн зураг, дүрс бичлэгийг ашиглах үйлдэл юм.	Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл. Заналхийлэх гэмт хэрэгт “бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн...” Эрүүгийн хуулийн 13.10 Хувь хүний нууцад халдах гэмт хэрэгт “Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан...”
Заналхийлэх, дарамтлах (Retaliations against supporters of survivors)	Хохирогчийн гэр бүл, ойр дотны хүмүүс, найз нөхөд, ажил олгогч, хамгаалагчдыг айлган сүрдүүлэх, дарамтлах үйлдлийг хэлнэ.	Уг гэмт хэргийг харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан байна.

Эрүүгийн хуульд тусгагдсан “заналхийлэх” гэмт хэрэг нь “бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотны хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, ...хэрэв уг гэмт хэргийг “бүлэглэж; зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол хүндрүүлэх⁴⁵-ээр заажээ. Энд дурдсан тусгайлан бэлтгэсэн зэвсэг гэдэгт интернэт, мэдээлэл, харилцаа холбооны технологи орж буй эсэх, мөн бэлгийн сэдлээр сүрдүүлэх, бусдыг эршээлдээ байлгах зорилгоор заналхийлэх үйлдэл хамааруулсан эсэх нь тодорхойгүй байна.

Тохиолдол 4.10

...Шүүгдэгч нь 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр өмнө хамтран амьдарч байсан, хохирогч...-г эргэж уулзахыг шаардах, цагдаагийн байгууллагад өөрийнх нь эсрэг гомдол, мэдээлэл гаргуулахгүй байх, хохирогчийн нэр төр, алдар хүндийг түүний ажлын байр, хамт олны дунд унагаах, бусдын дунд ичгэвтэр байдалд оруулах зорилгоор хохирогч...-ийн сошиал орчинд байрлах “U” гэх инстаграм хаяг руу түүний нүүр царай гарсан, нүцгэн байгаа зураг зэргийг олон нийтэд тараахаар заналхийлж сүрдүүлсэн хэрэгт буруутай тооцож Шүүхээс тусгай ангийн 13.5 дугаар зүйлд заасан заналхийлэх гэмт хэргийг мөн хуулийн 13.10 дугаар зүйлд заасан хувь хүний нууцад халдах гэмт хэргийг 13.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулж гэмт хэрэг үйлдсэн буруутайд тооцож 6.000.000 төгрөгөөр торгох ял шийтгэсэн.

(Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоос...) ⁴⁶

Эдгээрээс үзэхэд цахим технологи нь жендэрт суурилсан хүчирхийллийн дэвэргэх, хүчирхийллийг үйлдэх гол талбар болохын зэрэгцээ технологийн тусламжтайгаар түүний төрөл хэлбэрүүд өргөжиж байгаа нь оновчтой хууль эрх зүйн зохицуулалтыг шаардаж байна. Иймд Монгол Улсад технологи ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил цаашид нэмэгдэх хандлагатай байх тул дээр дурдсан олон улсын нэр томьёоны тайлбаруудыг анхааран судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цахим технологийн тусламжтайгаар үйлдэгдэж буй энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр дүнтэй хариу арга хэмжээ авах нь зүйтэй юм.

⁴⁵ Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйл.

⁴⁶ https://shuukh.mn/single_case/116034?daterange=2025-01-01%20-%202025-03-24&id=1&court_cat=2&bb=1

4.4 МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар (КГХТГ) нь цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн дуудлага, мэдээллийг хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна. Энэ нь ЦЖСХ-д хамаарах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хууль сахиулах гол нэгж⁴⁷ байна.

Цахим орчинд үйлдэгдсэн жендэрт суурилсан хүчирхийлэл (гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг) гэх мэт гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг ихэвчлэн харьяа дүүргийн цагдаагийн хэлтэст хүлээн авч, хэрэг бүртгэл нээж, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг ба шаардлагатай тохиолдолд КГХТГ-аас цахим нотлох баримтыг бэхжүүлэх, техникийн туслалцаа авах, эсвэл прокурорын заавраар хэргийг тус газарт шилжүүлэх байдлаар уг гэмт хэргийг илрүүлэх мөрдөн шалгах үйл ажиллагаа явагдаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг, хүчирхийлэлтэй тэмцэхэд тусгай мэдлэг, ур чадвартай мэргэшсэн хүний нөөц нэн чухал тул чадварлаг боловсон хүчнийг ажиллуулах боломжийг бүрдүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах, бодлого, аргачлалаар дэмжих, өнөөдрийн технологи, хэрэглээнд хариу үзүүлэхээс гадна ирээдүйд чиглэж ажиллах хэрэгцээтэй байна.

Монгол Улсад фейсбүүк, инстаграм, твиттер, тикток зэрэгт шууд зохицуулалт хийх боломжгүй, гадаад улсад сервертэй олон нийтийн сүлжээ нь идэвхтэй ашиглагддаг. Ялангуяа фейсбүүк орчинд бага болон өсвөр насны хүүхдүүдийн дунд нээлттэй, хаалттай групп идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас хаалттай группүүд их байдаг. Эдгээр хаалттай групп, чатуудад гэмт этгээдүүд хуурамч хаяг ашиглан орж, хохирогч нартай харилцаа тогтоох, садар самуун агуулгатай зураг, дүрс бичлэг солилцох, биеэ үнэлэлт зохион байгуулах зэрэг хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа тохиолдол түгээмэл байна⁴⁸.

Цахим гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинжтэй, өргөн цар хүрээтэй үйлдэгддэг тул нотлох баримт цуглуулах, гэмт этгээдийг олж илрүүлж, хариуцлага тооцох зэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулахад дараах нийтлэг асуудлууд тулгарч байна. Үүнд:

Нэг. Манай улсын иргэд гадаад улсад сервертэй олон нийтийн сүлжээ, веб сайтуудыг хэрэглэдэг бөгөөд эдгээр нь тухайн улсынхаа хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Мөрдөн шалгах ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээлэл авах талаар хүсэлт явуулдаг ч хариу өгөхгүй удаах, дийлэнх тохиолдолд хүсэлтийг хангахаас татгалздаг байна.

Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын “Мета” компанитай хамтран хууль бус үйл ажиллагаатай холбоотой контентыг устгах, хэрэглэгчийн талаарх холбогдох мэдээллийг гаргуулж авах ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хороо болон “Мета” компанийн удаа дараагийн уулзалтаар Монгол Улсад аюулгүй, ёс зүйтэй нийгмийн сүлжээний орчныг бий болгоход хамтран ажиллах шаардлагатай гэдэгт санал нэгдсэн ба “Мета” компани нь өөрийн платформ дахь хуурамч хэрэглэгчийн бүртгэлийг устгах, хууль бус контентыг хязгаарлах чиглэлээр тус хороотой хамтран “Ногоон суваг” буюу “Government Case Work Channel”-ыг ажиллуулж байна.

“Ногоон суваг”-ийн хүрээнд 2022-2024 онд цахим орчны хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхдэд хортой агуулгатай, хууль зөрчсөн дараах мэдээ, мэдээлэл, контентыг хязгаарласан байна.⁴⁹

⁴⁷ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2024 он.

⁴⁸ ДХИС, Кибер гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2023 он.

⁴⁹ ХХЗХ-ны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02/44 тоот албан бичгийн хавсралт.

Хүснэгт 4.5 Цахим орчинд хязгаарласан хууль зөрчсөн мэдээ, мэдээлэл, контентын тоо

№	Контентын агуулга	2022	2023	2024	Нийт
1	Мөрийтэй тоглоом зохион байгуулсан	1138	4196	454	5788
2	Бусад /оюуны өмч, садар самуун, залилан	0	10	17	27
	Нийт	1138	4206	471	5815

Гэвч тус компаниас хэрэглэгчийн мэдээллийг зөвхөн “терроризм”, “хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон”, “бага насны хүүхдийн садар самуун сурталчилсан контент”, “секс сүрдүүлэг” болон “үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг” зэрэгт мэдээлэл гаргаж өгнө гэж мэдэгджээ.

Хоёр. Манай улсын интернэтийн дэд бүтэц одоогоор “IP” хаягийн мэдээллийг дэлгэрэнгүй гаргах, эзэмшигчийг тогтоох, урсгалын хяналт хийх техникийн боломж хязгаарлагдмал байгаа нь кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэгтнийг олж илрүүлэхэд хүндрэл учруулж байна. Тодруулбал, нэг “IP” хаягийг олон хэрэглэгч дундаа хэрэглэдэг байдлаас шалтгаалан гэмт этгээдүүдийн тухайн цаг хугацаанд, ямар “IP” хаяг ашигласан талаарх мэдээллийг гаргуулан авах боломж дутагдалтай байна.⁵⁰

Тохиолдол 4.11

...Манай улсад ихэвчлэн жи-мэйл, фейсбүүкээр дамжуулан хүмүүс гэмт хэрэгт өртөх тохиолдол гардаг. Жишээ нь: нэг үл таних этгээд миний хувийн мэдээллийг хууль бусаар хакердаж авчхаад намайг дарамталж, заналхийлээд байна, энэ хүнийг олж өгөөд, хариуцлага тооцооч гэсэн гомдол өглөө гэж бодоход гэмт этгээд хаанаас интернэтэд холбогдож, заналхийлэл үйлдэж байгааг тогтооход хүндрэлтэй. Учир нь манай улсын ихэнх интернэтийн үйлчилгээ үзүүлэгчид IP4 хувилбарын хүрээнд IP хаягийн багцаар нь буюу нэг хаягийг 20 хүртэлх хүнд зэрэг олгодог гэж ойлгож болно. Тэгэхээр бид энэ 20 хүнээс чухам хэн нь гомдол гаргасан иргэнийг дарамталж, заналхийлж байгааг тогтоох боломжгүй болдог. Зарим тохиолдолд “Мета” компани руу ХХЗХ-р дамжуулан мэдээлэл хүсэх, мэдээлэл устгуулах хүсэлт илгээх үед “Мета” компани өөрийнхөө “Community standards” буюу дотоодын дүрмийг зөрчөөгүй байна гэж үзэх юм уу, эсвэл хэрэглэгчдийнхээ хувийн мэдээллийг хамгаалах үүднээс мэдээлэл гаргаж өгөхгүй байх тохиолдол гардаг.

Тэгэхээр энэ бол биднээс шалтгаалахгүй, дэлхий нийтийн асуудал, техникийн нөхцөлтэй холбоотой асуудал юм. Үүнийг ард иргэд ойлгохгүй “Цагдааг хэрэг илрүүлж чадахгүй байна, чадваргүй байна” гэж буруутгах хандлага гаргадаг.

(Кибер гэмт хэргийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс)⁵¹

Гурав: Кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг нь орон зайг үл хамааран нэг төхөөрөмжөөс нөгөө төхөөрөмж рүү хууль бус халдлага явуулдаг тул энгийн мөрдөгч шалгахад хүндрэлтэй, мэдээллийн технологи, харилцаа холбоо болон гадаад хэлний өндөр мэдлэг, мэргэшилтэй алба хаагч хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

Тохиолдол 4.12

...Манай хэлтэст мөрдөн байцаах ур чадвараас гадна техник, технологийн мэдлэг шаарддаг учир мэдээлэл, харилцаа, холбооны чиглэлээр мэргэшсэн хүн авч ажиллуулах зайлшгүй шаардлагатай. Гэвч ийм мэргэжилтнүүд ихэвчлэн өндөр цалинтай технологийн компаниудад ажиллах сонирхолтой байдаг. Манайх шиг ажлын ачаалал өндөр, цалин багатай газарт тэр бүр сайн мэргэжилтэн ажиллахаар ирэх нь ховор. Тиймээс хүний нөөц бүрдүүлэлт дээрээ анхаарах хэрэгтэй.

(Кибер гэмт хэргийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс...)⁵²

Кибер гэмт хэрэг тэр дундаа ЦЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголт нь Монгол Улсад харьцангуй шинэ төрлийн гэмт хэрэгт тооцогдож байгаа тул мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, прокурор, шүүхийн байгууллага тухайн хэргийг таньж илрүүлэх, мөрдөн шалган шийдвэрлэх нэгдсэн арга барил, туршлага хомс байна. Иймд хууль сахиулах

⁵⁰ ДХИС, Кибер гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2023 он.

⁵¹ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2024 он.

⁵² Мөн тэнд.

байгууллагын алба хаагчдын энэ талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрийн боловсруулж, үе шаттай сургалт зохион байгуулах шаардлагатай байна.

Дөрөв: Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар нь ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нэртэй үйл ажиллагаа явуулж байгаад 2023 оноос эхлэн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар нэртэй тусдаа бие даасан нэгж болсон ч өнөөдрийг хүртэл хүний нөөцийн дутагдалтайгаар үйл ажиллагаа явуулж байна.⁵³ Түүнчлэн КГХТГ нь гэмт хэргийг бүртгэл нээж, мөрдөн шалгах үедээ нотлох баримтыг тусгай программ болон техник хангамжийн тусламжтайгаар бэхжүүлдэг. Гэвч тус газрын албан хаагчдын мэдлэг ур чадвараас хамаарахгүйгээр техникийн хүндрэл ихэвчлэн тулгардаг байна. КГХТГ-ын албан хаагчидтэй ярилцахад “цахим нотлох баримт бэхжүүлэх программ хангамжийн хөгжил гар утас, компьютерын хурдтай хөгжлийг даган асар хурдан өөрчлөгддөг бөгөөд байгууллагын санхүүжилтийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж шинээр гарсан программ болон техник хангамжийг тухай бүр нь худалдан авч чаддаггүй” гэжээ.

Тав: ЦЖСХ нь шинэ тутам ойлголт тул энэ төрлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бүртгэж авч байгаа мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо нь хэт ерөнхий байгаа нь дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бодлого боловсруулахад хүндрэлтэй байна. Тухайлбал, жендэрт суурилсан хүчирхийллийн нэг хэлбэр болох Эрүүгийн хуулийн 14.1-т заасан “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн хэд нь цахим орчинд үйлдэгдсэн талаарх нарийвчилсан бүртгэл, мэдээлэл байхгүй байна.

Сүүлийн үед технологийн хөгжлийг даган “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх”, “хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх”, “заналхийлэх”, “ялгаварлан гадуурхах”, “хууль бусаар мөрдөж мөшгөх” зэрэг тодорхой төрлийн гэмт хэргүүд нь цахим орчинд үйлдэгдэх хандлага давамгайлж байх тул нас, хүйс, байршил, ямар платформ, хэрэгсэл ашиглаж үйлдсэн, ямар хохирол учруулсан гэх мэт нарийвчлан бүртгэх шаардлага тулгамдаж байна. Иймд цагдаа, шүүх, прокурор зэрэг хууль, хяналтын байгууллагын мэдээлэл, бүртгэлийн тогтолцоогоо технологийн хөгжилтэй зэрэгцүүлэн тогтмол шинэчилж, сайжруулах шаардлагатай.

Зургаа: Тухайн гэмт хэргийн онцлогоос шалтгаалан КГХТГ дотоодын хувийн хэвшлийн байгууллагуудаас мэдээлэл хүсэж, нотлох баримт бэхжүүлэх тохиолдол гардаг ба хувийн хэвшлийн байгууллагууд мэдээллийг түргэн шуурхай, үнэн зөв гаргаж өгөх асуудал дээр хойрго ханддаг байна. Энэ нь гэмт хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, иргэдийн хүлээлт, шаардлагад нийцэхгүй байна.

Тохиолдол 4.13

...Зарим үед бид гар утасны операторууд, банк зэрэг дотоодын байгууллагуудаас мэдээлэл хүсэж, нотлох баримтын бэхжүүлэлт хийдэг. Шаардлагатай мэдээллийг ажлын 5 хоногт эсвэл яаралтай гаргаж өгөхийг албан бичгээр хүсэж, хүргүүлдэг ч 5-аас илүү хоногт мэдээлэл гаргаж өгөх, эсвэл зарим байгууллага нь техникийн хүчин чадлын улмаас баримт, мэдээлэл өгч болохгүй байна, энэ асуудлыг хариуцан ажилладаг хүн нь амралтаа авсан гэх мэт шалтгаанаар бидний хүссэн мэдээллийг гаргаж өгөхгүй байх тохиолдол гарна. Үүнээс улбаалж мөрдөн шалгах ажиллагаа хугацаа алдах, арга мухардах байдал руу орох үе гардаг. Хувийн хэвшлийнхэн бидний хүссэн мэдээллийг гаргаж өгсөн ч гэсэн тэдний мэдээлэл үнэн зөв, эсвэл бүрэн гүйцэд эсэхийг хянах, шалгах боломж бидэнд байдаггүйг хэлэх нь зүйтэй байх. Тиймээс төр болон хувийн хэвшлийн салбар хоорондын итгэлцэл, хамтын ажиллагаа чухал байна.

(Кибер гэмт хэргийн ажилтнуудтай хийсэн ярилцлагын хэсгээс...) ⁵⁴

Долоо: Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийдэг. Үнэлгээний шалгах асуултад цахим орчны эрсдэлийг оруулаагүй байгаа нь хохирогчийн эрсдэлийг үнэн зөв тодорхойлж, зохистой хариу арга хэмжээ авах, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах асуудал орхигдож байна.

⁵³ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2024 он.

⁵⁴ Мөн тэнд.

Тохиолдол 4.14

...Манай байгууллагад ирсэн үйлчлүүлэгчийг нөхөр нь цахимаар мөрдөж, ирсэн кэйсийн тухайд бид хуульд заасны дагуу тухайн “хохирогчийн” эрсдэлийн зэргийг үнэлж, түүний дараа хамгаалалтад авах эсэх яригдана. Гэтэл энэ тохиолдолд аюулын эрсдэлийн үнэлгээ хийх боломжгүй. Эрсдэлийн үнэлгээний асуумжид ийм төрлийн зөрчлийг тодорхойлох асуултыг тодорхойлж өгөөгүй. Тиймээс эрсдэлтэй гэж үзэх боломжгүй болохоор ямар нэг арга хэмжээ авч чадаагүй. Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрмээр аюулын эрсдэлийн үнэлгээг яг дуудлагаар очсон цагдаагийн алба хаагч нөхцөл байдал дээр нь хийдэг зохицуулалттай. Дээр дурдсан кэйсийн хувьд хутга, мэс ашигласан, зэвсэглэсэн, зодож цохисон зүйл байхгүй учир “өндөр эрсдэлтэйд” тооцогддоггүй. Тиймээс одоогийн дүрэм, журмаа өөрчилж, сайжруулахгүй бол эмэгтэйчүүд заавал зодуулж, цохиулж биетээр хохирсны дараа үйлчилгээ үзүүлдэг зохицуулалт үйлчилж байна. Өөрөөр хэлбэл, ийм хор хохирол амсахаас нааш ямар нэг тусламж үзүүлэх боломжгүй болчихоод байгаа нь харамсалтай.

(Хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагын ажилтны ярианаас...) ⁵⁵

Үүнээс үзэхэд цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, хүний, санхүүгийн нөөцөөр дэмжих, мэргэшүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх чадавхыг бэхжүүлэх жишиг аргачлал боловсруулах, КГХТГ-ын программ, техник хангамжийг тухай бүр нь шинэчлэхэд шаардлагатай санхүүжилтийг хангалттай олгох ажлыг нэн тэргүүнд ав хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.5 ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЖ БУЙ ХАРИУ ҮЙЛЧИЛГЭЭ

Монгол Улсад ЖСХ-ийн хохирогчдод тусламж, үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай болон холбогдох бусад хуулиар зохицуулж байна.

ЖСХ-ийн хохирогчийн онцлог хэрэгцээнд нийцсэн, нийгэм, сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээ хангалтгүй байна. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 737 хамтарсан баг анхан шатны нэгжид ажиллаж, хүчирхийлэлд өртсөн иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө, хууль болон эрх зүйн туслалцаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна.

ЖСХ-ийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, тусламж, үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр (ТХБ), нэг цэгийн үйлчилгээ төв (НЦҮТ)-ийг аймаг бүрд байгуулснаар улсын хэмжээнд 39 төв, байранд энэ төрлийн үйлчилгээг үзүүлж буй хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны онцлог хэрэгцээнд нийцсэн байдлаар төрөлжөөгүй, ихэнх НЦҮТ, ТХБ нь хүний нөөц, төсвийн хомсдолтой, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл стандартын шаардлага хангахгүй хэвээр байна.

Тохиолдол 4.15

...Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ЦЖСХ-д их өртдөг. Гар утсыг нь гэрийнхэн нь хурааж, найз нөхөдтэйгөө холбогдох харилцааг нь хязгаарлаж, халамжийн мөнгийг нь өөрт байгаа давуу байдлаа ашиглан өөрийн данс руу сар бүр автомат таталт хийж авдаг гэх мэт олон гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил үйлдэгддэг. Харамсалтай нь, хөгжлийн бэрхшээлтэй хохирогчдод чиглэсэн үйлчилгээ хүртээмжгүй байдаг. Жишээ нь, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тэргэнцэртэй иргэнийг хамгаалах байранд авах гэтэл тэргэнцэртэй хүнд хүртээмжгүй байсан тул гэр бүлд нь эргэн нэгтгэсэн буюу хүчирхийлэгч рүү нь буцаасан тохиолдол гарсан. Тиймээс хохирогчдын онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх шаардлагатай.

(Хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагын ажилтны ярианаас...) ⁵⁶

ЖСХ-ийн хохирогчдод зөвлөгөө өгөх түргэн тусламжийн утас, чатбот үйлчилгээг үзүүлэх суваг, цахим хуудас бий болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан

⁵⁵ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн үнэлгээний тайлан, 2024 он.

⁵⁶ Мөн тэнд.

сэргийлэх ажилд ахиц дэвшил гарч байгаа ч⁵⁷ үндэсний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй хэвээр байна.

ЖСХ-ийн хохирогч нь энэ төрлийн хүчирхийлэл болон хууль эрх зүйн талаарх мэдлэг, ойлголт хангалтгүйгээс хаана, хэнд, хэрхэн, яаж хандахаа мэдэхгүй байх, цаашлаад хохирогчийг буруутгах хэвшмэл ойлголт, хандлага нийгэмд түгээмэл байдгаас үүдэн мэдээлэхгүй байх, дахин хохирогч болох эрсдэл өндөр байна.

Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 26.5 хувь нь энэ тухайгаа хэнд ч мэдэгдээгүй байна. Харин энэ талаар хэн нэгэнд хэлсэн эмэгтэйчүүдийн 36 хувь нь найздаа, 32.9 хувь эцэг эхдээ, 31.4 хувь нь бусад хамаатан садандаа хэлсэн бол 8.3 хувь нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийллийг цагдаад мэдээлсэн байна.

Иймд хүчирхийллийн хохирогчид урт хугацааны сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл заслын эмчийн хүрэлцээг нэмэгдүүлэх, хохирогч төвтэй тусламж үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 онд Улсын Их Хурал баталж, улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”, “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл”-ийг тус тус баталж мөрдөн ажиллаж байна. Журам батлагдсанаас хойш сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээг шүүх шинжилгээний байгууллагын бүсийн төвүүдэд хийж байна. Тухайлбал, баруун бүсийн төв буюу Ховд аймаг дахь шүүх шинжилгээний байгууллагад 2024-2025 онд нийт 64 иргэн хандаж, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгосон бол зүүн бүсийн шүүх шинжилгээний байгууллага шинжээч эмчгүй тул иргэд Улаанбаатар хотод ирж дүгнэлт гаргуулж байна.

Эрүүгийн хуулийн хүчиндэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод нөхөн төлбөр олгохгүй байгаа нь “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном”-ын 2022 оны өгөгдөл мэдээллээс харагдаж байна.

Хүснэгт 4.6 Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын нөхөн олговор

№	Хохирогчдын тоо	Хохирсон		Гэмтсэн		Хохирлын хэмжээ (сая.төг)		Нөхөн төлүүлсэн (сая.төг)	
		2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1.	Хүчиндэх	458	552	51	59	-	-	-	-
2.	Гэр бүлийн хүчирхийлэл	1489	1664	1228	1432	-	-	-	-
3.	Цахим орчинд үйлдэгдсэн	4103	8438	-	-	18508.7	32662.6	9228.8	10413.8

Хүснэгтээс харахад хүчиндэх болон гэр бүлийн хүчирхийллийн улмаар хохирсон хохирогчдын хохирлын хэмжээ болон нөхөн төлбөрийн бүртгэл мэдээлэл байхгүй байгаагаас харахад энэ төрлийн гэмт хэргийн хохирлыг тогтооход хүндрэлтэй, нотлох баримт хангалтгүй байдгаас үүдэн хохирлыг нөхөн төлүүлдэггүй байх нийтлэг дүр зураг харагдаж байна. Харин цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргүүдийн тухайд хохирлын тоо

⁵⁷ Хүүхдийн тусламжийн 108 утасны төвөөс 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ирүүлсэн мэдээлэл, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, ЦЕГ-ын 107 (гэр бүлийн хүчирхийлэл), 102 (гэмт хэрэг, зөрчил), cybercrime@police.gov.mn хаяг, 88222255 (цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил), ХНХЯ-ны duudlaga.mn сайт (энгийн болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн дуудлага), ХЭҮТ итгэлтэй утас 96490505, Хүйсийн тэгш эрхийн төвийн 1800-1903 (хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой) тусгай дугаар тус тус ЖСХ-ийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авч, зөвлөгөө тусламж үзүүлж байна.

хэмжээ мөнгөн дүнгээр илэрхийлснээс харахад цахим залиланд өртсөн хохирогчдын тоо мэдээлэл байх магадлалтай байна.⁵⁸

ЖСХ-ийн хохирогчид сэтгэл санааны хор хохирол илүүтэй амсдаг боловч үүнийгээ тогтоолгож, нэхэмжилж, нөхөн төлүүлэх явдал маш бага байна. Тухайлбал, “Нээлттэй нийгэм форум”-аас 2016 онд хийсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хавтаст хэргүүдэд хийгдсэн дүн шинжилгээ”-ээр хохирогч өөрт учирсан бодит хохирлоо нэхэмжилсэн ч нотлох баримт байхгүй, хууль бусаар олсон орлогыг орлогод тооцохгүй гэх шалтгаанаар шүүхээс нэхэмжлэлийн 6 хувийг барагдуулахаар шийдвэрлэсэн байна.

Мөн хүн худалдаалах гэмт хэргийн Улсын ерөнхий прокурорын газрын архивд хадгалагдаж буй 4 хавтаст хэрэгт хохирогчоор тогтоогдсон 10 хохирогчийн 9 нь огт хохирол нэхэмжлээгүй, хэргийг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн 20 хохирогчийн 17 нь хохирол огт нэхэмжлээгүй байна.⁵⁹ Тиймээс хохирогч сэтгэл санааны хохирлоо нэхэмжлэхгүй байгаа асуудлын шалтгаан нөхцлийг судлах, шүүхээр хангаж шийдвэрлэж буй байдал хангалтгүй байгаад анхаарал хандуулж, энэ төрлийн хохирогчийн онцлог ялгааг харгалзан үзэж, сэтгэл санааны хохирлыг бүрэн нөхөн төлүүлдэг байх хэрэгтэй байна.

4.6 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Бүх нийтэд чиглэсэн албан болон албан бус боловсролын хөтөлбөр, урьдчилан сэргийлэх мэдээлэл, нөлөөллийн ажил нь ЦЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга гэдгийг хүний эрхийн байгууллагууд зөвлөж байна. Энэ чиглэлээр бүх үүрэг хүлээгч талууд үр дүнтэй хамтран ажиллах нь чухал юм.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг чадавхижуулах, жендэрийн эрх тэгш байдлын нэгжийн ажиглагчдаас “ЦЖСХ эсрэг урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг идэвхижүүлэхээр тусгай илтгэгчийн дүгнэлт, НҮБ-аас хийсэн дүн шинжилгээ, судалгаанд үндэслэн хууль тогтоомж, бодлого гаргахын зэрэгцээ урьдчилсан сэргийлэх, охид эмэгтэйчүүдийг чадавхижуулах, мэдээллийг хүртээмжтэй хүргэх байдлаар үр дүнтэй хариу арга хэмжээ хэрэгжүүлэх”-ийг зөвлөжээ.⁶⁰

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс албан болон албан бус боловсролын хөтөлбөрт ЦЖСХ-ын агуулга орсон эсэхэд хийсэн дүн шинжилгээний үр дүнг “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал” түргэвчилсэн судалгаанд дурджээ. Тухайлбал, албан боловсролын хүрээнд ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн бүх сурах бичигт хийсэн үнэлгээнд зарим⁶¹ хичээлийн агуулгад өөрийгөө цахим болон бодит орчинд аливаа аюул, эрсдэлээс хэрхэн хамгаалах, бусдын нэр төр, хувийн мэдээллийг хамгаалах, зүй зохисгүй агуулга татан авч үзэхгүй, нийтлэхгүй байх талаар ерөнхий утгаар багтсан байх боловч жендэрийн болон ЖСХ-ийн тухай цогц мэдээлэл өгсөн агуулга хангалтгүй байна” гэжээ. Иймд ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгахын зэрэгцээ багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрх зүйч бэлгэдэг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт ч тусгах шаардлага байна.

Албан бус боловсролын хөтөлбөрөөр дамжуулан төрийн бус байгууллагуудаас тоон үсгийн боловсрол, цахим орчин дахь аюул эрсдэлээс өөрийгөө хамгаалах зэрэг технологи ашиглах ур чадвартай холбоотой мэдлэгийг олгож байгаа ч цахим жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголтыг олгодоггүй байна.

⁵⁸ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал түргэвчилсэн үнэлгээний тайлан” 2024 он

⁵⁹ Хэцсийн тэгш эрхийн төв, Азийн сан, “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан 2022-2023”

⁶⁰ https://www.unwomen.org/sites/default/files/2022-12/OP.6_UN%20Women.pdf

⁶¹ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал түргэвчилсэн үнэлгээний тайлан” 2024 он, ЕБС-ийн 1-12 ангийн бүх сурах бичигт үнэлгээ хийхэд: 2-р ангийн “Хүн ба орчин”, 6-10-р ангийн “Мэдээлэл технологи”, 10-р ангийн “Нийгэм судлал” хичээлийн агуулгад өөрийгөө цахим болон бодит орчинд аливаа аюул эрсдэлээс хэрхэн хамгаалах, бусдын нэр төр, хувийн мэдээллийг хамгаалах, зүй зохисгүй агуулга татан авч үзэхгүй, нийтлэхгүй, тараахгүй байх талаарх агуулгууд багтсан байна.

“Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын суурь судалгаа”-нд хамрагдсан 651 эцэг, эхчүүдийн 96 хувь нь хүүхдийн гар утасны хэрэглээг хянахад тусалдаг аппликэйшны тухай мэддэггүй, 74 хувь нь гэрийн компьютер, таблет, гар утас зэрэгт хүүхдээ цахим орчноос хамгаалах ямар нэг хамгаалалтын тохиргоо хийдэггүй, ямар хамгаалалт хийхээ мэддэггүй, гар утсыг нь шалгах, цагийн хязгаарлалттай үзүүлэх, утсыг нь хурааж авах, юу үзсэнийг нь харах зэргээр хянадаг гэжээ.⁶² Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол залуучуудын дундах цахим орчны дарамт судалгаа”-нд⁶³ хамрагдсан эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ интернэт хэрэглээг зохицуулах асуудалтай тулгарч байгаа тухай дурджээ. Тиймээс технологийн хэрэглээ нь эцэг, эхчүүдийн хувьд ч тулгамдсан асуудал бөгөөд тэдэнд технологийн тусламжтайгаар хүүхдийнхээ цахим аюулгүй байдалд анхаарал тавих, хамгаалах ур чадварт суралцах хэрэгцээ, шаардлага өндөр байна.

Дээрх судалгаагаар эцэг эх, хүүхдүүд цахим дээрэлхэлтийг таньж мэдэх, арга хэмжээ авах, мэдээлэх талаар хангалттай мэдлэггүй, өсвөр насныхны гуравны хоёр нь кибер дээрэлхэлтийн талаар хаана, хэнд, хэрхэн хандахаа мэддэггүй, хэлээд ч үр дүнгүй гэж боддог байна.

Түүнчлэн “ЦЖСХ:Сурагчдын жишээн дээр” судалгаанд⁶⁴ оролцогчдоос “Сургуулийн багш, ажилчид технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрийн хүчирхийллийн талаарх мэдээлэл өгч байсан уу?” гэсэн асуултад 49.3 хувь нь “үгүй”, 50.7 нь “тийм” гэж хариулжээ. Энэ нь эцэг эх, хүүхэд, сургуулийн гурвалсан холбоог сайжруулах, итгэлцлийг нэмэгдүүлэхэд нэн тэргүүний анхаарах шаардлагатай бөгөөд ЕБС-ийн сурагчдад ЦЖСХ-с урьдчилан сэргийлэх, ийм төрлийн гэмт хэрэг, хүний эрхийн зөрчлийн хохирогч болсон тохиолдолд хаана, хэнд, хэрхэн хандах талаар мэдлэг мэдээлэлтэй байх нь чухал байна.

НҮБ Хүн амын сан, Азийн зан зэрэг олон улсын байгууллагуудаас санаачлан ЦЖСХ-тэй тэмцэх хүний эрхэд суурилсан хууль, бодлого, тогтолцоо, үйл ажиллагааг боловсруулж, хэрэгжүүлж, мөрдүүлэхэд зориулсан тусгайлсан санхүүжилт, нөөц бололцоог бий болгох, ингэхдээ хохирогч төвтэй, сэтгэлзүйн гэмтэлд суурилсан ойлголттой, олон талт хандлагыг шингээсэн байх, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд технологийн салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдийн чадавхыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг анхаарч үзэж, орхигдуулахгүй байхыг уриалсан.

Монгол Улсад ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээ авах механизмууд бий болсон ч урьдчилан сэргийлэх хөтөлбөр, суурь шалтгааныг арилгахад чиглэсэн төлөвлөгөө, санхүүжилт хязгаарлагдмал хэвээр байна. Тиймээс цахим орчинд технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, үйлдлийн арга, хохирогчийн онцлог, хор уршгийг нарийвчилсан судалж, урьдчилан сэргийлэх бодлого, зөвлөмж боловсруулах хэрэгтэй байна.

Иргэд, олон нийт нь гэмт хэрэг, зөрчлийг ялгаж, танин мэдэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудын цахим орчинд түгээж буй контент, зураг, дүрс, гар бичмэл, текст нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэргэжлийн ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Монголын Хэвлэл мэдээллийн зөвлөл” ТББ нь жендэрийн талаарх ойлголтыг олон нийтэд, нийгэмд зөв түгээхэд чиглэсэн хүчин чармайлт гаргаж байгаа нь сайшаалтай.

Түүнчлэн ЦЖСХ-тэй тэмцэхэд хувийн хэвшлийг татан оролцуулах, цаашлаад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах нь зүйтэй.

Харамсалтай нь, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хувийн хэвшлийнхний үүрэг, оролцоо, идэвх санаачилга эрэлттэй байгаа хэдий ч ЖСХ-ийн талаарх тэдний ойлголт, мэдлэг ямар түвшинд байгааг судалсан баримт, нотолгоо ховор байна. Тиймээс интернэт

⁶² ХХЗХ, “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын талаар үндэсний суурь судалгаа”, 2020 он, 34 дэх тал.

⁶³ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, “Монгол залуучуудын дундах цахим орчны дарамт судалгаа”, 2024 он, 9-17 насны 3620 сурагч, 1610 эцэг эхийг хамруулан хийсэн байна.

⁶⁴ Монгол Улсын Их Сургуулийн Жендэр судлалын төв, “ТАҮБЖСХ:Сурагчдын жишээн дээр” судалгаа, 2024 он.

үйлчилгээ үзүүлэгчид, цахим контент бүтээгчид, банк санхүүгийн салбар зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудад энэ талаарх мэдлэг, ойлголт олгох сургалтыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран зохион байгуулах хэрэгцээ шаардлага⁶⁵ нийгэмд оршсоор байна.

Цахим орчинд ЖСХ-тэй холбоотой аливаа контент, тухайлбал охид, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд ашиглаж буй зураг, дүрс, гар бичмэл, текстэн агуулгыг сүлжээнээс татан буулгах нь энэ төрлийн гэмт хэрэг, хүний эрхийн зөрчилтэй тэмцэх чухал алхмын нэг болдог. Монгол Улсад энэ арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (Интернэтийн үйлчилгээнд)”⁶⁶-аар зохицуулж байна.

Тус шаардлагын 3.2.6 дахь дэд хэсэгт “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу насанд хүрэгчдэд зориулсан контент (+18)-д хандах хандалтыг хязгаарлах системийн эсвэл програм хангамжийн үйлчилгээтэй байна. Энэхүү үйлчилгээг хэрэглэгчийн гэрээ болон өөрийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд санал болгож мэдээлдэг байх”-аар тусгажээ.

ЦЖСХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, мөрдөн шалгах, хариуцлага тооцох нь дан ганц Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын чиг үүрэгт хамаарахгүй бөгөөд Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Жендэрийн үндэсний хороо, Цахим хөгжил, инновац харилцаа холбооны яам болон Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгаалах хэлтсийн түншлэл хамтын ажиллагаанд суурилан төр, хувийн хэвшлийн бүхий л байгууллагуудын үүрэг оролцоо чухал юм.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсэгт мэдээлэл хариуцагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох үүрэгтэй. Гэвч хувийн хэвшлийн байгууллагууд нь мэдээлэл хариуцагч болохын хувьд хүний хувийн мэдээллийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэлт хийж буй аппликэйшн, платформууд нь хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажилладаг талаар баримт нотолгоо хомс байна. Тиймээс энэ асуудлыг үнэлэх, бодит хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа шинжилгээ хийхийг зөвлөж байна.

Өнөө үед сошиал медиа үйлчилгээ үзүүлэгч нь аливаа төрлийн хүчирхийллийг арилгах, таслан зогсоох, тусламж үзүүлэх стандарт код зааварчилгааг өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх үүрэг, хариуцлагыг бизнесийн болон нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээдэг. Харамсалтай нь, зарим олон нийтийн сүлжээ эрхлэгч нь энэ төрлийн хариу арга хэмжээг хангалттай авч хэрэгжүүлдэггүйгээс үүдэн тухайн платформд үйлдэгдэж буй ЖСХ-ийг таслан зогсоох, илрүүлэх, арилгах, саармагжуулах, урьдчилан сэргийлэх нөөц боломж хязгаарлагдахад нөлөөлж байна.

⁶⁵ ХЭҮТ, “Технологи ашиглан үйлдэгддэг жендэрт суурилсан хүчирхийллийн өнөөгийн байдал түргэвчилсэн үнэлгээний тайлан” 2024 он

⁶⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140956328741&showType=1>

САНАЛ

1.ЦЖСХ үйлдэгдэж буй арга хэлбэр, хор уршиг, хохирол, хохирогчийн онцлогийг нарийвчлан судалж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд энэ төрлийн гэмт үйлдэлтэй үр дүнтэй тэмцэх шаардлагыг хангахуйц нэмэлт өөрчлөлт оруулах,

2.Эрүүгийн хуулийн 14.1 ялгаварлан гадуурхах, 10.4 хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 11.7 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 13.1 хүн худалдаалах, 13.5 заналхийлэх, 13.12 хууль бусаар мөрдөж, мөшгих зэрэг гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байдалд цахим орчныг ашиглан үйлдсэн шинжийг нарийвчлан тусгах;

3.Цахим технологи, цахим орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлал боловсруулж, үе шаттай сургалт явуулах замаар цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх

4. ЦЖСХ-ээс урьдчилсан сэргийлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөж, бүх үүрэг хүлээгч талуудыг оролцуулан хэрэгжүүлэх

V БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН
ДАХЬ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН
ЭРХИЙН ЗАРИМ АСУУДАЛ

“... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалт)

“Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.”

(Хүүхдийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг)

“Аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй”.

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 24 дүгээр зүйл)

“Оролцогч улсууд хүүхдийг үл хайхрах, мөлжих, зүй бусаар ашиглах, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг нь доромжилсон харьцаа, хандлага, зэвсэгт мөргөлдөөний хохирогч хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн амьдралд буцаан оруулахад тус дөхөм болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Ийнхүү нөхөн сэргээх, нийгэмд нэгтгэх үйл явц нь хүүхдийн эрүүл мэнд, нэр төр, үе тэнгийнхний хүндэтгэл хангагдсан нөхцөлд хэрэгжих ёстой.”

(Хүүхдийн эрхийн тухай конвенцын 39 дүгээр зүйл)

“Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй...”

(Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг)

5.1. ТАНИЛЦУУЛГА

Комисс Монгол Улсын Их хуралд жил бүр өргөн барьдаг Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэлдээ хүүхдийн эрхийн асуудлыг 18 удаа тусгаж, УИХ-аас тодорхой шийдвэрүүдийг гаргуулсан бөгөөд энэ удаагийн илтгэлдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн асуудлыг хөндөж байна.

Манай улс нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, дотоодын хууль тогтоомжоор хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж хүүхдийн эрхийг хангаж хамгаалах чиглэлээр ахиц, дэвшил гаргаж байгаа ч цахим хөгжлийг даган хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд хүүхдүүд хүчирхийллийн хохирогч болох тэр дундаа бага насны хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртөх тохиолдол жил бүр нэмэгдэж байна.

Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээний ажлууд тогтмол хийгдэж байгаа боловч байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа муу байгаагаас тэдгээрийн дүгнэлт зөвлөмжүүд хязгаарлагдмал хүрээнд ашиглагдаж, хүүхдийн хүчирхийлэлээс ангид байх эрхийн хэрэгжилтэд бодитой үр дүн гарахгүй байна.

Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширдаг, хохирогч хүүхдээс эмзэг асуудлыг хөндөж олон дахин мэдүүлэг авдаг, мөрдөн шалгах ажиллагаа хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байдлаар явагддаггүй зэргээс шалтгаалж бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд шаардлагагүй их хүндрэл, дарамтыг даван туулах, сэтгэл санаа болон бие махбодоороо давтан хохирох явдал байсаар байна.

Комисс энэхүү бүлгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нөхцөл байдлын талаар төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудаас хийсэн судалгаа, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүх шинжилгээний байгууллага болон бусад холбогдох төрийн байгууллагын тоон мэдээлэл, Комиссоос хийсэн хяналт шалгалт, дүн шинжилгээний үр дүн, шүүгч, хуульч, өмгөөлөгч, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагыг үндэслэн боловсруулав.

5.2. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, тэр дундаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг тогтмол өсөж, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байх эрх зөрчигдсөөр байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох, биеэ үнэлэхийг зохион байгуулах, хүн худалдаалах, хууль бусаар үр хөндөх, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах зэрэг бие даасан 9 гэмт хэргийг хуульчилсан.

Цагдаагийн байгууллагын мэдээллээс Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт сүүлийн 5 жилийн байдлаар 2,207 (2020 онд 248, 2021 онд 362, 2022 онд 458, 2023 онд 541, 2024 онд 598) хүүхэд өртсөн¹ бөгөөд хохирсон хүүхдийн тоо өмнөх онтой харьцуулахад 2021 онд 16.7 хувь, 2022 онд 22.4 хувь, 2023 онд 9.6 хувь, 2024 онд 9 хувиар тус тус өссөн байна.

¹ ЦЕГ-ын 2025 оны 03/58 дугаар албан бичиг.

Сүүлийн 5 жилийн хугацаанд насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах нийт 1,601 гэмт хэрэг бүртгэгдэж, 1,630 хүүхэд хохирсон бөгөөд үүнээс 0-7 насны 110, 8-13 насны 685, 14-17 насны 835 хүүхэд байна².

Хүснэгт 5.1. Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг зарим гэмт хэргийн тоон мэдээлэл

Эрүүгийн хуулийн зүйл анги	2020	2021	2022	2023	2024	Нийт
12.1.2.1. Арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж	66	78	82	123	119	468
12.1.3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ	21	15	19	18	8	81
12.1.4. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ./тайлбар1/	138	171	222	212	247	990
12.2.2. Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2	1	3	3	7	16
12.2.3. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	6	7	7	9	17	46
Нийт	233	272	333	365	398	1601

Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж прокурорын байгууллагад шилжүүлсэн насанд хүрээгүй хүнийг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг үзвэл сүүлийн 5 жилийн хугацаанд нийт 1,413 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, 88 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ³.

Хүснэгт 5.2. Прокуророос хэрэгсэхгүй болгосон болон яллах дүгнэлт үйлдсэн хэргийн тоо

Эрүүгийн хуулийн зүйл анги	Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	Нийт
12.1.2.1 Арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж	Хэрэгсэхгүй болгосон	3	3	1	2	1	10
	Яллах дүгнэлт	62	71	72	92	97	394
12.1.3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ	Хэрэгсэхгүй болгосон	1	2	1	0	1	5
	Яллах дүгнэлт	22	24	24	20	11	101
12.1.4. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.	Хэрэгсэхгүй болгосон	13	9	18	13	10	63
	Яллах дүгнэлт	155	178	190	174	162	859
12.2.2. Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд	Хэрэгсэхгүй болгосон	0	0	0	1	0	1

² ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

³ ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Яллах дүгнэлт	0	2	2	2	1	7
12.2.3. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Хэрэгсэхгүй болгосон	3	1	3	1	1	9
	Яллах дүгнэлт	6	6	13	10	17	52
Нийт	Хэрэгсэхгүй болгосон	20	15	23	17	13	88
	Яллах дүгнэлт	245	281	301	298	288	1413

Насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн тоон үзүүлэлт жил ирэх бүр өсөж, гэмт хэргийн илрүүлэлт буурч байгаа нь тус гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил үр дүн муутай, нөгөө талаар ураг төрлийн хүчингийн хэргийг нуун дарагдуулах хандлагатай гэж үзэж болно. Түүнчлэн хохирогч хүүхдийн өмнөөс эцэг, эх, асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгчид шийдвэр гаргадаг, хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа хүнд сурталтай, удааширдаг, хохирогчид ээлгүй байдгаас хохирогч залхдаг, төвөгшөөдөг, хуулийн байгууллагад хандахаас татгалздагтай холбоотой байж болно.

Комиссоос 2022, 2023 онд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 40 хэргийг түүвэрлэн дүн шинжилгээ хийхэд хэргүүдийн 15 нь прокурорын хяналтаас, 7 нь шүүхийн шатнаас нэмэлт мөрдөн байцаалтад буцаагдаж байсан бөгөөд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хугацаа ихдээ 1 жил 5 сар 23 хоног, багадаа 30 хоног байсан бол хэрэг шүүхэд шилжсэнээс хойш багадаа 18 хоног, ихдээ 11 сар 28 хоногийн хугацаанд эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт 5.3. Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг зарим гэмт хэргийн илрүүлэлт⁴ (хувиар)

Эрүүгийн хуулийн зүйл анги	2020	2021	2022	2023	2024
12.1.2.1 /Арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэрэг/	51.1	69.6	56.5	56.9	45.8
12.1.3 /Арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн гэмт хэрэг/	81.8	50.0	64.3	46.2	14.3
12.1.4 /Хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн/	62.2	60.4	63.8	48.1	42.3
12.2.2 /Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн/	50.0	100	100	100	28.6
12.2.3 /Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн/	33.3	50	50	66.7	18.8

Сүүлийн 5 жилийн хугацаанд шүүх шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон гэх үндэслэлээр нийт 4,161 хүүхэд үзлэгт хамрагдсанаас эрэгтэй хүүхэд 263, эмэгтэй хүүхэд 3,898 байна. Эдгээр хүүхдүүдийг насны хувьд авч үзвэл 0-6 насны 350, 7-13 насны 1,395, 14-15 насны 1,558, 16-17 насны 858 хүүхэд байна⁵.

Хүснэгт 5.4. Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр үзлэг шинжилгээнд хамрагдсан хүүхдийн тоон судалгаа⁶

№	Хамрагдах он	Нийт тоо		Насаар нь			
		Эрэгтэй	Эмэгтэй	0-6 нас	7-13 нас	14-15 нас	16-17 нас
1	2020	25	644	64	226	217	162
2	2021	52	657	72	269	238	130
3	2022	47	853	80	320	312	188

⁴ ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

⁵ ШШГЕГ-ын 2025 оны 02/824 дугаар албан бичиг.

⁶ ШШЕГ-ын 2025 оны 01/2172 дугаар албан бичиг.

4	2023	92	883	68	304	412	193
5	2024	47	861	69	276	378	185
Нийт		263	3898	350	1395	1558	858

Сүүлийн таван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн хохирогчоор бүртгэгдсэн насанд хүрээгүй хүний тоог шүүх шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр үзлэг шинжилгээнд хамрагдсан насанд хүрээгүй хүний тоотой харьцуулахад зөрүү өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Хүснэгт 5.5. Цагдаагийн болон шүүх шинжилгээний байгууллагад бүртгэгдсэн тоон мэдээллийн харьцуулалт

№	Он	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хүн	Шүүх шинжилгээний байгууллагад бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон үндэслэлээр үзлэг шинжилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	Харьцуулалтын зөрүү
1	2020	248	669	421
2	2021	361	709	348
3	2022	458	900	442
4	2023	541	975	434
5	2024	598	908	310

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс өгсөн мэдээллээр сүүлийн 5 жилийн хугацаанд бага насны хүүхэд 98, насанд хүрээгүй 11,878 хүн төрж, бага насны хүүхэд 215, насанд хүрээгүй 2,950 хүн үр хөндүүлсэн байна. Үүнээс 2020-2024 онд 10-14 насны нийт 215 хүүхэд төрж, 98 хүүхэд үр хөндүүлсэн байна.⁷ Энэ нь эдгээр хүүхдүүд бүгд гэмт хэргийн хохирогч болсныг болон бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчингийн гэмт хэрэг нуугдмал, далд хэлбэрээр оршиж байгааг илэрхийлнэ. Харин 15-19 насны 2,950 хүүхэд төрж, 11,878 хүүхэд үр хөндүүлснийг гэмт хэргийн улмаас гэж үзэхгүй ч насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн цөөнгүй тохиолдол эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн мэдээллийн үндсэн дээр тогтоодгийг холбогдох албаны хүмүүс хэлдэг төдийгүй тохиолдол бүрийн цаана хүүхэд хохирч байхыг үгүйсгэхгүй⁸.

Хүснэгт 5.6. Төрсөн(1), үр хөндүүлсэн (2) насанд хүрээгүй хүний тоо

№	2020		2021		2022		2023		2024		Нийт	
	1	2	1	2	1	2	1	2	1	2		
10-14 нас	11	30	18	35	22	41	24	40	23	69	313	
15-19 нас	2934	675	2553	618	2386	587	2074	571	1931	499	14828	

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллээр сүүлийн 5 жилийн хугацаанд дээрх гэмт хэрэгт холбогдон 902 хүн ял шийтгүүлснээс⁹ 152 хоригдол хугацаанаас өмнө суллагдаж, долоон хоригдол өвчний учир ялаас чөлөөлөгдөж, дөрвөн хоригдлыг УДШ-ээс цагаатгажээ.¹⁰

⁷ ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

⁸ ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

⁹ ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх алба “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”, Судалгааны тайлан, УБ, 2025 он.

¹⁰ ШШГЕГ-ын 2025 оны 02/824 дугаар албан бичиг.

Хүснэгт 5.7. Шүүхээр ял шийтгүүлсэн болон суллагдсан байдал

Он	Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо	Хугацааны өмнө суллагдсан	Өвчний учир ялаас чөлөөлөгдсөн	МУДШ-ээс цагаатгасан
2020	101	25	1	1
2021	149	39	1	0
2022	212	44	2	0
2023	218	39	0	1
2024	222	5	3	2
Нийт	902	152	7	4

Өнгөрсөн хугацаанд насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтэй холбоотой цөөнгүй судалгаа, шинжилгээний ажлууд хийгдэж тодорхой санал, дүгнэлтүүд гарсан байна. Тухайлбал 2019 онд Нээлттэй нийгэм форумын “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгаа, Монголын эмэгтэйчүүдийн сан, ДХИС, ХТЭТ-өөс “Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг: шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс” судалгаа, ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг”-ийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаагийн “Бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал” судалгаа, ХЭҮК, ЦЕГ, ДХИС, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллага, НҮБ-ын Хүүхдийн сангаас хамтран боловсруулсан “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” цагдаагийн байгууллагын албан хаагчдад зориулсан гарын авлага, ХЭҮК, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хийсэн “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ”, 2023 онд ХТЭТ-өөс “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл, байдалд хийсэн дүн шинжилгээ” судалгаа, 2024 онд судлаач Э.Товуудоржийн “Хүчиндэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй” судалгаа, 2025 онд ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх албанаас “Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх, бэлгийн дур хүслээ өс бусаар хангах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашид хийж хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” зэрэг судалгаа хийгдсэн байна.

Эдгээр судалгаанууд ихэвчлэн насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтын тоо, түүний илрүүлэлт, хохирогчийн болон гэмт хэрэг үйлдэгчийн хувийн байдал, хамаарал, гэмт хэрэг үйлдэгчийн боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэмт хэрэг гарсан газар, улирал, гараг, цаг, гэмт хэргийн давтамж, гэмт хэргийн улмаас учирсан хор уршиг зэрэг үзүүлэлт дээр төвлөрч, насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг “ядуурал, ажилгүйдэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн тогтворгүй байдал, сургууль завсардалт, эцэг, эхийн хайр халамж, анхаарал дутах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчил, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгчийн таагүй харьцаа, найз нөхдийн сөрөг нөлөө, хяналтгүй цахим хэрэглээ, бэлгийн гаж зан үйлтэй этгээдүүдэд тавих хяналт сул байгаагаар холбоотой” гэж үзсэн байна.

Түүнчлэн хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн гаралт өсөх үзүүлэлттэй бөгөөд хохирогч нь насанд хүрээгүй хүн, ялангуяа бага насны хүүхэд ихээр өртөж байгаад дүн шинжилгээ хийж, тэднийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай, хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлддэг гэмт хэргүүдээс хүчиндэх гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж, цаашид өсөх хандлагатай байна гэх дүгнэлтийг нийтлэг хийсэн байна.

Хэдийгээр насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд тус тусдаа судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээний ажлууд хийж байгаа нь сайшаалтай ч ихэнхдээ хязгаарлагдмал

хүрээнд, байгууллагын өөрийн хэрэгцээнд ашигладаг, судалгааны дүгнэлт, саналын мөрөөр дорвитой арга хэмжээ авагддаггүй байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн асуудлаар шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчидтэй уулзаж ярилцахад хөндөгддөг нэг асуудал бол хүүхдийн бэлгийн бойжилт эрт эхэлдэг болсонтой холбоотойгоор хүүхдүүд хоорондоо үерхэж, бэлгийн харьцаанд орох нас залуужиж байгаагаас хөвгүүд гэмт хэрэгтэн болж байгаа явдал болно. 14-өөс доош насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нь хэлбэрийн болоод агуулгын шинж шаарддаггүй тул холбогдогч этгээд шууд гэм буруутан болдог. 2025 оны 2 дугаар сарын байдлаар Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж буй эрэгтэй 39 хүүхдээс 17 хүүхэд нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн үндэслэлээр хүмүүжиж байгаа нь үүний илрэл байж болно.

МУИС-ийн Жендэр судлалын төвөөс судалгаа хийж 6-12 дугаар ангийн нийт 18,044 суралцагчдаас технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрийн хүчирхийлэлд өртөж байсан эсэхийг асуухад 1,786 хүүхэд буюу 9.9 хувь нь садар самуун, зураг, бичлэг илгээх үйлдэл, 1,226 хүүхэд буюу 6.8 хувь нь бэлгийн сэдлээр хүүхэдтэй холбоо тогтоох, 1,064 хүүхэд буюу 5.9 хувь нь секс илэрхийлэл бүхий дүрс бичлэг хийх, түгээх, 992 хүүхэд буюу 5.5 хувь нь бэлгийн амьдрал, бэлгийн зан үйлээр шүүмжлэх, доромжлох, 974 хүүхэд буюу 5.4 хувь нь бэлгийн сэдлээр сүрдүүлэг, 974 хүүхэд буюу 5.4 хувь нь бэлгийн дур таашаал авах зорилгоор зураг авах, бичлэг хийх хүчирхийлэлд өртөж байжээ¹¹. Үүнээс үзвэл 6 дугаар ангийн 12 настай хүүхдүүд бэлгийн харилцааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсон байна. Энэ нь бэлгийн боловсрол, өөрийгөө болон бусдыг хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг чадавхыг зохих наснаас эхэлж олгох шаардлагатай болсныг илэрхийлж байна.

Дээрх судалгаануудад бага насны хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаагийн нэг шалтгаан бэлгийн гаж зан үйлтэй холбоотой байж болох талаар дурдагдсан бөгөөд үүнийг педофил буюу хүүхэдтэй бэлгийн зан үйл үйлдэж таашаал авдаг бэлгийн гаж зан үйл юм. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн секс судлалын эмч “Педофили зан үйлтэй хүмүүсийг ажиглахад бага насандаа хүчирхийлэлд өссөн, хүүхэд байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртөж сэтгэл зүйн гэмтэл авч нас биед хүрсэн үедээ өөрөө хүүхэд хүчирхийлдэг, түүнээсээ таашаал авдаг, сэдэл зуршилтай болсон, бага, бүрэн бус дунд боловсролтой хүмүүс байдаг”¹² гэж тодорхойлсон. Педофил нь бэлгийн хүчирхийллийг ихэвчлэн хүүхдийн эсрэг үйлддэг хүмүүс бөгөөд дийлэнхдээ 14-өөс доош насны буюу бага насны хүүхдийн эсрэг үйлддэг. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн сэдэлтийг судалснаар педофил хүмүүсийн гэмт үйлдэл, зан үйлийг өдөөдөг хүчин зүйлийг тодорхойлох боломжтой¹³.

ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад 2024 оны 10 дугаар сарын байдлаар Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн 771 хоригдол ял эдэлж байгаа бөгөөд эдгээр хоригдлууд педофил сэтгэцийн эмгэгтэй этгээдүүд мөн эсэхийг оношилж тогтоох, ял эдлэх хугацаанд сэтгэцийн эмгэгийг эмчлэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэхгүй байгаа зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэг дахин үйлдэх шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байна”¹⁴.

Харин ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх албанаас хийсэн судалгаагаар “Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч нарын хэрэг хариуцах чадвартай эсэхэд шинжилгээ хийхэд дийлэнх нь бэлгийн чиг хандлага хэвийн, оюуны ямар нэгэн хомсдолгүй хүмүүс байдаг бөгөөд педофил бэлгийн чиг хандлагатай хүмүүс маш бага хувийг эзэлдэг. Гол төлөв архидан согтуурсан үедээ өөрийн ойр орчмын хүмүүсийг хүчиндэж, бэлгийн дур хүслээ

¹¹ Ч.Энхболд, “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрийн хүчирхийлэл”, Судалгааны тайлан, 2025 он.

¹² ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, “Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэрэг”-ийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн хэсэгчилсэн судалгаа, УБ, 2019 он.

¹³ Э.Товуудорж, “Хүчиндэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй”, Судалгааны тайлан, 2024 он.

¹⁴ Мөн тэнд

хангасан байдаг. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн хүмүүс нь нийгмийн харилцаанд бүрэн орж чаддаггүй, өөрийгөө илэрхийлэх чадвар сул учраас өөрийн ойр тойрныхоо хүмүүсээр бэлгийн дур хүслээ хангаж байдаг.”¹⁵ гэж дүгнэсэн.

Манай улсад бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэгтнийг педофилийн эмгэгтэй эсэхийг тогтоодоггүй, шаардлагатай сэтгэл зүй болон эмчилгээ хийгддэггүй, ял эдэлж дууссаны дараах хяналт буюу бүртгэл байдаггүй байна. Улс орнуудад педофилийн эмчилгээнд сэтгэл зүй, анагаах ухаан, хууль, эрх зүйн холимог аргыг ашигладаг байна.

Тодруулбал, Герман Улсад урьдчилан сэргийлэх төсөл Dunkelfeld¹⁶ нь аливаа гэмт хэрэг гарахаас өмнө педофил хандлагатай хүмүүст нууц эмчилгээг санал болгодог. Швед Улс бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнүүдийн дунд хэт бэлгийн харьцаанд орох зэрэг криминоген эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн тусгай эмчилгээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг¹⁷. Бельги Улсад шорон, сэтгэцийн эмнэлгүүд зэрэг төрөл бүрийн орчинд эмчилгээ хийдэг бөгөөд голчлон Хойд Америк, Канадын хөтөлбөрөөс үндэслэсэн арга барилтай байна¹⁸. Харин Америкийн Нэгдсэн Улс шийтгэлийн арга хэмжээ авдаг боловч бэлгийн гэмт хэрэг үйлдэгчдийн дунд дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг бууруулах зорилгоор олон нийтийн сайн дурынхныг оролцуулдаг байна¹⁹. Калифорнийн Эрүүгийн хуулийн § 290.46-д ял шийтгүүлсэн педофилуудыг Калифорнийн Хууль зүйн яаманд бүртгүүлэхийг шаарддаг бөгөөд тэдний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгодог зэрэг арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.

Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн нарийвчилсан, дэлгэрэнгүй, криминологи судалгааг энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан өргөн хүрээнд, цогц байдлаар хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга, хэлбэрээ шинэчлэн хүүхэд багачуудаа хамгаалах шаардлага байсаар байна.

Комисс 2022 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зүйн байдлын талаарх олон улсын болон үндэсний хууль тогтоомжид дүн шинжилгээ хийсэн бөгөөд “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг тусгайлсан бүлгээр насанд хүрэгчдээс ялгамжтай зохицуулж байгаа бол гэрч, хохирогч хүүхдийн (ялангуяа бэлгийн хүчирхийллийн) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлогийг тусгайлан системчлээгүй байгаа нь мөрдөгч, прокурор, өмгөөлөгч төдийгүй хохирогч, гэрч хүүхэд улмаар тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид бэрхшээл үүсгэж байна”, “Цагдаагийн алба хаагчдын тэр дундаа мөрдөгчдийн албаны давтан, мэргэшүүлэх сургалтууд нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, кодуудад суурилсан байх шаардлагатай бөгөөд энэхүү хөдөлмөрийн дотоод журмыг уншдаггүй, судалдаггүй нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг үл ойшоох, зөрчих хүчин зүйл болж байна”, “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хууль тогтоомж, нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрүүдийн хэрэгжилт тэр дундаа шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны дорвитой өөрчлөлт ороогүйгээс бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд хохирсоор байгааг судлаачид, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын тайланд дурдагдсаар байна. Энэ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, тогтоомж, Засгийн газраас батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх механизм, менежмент үгүйлэгдэж, явуулж буй үйл ажиллагааны үр дүн гагцхүү цагдаа болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх төдийхнөөр мониторинг явуулж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого чиглэл, шинэчлэгдээгүйтэй холбоотой байна”, “Захиргааны хэм хэмжээний актуудын дийлэнх нь утга агуулга, үйл ажиллагааны онцлог ижил байгаагаас гадна амьдралын хөрсөнд бууж хэрэгжихэд

¹⁵ Э.Товуудорж, “Хүчиндэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга зүй”, Судалгааны тайлан, 2024 он.

¹⁶ <https://eucpn.org/document/german-project-prevention-project-dunkelfeld-ppd>

¹⁷ <https://uu.diva-portal.org/smash/get/diva2%3A1624984/FULLTEXT01.pdf>

¹⁸ <https://www.ojp.gov/ncjrs/virtual-library/abstracts/treatment-sexual-abusers-belgium>

¹⁹ <https://nij.ojp.gov/library/publications/implementation-circles-support-and-accountability-united-states>

мөрдөгчид ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах баталгааг хангахгүй байгаа нь нэгдүгээрт, хуулиудын уялдаа холбоо системчлэл алдагдсан хоёрдугаарт, хуульд захиргааны хэм хэмжээний акт гаргахаар тусгахдаа бусад журмын уялдаа холбоог хангадаггүй, гуравдугаарт, захиргааны хэм хэмжээний акт боловсруулж байгаа албан тушаалтнуудын мэдлэг, хандлага өөрчлөгдөөгүй дөрөвдүгээрт, энэхүү захиргааны хэм хэмжээний актын үйлчлэлд дүн шинжилгээ хийгддэггүй зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна”, “Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нь батлагдсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын агуулга, мөн чанараас гадна түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, иргэн, албан тушаалтны үйл ажиллагаа, сэтгэлгээний хандлагаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг үйлдэгдэж байгаа онцлогоос шалтгаалан энэхүү төрлийн гэмт хэргийн гомдол, мэдээллийг хүлээн авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах явдал хангалтгүй байна” гэж дүгнэсэн.

Насанд хүрээгүй хүний хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг хамгаалах чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагаас хүчин чармайлт, олон улсын дэмжлэгтэйгээр олон судалгаа хийгдэж бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн чадавх, эрх зүйн зохицуулалт сайжирсан хэдий ч бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэрэг жил бүр өсөж байгааг бүх түвшинд онцгой анхаарч зохих арга хэмжээг нэн яаралтай авах шаардлагатай байна.

5.3.НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХОХИРОГЧООС МЭДҮҮЛЭГ АВАХ АЖИЛЛАГАА

Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад бага насны хүүхдэд хууль сануулж гарын үсэг зуруулах, эсрэг хүйсийн албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авах, мэдүүлэг авах хуулийн хугацааг хэтрүүлэх, мөрдөгч солигдох, удаа дараа мэдүүлэг авч, үйл баримтын талаар давтан яриулах, хүүхдэд ээлгүй өрөөнд мэдүүлэг авах, насны онцлогт тохирсон асуулт асуудаггүй зэрэг нь хохирогч хүүхдийг давхар хохироож байна.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргээс онцлог, хохирогч хүчирхийллийн улмаас сэтгэцийн гэмтэл авсан, түүний үр дагавар их байдаг учраас хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хохирогчид шаардлагатай сэтгэл зүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсний дараагаар мэдүүлэг авах нь мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй болгодог.

Бэлгийн хүчирхийллийн хохирогчид бие махбод болон сэтгэл сэтгэл зүйн шинжтэй нойргүйдэл, хоолны дуршил буурах, түгшүүр зэрэг олон таагүй эмгэг үүссэн, мөн сэтгэл гутрал, санаа зовнил зэргээс шалтгаалан өөрийгөө буруутгах байдалд орсон, улмаар сэтгэн бодох, дүгнэлт хийх, чадвар буурсан байдаг тул юуны түрүүнд хохирогчид нөхцөл байдлыг тайлбарлан ойлгуулах, тайвшруулах, мэдээллээр хангах ажлыг мэргэшсэн эмч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын ажилтан, сэтгэл зүйчтэй хамтран зохион байгуулах шаардлагатай байдаг.

Хохирогч хүүхэд нь олон давхар дарамт, айдас, эрсдэлийн улмаас өөрт учраад байгаа аюултай нөхцөл байдлыг зөв үнэлэх чадваргүй болсон байдаг. Үүнээс шалтгаалж үйлчилгээ, аюулгүй байдлын хамгаалалтаас татгалзах, цагдаагийн байгууллагын нийгэмд тогтсон харилцааны буруу хэв маягаас болж айх, хуулийн байгууллагад хандахаас зайлсхийх нь түгээмэл байдаг. Түүнчлэн, хүчирхийлэл үйлдэгчээс сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хараат байдгаас өөрт хэрэгцээтэй тусламж, үйлчилгээг хаанаас, хэрхэн авах талаар ямар нэгэн мэдээлэлгүй, төлбөрийн чадваргүй, бичиг баримтгүй, харьяаллын бус, эсхүл хүчирхийлэл үйлдэгчийн зүгээс учруулах эрсдэлээс бүрэн хамгаалагдаж чадахгүй байх гэсэн айдсаас болж үйлчилгээнд хамрагдахаас татгалздаг.

Иймд хохирогч хүүхдийг ямар нэгэн байдлаар ямар ч тохиолдолд буруутгаж, шүүмжлэлтэй хандахгүйгээр тэдэнд энэрэнгүй, мэдрэмжтэй хандан, тэдний хэрэгцээ,

санааг нь зовоож байгаа зүйлд анхаарч, мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогч хүүхдийг сэтгэл санааны цочрол, гутралд дахин орох эрсдэлийг бууруулж, хохирогчийн тухайн нөхцөл байдлыг зөв тодорхойлох, эрсдэлт нөхцөл байдлыг үнэлэх, хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч, бусад хүүхэд хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах нь чухал юм.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 2005 оны 2005/20 дугаар “Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар баримтлах удирдамж”-д хүүхдэд цаашид хүндрэл учруулахгүйн тулд ярилцлага, шалгалт болон бусад төрлийн мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэшсэн мэргэжлийн хүмүүс мэдрэмжтэй, хүндэтгэлтэй, нухацтай явуулна. Тэгэхдээ “Ярилцлага, мэдүүлгийн тоог хязгаарлах: хохирогч хүүхдүүдээс нотлох баримт цуглуулах тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ярилцлага, мэдүүлэг, сонсголын тоог багасгах, видео бичлэг ашиглах...” гэж заасан байдаг бол Хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Европын Холбооны 2011 оны 2011/93/ЕХ дугаартай удирдамжид “Мөрдөн байцаалтын явцад хохирогч хүүхэдтэй ярилцлага хийхдээ зориулалтын буюу тохижуулсан өрөөнд, бэлтгэгдсэн мэргэжилтнүүд, боломжтой бол нэг хүн хохирогч хүүхэдтэй бүх ярилцлагыг хийх” гэж зөвлөсөн.

Манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд хохирогч хүүхдийн эрхийг хангаж хамгаалах тусгайлсан журам байхгүй бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр батлагдаж тус оныхоо 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн 29 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллыг асуудлыг тусгасан. Энэ хүрээнд Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд долоон нас хүрсэн хүүхдийн үг хэлэх, саналаа илэрхийлэх эрхийг заавал хангах, хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авах, хүүхдийн биед үзлэг, нэгжлэг хийх ажиллагааг хүүхдийн нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон тусгай өрөөнд гүйцэтгэх бөгөөд уг ажиллагааг хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг байлцуулахгүйгээр гүйцэтгэхийг хориглоно, эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, шүүх хүүхдээс тайлбар, мэдүүлэг, санал авахын өмнө хүүхэд өөрийн санал, шийдвэрээ гаргахад нь шаардлагатай мэдээллийг өгөх, өөрийнх нь хүсэл зориг, дэмжсэн санал, хэлсэн үг, шийдвэрээс гарч болох үр дагаврыг тайлбарлах ажиллагааг гүйцэтгэсэн байх, Эрх бүхий албан тушаалтан, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, прокурор, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээдийн болон хүүхэд 14 нас хүрсэн бол түүний зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдэгдэхийг хориглоно гэх шаардлагууд тусгагдсан нь хүүхдийн эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхдийн эрхийн баталгааг нэмэгдүүлэхэд ахиц болсон.

Уг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт ш “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, Улсын ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.” гэж заасан боловч өнөөдрийг хүртэл энэ журам батлагдаагүй байгаа нь хүүхдийн эрх зөрчигдөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүүхдийн эрхийг хангах талаар тусгайлан зохицуулалт байхгүй байгаа ч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж сэтгэл зүйн эерэг орчныг бүрдүүлэх дэг горимыг тогтоох зорилго бүхий Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код /317/ “Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ”, олон улсын гэрээ, конвенц, үндэсний хууль тогтоомжийг удирдлага болгон хүүхэд хамгаалал, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн болон өртөж, хохирсон, холбогдож болзошгүй хүүхдийн эрхийг хангах, түүнтэй хүнлэг харьцаж, ашиг сонирхлыг нь хамгаалах дэг горимыг тогтоох зорилго бүхий код /316/ “Хүүхдийн эрхийг хангах журам”, гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч, түүний хамаарал бүхий этгээд /цаашид “гэрч, хохирогч” гэх/-ийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах учирч болох аюул, сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, дэмжлэг тусалцаа, үзүүлэх, хамгаалах ажлын дэг горимыг тогтоох, хамгаалалтын арга хэмжээний мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон

харилцааг зохицуулах зорилго бүхий код /511/ “Гэрч, хохирогчийг хамгаалах журам” зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Энэ хүрээнд хохирогч хүүхдийн сэтгэл санааны өвөрмөц онцлогийг харгалзах, хохирогч болон түүний гэр бүл, асран хамгаалагчдыг аль болох дахин сэтгэл зүйн таагүй байдалд оруулахгүй байх; олон дахин дуудах явдлаас аль болох зайлсхийж, нэг удаа чанартай мөрдөн шалгах ажиллагаа явуулах гэсэн зарчмаар ажиллах; хохирогч хүүхэдтэй харьцахдаа тусгайлан бэлтгэсэн, сэтгэл зүйн байдалд сөргөөр нөлөөлөхгүй өрөөнд уулзах (ялангуяа, хохирогчийн хувьд анх удаа мэдүүлэг өгөх үед); сэтгэл зүйн талаар мэдлэг, туршлагатай, эмэгтэй алба хаагчийг ажиллуулах; хувь хүний нууцлалыг чанд хадгалах; хохирогчийг буруутгасан, үл итгэсэн байр сууринаас хандахгүй байх; хохирогчид хүүхдийн эрхийг хамгаалах байгууллага, алба хаагчаас хамаарах дэмжлэг, туслалцааг шуурхай үзүүлэх; хохирогч хүүхдээс мэдүүлэг авахдаа түүний нас, сэтгэхүйн онцлогт тохируулан асуултаа бэлтгэх; хохирол тооцох, барагдуулах, хохирогчид туслалцаа, дэмжлэг үзүүлэх байгууллага, дахин хохирохоос урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат, хугацаа, журмын талаар энгийн үг, хэллэгээр тайлбарлан, мэдээлэл өгч байхыг зөвлөдөг. Гэхдээ эдгээр зөвлөмжүүд зөвхөн цагдаагийн алба хаагчид хамаарч байгаа бөгөөд бэлгийн хүчирхийллийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдын хувьд нэг мөр ашиглагдах нь хууль зүйн үндэслэлийн хувьд учир дутагдалтай байна.

ЭХХШТХ-д хохирогч хүүхдээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөвөөр мэдүүлэхийн чухлыг тайлбарлах бөгөөд арван зургаан насанд хүрээгүй гэрч, хохирогчид санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй гэж хуульчилсан²⁰. Мөн УДШ-ээс “Арван зургаан насанд хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан өгөх ба харин худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай сануулж болохгүй”²¹ гэж хуулийн зүйл, заалтыг нэг мөр ойлгон хэрэглэх талаар тайлбарласан байдаг ч хуулийн энэ заалтын хэрэгжилт практикт учир дутагдалтай байна.

Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хавтаст хэргийн 21 хэрэгт буюу 52.5 хувьд нь мөрдөгч мэдүүлгийн тэмдэглэл болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, худал мэдүүлэг өгсөн бол Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан хариуцлагын талаар сануулж, эрх, үүрэг тайлбарласан баталгааны хуудаст хууль ёсны төлөөлөгчөөс гадна хохирогч хүүхдээр гарын үсэг зуруулжээ. Эдгээрээс нэг л тохиолдолд прокурор мөрдөгч бага насны буюу насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авахдаа хууль сануулж, баталгаа гаргуулж мэдүүлэг авсан нь хууль зөрчсөн гэх үндэслэлээр “хууль сануулсан баталгаа”, “насанд хүрээгүй хохирогчоос авсан мэдүүлэг”-ийг тус тус хүчингүй болгох тогтоол гаргасан байна.

Мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд тэр дундаа бага насны хохирогч хүүхэд болон түүний хууль ёсны төлөөлөгчөөр мэдүүлгийн тэмдэглэлийн хуудас бүр дээр болон эрх, үүрэг тайлбарласан баталгаанд гарын үсэг зуруулахаас гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үйлдэгддэг үзлэгийн тэмдэглэл, хохирогчоор тогтоосон тогтоол, шинжээч томилсон мөрдөгчийн тогтоол, шинжээчийн дүгнэлт зэрэг баримтад арван зургаан насанд хүрээгүй хохирогчоор гарын үсэг зуруулах явдал нийтлэг байгаа нь ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 25.3.6 дахь хэсэг “Мэдүүлэг авч дуусмагц мэдүүлэг зөв бичигдсэн эсэхийг мэдүүлэг авахад оролцсон хүнд танилцуулж, гарын үсэг зуруулна.”, 28.3 дугаар зүйлийн 28.3.1 дэх хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлийг тухайн ажиллагаа дуусмагц ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд даруй танилцуулж, гарын үсэг зуруулна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон, байлцсан хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна.” гэж заасантай холбоотой гэж үзэж болохоор байна.

Арван зургаан наснаас доош хүүхдээр удаа дараа гарын үсэг зуруулах нь төрийн байгууллагын зүгээс хүүхдэд үзүүлж буй шаардлагагүй сүр хүч, дарамт бөгөөд эрх зүйн

²⁰ ЭХХШТХ-ийн 25.3 дугаар зүйлийн 25.3.1 дэх хэсэгт.

²¹ УДШ-ийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 04 сарын 14 өдрийн 16 дугаар тогтоол, 1.14 дэх хэсэгт.

бүрэн чадамжгүй буюу бага насны хохирогч хүүхдийн хувьд хууль зүйн хувьд ач холбогдолгүй юм. хохирогч хүүхдийг улам бүр айдас, түгшүүрт автуулж байгаа явдал юм.

Бэлгийн хүчирхийллийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхны мэдүүлэг чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд анхны мэдүүлгийн явц, байдлыг дуу-дүрсний бичлэгээр давхар бэхжүүлэн авах ач холбогдолтой байдаг. Гэхдээ тухайн дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж буй талаар хохирогч хүүхэд мэдэхгүй байвал зохимжтой байдаг. Учир нь камер зэрэг тусгай төхөөрөмж хүүхэд рүү чиглэсэн байгааг хүүхэд мэдэж буй тохиолдолд биеэ барих, тухгүй мэдрэмжтэй болж мэдүүлгээ гуйвуулах, асуулт дагуулах зэрэг сөрөг байдлыг бий болгодог.

Комиссоос бэлгийн хүчирхийллийг шийдвэрлэсэн 40 хэрэгт дүн шинжилгээ хийхэд 41 хохирогчоос 40 нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрээс мэдүүлэг авсан 112 тохиолдлын 81 буюу 72.3 хувьд нь эрэгтэй, 31 буюу 27.7 хувьд нь эмэгтэй мөрдөгч байсан. Энэ нь Цагдаагийн байгууллагад эмэгтэй мөрдөгчийн хүний нөөц хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд ялангуяа орон нутагт ажиллах эмэгтэй мөрдөгчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлага байна. Олон улсын байгууллагуудын зүгээс зөвхөн мөрдөгч төдийгүй шүүхийн шинжилгээний байгууллагаас хохирогч хүүхдэд үзлэг хийх шинжээч, эмчийн хүйсийг ижил хүйсийн байхыг зөвлөдөг.

Тохиолдол 5.1.

Өмнө нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг харьцангуй бага бүртгэгддэг байсантай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийг эмэгтэй мөрдөгчид шалгадаг байсан бол одоо мөрдөгчийн хүйс харгалзахгүйгээр шалгаж байгаа. Үүнээс болж хүүхдэд ичих асуудал тулгарч байна.

(Мөрдөгчтэй хийсэн фокус ярилцлагын үр дүнгээс)

ЦЕГ-ын дарга 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр албан даалгавар гаргаж “Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-д заасан тусгай журмыг баримтлахаас гадна эмэгтэй хүний төрмөл шинж, хүүхэдтэй харилцах уян хатан зан чанар нь эерэг нөлөө үзүүлдэг тул хүүхдийн сэтгэлзүйн онцлогт тохируулан ялангуяа бага насны хүүхэд хүчирхийлүүлсэн хэрэгт явуулах мөрдөн шалгах ажиллагааг эмэгтэй мөрдөгчөөр гүйцэтгүүлэх шаардлагатай талаар УДШ-ийн 2023 оны 06 дугаар тогтоол гарсан”-ыг дурдаж, шаардлагатай тохиолдолд эмэгтэй мөрдөгч ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох албан тушаалтныг томилуулах арга хэмжээ авах”-ыг, “Насанд хүрээгүй хүүхдээс ...мэдүүлэг авах ажиллагаанд сэтгэл зүйчийг заавал байлцуулж, мэргэшсэн, ижил хүйсийн мөрдөгчөөр мэдүүлэг авхуулах.”-ыг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нарт даалгасан нь нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлэх шийдвэр болсон байна.

ЭХХШТХ-ийн 25.2 дугаар зүйлийн 25.2.2 дахь хэсэгт “Арван найман насанд хүрээгүй хүнээс авах мэдүүлгийг хоёр цагийн хугацаагаар тасралтгүй явуулж болох ба түүнээс илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа дөрвөн цагаас илүүгүй байна.” гэж заасан бөгөөд Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэрэгт нийт 112 удаагийн мэдүүлэг авснаас 60 минутаас бага хугацаанд 83, 61-120 минутын хооронд мэдүүлэг авсан 25 тохиолдол байна. Тасралтгүй хоёр цагаас дээш хугацаагаар мэдүүлэг авсан дөрвөн тохиолдол гарсан бөгөөд эдгээрээс хамгийн удаан үргэлжилсэн нь 2 цаг 56 минут байна. Ийнхүү завсарлага авахгүй 3 орчим цаг үргэлжилсэн явдал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зөрчил төдийгүй хүүхдэд хүнлэг бус хандсан, хүүхдийн эрхийн зөрчил юм. Мэдүүлгийн хугацаа хэтэрсэнтэй холбоотой ямар нэг арга хэмжээ авсан талаар хавтаст хэрэг тэмдэглэл байхгүй, үүнд прокурор, шүүхээс хяналт тавьсан эсэх нь тодорхойгүй байна. Мэдүүлэг авах ажиллагааны дуу, дүрсний бичлэгийг хавтас хэрэгт хавсаргадаггүй бөгөөд мэдүүлэг авах хугацаанд хүүхдэд ус, ундаа өгсөн эсэх нь тодорхойгүй байна.

Тохиолдол 5.2

СХД-ийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн 108 тоот өрөөнд 13 нас 11 сартай хохирогчоос авсан эхний мэдүүлэг 16 цаг 54 минутад эхэлж, 19 цаг 50 минутад дууссан. Мэдүүлгийн дунд нь завсарласан эсэх нь тодорхойгүй, мэдүүлгийн тэмдэглэлд дугаар байхгүйгээс гадна хуудас бүр дээр хохирогчоор гарын үсэг зуруулж, Үндсэн хуульд заасан эрх, үүрэгтэй танилцлаа гэж мэдүүлсэн нь анхаарал татаж байна.

(Эрүүгийн хэргийн ... дугаартай хэрэгт хавсаргагдсан материалаас)

Комиссын дүн шинжилгээ хийсэн 40 хэргийн 7 хэрэгт буюу 17.5 хувьд нь мөрдөгч солигдоогүй, долоо буюу 17.5 хувьд нэг удаа, 10 буюу 25 хувьд хоёр удаа, 16 буюу 40 хувьд нь гурав ба түүнээс дээш удаа мөрдөгч солигдсон байна. Түүнчлэн 40 хэргээс нэг удаа мэдүүлэг авсан тав буюу 12.5 хувь, хоёр удаа мэдүүлэг авсан 19 буюу 47.5 хувь, гурван удаа мэдүүлэг авсан 10 буюу 25 хувь, дөрвөн удаа мэдүүлэг авсан дөрөв буюу 10 хувь, таван удаа мэдүүлэг авсан нэг буюу 2.5 хувь, зургаа ба түүнээс дээш удаа мэдүүлэг авсан гурав буюу 7.5 хувь байна. Мөрдөгч солигдох тохиолдол бүрд мэдүүлэг авах тохиолдлын тоо нэмэгдэх эрсдэлтэй бөгөөд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд өөрт болсон явдлын талаар өөр өөр мөрдөгчид удаа дараа ярих нь хохирогч хүүхдийг дахин сэтгэл зүйн таагүй байдалд оруулахаас гадна хүүхдийн нууц задрах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Олон удаа мэдүүлэг авах нь хуулиар хориглоогүй ч олон дахин дуудах явдлаас аль болох зайлсхийж, нэг удаа чанартай мөрдөн шалгах ажиллагаа явуулах гэсэн зарчим болон хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй юм.

Тохиолдол 5.3

Хэргийн талаар дахин давтан мэдүүлэг өгч байгаа нь хүүхдийн сэтгэлд байгаа шархыг сэдэрээж байна. Өмнө нь удаа дараа болсон үйл явдлыг үнэн зөвөөр хэлсэн. Б-тэй манай гэр бүлийн зүгээс өс хонзон, өр авлага, эд хөрөнгийн маргаан, муудалцах шалтгаан байхгүй. Гэтэл хүүхдийг минь болон хохирсон биднийг яагаад байнга дуудаж нэг асуусан зүйлээ эсхүл шаардлагагүй зүйлийг асууж сэтгэлийн шархыг сэдэрээгээд байгаад гайхаж, гомдож байна.

(Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн мэдүүлгээс)

Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хавтаст хэрэг дэх мэдүүлгийн асуултууд нь хүүхдийн хувийн байдал, нас, сэтгэхүйн хөгжлийн үе шат, сэтгэл зүйн гэмтэл зэргийг харгалзан үзээгүйгээс гадна тухайн хохирогч хүүхэд мэдэхгүй, мэдэх боломжгүй, тохиромжгүй асуултуудыг асуусан байна. Тухайлбал, долоон настай хүүхдээс “Эгчийн дүү б**в гэж юу юм бэ?, урьд өмнө нь б**в харж байсан уу?”, 10 настай хүүхдээс “Бэлэг эрхтэн рүү чинь бэлэг эрхтнээ хийсэн үү?, Хэрэг үйлдэгч хэр согтолттой байсан вэ?, Биеэ хянах чадвартай байсан уу?”, Миний дүүгийн охин хальсны бүтэц, онцлогоос харахад, хойд аав нь миний дүүг хүчиндээгүй юм биш үү?, 11 настай хүүхдээс “Ямар хэргийн улмаас хэрхэн хохирсон талаар үнэн зөвөөр тодорхой ярина уу?, Хэдэн удаа, хаана, хэдий хэр хугацаанд, хүч хэрэглэж хүчиндэж байсан бэ?”, 12 настай хүүхдээс “Хүчиндэхдээ яаж хүчиндсэн бэ?, Дур тавих гэж мэдэх үү?, Дур тавьсан уу?, Бэлэг эрхтнээс нь шингэн зүйл гарсан уу?”, 13 настай хүүхдээс “Чамайг хүчирхийлж байхад чиний бэлэг эрхтэн хэр их өвдсөн бэ?” зэрэг асуултууд болно.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд түүний нас, сэтгэхүйн хөгжлийн үе шатнаас шалтгаалан өөр шинж тэмдгүүд илэрдэг. Тухайлбал, 3-6 настай хохирогч хүүхдэд анхаарал төвлөрөхгүй байх, болсон үйл явдлыг дуурайн хийх, үзүүлэх, тоглох, бусдад итгэхгүй байх, өөрийгөө буруутгах, өөртөө итгэлгүй, түгшүүртэй, гунигтай байх шинж тэмдэг илэрдэг бол 6-12 настай хүүхдэд анхаарал сарних, анхаарлаа төвлөрүүлэн барьж чадахгүй байх, өөртөө үл итгэх, зан үйлийн сөрөг өөрчлөлт буюу бүрэг зожиг болох, түгших, зовних, дахиж үйл явдал давтагдах вий гэхээс айх, хайрлагдахаас айх шинж тэмдэг илэрдэг байна. Харин 12-18 настай хүүхдийн хувьд томчуудыг эсэргүүцэх, сөргөлдөх, зожгирч ганцаардах, өөртөө итгэлгүй, айдас түгшүүртэй болох, сэтгэлээр гутрах гэх мэт шинж тэмдэг илэрдэг. Тиймээс

эдгээрийг харгалзан асуух асуултаа боловсруулж, ярилцаж, мэдүүлэг авснаар хохирогч хүүхдийг аливаа эрсдэл бусад сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх боломжтой²².

Тохиолдол 5.4.

Шүүгч "...Манай улсад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдээс маш олон удаа мэдүүлэг авдаг. Гадаад улсуудын туршлагаас харахад, мөрдөгч, сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын байгууллагын ажилтан нар хамтарч хохирогч хүүхдээс асуух асуултаа урьдчилан бэлдэж, нэг удаа мэдүүлэг авдаг болсон. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд орхигдсон асуудал болоод байгаа ба мөрдөгч, хүүхдийн эрх хамгаалах байгууллагын ажилтнууд хэрэгээ нотлоход анхаарал хандуулж, хүүхдийн эрхийн асуудал, хүүхдийн сэтгэл зүйд яаж нөлөөлж байгааг орхигдуулж байна."

(УДШ-ийн шүүгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэлээс)

Олон улсын байгууллагын зүгээс бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдээс нээлттэй асуулт асуух, тийм, үгүй гэж хариулах боломжтой, хөтөлсөн асуулт асуухгүй байхыг зөвлөдөг бөгөөд ярилцлага хийх буюу мэдүүлэх авах явцад анхаарал сарниулах аливаа үйлдэл хийхгүй байх, анхаарлаа зөвхөн хүүхдэд төвлөрүүлэх нь хүүхэд тайван, айдасгүй байх нөхцөл болдог. Үүнтэй холбоотойгоор Комиссоос мэдүүлэг авах ажилаагааны явцыг баримтжуулсан бичлэг үзэхэд хүүхэд байнга камер луу харах, мэдүүлгийн дундуур өөр алба хаагч мэдүүлэг авч буй мөрдөгчтэй ярилцах, мөрдөгч өөр асуудлаар хүнтэй утсаар ярих нь мэдүүлэг өгч буй хүүхдэд таагүй мэдрэмж өгч байгаа нь ажиглагдсан. Мөн асуултад өгсөн хариуг шивэх хугацаа, хариултыг компьютерт шивэх дуу чимээнд хүүхдийн анхаарлыг сарниж байгаа нь харагдсан.

ЭХХШТХ-ийн 25.1 дүгээр зүйлийн 25.1.2 дахь хэсэгт "Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна", Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны А/57 дугаарын тушаалаар батлагдсан Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагын 4.4 дүгээр зүйлд "Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөө"²³ нь арван зургаан насанд хүрээгүй хүмүүсийн насны онцлог болон тэдний хүмүүжил, сэтгэхүйд сөргөөр нөлөөлөхгүй байдлаар зохион байгуулагдсан байна", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 317.4.1.в²⁴ дэх заалтад "эмзэг хохирогч хүүхэдтэй харьцахдаа тусгай өрөөнд орж уулзахыг эрмэлзэх", мөн УДШ-ийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 16 дугаар тогтоолд " ... мэдүүлгийг хүүхдийн тусгай өрөөнд авч дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулах шаардлагатай ба энэ нь мэдүүлгийн нотолгооны ач холбогдлыг мэдэгдэхүйц нэмэгдүүлнэ." гэж заасан бөгөөд улсын хэмжээнд мэдүүлэг авахад шаардлага хангасан буюу прокурор зөвшөөрөл олгосон нийт 565 өрөө байгаагаас 49 нь насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахад зориулагдсан байна.

Цагдаагийн байгууллагаас насан хүрээгүй хүнээс мэдүүлэг авах ажиллагааг аль болох цагдаагийн байрнаас зохион байгуулах бодлогыг баримталж байгаа ч энэ нь нэг мөр шийдэгдэж хэрэгжихгүй байна. Цагдаагийн байгууллагын насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөнүүд хэлтэс нэгж дээрээ байх бөгөөд тохижилтын хувьд харилцан адилгүй ихэнх тохиолдолд цөөн тооны хүүхдийн тогтоом байршуулсан байна. Нэг давхарт байрлах насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөөнүүд төмөр сараалжин тортой, мэдүүлгийг мөрдөгчийн өөдөөс нь харж суух байдлаар өгөхөөр зохион байгуулсан байна. Мэдүүлэг өгч буй хүүхэд ариун цэвэр сахих тохиолдолд нийтийн ариун цэврийн өрөөг ашиглах боломжтой байна.

²² ХЭҮК, ЦЕГ, ДХИС, НҮБ-ын Хүүхдийн сан, "Бэлгийн хүчирхийллийг хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь", Гарын авлага, УБ, 2022 он.

²³ Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах өрөө гэж 16 насанд хүрээгүй гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлдсэн өрөөг ойлгоно.

²⁴ 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээний талаар.

5.4.ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох зохицуулалт байхгүйгээс бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх зөрчигдөж байна.

Насанд хүрээгүй бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд хууль зүйн туслалцааг аль болох боломжит эрт шатнаас авах нь өөрийн эрхээ хамгаалуулахад чухал ач холбогдолтой бөгөөд өмгөөлөгчийн оролцоог хангаснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, бусад эрхээ эдлэх баталгаа нь болж өгдөг.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2002 он)-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүх нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүрэгтэй” гэж заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалттай байсан бол 2017 оноос мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд насанд хүрээгүй хохирогч заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалтыг орхигдуулсан байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар насанд хүрээгүй хохирогч өмгөөлөгч авах эрхээ өөрөө, эсвэл эрх бүхий этгээд (хууль ёсны төлөөлөгч-төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, томилогдсон хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтан; мөрдөгч, прокурор, шүүгч) зөвхөн хүсэлт гаргасан тохиолдолд эдлэхээр зохицуулжээ.²⁵ Өөрөөр хэлбэл бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн зүгээс өмгөөлөгч авахаас татгалзах, эсвэл өмгөөлөгч авах хүсэлт гаргахгүй тохиолдолд хүүхдийн өмгөөлөгч авах эрх хязгаарлагдахаар байна.

Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэргээс 21 хэрэгт буюу 52.5 хувьд хохирогч өмгөөлөгчгүй, 19 хэрэгт буюу 47.5 хувьд өмгөөлөгчтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна.

2022 онд батлагдсан Хууль зүйн туслалцааны тухай тухай (Шинэчилсэн найруулга) хуулиар Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг)-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсвэл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан тохиолдолд төлбөрийн чадвартай эсэхээс үл хамаарч хохирогч хүүхдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан.²⁶

Хууль зүйн туслалцааны төвөөс 2023 онд 68, 2024 онд 93 буюу нийт 161 бэлгийн хүчирхийллийн хохирогч насанд хүрээгүй хүнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн нь мөн онуудад цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлтэй харьцуулахад хангалтгүй байна.²⁷ Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчид 2023-2024 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас 112, прокурорын шатнаас 27, шүүхийн шатнаас 22 хэрэгт орж өмгөөллийн үйлчилгээ тус тус үзүүлсэн байна.²⁸ Түүнчлэн Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэргийн 19 хэрэгт өмгөөлөгч оролцсоноос 12 нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатнаас, долоо нь шүүхийн шатнаас өмгөөлөгч оролцсон байна.

Тохиолдол 5.5.

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч: “Энэ гэмт хэргийн хохирогч болж цагдаад бүртгэгдсэнээс эхлэн шууд улсын өмгөөлөгчид мэдээлдэг байх хэрэгтэй. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хожуу үед өмгөөлөгчийг оролцуулж байгаа нь эргээд хүүхдээс удаа дараа мэдүүлэг авах, хүүхдийг залхаах нөхцөл байдал бий болгож байна”

(Хуульч, өмгөөлөгчидтэй хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс ..)

²⁵ ЭХХШТХ-ийн 1.14 дүгээр зүйлийн 1, 5.2 дугаар зүйлийн 1, 2 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 3, 8.2 дугаар зүйлийн 2, 25.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

²⁶ Хууль зүйн туслалцааны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт.

²⁷ Хууль зүйн туслалцааны төвийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/134 дугаар албан бичиг.

²⁸ Хууль зүйн туслалцааны төвийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/134 дугаар албан бичиг.

Өмгөөлөгч хохирогч хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэхтэй холбоотой мөрдөгч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, холбогдох шийдвэрт гомдол, хүсэлт, тайлбар гаргах, шийдвэрлүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуулийн дагуу явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт заавал өмгөөлөгч оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

5.5.ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ХОХИРЛОО БАРАГДУУЛАХ ЭРХ

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн бие махбод болон сэтгэл санаанд учирсан хохирол, гэмт хэргийн улмаас гарсан бусад зардлуудыг бодитоор тооцон тодорхойлох, үндсэн хэргийн хамт шийдвэрлэх, хохирогч хүүхдэд нөхөн төлбөрийг эхний ээлжид төрөөс олгох, дараа нь төр гэм буруутай этгээдээс гаргуулах зохицуулалт хийх шаардлагатай байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн бие махбодоос гадна сэтгэл зүй бүхэлдээ хэвийн байдлаа алдах буюу гэмтдэг бөгөөд энэ төрлийн хохирлыг сэтгэл зүйн хохирол гэдэг. Бие махбодод үүссэн аливаа хохирол, хор уршгийг холбогдох дүгнэлт, эмчилгээ хийсэн баримт зэргээр тодорхойлдог бол сэтгэл санааны хохирлыг барагдуулах нэгдсэн практик өнөөдрийг хүртэл хугацаанд тодорхойгүй байна.

Эрүүгийн хуульд зааснаар гэмт хэргийн хохиролд гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг тооцдог бол гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцдог.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсруулах, аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн бий болгох, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн нийгэм, сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээнд гарч байгаа зардлыг төр бүрэн хариуцдаг байх асуудал өнөөдөр ч тулгамдсан хэвээр байна.

Шүүхээс хүчиндэх гэмт хэргийг шийдвэрлэхдээ хохирогчийн гэр бүлээс гарсан бодит зардлыг нотлох баримтаар заавал гаргуулж түүнд үндэслэн шийдвэрлэх бус зарим хэрэгт уг хэргийн улмаас заавал төлбөл зохих хохирлын мөнгөн дүн буюу сэтгэл зүйч, мэргэжилтний дүгнэлт, оношлуулсан өвчин, эмгэгийг эмчлэхэд тухайн эмнэлгийн байгууллага, сэтгэл зүйн төвийн урьдчилсан байдлаар тогтоосон зардал зэргийг мөрдөн байцаалтын явцад тогтоон, шүүх түүнийг харгалзан гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүхийн шийдвэрээр баталгаажуулах боломжтой²⁹ байдаг хэдий ч хохирол нэхэмжилсэн иргэний нэхэмжлэлүүдийг хохирол нотлогдохгүй байна, шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлж өгөөгүй тул иргэний журмаар хохирлоо нэхэмжлэх эрхийг нээлттэйгээр үлдээн шийдвэрлэж байна. Үүнээс болж бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд эрүүл мэндийн хувьд хохироод үлдэх тохиолдол цөөнгүй байна.

Шүүх шинжилгээний тухай хууль 2022 онд шинэчлэгдсэн батлагдахаас өмнө Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж хуульчилсны дагуу УДШ-ийн 2009 оны “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” 15 дугаар тогтоолд Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн

²⁹ Б. Өнөрмаа, “Бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал”, Судалгааны тайлан, УБ, 2022 он.

зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй гэж тайлбарласнаар сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн барагдуулах эрхийг хязгаарлаж ирсэн.

Шүүх шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/ хууль 2022 онд батлагдаж, Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2³⁰, 497 дугаар зүйлийн 497.1³¹, 511 дүгээр зүйлийн 511.4³² дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлалыг батлах тухай” 25 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан 2024 оны А/225/А/153/А/85 дугаар тушаалаар батлагдсан “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам” батлагдаж сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь сайшаалтай ч хэрэгжилт хангалтгүй байна.

Цагдаагийн байгууллагад 2023, 2024 онд насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт 598 бүртгэгдсэнээс 318 хүүхэд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгох хүсэлтээ гаргасан³³ бөгөөд эдгээр хохирогч хүүхдүүдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлээр авч үзвэл нэгдүгээр зэрэглэл 66, хоёрдугаар зэрэглэл 121, гуравдугаар зэрэглэл 47, дөрөвдүгээр зэрэглэл тав, тавдугаар зэрэглэл нэг тогтоосон.

Хүснэгт 5.8. Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоосон талаарх мэдээлэл

№	Он	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн	Нийт сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгох хүсэлт гаргасан	Үүнээс сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоосон
1	2023	541	16	13
2	2024	598	302	227
Нийт		1,139	318	240

Комиссоос дүн шинжилгээ хийсэн 41 бэлгийн хүчирхийллийн хохирогчтой 40 хэргийн 9 хэрэгт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын тооцоолол хийгдсэн ба хэргийн улмаас давхардсан тоогоор 4 хохирогчид бие махбодын, 27 хохирогчид сэтгэл санааны хохирол учирсан байна. Мөн эдгээр 40 хэргээс 17 хэрэгт хохирол нэхэмжилсэн байх бөгөөд 10 хэрэгт хууль ёсны төлөөлөгч, долоон хэрэгт өмгөөлөгч хохирол барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Нэхэмжилсэн хохирлыг ангилж авч үзвэл, найман хэрэгт сэтгэл санааны хохирол, есөн хэрэгт бусад төрлийн хохирлоо нэхэмжилжээ. Харин шүүхээс хохирол нэхэмжилсэн 17 хэргээс долоон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, 10 нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн бөгөөд нийт 50,030,939 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулсан байна. Хохирлыг гэмт хэрэг үйлдэгчээс албан ёсоор нэхэмжлэхээс гадна эрүүгийн хэрэг хянан шалгах ажиллагааны явцад гурван хэрэгт талууд тохиролцож 3,000,000, 10,200,000, 30,000,000 төгрөгийг тус тус хохирогч талд өгснөөр хохирогч талаас “гомдол саналгүй” гэж мэдүүлсэн бөгөөд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан хохирол болон нөхөн сэргээх үйлчилгээний зардлыг шүүхийн шатанд нэхэмжлээгүй байна.

Дүн шинжилгээ хийсэн хэргүүдэд хууль ёсны төлөөлөгч буюу хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хохирогчид учирсан хохирол нэхэмжилдэггүй, харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан зардал буюу өмгөөлөгчийн хөлс, эмчилгээний болон унааны зардал зэргийг нэхэмжлэх тохиолдол нийтлэг байна. Энэ нь хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн эрх зүйн мэдлэг ихэнхдээ хангалтгүй байдагтай

³⁰ Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана.

³¹ Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

³² Гэмт хэргийн улмаас бүтэн өнчин болсон бага насны хүүхдийн сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг насанд хүрсэн хүний сэтгэцэд учирсан гэм хорыг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлж тогтооно.

³³ ШШГЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/2172 дугаар албан бичиг.

холбоотой байдаг бөгөөд бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хохирогч хүүхдэд учирсан хохирол, хор уршгийг тодорхойлж, мөнгөн хэлбэрээр тооцох, сэтгэл санааны хохирол болон охин хальсыг нөхөн төлүүлэх асуудал орхигддог байна.

Түүнчлэн насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэр бүлийн хамаарал бүхий (төрсөн болон хойд эцэг, авга, нагац ах, үеэл ах, төрсөн ах, хойд өвөө г.м) хүмүүс дунд үйлдэгдсэн тохиолдолд хохирогчийн хууль ёсны төлөөлөгч хохирогч хүүхдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргадаггүй³⁴ гэж судлаачид үзсэн байна. Тиймээс хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь иргэний журмаар нэхэмжлэл гаргаж, хохирлоо төлүүлэх талаар хангалттай мэдлэггүй, эсвэл ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгч оролцуулж, хохирлын асуудлыг нэг мөр цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн хохирогчийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, ялангуяа хохирлыг барагдуулах чиглэлээр Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлд гэмт хэргийн хохирогчид Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөр олгоно гэж заасан. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, 21 төрлийн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 10.1, 11.1, 11.4, 12.1, 13.2, 13.3 дугаар зүйл г.м)-ийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн болон хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зохицуулалттай. Гэвч тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна” гэж заасан нь бусад төрлийн хохирол, зардлыг нөхөн төлбөр олгох сангаас олгохыг хязгаарласан.

Олон улсын байгууллагаас бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг гэмт хэрэг үйлдэгч нэг дор бүгдийг нь төлөх боломжгүй тохиолдолд төрөөс нөхөн олговрыг бүрэн олгож, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг зөвлөдөг. Тухайлбал, НҮБ-ын 2005 оны “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлүүдийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд”-д зааснаар буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжид байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг³⁵, НҮБ-ын Гэмт хэргийн гэрч болон хохирогч хүүхдүүдийн асуудалтай холбогдох шүүх эрх зүйн үйл ажиллагааны журмын 8.35 дугаар зүйлд “хохирогч хүүхдийг нөхөн олговроо бүрэн авах, эргэн нийгэмжих, нөхөн сэргээхэд бололцоотой бүхий л тохиолдолд түүнд учирсан хохирлыг барагдуулах. Хохирол барагдуулах ажиллагаа нь хүртээмжтэй, хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан үзэх” гэж заасан. Мөн, Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалд³⁶ нөхөн олговрыг гэм буруутай этгээд төлөх боломжгүй буюу эх үүсвэр тодорхойгүй бол төрөөс нэн тэргүүнд хүнд гэмт хэргийн улмаас бие махбодод нь их

³⁴ Монголын криминологичдын холбоо, Нээлттэй Нийгэм Форум, “Хохирлын Үндэсний Тогтолцоо: Монголд гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлж буй нөхцөл байдал”, Судалгааны тайлан, УБ, 2023 он.

³⁵ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2005 оны 60/147 дугаар тогтоолоор “Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлүүдийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд” баталсан.

³⁶ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал”(Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power) батлагдсан.

хэмжээний гэмтэл учирсан болон бие махбод, сэтгэцийн эрүүл мэндээрээ хохирсон хохирогчид нөхөн төлбөр олгоно гэж заасан байдаг.

Гадаадын зарим улс орнуудад бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд санхүүгийн нөхөн олговор олгодог бөгөөд энэ тусламжийг Засгийн газрын хөтөлбөрөөр санхүүжүүлж, гэмт хэрэг үйлдэгчээс нөхөн төлбөрийг гаргуулдаг байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсад Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох хөтөлбөр (CVC) муж бүрд байдаг бол Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүст нөхөн олговор олгох газраас (CICA) хохирогчдод нөхөн төлбөр олгодог байна. Түүнчлэн Канад³⁷, Австрали³⁸, Герман³⁹, Франц⁴⁰ зэрэг улсуудад эмнэлгийн зардал, эмчилгээ болон бусад зардлыг нөхөх нөхөн олговрын сангууд байдаг. Швед⁴¹, Норвеги⁴², Нидерланд⁴³ зэрэг Скандинавын орнууд хохирогчдод нөхөн олговор олгохын зэрэгцээ хүчирхийлэгчдэд санхүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Тохиолдол 5.6.

Гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хохирлоо нэхэмжилсэн 10 хэрэг тутмаас хоёр хэрэгт нь шүүхээс нэхэмжилсэн шаардлагыг хангаж шийдсэн байх ба нэг хэрэгт дунджаар 10,000,000 төгрөгийг сэтгэцэд учирсан хохирол гэж шийдсэн. Шүүхээр шийдэгдсэн хохирлын хэрэгжилтийг авч үзэхэд, шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй буюу хохирол нөхөн төлөгдөхгүй байна.

(Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн албан хаагчтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд учирсан хохирлын тооцооллыг бүхэлд нь цогц байдлаар хийж, эхний ээлжид нөхөн төлбөрийг төрөөс гаргуулах зохицуулалтыг хийх нь хүүхдийн Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хангахад чиглэсэн чухал алхам болно.

Бэлгийн хүчирхийлэл нь хүүхдийн бэлгийн хэвийн хөгжлийг тасалдуулж, тэднийг сэтгэл зүй, бие махбодын хувьд хэт их ачаалалтай болгож, сөрөг бодол, мэдрэмж, туршлагыг даван туулахад хүргэдэг богино болон урт хугацааны ихээхэн хор хөнөөлтэй үзэгдэл юм⁴⁴.

Хүүхэд насны сэтгэцийн гэмтэл зөвхөн тухайн цаг үед хор нөлөө үзүүлээд зогсдоггүй ба даван туулж буй онцлогоос хамааран урт хугацааны хор хохирол учруулдаг бөгөөд архидалт, согтууруулах ундааны хэтрүүлсэн хэрэглээ, уушгины архаг бөглөрөл, сэтгэл гутрал, түгших эмгэг, ураг амьгүй болох, эрүүл мэндийн шалтгаантай амьдралын чанар муудах, хууль бус бодисын хэрэглээ буюу сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, мансууруулах бодис, зүрхний ишеми буюу зүрхний титэм судас нарийсаж зүрхний булчинд очиж байгаа цусан хангамж дутагдах өвчин, элэгний өвчин, дотно хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй, бэлгийн олон хамтрагчтай байх, бэлгийн замын халдварт өвчин,

³⁷ Мужийн нөхөн олговрын хөтөлбөрүүд: Муж бүр (жишээ нь, Онтариогийн "Хохирогчдод хурдан хариу өгөх хөтөлбөр") эмчилгээ, эмчилгээний зардал, нөхөн сэргээхэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Шүүх хүчирхийлэгчдээс эдгээр зардлыг нөхөн төлөхийг шаардаж болно.

³⁸ Гэмт хэргийн хохирогчдод туслах шүүх (VOCAT): Эмнэлгийн зардал, зөвлөгөө өгөх, орлогоо алдах зэрэгт санхүүгийн тусламж үзүүлдэг. Засгийн газар гэмт хэрэг үйлдсэн хүмүүсээс мөнгөө буцааж авах боломжтой.

³⁹ Гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох тухай хууль (OEG): Хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эмчилгээ, нөхөн сэргээх зорилгоор санхүүгийн тусламж үзүүлдэг. Эрх баригчид гэмт хэрэг үйлдсэн этгээдээс нөхөн төлбөр авна.

⁴⁰ Эрүүгийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох хороо (CIVI): Хохирогчдод мөнгө төлж, улмаар боломжтой бол хүчирхийлэгчээс гаргуулдаг.

⁴¹ Гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах, дэмжих газар: Хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгож, дараа нь хүчирхийлэл үйлдэгчээс гэм буруутай нь тогтоогдвол хохирлоо барагдуулахыг шаарддаг.

⁴² Норвегийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх газар: Хохирогчид санхүүгийн тусламж үзүүлдэг бөгөөд засгийн газар гэмт хэрэг үйлдэгчээс эгүүлэн гаргуулдаг.

⁴³ Schadefonds Geweldsmisdrijven (Хүчирхийллийн гэмт хэргийн нөхөн төлбөрийн сан): Хохирогчдод нөхөн төлбөр олгох бөгөөд гэмт хэрэг үйлдэгчээс буцаан гаргуулж болно.

⁴⁴ ХЗДХЯ, ХНХЯ, "Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй", Гарын авлага, УБ, 2022 он.

тамхидалт, илүүдэл жин, амиа хорлох оролдлого, хүсээгүй жирэмслэлт зэрэг эрсдэлийг дагуулдаг⁴⁵.

Тиймээс бэлгийн хүчирхийллийн сэтгэцийн гэмтэл нь тухайн хүүхдийн насан туршийн амьдралд тал бүрээр нөлөө үзүүлэн даван туулах шаардлагатай болдгийг өргөн хүрээнд тусган ойлгож хохирогч хүүхдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлэхээс шийдвэрлэгдэх хүртэл бүхий л шатанд, мөн хэрэг шийдвэрлэгдсэний дараа ч үргэлжлүүлэн богино болон урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг тогтмол үзүүлэх, шаардлагатай хүний нөөц(сэтгэл засалч), төсөв санхүүжилтийг гаргах нь төрийн үүрэг юм.

Хүүхдэд зайлшгүй сэтгэл зүйн үйлчилгээ шаардлагатай гэдгийг шүүхийн шийдвэрт тусгаж шийдвэрлэсэн тохиолдлууд байгаа ч энэ нь нийтлэг биш байна. Тухайлбал, 20 238 дугаартай Эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолд “Сэтгэл зүйн оношилгооны дүгнэлтээр өсвөр насны хохирогч Н.М, Н.О, Н.М нар сэтгэл зүйн хувьд зовуурь шаналлын ямар хэлбэр, төрөлтэй байгаа, тэдгээрт сэтгэл заслын ямар эмчилгээг хэдий хэр хугацаанд хийх, тэдгээрийн үнэ тариф зэргийг тодорхой зааснаас гадна бага насны хүүхдийн хувьд тархи бүрэн хөгжиж, бие хүн болж төлөвших хүртэл өөрийн сэтгэл хөдлөл дээр тулгуурлаж шийдвэр гаргах, өөрийн хяналтгүй шийдвэр гаргах магадлал өндөр, түүнчлэн бага насанд авсан санаа сэтгэлийн цочрол нь насан туршид нь хадгалагдаж үлдэх, буруу зан үйлд татагдах зэрэг үр дагавартай тул тогтмол сэтгэл зүйчтэй уулзаж, зөвлөгөө авах”⁴⁶ гэж тусгажээ.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмнэлгийн тусламж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрүүдийг олон улс орнууд хэрэгжүүлдэг байна. Америкийн Нэгдсэн Улсад Хүүхдийн хүчирхийллийн үндэсний утас (Childhelp⁴⁷), RAINN⁴⁸ зэрэг байгууллагууд сэтгэл зүй, сэтгэл засал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг бол Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын NSPCC⁴⁹ болон Childline⁵⁰ мөн Австралийн Холбооны Улсын Bravehearts⁵¹, 1800RESPECT⁵² зэрэг байгууллагаар дамжуулан тусламж үзүүлдэг. Харин Герман, Франц, Энэтхэг, Өмнөд Африк, Швед, Бразил зэрэг улсуудад бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зориулсан хөтөлбөр, хэрэгжүүлж буй арга хэмжээ нь сэтгэлзүйн болон эмнэлгийн тусламж, хууль эрх зүйн хамгаалалт, нөхөн сэргээх үйлчилгээг цогцоор нь үзүүлэхэд чиглэгддэг байна.

Тохиолдол 5.7.

Хүүхэд хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээ хангалтгүй байгаагийн гол шалтгаан нь салбарын түвшинд хүний нөөц, тэр дундаа сэтгэл засалчийн орон тоо, хүний нөөц хомсдолтой холбоотой байгаа нь бодлогоор мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна.

(Салбарын мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас)

Манай улсын хувьд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг “Хөөрхөн зүрх”, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” зэрэг төрийн бус байгууллагуудаар дамжуулан үзүүлдэг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээллээр 2022 онд бэлгийн хүчирхийллийн хохирогч 369, 2023 онд 452, 2024 онд 198 хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлсэн байна. Жил бүр бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа хүүхдийн тоотой нөхөн сэргээх үйлчилгээ авсан хүүхдийн тоог харьцуулж үзвэл нөхөн сэргээх үйлчилгээ хүртээмжгүй, хүүхэд бүр энэ үйлчилгээг авч чаддаггүй хохирсоор байна. Үүнийг салбарын хүмүүс мэргэжлийн хүний нөөц, төсөв, санхүүжилт дутмагтай холбоотой тайлбарладаг бөгөөд цаашид нөхөн сэргээх үйлчилгээний төсвийг нэмэгдүүлэх, мэргэшсэн хүний нөөц тэр дундаа сэтгэл засалч бэлтгэх, тэдгээрийн

⁴⁵ Хүүхдийг Ивээх Сан, “Сэтгэцийн гэмтэлд суурилсан хохирогч/даван туулагч төвтэй үйлчилгээ” модуль 9, УБ, 2023 он.

⁴⁶ ХЭҮК, ЦЕГ, ДХИС, НҮБ-ын Хүүхдийн сан, “Бэлгийн хүчирхийллийг хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь”, Гарын авлага, УБ, 2022 он, 73 дахь тал.

⁴⁷ National Child Abuse Hotline

⁴⁸ Rape, Abuse & Incest National Network

⁴⁹ National Society for the Prevention of Cruelty to Children

⁵⁰ Free counseling for children

⁵¹ Support & prevention for child abuse victims

⁵² National Sexual Assault Helpline

нийгмийн баталгааг сайжруулах замаар тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороо Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гурав, дөрөвдүгээр тайланг хэлэлцээд “... бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүдэд хамгаалал, нөхөн сэргээх тусламж хангалттай хүрдэггүй...” гэж дүгнэсэн.

Бэлгийн хүчирхийллийн хохирогчийн бодол санаанд гэмт хэрэг үйлдэгдэх үед болж өнгөрсөн аймшигтай, гутамшигтай дурсамж үе үе орж, сэтгэлийг нь зовоох стрессийн хариу урвал нь ааш зангаа барьж дийлэхгүй байх, хэт цочмог хариу үйлдэл үзүүлэх зэрэг шинжээр илэрдэг төдийгүй сэтгэцийн эмгэгтэй болдог тул хохирогчийг сэтгэл заслын болон нөхөн сэргээх үйлчилгээнд заавал хамруулах нь чухал юм.

5.6.ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БУСАД БҮТЦИЙН ОРОЛЦОО

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан баг, хүүхдийн эрхийн улсын байцаагч болон хууль ёсны төлөөлөгчийн оролцоо хангалтгүй байна.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг илэрсэн ч хохирогч өөр бусад төрлийн дарамтад өртөх нь түгээмэл байдаг. Тухайлбал, гэр бүлийн болон бусад холбогдох хүмүүсийн зүгээс мэдүүлгээ өөрчлөхийг шаардсан ятгалга, сүрдүүлэг, дарамт заналхийлэл ирэх, хэрэв гэмт хэрэг үйлдэгч нь тэжээн тэтгэгч бол эдийн засгийн дарамтад орох, хохирогчийн хувийн мэдээлэл алдагдах зэрэг сөрөг үр дагавартай.

Дээрх тохиолдолд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх “Хүүхэд хамгааллын үйлчилгээ”-нд Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлэг, сэтгэл зүй, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээнээс гадна суурь боловсролын үйлчилгээ, асрамжийн хувилбарт үйлчилгээ, гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээг хүүхдийн тухайн оршин байгаа газрын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага, эсвэл тухайн чиглэлээр мэргэжсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийг нийгмийн хэвийн амьдралд нь тусалж, дэмжих зорилгоор Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлдэг. Хүүхэд хамгааллын эдгээр бүтэц нь хохирогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлж, дахин хохирохоос урьдчилан сэргийлэх боломжийг нэмэгдүүлэх юм.

Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон эдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүүхэд тус бүр дээр төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавих, бага насны хүүхдийн мэдүүлгийг дуу, дүрсний бичлэгээр баталгаажуулах, хүүхдийг дарамт, шахалтаас урьдчилан сэргийлж, сэтгэл зүйн болон эрх зүйн зөвлөгөө өгөх, эцэг, эх, гэр бүл, сургууль, хамт олонд зөвлөгөө өгөх, уулзалт зохион байгуулах, хүүхдийг хорт зуршлаас ангижруулах сургалтад хамруулах, эрүүгийн хэрэг болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үеэр сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүрэгтэй. Гэсэн хэдий ч Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэрэгт Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хохирогч хүүхдийн эрхийг хангах чиглэлээр ажилласан эсэх нь тодорхойгүй, хэргийн материалд хорооны дүгнэлт, санал хэргийн материалд авагдаагүй байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад

хүүхдийн нөхцөл байдлыг үнэлсэн ач холбогдол бүхий мэдээллийг мөрдөгч, прокурор ашиглахгүй, хамтран ажиллахгүй байгааг харуулж байна.

Комисс 2023 онд УИХ-д өргөн барьсан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлдээ Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа хангалтгүй гэж дүгнэ бөгөөд УИХ 2023 оны “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийг хэлэлцүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолдоо “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэргийн холбогдогч, хохирогч, гэрч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх” арга хэмжээг тусгасан боловч хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмаар зохицуулж байсныг 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулиар өөрчилсөн.

Хүснэгт 5.9. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчилгээ авсан хүүхдийн тоо⁵³

Үйлчилгээ	2020	2021	2022	2023	2024 ⁵⁴
Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчилгээ авсан хүүхдийн тоо	811	733	1682	1840	1162
Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд	96	91	318	210	102
Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд	1181	1365	775	599	560
Гэрч хүүхэд	59	50	227	182	139
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхэд	115	345	369	452	311

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 2020 оноос 2024 оны 11 дүгээр сарын байдлаар 6,228 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлснээс гэмт хэргийн хохирогч болсон 4,480 хүүхэд, үүнээс 1,592 нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхэд байна. Дээрх тоон мэдээллийг тус онуудад цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоотой харьцуулахад, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан хохирогч хүүхдийн тоо харьцангуй бага байгаагаас үзвэл тус хороо хангалтгүй ажиллаж байна гэж дүгнэхээр байна.

Насанд хүрээгүй хүн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болж байгаа нь амьдралын түвшин доогуур, гэр бүлийн орчин архидалт ихтэй, хүүхдүүд эцэг, эхийн хараа хяналт сул зэргээс шалтгаалж байна. Тухайлбал, 2022 онд бүртгэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн 550 гэмт хэргийн 364 буюу 66.2 хувь нь гэр, орон сууцанд, 59 буюу 10.7 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ. Харин 2023 онд бүртгэгдсэн 564 гэмт хэргийн 385 буюу 68.3 хувь нь гэр, орон сууцанд, 45 буюу 8.0 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ⁵⁵.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар хамтарсан баг⁵⁶ нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх чиг үүрэгтэй бөгөөд хүүхэд хамгааллын үйлчилгээ, тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд шуурхай

⁵³ ХГБХХЕГ, Монголын хүүхдүүд статистик эмхэтгэл 2022-2023, УБ хот.

⁵⁴ ХГБХХЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн тайлан.

⁵⁵ ЦЕГ, “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” /Албан хэрэгцээнд/, УБ, 2024 он.

⁵⁶ Хамтарсан баг нь орон нутгийн түвшинд ажиллаж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж үйлчилгээг нэг дороос үзүүлэх боломжийг хангаж, холбон зуучлах үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын нэгж юм.

тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх болон урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэхээр хуульчилсан.

Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн бөгөөд хүчирхийлэл үйлдэгчтэй нэг дор амьдарч байгаа, хүчирхийлэл үйлдэгч өөрт ашигтай шийдвэр гаргуулахад ашиглаж болзошгүй нөхцөл байдал үүссэн бол харьяалах хамтарсан баг нь хүүхдийн болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээгээр 24 цагийн дотор хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах арга хэмжээ авах үүрэгтэй. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд буюу бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд эрсдэлт нөхцөл болон аюулын зэргийн үнэлгээг тогтоосноор хохирогчийг цаашид хамгаалах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой нэг төрлийн нотлох баримт юм.

Гэвч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн нөхцөл байдлыг тогтоохдоо хүүхдийн аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээг төдийлөн ашигладаггүй байна. Энэ нь мөрдөгч, прокурор гэмт хэргийг илрүүлэх, нотлох, бодит нөхцөл байдлыг тогтоох, хохирлын хэмжээг үнэлэхэд чухал ач холбогдолтой. Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэргээс долоон хэрэгт хамтарсан баг ажиллаж, зургаан хэрэгт нөхцөл байдлын үнэлгээ, долоон хэрэгт аюулын зэргийн үнэлгээ хийсэн байна.

Хамтарсан баг 2022-2024 оны байдлаар нийт 31,820 тохиолдолд ажилласан ч үйлчилгээний төрлөөр ангилдаггүй, бэлгийн хүчирхийллийн хохирогч хэдэн хүүхдэд хүүхэд хамгааллын болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлсэн эсэхийг нарийвчилж бүртгэдэггүй нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 5.10. Хамтарсан баг, багийн гишүүдийн тоо, ажилласан кейс⁵⁷

Он	Хамтарсан баг	Ажилласан кейс
2022	720	12,200
2023	806	12,490
2024 ⁵⁸	774	7,130

Хамтарсан баг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн үзүүлдэг гэж дүгнэхэд учир дутагдалтай, хүүхдийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тодорхойлсон эсэх нь эргэлзээтэй байна. Иймд мөрдөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангах, хамгаалах үүднээс хамтарсан багийн дүгнэлт, үнэлгээг харгалзан үзэх шаардлагатай юм.

Хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хууль эрх зүйн мэдлэг, ойлголт хангалтгүй, сэтгэл санааны байдал, гэр бүлийн дарамт, айдас, нэр төр, гэр бүлийн харилцааг чухалчлах, эдийн засгийн хараат байдал зэрэг ашиг сонирхлын зөрчилтэй байдлаас шалтгаалан хохирогч мэдүүлгээ өөрчлөх, харилцан тохиролцох, улмаар гомдол саналгүй, нэхэмжлэх зүйлгүй гэж мэдүүлгээсээ буцах, хохирогч хүүхэд өөрөө дарамтад орох эрсдэлтэй нөхцөл байдал үүсдэг нь холбогдох бүлгүүдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлага, зарим судалгаанд тусгагдсан байна.

Тохиолдол 5.8.

... хэрэгт хууль ёсны төлөөлөгчөөр төрсөн эхийг нь томилсон бөгөөд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч гомдол, саналгүй, шүүх хуралдаанд оролцохгүй гээд шүүх хуралдаа оролцоогүй, хохирол нэхэмжлээгүй байдаг. Түүнчлэн УДШ-д хууль ёсны төлөөлөгчөөс нь “Миний охин худал мэдүүлсэн. Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү” гэх гомдлыг гаргаж хохирогчоор мөн гарын үсэг зуруулсан байна.

(Эрүүгийн хэргийн ... дугаартай хэрэгт хавсаргагдсан материалаас)

ЭХХШТХ-д мөрдөгч, прокурор нь арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор хуульчилсан. Хэрэв арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны

⁵⁷ ХГБХХЕГ, Монголын хүүхдүүд статистик эмхэтгэл 2022-2023, УБ хот.

⁵⁸ ХГБХХЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн тайлан.

төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.⁵⁹ гэж заасан. Мөн улсын байцаагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо ЭХХШТХ-ийн 9.5 дүгээр зүйлийн 9.5.1 дэх хэсэгт заасны дагуу хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтны хувьд хууль ёсны төлөөлөгчөөр томилогдох эрх зүйн зохицуулалттай байна.

Комиссоос дүн шинжилгээ хийсэн 40 хэрэгт нийт 51 хууль ёсны төлөөлөгч томилогдож ажилласан бөгөөд тус бүр 1-3 удаа солигдон ажилласан байна. Үүнээс 24 нь хохирогчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 24 нь хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын мэргэжилтэн, гурав нь нийгмийн ажилтан оролцсон байна. Хууль ёсны төлөөлөгчөөс гадна сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч оролцуулсан тус бүр нэг тохиолдол байна.

Харин хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас томилогдон оролцож байгаа төрийн албан хаагч нь үндсэн үүрэгт ажлын зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог тул оролцоо харилцан адилгүй, түүнчлэн энэ төрлийн гэмт хэрэг хянан шалгах ажиллагаатай холбоотой хууль зүйн мэдлэг, ажлын туршлага дутмаг байгаагаас үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.⁶⁰

Тохиолдол 5.9.

Шүүгч: Та насанд хүрээгүй хохирогчтой уулзсан уу?

Хууль ёсны төлөөлөгч: Насанд хүрээгүй хохирогчтой уулзаагүй. Харин ээжтэй нь уулзсан бөгөөд хохирогчийн ээж нь миний охины буруу бас байсан байна гэж хэлсэн.

Шүүгч: Та ямар үүрэгтэйгээр өнөөдрийн шүүх хуралдаанд оролцож байна вэ?, Та ядаж нэг удаа хохирогчтой уулзаж байсан уу?, Байр байдлыг ажиглах боломж байсан уу?, Хүүхэд үнэнийг хэлэх боломжгүй нөхцөлд байхыг үгүйсгэхгүй. Харин та ганцаарчилж уулзах боломжтой байсан уу?” Хууль ёсны төлөөлөгч: Уучлаарай.

Шүүгч: Насанд хүрээгүй хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон байхад та ийм хайхрамжгүй байж болох уу?

Хууль ёсны төлөөлөгч: Болохгүй.

Шүүгч: Хохирогчийн оршин суух хаяг нь хаана бүртгэлтэй байдаг вэ?

Хууль ёсны төлөөлөгч: /Хариулсангүй/

Улсын яллагч: Хүүхэд өмнө нь ямар зан төлөвтэй байсан бэ?, гэмт хэргийн хохирогч болсноос хойш ямар зан төлөвтэй болсон бэ?, Ямар эмчилгээ хийлгэсэн талаар асуумаар байвч хууль ёсны төлөөлөгч хэргийн материалтай танилцаагүй нь харагдаж байна.

Хууль ёсны төлөөлөгч: Сэтгэл зүйн эмчилгээ хийлгэх шаардлагагүй гэж хохирогчийн ээж нь хэлсэн.

Шүүгч: Хариултыг та хаанаас авсан бэ?

Хууль ёсны төлөөлөгч: Хохирогчийн ээжтэй нь уулзсан.

Улсын яллагч: Та хүүхдийн гэрт очиж уулзсан уу?

Хууль ёсны төлөөлөгч: Би өнгөрсөн 7 хоногт шинээр томилогдсон.

(Шүүх хурлын тэмдэглэлээс ...)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийг хамгаалж, хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж буй албан хаагчдын мэргэшил, ур чадвар, туршлага харилцан адилгүй байгаа тул чадавхжуулах шаардлагатай байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалахад хүүхэд хамгааллын бүтцийн буюу Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багийн гаргасан дүгнэлт, саналыг хэрэгт хавсаргаж нөхцөл байдлыг тогтооход тал бүрээс дүгнэн шийдвэрлэхэд ашиглахад анхаарах, байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах нь зүйтэй байна.

⁵⁹ ЭХХШТХ-ийн 9.5 дугаар зүйлийн 9.5.1 дэх хэсэгт.

⁶⁰ Хүйсийн тэгш эрхийн төв, “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ” Судалгааны тайлан, УБ, 2023 он.

САНАЛ

1) Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан дэлгэрэнгүй хийх, судалгааны үр дүнг үндэслэсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх арга хэлбэрийг шинэчлэх;

2) Педофил буюу бага насны хүүхэдтэй бэлгийн харилцаанд орж таашаал авдаг гаж зан үйлийн эмгэгтэй гэмт хэрэгт холбогдогчид сэтгэцийн шинжилгээ хийх журам, энэ төрлийн эмгэгийг оношлох, эмчлэх, эмгэгтэй хүнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3) Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалсан, дахин хохирохоос урьдчилан сэргийлсэн тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан бий болгох;

4) Насанд хүрээгүй болон бага насны хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг мэргэжлийн, бэлтгэгдсэн сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтнаар ярилцлага хийлгэх замаар дагнан, нэг удаа, чанартай, шуурхай явуулж, үүнийг дуу, дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцох хуулийн зохицуулалтыг бий болгох;

5) Хүүхдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн газраас өөр тайван, хүүхдэд аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй орчинд авах зохицуулалтыг хийх;

6) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалтыг сэргээх;

7) Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд учирсан хохирлыг заавал тодорхойлж, тогтоох, тэр дундаа нөхөн сэргээх, сэтгэл заслын зардлыг хэргийн хамт шийдвэрлэдэг болох, хохирлыг эхний ээлжид төрөөс гаргаж, төр гэм буруутай этгээдээс дараа нь гаргуулдаг байх зохицуулалтыг хийх;

8) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын тогтолцооны хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын оролцоог нэмэгдүүлэх;

9) Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт гагцхүү мэргэшсэн, тусгайлан бэлтгэгдсэн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, мөрдөгч, прокурор, шүүгчийг оролцуулах.

VI БҮЛЭГ

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

“Монгол Улсын иргэн... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх... Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг)

“Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа ... хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйл 1 дэх хэсэг)

“Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд ...байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх;...ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх ...баталгаагаар хангагдах эрхтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг (d)).

“Хүн бүр... өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй байх... наад захын баталгаагаар хангагдах эрхтэй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг (g))

“Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй”

(Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

“Төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна”

(НҮБ-ын Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3)

“Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй”

(Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг)

6.1. ТАНИЛЦУУЛГА

Шударгаар шүүлгэх эрхийн агуулга нь аливаа хүн эрүүгийн хэрэгт татагдсан үеэс эхлэн ял шийтгэл эдэлж дуусах хүртэлх үе шатыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм. Гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж байгаа хүнтэй мөрдөн шалгах, шүүх эрх мэдлийн байгууллагууд хэрхэн харьцаж байгаа, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийг хэрхэн хүндэтгэн хамгаалж байгаагаас тухайн улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдал, хууль дээдлэх ёс ямар түвшинд хүрснийг илэрхийлэх шалгуур үзүүлэлт болдог.

Хүний эрхийн Үндэсний Комисст 2024 онд ирсэн гомдол, мэдээллийн 52.9 хувь нь шударгаар шүүлгэх эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл эзэлж байх ба агуулгаар нь авч үзвэл, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, хилс хэрэг хүлээсэн, эрүү шүүлтээс ангид байх, хууль бусаар цагдан хоригдсон, орон байрны халдашгүй байдалд халдсан, гэмт хэрэг үйлдсэн мэтээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд зарласан, шүүх эрх мэдлийн болон мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хууль бус үйл ажиллагааны улмаас хохирсон зэрэг гомдлууд дийлэнх хувийг эзэлж байна.

Комисст ирүүлсэн гомдол мэдээлэл, зохион байгуулсан хяналт шалгалт, шинжээч, судлаач нартай хамтран хийсэн судалгааны үр дүн, комиссын гишүүний шаардлага зөвлөмж, холбогдох байгууллагын баримт мэдээлэлд үндэслэн шударгаар шүүлгэх эрхийн зарим асуудлыг хөндөж, цаашид авах арга хэмжээний талаар боловсруулсан дүгнэлт саналыг тусгалаа.

Энэ бүлэгт дараах хүний эрхийн асуудлыг авч үзсэн болно.

- Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тайлагнах асуудал, эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцааны нөхцөл байдал, тэр дундаа бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох хэлбэр, хариуцлага хүлээсэн байдал, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хорих анги, цагдан хорих байран дахь хүнлэг бус харьцааны нөхцөл байдал, цэргийн анги, байгууллага дахь дүрмийн бус харьцааны нөхцөл байдал, эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах чадавхыг бэхжүүлэхэд авах шаардлагатай арга хэмжээ;
- Мэдүүлэг авах үеийн хүний эрхийн асуудлын хүрээнд хүн өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн хэрэгжилт, хүн өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадах, хүч хэрэглэж буй байдал, улсын хэмжээнд хууль сахиулах байгууллагуудын хүрээнд байх мэдүүлэг авах өрөөний нөхцөл байдал, түүнд тавигдах шаардлагыг шинэчлэн батлах, хэрэгжүүлэх хэрэгцээ зэрэг асуудал;
- Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийн талаар хүн аливаа байдлаар мэдүүлэг өгөх үедээ өмгөөлөгчийн туслалцаа авч чадаж байгаа эсэх, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрд яллах талтай мэтгэлцэх зарчмыг бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх, өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт, улсын өмгөөлөгчийн тоо, хүртээмж, ачаалал зэрэг хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтэд нөлөөлж буй, тулгамдсан асуудал;
- Сэтгэцийн шинжилгээ ба хүний эрх сэдвийн хүрээнд эрүүгийн хэрэг мөрдөн шалгах, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийж буй байдал, процессын зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал, зөвхөн шүүхийн шийдвэрээр энэхүү ажиллагааг хийх замаар хүний халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн баталгааг бүрдүүлэх шаардлага;
- Төрийн нууцтай холбоотой хэрэг, мөрдөн шалгах нууц ажиллагааны тухайд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхээр хэрэг хянан хэлэлцэх, таслан сэргийлэх арга хэмжээ авахад үндэслэл болгож буй байдал, нууц мөрдөн шалгах ажиллагааг шүүхийн зөвшөөрлөөр явуулах зохицуулалтыг хуульчлах шаардлага;
- Мөрдөн шалгах ажиллагааны нууц, хүний хувийн мэдээлэл сэдвийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд хүний эмзэг мэдээллийг задруулах, хохирогчийг буруутгах агуулгатай мэдээлэл олон нийтэд тараах зэрэг хүний эрхийг зөрчих явдал,

тэдгээрийг шийдвэрлэж буй байдал, хуульд тусгах шаардлагатай эрх зүйн зохицуулалтын талаар;

- Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ сэдвийн хүрээнд шүүхээс гаргасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийн тоо, статистик, уг арга хэмжээг авах, хугацаа сунгах, шүүх хуралд өмгөөлөгч оролцуулж буй байдал, цагдан хорих байрны орчны нөхцөл болон хүний эрхийн байдал зэрэг асуудал;
- Хилээр гарахыг хориглох, таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох шийдвэрийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүний эрхийн зөрчил, тэдгээрт хамаарах буй эрх зүйн хийдэл, шаардлагатай эрх зүйн зохицуулалтын талаар;
- Хорих ял ба хорих ангийн орчин нөхцөл сэдвийн хүрээнд шүүхээс хорих ял оногдуулж буй байдал, тоо статистик, хорих ангийн багтаамж, барилга, байгууламж, орчины нөхцөл, хорих анги дахь хоолны хүртээмж, илчлэг, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төсөв, нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ, эргэлт, уулзалт авах, өргөдөл гомдол гаргах эрх, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт;
- Баривчлах шийтгэл эдлүүлэх байрны орчин нөхцөл байдал, багтаамж, тавигдах стандартын хэрэгжилт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилт, холбогдох төсөв, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд гарч буй төсөв санхүүгийн бэрхшээл, түүнээс үүдэлтэй хүний эрхийн асуудал;
- Зөрчлийн хэрэгт давж заалдах эрх сэдвийн хүрээнд зөрчлийн хэрэгт баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх явцад шийтгүүлсэн хүн шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргаж буй байдал, давж заалдах эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал, мэдлэг ойлголтын асуудал, эдгээрээс үүдсэн хүний эрхийн зөрчил;
- Хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлын хүрээнд хорих ял эдэлж байгаа хүнээс хохирол, нөхөн төлбөр төлүүлж буй байдал, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нөхөн төлбөр олгоход үүсэж буй хүний эрхийн зөрчил, сэтгэцэд учруулсан хор уршиг буюу сэтгэл санааны хохирлыг тооцож олгож буй байдал, эрүү шүүлтийн хохирогч хамгаалал, нөхөн төлбөр;
- Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа сэдвийн хүрээнд Комиссоос эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрхэд суурилсан мөрдөн шалгах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийг хангуулах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох, алба хаагчдын хүний эрхийн боловсролыг дэмжих үйл ажиллагааны үр нөлөө, цагдаагийн алба хаагч бэлтгэх хөтөлбөрийг сайжруулах төсөл, хууль сахиулах байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй хүний эрхийн сургалт, ялангуяа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, шударгаар шүүлгэх эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй сургалт, нөлөөллийн ажлын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлуудыг тусгалаа.

6.2. ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ ЭРХ

6.2.1. Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд тайлагнах асуудал

Комисс Монгол Улсын Засгийн газарт Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (*цаашид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц гэх*)-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг бэлтгэхдээ эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгийн харьцах үйлдлийг Эрүүгийн хуульд хэрхэн хуульчилсан, үйлдэгдсэн гэмт хэргийн бүртгэл, шийдвэрлэлт, түүнд оногдуулсан ял шийтгэлийн талаар тодорхой дурдаж, тайлангийн агуулгыг конвенцын 1 дүгээр зүйлд заасны дагуу оновчтой тодорхойлж, тайлан бэлтгэх жишиг аргачлалыг боловсруулах шаардлагатайг зөвлөж байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит III тайланг тус конвенцын хэрэгжилтэд хяналт тавьдаг Эрүүдэн шүүхийн эсрэг хороо 2024 оны 11 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд 81 дүгээр чуулганахаа 2157, 2160 дугаар хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд хөтөлбөрийн дагуу Комиссын төлөөлөл Хороотой хаалттай уулзалт хийж, тайлангийн хуралдаанд ажиглагчаар оролцсон.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хамгаалагдсан эрхийг зөрчсөн үйлдлүүд нь зөвхөн нэг гэмт хэргийн шинжээр тодорхойлогдохгүй юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн

газар тайлангийн явцад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12 дугаар зүйл “Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг”-ийн нөхцөл байдал, шийдвэрлэлтийн талаар тайлагнасан бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг хороо мөн оны 12 дугаар сарын 11-ний өдөр урьдчилсан ажиглалт дүгнэлтээ хийж, холбогдох зөвлөмжийг өгсөн.

Зөвлөмжид Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын агуулгад бүрэн нийцэхгүй байгаа дутагдалтай талуудыг цохон тэмдэглэсэн. Тухайн заалт нь хохирогч болон гуравдагч этгээдийг айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор үйлдсэн, төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад этгээдийн өдөөн хатгалга, ил, далд зөвшөөрлөөр үйлдсэн, эрүү шүүлт тулгахыг завдах, эрүү шүүлт тулгахад хамтран оролцох үйлдлийг тус тус хамааруулаагүй, доод шатны албан тушаалтнууд нь эрүү шүүлт тулгаж, зүй бус харьцсан үйлдлийг мэдсэн эсвэл мэдэж байх ёстой байсан ч урьдчилан сэргийлэх талаар зохих арга хэмжээ аваагүй дээд шатны албан тушаалтнуудад эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байна гэж дүгнэсэн.

Олон улсын практик, сайн туршлагад эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг илүү өргөн хүрээнд, бие даасан олон төрлийн гэмт хэргийн шинжээр тодорхойлж, эрүүгийн хариуцлагын хатуу бодлого баримталдаг байна. Тухайлбал Бүгд Найрамдах Франц Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсыг дурдаж болно. Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нэг гэмт хэргийн шинжид хамааруулан тодорхойлсон улсууд ч байгааг анхаарах нь зүйтэй. Дээр дурдсан улс орнууд Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийг тайлагнахдаа хүний бие махбод, сэтгэл санааны халдашгүй байдлын эсрэг санаатай үйлдсэн, харгис хэрцгий шинжтэй олон гэмт хэргийн хүрээнд тайлагнадаг байна.¹ Мөн хүчирхийлж, харгис хэрцгий үйлдэл хийх гэмт хэргээр хязгаарлалгүй хууль бусаар баривчлах, хорих,² хүн төрөлхтний эсрэг гэмт хэргүүд,³ Олон улсын эрүүгийн шүүхийн харьяаллын гэмт хэргүүд, баривчлах, хорихдоо хүндрүүлэн шийтгэх гэмт хэрэг⁴ эрүү шүүлт, хүнлэг бус, харгис хэрцгий харьцах, шийтгэх элемент агуулсан гэмт хэргүүдийн хүрээнд тайлагнадаг байна.⁵

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод заасан эрүүдэн шүүх гэсэн тодорхойлолтын бүх шинжийг нэг гэмт хэрэгт хамааруулан хуульчлах нь хүндрэлтэй байдгийг олон улсын практик харуулж байна. Тиймээс Эрүүдэн шүүхийн эсрэг хороо тус конвенцын 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолтыг бүрэн агуулгаар нь гэмт хэрэгт тооцож хуульчлахыг зөвлөдөг бөгөөд нэг зүйлд хамааруулан үзэхийг шаарддаггүй.

6.2.2. Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцааны нөхцөл байдал

Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл)

УИХ-аас 2017 онд баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын холбогдох зүйл, хэсгүүдэд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинж, хор уршгийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын агуулгад нийцүүлэн тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан. Эрүүгийн хуульд “Эрүү шүүлт тулгах” гэмт хэргийн үндсэн шинжийг “Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”⁶ гэж заасан.

Эрүүгийн хуульд “эрүүдэн шүүж” хүнийг алсан бол арван хоёроос хорин жил хүртэл, эсхүл бүх насаар хорих ял,⁷ “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан

¹ <https://docs.un.org/en/CAT/C/FRA/CO/4-6>

² Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл.

³ Мөн хуулийн 9 дүгээр зүйл.

⁴ Мөн хуулийн 4-2 дугаар зүйл.

⁵ <https://docs.un.org/CAT/C/KOR/6>.

⁶ Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл.

⁷ Мөн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2.12 дахь заалт.

бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял,⁸ “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял,⁹ “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял¹⁰ шийтгэхээр тус тус заасан.

Прокурорын байгууллагын мэдээллээс үзэхэд 2017 оны сүүлийн хагас жилээс 2024 оны эхний 7 сарын байдлаар эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар нийт 414 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 275 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. Дээрх хугацаанд нийт 203 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, үүнээс 159 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 2 хэргийг хэрэгсэхгүй болгож,¹¹ 17 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлснийг гурван шатны шүүхээр шийдвэрлэсэн байна.¹² Энэ нь жилд дунджаар 2 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэдэг гэсэн үзүүлэлт бөгөөд бүртгэгдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлтэй харьцуулахад маш бага хувийг эзэлж байна.

Төрийн албан хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэрэг нь хүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох хэлбэрээр илэрч байгаа ба гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хохирол учруулах явдал цөөнгүй байна. Түүнчлэн тухайн хүнд чиглэсэн сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох, тарчлаах шинжтэй аргыг хэрэглэхээс гадна гэр бүл, хамаарал бүхий хүнд шууд бусаар нөлөөлөх хандлага түгээмэл байна.¹³

Бусдын бие махбодыг шаналган зовоох хэлбэр

Шүүхээр шийдвэрлэсэн хэргүүдээс үзвэл, эрүү шүүлтийн улмаас хүнд гэмтэл учирсан 1, хүндэвтэр гэмтэл учирсан 2, хөнгөн гэмтэл учирсан 6, гэмтэл учраагүй 7 хэрэг шийдвэрлэгдсэн бол үйлдлийн аргын хувьд чих, шанаа, нүүр, толгой, гар, нуруу, бэлэг эрхтэн, цээж рүү цохих, алгадах, гуя, өгзөг, хөл хэсэгт өшиглөх, бороохойдох, чихнээс зулгаах, цамцны захаар хоолойг нь боох, өвдөглөх, нүд, ам руу нулимс асгаруулагч цацах, цагдан хорих, ганцаарчлан хорих, эрх чөлөөг нь хасах байдлаар илэрч байна. Хэрэглэсэн зэвсэг хэрэгслийн хувьд цахилгаан болон резин бороохой, галт зэвсэг (гар буу), нулимс асгаруулагч, гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл, төрийн тусгай албаны байр, хорих саатуулах өрөөг ашиглажээ.

Сэтгэл санааг шаналган зовоох хэлбэр

Сэтгэл санааг шаналган зовоох эрүү шүүлт нь хүйтэнд нүцгэн гадаа зогсоох, айдас хүргэхүйц орчинд хүлээлгэх, тодорхойгүй байдал үүсгэх, эд эрхтнийг нь гэмтээнэ, шатаана, өөр хэргийг чинь ил гаргана, цагдан хорино, цагдан хорих хугацааг сунгана, хорих ял эдлүүлнэ, гэр бүлд чинь хохирол учруулна гэх мэтээр айлган сүрдүүлэх, гэмт хэрэг үйлдсэн мэтээр нотлох баримтын эх сурвалж болгож баримтжуулах, болзол тавих, бусдыг гүтгүүлэхээр санал тавих, шаардлага хангахгүй өрөөнд хорих, усанд оруулахгүй байх, эргэлт уулзалт оруулахгүй байх, мал амьтан мэтээр харьцаж, дуурайлгаж тохуурхах, чихэнд чийртэй дуу авиа гаргах зэрэг хэлбэрээр илэрч байна.

⁸ Мөн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт.

⁹ Мөн хуулийн 11.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт.

¹⁰ Мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

¹¹ Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/6641 дугаартай албан бичиг.

¹² Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан.

¹³ Комиссын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/1492 дугаартай албан бичгээр УИХ-ын ХЗБХ-нд хүргүүлсэн дүгнэлт.

Шүүхээр 2024 онд шийдвэрлэгдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн үйлдлийн арга, илрэх хэлбэрийг авч үзвэл хэрэг хүлээлгэх зорилгоор зодож эрх чөлөөнд халдсан, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан, саатуулах байранд хорьсон, хэл амаар доромжилж хүнлэг бус байдлаар харьцсан нь тогтоогджээ.¹⁴

Комисст эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанд өртсөн талаар 2023 онд 60, 2024 онд 48 нийт 108 гомдол, мэдээлэл ирснийг хуульд заасны дагуу шалгах ажиллагаа явуулахад 24 гомдол буюу 22.2 хувьд нь мэдүүлэг авах үед албадах, хоол унд, ус өгөхгүй байх, тодорхойгүй байдлаар удаан хугацаанд хүлээлгэх, 23 буюу 21.3 хувьд нь цагдан хорино, гэр бүлийн хүмүүсийг нь хорино гэх зэргээр айлган сүрдүүлсэн, 13 буюу 12 хувьд нь хэл амаар доромжлон, нэр төрийг гутаах, 37 буюу 34.3 хувьд нь бие махбодод халдсан, 11 буюу 10.2 хувьд нь гэр бүл, бусад хүмүүсийн дэргэд айлган сүрдүүлсэн, нөлөөлсөн гэжээ.

Хүснэгт 6.1. Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанд өртсөн талаар ирүүлсэн гомдол (2023, 2024 он)

№	Холбогдох албан тушаалтан	Гомдлын тоо
1	Цагдаа	55
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагч	45
3	Прокурор	4
4	Авлигатай тэмцэх газрын мөрдөгч	3
5	Шүүгч	1
	Нийт	108

Тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байж болзошгүй 34 гомдлыг Авлигатай тэмцэх газарт, 3 гомдлыг Цагдаагийн ерөнхий газар (цаашид ЦЕГ гэх)-т шилжүүлэн шийдвэрлэсэн. Дээрх нөхцөл байдлаас үзэхэд, эрүү шүүлтэд өртсөн талаар ирүүлж байгаа гомдол мэдээлэл, шүүхээс эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн үйлдлийн арга, сэдэл нийтлэг байгаа ба нотлох баримтаас илүү мэдүүлэгт тулгуурласан мөрдөн шалгах ажиллагаа явуулах хандлагад бодитой өөрчлөлт гарахгүй байгааг харуулж байна.

Хариуцлага хүлээсэн байдал

Шүүх 2017-2024 оны хугацаанд нийт 33 хүнд холбогдох 16 хэргийг хянан шийдвэрлэж эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт цагдаагийн байгууллагын 24, тагнуулын байгууллагын 5, Авлигатай тэмцэх газрын 2, прокурор 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1 алба хаагч, олон нийтийн цагдаа 1 (иргэн) хүнд тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн ба үүнээс 23 хүнд торгох ял, 6 хүнд хорих ял оногдуулж, 1 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 3 хүнийг өршөөлийн хуульд хамруулж шийдвэрлэсэн байна.¹⁵ Эрүүгийн хариуцлага хүлээсэн байдлаас үзэхэд, эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт хүлээлгэх ялын бодлого сул, ихэнх тохиолдолд торгох, нийтийн албанд ажиллах эрхийг хасах, зарим тохиолдолд өршөөл үзүүлэн суллаж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөл

Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт холбогдсон төрийн алба хаагчдын 69.6 хувийг цагдаа, 15 хувийг тагнуулын байгууллагын ажилтан эзэлж байгаа бол насны хувьд 23-27 настай албан хаагч 14 буюу 42.4 хувийг эзэлж байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд ихэвчлэн камерын хяналтгүй орчинд, удирдах албан тушаалтны хяналт суларсан, хот суурин газраас алслагдсан газарт бие даан үйл ажиллагаа явуулж байхдаа үйлдсэн, ажлын ачаалал, стресс зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн бол зарим тохиолдолд удирдах албан тушаалтны хууль бус үүрэг даалгавар, хариуцлага хүлээхгүй, эрүүдэн шүүсэн нь илрэхгүй гэсэн итгэл үнэмшил нөлөөлжээ. Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллагууд бие биеэ шалгах зохицуулалт үйлчилж байгаа, ялын бодлого сул, мөрдөгч, прокурор, шүүгч,

¹⁴ Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/-ийн 2024/ШЦТ/154 дугаартай шийтгэх тогтоол.

Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/-ийн 2024/ШЦТ/263 дугаартай шийтгэх тогтоол.

¹⁵ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан.

хорих байгууллагын алба хаагчдын энэ талаарх мэдлэг хандлага сул, мөрдөн байцаах, нотлох ажиллагааны арга барил дутмаг байгаатай холбоотой юм.

Хорих анги, цагдан хорих байран дахь хүнлэг бус харьцаа

Хорих байгууллага, цагдан хорих байр, албадан саатуулах байранд хүн (хоригдол, хоригдогч) нас барсан тохиолдол 2022 онд 6, 2023 онд 4, 2024 онд 7, хүний эрүүл мэнд хохирсон тохиолдол 2022 онд 12, 2023 онд 20, 2024 онд 18 бүртгэгдэж хуулийн дагуу шалгах ажиллагаа явуулжээ.¹⁶ (Тайлбар: Эрх чөлөөгөө хасуулсан хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах үүргийг төр хүлээдэг бөгөөд энд дурдсан тоон мэдээлэл бүгд эрүү шүүлт, хүнлэг бус харьцаатай холбоогүй болно).

Хорих анги, цагдан хорих байранд гэмт хэрэг хүлээлгэхээр албадах, дарамт шахалт үзүүлэх байдлаар эрүүдэн шүүсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж, 2017 онд дээд шүүх эцэслэн шийдвэрлэсэн.

Комисст 2024 онд нийт 1311 гомдол, мэдээлэл ирснээс 360 нь буюу 27.5 хувь нь хорих анги, цагдан хорих байранд хоригдож байгаа хүнээс ирсэн. Үүний 33 гомдол, мэдээлэл буюу 9.2 хувь нь халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудлаар хандсан.

Хүний эрх чөлөөнд халдах, хүнлэг бус хэрцгий харьцах явдал хорих анги, цагдан хорих байранд удаа дараа гарч байгаа ба Комисс гомдлын мөрөөр шалгах ажиллагаа явуулж, холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэж байна.

Тохиолдол 6.1

...хоригдол Н.Б-г 2024 оны 05 дугаар сард зодож гэмтээсэн талаар Комисст мэдээлэл авагдаж, шалгах ажиллагаа хийж, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн холбогдох байгууллагад шилжүүлэв.

“...хорих ангийн эрүүгийн ахлах төлөөлөгч миний нөхөр М.Ц-г гар утас нууцаар ашигласан зөрчлөөр 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр биед нь маш ноцтойгоор гар хүрч, ар гэрийнхэнтэйгээ уулзахыг хориглож, сахилгын байранд хийж, нуун дарагдуулж, эмчийн үзлэгт хамруулаагүй, сэтгэл санааны хүнд нөхцөлд байлгаж байна”

(Комиссын 2024 онд шийдвэрлэсэн гомдлын хэсгээс)

Албаны мэдээллээс үзэхэд ШШГЕГ-аас дотоод хяналт шалгалтын хүрээнд хорих ангид гарч байгаа хүний эрхийн зөрчлийг таслан зогсоож, хариуцлага тооцож ажилласан байна. Тухайлбал 2024 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн 9, хоригдолтой хувийн харьцаа тогтоосон 5, хоригдлын дундаас бусдыг дарамталж, эд зүйл булаасан 3, хориотой эд зүйл хадгалсан, хэрэглэсэн 8, бусад хоригдлыг гутаан доромжилсон, нэр төрд халдсан 37, алба хаагчтай хувийн харилцаа тогтоосон 1, өөрийн биед гэмтэл учруулсан 2, хориотой тоглоом тоглосон 3, бусдын биед халдсан 13, хоригдолтой маргалдаж, зодолдсон 40, нийт 121 зөрчил үйлдэгдсэн байна.

Комисс 2022 онд хорих ангид ял эдэлж байсан 1142 хоригдлоос авсан санал асуулгад “алба хаагчдын зүгээс хүнлэг бус, нэр төрийг нь доромжлон харьцаж байсан” гэж 22.5 хувь нь хариулж байсан бол 2024 онд 274 хоригдлоос авсан санал асуулгад 27 хувь нь мөн “тийм” гэж хариулсан нь 4.5 хувиар өссөн байна. Үүнээс үзэхэд энэ төрлийн зөрчил хорих анги, цагдан хорих байранд буурахгүй байгааг илтгэж байна.

Цэргийн анги, байгууллага дахь дүрмийн бус харьцаа

Цэргийн анги байгууллагын байрлалд цэргийн алба хаагч, хүний нас хохирсон тохиолдол 2022 онд 2, 2023 онд 7, 2024 онд 1, хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд 2022 онд 9, 2023 онд 8, 2024 онд 9 бүртгэгджээ. Эдгээр тоо баримт нь бүгд

¹⁶ Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/6641 дугаартай албан бичиг.

хугацаат цэргийн алба хаагч хохирсон үзүүлэлт биш боловч цэргийн ангийн байрлалд үйлдэгдэж байгаагаар анхаарал татаж байгаа юм.¹⁷

Зэвсэгт хүчний жанжин штабын мэдээлэлд 2021 оноос 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 5 хугацаат цэргийн алба хаагч амь насаа алдсан, 16 офицер ахлагч, 13 хугацаат цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна. Үүний шалтгаан нөхцөлийг дүрмийн бус харьцааны зөрчил, эрүүл мэнд суурь өвчний улмаас, ар гэр, найз нөхдийн хүрээнд үүссэн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй, цэргийн албанаас шантарч өөрийн биед санаатай гэмтэл учруулсан гэж үзжээ.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2023 оны 06 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 14 цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирсон байна.

Тохиолдол 6.2

Хилийн цэргийн ... дугаар ангийн ... авто замын боомтын ... дугаар салбарын Харуулын дарга, нохой хөтлөгч албан тушаалтай дэд ахлагч Т.О нь 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байлдагч Б... нарын 6 хугацаат цэргийн алба хаагчийг тус салбарын Соёл амралтын өрөөнд жагсаан зогсоож элсэн тус газар нь цохих, давтамжтай сунгалгах, цэргийн дүрэмд заагдаагүй үг хэллэг хэрэглэж сүрдүүлэх, цэргийн цагийн хуваарийг зөрчих байдлаар дүрмийн бус харьцаж, эрх чөлөөнд нь халдсан байна.

(Комиссын гишүүний Хил хамгаалах ерөнхий газрын даргад 2024 онд хүргүүлсэн 06/22 дугаар шаардлагаас)

Цагдаагийн ерөнхий газрын харьяа ... ангийн хугацаат цэргийн алба хаагчид 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ангийн байрлалаас гадна ажил хөдөлмөр эрхэлж байх үед 1 цэргийн алба хаагч зам тээврийн осолд өртөж амь насаа алдсан.

(Комиссын гишүүний Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2024 онд хүргүүлсэн 07/20 дугаар шаардлагаас)

Цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цэргийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, УИХ-ын 2022 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Мөрдөн шалгах чадавхыг бэхжүүлэх

а. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах чадавхыг бэхжүүлэх

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан нэгжийг байгуулах асуудал шийдвэрлэгдэхгүй байгаад Комисс шүүмжлэлттэй хандаж байна. Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (цаашид ЭХХШТХ гэх) 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий прокурор 2024 онд “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” журмыг баталсан.¹⁸

Энэхүү журмаар Цагдаа, Тагнуулын байгууллагын алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг ЦЕГ-ын Мөрдөн байцаах алба мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар тус тус харьяалал тогтоосон нь оновчтой шийдэл биш бөгөөд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан нэгнээ шалгах нөхцөлийг бүрдүүлсэн гэж дүгнэж байна. Дээрх байгууллагууд болон шүүхийн мэдээллээс үзэхэд эрүү шүүлт тулгах гэмт хэрэгтэй холбоотой гомдол мэдээлэл жилд дунджаар 55 орчим бүртгэгдэж, шүүхээр 2 хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж байна.

¹⁷ Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/6641 дугаартай албан бичиг.

¹⁸ Монгол Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаал.

УИХ-аас 2023 онд “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолыг баталж “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан бүтэц байгуулах асуудлыг судлан танилцуулах” үүргийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан боловч өнөөдрийг хүртэл бүрэн шийдвэрлээгүй байна. Төрийн тусгай албан хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах хараат бус байгууллагыг байгуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэхдээ дараах хэдэн зүйлийг анхаарах нь үр нөлөөтэй юм. Үүнд: 1) мөрдөн шалгах мэргэшсэн байдлыг харгалзах; 2) хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэх хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлыг хангах; 3) удирдлагын томилгоо, төсөв санхүүгийн бие даасан байдлыг хангах; 4) прокурорын хяналт, чадавхыг бэхжүүлэх, бие даасан байдлыг хангах зэргийг анхаарах нь зүйтэй.

6. Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн ажлын ачааллыг зохистой түвшинд хүргэх

Хэргийг аль болох богино хугацаанд мөрдөн шалгах, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчийн хөдөлмөрлөх эрхийг хангах зорилгоор мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын ачааллыг зохистой түвшинд хүргэх шаардлага тулгарч байна.

Цагдаагийн байгууллагаас мөрдөгчийн ажлын нормативыг тогтоох, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, иргэдийн зөрчигдсөн эрх сэргээгдэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэх зэрэг удирдлага, зохион байгуулалтын олон талт ажил, арга хэмжээг явуулсан хэдий ч цагдаагийн байгууллагын гэмт хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн 2025 оны 03 дугаар сарын байдлаар нэг мөрдөгч дунджаар нийслэлд 14.9, орон нутагт 9.3 гомдол, нийслэлд 82.4 хэрэгт, орон нутагт 23.5 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.¹⁹

Цагдаагийн байгууллага Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 110 гаруй хууль, 153 эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж, хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийн хүрээнд Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 20 бүлэг 213 зүйл 446 хэсэгт заасан гэмт хэргүүдээс Тагнуулын байгууллагад шууд харьяалал тогтоосон 31 зүйл, 1 хэсэг, өөрсдөө илрүүлсэн 4 зүйл, 1 хэсэгт, Авлигатай тэмцэх газарт шууд харьяалал тогтоосон 11 зүйл, өөрсдөө илрүүлсэн 1 зүйлд, Цагдаагийн байгууллага 171 зүйл, 366 хэсэгт тус тус мөрдөн шалгах ажиллагааг явуулж байна.

Мөн судалгаагаар Тагнуулын ерөнхий газрын мөрдөгч, Авлигатай тэмцэх газрын мөрдөгчөөс цагдаагийн байгууллагын мөрдөгчийн цалин хөлс харьцангуй доогуур, ажлын ачаалал хоёр дахин өндөр байгаа бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэн ажилладаг байгууллагуудын хувьд харилцан адилгүй цалин хөлс, нийгмийн баталгаагаар хангагдаж байна.

Сүүлийн жилүүдэд ихээр бүртгэгдэж буй залилах, эдийн засаг, цахим зэрэг гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хэргийн хамрах хүрээ өргөн, олон үйлдэлтэй, дахин давтан үйлдэгдэх, мөрдөгч нарт эдийн засгийн болон техник, технологийн мэдлэг шаардагдах, шинжилгээний багаж, тоног төхөөрөмж, программ хангамжийн хүртээмж хязгаарлагдмал, хүний нөөцийн хомсдол, эрх зүйн орчин, цагдаагийн байгууллагад итгэх иргэдийн итгэл сулрах зэрэг нөхцөл байдлын улмаас мөрдөн шалгах ажиллагааг богино хугацаанд явуулахад хүндрэл учирч байна.

Эрх зүйн орчны хувьд алба хаагч нарт зохиомол ачаалал үүсгэж байгаа өмнө хуульд заасан зарим зохицуулалт тухайлбал эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг түр хугацаанд түдгэлзүүлэх зохицуулалт байхгүй болсон, мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай оролцогчийг мөрдөгчийн дуудах хуудсаар дуудан ирүүлэх хөшүүрэг байхгүй болсон зэрэг шуурхай байдлыг хангах, хохирсон иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд эрх зүйн орчны

¹⁹ Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 04/97 дугаартай албан бичиг. 235

дутагдалтай байдал үүсэж байгаа талаар цагдаагийн байгууллагаас гаргаж байгаа саналыг анхаарах нь зүйтэй.

Комисс Нийслэлийн 6 дүүргийн 8 цагдаагийн газар, хэлтэст ажиллаж байгаа мөрдөгчдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас үзэхэд аймаг, орон нутагтай харьцуулбал хэргийн тоо их, ажлын ачаалал өндөр, илүү цагаар ажиллах, нийтээр тэмдэглэдэг баяр ёслол, амралтын өдрүүдээр эргүүлд гардаг, хоногийн жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн ч маргааш нь буудаггүй, үргэлжлүүлэн ажилладаг, хувийн тээврийн хэрэгсэл, шатахуунаар албаны ажлыг хийдэг, эргэж ямар нэг байдлаар нөхөж өгдөг зүйл байхгүй. Хувийн гар утсаараа хэргийн оролцогч нартай холбогддог, оролцогч нарын зүгээс хувийн гар утас руу ажлын цаг харгалзахгүй залгадаг, утсаа аваагүй тохиолдолд алба хаагчдад гомдол гаргадаг. Гэр бүл, үр хүүхдэдээ зарцуулах цаг гардаггүйгээс гэр бүлийн харилцаанд зөрчилдөөн үүсдэг, хэргийн хугацаа сунгах, зөвшөөрөл авах шаардлагаар прокурор болон бусад байгууллагаар явахад цаг их зарцуулдаг, үүнтэй холбоотойгоор ажлын цаг дууссаны дараа ажилладаг талаар нийтлэг дурдаж байлаа.

Тиймээс нэг мөрдөгч, прокурорт ноогдох гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн тоог үндэслэлтэйгээр тооцож, хүний нөөцийг нэмэгдүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байх нь зүйтэй.

6.3. МЭДҮҮЛЭГ АВАХ ҮЕИЙН ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад (*цаашид ИБУТЭТОУП гэх*) “Хүн бүр... өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй байх... наад захын баталгаагаар хангагдах эрхтэй”²⁰, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн... өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх... Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно”, ЭХХШТХ-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно”,²¹ “Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно”,²² “Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна”²³ гэж тус тус заасан нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулсан хэм хэмжээ юм.

Мэдүүлэгт суурилсан нотлох ажиллагааны арга барил хэвээр байгаа нь эрүү шүүлт тулгах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Мэдүүлэг тайлбар авах үед гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүнээс гэм буруугаа өөрөө нотлохыг шаардах, мэдүүлэг авахаар албадах, камерын хяналтгүй, зориулалтын бус өрөө тасалгаанд мэдүүлэг авах, албан ёсны мэдүүлэг өгөхөөс өмнө өмгөөлөгчгүйгээр уулзалт ярилцлага хийх, гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхийг тулгах хандлага гарсаар байна. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт өртсөн талаар Комисст ирүүлсэн гомдол мэдээлэл, шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг, мөрдөн шалгах байгууллагаас ирүүлж байгаа мэдээллээс үзэхэд мэдүүлэг авахаар албадах үйлдлийг ихэвчлэн камерын хяналтгүй орчинд, мэдүүлэг авах зориулалтын бус газар үйлдэгдсэн талаар дурджээ.

Тухайлбал 2016-2024 оны хооронд эрүү шүүлт тулгах 16 гэмт хэргийг гурван шатны шүүхээр шийдвэрлэсний 9 нь буюу 56 хувь нь цагдаагийн байгууллагын камерын хяналтгүй өрөө тасалгаанд, 2 буюу 12.5 хувь нь ариун цэврийн өрөөнд үйлдэгдсэн байна. Мөн шүүхээс

²⁰ ИБУТЭТОУП, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг (г).

²¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

²² Мөн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

²³ Мөн хуулийн 25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

2024 онд 2 хэргийг шийдсэн байх бөгөөд үйлдлийн аргын хувьд мэдүүлэг авахаар албадаж, хүч хэрэглэж бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон шинжтэй байна.²⁴

Комисст 2023, 2024 онд ирүүлсэн гомдол мэдээллийн агуулгаас үзэхэд 14 буюу 25.5 хувь нь ажлын байранд мэдүүлэг авах үед, 10 буюу 18.8 хувь нь саатуулах, нэгжлэг хийх явцад, 4 буюу 7.3 хувь нь таньж олуулах ажиллагааны явцад мэдүүлэг өгөх албадлагад өртсөн талаараа дурдсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчтай холбоотой гомдлын 31 нь буюу 68.9 хувь нь хорих болон цагдан хорих байрны камерын хяналтгүй орчинд үйлдэгдсэн гэжээ.

Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд хэргийн оролцогч, шаардлагатай гэрч, хохирогч нараас амралтын өдөр, шөнийн цагаар мэдүүлэг авахыг хуулиар хориглоогүй боловч хуульд заасан хойшлуулшгүй тохиолдол үүсээгүй байхад амралтын өдөр, шөнийн цагаар мэдүүлэг авахаар дуудах, энэ тухайгаа холбоо барих боломжгүй байсан гэх шалтгаанаар гэр бүлийн гишүүдээр дамжуулж мэдэгдэх зэргээр таагүй нөхцөл байдал үүсгэх асуудал гарсан.

Хүүхэд, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсээс мэдүүлэг, тайлбар авах талаар цагдаагийн байгууллагаас тодорхой хэмжээнд анхаарч сургалт, дохионы хэлний хэлмэрч бэлтгэж байгаа ч анхаарал татсан хэд хэдэн тохиолдол гарсан. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн хохирогчийн эмзэг мэдээлэл агуулсан мэдүүлгийг авахдаа төрсөн хүүхдээр нь хэлмэрчлүүлсэн, өөрөө хэлмэрчээ авчирч тайлбар өгөхийг шаардсан тохиолдол гарсан. (Хүүхдээс мэдүүлэг авахтай холбоотой асуудлыг Илтгэлийн V бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү).

Мэдүүлэг авах өрөөнд тавигдаж буй шаардлага нь гэрч, хохирогч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, таньж олуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хамгаалах зорилготой юм.

Тиймээс ЭХХШТХ-ийн 25.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна”, мөн зүйлийн 17 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг Улсын ерөнхий прокурор батална” гэж заасан. Улсын ерөнхий прокурорын 2017 онд баталсан “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”²⁵-ын 3.14 дэх хэсэгт “Мэдүүлэг авах ажиллагаанд ашиглагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг тухай бүр нь хуулбарлан авах, хадгалах боломжтой төхөөрөмжийг ашиглах бөгөөд бичлэгийг засварлах, устгах зэрэг эрсдэлээс бүрэн хамгаалсан байна” гэж заасан.

Улсын хэмжээнд мэдүүлэг авах шаардлага хангасан буюу прокурор зөвшөөрөл олгосон нийт 565 өрөө байгаагаас 482 нь буюу 85.3 хувь нь дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх төхөөрөмж буюу хяналтын камераар тоноглогдсон байна.²⁶

Хүснэгт 6.2 Улсын хэмжээнд байгаа шаардлага хангасан мэдүүлэг авах өрөө

№	Байгууллага	Өрөөний тоо	Хувь
1	Цагдаагийн алба, газар, хэлтэс	350	62
2	Хэсгийн төлөөлөгч	134	23.7
3	Цагдан хорих төв	36	6.4
4	Тагнуулын байгууллага	26	4.6
5	Авлигатай тэмцэх газар	17	3
6	Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	2	0.3
	Нийт	565	100

²⁴ Говь-Алтай аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/-ийн 2024/ШЦТ/154 дугаартай шийтгэх тогтоол.

Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /эрүүгийн хэрэг/-ийн 2024/ШЦТ/263 дугаартай шийтгэх тогтоол.

²⁵ Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/57 дугаар тушаалаар.

²⁶ Улсын ерөнхий прокурорын газрын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/6641 дугаартай албан бичиг.

Комисс иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэлд үндэслэн 2024 оны 05 дугаар сараас эхлэн Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (цаашид ШШГЕГ гэх)-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Багануур, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар, Говьсүмбэр, Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Булган аймгууд дахь 21 цагдаагийн газар, хэлтэс нэгжийн 109 уулзалт, мэдүүлэг авах өрөөний орчин нөхцөл, техник хэрэгслийн хүртээмж, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Авлигатай тэмцэх газар, ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид байрлах мэдүүлэг, уулзалтын өрөөнүүдийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулж, хэвийн үйл ажиллагаа явуулж байсан бол цагдаагийн газар, хэлтсүүдийн хэмжээнд мэдүүлэг авах өрөөг шинэчлэх зорилгоор засвар тохижилтын ажлыг эхлүүлсэн байдалтай байсан.

Хяналт шалгалтын үр дүнгээс үзэхэд уулзалт хийх, мэдүүлэг авахад зориулж тусгайлан бэлтгэсэн өрөөний хүрэлцээ муу, камерын хяналт хангалтгүй, камерын дүрс бичлэгийг хадгалах, хамгаалах, хуулбарлан авахад тохиромжтой байдлаар тоноглоогүй, прокуророос мөрдөгч нарын албан өрөөнд мэдүүлэг авах зөвшөөрөл олгосон байдал түгээмэл байна. Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, нэгжүүдийн хэмжээнд өрөө тасалгааны хүрэлцээгүй байдлаас шалтгаалан насанд хүрсэн хүнээс мэдүүлэг, тайлбар авах ажиллагааг ихэнх тохиолдолд мөрдөгч, байцаагч нар өөрийн албан өрөөндөө гүйцэтгэж байсан. Ихэнх цагдаагийн газар, хэлтсүүд “Эрүүгийн цагдаагийн албаны тасаг” гэсэн нууц кодоор нэвтрэн орох тусгай хаалт бүхий хэсгийг бэлтгэсэн байх боловч, түүнийг нийтийн эзэмшлийн хяналтын камераар хянах боломжтой, харин тухайлсан өрөө тасалгаануудад хяналтын камер суурилуулаагүй байдалтай байна.

Хэдийгээр мэдүүлэг авах өрөөнд дүрс бичлэгийн хяналтын камер суурилуулсан боловч эрүү шүүлт явагдсан эсэхийг хянах зорилгоор бичлэгийг гаргуулан авах үед бичлэг гаргаж өгөх боломжгүй, цахилгааны саатал, гэмтэл учирсан гэх шалтгааныг түгээмэл дурдаж, шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөхгүй, камерын хяналтын бичлэгийг бүрэн үзүүлэхгүй байх тохиолдол Комисст тулгарч байсныг дурдах нь зүйтэй.

Тохиолдол 6.3

“...Цагдаагийн хэлтсийн мэдүүлэг авах өрөөний камерын бичлэгийг гаргуулан авахаар очих үед хэргийн газрын үзлэгээр хяналтын камерын чиглэлийг зориуд өөрчилсөн, эрүүгийн мөрдөгчид суух өрөөнд дүрс бичлэгийн камер байршуулаагүй, хэлтсийн дотоод орчныг хянах хяналтын камерууд бүрэн ажиллагаагүй байна. Энэ нөхцөл байдал нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн, гэмт хэрэгт сэрдэгдэн шалгагдаж буй этгээдэд эрүү шүүлт тулгах, түүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг хийх орчныг бүрдүүлсэн, ...”

(Авлигатай тэмцэх газраас 2024 онд Комисст ирүүлсэн арга хэмжээ авуулах тухай албан бичгээс)²⁷

Комисс тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЦЕГ-ын даргад улсын хэмжээнд цагдаагийн газар, хэлтэс, Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид ашиглаж байгаа мэдүүлэг авах тусгайлан бэлтгэсэн өрөөнд үзлэг хийх; мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг бүрэн хангуулах; мэдүүлэг авах өрөөг бүрэн камержуулж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх; бичлэгийг тухай бүр нь хуулбарлан авах, хадгалах; бичлэгийг засварлах, устгах эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах; цахилгааны гэмтэл, саатал гарах, тог тасрах үед мөрдөн шалгах ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, боломжийг хангах үүднээс нэмэлт цахилгааны эх үүсгүүр, тог баригч суурилуулах; цаашид цахилгааны саатал гарсан гэх шалтгаанаар баримт ирүүлэхгүй байх явдлыг таслан зогсоох талаар Комиссын гишүүний зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан.²⁸

²⁷ Авлигатай тэмцэх газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 06/2846 дугаартай албан бичиг. Мөн газрын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 06/12888 дугаартай албан бичиг.

²⁸ Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06/43 дугаар зөвлөмж.

Комисст ирүүлсэн мэдээлэл, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгасан баримтаас үзвэл 2025 оны 02 дугаар сарын байдлаар мэдүүлэг, уулзалтын өрөөнүүдийг бүрэн ашиглалтад оруулж, уулзалт, мэдүүлгийг зориулалтын өрөөнд явуулж хэвшсэн нь сайшаалтай байна.

Улсын хэмжээнд мэдүүлэг авах нийт 844 өрөөг камерын хяналт буюу дуу-дүрсний бичлэг хийх, хадгалах, хуулах төхөөрөмжөөр тоноглон, зөвшөөрлийг авч тухайн нэгжийн Эрүүгийн цагдаагийн болон Мөрдөн байцаах тасгийн дарга, Прокурорын байгууллагаас тогтмол хяналт тавьж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн талаар дурджээ.

Харин мэдүүлэг, уулзалтын өрөөг шинээр стандартад нийцүүлэн тохижуулсантай холбоотойгоор мөрдөгч нарын албан өрөөг заалны зохион байгуулалтад оруулсан нь ажлын бүтээмж, ажиллах орчин нөхцөлд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байгааг анхаарч шийдвэрлэх нь зүйтэй.

Цаашид уулзалт, мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг хүний эрхийн зарчимд нийцүүлэн шинэчлэн батлах, хяналтын камераар бүрэн тоноглох зохицуулалтыг тусгах, зориулалтын өрөөнд уулзалт, мэдүүлэг авах ажиллагааг явуулж хэвших, мэдүүлэг авах үед иргэдэд өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, дуугүй байх, хэлмэрч орчуулагч авах эрхийг нь сайтар тайлбарлан ойлгуулах байдлаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төлөвшүүлэх шаардлагатай.

6.4. ӨМГӨӨЛӨЛ, ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХ

ИБУТЭТОУП-д “Хүн бүр... хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх... баталгаагаар хангагдах эрхтэй”,²⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын иргэн... олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэж тус тус заасан нь хүн өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан хэм хэмжээ юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэтгэлцэх зарчмыг бодитоор хэрэгжүүлэх, оролцогчдын өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, өмгөөлөгчдийн үйл ажиллагааны баталгааг бүрдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлсэн нь сайшаалтай. Гэвч 2024 онд Комисс болон НҮБ-ын хүний эрхийн тусгай механизмуудаас гаргасан судалгаа, дүгнэлтүүдэд өмгөөллийн үйл ажиллагаа явуулах, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхтэй холбоотой олон бэрхшээлийг онцолж байгаа нь Монгол Улсад хэргээ шударгаар шүүлгэх эрхийн баталгаа бүрэн хангагдаагүй болохыг илэрхийлж байна.

ЭХХШТХ-д 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулж УИХ-аас 18 дугаар тогтоолыг баталсан.³⁰ Тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газраас ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын даргад өргөн барьсан.³¹

Хуулийн төсөлд гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдвол мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг хуульд заасны дагуу явуулах, мэдүүлэг авах ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулахгүй байх, хууль бусаар хэрэг хүлээлгэх, өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгүүлэхээр албадахгүй байх, өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх

²⁹ ИБУТЭТОУП, 14 дүгээр зүйл 3 дахь хэсэг (d).

³⁰ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоол.

³¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл өргөн мэдүүлэв. <https://www.parliament.mn/nn/63771/>.

ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулах, хүний халдашгүй байх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хүрээнд мөрдөн байцаалтыг өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр явуулахгүй байх, хэрвээ өмгөөлөгчийг байлцуулахгүйгээр мөрдөн байцаалт явуулж нотлох баримт цуглуулсан, хэрэг хүлээлгэсэн тохиолдолд тухайн мэдүүлэг, нотлох баримтыг үнэлэхгүй байх, шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа хойшлуулахгүй байх зэрэг эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх тодорхой заалтуудыг тусгажээ.³²

Монгол Улсад 2025 оны 01 дүгээр сарын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 250 гаруй өмгөөллийн хуулийн этгээд, 2238 өмгөөлөгч байна.³³ Комиссоос 2024 онд Улаанбаатар болон орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, түүвэр судалгааны дүнгээс үзэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх бүрэн хангагдахгүй байгаа нь илэрсэн³⁴ бөгөөд бусад байгууллагын ижил төрлийн судалгааны дүгнэлттэй таарч байгааг анхаарах шаардлагатай.³⁵

Тохиолдол 6.4

...Сэжигтэн ямар хэрэгт сэжиглэгдэж, яллагдаж, шалгагдаж байгаагаа мэдэх эрхтэй боловч практикт бүрэн хэрэгжихгүй байна. Жишээ нь “Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоол” дунджаар 3-10 хуудас байдаг, үүнийг хуулбарлаж өгдөггүй, ЭХХША-г эрхлэн явуулж буй субъектээс зөвхөн уншаад танилцах чиглэл өгдөг. Зарим хүн бүрэн уншаад ойлгоогүй байдаг...;

...Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалахаар гаргасан хүсэлт, гомдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй субъектээс хэтэрхий ерөнхий хариу өгдөг, ойлгомжгүй байдлаар тайлбарладаг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна гэдгээр шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгөх байдал нийтлэг практик болж тогтсон. Ер нь хүсэлт гомдлын шийдвэрлэлт 30 хувьтай байгаа...;

...Мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн материалтай танилцах хугацааг мөрдөгч, прокурор шийдвэрлэдэг. Тэдний заасан газар, заасан хугацаанд багтааж хэргийн материалтай танилцах болдог. Хэргийн материалыг хуулбарлан авахыг зөвшөөрдөггүй тул гараараа хурдан хуулж авдаг, заримдаа бүрэн мэдээллээ авч чадахгүй шүүх хуралд ордог...;

...Өмгөөлөгч буюу өмгөөлөх тал нотлох баримтыг цуглуулах эрх эдэлдэггүй, үүнээс шалтгаалан хууль зүйн туслалцааг хангалттай үзүүлж чаддаггүй, өмгөөлөгч өөрийн санал, дүгнэлтээ шүүх, /шүүгч/-д шууд хүргэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй...;

...Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд мэтгэлцэх зарчим үйлчилдэг байх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлага бодитоор үүссэн...;

...Шүүхээс өмнөх мөрдөн байцаалтын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байдаг. Харин өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал шинжтэй байгаагаас хүний эрхийн зөрчил, маргаан цөөнгүй дагуулж байна. Энэ тогтолцоо, системийн сөрөг, дутагдалтай талыг засах шаардлага бий болсон нь үнэн...

(Комиссоос өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, судалгаанд оролцогчдын ярилцлагаас)

Комисст 2023, 2024 онд өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөллийн үйл ажиллагааны баталгаатай холбоотой нийт 96 гомдол ирснийг шалгах ажиллагаа явуулж шийдвэрлэсэн.

Хүснэгт 6.3 Комисст ирүүлсэн гомдлын эрхийн төрөл, тоо (2023, 2024 он)

№	Эрхийн төрөл	Гомдлын тоо
1	Халдашгүй чөлөөтэй байх эрх	42
2	Шударга шүүхээр шүүлгэх эрх	28
3	Хөдөлмөрлөх эрх	6
4	Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрх	6
5	Хүүхдийн эрх	5
6	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	4

³² <https://d.parliament.mn/tusul/fb92408f-8af7-4aa3-b24c-26bf68e4e860>.
³³ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим хуудас. <https://umguulul.mn/about-us/introduction>
³⁴ Комиссоос өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2025 он.
³⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дах өмгөөлөгчийн оролцооны эрх зүйн асуудал судалгааны тайлан, УБ 2024 он, 39 дөх тал.

7	Үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрх	2
8	Мэдээлэл хүлээн авах түгээх, хайх эрх	1
9	Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх	1
10	Чөлөөтэй зорчих эрх	1
Нийт		96

Тохиолдол 6.5

...Хэрэгт холбогдогчид 3 жилийн дараа шүүхийн хэрэгсэхгүй болгосон тогтоолыг нь танилцуулсан тохиолдол байна. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоогүйгээр хэргийг шийдвэрлэдэг, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянаж шалгах ажиллагаанд хууль тогтоомжоор олгогдсон эрхийн хүрээнд оролцож чадахгүй байгаагийн тод жишээ. Энэ мэт жишээ нь иргэдийн шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилт ямар байгааг харуулж байна...

...Цагдан хоригдож буй хүнтэй уулзахаар хорих ангид очиход өмгөөлөгчийн хувийн мэдээллийг авч, бүртгэдэг, өмгөөлөгчийн хувийн байдал, өмнө нь өмгөөлж байсан хэрэг, шийдвэрийн талаар үйлчлүүлэгчид мэдээлж, сэтгэл санааг нь хямраадаг нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө, баталгаа зөрчигдөж байгаа хэлбэр мөн...

...Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй байх, хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхийг хэн нэгэн албан тушаалтны гаргасан дүрэм, журмаар хязгаарлаж, хууль зөрчих явдал газар авсан. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд өмгөөлөгчийн утас болон электрон хэрэгслүүдийг хураан авч, доторх мэдээллийг хуулбарлан авах, хуулиар баталгаажуулсан эрхийг хязгаарлаж, байгууллагын дотоод журам, даргын заавар, тушаал биелүүлж байгаа нэрээр хууль зөрчсөн үйлдэл газар авсан...;

(Комиссоос өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, судалгаанд оролцогчдын ярилцлагаас)

Томилолтын өмгөөлөгчийн үйл ажиллагаа

ЭХХШТХ-д 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр томилолтын өмгөөлөгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд³⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайд 2024 оны А/58 дугаартай тушаалаар “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журам”-ыг баталсан.³⁷

Батлагдсан журмыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зорилгоор 2024 оны 09 дүгээр сард алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад танилцуулж хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Монголын Өмгөөлөгчдийн Холбооны салбар зөвлөлүүдтэй хамтран журамд заасны дагуу өмгөөлөгч томилон ажиллуулах, мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагч нарын өмгөөлүүлэх эрхийг ханган ажиллахыг даалгасан байна.³⁸

Дээр дурдсан журмын дагуу өмгөөллийн үйл ажиллагааны хөлс, урамшууллыг Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасан “Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн хөлсний жишгээр тогтооно”, мөн журмын 4.5-д “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид томилсон өмгөөлөгчийн хөлсийг өмгөөлөгч томилсон мөрдөгч, прокурор, шүүгчийн харьяалах байгууллагын тухайн жилийн төсөвт тусган тухай бүр олгоно” гэж заажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд энэ журмын хэрэгжилтийг хангах, тайлбарлан таниулах шаардлага үүсэж байна.

³⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

³⁷ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” А/58 дугаар тушаал. ЗХХА-ын эмхэтгэл: 2024 он, №26.

³⁸ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 3/1476 дугаартай албан бичиг.

Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрх

Гэмт хэрэгт холбогдсон, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн цөөнгүй иргэд төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ баталгаатай эдэлж чадахгүй байна.

УИХ-аас эдгээр иргэдийн Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хангах зорилгоор цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж Хууль зүйн туслалцааны тухай хуулийг 2022 онд шинэчилсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд 2022 оны А/351 дүгээр тушаалаар “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”³⁹-ыг баталж, Хууль зүйн туслалцааны төвийн нийт 34 салбар (21 аймаг, нийслэлийн 8 дүүрэг, сум дундын шүүхтэй 5 сум)-аар дамжуулан төлбөрийн чадваргүй, зорилтот бүлгийн иргэдэд хуулиар харьяалуулсан хэрэг, маргаанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байна.⁴⁰

Тус төвд 2024 онд 2927 хэрэгт холбогдсон 3026 иргэнээс өмгөөллийн үйлчилгээ авах хүсэлт ирүүлснээс 1687 хэргийг шүүхээр, 159 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлэхэд оролцжээ.⁴¹

Хүснэгт 6.4 Хууль зүйн туслалцааны төвийн 2024 онд хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн эрх зүйн чиглэл

№	Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн эрх зүйн чиглэл	Хүний тоо
1	Эрүүгийн хэргийн чиглэлээр	8164
2	Иргэний эрх зүйн чиглэлээр	2245
3	Зөрчлийн хэргийн чиглэлээр	673
4	Захиргааны эрх зүйн чиглэлээр	416
Нийт		11498
1	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн	558
2	Хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг боловсруулсан	3153

Хууль зүй, дотоод хэргийн сайдын жил бүр аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулдаг хамтран ажиллах гэрээнд хуульд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ ажиллаж буй Улсын өмгөөлөгчийг стандартын шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах тухай заалтыг тусгасан байдаг ч бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байгаа нь “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Цөөнгүй Улсын өмгөөлөгч стандартад нийцсэн ажил, уулзалтын болон ариун цэврийн өрөөгүй, байрлаж буй барилга руу тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн ороход саадтай, иргэд очиход хүндрэлтэй, төвөөс алслагдмал байршилд байрладаг, тогтсон ажлын өрөөгүйгээс байнга нүүдэг зэрэг хүндрэл, бэрхшээлүүд тулгардаг байна. Мөн орон тоо дутуу байдгаас хувиараа өмгөөллийн үйл ажиллагаа явуулдаг өмгөөлөгчтэй харьцуулахад ажлын ачаалал 3-4 дахин их байна.

Тохиолдол 6.6

“...Улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал хувиараа өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа өмгөөлөгчөөс хэд дахин их, би 2018 онд төлбөрийн чадваргүй 84 хүнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байсан, олон хэрэг зэрэг өмгөөлөх нь тухайн өмгөөлөгчийн ажлын ачаалал ихсэхээс гадна өмгөөллийн үйлчилгээ авч байгаа иргэнд чанартай хууль зүйн туслалцаа үзүүлэх боломж хомс болдог, мөн хэргийн материалтай танилцах, шаардлагатай үнэлж болох нотлох баримт бүрдүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд үйлчлүүлэгчээ бүрэн дүүрэн төлөөлөх боломж бүрдэхгүй зэрэг хүндрэл бэрхшээл гарсаар байна...”

³⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 12 сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” А/351 дүгээр тушаал. ЗХХА-ын эмхэтгэл: 2022 он, №36

⁴⁰ Хууль зүйн туслалцааны төвийн 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 01/126 дугаартай албан бичиг.

⁴¹ Мөн тэнд.

...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хүний эрхийг зөрчих, өмгөөлөгчид хууль зүйн туслалцаа үзүүлэх процессын баталгааг эдлүүлэхгүй, хязгаарлах хандлага байсаар байна...;

...Гэрчээс мэдүүлэг авахдаа өмгөөлөгч авах эрхийг бүрэн тайлбарлаж өгдөггүй, зөвхөн худал мэдүүлэг өгөхгүй гэсэн маягт дээр гарын үсэг зуруулдаг. Эрх, үүргийг бүрэн тайлбарлаж өгөхгүй байна...;

...Амьдрал дээр хэрэг бүртгэлт эхлэх буюу мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгчгүй хэргийг мөрдөн шалгаж, хэрэг боосон хойно өмгөөлөгч ордог тохиолдол байна. Энэ нь сэжигтэн, яллагдагчийн өмгөөлөгчөөр хангагдах хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигддөг шалтгаан. Мөн хавтаст хэрэгтэй өмгөөлөгч танилцаж чадалгүй нууц явсаар шүүх дээр ирсэн хойно өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцдаг. Энэ үед аль хэдийн хэргийн материалыг “боосон” байдаг тул хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг шүүхэд танилцуулах боломжгүй болж, хуульд заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өмгөөлөгчөөр хангагдах, хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигдөж, тухайн хүний эрх зүйн байдал дорддог...

(Комиссын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 01/1166 дугаартай албан бичгээс)

Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хариуцан хэрэгжүүлэх⁴² чиг үүргийн хэрэгжилтийг бодитоор үнэлж, тооцдог байх, иргэдийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаатай эдлүүлэх, Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг олон нийт, мэргэжлийн байгууллагын алба хаагчдад сурталчлан таниулах, нэгдсэн ойлголтод хүргэх ажлыг зохион байгуулж, гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж ажиллах шаардлагатай байна. (Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны баталгааны талаар Илтгэлийн II бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү).

6.5. СЭТГЭЦИЙН ШИНЖИЛГЭЭ БА ХҮНИЙ ЭРХ

Монгол Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвараа алдсан нийт хүний дунд сэтгэцийн эмгэгтэй хүн 15 хувийг эзэлж байгаа ба өнөөдрийн байдлаар сэтгэцийн болон зан үйлийн эмгэгтэй 20,743 хүн бүртгэлтэй байна.⁴³ Монгол Улс дахь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээний сөрөг үр дагавраас шалтгаалан гэмт хэрэг үйлдэх эрсдэл нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд сэтгэцийн шинжилгээ хийх, түүний үр дүнг үнэлэх асуудал нэмэгдэх хандлагатай байна.

Мөрдөн шалгах, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх процессын зохицуулалтыг боловсронгуй болгох, зөвхөн шүүхийн шийдвэрээр энэхүү ажиллагааг хийх замаар хүний халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн баталгааг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Хүний сэтгэцийн байдлыг шинжилгээ хийж тогтоох асуудал Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан халдашгүй чөлөөтэй байх эрхийн хамгийн эмзэг асуудал бөгөөд дэлхийн улс орнуудын практикт сэтгэцийн шинжилгээ хийх ажиллагааг хүний эрхийн зарчимд нийцүүлэн явуулах асуудал анхаарлын төвд байсаар байна. Учир нь сэтгэцийн өвчин, эмгэг, өөрчлөлтүүд нь сэтгэл судлал, шүүх-сэтгэц эмгэг судлалын шинжлэх ухааны нарийн төвөгтэй ойлголтууд бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн эмгэгтэй байх нь хариуцлага хүлээлгэх эсхүл хүлээлгэхгүй байх гол шалгуур үзүүлэлт болдог.

ИБУТЭТОУП-ын 7 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй”⁴⁴, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэнд ч эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар нэр төрийг нь доромжлон

⁴² Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг.

⁴³ Сэтгэцийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр (2020-2024 он).

⁴⁴ Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталж, Монгол Улсад 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

харьцах буюу шийтгэхийг хориглоно. Ялангуяа, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй” гэж тус тус баталгаажуулжээ. Эдгээр зохицуулалт нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн, яллагдагчаар татагдсан хэнтэй ч мөрдөн шалгах ажиллагааны явцад хүнлэг бус харьцах, нэр төрийг нь доромжилж болохгүй⁴⁵ гэсэн санааг илэрхийлдэг бөгөөд хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хамгаалдаг.

Пактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. ...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй” гэж заасан бөгөөд хүний эрх хасах, албадан эмнэлэгт хэвтүүлэн шинжилгээ хийх асуудлыг зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр хийх шаардлага тавьдаг.

ЭХХШТХ-д хүний сэтгэцийн байдлыг тогтоох зорилгоор хийх шинжилгээний үндэслэл журмыг ойлгомжгүй хуульчилсан, шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах албан тушаалтныг давхардуулан тодорхойлсон, шинжилгээ хийх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй зэрэг давхардал хийдэл байна. Тухайлбал ЭХХШТХ-ийн 19.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т “прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь яллагдагчийн сэтгэцийн эрүүл мэндэд эргэлзэх үндэслэл байвал хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгох” үндэслэл болно, мөн зүйлийн 2-т “Энэ зүйлийн 1.2-т заасан тохиолдолд прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь хүсэлтээ шүүхэд гаргах бөгөөд шүүх үндэслэлтэй гэж үзвэл шинжилгээ хийлгэх шийдвэр гаргана” гэж заасан нь олон улсын хэм хэмжээнд нийцэх юм.

Харин ЭХХШТХ-ийн 27.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт дараах тохиолдолд заавал шинжилгээ хийлгэнэ:

- Гаднын нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;
- Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох;
- Гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- Бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай бичиг баримт байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох нь хэрэгт ач холбогдолтой байвал гэж заажээ.

Дээрх зохицуулалтаас үзэхэд “Гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох”, “Бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох” гэсэн үндэслэлүүд нь 19.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээс ялгагдах шинжгүй байна.

Хүний сэтгэцийн байдлыг тогтоох шинжилгээний ижил агуулга бүхий ажиллагааг хоёр ялгаатай зохицуулалтаар зохицуулсан бөгөөд прокурор, мөрдөгчийн шийдвэрээр эрүүгийн болон зөрчлийн хэрэгт шинжилгээ томилох явдал түгээмэл байна. Өөрөөр хэлбэл, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний сэтгэцийн байдлыг тогтоох шинжилгээг шүүхийн шийдвэрээр хийх тохиолдол маш цөөн байгаа нь халдашгүй чөлөөтэй байх эрхийг хөндөж байгаа онцгой хэлбэр юм.

СЭМҮТ шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагаагаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагдагч, шүүгдэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал эргэлзээтэй

⁴⁵ Улсын Дээд шүүх, Ханс-Зайделийн сан. “Эрүүгийн хуулийн тайлбар”. УБ., 2013. 12 дахь тал.

гэж үзсэн тохиолдолд тэдний сэтгэцийг шалгаж, хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоож байна.

Хүснэгт 6.5 Шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагаа, төрлөөр⁴⁶

№	Он	Эрүүгийн хэрэгт хамааралтай	Иргэний хэрэгт хамааралтай	Бусад
		Тоо/(%)	Тоо/(%)	Тоо/(%)
1	2018	1187/(97.5)	30/(2.5)	-
2	2019	1243/(97.6)	28/(2.2)	3/(0.2)
3	2020	1188/(96.4)	12/(0.9)	33/(2.7)
4	2021	985/(93.5)	21/(2.0)	47/(2.5)
5	2022	1172/(96.2)	26/(2.1)	20/(1.6)
Нийт		5775	117	103

Сүүлийн 5 жилийн байдлаар эрүүгийн нийт 5775 хэрэгт шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагаа гаргасан байна. 2022 онд 1172 магадлагаа гаргасан нь өмнөх оноос 187 магадлагаа буюу 18.9 хувиар өсчээ.

Бүдүүвч 6.1 Шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагаа хийсэн үзүүлэлтүүд (2012-2022 он)⁴⁷



СЭМУТ-д 2024 онд нийт 1157 иргэн сэтгэцийн шинжилгээнд хамрагдсанаас эрүүгийн хэрэгт шүүгчийн шийдвэрээр 2, прокурорын шийдвэрээр 13, зөрчлийн хэрэгт 1 оролцогч тус тус хамрагджээ.⁴⁸

Практикт давтан шинжилгээ буюу шинжлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал эргэлзээтэй, онош тодруулах шаардлагатай тохиолдолд илүү нарийвчилсан бие махбодын шинжилгээ хийлгэдэг туршлага байна. Тухайлбал “Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ”-г эмгэг сэтгэл судлаач эмчээр, мөн шаардлагатай тохиолдолд уураг тархины органик эмгэгийг тодруулах зорилгоор мэдрэлийн эмчид үзүүлж, шаардлагатай тохиолдолд MRI (соронзон үелзүүрт томографи), СТ (компьютер томографи) хийдэг. Тархины цахилгаан бичлэг, тархины судасны доплерографи, дааврын шинжилгээ гэх зэрэг шинжилгээг бусад эмнэлгүүдэд хийлгэн онош тодруулдаг. Уураг тархины голомтот эмгэг, тархины гэмтэл болон бусад биеийн эмгэгийн улмаас сэтгэцийн эмгэг үүссэн байж болзошгүй тохиолдолд онош тодруулах шинжилгээ ч хийлгэж байна.

Прокурор, мөрдөгчийн шийдвэрээр сэтгэцийн шинжилгээ хийх мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалтыг халах зөвлөмжийг НҮБ-ын Хүний эрхийн хороо 1999, 2009 онд гаргасан байдаг. Мөн дээрх ажиллагаагаар халдашгүй чөлөөтэй байх эрхэд

⁴⁶ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Статистик үзүүлэлт. 2018-2022 он.
⁴⁷ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв. Статистик үзүүлэлт. 2018-2022 он.
⁴⁸ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2/194 дугаартай албан бичиг

халдахад шүүхийн зөвшөөрөл авсан байх шаардлага нь ХБНГУ, АНУ, Итали, БНФУ зэрэг ардчилсан улсуудад нийтлэг чиг хандлага болсныг дурдах нь зүйтэй⁴⁹.

Комисст сэтгэцийн шинжилгээ хийлгэх, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй холбоотой гомдол мэдээлэл сүүлийн жилүүдэд ирж байна. Тухайлбал 2022 онд 2, 2023 онд 1, 2024 онд 3, 2025 онд 1 гомдол иржээ.

Тохиолдол 6.7

“Миний бие сэтгэц эв эрүүл бөгөөд цаашдаа амьдрах эрхтэй, намайг хүчээр шинжилгээнд хамруулж өөрийн сүлжээгээр сэтгэцийн өвчтэй гэж дүгнэлт гаргуулах гэж улайрч байгаа ... аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газарт нэн даруй шалгалт хийж дүгнэлт гаргаж өгнө үү. Би эрүүл хүн, сэтгэцийн шинжилгээнд орохыг эрс эсэргүүцэж байна...” гэжээ

Дээрх гомдолд шалгах ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдсон 1) ... аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч Б.Г нь ЭХХШТХ-ийн 27.1 дүгээр зүйлийн 1,2,3 дугаар зүйлийг үндэслэн сэтгэцийн шинжилгээ хийлгэх мөрдөгчийн тогтоол гаргаж, шинжилгээ хийлгэхийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нарт даалгасан, 2) Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ... дугаар албан бичгээр “...Сэтгэцэд хийх шинжилгээ нь үзүүлэгчийг өөрийн биеэр үзэж эмнэл зүйн ярилцлагаар үзлэг хийх, хавтаст хэргийн материал болон бусад холбогдох эмнэлгийн бичиг, материалыг үзэж, танилцаж судалж дүгнэлт гаргадаг болно. Иймээс танай байгууллагаас шинжилгээ хийлгүүлэх хүн нь биечлэн ирээгүй, хавтаст хэргийн материал, бусад холбогдох бичиг баримт ирүүлээгүй тул сэтгэцийн шинжилгээг хийх боломжгүйг үүгээр мэдэгдэж байна.” гэх хариуг хүргүүлсэн байна.. 3) тухайн иргэн мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийж мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулж байсантай холбоотойгоор мөрдөгч, прокурорын дуудан ирүүлэх мэдэгдэх хуудас өгсөн боловч ирээгүй тул шүүхэд хүсэлт гаргаж албадан ирүүлэх захирамж гаргуулжээ.

Комисс .. прокурорын газарт хуульд заасан үндэслэл журмын дагуу сэтгэцийн шинжилгээ хийх тодорхой ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн явуулах талаар санал хүргүүлж шийдвэрлэжээ.

(Комисст ирүүлсэн иргэн П.Б-н гомдол, мэдээллээс)

Дээрх тохиолдлоос үзэхэд ЭХХШТХ-д заасан үндэслэлийн дагуу сэтгэцийн шинжилгээ хийх ажиллагааг мөрдөгчийн тогтоолоор хийхээр шийдвэрлэсэн боловч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд шинжилгээнд хамрагдах хүн, түүний хууль ёсны төлөөлөгч шинжилгээ хийлгэхээс татгалзсан, эрүүл мэндийн байгууллага тухайн хүний нөхцөл байдалд нийцүүлэн шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд шинжилгээг хэрхэн хийх, зайлшгүй тохиолдолд шинжилгээг албадан хийх талаарх зохицуулалтыг хуулиар нарийвчлан зохицуулаагүй байна.

Комисс Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн шинжээч эмч нартай хийсэн бүлгийн ярилцлагад практикт тулгамдаж буй хүндрэл бэрхшээл дурдаж байсныг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал шүүгчийн захирамжаар шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулахаар явуулсан иргэн хэзээ ирэх, хаана байгаа нь тодорхойгүй, утас, оршин суух хаяг, хувийн байдлыг тодруулсан мэдээлэл байхгүйгээс гадна шинжилгээнд хамрагдах иргэнийг хэн, хэзээ, ямар байдлаар авчрах нь ойлгомжгүй, эмнэлгийн холбогдох баримт дутуу, тогтоолд заасан хугацаанд иргэн нь ирдэггүй, хувийн байдлыг нь тогтоодоггүйгээс шинжилгээ хийхэд хүндрэлтэй байдаг гэсэн бол мөрдөгч, цагдаагийн алба хаагч нарын хувьд өөрөө хүнээ дагуулж, хэргийн материалаа авч ирдэг талаар дурджээ.

Харин мөрдөгчтэй хийсэн ярилцлагаас үзэхэд хэргийг шийдвэрлэхийн тулд оролцогчийн хэрэг хариуцах чадвартай эсэхийг заавал тогтоох шаардлагатай гэж зарим шүүгч, прокуророос албан бус үүргийг мөрдөгч нарт өгдөг. Үүнтэй холбоотойгоор оролцогч нарыг үзүүлэх шинжээчийн тогтоол мөрдөгч нар үйлдэж СЭМҮТ-д аваачиж үзүүлэхээс гадна заавал гэдэг байдлаар тухайн хэргийн оролцогчийг цагдаагийн алба хаагч харгалзан авч явдаг. Энэ ажиллагааг хийгээгүйгээс хэргийн шийдвэрлэлт удаашрах, буцаах тохиолдол гардаг гэжээ.

⁴⁹ О.Мөнхсайхан, Р.Очирбал. “Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл” тойм судалгаа. УБ. 2021, 71 дэх тал.

Зарим төрлийн сэтгэцийн шинжилгээг хийх чадавхыг нэмэгдүүлэх замаар эрүүгийн хариуцлагын үр нөлөөг сайжруулах, зарим төрлийн ноцтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар⁵⁰ гэдэг нь хэрэг хариуцах чадварыг бүрэн үгүйсгэхгүй боловч гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ухамсарлах, үйлдлээ удирдах, жолоодох чадварт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа бодит хүчин зүйлээр нөхцөлдсөн сэтгэцийн эмгэг байдал, өөрчлөлт, процесс юм.⁵¹ Жишээлбэл согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэх болон бэлгийн гаж дон, зуршил бусад сэтгэцийн эмгэг өөрчлөлт үүнд хамаардаг.

Зарим эрдэмтдийн хийсэн судалгаагаар хүний амь бие, эрүүл мэнд, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийн 65-70 хувь нь сэтгэцийн ямар нэгэн өөрчлөлттэй байдаг гэжээ.⁵² Хорих ангид ял эдэлж байгаа хоригдлуудын дунд сэтгэцийн эмгэгтэй, хэрэг хариуцах чадвартай эсэх нь эргэлзээтэй хүмүүс байдаг эсэх талаар санал асуулгад оролцсон хорих байгууллагын алба хаагчдын 66.7 хувь нь цөөнгүй байдаг, 8.3 хувь нь түгээмэл байдаг гэж үзсэн бол сэтгэцийн эмгэгтэй хоригдол хорих ангийн хэвийн үйл ажиллагаа, нийгэм сэтгэл зүйн ажил, бусад хоригдлын сэтгэл зүйн байдалд маш их нөлөө үзүүлдэг гэж 58.3 хувь нь үзсэн бөгөөд тэднийг сэтгэцийн эмнэлэгт ял эдлүүлэх, эмчилгээнд хамруулах, сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх тусад нь тусгай нэгжид байлгах шаардлагатай гэжээ.

ЭХХШТХ-ийн 27.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтад “Бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох” гэж заасан. Түүвэр судалгаанаас үзэхэд “Хүнийг алах” болон “Хүчиндэх” гэмт хэрэг үйлдсэн хүний сэтгэцийн байдлыг тодорхойлоход сэтгэцийн эмгэгтэй, оюун ухааны хомсдолтой боловч хэрэг хариуцах чадвартай гэсэн дүгнэлт цөөнгүй гардаг бөгөөд энэ нь хэрэг хариуцах хязгаарлагдмал (завсрын) чадварт хамаарах юм.

Энэ тохиолдолд шүүхээс ял оногдуулахын зэрэгцээ шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн тохиолдол байхгүй, эмчийн оношны дагуу сэтгэцийн эмчилгээ хийдэг практик тогтоогүй байна.

Энэ талаар шүүгч, прокурор, мөрдөгчдийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд оюун ухааны хөнгөн хомсдолтой, сэтгэцийн эмгэгтэй боловч шинжээчийн дүгнэлтээр хэрэг хариуцах чадвартай гэж тогтоогдсон хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ эмчилгээний арга хэмжээг шүүхийн шийдвэрээр хэрэглэх нь зүйтэй гэдэгтэй шүүгчдийн 53.7 хувь нь зарим тохиолдолд санал нийлнэ, 29.3 хувь нь санал нийлнэ, 17.1 хувь нь санал нийлэхгүй гэж хариулсан байна. Харин прокуроруудын 66.7 хувь нь зарим тохиолдолд санал нийлнэ, 33.3 хувь нь санал нийлнэ гэж хариулсан бол мөрдөгчдийн 52.3 хувь нь санал нийлнэ, 36.4 хувь нь зарим тохиолдолд санал нийлнэ, 11.4 хувь нь санал нийлэхгүй гэж тус тус хариулжээ.⁵³

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн тоо өсөж, гэмт хэрэг үйлдсэн хүнд ялын хатуу бодлогоор тэмцэж байгаа хэдий ч сэтгэцийн нарийвчилсан шинжилгээнд хамруулж сэтгэцийн эмгэгийн ангилалд хамаарах бэлгийн замын таашаал авах арга замын хэлбэрүүдийн эмгэг (F65)⁵⁴, түүн дотроо педофили

⁵⁰ Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварын тухай үзэл баримтлал 19 дүгээр зуунд сэтгэл судлал, шүүх-сэтгэгч гэм судлалын шинжлэх ухааны хөгжлийн үр дүнд эрүүгийн эрх зүйд шинээр орж иржээ.

⁵¹ Жанцан, С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Гэмт хэргийн тухай сургаал/. I боть. УБ., 2009. 438 дахь тал.

⁵² Курс уголовного права. Общая часть. МГУ. 1999. С.278.

⁵³ Б.Энхболд, Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ эрх зүйн зохицуулалт эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” УБ., 2024 он.

⁵⁴ ДЭМБ-аас 1989 онд өвчний олон улсын 10 дугаар ангилал (International Classification of Diseases-10 буюу ICD-10)-ыг баталсан бөгөөд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн дагуу Монгол Улс 2000 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн өвчний олон улсын ангиллын “Сэтгэгч зан үйлийн эмгэгүүд” бүлэгт заасан оношилгооны хэмжүүрээр сэтгэцийн өвчнүүдийг оношлох болсон

(F65.4)⁵⁵ шинж байгаа эсэхийг тогтоож тохирсон хариуцлага хүлээлгэх, суллагдсаны дараа байнгын хяналтад авах арга хэмжээ хангалтгүй байна.

Судалгаанаас үзэхэд бага насны хүүхдийг хүчиндэх (*Бага насны хүүхдийг эсрэг бэлгийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар Илтгэлийн V бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү*), онц харгис аргаар хүний амь насыг хохироох хэрэгт ял шийтгүүлсэн хүмүүсийн 90 орчим хувь урт хугацааны хорих ялаар шийтгүүлж байгаа ч суллагдах боломжтой нөхцөлтэй хариуцлага хүлээж байна. Судалгаанаас үзэхэд СЭМҮТ-ийн бүртгэгдсэн өвчлөлийг ДЭМБ-ын баталсан өвчний олон улсын 10 дугаар ангиллын “Сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд” 5 дугаар бүлэгт заасан өвчний ангиллаар нь авч үзвэл Насанд хүрэгчдийн бие хүний ба зан төрхийн эмгэг (F60-F68.9) нийт хяналтад байдаг хүний 7 орчим хувийг эзэлдэг байна⁵⁶.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд сэтгэцийн эмгэгтэй буюу хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай байх эсэх ойлголтыг дэлхийн олон улсад эрүүгийн хуульд тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр нөлөөтэй хэрэгжүүлдэг байна. Тухайлбал ОХУ, БНКУ, БНФУ, ХБНГУ, Япон, Испани зэрэг орнуудын хуульд хуульчилж өгчээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “....Хэрэг хариуцах чадвартай байдлыг үгүйсгэхгүй сэтгэцийн өөрчлөлттэй байдлыг шүүх ял оногдуулахдаа болон эмнэлгийн шинж чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ харгалзан үзнэ”⁵⁷ гэж ерөнхий нөхцөл байдлыг заажээ. Тус хуулийн 97 дугаар зүйлийн Д-д “Арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн арван найман нас хүрсэн, эрүүл мэндийг үгүйсгэхгүй бэлгийн дур хүслийн эмгэг (педофили) өвчтэй хүн” гэж нарийвчлан заасан бол БНКУ-ын Эрүүгийн хуульд яг үүнтэй төстэй зохицуулалтыг тусгажээ. Франц Улсын Эрүүгийн хууль⁵⁸-ийн 122.1 дүгээр зүйлд “...Гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн үйлдлийг ойлгож ухамсарлах, эсхүл удирдах чадварыг бууруулсан сэтгэцийн өөрчлөлт, эмгэгтэй байсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”⁵⁹ Гэхдээ шүүх энэ нөхцөл байдлыг ял оноох, түүнийг эдлүүлэх дэглэм журмыг тогтоохдоо харгалзана...” гэж заажээ.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүст хатуу ял оногдуулахын зэрэгцээ шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх арга хэмжээг хэрэглэх, суллагдсаны дараа хяналт тавих үндэслэлийг Эрүүгийн хуульд тусгах шаардлагатайг зөвлөж байна.

Хэрэг хариуцах чадвар, ялангуяа хэрэг хариуцах хязгаарлагдмал (завсрын) чадварыг хуульчлах нь ял завших эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой гэж судлаачид үздэг бөгөөд шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг дагнан хийх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, холбогдох аргачлалыг боловсронгуй болгох шаардлагатай. Комиссоос зарим судлаачтай хамтран мөрдөгч, прокурор, шүүгчдийн дунд хийсэн социологийн судалгааны үр дүнгээс үзэхэд сэтгэцийн байдлыг тогтоож байгаа шинжээч эмчийн мэргэжил, ур чадвар хангалтгүй байгаа талаар илэрхийлсэн.⁶⁰ Үүнд:

- Сэтгэцийн шинжээч эмчийн мэргэжлийн ур чадварыг судалгаанд оролцсон шүүгчдийн 88 хувь, прокуроруудын 77.8 хувь, мөрдөгчдийн 79.1 хувь нь дунд болон муу гэж дүгнэжээ.

- Гэмт хэрэг үйлдсэн хүний сэтгэцийн байдлын талаар гаргасан шинжээч эмчийн дүгнэлтийг шүүгчдийн 46.3 хувь, прокуроруудын 44.4 хувь, мөрдөгчдийн 54.5 хувь нь хэрэглэхэд хүндрэлтэй, эргэлзээтэй байдаг гэж үзсэн бол шүүгчдийн 41.5 хувь,

⁵⁵ Ихэвчлэн шилжилтийн өмнөх буюу шилжилтийн эрт үе байгаа (оход, хөвгүүд, эсвэл аль альтай нь) хурьцах, дур тачаал төрөх байдлаар илэрдэг эмгэг.

⁵⁶ Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв. Статистик үзүүлэлт. УБ., 2018-2022. 9 дэх тал.

⁵⁷ Уголовный кодекс РД. М., 2000.С.7.

⁵⁸ <https://eige.europa.eu/gender-based-violence/resources/france/french-penal-code-general-criminal-law>

⁵⁹ Гантөмөр. Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2011. 161 дэх тал.

⁶⁰ Б.Энхболд, Н.Одонтуул. “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ эрх зүйн зохицуулалт эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” УБ., 2024 он.

прокуроруудын 44.4 хувь, мөрдөгчдийн 20.5 хувь нь дүгнэх боломжгүй учраас шууд хэрэглэдэг гэж хариулжээ.

Хэрэг хариуцах чадваргүй хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ ямар нотлох баримтыг голчлон баримталдаг талаар асуухад шүүгчдийн 68.3 хувь, прокуроруудын 66.7 хувь, мөрдөгчдийн 47.7 хувь нь бусад нотлох баримт, шинжээч эмчийн дүгнэлт, тухайн хүний хувийн байдлыг тал бүрээс нь хардаг гэсэн байна. Харин шүүгчдийн 12.5 хувь, прокуроруудын 33.3 хувь, мөрдөгчдийн 20.5 хувь нь шинжээч эмчийн дүгнэлтийг голчлон анхаардаг гэжээ.

6.6.ТӨРИЙН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ, МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА

Гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагаас явуулж байгаа гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл, санал хүсэлт Комисст удаа дараа ирж байгаа ч шалгах ажиллагаа явуулж, үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчин дутмаг байна. ЭХХШТХ-д заасан нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхээр хэрэг хянан хэлэлцэх, таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа ил болгож, нээлттэй хэлэлцдэггүйгээс шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх эрсдэл үүсэж, шүүх, прокурор болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагад итгэх олон нийтийн итгэл суларч байна. Нөгөө талаар гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулсан албан тушаалтан, түүний мөрөөр илрүүлсэн нотлох баримтыг үндэслэж шийдвэр гаргасан хууль хяналтын байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны баталгаа алдагдах сөрөг үр дагавар үүсэж байна.

Комисст авагдсан баримт мэдээллээс үзэхэд, төрийн болон албаны нууц мэдээлэл агуулсан гэсэн шалтгаанаар шүүх хуралдаан хаалттай явагдах, нотлох баримт шалгуулах хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, оролцогчдод танилцуулахгүй байх, нууцын баталгаа авч өмгөөллийн үйл ажиллагааны цар хүрээг хумих, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болгож хэрэглэх, хавтаст хэргийн материалд хамааралгүй төрийн нууц, түүнд хамаарах мэдээ баримтыг хавсаргаж хэргийг бүхэлд нь нууцад хамааруулах зэрэг нөхцөл байдал илэрч байна. Түүнчлэн хорих анги, цагдан хорих байранд гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх зүйн боломж өнөөг хүртэл нээлттэй байгаа нь эрүү шүүлт тулгах, хүний эрхийн аливаа зөрчил үүсэх эрсдэлийг үүсгэж байна.

Тохиолдол 6.8

“... дугаар хэрэгт нотолгооны маш чухал ач холбогдолтой баримтуудыг төрийн болон албаны нууцын тухай хуулийг зөрчиж төрийн нууцад орохгүй энгийн 96 хуудас материалд “Маш нууц”-ын дардас дарж явуулсан нь нотлох баримтыг зориудаар эрүүгийн хэргийн шүүхээс нуун дарагдуулж төөрөгдүүлсэн байна. 2018 оноос хойш надад холбогдох хэргийг 2 удаа прокуророос хааж, 3 удаа сэргээн шалгаж байгаа боловч хийвэл зохих зайлшгүй ажиллагаануудыг хийлгүй хэргийн хугацааг үндэслэлгүйгээр байнга сунгаж, олон жил хэрэгт дорвитой ажиллагаа хийж явуулахгүй миний нэр хүнд, эрүүл мэнд, эдийн засгийн эрх ашгийг байнга хохироож байгааг анхаарч өгнө үү...”

...гомдол гаргагч нь өөрт холбогдох эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргуулж эрүүгийн ... дугаартай хэрэгт тусгуулах талаар 2019 онд 1 удаа, 2023 онд 9 удаа, 2024 онд 14 удаа нийт 24 гомдол, хүсэлтийг УИХ-ын Тусгай хяналтын дэд хороо, УИХ-ын гишүүн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Монгол Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газарт гаргаж, үүний дагуу холбогдох байгууллагууд 24 удаа хариу өгсөн (Комисст ирүүлсэн баримт) боловч түүний шалгуулах хүсэлт гаргасан хэрэгт ач холбогдол бүхий баримтыг “маш нууц” дардас дарсан гэсэн шалтгаанаар шинжлэн судлах арга хэмжээг бүрэн аваагүй байна...

(Комисст 2024 оны 05 дугаар сард ирсэн гомдлоос)

Хэрэгт ач холбогдол бүхий баримтуудыг шинжлэн судалж, эргэлзээг арилгах нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан гэм буруугүйд

тооцогдох, шударгаар шүүлгэх, шүүхэд нотлох баримт гаргах, өөрийгөө өмгөөлөх эрхийг⁶¹ хангахад ач холбогдолтой бөгөөд ийм практик тогтооход чухал үүрэг гүйцэтгэх юм.

Гэвч төрийн нууцтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах, гэм буруутай этгээдэд шударгаар хариуцлага хүлээлгэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим үйлчилж чадахгүй байна.

Тохиолдол 6.9

Сэтгүүлч Н.Ө-д Төрийн нууцыг хууль бусаар олж авах гэмт хэрэгт гэм буруутайд тооцож ... жилийн хорих ялаар шийтгэж хариуцлага хүлээлгэсэн боловч төрийн нууцыг задруулсан, хадгалж хамгаалах үүрэг бүхий төрийн албан тушаалтныг олж тогтоох, тохирсон хариуцлага хүлээлгэх ажиллагаа удаашралтай байгаад шүүмжлэлтэй хандаж байна.

Нийслэлийн прокурорын газраас 2024 оны 07 дугаар сард Комисст ирүүлсэн алба бичигт⁶² Н.Ө-д холбогдох хэргээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлийн 6 дахь заалтад заасны дагуу дугаартай хэргийг тусгаарлаж Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар мэдээдсэн боловч өнөөдрийг хүртэл ямар нэгэн албан тушаалтан хариуцлага хүлээсэн талаар мэдээлэл Комисст авагдаагүй байна.

(Нийслэлийн прокурорын газрын 2024 оны 01/4193 дугаартай албан бичгээс)

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 35 дугаар тогтоолд “цагдан хорих байранд гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах хүрээг хязгаарлаж, хүний эрхийн зарчимд нийцүүлэн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, танилцуулах талаар тусгасантай холбоотойгоор, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар хүрээ хязгаарыг хумьсан хэдий ч энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй байна.”⁶³

Мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журмыг аль болох хуулиар зохицуулах,⁶⁴ хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг прокурорын саналаар шүүхийн зөвшөөрлөөр явуулах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “Монгол Улсын иргэн... халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” гэж заасан агуулгад нийцэх юм. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭХХШТХ-д зааснаар 12 төрлийн нууц мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байна. Түүнчлэн ИБУТЭТОУП-д “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байр, захидал харилцаанд нь дур мэдэн буюу хууль бусаар оролцох, эсхүл нэр хүнд, нэр алдарт нь хууль бусаар халдахыг хориглоно”⁶⁵ гэж заасан. Үүнээс үзэхэд мөрдөн шалгах нууц ажиллагаа нь халдашгүй чөлөөтэй байх эрх, хүний хувийн амьдралд оролцох, халдах агуулгатай учраас зөвхөн хуулиар, шүүхийн хяналтад явуулж байхыг энэхүү пакт шаардаж байна.⁶⁶

Энэ талаар иргэний нийгмийн байгууллагууд Монгол Улсад гарсан эрүү шүүлт тулгах хэрцгий, хүнлэг бус гэмт хэргийн тохиолдлуудад үндэслэн сануулж байгааг анхаарч үзэх ёстой. Тухайлбал Монгол Улсын Хүний эрхийн ТББ-уудын форум “Мөрдөн шалгах нууц ажиллагааны зөвшөөрлийг прокурор өгч байгаа нь учир дутагдалтай. Хүний халдашгүй байх эрхэд халдаж буй хэрэг тул зөвшөөрлийг шүүх өгөх нь зөв алхам юм. Мөн цагдан хорих байранд “мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулахыг бүрмөсөн хориглохгүй бол эрүүдэн

⁶¹ ИБУТЭТОУП, 14 дүгээр зүйл 1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Мөн хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

⁶² Нийслэлийн прокурорын газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/4193 дугаартай албан бичиг.

⁶³ Комиссын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 06/872 дугаартай албан бичиг.

⁶⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг.

⁶⁵ ИБУТЭТОУП, 17 дугаар зүйл.

⁶⁶ О.Мөнхсайхан, Р.Очирбал. Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: Тулгамдсан асуудал, шийдэл, УБ, 2021 он, 77-79 дэх тал.

шүүхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд тодорхой ахиц гарахгүй. ХЗДХ-ийн Сайд Ц.Нямдоржийн нийтэд зарласан эрүүдэн шүүсэн хэрэг нь (Төр, нийгмийн зүтгэлтэн С.Зориг агсны хэрэг) цагдан хорих байранд хийгдсэн гүйцэтгэх ажлын бичлэг юм” гэжээ.

Цаашид ЭХХШТХ-д дурдсан мөрдөн шалгах нууц ажиллагаа бүрийн агуулгыг тодорхойлж өгөх, энэ ажиллагааг явуулах үндэслэлийг маш тодорхой заах, мөрдөн шалгах нууц ажиллагааг гүйцэтгэх, дуусгавар болгох, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж олж авсан нотлох баримтын үр дүн бүрийг шүүхийн шатанд ил болгож хавтаст хэрэгт тусгах асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах замаар хүний хувийн халдашгүй байдлыг хангах ёстой.

6.7.МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ НУУЦ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

ЭХХШТХ, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчиж хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд хүний эмзэг мэдээллийг задруулах байдлаар гэмт хэрэгт холбогдогчийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон мэтээр ойлгуулах, хохирогчийг буруутгах агуулгатай мэдээлэл олон нийтэд тараах зэргээр хүний эрхийг зөрчих хандлага түгээмэл байгааг онцлон тэмдэглэж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд байгаа гэмт хэргийн талаар мэдээлэл өгөхтэй холбоотой асуудлыг ЭХХШТХ-ийн 29.3 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд цагдаагийн байгууллагын зүгээс олон нийтэд мэдээлэл өгөхдөө дээрх хуулийн заалтыг удирдлага болгож байна. Тус хуулийн 29.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авна”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно” гэж тус тус заасан.

Комисст ирүүлсэн гомдол мэдээллээс үзэхэд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны нууц, хүний хувийн мэдээллийг задруулсан шинжтэй хэд хэдэн тохиолдол бүртгэгдэж, хуульд заасан чиг үүргийн хүрээнд шалгах ажиллагаа явуулж хүний эрхийн зөрчлийг арилгах, хянан шалгуулах арга хэмжээ авсан.

Тохиолдол 6.10

Цагдан хорих ... хаалттай ангид цагдан хоригдож байгаад нас барсан 21 настай иргэн Б.О-ийн асуудлаар 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр Цагдаагийн ерөнхий газраас хийсэн мэдээлэл, түүнийг агуулгыг прокурорын мэдэгдэх бололцоотой гэсэн хүрээнд өгсөн боловч нэмэлт асуулт хариултын хүрээнд хүний эмзэг мэдээлэл болох “ял эдэлж байсан” талаар олон нийтэд мэдээлсэн нь хүний эрхийг зөрчсөн үйлдэл гэж дүгнэж байна.

(Комиссоос УИХ-ын ХЗБХ-нд 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хүргүүлсэн дүгнэлтээс)

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд “хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээлэл”-ийг ойлгохоор заасан.⁶⁷

Тохиолдол 6.11

“... цагдаагийн... газраас үзлэг, нэгжлэгээр хураан авсан, компьютероос Ц.Э, П.Ц нарын харилцан “мессеж”-ийг илрүүлсэн гэх мэдээллийг Цагдаагийн байгууллага хэвлэлийн хурлаар олон нийтэд цацаж, захидал харилцааны нууц, халдашгүй чөлөөтэй байх, хэргээ шударгаар шүүлгэх эрхийг зөрчсөн ” тул шийдвэрлэж өгнө үү...”

(Өмгөөлөгч Д.А-аас Комисст гаргасан гомдлоос)

“...манай нөхөр Б-г Цагдаагийнхэлтсээс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ажлын байран дээрээс нь хүч хэрэглэн баривчилсан. Энэ ажиллагаанд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл,

⁶⁷ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт.

сонин, сайтуудыг ашиглаж шууд дамжуулалт хийсэн, холбогдоогүй хэргийн талаар олон нийтэд зориуд худал мэдээлэл тараасан...”

...ажиллагаа эхлэхээс өмнө мэдээ, мэдээлэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн сүлжээ (сошиал)-ээр цацагдаад эхэлсэн, ажлын байранд сэтгүүлч нэвтэрч фото зураг дарсан байсан (цагдаа, сэтгүүлч холилдсон)...”

(Иргэн А-аас Комисст гаргасан гомдлоос)

Комисс хуульд заасан шалгах ажиллагаа явуулж гомдол гаргасан асуудал нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэж Авлигатай тэмцэх газарт шилжүүлж шийдвэрлэсэн боловч асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн нь өнөөдрийг хүртэл тодорхойгүй байна.⁶⁸

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд ЭХХШТХ-д заасан тодорхой ажиллагаа явуулах талаарх мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах мэдээлэл задарсан байх боломжтой. Иргэн Б-ийн холбогдсон эрүүгийн хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд ийнхүү хэвлэл мэдээллээр мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээлэл өргөн хэмжээнд тархсан нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан шүүхийн шийдвэр гарах хүртэл гэм буруугүйд тооцогдох зарчмыг зөрчсөн үйл ажиллагаа юм.

Шүүн таслах ажиллагааны 2024 оны тайлангаас үзэхэд Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл мөрдөн шалгах ажиллагааны нууцыг албан үүргийн хувьд мэдсэн этгээд задруулах зүйл, хэсгээр эрүүгийн хариуцлага хүлээсэн мэдээлэл дурдагдаагүй байна.

Мөрдөн шалгах ажиллагааны нууц, хувь хүний мэдээллийг хамгаалахтай холбоотой ЭХХШТХ-ийн 29.3 дугаар зүйлийг боловсронгуй болгох, ялангуяа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа эхлээгүй байгаа гэмт хэргийн гомдол мэдээллийн шинжтэй үйлдлийг шалгах шатанд прокурорын хяналт дутмаг байгаагаас хэргийн материал задрах, зориуд олон нийтэд тараах үйлдэл гарч байгааг засах шаардлагатай.

6.8.ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ


ЭХХШТХ-д 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлт нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход чухал ач холбогдолтой хууль болсон. Тухайлбал зөвхөн хорих ял оногдуулж болох гэмт хэрэгт цагдан хорих, баривчлах арга хэмжээг хэрэглэх, шүүхийн хэлэлцүүлгийг үр нөлөөтэй явуулах, цагдан хоригдсон болон баривчлагдсан этгээд суллагдсаны дараа шүүхэд гомдол гаргах эрхийг нээж өгсөн. Үүнтэй холбоотойгоор цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг эцсийн арга хэмжээ болгож хэрэглэх, хүний эрхийг хангах талаар тодорхой ахиц дэвшил гарч байгааг холбогдох байгууллагуудын статистик мэдээллээс үзэж болохоор байна.

Прокурорын байгууллагаас цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авуулахаар ирүүлсэн хүний тоо өмнөх онтой харьцуулахад 623 хүн буюу 24.3 хувиар, цагдан хорих таслан сэргийлэх арга авч шийдвэрлэсэн 1672 хүнийг өмнөх онтой харьцуулахад 501 хүн буюу 23 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа бол нийт яллагдагчаар татагдсан хүний 6.6 хувьд⁶⁹ цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

⁶⁸ Комиссын гишүүний гомдол шийдвэрлүүлэх тухай 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 04/1453 дугаартай албан бичиг.

⁶⁹ Үндэсний статистикийн хороо. “Гэмт хэрэг, 2024 онд”. <https://www.nso.mn/mn/dissemination/92389337>

Бүдүүвч 6.2 Шүүхэд 2023, 2024 онд ирүүлсэн цагдан хорих сэргийлэх арга хэмжээ авхуулах санал



Шүүхийн өмнөх шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг заавал хэрэглэхүй байхад эерэг өөрчлөлт гарч байгаа ч уг арга хэмжээ авах, сунгах хэлэлцүүлэгт мэтгэлцэх зарчмын хэрэгжилтийг хангуулах, цагдан хорих үндэслэлд хамаарах нотлох баримтыг талуудад бүрэн танилцуулах, өмгөөлөгчийн оролцоо хэлбэрийн төдий байгаа зэрэг процессын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Комиссоос 2024 онд аймаг, нийслэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, уулзалт, түүвэр судалгааны дүнгээс үзэхэд тэдний 70.3 хувь нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгчдийн оролцоо хангалтгүй хэвээр байгаа тухай илэрхийлсэн. Мөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, сунгах, цуцлах асуудал ихэвчлэн прокурорын гаргасан саналаар шийдэгддэг, маш цөөн тохиолдолд өмгөөлөгчийн хүсэлтийг хангаж шийдвэрлэж байгаагаас шүүхийн хараат бус, хөндлөнгийн байх зарчим хангагдаж байгаад эргэлзэж байгаагаа илэрхийлжээ.⁷⁰

Хүснэгт 6.6 Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой шүүгчийн захирамж (2024 он)⁷¹

№	Шүүгчийн захирамж	Тоо
1	Яллагдагчаар цагдан хорих тухай	1144
2	Яллагдагчийг цагдан хорихоос татгалзах тухай	164
3	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах тухай	2201
4	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгахаас татгалзах тухай	160
5	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөр арга хэмжээгээр солих тухай	145
6	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг цуцлах тухай	29
7	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгчийн захирамжид гарсан гомдлыг хянан шийдвэрлэсэн тухай	342

Яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагч, өмгөөлөгч нарыг оролцуулахгүйгээр шийдвэрлэх боломжтой хуулийн зохицуулалт үйлчилж байгаа нь Монгол Улсын үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүн шүүх хуралдаанд биеллэн оролцох, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хязгаарласан шинжтэй зохицуулалт бөгөөд үүнтэй холбоотой хүний эрхийн зөрчлийн талаарх мэдээлэл Комисст 2024 онд бүртгэгдсэн.

Тохиолдол 6.12

...Цагдан хорих ...хаалттай ангид хоригдож байгаад өвчний улмаас нас барсан Б.О-д авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх анхны шүүх хуралдаанд яллагдагч Б.О цахимаар оролцож гадуур шалгаагдах санал хүсэлтээ илэрхийлж байсан бол 1, 2 дугаар хугацаа сунгах шүүх хуралдаанд Б.О, түүний өмгөөлөгчийн аль аль нь биеллэн болон цахимаар

⁷⁰ Хүний эрхийн Үндэсний Комиссоос өмгөөлөгчдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлгийн тэмдэглэл, 2025 он. ХЭҮК-оос Хөвсгөл, Өмнөговь, орон нутагт хийсэн хяналт шалгалтын илтгэх хуудас.

⁷¹ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. УБ, 2025 он.

оролцоогүй, цагдан хорих хугацааг сунгах үндэслэл ижилхэн боловч хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг тайлбарласан мэдээлэл, холбогдох нотлох баримт шүүгчийн захирамжид тусгаадаагүй байсан...

(Комиссын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/01 дугаар зөвлөмжөөс)

ЭХХШТХ-ийн 14.13 дугаар зүйлийн 3-т “Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулах ба хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагчийг оролцуулна” гэж заасан бөгөөд дээр дурдсан тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах шүүхийн хэлэлцүүлэгт “өмгөөлөгч, яллагдагч” нарын аль аль нь оролцоогүй, хоригдогчийн санал, хүсэлтийг сонсохгүйгээр шийдвэрлэжээ. Ийм байдлаар шийдвэрлэх боломжтой зохицуулалт үйлчилж байгааг анхаарч засах шаардлагатай.

ЭХХШТХ-д шүүхийн шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж болохоор заасан хэдий ч уг хугацааг яллагдагчаар цагдан хорьсон хугацаанд оруулан тооцохгүй байх эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа нь хэргээ аль болох богино хугацаанд шийдвэрлүүлэх, Үндсэн хуулиар баталгаажуулсан халдашгүй чөлөөтэй байх, гэм буруугүйд тооцогдох зарчимд нийцэхгүй байгааг онцлон тэмдэглэж, цаашид шүүхийн шатанд цагдан хорих арга хэмжээ хэрэглэх процессыг илүү нарийвчлан зохицуулах, хугацааг цагдан хорих нийт хугацаанд оруулан тооцох нь зүйтэй.⁷² Энэ асуудлаар нэр бүхий иргэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.⁷³

Хуульд заасан үндэслэл журмаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж байгаа дур зоргын шинжтэй үйлдэл гарч байна. Өөрөөр хэлбэл “мэдэгдэл” гэх баримт бичигт үндэслэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлдэг боловч үүнтэй ижил төрлийн баримт бичгийг үндэслэн суллах арга хэмжээг хэрэгжүүлдэггүй нийтлэг зөрчлийг таслан зогсоож, зөвхөн шүүгчийн захирамжаар хүний эрх чөлөөг хасах арга хэмжээг хуульд нийцүүлэн хэрэгжүүлэх, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах технологийн дэд бүтцийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл болно” гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргах шийдвэрийн хэлбэрийг хуульчилсан бөгөөд мөн зүйлийн 22.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.4-т зааснаас бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж тус тус заасан.

Тохиолдол 6.13

“...аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хяналт шалгалт явуулахад хуульд заагаагүй “мэдэгдэл” гэх баримт бичигт үндэслэн цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлсэн, шүүгчийн захирамжид цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэх цагдан хорих байр, хэрэгжүүлэх албан тушаалтныг тодорхой заагаагүй, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид мэдэгдэх талаар дурдаагүй байсан...”

(Комиссын гишүүний 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 06/29 дугаар зөвлөмжөөс)

“Дур зорго” гэдэг нь “...хуульд заасан үндэслэлээс гадуур баривчлах, цагдан хорих, саатуулахыг дур зоргын гэж үзнэ, мөн зохисгүй, хууль журмыг баримтлаагүй байдал, хуулийг

⁷² Дэлгэрэнгүй үндэслэлийг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлээс үзнэ үү.

⁷³ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх тухай 26 дугаар магадлал.

өөртөө нийцүүлэн тайлбарлах, үндэслэлтэй байх, зайлшгүй байх, тохирсон байх зарчмыг мөрдөөгүй байх” зэргийг агуулсан өргөн хүрээтэй ойлголт юм.⁷⁴ Мөн Аливаа хэлбэрээр саатуулагдсан, хоригдсон бүх хүнийг хамгаалах зарчмуудын цогц-ын 2 дугаар зарчимд “баривчлах, цагдан хорих, хорих арга хэмжээг зөвхөн хуульд заасан журмыг ягштал баримтлан уг зорилгоор эрх олгогдсон албан тушаалтан, этгээд хэрэгжүүлнэ” хэмээн заасан.

Харин цагдан хорих таслан сэргийлэх хэмжээг цуцалсан, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсны дараа шүүгчийн захирамжийг албажуулах хүртэл цагдан хорих байрнаас тухайн хүнийг суллахгүй байгаа нь хуульд зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа агуулгыг илэрхийлнэ. Комисст авагдсан мэдээлэл, ажиглалтаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний шүүхийн хэлэлцүүлэг дууссанаас хойш 1-3 цагийн дараа шүүгчийн захирамж албаждаг, албажсан захирамжийг ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид хүргэхэд 1-2 цагийн хугацаа зарцуулж байна. Өөрөөр хэлбэл цагдан хоригдсон хүнийг суллах тухай шүүгчийн захирамж гарснаас хойш нэн даруй суллах арга хэмжээ хийгдэхгүй байгаа бөгөөд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хооронд харилцдаг албан ёсны цахим систем өнөөг хүртэл нэвтрээгүй байна.

Шүүхээс цагдан хоригдож буй хоригдогчийн ар гэрийн нөхцөлийг үнэлж, тэдний хүүхдүүдэд учирч болох аливаа эрсдэлийг урьдчилан тооцож, цагдан хорих шийдвэр гаргахдаа харгалзаж бага насны хүүхэд, асаргаа шаардлагатай өндөр настныг халамжлах боломжоор хангаж байх нь зүйтэй.

Комисст 2024 онд ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих ангиас давхардсан тоогоор 312 хоригдогч гомдол мэдээлэл ирүүлсний 9 буюу 2.8 хувь нь “хүүхдийн эрхийн” асуудлаар хандсан байна. Хүүхдийн эрхтэй холбоотой ирүүлж буй гомдолд дурдагддаг нийтлэг асуудал нь бага насны хүүхэд асран хамгаалагчгүй үлдсэн тухай, бага насны хүүхдүүд нь асаргаанд байдаг өндөр настай аав, ээжтэй нь хамт байгаа, асрах төвд байдаг хүүхэдтэйгээ уулзаж байх тухай байна.

Цагдан хорих байрны орчин нөхцөл, хүний эрхийн байдал

ШШГЕГ-аас харьяа цагдан хорих байрын орчин нөхцөлийг сайжруулах, хоригдогсдын хоол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эргэлт уулзалт, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах орчин нөхцөлийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг шат дараатайгаар хийж байгаа нь сайшаалтай байна. 2024 оны байдлаар нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 27, нийт 28 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж байгаагаас орчин нөхцөлийг сайруулж, олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор барилга байгууламжийн 78.6 хувийг үе шаттайгаар шинэчилж, шинээр барьсан бол цаашид 6 аймаг, дүүргийн цагдан хорих байрыг шинэчлэх шаардлагатай.

Тухайлбал 2016-2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Ховд, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь цагдан хорих байрын барилгыг шинээр барьж, ашиглалтад оруулсан бол 2024 онд Хэнтий, Төв аймаг дахь цагдан хорих байрыг шинээр барьж ашиглалтад оруулжээ.⁷⁵

Комиссын гишүүний санаачилгаар 2024 онд ШШГЕГ-ын харьяа цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Хөвсгөл, Сүхбаатар, Булган, Дорноговь, Завхан, Өмнөговь, Баянхонгор аймгууд дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд удирдамжтай хяналт шалгалт, 21 аймгийн цагдан хорих төвд урьдчилан сэргийлэх үзлэг явуулсан.

Шалгалтын үр дүнгээр Баян-Өлгий, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байр, Өвөрхангай аймгийн

⁷⁴ НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2014 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн Ерөнхий тайлбар.

⁷⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 1/749 дугаартай албан бичиг.

Хархорин сум, Нийслэлийн Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн Цагдан хорих байр холбогдох стандартад заасан шаардлагыг хангахгүй байгааг нэн даруй шинэчлэх шаардлагатай.

Цагдан хорих байрны стандарт хангагдаагүйгээс нэг хүнд ноогдох талбайн хэмжээ, ариун цэврийн байгууламж, усанд орох газар, агаарын сэлгэлт, хоол бэлтгэх хэсэг, эргэлт, уулзалт хийх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах өрөө, алба хаагчдын хөдөлмөрийн нөхцөл зэрэг хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудал түгээмэл болжээ.

Комисст 2024 онд нийт 1311 гомдол, мэдээлэл ирснээс 360 гомдол, мэдээлэл буюу 27.5 хувь нь цагдан хорих төв, хорих ангиудаас ирсэн ба 7 хяналт шалгалт хийж, 4 зөвлөмж хүргүүлсэн.

Хүснэгт 6.7 Комисст цагдан хорих төв, хорих ангиудаас ирсэн гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлтийн төрөл	Тоо	Хувь
1	Биечлэн уулзаж хууль зүйн зөвлөгөө өгсөн	155	43.1
2	Өөрт нь албан бичгээр хууль зүйн зөвлөгөө өгсөн	59	16.4
3	Харьяаллын дагуу шилжүүлсэн	50	13.9
4	МУХЭҮКтХ-ийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт зааснаар хариу өгсөн	38	10.6
5	Эрүү зөрчлийн шинжтэй гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлсэн	26	7.2
6	Гомдолд дурдсан нөхцөл байдал арилсан тул өөрт нь хариу өгсөн	12	3.3
7	Гомдлоос татгалзсан	8	2.2
8	Гомдлын мөрөөр зөвлөмж хүргүүлсэн	4	1.1
9	Эвлэрүүлсэн	3	0.8
10	Гомдлын мөрөөр шаардлага хүргүүлсэн	2	0.6
11	Гомдлын мөрөөр хяналт шалгалт хийсэн	1	0.3
12	Шаардлага хангаагүй гомдлыг буцаасан	2	0.6
Нийт		360	100

Цагдан хорих байранд эмнэлгийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байгаа ч анхаарал татсан зарим хоригдогсдыг дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх, нэн шаардлагатай эмчилгээг хийхгүй хойшлуулах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг хугацаанд нь татаж аваагүй, эмчилгээний хоолны стандарт нормыг мөрдөөгүй, зуны амралт, бүх нийтээр амрах баяр, амралтын өдрүүдэд хоригдогсдод үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж муудаж, хяналт сулардаг зэрэг асуудал Комиссын шалгалтын явцад илэрсэн. Түүнээс гадна эрсдэл өндөртэй ажлын байранд ажиллах сонирхол бүхий эмнэлгийн мэргэжилтэй хүний хомсдол үүссэн хэвээр байна.⁷⁶

Тухайлбал Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид хоригдож байхдаа эрүүл мэндийн шалтгаанаар нас барсан Б.О-ын эрүүл мэндийн байдал хэвийн бус байсан, дараагийн шатны эмнэлэгт шилжүүлж нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд яаралтай хамруулах, шаардлагатай эмчилгээг цаг алдалгүй үзүүлэх нөхцөл байдал үүссэн байсан гэж Комисс дүгнэсэн.

2024 оны 08 дугаар сард Хөвсгөл аймгийн цагдан хорих төвд хийсэн хяналт шалгалтын үеэр хоригдогч Д.Ү-ийн нөхцөл байдалтай танилцахад цээжний зүүн доод хэсэг, суганы доод талд өмнө орсон гэх хагалгааны ил харагдах, нээлттэй ажилбартай шарх (нээлттэй байх заалттай), тэр хэсэгт ариун цэврийн шаардлага хангаж, ариутгасан эсэх нь тодорхойгүй 20х40 харьцаатай даавуу мэт зүйлийг дөрвөлжилж онгорхой хэсэг дээр тавьсан, үзлэг хийх үед эвгүй үнэртэй, цайвар ногоон өнгийн бохир шингэн зүйлс гарсан байдалтай, биеийн байдал таагүй шинжтэй байсан, мөн хоригдогч Д.Д “...зүүн талын нүд юм харахгүй, байнгын хатгаж өвддөг. Өдөр ирэх тусам баруун нүдний хараа муудаж байгаа талаараа дурдаж, хагалгаанд орох заалттай эмчлүүлж байсан боловч цагдан хорих байр

⁷⁶ Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/142, А/47 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-ын 2.3-т “Хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн нь хоригдсон этгээдийн эмнэлгийн тусламж авах хүсэлтийн дагуу цаг алдалгүй, эрүүл мэндийн үзлэг хийж, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хамруулна”.

шилжүүлэн хорих шүүгчийн захирамж гарсантай холбоотойгоор төлөвлөгдсөн нүдний хагалгааг хийлгэлгүйгээр Хөвсгөл аймаг дахь цагдан хорих байранд шилжүүлэн авч ирснээр миний эрүүл мэндийн байдал дордож, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг зөрчиж байгаад санаа зовниж байна” гэжээ.⁷⁷

Дээрх нөхцөл байдлуудаас үндэслэн хүний эрүүл мэндийг үл хайхрах, шийдвэр гарсан нэрээр өөрсдийн харьяаллаас холдуулах байдлаар хүнлэг бус харьцсан явдал тогтоогдсон бөгөөд Комиссын гишүүний зөвлөмж хүргүүлж эмчилгээнд хамруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг стандартад нийцүүлэх арга хэмжээ авсан.

Хуульд заасан үндэслэл журмын дагуу жирэмсэн эмэгтэй болон өсвөр насны хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. 2024 онд Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид өсвөр насны 27 яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд тэдний 25 нь эрэгтэй, 2 нь эмэгтэй хүүхэд байжээ. Эдгээр өсвөр насны хоригдогч нарыг хэргийн зүйл ангиар авч үзвэл хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэгт 4, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 3, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 3, хүний халдашгүй чөлөөтэй байхын эсрэг гэмт хэрэгт 1, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт 24 хүүхэд тус тус хоригджээ.⁷⁸

2025 оны 03 дугаар сарын байдлаар тус цагдан хорих байранд 20 хүүхэд хоригдож байгаагаас 2 хүүхэд өмгөөлөгчгүй бол 2 хүүхэд ар гэрийн боломж бололцоо тааруу, хөдөө орон нутагт ар гэрийнхэн нь байдгаас шалтгаалж эргэлт, уулзалт огт аваагүй байдалтай байна.

Цагдан хоригдож байгаа хугацааны хувьд 13 хоногоос 9 сар хүртэл хугацаагаар хоригдож байгаа бөгөөд шүүгчийн захирамжид хүүхэд бүр ерөнхий боловсролын сургуульд суралцдаг талаар мэдээлэл оруулсан байх боловч биечилсэн уулзалтын үеэр тэдний 90 орчим хувь нь сургуулиасаа хөөгдсөн, эсхүл өөрийн хүслээр сургуулиа орхисон гэх мэдээлэл өгсөн. Тэдэнд хоригдож байх хугацаанд нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа сургалтын хөтөлбөрийн дагуу явуулах ажил хангалтгүй байна.

Тохиолдол 6.14

...Цагдан хорих ангийн зүгээс ерөнхий боловсролын хичээлийг тогтмол явуулдаггүй, хүүхдүүдийн нас болон боловсролын түвшнийг харгалзахгүйгээр сардаа 1-2 удаа зурагтаар теле хэлбэрээр түүх, монгол хэл, иргэний ёс зүй зэрэг хичээлийг өрөөний гадна талаас зурагтаар үзүүлж, бичгийн цаасан дээр хуулбарласан тест бөглүүлэх, бодлого бодуулах зэрэг аргачлалаар явуулж байна. Тус хичээлүүдийг цагдан хорих ангийн багшлах эрхийн гэрчилгээгүй ангийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ордог бөгөөд батлагдсан сургалтын хөтөлбөргүй байв...

(Комиссын хяналт шалгалтын илтгэх хуудаснаас)

Цагдан хорих ангид 2024 онд нийт 20 жирэмсэн эмэгтэй цагдан хоригдсоноос давхардсан тоогоор 19 эмэгтэйг жирэмсний хяналтын үзлэгт хамруулж, 3 эмэгтэйг гадна эмнэлэгт хэвтүүлж, 1 жирэмсэн эмэгтэйн ураг өсөлтгүй болсон тул ургийг авхуулах ажилбарыг мэргэжлийн эмнэлэгт хийлгэсэн байна. Тухайн онд ангийн эмнэлэгт давхардсан тоогоор 12 жирэмсэн эмэгтэй хэвтэн эмчлүүлжээ. 2025 оны 03 дугаар сарын байдлаар 4 жирэмсэн эмэгтэй цагдан хоригдсон байх бөгөөд 3 эмэгтэйг жирэмсний хяналтын үзлэгт хамруулж, дутуу зулбасан оноштой 1 эмэгтэйг Амгалан амаржих газарт хэвтүүлж, ургийг авуулах ажилбар хийлгэжээ. 2024, 2025 онд хоригдож байсан 2 жирэмсэн эмэгтэйг гадна эмнэлэгт хэвтүүлж амаржуулсан байна.

6.9. ХИЛЭЭР ГАРАХЫГ ХОРИГЛОХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

ЭХХШТХ-ийн 14.5 дугаар зүйлд хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хуульчилсан бөгөөд тус зүйлийн 1 дэх хэсэгт “Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан

⁷⁷ Комиссын гишүүний 2024 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн 06/45 дугаар зөвлөмж.

⁷⁸ Комиссын 2025 онд хийсэн хяналт шалгалтын дүн мэдээ.

сэргийлэх зорилгоор... Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах... таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ” гэж заасан.

Шүүн таслах ажиллагааны мэдээнээс үзэхэд шүүх Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг 2023 онд 806, 2024 онд 634 хүнд авсан нь өмнөх онтой харьцуулахад 172 хүн буюу 21.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 6.8 Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээ авсан шүүгчийн захирамж⁷⁹

№	Утга	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Нийт
1	Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах тухай	399	158	445	806	634	2442


Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээ авсан шүүгчийн захирамжийг холбогдох байгууллагууд болон Хил хамгаалах байгууллагад хүргүүлж, Улсын хилээр үл нэвтрэх, саатуулах иргэний жагсаалтад оруулснаар уг арга хэмжээ хүчин төгөлдөр болж байна.

ЭХХШТХ-ийн 14.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт уг “таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэнэ” гэж зааснаас үзэхэд цуцлах асуудлыг мөн төрийн эрх бүхий байгууллага албан тушаалтан хариуцаж, холбогдох иргэнийг мэдээллээр хангах үүрэгтэй.

Комисст авагдсан мэдээллээр Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг цуцалсан тухай шүүхийн шийдвэр гардаг боловч дээр дурдсан албан тушаалтан хил хамгаалах байгууллагад энэ талаар мэдэгдэж хилээр чөлөөтэй зорчин гарах боломжийг цаг тухайд нь бүрдүүлээгүйгээс иргэдийн Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан “...гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн үндсэн эрх зөрчигдөж байна.

Хил хамгаалах байгууллагын мэдээллээс үзэхэд, 2025 оны 3 дугаар сарын байдлаар улсын хилээр үл нэвтрэх, саатуулах иргэний жагсаалтад бүртгэлтэй 9594 хүн байгаа бол Улсын хилээр үл нэвтрүүлэх хүмүүсийн жагсаалтад бүртгэлтэй эсэхээ мэдэх зорилгоор 2024-2025 онд нийт 1088 хүн лавлагаа авсан байна. Харин улсын хилийн боомтоор гарах чиглэлд бүртгүүлсэн боловч хязгаарлалтын улмаас хилээр гарч чадалгүй буцсан иргэд 541 байсан бол тэдний 26 нь уг асуудлыг шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол гаргажээ.⁸⁰

Бүдүүвч 6.3 Монгол Улсын хилээр үл нэвтрэх, саатуулах иргэний жагсаалтад бүртгэлт, хилээр гарч чадалгүй буцсан, гомдол гаргасан иргэд



Иймээс улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн, санал гаргасан албан тушаалтан уг арга хэмжээг цуцалсан бол энэ талаарх мэдээллийг холбогдох иргэнд

⁷⁹ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн 2020-2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.
⁸⁰ Комисст Хил хамгаалах ерөнхий газрын 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн 1/592 дугаар албан бичгийн хавсралт.

мэдээлэх, хил хамгаалах байгууллагад холбогдох саналыг хүргүүлж шийдвэрлэж хэвших нь зүйтэй.

Шүүх, прокурорын байгууллагын зүгээс хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ЭХХШТХ-д заасан яллагдагч биш хүмүүст хуульд заасан үндэслэл журмаас гадуур Монгол Улсын хилээр гарах хязгаарлалт тогтоох арга хэмжээг дур мэдэн үргэлжлүүлэн хэрэглэж, 4 сар 26 хоногийн турш эрүүл мэнд, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд хохироосон бөгөөд цаашид үүнтэй ижилхэн нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Тохиолдол 6.15

“...Нийтийн тээврийн автобус худалдан авахтай холбоотой гэмт хэрэгт холбогдуулан БНСУ-ын иргэн И, К нарыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр яллагдагчаар татаж, зарим яллагдагч нарт холбогдох зарим хэргийг хэрэгсэхгүй болгох тухай 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Нийслэлийн прокурорын газрын нэр бүхий прокурорын шийдвэрээр тэдэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, уг тогтоолын 2 дахь хэсэгт Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах болон хэргийн оролцогч нартай уулзахыг хориглох хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг тогтоол хүчин төгөлдөр болмогц хүчингүй болгуулахаар шүүхэд санал хүргүүлэх⁸¹ талаар дурдсан хэдий ч Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн захирамжаар таслан сэргийлэх арга хэмжээг цуцлах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож, уг шийдвэрт гомдол гаргах эрхтэй гэж дурджээ. Улмаар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр уг таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэжээ...”

(Комисст 2024 онд ирүүлсэн гомдлоос)

Комисст авагдсан баримтуудаас үзэхэд уг арга хэмжээг цуцлахгүй байсан үндэслэл нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед БНСУ-ын иргэн И, К нартай холбоотой нотлох баримт гарч ирж болзошгүй талаар бусад оролцогчид санал хүсэлт гаргасантай холбоотой байна.

Дээрх баримтуудаас дүгнэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчсөн шинжтэй хэд хэдэн анхаарал татсан асуудал гарсан. Үүнд: 1) Эрүүгийн хэргийн оролцогч бус хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авсан; 2) Шүүгч, прокурорын зүгээс гэм буруутайд тооцож болох нотлох баримт илэрч болзошгүй гэж урьдчилан тогтоож, таамаглалаар хүний эрхийг хязгаарласан; 3) Прокурорын байгууллагаас яллагдагчаар татсан тогтоолыг хэрэгсэхгүй болгосон даруйд таслан сэргийлэх арга хэмжээ цуцлах саналаа шүүхэд хүргүүлэх үүргээ биелүүлээгүй; 4) Хүний эрх зөрчигдсөн нөхцөл байдал үүссэн байхад шүүх хуульд заасны дагуу цуцлах арга хэмжээ аваагүй зэргийг дурдаж болно.⁸²

Дээрх эс үйлдэхүй нь ИБУТЭТОУП-ын 14 дүгээр зүйлийн 2-т заасан “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугийд тооцогдох эрхтэй”, мөн пактын 12 дугаар зүйлийн 2-т “Хүн бүр аливаа улсыг... орхин явах эрхтэй”, ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн хэм хэмжээг тус тус зөрчжээ.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээг хуульд нийцүүлэн хэрэглэхгүй, шударга бус хандаж байгаагаас шалтгаалан хэргийг аль болох богино хугацаанд шийдвэрлэх боломж бүрдэхгүй, улмаар бусад оролцогчдын эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсэж байна. Ялангуяа улс төрд нөлөө бүхий этгээд, авлига албан тушаалын гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүмүүст Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээ авахгүй, эсхүл цуцалсантай холбоотойгоор мөрдөн

⁸¹ Нийслэлийн Прокурорын газрын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар Прокурорын тогтоол.

⁸² Сахилгын хорооны 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн ГЗТ/2024/0084 дугаар захирамж.

байцаалтыг түдгэлзүүлэх, бусад оролцогчдын эрх зүйн байдал дордох нөхцөл байдал үүсэж байна.

Тохиолдол 6.16

“... миний нөхөр Р (БНХАУ-ын иргэн) 2021 онд бусдаар дамжуулан карьер олборлох зөвшөөрөл хүсэж байгааг далимдуулан 10,000,000.00 (арван сая) төгрөгийг ...аймгийн эрх бүхий албан тушаалтан манай нөхөр Р-ээс авсан. Энэ талаар нөхөр бид хоёр Авлигатай тэмцэх газарт гомдол гаргаж, мөрдөн шалгах ажиллагаа явагдаж, мөнгө авсан Ш.О болон манай нөхөр Р-д ч эрүүгийн хэрэг үүсгэсэн. Мөн тус эрүүгийн хэргийн холбогдогч нарт таслан сэргийлэх арга хэмжээг авч, Монгол Улсын хилээр гарахыг хориглосон. Нийслэлийн прокуророос асуухад Ш.О нь ...гадаад улсад дипломат ажилтнаар томилогдсон тул хэргийг түдгэлзүүлсэн гэсэн. Миний нөхөр Р-д холбогдох хэргийг шийдвэрлэхгүй удааж, хилээр гарах хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөөгүйгээс бидний олон эрх зөрчигдөж байна...”

(Комисст 2024 онд ирүүлсэн гомдлоос)

Дээрх гомдлын дагуу Комисс хуульд заасан хүрээнд шалгах ажиллагаа явуулж ИБУТЭТОУП-ын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй” гэсэн заалт, Дипломат харилцааны тухай Венийн конвенцын 31 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг удирдлага болгон холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлэсэн.⁸³

Цаашид эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, оролцогчдын санал хүсэлтийг шийдвэрлэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлах, шүүх, прокурор, мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын хүний эрхийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, хууль зөрчсөн, ёс зүйн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлагыг шударгаар оногдуулахад анхаарах хэрэгтэй.

6.10. ХОРИХ ЯЛ БА ХОРИХ АНГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллага 1990 онд Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм⁸⁴ (Токиогийн дүрэм)-ийг баталж гишүүн орнуудад хорих ялын хэрэглээг бууруулж, хувилбарт арга хэмжээг нэвтрүүлэх, гэмт хэрэгтнийг нийгэмд эргэн нэгтгэх, нийгмийн шударга ёсыг хангах, хүний эрхийг хамгаалах зорилгоор эрүүгийн хууль тогтоомжийг оновчтой болгохыг уриалсан. Энэхүү дүрэм нь хорих ялаас татгалзах, хорихоос бусад төрлийн шийтгэлийг өргөн хэрэглэх зарчмын суурийг тавьсан чухал алхам болсон.

Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хууль нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлаж урт хугацаанд хорихоос татгалзаж, хорихоос өөр төрлийн ялын бодлогыг хэрэгжүүлэх замаар иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх үзэл баримтлалыг удирдлага болгосон нь тодорхой үр дүнд хүрсэн байна.


Шүүхийн шийдвэрээс үзэхэд шүүхээс 2015 онд нийт 7696 хүнд ял оногдуулахдаа 5757 хүн буюу 75 хувьд нь хорих ял, 370 хүн буюу 5 хувьд нь торгох ял шийтгэл оноож байсан бол 2024 онд нийт 14663 хүнд ял оногдуулсны 2505 хүн буюу 17 хувьд нь хорих ял, 8811 хүн буюу 60 хувьд нь торгох ял оноожээ. Өөрөөр хэлбэл 2015 онтой харьцуулахад хорих ял оногдуулах байдал 50 орчим хувиар буурсан үзүүлэлттэй байна.⁸⁵

⁸³ Комиссын гишүүний 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 06/1005 дугаартай гомдол шилжүүлэх тухай албан бичиг.

⁸⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм”. Ерөнхий Ассамблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний 45/110 дугаар тогтоолоор батлагдсан.

⁸⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн 2015-2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.

Бүдүүвч 6.4 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хорих ял оноосон байдал (2015-2024 он)⁸⁶



Шүүхээс тодорхой гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хорих ял оногдуулахдаа аль болох богино хугацаагаар оногдуулж байна. Улсын хэмжээнд 2015 онд нийт хорих ял оногдуулсан хүний 57 хувьд 1-3 жил, 43 хувьд 3-аас дээш жилийн хорих ял оноож байсан бол 2024 онд хорих ял биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн хүний 68 хувьд нь 6 сараас 3 жил, 32 хувьд нь 3-аас дээш жилийн хорих ял оноожээ.

Хэдийгээр хорих ял оногдуулахаас татгалзаж байгаа ч хоригдлын тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь хорих байгууллагын ачаалал, төсвийн зардалд сөргөөр нөлөөлж эрүүдэн шүүх буюу бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх эрсдэл нэмэгдүүлж байна. ШШГЕГ-ын мэдээллээс үзэхэд 2021 онд 3044 хоригдол ял эдэлж байсан бол 2022 онд 4157 болж 36.5 хувиар, 2023 онд 4526 болж 8.9 хувиар, 2024 онд 4565 болж 0.9 хувиар, 2025 оны 01 дүгээр улирлын байдлаар 4591 болж 0.6 хувиар тус тус өссөн байна.⁸⁷

ШШГЕГ-ын харьяанд нээлттэй 7, хаалттай 7, нээлттэй хаалттай 6, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих хаалттай анги, нийт 22 ангид хорих ял эдлүүлэх ажиллагааг Прокурорын байгууллагын хяналтад гүйцэтгэж байна. Хорих ял эдлүүлэх ажиллагааг НҮБ-аас батлан гаргасан “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм”, “Хоригдолтой харьцах үндсэн зарчим” болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулж байна.

Комисс 2024 онд хоригдол, хоригдогчоос 360 гомдол, мэдээллийг хүлээн авч холбогдох ажиллагаа хийж, 155 хүнд хууль зүйн зөвлөгөө өгч, төв, орон нутгийн 11 хорих ангид хяналт шалгалт хийж, нөхцөл байдалтай танилцаж, Комиссын гишүүний 7 шаардлага, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Хорих ял эдлүүлэх орчин нөхцөлд гарсан зэрэг өөрчлөлт

Хорих ангиудын эргэлт, уулзалт, хоригдлын байрт засвар шинэчлэлийг хийх, хоригдлын хоолны чанар, нэр төрөл, илчлэгийг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал гарч,⁸⁸ зарим ангиудад хэрэгжиж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хоригдлыг нийгэмшүүлэх, хорих ялын бодлогыг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах чиглэлд зохих хэмжээнд төсөв нэмэгдсэн байна.

⁸⁶ Мөн тэнд.

⁸⁷ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаартай албан бичиг.

⁸⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/352 дугаар тушаалаар батлагдсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, баривчлагдсан этгээд, албадан эмчлүүлэгч, хоригдлын хоногийн хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм”, мөн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаал.

Бүдүүвч 6.5 Хорих ангиудад гарч буй эерэг өөрчлөлтүүд

409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги

Хоолны чанарыг сайжруулж, урт хугацааны эргэлт уулзалтын байрыг стандартын дагуу шинэчлэн тохижуулсан.

405 дугаар хаалттай хорих анги

Алба хаагчдын ажлын өрөөг засварласан.

421 дүгээр нээлттэй хорих анги

Түр хугацааны уулзалтын өрөөний хоригдол болон ар гэрээс ирсэн иргэдийг уулзалтын үед тусгаарлах зорилготой шилэн хаалтыг авч, ар гэртэйгээ чөлөөтэй уулзах боломжийг бүрдүүлсэн.

407 дугаар хорих анги

Нярай хүүхэдтэй эхчүүдийн байрыг шинэчлэн өргөтгөж, зай талбайг нэмэгдүүлсэн, гадна талд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн.

407, 409, 415, 445, 423 дугаар хорих ангиуд

- Хоригдлыг "Суллагдахад бэлтгэх байр"-ыг шинээр барьж ашиглалтад оруулсан.

413 дугаар хорих анги

- "Суллагдахад бэлтгэх байр"-ыг барихаар төлөвлөсөн.

Түүнчлэн алба хаагчдын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, цалин хөлс, тэтгэмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн сул орон тоог нөхөх, хүний эрхийн сургалтыг тогтмолжуулах арга хэмжээг авчээ. "Хоригдлыг нийгэмшүүлэх, суллахад бэлтгэх хөтөлбөр"-ийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж хэвшжээ.⁸⁹

Комиссын хяналт шалгалт, олон улсын хүний эрхийн тусгай механизм, илтгэгч нараас өгсөн зөвлөмжийн хүрээнд дараах асуудлуудад тогтмол анхаарч, ахиц дэвшил гаргаж, үр дүнг тооцож байх нь НҮБ-ын хоригдогсодтой харьцах жишиг дүрэмд нийцэх юм.

Хорих ангийн барилга, дэд бүтэц

Комиссын хяналт шалгалтын дүнгээр хорих ангийн орчин нөхцөл, дэд бүтэц харилцан адилгүй, зарим хорих анги, цагдан хорих байрын барилга байгууламж, хуучирч муудсан, уулзалтын байрны өрөө, тасалгааны тохижилт, гэрэлтүүлэг муу, тавилга, эд хэрэгсэл хуучирсан нөхцөл байдалтай хэвээр байна. ШШГЕГ-аас хорих ангийн барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шат дараатайгаар шинэчлэн барьж, засварлаж байгаа хэдий ч хорих ангиудын хоригдлын байр, гал тогоо, эмнэлгийн нэгж, халуун усны байр, халаалт, дулааны болон материаллаг хэрэгцээ шаардлагын асуудлыг цогцоор шийдвэрлэх шаардлагатай байна.

Ялангуяа, 401 дүгээр хаалттай хорих ангийн нэгдсэн эмнэлгийн барилгын дээвэр, барилгын гадна талыг шинэчлэн завсарлах, 407 дугаар хорих ангийн эмнэлгийн хэсэг гаднаа ариун цэврийн байгууламжтай, гар угаалтуурт ус зөөвөрлөн хэрэглэдэг асуудлыг шийдвэрлэх, Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 445 дугаар нээлттэй хорих ангийн барилгын инженерийн далд шугам сүлжээ, насос, тоног төхөөрөмжийг бүрэн засварлах, 421 дүгээр нээлттэй хорих ангийн хамгаалалтын хэрмэн хашааг нурааж шинээр барих, төвлөрсөн бохир усны системд холбогдоогүй 12 хорих анги, байгууллагад бохир усны системийг шинэчилж саарал ус боловсруулах шаардлага үүссэн.⁹⁰

Зарим хорих анги ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн хаяж байгаа нь хүрээлэн буй орчин, байгаль экологи, хүн, малын эрүүл аюулгүй байдалд шууд нөлөөлөх нөхцөл байдал үүсгэж, уулын хормой, ойр орчмын айл, өрхүүдийн хашаа, гэр лүү бохир ус халин орж

⁸⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаартай албан бичиг.

⁹⁰ Комиссын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/1492 дугаартай албан бичгээр УИХ-ын ХЗБХ-нд хүргүүлсэн дүгнэлт.

хөлдсөн асуудал 2021-2023 онд тус тус гарсан бөгөөд энэ нөхцөл байдал дахин давтагдах эрсдэл үүссэн хэвээр байна.⁹¹

Насанд хүрээгүй хүмүүст оногдуулсан эрх чөлөөг хасах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа сургалт хүмүүжлийн тусгай байгууллага (сургууль)-ын барилга байгууламжийг стандартад нийцүүлэн шинэчлэх ажил удаашралтай байгаа бол эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар ангийн барилга байгууламжийг шинэчлэх ажил огт эхлээгүй байна.

Хорих ангийн багтаамж

Олон улсын стандарт, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дотоодын хууль тогтоомжийн дагуу нэг хоригдолд 2.5 м.кв талбай ногдохоор заасан ч хорих ангийн байршил, тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдлаас хамаарч 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 10 хорих ангид хоригдлын тоо 2-48 хувиар хэтэрсэн байдалтай байна.⁹² Тухайлбал улсын хэмжээнд ганц байдаг эмэгтэйчүүдийн 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн ачаалал, багтаамж 34.1 хувиар хэтэрч, эмнэлгийн хэсгийн зарим өрөөг хоригдлын өрөө болгон ашиглаж байна.

Хоолны хүртээмж, илчлэг

Комиссын хяналт шалгалтын явцад төсвийн хүрэлцээгүй байдал, хорих ангид үйлдвэрлэл явуулдаг, явуулдаггүйгээс шалтгаалан хоолны чанар хүртээмж харилцан адилгүй байгаа нь тогтоогдсон. Ялангуяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангиас энэ талаар гомдол, санал их ирж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас нормд тусгагдсаны дагуу хоолны хүртээмж чанарыг сайжруулах, хүнсэнд мах хэрэглэхэд шаардагдах төсвийн тооцоолол хийж, жил бүр төсвийг нэмэгдүүлж байна. Тухайлбал 2024 онд зөвхөн хоол, хүнсний зардалд 10.5 тэрбум төгрөг зарцуулсан⁹³ бол 2025 онд хоригдлын хоол хүнсний зардалд улсын төсвөөс 12.9 тэрбум төгрөг тусгаж, өмнөх оноос 2.5 тэрбумаар нэмэгдүүлсэн⁹⁴ боловч салбарын хэмжээнд хоолны хангалт жигд сайжрахгүй байна.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төсөв

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн 4 эмнэлэг, цагдан хорих байр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих ангийн эмнэлгийн 42 хэсэг үйл ажиллагаа явуулж байна. ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэгт сүүлийн 5 жилийн хугацаанд 14709 хоригдолд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснээс сэтгэцийн тулгамдсан асуудалтай (давхардсан тоогоор) 7960 (54.1 хувь) хоригдол байна. Хүнд өвчний улмаас 2024 онд 23, 2025 онд 5, нийт 28 хоригдол холбогдох журмын дагуу ялаас чөлөөлөгджээ.⁹⁵

Эмч, эмнэлгийн ажилтны орон тоо дутуу, эм, эмнэлгийн хэрэгслийн зах зээлийн үнэ жил ирэх тусам өсөж байгаатай холбоотойгоор шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад тухайн жилийн төсөв хүрэлцдэггүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж муу, ихэвчлэн өвчин намдаах, артерийн даралт бууруулах, хоол боловсруулах эрхтэнд хэрэглэх эм, тариа болон яаралтай тусламжийн эм, тариаг авдаг. Мөн цагдан хорих, хорих ангид эхчүүд амаржих, жирэмсний хяналтын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ авах, хорт хавдрын оноштой, сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй, мансуурах, согтуурах донтолттой, хүнд хэлбэрийн хагалгааны дараах тусламж үйлчилгээ авах шаардлагатай

⁹¹ Комиссын гишүүний 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 06/40 дугаартай зөвлөмж.

⁹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 01/2396 дугаартай албан бичиг.

⁹³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 01/2396 дугаартай албан бичиг.

⁹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаар албан бичиг.

⁹⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаартай албан бичиг. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Журам, жагсаалт шинэчлэн батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/48, А/70 дугаар тушаал.

хоригдогч болон хоригдол түгээмэл байгаа нь олон төрлийн эрсдэлийг үүсгэж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн төсөв нэмэгдсэн хэдий ч нэг хоригдолд оногдох нэг сарын төсөв харилцан адилгүй байна. Тухайлбал 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид 4900 төгрөг, 405 дугаар хаалттай хорих ангид 7750 төгрөг, 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангид 7500 төгрөг, 421 дүгээр нээлттэй хорих ангид 8000 төгрөг байна. Хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр зэрэг 56 нэгжид 1138 ширхэг 56 нэр төрлийн, нэгдсэн болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг болон 401, 429, 461 дүгээр хаалттай ангийн эмнэлгүүдэд 273 ширхэг, 110 нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмж дутмаг байгаа судалгаа гарчээ.⁹⁶

Комиссоос 407, 421, 409 дүгээр хорих ангид ял эдэлж буй 274 хоригдлыг хамруулан авсан санал асуулгын дүнгээр тэдний 73 нь буюу 27 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээг хугацаанд нь авч чаддаггүй гэж хариулсан бол 108 нь буюу 39 хувь нь эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ муу байдаг гэж хариулжээ.

Нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ

Хорих ангиудын төсөвт сургалт, нийгмийн ажил болон номын сангийн баяжилт, үйл ажиллагаанд зориулсан санхүүжилт хангалтгүйгээс сургалтын хэрэглэгдэхүүнийг дотоод нөөц бололцоо, төрийн бус байгууллагын дэмжлэгээр баяжуулах тохиолдол нийтлэг байна. Хорих ял эдлээд суллагдсан иргэдийн дунд явуулсан судалгаагаар 56 хувь нь хорих ангид явуулдаг сургалт үр дүн муутай, ач холбогдолгүй байна гэжээ. ШШГЕГ-ын даргын тушаалаар баталсан “Хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-т тусгагдсан сургалт, нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ хорих анги бүрд харилцан адилгүй зохион байгуулагдаж байгаад дүгнэлт хийж, сайжруулах шаардлагатай. Санал асуулгад оролцсон хоригдлуудаас “чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?” гэж асуухад 56.6 хувь нь ном сонин уншдаг, 7.6 хувь нь тийм боломж байдаггүй, 12.8 хувь нь угаалга, хатаалгын өрөөнд өнгөрөөдөг, 6.7 хувь нь суралцдаг, 7.8 хувь нь зөвшөөрөгдсөн спортоор хичээллэдэг, 4.0 хувь нь шашны зан үйл үйлддэг гэж хариулсан бол нийт оролцогчдын 68.4 хувь нь сургалтын өрөө танхим тохижилт муу гэжээ.

Эргэлт, уулзалт авах, өргөдөл гомдол гаргах эрх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан удаан хугацааны уулзалтыг зохион байгуулах байрны өрөө, түүний зохион байгуулалт харилцан адилгүй, дотоод нөөц бололцоогоор тохижуулсан шинжтэй байна. Ихэнх хорих ангийн уулзалтын байрны өрөө, тасалгааны тохижилт, гэрэлтүүлэг муу, тавилга, хэрэгсэл хуучирч муудсан байдалтай байна.

Улсын хэмжээнд хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, эмэгтэйчүүдийн хорих анги Улаанбаатар хотод байрладгаас хамаарч гэр бүлээсээ хол, эргэлт уулзалтыг биеэр авах боломж хязгаарлагдах, ар гэрийнхний хувьд санхүү, цаг хугацааны хүндрэл бэрхшээл үүсэж, эргэлт уулзалтыг хуульд заасан боломжоор авч чадахгүй нөхцөл байдал бий болдог тохиолдол цөөнгүй байна.

Хоригдлуудаас өргөдөл, гомдол гаргах эрх нээлттэй ч шийдвэрлэлт хангалтгүй, ажлын байр хангалтгүй тул хөдөлмөр эрхлэхтэй холбоотой гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байдаг талаар мэдээлэл өгсөн. Комисст 2024 онд хоригдол, хоригдогчоос 360 гомдол, мэдээлэл ирснээс үзэхэд, өргөдөл гомдол гаргах эрх нээлттэй, хорих анги бүр санал хүсэл авах лац бүхий прокурорын хайрцгийг байрлуулсан байх бөгөөд 7 хоногт нэг удаа прокурор санал хүсэлттэй танилцдаг байна. Зарим хорих ангийн алба хаагч дотоод үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хүлээн авдаггүй, авсан ч дотооддоо шийдвэрлэдэг, хүний эрхийн болон бусад байгууллагад уламжилж өгдөггүй гэсэн мэдээллийг шалгалтын үеэр хоригдол болон хоригдогчид илэрхийлж байсан.⁹⁷ Хорих ангиас ирж байгаа гомдлын агуулгаас үзэхэд хорих ангитай холбоотой гомдол 10 орчим

⁹⁶ Комиссын 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/1492 дугаартай албан бичгээр УИХ-ын ХЗБХ-нд хүргүүлсэн дүгнэлт.

⁹⁷ Комиссын гишүүний 2024 оны 04/12 дугаар Зөвлөмж.

хувийг эзэлж байгаа бол хорих ангийн дотоод үйл ажиллагаа, хоригдол болон хоригдогчийн эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл ихэвчлэн ар гэр, өмгөөлөгч нараас ирж байна.

Цаашид удаан хугацааны уулзалтыг зохион байгуулах байрны орчин нөхцөлийг сайжруулах, хоригдлоос гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, хариу мэдэгдэх үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай юм.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлт

Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 4518 хоригдол ял эдэлж байснаас хорих ангийн үйлдвэрт 517, аж ахуйн үйлчилгээнд 2035, гэрээт хэсэгт 793, нийт 3345 хоригдол буюу нийт хоригдлын 74 хувийг ажлын байраар хангаж, 4,301.7 сая төгрөгийн цалин, хөлс бодсон байна.⁹⁸ Комиссын судалгаа болон хяналт шалгалтын дүнгээс үзэхэд хорих ангиас хоригдлыг оёдлын цех, гар урлал, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, мод бэлтгэл, модон эдлэлийн үйлдвэрлэл зэрэгт ажиллуулж байгаа нь энэ төрлийн ажил үйлчилгээ, ажлын байрын олдоц их байгааг илтгэж байна.

Гэвч Комиссоос хийсэн хяналт шалгалтаар прокурорын зөвшөөрөлгүй дур мэдэн хоригдлыг аж ахуйн нэгжид ажиллуулсан, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдөж ажиллагаагүйгээс хүний амь нас хохирсон тохиолдол гарч мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна. Комисс ШШГЕГ-т хууль бусаар, прокурорын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх нөхцөл байдлыг таслан зогсоож, ийм төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, шаардагдах арга хэмжээг нийт хорих анги байгууллагад авч хэрэгжүүлэх талаар Комиссын гишүүний шаардлагыг хүргүүлжээ.⁹⁹

Алба хаагчдын хөдөлмөрлөх эрх

Нийслэл, аймгийн төвийн ойролцоох хорих ангиудад алба хаагчдын усанд орох алжаал тайлах, сэтгэл зүйн зөвлөгөө авах, чанартай хоол хүнсээр хангагдах, тээврийн хэрэгсэл болон эрүүл мэндийн зардал зэрэг нийгмийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Ялангуяа, өөрийн үйлдвэр, үйл ажиллагааны тодорхой чиглэлгүй, хөрөнгө төвлөрүүлэх боломжгүй хаалттай хорих анги, тусгай нэгж, хүүхэд хүмүүжиж байгаа ангиудад ахуйн нөхцөл эрс муу байгааг бодлогын түвшинд тогтмол анхаарч, ахуйн нөхцөлийг сайжруулах шаардлагатай. Мөн хаалттай хорих ангийн алба хаагчид сэтгэл зүйн хувьд таагүй орчинд хоригдолтой ажиллаж, онц ноцтой гэмт хэргийн талаар хүнд хэлбэрийн мэдээлэл тогтмол авдаг ч сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагддаггүй, тусгай нэгжид хоригдолтой харилцах стандарт журмыг нарийвчлан тодорхойлоогүй байна.

Ажиллах орчин нөхцөл, ажлын ачаалал, стрессээс шалтгаалан алба хаагчид сайн дураараа ажлаас гарч байгаагаас салбарын хэмжээнд батлагдсан орон тооноос тогтмол дутуу алба хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Ажлын ачаалал, стресс бухимдлаас шалтгаалан ажлын хариуцлага алдах, ажлаас халшрах, хоригдолтой зүй бус харьцаж эрх чөлөөнд нь халдах явдал гарч байгаа бөгөөд хариуцлага алдсан алба хаагчдад тухай бүр хариуцлага тооцсон байна. Тухайлбал 2024 онд алба хаагчдын зүгээс ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, сахилга хариуцлага алдсан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн 211 алба хаагчид хариуцлага тооцсон бол алба хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, алба хаагчийн биед халдсан, хэл амаар доромжилсон 44 хоригдолд арга хэмжээ авчээ.

Албаны мэдээллээс үзэхэд нэг алба хаагч “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д зааснаас 3-4 дахин их хоригдол, хоригдогчид хяналт тавьж байгаа нь харуул хамгаалалтыг дөрвөн ээлжээр зохион байгуулах боломжгүй нөхцөл байдалтай, хоригдол, хоригдогчийн зүгээс алба хаагчийн

⁹⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаартай албан бичиг.

⁹⁹ Комиссын гишүүний 2024 оны 06/27 дугаар Шаардлага

хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх, алба хаагчийн биед халдах, хууль, журам, хорих ангийн дотоод цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдөхгүй, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж буй гол шалтгаануудын нэг болж байна гэжээ¹⁰⁰.

Хорих анги, цагдан хорих байрны хоногийн жижүүрийн харуул хамгаалалтыг холбогдох хуульд заасны дагуу дөрвөн ээлжээр зохион байгуулах, биечилсэн хяналтыг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д нийцүүлэн ажиллахад хүрэлцэхүйц орон тоогоор нэмэгдүүлэх, хорих анги, цагдан хорих төвд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатайг зөвлөж байна.

6.11. БАРИВЧЛАХ ШИЙТГЭЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙРНЫ ОРЧИН НӨХЦӨЛ

Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр шүүхээс баривчлах шийтгэлийг эдлүүлэх стандартын шаардлага хангасан баривчлах байрны асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа нь НҮБ-ын хоригдогсодтой харьцах наад захын жишиг дүрмүүдэд нийцэхгүй, дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

УИХ-аас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2017 онд баталсантай холбогдуулан мөн оны 06 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталж, тус хуулийн 3 дугаар зүйлд “Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд нийслэлд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аймаг, суманд цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ. Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг энэ зүйлд заасан хугацааны дотор үе шаттайгаар Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ” гэж заасан ч төсөв санхүү, хүний нөөцийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж 2025 оны 01 дүгээр 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Комиссын хяналт шалгалтын дүн, авагдсан мэдээллээс үзэхэд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Булган, Орхон, Дундговь, Дорнод, Увс аймгийн баривчлах байруудыг цагдаагийн байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлсэн бол бусад аймгуудын хувьд хуулийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох төсөв, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлээгүй, үүнээс үүсэж болох үр дагаврыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2025 оны батлагдсан төсвөөс шалтгаалан баривчлах шийтгэлийг Цагдаагийн байгууллагаас авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 2 жилээр хойшлуулах саналыг Улсын Их Хуралд хүргүүлсэн¹⁰¹ талаар мэдээлэл ирүүлсэн бөгөөд одоогоор тус хууль батлагдаагүй.

ЦЕГ, ШШГЕГ-ын даргын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/106, А/60 дугаар хамтарсан тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх тухай хуулийн 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулж, ажлын хэсгийн шийдвэрээр Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Төв, Ховд, Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрууд баривчлах чиг үүргийг Цагдаагийн байгууллагаас хүлээн авсан талаарх мэдээлэл ирүүлсэн.¹⁰² Бусад орон нутаг дахь баривчлах байрыг шинээр барих болон засварлаж, шаардагдах орон тоо, төсөв, санхүүгийн зардлыг

¹⁰⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/2396 дугаартай албан бичиг.

¹⁰¹ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 3/1476 тоот албан бичгийн хавсралт.

¹⁰² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01/749 дугаар албан бичгийн хавсралт.

шийдвэрлэснээр баривчлах шийтгэл эдлүүлэх чиг үүргийг шилжүүлэн авах боломжтой байна гэж ХЗДХЯ үзэж байна.¹⁰³ Комиссын үзэж байгаагаар цаашид 10 аймаг, 4 сум, нийт 14 нэгжид баривчлах байрны барилга шинээр барих шаардлага үүссэн.

Түүнчлэн орон нутаг дахь цагдаагийн байгууллагын ашиглаж буй эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр нь зай талбай багатай, барилгын насжилт өндөр, барилгын суурийн давхарт байрладаг зэргээс хамаарч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Баривчлах байрны дотоод журам”-ын 2.2, 2.3, 2.4,¹⁰⁴ мөн сайдын 2020 оны А/192 дугаар тушаалаар баталсан “Саатуулах байрны дэглэм, журам”-д заасан эрүүлжүүлэгдсэн, албадан саатуулагдсан, шүүхийн шийтгэврээр баривчлагдсан хүмүүсийг эсрэг хүйсийн хүнээс тусгаарлах, байгалийн ердийн гэрэлтэй, салхивчтай байх, эрүүл мэндийн шалтгаантай этгээдийг тусгаарлах, насанд хүрээгүй этгээдийг тусгаарлах, хоолны өрөө, эмэгтэй, эрэгтэй бие засах өрөө тусдаа байх, нэг хүнд ноогдох зай, талбайн хэмжээ саатуулагдсан нэг хүнд 2 ам.метрээс доошгүй байна” гэсэн журмын хэрэгжилт хангалтгүй байгаа нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөд хүрч байгаа юм.

Комисс 2021-2024 оны байдлаар төв орон нутгийн эрүүлжүүлэх, баривчлах шийтгэл эдлүүлэх байранд 26 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж, холбогдох байгууллага албан тушаалтанд удаа дараагийн шаардлага, зөвлөмж хүргүүлж байсан ч үр дүн хангалтгүй байна. Энэ нь цагдаагийн алба хаагчдад ажлын ачаалал нэмэгдэх, үүнээс шалтгаалан эрхээ хасуулсан иргэдтэй дүрмийн бусаар, хүнлэг бус харьцах, цаашлаад иргэд эрүү шүүлтэд өртөх эрсдэлийг бий болгож байна. Түүнчлэн эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах шийтгэл эдлүүлэх ажиллагааг нэг байранд хэрэгжүүлснээр нэг хүнд ногдох стандарт хэмжээ алдагдах, хэт олон хүний бөөгнөрөл үүсэх, үүнээс улбаалан зохистой хоол хүнсээр хангагдах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эрүүл аюулгүй орчинд байх эрх хөндөгдөж байна. Мөн хэтэрсэн ачааллаас үүдэн баривчлах шийтгэл эдлүүлж буй хүнд явуулах зан үйлд нөлөөлөх сургалт, соён гэгээрүүлэх, бусад сургалт нөлөөллийн үйл ажиллагааг хэлбэр төдий явуулах, зорилтот үр дүнд хүрэхгүй байх нөхцөлийг бий болгож байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, баривчлах шийтгэл эдлүүлэх үйл ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүрэн шилжүүлэх зохион байгуулалтыг хийж, шаардлагатай барилга байгууламж болон хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, санхүүжилтийг хойшлуулахгүйгээр шийдвэрлэхийг зөвлөж байна.

6.12. ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ДАВЖ ЗААЛДАХ ЭРХ

Монгол Улсын шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Дүүргийн эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийг байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 41 шүүгчтэй, 144 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр шүүн таслах ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа¹⁰⁵ нь шударгаар шүүлгэх эрхийг баталгаатай эдлүүлэх, давж заалдах эрхээ бодитоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн томоохон дэвшил юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, хорих, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...”, 14 дэх заалтад “...шүүхийн шийдвэрийг давж заалдах, ...” гэж, ИБУТЭТОУП-ын 14 дүгээр зүйлийн 5-д “Ямар нэг гэмт хэрэгт шийтгүүлж ял заагдсан хүн бүр шийтгэгдсэнээ болон оноосон ялыг эргэж хянуулахаар хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй” гэж заасан.

¹⁰³ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 3/1476 дугаартай албан бичиг.

¹⁰⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/246 дугаар тушаал.

¹⁰⁵ Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны Анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газрын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 255 дугаартай албан бичиг.

Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр шүүхээс баривчлах шийтгэл хүлээсэн иргэдийн давж заалдах эрхийг холбогдох хуулиар баталгаажуулсан ч өнгөрсөн хугацаанд шүүхийн оновчгүй зохион байгуулалт, цаг хугацааны тохиромжгүй байдлаас шалтгаалан Үндсэн хууль, олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид заасан шүүхийн аливаа шийдвэрийг давж заалдах эрхийн хэрэгжилт хангалтгүй, улмаар хүний эрх зөрчигдөх нөхцөл байдал үүссэн.

Баривчлах шийтгэл нь ИБУТЭТОУП-ын 9 дүгээр зүйлээр хамгаалсан халдашгүй чөлөөтэй байх эрхийг хөнддөг бөгөөд нэг төрлийн хүний эрх чөлөөг хасаж байгаа онцгой арга хэмжээ юм. Тиймээс хүн бүр өөрийн эрх чөлөөг нь хасаж байгаа шийдвэрийн үндэслэлийг дээд шатны шүүхээр хянуулах, давж заалдах эрхтэй бөгөөд тийм бололцоо нөхцөлөөр хангагдсан байх ёстой.¹⁰⁶

Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна” гэж тус тус заасан.

Албаны мэдээллээс үзэхэд 2024 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс зөрчлийн хэрэгт 45507 хүнд шийтгэл оногдуулснаас 37 хувь буюу 16854 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан. Үүнээс Нийслэлийн хэмжээнд 20511 хүнд шийтгэл оногдуулснаас 7882 хүнд баривчлах шийтгэл оногдуулсан, тэдгээрийн 9 нь өсвөр насны хүн байна.¹⁰⁷

Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2024 онд нийт 875 зөрчлийн хэрэг хүлээн авч, 829 зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн нь нийт зөрчлийн хэрэгт шийтгүүлсэн хүний 1.9 хувь нь давж заалдахаар гомдол гаргасан үзүүлэлт юм. Харин баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдсан тохиолдол Нийслэлийн хэмжээнд 18 зөрчлийн хэрэг буюу 0.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6.9 Зөрчлийн хэрэгт завж заалдах гомдол гаргасан байдал, шийдвэрлэлт¹⁰⁸

№	Шийдвэрлэсэн байдал	Хэргийн тоо	Хувь
1	Гомдол эсэргүүцэл гаргасныг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.	383	46.2
2	Албадлагын арга хэмжээг хөнгөрүүлж эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.	238	28.7
3	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаасан.	157	18.9
4	Шийдвэрийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон.	51	6.2
Бүгд		829	100

ШШГЕГ-ын харьяа баривчлах шийтгэл эдлүүлэх 2 төв Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ба Комисс тус төвүүдэд хяналт шалгалт хийж, хүний эрхийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд дараах нөхцөл байдал илэрсэн.

Тус төвүүдэд 2024 онд нийт 7882 хүнд баривчлах шийтгэлийг эдлүүлснээс 14 хоногоос дээш хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулсан 13 хүн, 7 хоногийн баривчлах шийтгэл оногдуулсан 3 хүн нийт 18 хүн давж заалдах гомдол гаргаж шийдвэрлүүлсэн байна.¹⁰⁹

Давж заалдах шатны шүүх нийт хэлэлцсэн гомдлын 5-д нь буюу 27.7 хувьд оногдуулсан шийтгэлийн хоногийг бууруулж, 2-т нь буюу 11.1 хувьд оногдуулсан шийтгэлийг хойшлуулж, 2-т нь буюу 11.1 хувьд оногдуулсан шийтгэлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн

¹⁰⁶ General comment No. 35, paras. 12, International Covenant on Civil and Political Rights.
¹⁰⁷ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.
¹⁰⁸ Мөн тэнд.
¹⁰⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байрны 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/113 дугаартай албан бичиг, мэдээлэл.

бол бусад гомдлын шийтгэлийн биелэлтийг түдгэлзүүлж, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Зөрчлийн хэрэгт давж заалдах гомдол 2025 оны 01 дүгээр сараас нэмэгджээ.

Комиссоос Баривчлах төвд байсан хүмүүсээс авсан судалгаанд оролцогчдын 92 хувь нь өмгөөлөгчгүй, 43 хувь нь давж заалдах гомдол гаргах эрхээ мэдэхгүй гэж хариулжээ.

Тохиолдол 6.17

“...Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрийг бүрэн ойлгоогүй...”;
“...шүүхээс давж заалдах гомдол гаргах эрхтэйг дурдаагүй...”;
“...цөөхөн хоногтой юм чинь дахиад заргалдаад явж байх хооронд энэ хоног нь таарах байх...”;
“...анхан шатны шүүхийн тогтоолоо уншиж танилцаагүй болохоор албажиж ирэх хүртэл 5 хоног хүлээгээд, ирсний дараа гомдол гаргах эрхтэй гэж бодсон...”;
“...давж заалдахаар илүү хоног нэмж өгдөг гэж сонссон болохоор айгаад гомдол гаргаагүй...”;
“...хэрхэн яаж гомдол гаргаах мэдэхгүй”;
“...хуулийн нарийн юмыг нь мэдэхгүй болохоор шүүхээс өгсөн хоногийг нь аваад л ирсэн...”;
“...ямар зүйл ангиар баривчлагдсанаа ойлгоогүй, хэдэн тоо хэлээд л шүүх хурал дууссан...”

(Комиссоос Баривчлах төвд байгаа хүмүүстэй хийсэн ярилцлагаас)

Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргахгүй байгаа нийтлэг шалтгаан нь иргэдийн эрх зүйн мэдлэг тааруу, өмгөөлөгч хөлслөх, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдахгүй байгаатай холбоотойгоос гадна хууль, эрх зүйн ойлгомжгүй байдал, цаг хугацааны нөхцөлөөс ихээхэн шалтгаалж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш ажлын 5 өдрийн дотор бичгээр үйлдэж, оролцогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид гардуулан өгнө”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл эрх бүхий албан тушаалтан, оролцогч гомдол гаргаж, прокурор эсэргүүцэл бичиж болно”, мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан гомдол, эсэргүүцлийг ЭХХШТХ-ийн 38.1, 38.2 дугаар зүйлд заасан журмаар гаргана” гэж тус тус заасан. ЭХХШТХ-ийн 38.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оролцогч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болохыг зааснаас зөрчилд холбогдогчид шүүхийн шийдвэрийг гардан авсны дараа гомдол гаргаж болно гэж ойлгодог байна.

Тохиолдол 6.18

“...Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх зөрчлийн хэргийг тусгайлан бэлтгэсэн зориулалтын өрөөнд явуулж байсан. Шүүхээр зөрчил хянан шийдвэрлэх хэлэлцүүлгийн өмнө зөрчилд холбогдогчдыг хэсэг, хэсгээр нь нэгтгэн оруулж эрх, үүргийг нь бөөнд нь тайлбарлаж гаргаад, дараагаар нь тухайн хүнийг холбогдох асуудлыг нэг бүрчлэн хэлэлцэн шийдвэрлэж байлаа. Нэг хүнд холбогдох зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа 10-30 минутын хугацаанд үргэлжилж байна...”;
“...Зөрчилд холбогдогч нарыг тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн эрх бүхий албан тушаалтан хариуцаж шүүхэд хүргэх, шүүхийн шийдвэр гарсны дараагаар баривчлах төвд хүргэх үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна...”;
“...шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэр гармагц саатуулах, эрх чөлөөг нь хатуу хэлбэрээр хязгаарлах арга хэмжээ авахгүй байгаа ба ар гэрийнхэндээ мэдэгдэх, хувцас, хувийн бэлтгэлээ хангахыг даалгаж шүүхийн ойролцоо байхыг эсхүл цагдаагийн хэлтэс дээр тодорхой цаг зааж ирэхийг сануулж байна...”;
“...шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан хүмүүсийг ихэвчлэн 17-20 цагийн хооронд албаны тээврийн хэрэгслээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвүүдэд хүргэдэг байна...”

(Комиссоос Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн үйл ажиллагаа, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн ажиглалтын тэмдэглэлээс)

Дээрх ажиглалтаас үзэхэд зөрчилд холбогдсон иргэнд эрх үүргийг нь хуульд заасан журмын дагуу танилцуулдаггүй, 5-10 хүнд нийтлэг байдлаар танилцуулж байгаа нь ИБУТЭТОУП, Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хуулиар баталгаажуулсан “өөрт холбогдох хэргийн талаар” санал хүсэлт гаргах эрхийг хязгаарласан үйлдэл бөгөөд

баривчлах төвд шийтгэл эдэлж байгаа хүмүүсээс гаргаж байсан мэдээллийн агуулгатай ижил байна.

Нийслэлийн хэмжээнд 2024 онд 7882 хүнд оногдуулсан баривчлах шийтгэлийн хугацааг авч үзвэл 5338 хүн буюу 67.7 хувьд нь 7-10 хүртэл хоногоор баривчлах шийтгэл оногдуулжээ.¹¹⁰ Шүүхээс 7 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулсан тохиолдолд ихэвчлэн 5 дахь өдөртөө шүүхийн шийтгэврийг гардан авч давж заалдах гомдол, хүсэлт бичих, хуульчаас зөвлөгөө авах, хүргүүлэх шат дамжлагыг дамжих хугацаанд шийтгэлийн хоног дуусаад гардаг бөгөөд суллагдсаны дараа шүүхийн байгууллагаар явахаас төвөгшөөж гомдол гаргалгүй орхидог тохиолдол түгээмэл байна.

Хүснэгт 6.10 Нийт баривчлах шийтгэл оногдуулсан хугацаа (2024 он)

№	Баривчилсан хоног	Хүн		Нийт баривчлах шийтгэлд эзлэх хувь	Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй		
1	7-10 хоног	4992	346	67.7 %	5338
2	11-15 хоног	1145	49	15.1%	1194
3	16-20 хоног	720	29	9.5%	749
4	21-25 хоног	178	6	2.3%	184
5	26-30 хоног	377	17	5.0%	394
6	30-аас дээш хоног	21	2	0.3%	23
	Нийт тоо	7433	449	100%	7882

ШШГЕГ-ын харьяа Нийслэл дэх баривчлах төв, баривчлах байранд 2024 онд баривчлах шийтгэл эдэлсэн нийт 7882 хүнээс 3307 хүнийг шүүгчийн шийтгэврээр хүлээн авч, 4575 хүнийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 229 дүгээр тогтоол болон 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн баталсан 229 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт болох “Зөрчилд холбогдогчийг баривчлах төвд хүлээлгэн өгсөн тухай” 23 дугаар баримтаар хүлээн авсан байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргах шийдвэрийн хэлбэрийг хуульчилсан бөгөөд мөн зүйлийн 22.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.4-т зааснаас бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж, мөн хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах шийдвэрийг үндэслэн явуулна”, мөн хэсгийн 6.4.5-т “баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэр” гэж тус тус заасан.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор баталсан “Зөрчилд холбогдогчийг баривчлах төвд хүлээлгэн өгсөн тухай баримт” гэх бичгээр шүүхийн шийдвэрийг биелүүлж, хүний эрхийг хассан нь хүний эрхийг хязгаарлахад тавигдах хууль ёсны байх гэсэн шаардлагад нийцэхгүй бөгөөд уг баримтыг баривчлах шийтгэл эдэлж байгаа хүнд гардуулан өгсөн тохиолдол байхгүй байна. Түүнчлэн анхан шатны шүүхээс шүүгчийн шийтгэврийг танилцуулдаггүй, тухайн хүнд гардуулж өгдөггүй, баривчлах төвд хүлээлгэн өгсөн баримт, шийтгэвэр дээр баривчлах хоног, албадан сургалтын цаг зөрүүтэй ирдэг, цагдаагийн газарт саатуулагдсан хоногийг баривчилсан хоногт оруулан тооцсон боловч хүлээлгэн өгөх баримтад энэ талаар дурдаагүйгээс илүү хугацаагаар хоригдох, зарим тохиолдол шийтгэвэр дээр овог нэр, регистрийн дугаарыг буруу бичих зэрэг зөрчил гарсан байна.

Цаашид зөрчилд холбогдсон хүмүүст эрх, үүргийг нь хуульд заасан үндэслэл журмын дагуу танилцуулж, давж заалдах эрхтэй болохыг нь тайлбарлаж байх, баривчлах шийтгэл оногдуулсан шийтгэврийг нэн даруй гаргаж, уг шийдвэрийг үндэслэн баривчлах шийтгэлийг хэрэгжүүлж хэвших, давж заалдах талаар хүсэлт гаргасан даруйд шийдвэрийн биелэлтийг

¹¹⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах байрны 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/113 дугаартай албан бичиг, мэдээлэл.

түдгэлзүүлж, дараагийн шатны хуралдааныг шуурхай зохион байгуулах байх эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

6.13. ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бодитоор тооцох, нөхөн төлөх, гэм хорын хохирлыг арилгах ажил хангалтгүй, хууль тогтоомжийн хэрэгжилт сул байна. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох, хохирол нөхөн төлүүлэх талаар шүүхээс шийдвэр гаргадаг ч гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эдийн засгийн чадавх, нуун дарагдуулсан хөрөнгө орлогыг илрүүлэх ажиллагаа удаашралтай байгаагаас шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байна. Түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх асуудлыг иргэний хуульд заасан журмаар шийдвэрлэхээр нээлттэй орхиж байгаа нь хохирогч дахин хохирох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Улсын хэмжээнд 2023 онд шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ 153 тэрбум 260 сая төгрөг байсан бол 2024 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт хэмжээ 156 тэрбум 537 сая төгрөг болж 3.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.¹¹¹ Гэмт хэргийн улмаас 19,956 хүн, 552 төрийн байгууллага, 64 компани, 1 нөхөрлөл, 1 сан, 6 төрийн бус байгууллага хохирчээ.

Хорих ял эдэлж байгаа хүнээс хохирол, нөхөн төлбөр төлүүлж буй байдал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214-217 дугаар зүйлд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулсан. Хоригдлын хөдөлмөрийн норм үнэлгээг тооцохдоо ШШГЕГ-ын даргын 2018 оны А/131 дугаар тушаалаар баталсан “Хоригдлын хөдөлмөрийн норм, цалин хөлсний үнэлгээг тогтоох журам”-д заасны дагуу хоригдлыг хуулийн этгээдэд ажиллуулахдаа тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон түүнээс дээш цалин (хөлс) олгож байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хоригдлын гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, төлбөрийг барагдуулах, хохирогчийн эрхийг хамгаалах, хоригдлыг хугацаанаас нь өмнө суллах нөхцөлийг бүрдүүлэх, хоригдол болон тэдний ар гэрээс хохирол, төлбөр төлөх эрмэлзлийг бий болгох зорилгоор хохирлоо барагдуулах аяныг удаа дараа зохион байгуулж иржээ.¹¹²

Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 321.5 тэрбум төгрөгийн 9267 гүйцэтгэх баримт бичиг биелүүлэхээс 31 тэрбум төгрөгийн 5003 гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгож, 290.5 тэрбум төгрөгийн 4264 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 54 хувь, мөнгөн дүнгийн бодит биелэлт 6.9 хувьтай ажилласан байна.

¹¹¹ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн 2023, 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.

¹¹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас Комисст 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн мэдээлэл.

Бүдүүвч 6.6 ШШГЕГ-ын харьяа хорих ангиудад ял эдэлж буй хоригдлын гэмт хэргийн улмаас учруулсан хохирол барагдуулалтын дүн (сая.төг) ¹¹³



ШШГЕГ-ын хэмжээнд 2021 онд гэмт хэргийн улмаас бусдад учруулсан 2.1 тэрбум төгрөгийн хохирол, төлбөрийг барагдуулсан бол 2022 онд 2.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 11 хувиар, 2023 онд 4.5 тэрбум болж өмнөх оноос 91 хувиар, 2024 онд 4.7 тэрбум болж өмнөх оноос 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хэдийгээр хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны хувь хэмжээ нэмэгдэж байгаа нь сайшаалтай боловч Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх хэрэгжихгүй байна. Практикаас үзэхэд бусдад хохирол, их хэмжээний хохирол учруулсан, олон үйлдэлтэй, эсхүл хохирол, нөхөн төлбөрөө төлөөгүй хүмүүст шүүхээс хорих ял оногдуулах нь түгээмэл байгаа ч хоригдлын тоо, хорих ангид эрхлэх ажлын байрны хомсдол зэргээс шалтгаалж хохирол нөхөн төлөлт удаашралтай байна.

Цаашид хорих ангийг дагнасан сургалт, үйлдвэрлэлийн хэлбэрээр зохион байгуулалтад оруулах нь хорих ял эдлэгчдийн хохирол нөхөн төлөлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, хохирлын санг бүрдүүлэхэд эх үүсвэр болгон ашиглах ач холбогдолтой юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нөхөн төлбөр олгож буй байдал

УИХ-аас 2019 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсны дагуу Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ыг баталсан. Энэ хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 21 төрлийн гэмт хэргийн тодорхой хэсэгт заасан үйлдлийн улмаас хохирсон хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгчид хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн оршуулгын зардал, эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгохоор хуульчилсан.¹¹⁴

Дээрх хууль болон журмын дагуу 2012-2024 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 30 удаагийн тушаалаар 516 хохирогч иргэнд 3.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-аас олгож, 255 төлбөр төлөгчийн нийт 1.4 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлсэн ба 261 төлбөр төлөгчөөс төлбөрийн үлдэгдэл 1.9 тэрбум төгрөгийг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгааг мэдээлсэн. Үүнээс хорих ял эдэлж байгаа 1.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй 215 төлбөр төлөгч байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу 2024 онд хоёр удаагийн

¹¹³ Мөн тэнд.

¹¹⁴ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйл

шийдвэрээр 25 хүнд 384,031,000 төгрөгийг олгосон байна.

Тусгай сангаас олгосон төлбөрийн 73.8 хувийг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 (91.1)-т заасан хүн алах, 16.8 хувийг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 (96.1, 96.2) буюу хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 0.41 хувийг нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.4-т заасан хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах, 8.8 хувийг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 (126.1)-т заасан хүчиндэх гэм хэргийн улмаас учирсан хохирлын төлбөрт олгосон байна.¹¹⁵ Эмчилгээний зардалд 93 иргэнд 675.9 сая төгрөг, оршуулгын зардалд 421 иргэний 2.5 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдсан 2 иргэнд 5.1 сая төгрөгийг тус тус олгосон.

Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журмын 6.1-д сангаас олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, нөхөн төлүүлэхээр заасан.

Дээрх судалгаа баримтаас дүгнэхэд 2024 оны байдлаар нөхөн төлбөр авахаар тогтоосон 516 хохирогчоос 261 хүн хохирол, нөхөн төлбөрөө бүрэн авч чадаагүй байна. Иргэдээс Комисст ирүүлж байгаа мэдээллээс үзэхэд Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журамд зааснаар нөхөн төлбөр авахаар тогтоогдсон хүн шүүхийн шийдвэрт заасан нөхөн төлбөрийн хэмжээг нэг удаагийн шийдвэрээр бүрэн авч чадахгүй, улсын төсвөөс хуваарилсан төсвийн хэмжээнд тааруулан жил жилээр хуваан авч байгаа нь эд хөрөнгө, эрүүл мэндээ сэргээх, амьдралын чанараа дээшлүүлэх, алдагдсан боломжоо нөхөхөд хүндрэл учруулж байгааг дурджээ. Тухайлбал 290 сая төгрөгийн нөхөн төлбөр авахаар тогтоогдсон хүнд төсөвтөө тохируулан 2-10 жилийн хугацаанд хуваан олгож байгааг шийдвэрлэж өгөхийг хүссэн. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрийн биелэлтийг Засгийн газрын журмаар зохицуулж байгаа нь хүний эрхийг хязгаарлахад тавигдах шаардлагад нийцэхгүй юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг богино хугацаанд шийдвэрлэж, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх арга хэмжээг тухайн жилд нь шийдвэрлэж байхыг холбогдох хуулиар зохицуулах нь зүйтэй.

Сэтгэцэд учруулсан хор уршиг буюу сэтгэл санааны хохирлыг тооцож буй байдал

Шүүх шинжилгээний тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан бөгөөд энэхүү хуулийн нэг гол үзэл санаа нь гэмт хэргийн улмаас учирсан хүний сэтгэл санааны хохирол буюу хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, хохирлыг мөнгөн дүнгээр барагдуулах эрх зүйн үндэс юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам” болон “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт”, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ыг тус тус баталсан. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний зөрчигдсөн эрхийг сэргээхэд нэгэн чухал хууль зүйн үндэслэл бүрдсэн.

Шүүх шинжилгээний ерөнхий газар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ын дагуу 2023 оны 07 дугаар сараас 2024 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 1902 тогтоол, захирамж хүлээж авсан

¹¹⁵ ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 3/1476 дугаартай албан бичиг.

байна. 2024 онд 765 хүнийг үзлэг шинжилгээнд хамруулсан байгаа нь 2023 онтой харьцуулахад 523 хүнээр буюу 68 хувиар өссөн дүнтэй байна.

Хүснэгт 6.11 Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үзлэг шинжилгээний хариу (2023.07-2024.10)

№	Үзлэг, шинжилгээнд хамрагдсан	2024 он	2023 он
1	Зэрэглэл тогтоогдоогүй	35	4
2	Нэгдүгээр зэрэглэл	160	13
3	Хоёрдугаар зэрэглэл	343	102
4	Гуравдугаар	168	95
5	Дөрөвдүгээр зэрэглэл	28	14
6	Тавдугаар зэрэглэл	11	12
7	Үзлэг шинжилгээнд хамрагдан дүгнэлт гараагүй	20	-
Нийт тоо		765	242

Гэсэн хэдий ч хууль хэрэглээний явцад хүндрэлтэй асуудал гарч, Комисст зарим иргэн хандаж байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал гэмт хэргийн хохирогчоор хэнийг тогтоож шинжилгээ хийлгэх (төрсөн эх, эсхүл эхнэрийг тогтоох уу), хохирогчоор тогтоосон албан ёсны шийдвэр гаргаагүй байна гэх үндэслэлээр сэтгэцийн шинжилгээ хийхээс татгалзах, шинжилгээ хийх хугацааг тогтоосон хугацаанд гаргахгүй байх, шүүгч, мөрдөн шалгах байгууллагын алба хаагчдын мэдлэг, ойлголт дутмагаас шалтгаалж хохирлоо шийдвэрлүүлж чадахгүй байх¹¹⁶ зэргийг дурдаж болно.

Тохиолдол 6.19

“...дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн шинжээч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай ... дугаар захирамжид нэхэмжлэгч А-ийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр шүүхэд ирүүлэхийг даалгасан ч 2025 оны 03 дугаар сарын байдлаар дүгнэлт гараагүй байна...”;

(Комисст 2025 онд ирсэн гомдлоос)

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах асуудлыг цогц байдлаар хуульчлан зохицуулж Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д заасан “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө” хариуцах үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.¹¹⁷

Гэмт хэргийн хохирлын сангийн тухай хуулийг баталж, төсвийн эх үүсвэрийг гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого, бусад боломжит эх үүсвэрээр шийдвэрлэх боломжийг бүрдүүлэхийг зөвлөж байна.

Эрүү шүүлтийн хохирогч хамгаалал, нөхөн төлбөр

ИБУТЭТОУП-ын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль бусаар баривчлагдаж, эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй”, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй”, Мөн НҮБ-ын Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмуудын 3.3-т “Төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Засгийн газар нь

¹¹⁶ Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 16 өдрийн 2023/ДШМ/1101 дугаартай магадлал.

¹¹⁷ Нээлттэй нийгэм форум. Хохирлын үндэсний тогтолцоо. Цуврал судалгаа №1, 2, 3.

өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна” гэж тус тус заажээ.

Олон улсын эрх зүйн зохицуулалтаар эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг шударгаар, хангалттай нөхөн төлөх үүргийг Засгийн газар хүлээдэг. Өөрөөр хэлбэл эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” эрхийг баталгаажуулсан боловч эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалтгүй байна.¹¹⁸

Монгол Улсад эрүү шүүлтийн хохирогчдыг үр нөлөөтэй хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчдыг нөхөн сэргээхэд чиглэсэн эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин дутмаг байгаагаас хохирлоо нөхөн төлүүлэхэд цаг хугацаа зарцуулах, процессын олон үе шатыг дамжих, ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргуулан авах явцад олон саад бэрхшээл тулгарч байна.

Төр, нийгмийн зүтгэлтний амь насыг хөнөөсөн хэрэгт хилсээр гүтгэгдэн шалгагдах явцдаа эрүү шүүлтэд өртсөн нь тогтоогдож, үйлдэл холбогдол нь хэрэгсэхгүй болсон нэр бүхий иргэд хохирлоо нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан боловч нотолгооны өндөр шаардлага, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, нөхөн төлбөрийн хэт бага хэмжээ, шүүхийн харьяалал, төрийн байгууллагын хүнд суртал зэргээс шалтгаалан өнөөг хүртэл шийдвэрлэгдэхгүй байна.

Тохиолдол 6.20

“...Хохирогч Т.Ч гэм хорын хохиролд ... тэрбум ... төгрөг нэхэмжлэн Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 3 удаа, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1 удаа хандсан боловч нэхэмжлэлийн шаардлагыг хангуулахаар зааж, хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 101/... захирамжаар Монгол Улсын Засгийн газарт холбогдох гэм хорын хохирол 80,040,000.00 (наян сая дөчин мянга) төгрөг гаргуулах тухай иргэний хэрэг үүсгэсэн ч хариуцагчийн харьяаллын дагуу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжин ирж хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна...”

“...Хохирогч Б.С “Төрөөс ... тэрбум ... төгрөг гаргуулах” нэхэмжлэлийг Орхон аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гаргасныг шүүх хүлээн авч, 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр иргэний хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа ба тус шүүхийн шүүгчийн 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн “Шүүхийн даалгавар гүйцэтгүүлэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай”0746 дугаар захирамжаар Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөлд нэхэмжлэлийн хувийг гардуулах, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар иргэний хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах, нөлөөллийн мэдүүлэг танилцуулах, хариу тайлбар авах, хэргийн материал танилцуулах зэрэг ажиллагааг хийх даалгаврыг биелүүлж, холбогдох материалыг 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус шүүхэд ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд даалгасан байна....”

“...Хохирогч А.Г-г 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл 8 сарын турш яллагдагчаар цагдан хорьж, прокурорын газрын прокурорын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн МН/41 дүгээр тогтоолоор түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон боловч тус тогтоолын хувийг түүнд өгөлгүй, зөвхөн танилцуулж гарын үсэг зуруулснаас хойш 7 жилийн дараа буюу 2023 оны 08 дугаар сард уг тогтоолын хуулбар хувийг Мөрдөн байцаах газраас гаргуулан авчээ. Тэрээр тогтоол гардаг авсны дараагаар гэм хорын хохиролд ... тэрбум ... төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаж, хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Сэтгэгцэд учирсан гэмтлийн зэрэг тогтоолгох шинжээчийн дүгнэлт удаашралтай байгаа...”

(Комисст 2025 онд ирсэн гомдлоос)

Одоогийн байдлаар Т.Ч, Б.С болон тэдний гэр бүлийн гишүүдийг гэрч хохирогчийн хувиар хамгаалах, нийгмийн болон эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, нийгэмд дасан зохицож

¹¹⁸ Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл, 20 дахь тал.

амьдрах, хэвийн байдалд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх ямар нэгэн арга хэмжээ авагдаагүй байна.¹¹⁹ Т.Ч, түүний нөхөр, өмгөөлөгч нарын зүгээс эрүүл мэндийн байдалд анхаарч, зохих арга хэмжээг авах, нэхэмжлэлийн шаардлагыг нэмэгдүүлэх, цахим орчинд нэр төр алдар хүндийг гутааж гэмт хэрэгтэн мэтээр харьцаж байгаа үйлдлийг таслан зогсоож өгөх талаар Комисст хүсэлт гаргаж зохих арга хэмжээг авсан.

Тохиолдол 6.21

Комисст 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 02/08и дугаар албан бичгээр Эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлттэй тэмцэх Нийгэмд үйлчлэх ТББ-аас “Улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлийн зүгээс төрийн болон иргэдийн өмч хөрөнгийг луйвардах, хувийн өс хонзонгоо авах болон бусад ашиг сонирхлын үүднээс хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагыг ашиглаж бусдыг хэлмэгдүүлэн хохироох явдал хэрээс хэтэрч, үүний улмаас хохирсон иргэд хамтран энэхүү төрийн бус байгууллагыг байгуулж эрүүдэн шүүгдэж, хилс хэрэгт ял шийтгэгдсэн иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр ажиллаж байна. Биднийг эрүүдэн шүүж, хэлмэгдүүлсэн хэргийг 3 шатны шүүхээр шийдсэн гэдэг хариултаар ямар ч ажиллагаа хийх боломжгүй болгож байгааг анхаарч, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн сахилгын хороо, Монголын өмгөөлөгчдийн холбоо болон бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, хохирсон иргэдийн гомдлын дагуу хэргийг дахин хянаж, хүний эрхийн болон эрх зүйн алдаа гаргасан эсэх талаар дүгнэлт гаргах чиглэлээр ажиллах саналаа Засгийн газарт хүргүүлж шийдвэрлэж өгөхийг хүсжээ”.

Комисс мэдээллийн дагуу хилсээр шийтгэгдсэн, эрүүдэн шүүлтэд өртөж хохирсон гэх 47 иргэний мэдээллийг нэг бүрчлэн гаргуулан авах, хохирсон иргэдийн төлөөлөлтэй 3 удаагийн уулзалт зохион байгуулж санал, хүсэлтийг сонссон бөгөөд гомдолд дурдсан нөхцөл байдал, холбогдох баримттай танилцахад дээрх иргэдийн гаргаж байгаа зарим гомдол үндэслэлтэй байх боломжтой гэж дүгнээд нэр бүхий иргэдийн асуудлыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдах “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт” хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Улсын Их Хурлын хяналтын сонсголоор хэлэлцүүлж шийдвэр гаргуулахаар Монгол Улсын Их Хурлын хууль зүйн байнгын хороонд Комиссын дүгнэлтийг хүргүүлсэн¹²⁰.

(Комисст 2024 онд гаргасан гомдлоос)

Хяналтын сонсголын үр дүнгээр Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 09 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар цогц арга хэмжээг тусгасан бөгөөд эрүү шүүлт, хилс хэрэгт хариуцлага хүлээсэн иргэдийн талаар санал дүгнэлт гаргаж, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаарх санал дүгнэлтийг бэлтгэн Улсын Их Хурлын хаврын чуулганыг хугацаанд багтаан Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг даалгасан. Үүнтэй холбоотойгоор холбогдох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд эрүү шүүлтийн хохирогчдыг үр нөлөөтэй хамгаалах, хохирол нөхөн төлүүлэх, хохирогчдыг нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүй, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг үзүүлэх бие даасан хууль эрх зүйн орчин шаардлагатай гэж үзэж байна.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо гуравдугаар хурлын ерөнхий тайлбартаа эрүү шүүлтийн хохирогчдод үзүүлэх нөхөн сэргээх үйлчилгээг хэрэгжүүлэхэд анхаарах гурван шалгуурыг тогтоосон байна. Үүнд:

1. Нөхөн сэргээх үйлчилгээ хангалттай байгаа эсэх? Хохирогчдын эрх, нөхөн сэргээх үйлчилгээ авах тухай мэдээлэл нь олон нийтэд нээлттэй тэр дундаа үндэстэн болон цөөнхийн хэлээр байдаг уу? Нөхөн төлбөр олгох болоод нөхөн сэргээн засах

¹¹⁹ Комиссоос Эрүүл мэндийн сайдад 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06/1098 албан бичгээр хандаж, иргэн Т.Ч түүний нөхөр С.Б нарын эрүүл мэндийн байдалд анхаарч, зохих арга хэмжээг авч ажиллахыг хүссэнээр Улсын Нэгдүгээр эмнэлэгт эрүүл мэндийн бүрэн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан байна. Энэ хугацаанд Комиссоос Т.Ч, түүний нөхөр С.Б болон өмгөөлөгч С.О нартай 6 удаагийн уулзалт зохион байгуулж, 19 удаа албаны утсан харилцаагаар холбогдож тэднээс гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

¹²⁰ 2024 “Монгол Улс дахь эрүү шүүлтийн нөхцөл байдлын талаар” хариу хүргүүлэх тухай Комиссын 2024 оны 08 дугаар сарын 27-ний өдрийн 1/1247,

үйлчилгээнд хангалттай тооны холбогдох мэргэжилтнүүд ажиллаж байгаа эсэх, тэдгээр нь холбогдох орон нутгуудад хүрч ажиллаж чадаж байна уу?

2. Эрүү шүүлтийн хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ хүртээмжтэй байдаг уу? Тэдэнд ялгаварлан гадуурхахгүйгээр, шуурхай, аюулгүй, найдвартай, нууцлалтай орчинд эрхийг нь хангаж, хандах боломж бий юу?
3. Нөхөн сэргээх үйлчилгээ нь хохирогчдын хувь онцлог хэрэгцээг хангахаар байж чадсан уу? Эмзэг бүлгийн хохирогчид болон эрүү шүүлтийн жендерийн өвөрмөц хэлбэрт зориулсан эмнэлгийн ёс зүй, тусгай арга барил, үйлчилгээгээр хангадаг уу? Эрүүл мэнд, хуулийн мэргэжилтнүүдийг тусгайлан эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалахаар сургаж бэлдэх боломж бий юу? гэх зэрэг шалгуурыг асуулт болгон тавьсан байдаг.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд зарим улсын үндсэн хуульд эрүү шүүлтийн хохирогчид нөхөн төлбөр авах эрхийг шууд тусгасан байдаг бол заримд нь тодорхой салбар хуулиудад заалт оруулсан байна. Эндээс эрүү шүүлтийн эсрэг цогц хууль тогтоомжоор эсвэл эрүүгийн хууль тогтоомжийн нэг хэсэг агуулгаар нөхөн төлбөр олгох асуудлыг шийдэх гарц хайж байгааг харж болно.

Дэлхийн ихэнх улсууд эрүү шүүлтийн хохирогчийн эрхийг сэргээх, нөхөн олговор олгох болоод нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрхэн авах талаар эрх зүйн орчныг цогцоор бүрдүүлсэн байна. Хүний эрхийн Үндэсний Комиссоос судлаач нартай хамтран дэлхийн улс орнуудын сайн туршлагыг судлах зорилгоор АНУ, Европын холбооны стандарт, Филиппин, Армен, Чили, Финлянд, Итали, Мексик, Гүрж, Нидерланд, Дани, Швед, Перу, Кени, Герман, Австрали, Бельги, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах, Уганда улсын туршлагыг судалсан.¹²¹ Судалгаанд үндэслэн дараах дүгнэлтэд хүрсэн нь эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах цогц бодлого байх ёстойг илэрхийлэх юм. Үүнд:

- Эрүү шүүлтийн хохирогчийн хохирлыг барагдуулах нь процессын болоод гэм хорыг арилгах гэсэн хоёр арга хэлбэрээр ихэвчлэн хийгддэг. Процессын хохирол барагдуулах арга нь шуурхай, үр дүнтэй мөрдөн байцаалт явуулах, улмаар гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг яллах, хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлсэн зохих хууль эрх зүйн орчин, зохион байгуулалтын механизмтай байхыг шаарддаг.
- Эрүү шүүлтэд өртсөн хохирогчдод нөхөн сэргээх цогц үйлчилгээ ямар нэгэн хэмжээнд үзүүлдэг бөгөөд хохирогчдын нөхцөл байдал, ямар орчинд эрүүдэн шүүгдсэн, зүй бусаар харьцсантай холбоотойгоор нэлээдгүй туршлагатай болж чадсан байна;
- Дотоодын хууль тогтоомж, төрийн бодлого, улсын төсөв нь эрүүдэн шүүх гэмт хэргийн хохирогчийн хохирлыг барагдуулах, нөхөн сэргээх эрхийн хэрэгжилтийг хангаагүй, нөхөн сэргээх төрийн хөтөлбөр хэрэгжиж байгаа ч үр нөлөөгүй байгаа тохиолдолд төрд итгэх итгэл сулардаг;
- Шүүх хуралдаанд хохирогч өөрөө оролцох нь хохирогчийн нэр төр, шударга ёсны мэдрэмжийг сэргээхэд чухал хувь нэмэр оруулж, шүүхийн өмнө мэдүүлэг өгөх нь эрхээ эдэлж байгаа мэдрэмжийг төрүүлж, улмаар хүний эрхийн ноцтой зөрчлийн сөрөг үр дагаврыг бууруулж чаддаг.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд онцгой ач холбогдолтой бөгөөд хохирогчоос хөндлөнгийн мэдүүлэг авах, нотлох баримтыг хүлээн зөвшөөрөх эсэх дээр хатуу шалгуур тавих, хохирогчийн мэдүүлэгт эргэлзэх зэрэг нь хохирогчийг дахин цочрол, доромжлолд хүргэж болзошгүй байдаг гэдгийг онцгой анхаардаг;
- Хохирогчдыг шүүхийн бүх үе шатанд айлган сүрдүүлэх, өшөө авахаас хамгаалахад анхаарлаа хандуулж, хууль эрх зүйн хамгаалалттай болгосон байна;
- Эрүү шүүлтийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах, гэмт хэрэг үйлдсэн хүмүүст дархан эрх, өршөөл үзүүлэхтэй холбоотой асуудал гардаг. Түүнчлэн дэлхийн

¹²¹ “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогч хамгаалал, туслалцаа үзүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх нь” бодлогын судалгааны тайлан. УБ, 2025 он.

хэд хэдэн оронд гарсан нийтлэг жишээ бол эрүүдэн шүүсэн эрүүгийн хэргийг “эрх мэдлээ урвуулан ашиглах”, “хүний биед хөнгөн гэмтэл учруулах” зэрэг эрүүгийн өөр зүйл ангиар хариуцлага хүлээлгэх нь түгээмэл байна. Энэ нь эргээд хохирогчийг хохирлоо барагдуулах, учирсан хохирлоо арилгуулах үр дүнтэй арга хэмжээ авах боломжгүй болгодог буюу эрүү шүүлт тулгах гэмт хэргээр зүйлчлээгүйн улмаас эрүүдэн шүүлтийн хохирогч гэж тогтоогдохгүй үлдэх бодит эрсдэл үүсгэж байгааг анхаарах цаг болжээ.

- Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан тухай гомдол мэдүүлгээ хүргэхэд хялбар, бүрэн бие даасан тогтолцоотой болох шаардлагатай.

УИХ-аас анхаарал хандуулж Эрүү шүүлтийн хохирогч хамгаалах, гэрч хохирогчийг хамгаалах, эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээ авах талаар холбогдох хууль тогтоомжийг судлан санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын даргын захирамжаар байгуулан ажиллаж байна.¹²²

6.14. СУРГАЛТ, НӨЛӨӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт (2020, 3 дугаар цикл)-ээс Монгол Улсад хүний эрхийн хамгаалалтыг хангах чиглэлээр үндэсний механизм бүрдүүлэх, хүний эрхийн сургалт зохион байгуулах зэрэг хэд хэдэн зөвлөмжийг өгсөн.

Энэ хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллага, төрийн цэргийн байгууллагуудын зүгээс хүний эрхийн сургалтыг үйл ажиллагаандаа тогтмолжуулах, хууль сахиулагч бэлтгэх сургуулийн хөтөлбөрийн үнэлгээг хийх, хүний эрхэд суурилсан бодлого хэрэгжүүлэх, хүний эрхийн шинэ тутам мэдлэг ойлголтыг төлөвшүүлэхэд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа ч сургалтын үр нөлөөг дээшлүүлэх, тогтолцооны хувьд бүрэн бэхжүүлэх шаардлага байсаар байна.

Комиссоос шударгаар шүүлгэх эрхийн хүрээнд халдашгүй чөлөөтэй байх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрхэд суурилсан мөрдөн шалгах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах, хүний хувийн мэдээлэл хамгаалах болон хүүхдийн эрх, зорилтод бүлгийн чиглэлээр шүүх эрх мэдэл, хууль сахиулах, цэргийн байгууллагуудын алба хаагчдыг чадавхжуулах сургалтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр анхаарч бодлогын зөвлөмж өгч ирсэн.

Тухайлбал, 2020-2024 оны хугацаанд нийт 87 удаагийн 1520 цагийн сургалт, 26 удаагийн хэлэлцүүлгийг нийслэл болон 21 аймгийн шүүх, прокурор, цагдаа, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эрүүл мэндийн байгууллага, хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбооны 6000 гаруй алба хаагч, хуульчийг хамруулан зохион байгуулсан бол 3000 орчим цэргийн алба хаагчид хүний эрхийн сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагаа явуулж, дээрх салбаруудад дотооддоо хүний эрхийн сургалт явуулах үүрэг бүхий 180 орчим сургагч багш бэлтгэж, Монголын хуульчдын холбооны үргэлжилсэн сургалтын агуулгад “Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх”, “Шүүхийн практикт олон улсын гэрээг хэрэглэх” хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлүүлж, давхардсан тоогоор 760 орчим хуульчдад сургалт явуулсан.

¹²² 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 164 дүгээр захирамжаар ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн О.Номинчимэг, 2024 оны 09 дүгээр сарын 05-ний өдрийн 112 дугаар захирамжаар ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин, мөн өдрийн 90 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар томилогдсон.

Бүдүүвч 6.7 Хууль сахиулах зарим байгууллагын зохион байгуулсан сургалт, хамрагдсан алба хаагчид

Цагдаагийн ерөнхий газар (2021-2024 он)	•Цахим, танхим хосолсон 381 удаагийн сургалтад 26067 алба хаагч хамрагдсан
Дотоодын цэрэг (2024 он)	• Цахим, танхим хосолсон 143 удаагийн сургалтад 9145 алба хаагч хамрагдсан
Авлигатай тэмцэх газар (2024 он)	• 4 удаагийн танхимын сургалтад 183 алба хаагч хамрагдсан
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (2023-2024 он)	• 17 сэдэвт сургалтад 1524 алба хаагч хамрагдсан
Зэвсэгт хүчний жанжин штаб (2022-2024 он)	• 31 удаагийн танхимын сургалтад 3033 алба хаагч хамрагдсан

Улсын ерөнхий прокурорын газар 2019 онд зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлыг прокурорын байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүрэг бүхий “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийг байгуулж, Улсын ерөнхий прокурорын баталсан “Эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх тухай” 06 дугаар албан даалгаврын биелэлтийг жил бүр харьяа прокурорын газруудын хэмжээнд тооцдог болсон нь бусад байгууллагад хэрэгжүүлэх сайн жишиг болсон. Түүнчлэн Улсын ерөнхий прокурорын дэргэд Сургалт, судалгааны хүрээлэнг байгуулж прокурорын давтан сургалтыг зохион байгуулах тогтолцоог бүрдүүлжээ. Тус хүрээлэнгээс прокурор, хуульчдын дунд шударгаар шүүлгэх эрхийн агуулгад хамаарах сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж хэвшжээ. Гэсэн хэдий ч Комисст ирж байгаа гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргаж байгаа хүсэлтүүдэд прокурорын хүний эрхийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх шаардлагатай талаар удаа дараа дурдаж байна.

Тиймээс прокурорын байгууллагын зүгээс прокурор, бусад алба хаагчдынхаа хүний эрхийн мэдлэг хандлагыг үнэлэх аргачлал боловсруулж, тогтмол хугацаанд өөрийн үнэлгээ хийж, сургалтын үр нөлөөг хэмжиж байх нь эерэг үзүүлэлт болно.

Хууль сахиулах байгууллагын хэмжээнд Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрх, эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий хандах, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, шударгаар шүүлгэх эрхийн талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг сайжруулах зорилгоор алба хаагчдыг ажлын байранд чадавхжуулах, мэргэшүүлэх давтан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр боловсруулан хэрэгжүүлж байна.

Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүх түвшний алба хаагчдын хүний эрхийн боловсролыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хууль сахиулах ажиллагааны хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын тогтолцоо бүрдсэн гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал, Дотоод хэргийн их сургууль, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дэргэдэх сургалтын төв, гадаад, дотоодын хамтын ажиллагаатай сургалт судалгааны байгууллагуудад алба хаагчдыг чадавхжуулж байна. Эдгээр салбарын алба хаагчдыг чадавхжуулахад Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс санаачилга гарган ажиллаж байгааг онцлон тэмдэглэж байна.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр “Монгол Улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийг Хүний эрхийн Үндэсний Комисс, ХЗДХЯ, ЦЕГ, Дотоод хэргийн их сургууль 2023-2025 онд хамтран хэрэгжүүлсэн нь үр дүнтэй арга хэмжээ байсан ч санхүүжүүлэгч байгууллагын шийдвэрээр тухайн төслийг үргэлжлүүлэх боломжгүй болсон. Цаашид энэхүү төслийг үргэлжлүүлэх, алба хаагчдыг чадавхжуулах боломжийг үүрэг хүлээгч талууд эрэлхийлэх нь олон талын ач холбогдолтой.

Тус төслийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн цагдаагийн алба хаагч бэлтгэх хөтөлбөрт хүний эрхийн үүднээс үнэлгээ хийх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, багш, төв, орон нутгийн цагдаагийн алба хаагчдыг чадавхжуулах зорилтыг хэрэгжүүлсэн нь үр дүнтэй ажил байлаа. Энэ хүрээнд “Хичээлийн хөтөлбөр, агуулгад хүний эрхийн өөрийн үнэлгээ хийх аргачлал”-ыг боловсруулж, хүний эрхийн болон бусад хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийж, саналыг бүх түвшний цагдаагийн алба хаагч бэлтгэх хөтөлбөрт тусгасан ба нийт багш нарыг чадавхжуулан сургасан байна.

Дотоод хэргийн их сургуулийн 11 сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээлийг 2 багц цагийн агуулгаар, хөтөлбөрийн онцлогоос хамаарч заавал болон сонгон суралцахаар тусгасан. Цагдаа судлалын хөтөлбөрт заагдах хичээл тус бүрийн агуулгад хүний эрхэд суурилсан хандлагыг тусгаж бүх хичээлээр хүний эрхийн боловсрол олгох зорилтыг дэвшүүлэн шинэчилсэн байна. Мөн “Эрүүгийн процесс ба хүний эрх”, “Хүний эрхийг цагдаагийн байгууллага хангах нь” хичээл тус бүр 2 багц цаг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хөтөлбөрт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ба хүний эрх” хичээл 2 багц цаг, Эрх зүй магистрын хөтөлбөрт “Хүний эрхийн орчин үеийн чиг хандлага” хичээлийг 3 багц цагаар тус тус оруулж сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд энэ хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх агуулга, сургалт явуулах арга хэлбэрийн хувьд шинэчлэгдэж байна.

Цаашид Монгол Улсад хэрэгжүүлсэн хүний эрхийн төсөл хөтөлбөрүүд, ялангуяа хүүхдийн эрх, хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлал, жендерт суурилсан хүчирхийлэлд хамааралтай төслийн үр дүнг сургалтын агуулга бүрд шингээж, сургалтын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлагатай.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (ЦБҮАЖ)-уудыг иж бүрэн хянаж, шинэчлэн боловсруулах ажил эхэлсэн нь сайшаалтай хэдий ч цаашид үргэлжлүүлэн бүх журмыг хүний эрхийн зарчимд нийцүүлэх шаардлагатайг зөвлөмж байна. 2024 онд Хүний эрхийн хамгааллын хувьд онцгой ач холбогдолтой гэж үзсэн 14 журмыг шинэчлэн, холбогдох олон улсын гэрээ, конвенцын үүрэг хариуцлагыг тусган, цагдаагийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг илүү тодорхой болгожээ. Шинэчлэгдсэн журмуудад алба хаагчид албадлагын арга хэмжээ хэрэглэхийн өмнө тухайн иргэнд эрхийг нь урьдчилан тайлбарлах шаардлагыг тавьсан, бүх төрлийн эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцаа, дарамт шахалтыг бүрэн хориглож, эмзэг бүлгийн иргэдийг илүү сайн хамгаалах нэмэлт заалтууд оруулсан. Ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах аргачлалыг илүү тодорхой болгож, олон нийтийн цуглаан, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хязгаарыг нарийвчлан тодорхойлжээ.

Цагдаагийн байгууллага хүний эрхэд суурилан ажилладаг эсэх, алба хаагчдын хүний эрхийн мэдлэг, хандлага, үйл ажиллагаандаа хүний эрхийг хэр хангаж ажиллагдгийг болон хүний эрхийн сургалтын давтамж, үр нөлөөг тодорхойлох судалгааг улсын хэмжээнд зохион явуулсан бөгөөд сургалтыг үр нөлөөтэй шинэлэг хэлбэрээр зохион явуулах, ялангуяа шийдвэр гаргах удирдах албан тушаалтны хүний эрхийн боловсролын дээшлүүлэх талаар алба хаагчид санал гаргаж байсныг онцгой анхаарах нь зүйтэй. Мөн иргэдээс авсан санал асуулгын дүнгээр цагдаагийн алба хаагчдын хүний эрхийг мэдлэг ойлголтыг улам нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.¹²³

Зэвсэгт хүчний жанжин штаб “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-д хүний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бусаар харьцахыг хориглосон зохицуулалтыг тусган мөрдөхийн зэрэгцээ цэргийн албанд хүний амь нас, эрүүл мэнд хохирч байгаа шалтгаан, нөхцөлд дүгнэлт хийж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн дүрмийн бус харьцааг илрүүлэх, бүртгэх, таслан зогсоох, хяналт тавих чиглэлээр ЗХЖШ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний газар, Цэргийн албаны хэлтэс болон ЗХЖШ, нэгтгэл, анги, байгууллагуудын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”, Дотоод хяналт шалгалтын комисс, Ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.

¹²³ХЭҮК. Хүний эрхэд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа: социологийн судалгаа. УБ., 2025 он.

Хил хамгаалах ерөнхий газар алба хаагчдыг гэмт хэрэг, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, тэдэнд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хичээлийн жилд явагдах сургалтыг батлан мөрдүүлж байна. Хилийн цэргийн анги, тусгай салбаруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Ёс зүйн дэд хороо”-г байгуулж, бие бүрэлдэхүүнд тулгамдаж буй асуудлуудыг нээлттэй сонсох, хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх олон талт соёлын арга хэмжээг зохион байгуулж хэвшжээ. Мөн Комисстой хамтран 2020 онд 38 алба хаагчийг хүний эрхийн сургагч багш бэлтгэж, 2024 онд Хил судлалын хүрээлэн, Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран хилийн цэргийн анги, тусгай салбаруудын сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.

Байгууллагууд хүний эрхийн чиглэлээр тогтмол сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж байгаа боловч хүний эрхийн зөрчил, эрхэлж буй албан тушаалтай холбоотой үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа нь сургалтын агуулга, багшийн ур чадвар, алба хаагчдын хүлээж авах хандлага сайжрахгүй байгаатай холбоотой юм.

Иймээс алба хаагчдыг хүний эрхийн чиглэлээр мэргэшүүлэх, ахисан түвшний мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ажлын гүйцэтгэл, мэдлэг ур чадварыг үнэлэхдээ сургалт, олон нийтийн үйл ажиллагааны оролцоог харгалзаж дүгнэж байх, хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үйлсэд бусдыгаа хошуучлан манлайлж буй алба хаагчдыг салбарын хэмжээнд алдаршуулах, салбар, байгууллагын хэмжээнд хүний эрхийг дээдэлсэн соёлыг төлөвшүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

САНАЛ

Эрүү шүүлтээс ангид байх эрх

1. Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах болон эрүү шүүлтэд тооцогдохгүй бусад хэрцгий хүнлэг бус харьцах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг чангаруулах, ял шийтгэлгүй үлдэх боломжийг хаах, хөөн хэлэлцэх хугацаа тоолох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн тайлан бэлтгэх жишиг аргачлалыг боловсруулах;
3. Уулзалт, мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг хүний эрхийн зарчимд нийцүүлэн шинэчлэн батлах, хяналтын камераар бүрэн тоноглож, дүрс бичлэгийг хадгалах, хуулбарлан авах зохицуулалтыг нарийвчлан тусгах;
4. Зориулалтын бус өрөөнд уулзалт, мэдүүлэг авах ажиллагааг таслан зогсоож, мэдүүлэг авах үед ямар хэрэгт холбогдсон болон өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, дуугүй байх, хэлмэрч орчуулагч авах эрхийг нь сайтар тайлбарлан ойлгуулах байдлаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хандлагыг төлөвшүүлэх;
5. Нэг мөрдөгч, прокурорт ноогдох гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн тоог үндэслэлтэйгээр тооцож, хүний нөөцийг нэмэгдүүлэх;
6. Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байх;

Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрх

1. Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хариуцан хэрэгжүүлэх чиг үүргийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, тус төвийн өмгөөлөгчдийн ажиллах орчин нөхцөл, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх;
2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шардагдах зардлын санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгаж хэвших;

Сэтгэцийн шинжилгээ ба хүний эрх

1. Эрүүгийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх зэрэг хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байх, сэтгэцийн шинжилгээ хийх процессын зохицуулалтыг боловсронгуй болгох;
2. Хэрэг хариуцах хязгаарлагдмал (завсрын) чадвартай хүнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж, энэ төрлийн шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх;
3. Хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүмүүс, ялангуяа бага насны хүүхдээс бэлгийн таашаал авах эмгэгтэй хүнийг тогтоох шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх, тэдгээр хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх хийх, суллагдсаны дараа хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

Төрийн болон албаны нууц, хүний хувийн мэдээлэл хамгаалах

1. Мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журмыг аль болох хуулиар зохицуулах, хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг прокурорын саналаар шүүхийн зөвшөөрлөөр явуулах;
2. Гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
3. Мөрдөн шалгах ажиллагааны нууц, хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.3 дугаар зүйлийг боловсронгуй болгох, ялангуяа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа эхлээгүй байгаа гэмт хэргийн гомдол мэдээллийн шинжтэй үйлдлийг шалгах шатанд прокурорын хяналтыг нэмэгдүүлэх;

Таслан сэргийлэх арга хэмжээ

1. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, өөрчлөх, оролцогчдын санал хүсэлтийг шийдвэрлэх процессын зохицуулалтыг нарийвчлан хуульчлах;
2. Шүүгчийн хуульд заасан шийдвэрээр цагдан хорих, баривчлах шийтгэлийг хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, суллах ажиллагаанд мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах технологийн дэд бүтцийг шийдвэрлэх;
3. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ асран хамгаалагч, харгалзан дэмжих хүнгүй үлдэж байгаа бага насны хүүхэд байгаа эсэхийг нягтлан шалгах, асран хамгаалах, харгалзан дэмжих хүн, хуулийн этгээдийг шүүгчийн захирамжид тусгаж байх;
4. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг сунгах шүүхийн хэлэлцүүлэгт хоригдогч, өмгөөлөгчийн оролцоог заавал хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
5. Улсын хилээр гарахыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн, санал гаргасан албан тушаалтан уг арга хэмжээг цуцалсан бол хил хамгаалах байгууллагад нэн даруй хүргүүлж шийдвэрлэж хэвших;

Хорих анги, цагдан хорих байрны орчин нөхцөл

1. Хууль, стандартын шаардлага хангахгүй байгаа цагдан хорих, баривчлах шийтгэл эдлүүлэх байр, хотын төвд байрлах хорих ангиудын засвар, дэд бүтэц, ариун цэврийн байгууламжийг шинэчлэхэд шаардагдах зардлыг шийдвэрлэх;
2. Эмэгтэйчүүдийн хорих ангийн эх хүүхдийн байр, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хүүхдийн 411 дүгээр хорих ангийн дэргэдэх Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургуулийн барилгыг нэн яаралтай ашиглалтад оруулах;
3. Цагдан хорих байранд хоригдож байгаа хүүхдүүдэд ерөнхий боловсрол олгох үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрийн дагуу, чанартай явуулах;

4. Хорих анги, цагдан хорих байрны эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, алба хаагч, хоригдлуудад чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

Зөрчлийн хэрэгт давж заалдах эрх

1. Зөрчилд холбогдсон хүн бүрд эрх, үүргийг нь тайлбарлах, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулж байх;
2. Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах талаар хүсэлт гаргасан даруй шүүхийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

Хохирол нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх

1. Эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүй, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг үзүүлэх бие даасан хуулийн хэрэгцээ шаардлагыг судалж, шийдвэрлэх;
2. Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх сангийн тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг судалж, шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төсвийг гэм буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгах;
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт заасан нөхөн төлбөрийг тухайн жилд бүхэлд нь шийдвэрлэж байх эрх зүйн зохицуулалтыг би болгох;

Сургалт, нөөлийн үйл ажиллагаа

1. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэл хүн бүр гэм буруугүйд тооцогдох зарчмыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төлөвшүүлэх, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр бусдыг гэмт хэрэг үйлдсэн, гэм буутай мэтээр зарлах, дүгнэлт хийх байх талаар бүх нийтийн боловсролыг дэмжих арга хэмжээ авах;
2. Шударгаар шүүлгэх эрх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, үр нөлөөг үнэлэх;
3. Хуульч, хууль сахиулагч бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын хөтөлбөрт хүний эрхийн үнэлгээ хийх, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт хүний эрхийн үзүүлэлтийг тусгах;

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССООС
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААР ШИЙДВЭР ГАРГУУЛАХААР
ӨГЧ БУЙ САНАЛ

Сонгох, сонгогдох эрхийн талаар

- Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцод заасан сонгуулийн үндсэн зарчимд нийцүүлэн сонгуулийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зөрчил, хийдлийг арилгах, хууль тогтоомжийн үр дагаврыг үнэлж, үр дүнд тулгуурлан процедур, механизм, хугацаа, хариуцлагын талаарх хууль тогтоомжийн зохицуулалтыг өөрчлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй, гадаад улсад амьдарч байгаа, байнгын оршин суугаа газраас өөр газар амьдарч байгаа иргэд, оюутан суралцагч, төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж буй ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрх, санал өгөх боломжийг хуулиар зохицуулах;
- Сонгогчдын тоог үндэслэн сонгуулийн тойрог байгуулах, сонгуулийн мандат тогтоох асуудлыг хуульд тусгах, мандатын тоонд ногдох тойргийн сонгогчдын тооны хэт зөрүүтэй байдлыг арилгах;
- Сонгуулийн сурталчилгааны хугацааг бодитой тогтоох, сурталчилгааны хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг төсөвлөх, сонгуулийн нарийвчилсан статистик мэдээллийн сан бүрдүүлэх;
- Сонгуулийн зардлыг бууруулах, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад, залуучууд зэрэг нийгмийн олон бүлгээс сонгуульд нэр дэвших боломжийг дэмжих түр тусгай арга хэмжээг хуулиар тодорхойлох;
- Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, стандартыг сахиулах, хэрэгжилтэнд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах;
- Сонгуулийн гомдол, маргааныг үр дүнтэй шийдвэрлэх, үр нөлөөтэй хариуцлага тооцох, зөрчигдсөн эрхийг бодитой сэргээх тогтолцоог бүрдүүлэх;

Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар

- Хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийг эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдуулан хууль бусаар шалгах, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах, хариуцлага хүлээлгэхгүй байх баталгааг хангах;
- Өмгөөллийн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан өмгөөлөгчийг айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, бусад байдлаар нөлөөлсөн этгээдийн үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах, хуульд заасан хариуцлага хүлээлгэх;
- Өмгөөлөгч цахим шүүх хуралд үйлчлүүлэгч болон бусад оролцогчидтой чөлөөтэй харилцах талаар хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах, үйлчлүүлэгчтэй ганцаарчлан уулзах, түүний байгаа газарт чөлөөтэй нэвтрэх эрхийг хязгаарласан байгууллагын дотоод дүрэм, журмыг хуульд нийцүүлэх;
- Өмгөөлөгчийн ажил үүргээ гүйцэтгэх явцад түүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах тохиолдолд нийгмийн баталгааг хангах зохицуулалтыг судалж, шийдвэрлэх;
- Олон нийтэд үйлчлэх зорилго бүхий хамтын хэвлэл мэдээллийн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг байгуулж түүний үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох, төрөөс шууд хараат байдлаар санхүүжилт авах арга замаас зайлсхийж, өрсөлдөөнд суурилсан шударга зохицуулалт хийх боломжийг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар зохицуулах;
- Редакцын хараат бус байдлыг хангасан зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн хууль тогтоомжоор зохицуулах;
- Сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд ихэвчлэн холбогдож байгаа Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт заасан “ Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан ... этгээд түүнийхээ үнэн зөвийг өөрөө нотлох ...” гэж заасныг нотлох үүргийн хариуцагч тал нь сэтгүүлч бол эх сурвалжийг

хамгаалах зорилгоор нотлох баримт гаргаж өгөх үүргээс чөлөөлж болох агуулга бүхий заалтыг Иргэний хуульд тусгах.

Хүний эрх ба цахим технологийн талаар

- Цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг цахим хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах, уг аргачлалаар нэн тэргүүнд төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлж буй аливаа технологи, систем, платформ, алгоритмыг үнэлэх зохицуулалтыг ХХМХТХ-д тусгах;
- ХХМХТХ-иар тогтоосон мэдээллийн эзний эрх, мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн үүргийн зөрчлийг Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд бүрэн тусгаж, гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх;
- Улам бүр нэмэгдэх үүрэг, хариуцлагыг нь тооцоолж, дэлхий нийтийн түгээмэл чиг хандлагын дагуу ХХМХТХ-ийн хэрэгжилтийг хангах мэдээлэл хамгаалах эрх бүхий, бие даасан байгууллагыг Засгийн газрын бүтцэд байгуулж, бэхжүүлэх талаар үе шаттай хэрэгжүүлэх бодлогыг тогтоох;
- Хүнийг тагнах, мөрдөн мөшгих боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмж, нийтийн болон хувийн орон зайд байрших дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем, хүний биометрик мэдээллийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, халдашгүй чөлөөтэй байх эрх чөлөөг хамгаалах;
- Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалт хүн төвтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг энэхүү илтгэлд тайлбарласан агуулгаар “Үндэсний хиймэл оюуны стратеги”-д тусгах, улмаар Монгол Улсад хөгжүүлэх, ашиглахыг хориглох хиймэл оюуны төрөл, зорилгыг тогтоосон, “Хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалтад хүний эрхийг хангах удирдамж” батлах;
- Нэг талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, нөгөө талаас худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг дэвэргэх илэрхийлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хорюу контентыг хязгаарлах зохист тэнцвэрийг хангасан байдлаар олон нийтийн сүлжээг зохицуулах бодлогыг тодорхойлох;
- Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай болон хөдөөгийн өрх, Монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг дэмжих, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн практик ур чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг сөрөх бодлогыг баталж, хэрэгжүүлэх;
- “Ковид-19” цар тахлын үед цугларсан хувийн мэдээллийн сан, түүний ашиглалтыг Засгийн газрын дотоод хяналтын хүрээнд хянаж, үр дүнг УИХ-д танилцуулах.

Цахим орчинд үйлдэгдэж буй жөндөрт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар

- ЦЖСХ үйлдэгдэж буй арга хэлбэр, хор уршиг, хохирол, хохирогчийн онцлогийг нарийвчлан судалж, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд энэ төрлийн гэмт үйлдэлтэй үр дүнтэй тэмцэх шаардлагыг хангахуйц нэмэлт өөрчлөлт оруулах;
- Эрүүгийн хуулийн 14.1 ялгаварлан гадуурхах, 10.4 хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, 11.7 гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 13.1 хүн худалдаалах, 13.5 заналхийлэх, 13.12 хууль бусаар мөрдөж, мөшгөх зэрэг гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байдалд цахим орчныг ашиглан үйлдсэн шинжийг нарийвчлан тусгах;
- Цахим технологи, цахим орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлал боловсруулж, үе шаттай сургалт явуулах замаар цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- ЦЖСХ-ээс урьдчилсан сэргийлэх, хүүхэд, эмэгтэйчүүд, залуучуудад зориулсан мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөж, бүх талуудыг оролцуулан хэрэгжүүлэх.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар

- Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, криминологийн дэлгэрэнгүй судалгааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог байгууллагуудын төлөөллийг оролцуулан дэлгэрэнгүй хийх, судалгааны үр дүнг үндэслэсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх арга хэлбэрийг шинэчлэх;
- Бага насны хүүхдээс бэлгийн таашаал авах (педофил) эмгэгийг тогтоох, шинжилгээ хийх, эмчлэх, тэдэнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалсан, дахин хохирохоос урьдчилан сэргийлсэн тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлан бий болгох;
- Насанд хүрээгүй болон бага насны хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааг мэргэжлийн, бэлтгэгдсэн сэтгэл зүйч эсвэл нийгмийн ажилтнаар ярилцлага хийлгэх замаар дагнан, нэг удаа, чанартай, шуурхай явуулж, үүнийг дуу, дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцох хуулийн зохицуулалтыг бий болгох;
- Хүүхдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг цагдаагийн газраас өөр тайван, хүүхдэд аюулгүй, ээлтэй, хүртээмжтэй орчинд авах зохицуулалтыг хийх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч хүүхэд заавал өмгөөлөгчтэй оролцох эрх зүйн зохицуулалтыг сэргээх;
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд учирсан хохирлыг заавал тодорхойлж, тогтоох, тэр дундаа нөхөн сэргээх, сэтгэл заслын зардлыг хэргийн хамт шийдвэрлэдэг болох, хохирлыг эхний ээлжид төрөөс гаргаж, төр гэм буруутай этгээдээс гаргуулдаг байх зохицуулалтыг хийх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхэд хамгааллын тогтолцооны хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газрын оролцоог нэмэгдүүлэх;
- Насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт гагцхүү мэргэшсэн, тусгайлан бэлтгэгдсэн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, шинжээч, мөрдөгч, прокурор, шүүгчийг оролцуулах.

Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар

- Эрүүгийн хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх, хүний биеэс биологийн дээж авах зэрэг хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байх, сэтгэцийн шинжилгээ хийх процессын зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй нь тогтоогдсон хүнд нарийвчилсан шинжилгээ хийх, онош тогтоох чадавхыг бэхжүүлэх, тэдгээр хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчилгээ хийх, суллагдсаны дараа хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Нэг мөрдөгч, прокурорт ноогдох гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн тоог үндэслэлтэйгээр тооцож, хүний нөөцийг нэмэгдүүлэх;
- Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байх;
- Гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Баривчлах шийтгэл оногдуулсан шийдвэрт давж заалдах талаар хүсэлт гаргасан даруй шүүхийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Гэмт хэргийн хохирол нөхөн төлүүлэх сангийн тухай хуулийн хэрэгцээ шаардлагыг судалж, шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төсвийг гэм

буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлэхээр тусгах;

- Эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүй, эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн амьдралд эргэн ороход дэмжлэг үзүүлэх бие даасан хуулийн хэрэгцээ шаардлагыг судалж, шийдвэрлэх;
- Бусдыг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай мэтээр олон нийтэд зарлах, дүгнэлт хийх, түүний сөрөг үр дагаврыг ойлгуулахад чиглэсэн бүх нийтийн боловсролыг дэмжих;
- Хорих анги, цагдан хорих байранд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮНИЙ 2024 ОНЫ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Комиссын гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан зөвлөмж¹, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар гаргасан шаардлага² хүргэн ажилладаг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Үүний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 дахь хэсэгт заасан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээ хийх аргачлал³”-ыг удирдлага болгон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдээс 2024 онд байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлсэн шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн.

НЭГ.КОМИССЫН ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ

Комиссын гишүүнээс байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар гомдлын мөрөөр 8, хяналт шалгалтын мөрөөр 16, мэдээллийн мөрөөр 6, нийт 30 шаардлагыг хүргүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,3 хувиар өссөн байна.

Харин байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзсэн гомдлын болон хяналт шалгалтын мөрөөр тус бүр 20, Комиссын гишүүний санаачилгаар 5, дүн шинжилгээний мөрөөр 9, мэдээллийн мөрөөр 2, нийт 56 зөвлөмжийг хүргүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,1 хувиар буурсан байна.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж нь 2024 онд мэдээллийн мөрөөр 8 гаргасан нь өмнөх оны мөн үеэс өссөн, дүн шинжилгээний мөрөөр 9 гарсан нь 125 хувиар тус тус өссөн байна. Энэ нь хүний эрх, эрх чөлөөний талаарх иргэдийн боловсрол мэдээлэл сайжирч буйг илэрхийлж байна.

Хүснэгт 1.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж 2024 он.

Шаардлага, зөвлөмж		2023 он	2024 он
Комиссын гишүүний шаардлага	Хяналт шалгалтын хүрээнд	14	16
	Гомдлын дагуу	11	8
	Мэдээллийн мөрөөр	-	6
	Дүн шинжилгээний мөрөөр	1	-
Дүн		26	30
Комиссын гишүүний зөвлөмж	Хяналт шалгалтын хүрээнд	24	20
	Гомдлын дагуу	27	20
	Комиссын гишүүний санаачилгаар	6	5
	Дүн шинжилгээний мөрөөр	3	9
	Мэдээллийн мөрөөр	1	2
Дүн		61	56

¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг;

² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг;

³ "бүрэн хэрэгжсэн" - 100 хувь (90-100 хувийн гүйцэтгэл), "хэрэгжих шатанд" - 70 хувь (50-90 хувийн гүйцэтгэл), "хэрэгжилт хангалтгүй" - 30 хувь (10-50 хувийн гүйцэтгэл), "хэрэгжээгүй" – 0 хувь (0-10 хувийн гүйцэтгэл).

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж	Хяналт шалгалтын хүрээнд	38	36
	Гомдлын дагуу	38	28
	Комиссын гишүүний санаачилгаар	6	5
	Дүн шинжилгээний мөрөөр	4	9
	Мэдээллийн мөрөөр	1	8
Нийт		87	86

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг эрхийн төрлөөр нь ангилж үзвэл иргэний болон улс төрийн эрхийн асуудлаар **21 буюу 25 хувь**, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн асуудлаар **54 буюу 63 хувь**, бүлгийн эрхийн асуудлаар **11 буюу 12 хувийг** тус тус эзэлж байна. Үүнээс үзэхэд эдийн засаг, нийгэм соёлын эрхийн асуудал их хөндөгдсөн байна.

Хүснэгт 2.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн эрхийн төрөл. 2024 он.

Шаардлага, Зөвлөмж		2023 он	2024 он
Комиссын гишүүний шаардлага	Иргэний болон улс төрийн эрх	10	7
	Эдийн засаг, нийгэм соёлын эрх	16	17
	Бүлгийн эрх	-	6
Дүн		26	30
Комиссын гишүүний зөвлөмж	Иргэний болон улс төрийн эрх	22	14
	Эдийн засаг, нийгэм соёлын эрх	39	37
	Бүлгийн эрх	-	5
Дүн		61	56
Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж	Иргэний болон улс төрийн эрх	32	21
	Эдийн засаг, нийгэм соёлын эрх	55	54
	Бүлгийн эрх	-	11
Нийт		87	86

ХОЁР.КОМИССЫН ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ ХҮРГЭСЭН БАЙГУУЛЛАГА

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллагаар нь ангилж үзвэл Хууль сахиулах байгууллагад 15, Нийслэл, орон нутгийн Засаг даргад 23 хүргүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тухайн түвшинд өөрчлөлтгүй байгаа ба Засгийн газар, яам, агентлаг түүний салбар нэгжид 34 хүргэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсөж, төрийн үйлчилгээ, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагад 9 хүргэгдсэн нь 64 хувиар, Хувийн хэвшилд 5 хүргүүлсэн нь 55 хувиар тус тус буурсан байна.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн 40 хувийг Засгийн газар, яам агентлаг түүний салбарт хүргэсэн байна.

Хүснэгт 3.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтан. 2024 он.

Шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага		2023 он	2024 он
Комиссын гишүүний шаардлага	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	2	9
	Хууль сахиулах байгууллага	4	6
	Нийслэл орон нутгийн Засаг дарга	7	12
	Төрийн үйлчилгээ, ТӨХК	8	1
	Хувийн хэвшил	5	2
Дүн		26	30
Комиссын гишүүний зөвлөмж	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	7	25
	Хууль сахиулах байгууллага	12	9
	Нийслэл орон нутгийн Засаг дарга	19	11

	Төрийн үйлчилгээ, ТӨХК	17	8
	Хувийн хэвшил	6	3
Дүн		51	56
Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	9	34
	Хууль сахиулах байгууллага	16	15
	Нийслэл орон нутгийн Засаг дарга	26	23
	Төрийн үйлчилгээ, ТӨХК	25	9
	Хувийн хэвшил	11	5
Нийт		87	86

Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд шаардлагыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэх⁴ үүрэгтэй.

Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хариу мэдээллийг хугацаандаа ирүүлсэн 79, хугацаа хэтрүүлсэн 5, хариу ирүүлээгүй 2 байгууллага, албан тушаалтан байна. Үүнээс үзэхэд хугацаандаа хариу мэдэгдсэн байдал 92 хувьтай байна.

Хүснэгт 4. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа хэтрүүлсэн байгууллага, албан тушаалтан 2024 он.

№	Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж		Агуулга	Огноо дугаар	Хариу ирүүлсэн	Хэтэрсэн хоног
1	Комиссын гишүүний шаардлага	Боловсрол, шинжлэх ухааны сайд	Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын талаар	2024.05.29 №02/16	2024.09.02 02/737	63 хоног
2	Комиссын гишүүний зөвлөмж	Авлигатай тэмцэх газрын дарга	Хэргийн оролцогчдын өмгөөлүүлэх эрхийг хангаж ажиллах тухай	2024.03.14 №04/16	2024.07.08 03/11644	60 хоног
3		“Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	Тус компанид хийсэн хяналт шалгалтаар илэрсэн хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн тухай	2024.03.07 №03/15	2024.07.05 02/418	60 хоног
4		Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	УИХ-ын 2024 оны 37-р тогтоолд тусгаагүй эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой зарим асуудлыг хэрэгжүүлэх тухай	2024.07.25 №01/37	2024.12.03 01/1601	66 хоног
5		Сангийн сайд	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн асуудлыг улсын нэгдсэн төсөвт тусгах тухай	2024.07.25 №06/40	2024-11-29 03/9851	60 хоног

⁴ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг.

Хүснэгт 5.Комиссын гишүүний зөвлөмжийн хариу ирүүлээгүй байгууллага, албан тушаалтан 2024 он.

№	Комиссын гишүүний зөвлөмж	Агуулга	Огноо дугаар	Хариу ирүүлсэн
1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй ихэр хүүхдүүдийг орон байраар хангах	2024.07.08 №02/31	Хариу ирээгүй
2	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн эрх болон хүний эрх хамгаалагчдын эрхтэй холбоотой зарим асуудлыг хэрэгжүүлэх тухай	2024.07.25 №01/34	Хариу ирээгүй

ГУРАВ.КОМИССЫН ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1.Комиссын гишүүний шаардлагын хэрэгжилт

Комиссын гишүүний шаардлагаас 18 нь “бүрэн хэрэгжсэн”, 11 нь “хэрэгжих шатанд”, 1 нь “хэрэгжилт хангалтгүй” буюу хэрэгжилтийн дундаж хувь 87, “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна. Энэ нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 7 хувиар өссөн байна.

Хүснэгт 6.Комиссын гишүүний шаардлагын хэрэгжилт. 2024 он.

Шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага		Нийт тоо	Шаардлага, зөвлөмжийн тоо				Үнэлгээн -ий дундаж /%/
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэг-жээгүй	
			100%	70%	30%	0%	
Комиссын гишүүний шаардлага	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	9	3	5	1	-	76%
	Хууль сахиулах байгууллага	6	4	2	-	-	90%
	Нийслэл орон нутгийн Засаг дарга	12	8	4	-	-	90%
	Төрийн үйлчилгээ, ТӨХК	1	1	-	-	-	100%
	Хувийн хэвшил	2	2	-	-	-	100%
	Дүн	30	18	11	1	-	87%

3.2.Комиссын гишүүний зөвлөмжийн хэрэгжилт

Комиссын гишүүний зөвлөмжөөс 23 нь бүрэн хэрэгжиж, 21 нь хэрэгжих шатанд, хэрэгжилт хангалтгүй 5, хэрэгжээгүй 7, хэрэгжилтийн дундаж хувь 70, “тодорхой үр дүнд хүрсэн” үнэлгээтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн үнэлгээтэй харьцуулахад **2 хувиар буурсан** байна.

Хүснэгт 7.Комиссын гишүүний зөвлөмжийн хэрэгжилт 2024 он.

Шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага		Нийт	Шаардлага, зөвлөмжийн тоо				Үнэлгээний дундаж /%/
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэг-жээгүй	
			100%	70%	30%	0%	
Комиссын гишүүний зөвлөмж	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	25	11	7	3	4	67%

Хууль сахиулах байгууллага	9	4	5	-	-	83%
Нийслэл орон нутгийн Засаг дарга	11 ⁵	4	5	1	1	71%
Төрийн үйлчилгээ, ТӨХК	8	3	3	1	1	68%
Хувийн хэвшил	3	1	1	-	1	57%
Дүн	56	23	21	5	7	70%

Үндэсний их баяр наадам, даншиг, бүсийн хурдан морины уралдаан болон сунгаа, уралдааны бэлтгэлийн үеэр хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Комиссын гишүүний **2024 оны 02/28 дугаар зөвлөмжийг** бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 77 хувьтай байна.

Уг зөвлөмж нийт 11 заалттай ба хэрэгжилтийн тайлан, мэдээг ирүүлэхдээ 4 - 8 заалтын талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээлэл ирүүлээгүй байсныг үндэслэн тухайн заалтын хэрэгжилтийг 0 хувьтай үнэлсэн. Тиймээс дараах аймгуудын үнэлгээ хангалтгүй гарч байна. Үүнд: Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Өмнөговь аймаг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Тус зөвлөмжийн 10 дахь заалт болох “Унаач хүүхдийн судалгааг дэлгэрэнгүй гаргах хагас бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, үрчлэгдсэн эсхүл эрсдэлт бүлэгт хамаардаг гэх мэт” арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар нийт 30 шаардлагыг хүргүүлсэн нь **өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,3 хувиар өссөн**, харин байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй гэж үзэн нийт 56 зөвлөмжийг хүргүүлсэн нь **өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,1 хувиар буурсан** байна.

2024 онд Комиссын гишүүний 86 шаардлага, зөвлөмжөөс “бүрэн хэрэгжсэн” 41, “хэрэгжих шатанд” 32, “хэрэгжилт хангалтгүй” 6, “хэрэгжээгүй” 7 буюу дунджаар 76 хувийн хэрэгжилттэй байгаа нь өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад **тухайн түвшинд** байна.

Комиссын гишүүний шаардлагын хэрэгжилт 87 хувь байгаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг мөн хувиар арилгаж, зөвлөмжийн хэрэгжилт 70 хувь байгаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй нөхцөлийг мөн хувиар бууруулж тодорхой үр дүнд хүрч ажилласан байна.

Хүснэгт 8. Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 2024 он.

Шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан албан байгууллага		Нийт	Шаардлага, зөвлөмжийн тоо				Үнэлгээний дундаж %
			Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэг-жээгүй	
			100%	70%	30%	0%	
Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж	Засгийн газар, яам агентлаг түүний салбар нэгж	34	14	12	4	4	69%
	Хууль сахиулах байгууллага	15	8	7	-	-	86%
	Нийслэл орон нутгийн Засаг дарга	23	12	9	1	1	81%

⁵ Хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудлаар 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 02/28 дугаар зөвлөмжийг 21 аймгийн Засан даргад хүргүүлсэн.

	Төрийн үйлчилгээ, ТӨХК	9	4	3	1	1	71%
	Хувийн хэвшил	5	3	1	-	1	74%
Нийт		86	41	32	6	7	76%

Комиссын гишүүний нийт 86 шаардлага, зөвлөмжийн 439 заалтын хэрэгжилтийг заалт тус бүрээр дүгнэн үзэхэд 57 заалтыг хэрэгжүүлээгүй, 40 заалтын хэрэгжилт хангалтгүй, 30 заалт хэрэгжих шатанд, 312 заалт бүрэн хэрэгжсэн байна.

Хууль зүйн туслалцаа болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн зөрчилтэй холбогдох асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Харин төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах, шийдвэрлүүлэх, нийгмийн халамж хүртэх болон хувийн мэдээллээ хамгаалах эрхийн асуудал шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байна.

Хөдөлмөрлөх эрх болон хөдөлмөрийн харилцаа дахь жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотойгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Мөн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох, амьдрах болон хүүхдийн эрхийн асуудлаар нэлээдгүй арга хэмжээг хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулан ажилласан байна.

Хүснэгт 9.Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн заалт 2024 он

Хөндөгдсөн эрх	Нийт	Заалт тоо	Үнэлгээ /заалтын тоо/				Үнэлгээний дундаж /%/
			Бүрэн хэрэгжсэн 100%	Хэрэгжих шатанд 70%	Хэрэгжилт хангалтгүй 30%	Хэрэгжээгүй 0%	
Төрийн үйлчилгээ авах эрх	2	6	4	1	-	1	78%
Эвлэлдэн нэгдэх эрх	3	26	20	2	3	1	86%
Хөдөлмөрлөх эрх	13	63	43	6	9	5	79%
Жендерийн эрх тэгш байдлыг хангах эрх	14	65	44	4	5	12	74%
Эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох эрх	5	23	18	2	1	2	86%
Хүүхдийн эрх	12	65	54	3	3	5	88%
Нийгмийн халамж хүртэх эрх	3	10	2	-	-	8	20%
Хувийн мэдээллээ хамгаалуулах эрх	6	15	8	1	2	4	62%
Сурч боловсрох эрх	2	10	8	2	-	-	94%
Хууль зүйн туслалцаа авах эрх	1	2	2	-	-	-	100%
Хүний эрх хамгаалагчийг хамгаалуулах эрх	2	22	15	1	2	4	74%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх	1	4	-	2	2	-	50%
Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх	8	48	34	3	8	3	80%
Халдашгүй чөлөөтэй байх эрх	4	19	17	2	-	-	97%
Ахмад настны эрх	5	34	21	1	4	8	67%
Сонгох, сонгогдох эрх	1	9	8	-	1	-	92%

Эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх	1	5	5	-	-	-	100%
Шударга шүүхээр шүүлгэх эрх	2	9	8	-	-	1	89%
Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрх	1	4	1	-	-	3	25%
	86	439	312	30	40	57	-

Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд шаардлагыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичгээр хариу мэдэгдэх⁶ үүрэгтэй. Энэ тухай шаардлага, зөвлөмжийн төгсгөл хэсэгт хариу мэдэгдэх талаар тэмдэглэж анхааруулсаар байтал, удаа дараа шаардуулах, хугацааг 60 хүртэл хоногоор хэтрүүлэх зэрэг тохиолдол гарсаар байна.

Цаашид Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ тайлан, мэдээллийг хуульд заасан хугацаанд ирүүлж байх, шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан (хүний хувийн мэдээлэлд хамаарахаас бусад) хэрэгжилтийг цахим хуудсаараа иргэд, олон нийтэд мэдээлж байх нь зүйтэй байна.

⁶ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

VPN	Виртуал хувийн сүлжээ
АН	Ардчилсан нам
АНСДИТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АНСДИТХСтХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АСДҮОУХ	Ардчилсан сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
АШН	Ардчилал шинэчлэлийн нам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага
ЕАБХАБ/АИХЭГ	Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага Ардчилсан институт Хүний эрхийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЗЁН	Зүй ёс нам
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИХН	Иргэний хөдөлгөөний нам
КГХТГ	Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
МЛН	Монголын либерал нам
ММН	Миний монголын нам
МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн холбоо
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МУИС	Монгол Улсын их сургууль
МУИХ	Монгол Улсын Их Хурал
МУИХСтХ	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
МҮОНРТ	Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз
МХТН	Монголын хүний төлөө нам
МШН	Монголын шинэчлэл нам
МЭГ	Монополын эсрэг газар
МЭҮНН	Монголын эмэгтэйчүүдийн үндэсний нэгдсэн нам
ННФ	Нээлттэй нийгэм форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага

НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭМУТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТББ	Төрийн бус байгууллага
ТТЭНН	Тусгаар тогтнол эв нэгдлийн нам
ТХБ	Түр хамгаалах байр
УБ	Улаанбаатар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын Дээд Шүүх
УИХ	Улсын Их Хурал
УТНтХ	Улс төрийн намын тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХМХН	Хамаг Монгол хөдөлмөрийн нам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХСИС	Хууль сахиулахын их сургууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
ХХЕГ	Хил хамгаалах Ерөнхий газар
ХХЗХ	Харилцаа холбооны Зохицуулах Хороо
ХЭДКГ	Хүний эрхийн Дээд комиссарын газар
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХЭХЭЗБтХ	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦЖСХ	Цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭОН	Эх орон нам
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага